ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны нэгдүгээр сарын 9 №1 (188)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Гэрээ соёрхон батлах тухай (2000-12-28-ны хууль) 1
2. Гэрээ соёрхон батлах тухай (2000-12-28-ны хууль) 2
3. Гэрээ соёрхон батлах тухай (2000-12-28-ны хууль) 2
4. Гэрээ соёрхон батлах тухай (2000-12-28-ны хууль) 2

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

5. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 56 2

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

6. Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай Дугаар 172 3

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Дугаар 179 3

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Гэрээ соёрхон батлах тухай

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын хооронд 2000 оны 12 дугаар сарын 4-ний өдөр гарын үсэг зурсан Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд 2000 оны 5 дугаар сарын 2-ны өдөр гарын үсэг зурсан Иргэн, аж ахуйн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Украин Улсын хооронд 1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд 2000 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 56 — Улаанбаатар хот

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн С.Оюуны хүсэлтийг харгалзан Нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26–ны өдөр | Дугаар 172 | Улаанбаатар хот

Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай

"Хүнсний тухай" хуулиар хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоог хуульчлан батлагдсан боловч хяналтын бүтцийг хуульд заасны дагуу бий болгох, холбогдох эрхийн актуудыг уг хуульд нийцүүлэх ажил удаашралтай байна.

Хүнсний аюулгүй байдлын хяналтын өнөөгийн тогтолцоо зэрлийн нөхцөлд тавигдах шаардлагыг хангаж чадахгүй байгаа бөгөөд хүн амын хүнсний аюулгүй байдалтай холбогдох асуудлууд үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар зохицуулагдахгүй байгаа нь хуулийг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд саад учруулан, манай иргэдийн эрх ашигт нийцэхгүй байгаа юм.

Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд төрийн онцгой анхааралд байх шаардлагатай асуудал болохыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-ыг үндэслэн Засгийн газарт чиглэл болгох нь:

1.Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг мэргэжлийн нэгдмэл удирдлагар хангах бүтцийг зохион байгуулж, үйл ажиллагаатай нь холбогдон гарах бусад асуудлыг шийдвэрлэх;

2.Үйлдвэрлэлт, боруулалтын бүх шатанд хүнсний чанар, аюулгүй байдлын дотоод хяналтын тогтолцоог бий болгох арга хэмжээ авах;

3.Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтын үндэсний лавлах лаборатори байгуулж, хүнсний бүтээгдэхүүний хяналтын лабораторийн сүлжээг бэхжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 22–ны өдөр | Дугаар 179 | Улаанбаатар хот

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 33 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийн явцыг улирал тутам гарган Засгийн газарт мэдээлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, дараа оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд танилцуулж байхыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. **НИЙГМИЙН БОДЛОГО**

Нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах орчинг бүрдүүлэх, үргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчлэхээ хүртээмжтэй болгох, ажилчдийг, ялангуяа бүрүүлахад чиглэдэзнэ.

№		Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах этэн
1.1 Хүн амын боловсролын хэрэгцээг жигд хангах орчин бүрдүүлж бүх нийтээр суурь боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, орчин үеийн мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:					
1	1.1.1	Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, их засвар-рын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэг-дүүлнэ.	1. Бүх шатны сургууль, хүүхдийн цэцэрлэгт зайлшгүй шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тодорхойлсны үндсэн дээр холбогдох жагсаалт, хөрөнгийн тооцоог гаргаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авна.	2000, 2001-2004	А.Цанжид Ч.Улаан
			2. Боловсролын байгууллага санхүүжилтийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх зорилгоор төсөвт зардлыг хэмнэх, санхүүгийн нэмэлт эх үүсвэр олох механизм бүрдүүлэх үйл ажиллагааг дэмжих шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.	2000-2004	А.Цанжид
			3. Боловсролын байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд Азийн хөгжлийн банк болон хандивлагч орны тусламж авах талаар тодорхой төсөл, санал боловсруулж, шийдвэрлэнэ.	2000-2004	А.Цанжид Ч.Улаан
2	1.1.2	Ачаалал ихтэй сургуулийн барилгыг өргөтгөх, шинээр барихын зэрэгцээ хөдөөгийн сургуулиу-дын барилгыг засвар-лаж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана.	4. Гурван эрэлхээр хичээллэж байгаа болон эхний эрэлжинд өргөтгөх шаардлагатай, түүнчлэн их засвар хийх ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургуулиудын барилгын судалгааг гаргаж, эн тэргүүнд өргөтгөх, шинээр барих болон их засвар хийх сургуулийн барилгын жагсаалт, хөрөнгийн хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган тодорхой хугацаанд, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.	2000, 2001-2004	А.Цанжид Ч.Улаан
			5. Гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгө, туслалцаатайгаар сургууль, цэцэрлэгийн барилга барих, засварлах ажлыг дэмжинэ.	2001-2004	А.Цанжид
3	1.1.3	Боловсролын салбарт хувийн хэвшлээс хийх хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулна.	6. Ашгийн төлөө бус үйл ажилагаа явуулах зорилгоор гадаад орноос оруулж ирсэн сургалтын зорилуалттай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг импортын барааны татвараас чөлөөлүүлэх арга хэмжээ авна.	2001-2003	А.Цанжид
			7. Боловсролын салбарт хөрөнгө оруулсан хувийн хэвшлийн гадаад дотоодын байгууллага, иргэдийг урамшуулах журам гаргаж хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид
4	1.1.4	Ерөнхий боловсролын сургуулиудыг компьютержүүлж, интернэтийн сүлжээнд холбож эхэлнэ.	8. Компьютерийн суурин болон явуулын кабинет байгуулах шаардлагатай бүсийн төв, сургуулиудыг тодорхойлж, хөрөнгийн тооцоог гарган эх үүсвэрийг төвлөрсөн төсөв, гадаад орнуудын болон хандивлагчдаас оруулах хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.	2000, 2001-2004	А.Цанжид Ч.Улаан
			9. Техникийн болон мэргэжлийн сургууль, ерөнхий боловсролын дунд сургуулиудыг компьютержүүлэх арга хэмжээг зэрэг дараатай авч хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			10. Интернэтийн сүлжээнд холбох арга хэмжээг эхний эрэлжинд Улаанбаатар, аймгийн төвийн зарим сургуулиудыг шаардагдах хөрөнгийн, эх үүсвэртэй, үеэдүүлэн эрэлж дараатайгаар шийдвэрлэнэ.	2001-2004	А.Цанжид

5	1.1.5	Боловсролын агуулгыг хүүхэд, залуучуудыг ажилд сургах, амьдралд бэлтгэх, өөрийн орны уламжлалт болон орчин үеийн үйлдвэрлэлийн үндэс суурийг ээлмшүүлэх чиглэлээр шинэчилж, орчны стандартыг батлан мөрдүүлэх, чанарын үнэлгээний тогтолцоог төлөвшүүлнэ.	11. Бага, дунд боловсролын агуулгын стандартын хэрэжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр түүнийг хэрэглээний хандлагатай болгох, сурилцагчдыг өөрийн орны амьдралын хэв маягтай танилцуулах үйл ажиллагаог өргөтгөнө.	2001-2004	А.Цанжид
			12. Бүх шатны боловсролын сургалтын орчинд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үндсэн дээр сургалтын орчны стандартыг боловсруулж, батлан мөрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			13. Дээд боловсролын агуулгад тавих шаардлагыг олон улсын дээд боловсролын хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулна.	2001-2002	А.Цанжид
			14. Дээд боловсролын агуулгын цөм стандарт боловсруулж, хэрэжилтийг хангана.	2001-2003	А.Цанжид
			15. Хууль зүйн дээд боловсрол олгох үндэсний стандартыг иж бүрэн шинэчилж мөрдүүлнэ.	2000-2001	Ц.Нямдорж
			16. Сурилцагчдын мэдлэг, чадварын төлөвшлийг үнэлэх журам, элсэлт, төгсөлтийн шалгалтын жүрмүүдыг хянаж зохих шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулна.	2000-2002	А.Цанжид
6	1.1.6	Өөрийн орны болон гадаад орнуудын боловсролын баримт бичгийг харилцан зөвшөөрөх боломжийг идэвхтэй эрэлхийлнэ.	17. Өөрийн орны ерөнхий болон дээд боловсролын агуулга, түвшинг гадаад зарим орныхтой харьцуулсан судалгаа хийнэ.	2001-2002	А.Цанжид
			18. Судалгааны дүнг үндэслэн улс орнуудтай боловсролын баримт бичиг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ, хэлэлцээр байгуулна.	2001-2004	А.Цанжид
7	1.1.7	Мэргэжлийн боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн жүрмыг шинэчлэн сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авна.	19. Техникийн болон мэргэжлийн сургуулийг магадлан итгэмжлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			20. Магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын байгууллагад төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийн жүрмыг тогтооно.	2000-2001	А.Цанжид, Ч.Улаан
			21. Дээд боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчныг боловсруулж хэрэжүүлнэ.	2001-2002	А.Цанжид
8	1.1.8	Сурах бичгийг шинээр зохиох, хэвлүүлэх, түгээх арга механизмыг боловсронгуй болгоно.	22. Сурах бичиг сургалтын агуулга, стандартад нийцэж буй эсэхэд магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	2000-2004	А.Цанжид
			23. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн шинэчлэлийг дуусгана.	2000, 2001-2004	А.Цанжид
			24. Сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх жүрмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид
9	1.1.9	Дунд сургуульд	25. Аймаг, сумдад суурь боловсролын	2001-2004	А.Цанжид

		хамрагдах хүрээг нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлыг төр хариуцдаг болно.	хамрах сургалтын хүрээг 90 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.		аймгийн Засаг дарга нар
			26. Дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг жил бүр шинэчлэн тогтоож мөрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид, Ч.Улаан
			27. Сургуулийн дотуур байранд хүүхэд амьдрах нөхцөл болон хүүхдийн хоол, хүнсний хангамж, бусад үйлчилгээг сайжруулна.	2001-2004	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
10	1.1.10	Эмзэг бүлгийн болон олон хүүхэд нь зэрэг суралцдаг ерөнхий 3-аас дээшхи хүүхдэд 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн хичээлийн хэрэгслийг үнэ төлбөргүй олгоно.	28. Эмзэг бүлгийн ерх айлаас ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хүүхдийн судалгааг аймаг, нийслэл, сум, дүүргийн сургууль бүрээр жил тутам нарийвчлан гаргана.	2000-2004	А.Цанжид
			29. Эмзэг бүлгийн ерхийн хүүхдийг хичээлийн хэрэгслээр хангах жүрмыг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2000, 2001-2004	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
			30. Ерөнхий боловсролын сургуульд 3-аас дээш хүүхэд нь зэрэг суралцдаг ерх гэрийн судалгааг аймаг, нийслэл, сум, дүүргийн сургууль бүрээр нарийвчлан гаргаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэртэй нь уялдуулж, тэдэнд хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй олгох арга хэмжээг эцэг дараватай хэрэгжүүлнэ.	2000-2004	А.Цанжид Ч.Улаан аймаг, нийслэлийн Засаг дарга
11	1.1.11	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, хүүхдийг цэцэрлэгт өргөнөөр хамруулахын зэрэгцээ гэрийн нөхцөлд хүүхдийг сургууль бэлтгэх шинэ арга хэлбэрийг нэвтрүүлнэ.	31. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх албан бус хэлбэрийн сургалт /явуулын багш ажиллуулах, түр болон бэлтгэл сургалтууд зохион байгуулах, зайны сургалт г.м/-ын арга хэлбэрүүдийг нэвтрүүлж, түүнд нийцсэн сургалтын арга зүйг боловсруулан хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			32. Эцэг, эхчүүдэд зориулсан сургалтын хэрэгтэйдэхүүн, ном, гарын авлагыг боловсруулж хэвлүүлнэ.	2001-2003	А.Цанжид
			33. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын материаллаг нөхцөлийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид
12	1.1.12	Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулийн салбарыг Монгол Улсад байгуулж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр сургуульд суралцагсдад сургалтын төлбөрөө төлөхөд нь дэмжлэг үзүүлнэ.	34. Өндөр хөгжилтэй орнуудын их сургууль, коллежийн салбарыг Монгол Улсад байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2000-2001	А.Цанжид
			35. Өндөр хөгжилтэй орнуудын их сургууль, коллежийн салбарт суралцагсдад дэмжлэг үзүүлнэ.	2000-2004	А.Цанжид
13	1.1.13	Дотоодын их сургууль, коллежид суралцдаг онц сурлагатай болон төр аваяастай оюутнуудад урамшуулал, тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэнэ.	36. Төр аваяастай суралцагсдад урамшуулал, тэтгэлэг олгодог гадаад орны гуршлагыг судалж, дээд боловсролын байгууллагын сурлагын өндөр амжилт гаргасан болон төр аваяастай оюутнуудад урамшуулал, тэтгэлэг олгодог журмыг шинэчлэн мөрдөнө.	2001 оноос	А.Цанжид

14	1.1.14	Дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа ядуу өрхийн болон малчин өрх, хөөрөөс дэээш хүүхэд нь зөрэг суралцаж байгаа айлын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцдаг болно.	37. Богд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай малчин өрх, нэн ядуу өрх, гурав ба түүнээс дээш хүүхэд нь их сургууль, коллежид зөрэг суралцаж байгаа өрхийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцна.	2000-2004	А.Цанжид, Ч.Улаан
			38. Богд шилжүүлснээр 201-500 толгой малтай малчин өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төр хариуцна.	2002-2004	А.Цанжид, Ч.Улаан
			39. Богд шилжүүлснээр 501-1000 толгой малтай малчин өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төр хариуцна.	2003-2004	А.Цанжид, Ч.Улаан
15	1.1.15	Дотоодын их сургууль, коллежид суралцагсад үзүүлэх хөнгөлөлтийг олон улсын нийтлэг жишгийн дагуу бүрэн эдлүүлэх арга хэмжээ авч, оюутнуудыг чөлөөт цагаараа хөдөлмөр эрхэлж амьдрал, ахуйгаа дээшлүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлнэ.	40. Их сургууль, коллежид суралцагчдад Улаанбаатар, зарим аймгийн төвд нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход болон баруун таван аймгийн оюутныг өвлийн амралтаар орон нутагтаа зорчиход нэг талын тээврийн зардлын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэж мөрдөнө.	2000-2004	А.Цанжид, Ч.Улаан аймаг, нийслэлийн Засаг дарга
			41. Оюутнуудыг чөлөөт цагаараа хөдөлмөр эрхлэх боломж олгох, ажлын байрны судалгаа хийж, шийдвэр гарган хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2000-2002	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			42. Хууль тогтоомжид нэмэлт оруулах замаар төрийн сургуулийн нэг оюутанд ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоож мөрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид, Ч.Улаан
16	1.1.16	Албан бус боловсрол, алсын зайны сургалт, тур хугацааны төрөлжсөн сургалтын хэлбэрийг оновчтой зохион байгуулж, сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол эзэмшүүлж, бичиг үсэг үл мэдэх явдлыг эрс бууруулна.	43. Монгол Улсын хүн амын 2000 оны тооллогын дүнг үндэслэн бичиг үсэг үл мэдэгдийг бичиг үсэгт сургах тур сургалтуудыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			44. Төв, орон нутгийн албан бус боловсролын байгууллагуудыг бэхжүүлэх, иргэдэд боловсрол олгох, ажил мэргэжлийн дадал эзэмшүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			45. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	2001 оноос	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
17	1.1.17	Төрийн болон төсөвт байгууллагудыг мэдлэг чадвар өндөртэй боловсон хүчнээр хангах нэгдсэн бодлого, хэрэгцээт тодорхойлж улсын захиалга өгч байх, захиалгын дагуу бэлтгэгдсэн гэрээт боловсон хүчнийг ажлын байраар хангах үүргийг төр хариуцна.	46. Төрийн болон төсөвт байгууллагын боловсон хүчний өнөөгийн хангалтын байдалд судалгаа хийж, дүгнэлт гаргана.	2001	А.Цанжид, Ш.Батбаяр
			47. Төрийн болон төсөвт байгууллагад шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тооцож, тэдгийг бэлтгэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид, Ө.Энхтувшин Ш.Батбаяр
			48. Хүний нөөцийн хэрэгцээг мэргэжлийн боловсролын сургуулийн элсэлттэй уялдуулан суралцагсдыг төрийн болон төсөвт байгууллагын захиалга, гэрээний дагуу сургах, ажлаар хангах талаар журам боловсруулан мөрдөнө.	2001-2004	А.Цанжид, Ө.Энхтувшин Ш.Батбаяр
18	1.1.18	Өндөр хөгжилтэй орнуудад сургах оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлнэ. Орчин үеийн мэдээлэл, шинэ техник, технологитой танилцах гол хөшүүрэг болсон олон улсын	49. Улсын төвлөрсөн төсвийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй орны их сургуулиудад оюутан, магистрант, докторант сургах тэргүүлэх чиглэлийг жил бүр тогтоно.	2001-2004	А.Цанжид
			50. Тухайн орны сургуулиудтай сургалтын төлбөрийг хөнгөлөх талаар гэрээ, хэлэлцээр байгуулах, гадаад орон, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламж,	2001-2004	А.Цанжид

		түгээмэл гадаад хэл сурах, ашиглах өндөр шаардлага тавина.	хөнгөлөлттэй зээл авах замаар суралцагсдын тоог нэмэгдүүлнэ.		
			51. Өндөр хөгжилтэй орны их сургуулиудтай хамтарсан сургууль байгуулах замаар магистрантур, докторантурт суралцах хүмүүсийн тоог нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлнэ.	2001-2004	А.Цанжид
			52. Жил бүр АНУ, Англи, Герман, Франц зэрэг оронд оюутан суралцуулж байх талаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			53. Засгийн газрын хэлэлцээрийн шугамаар оюутан сургах орны тоог нэмэгдүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			54. Гадаад хэлийг бүх шатны сургуульд хөтөлбөрийн дагуу заахаас гадна, гадаад хэлний түр сургалт эрхлэх үйл ажиллагааг дэмжиж, сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна.	2001-2004	А.Цанжид
19	1.1.19	Багш, боловсролын удирдах ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчилнэ.	55. Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндсэн чиглэл боловсруулна.	2001-2004	А.Цанжид
			56. Багшид мэргэжлийн зэрэг олгох журмыг шинэчлэн мөрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			57. Цэцэрлэгийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал, хичээлийн эрхлэгч нарт зориулсан сургалтын тусгай хөтөлбөр гаргаж, түүний дагуу сургалтыг зохион байгуулна.	2001-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			58. Сургалт, арга зүйн бүсийн төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулна.	2000-2001	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
			59. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төвийн захирал, арга зүйч нарыг орон нутаг, бүсийн болон төвлөрсөн сургалтад үе шаттайгаар хамруулна.	2000-2001	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
20	1.1.20	Тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг эрчимжүүлнэ.	60. Ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар анги төгсөгчдөөс техникийн болон мэргэжлийн сургууль элсүүлж, сургалтын болон дотуур байрны зардлыг төр хариуцна.	2001-2004	А.Цанжид, Ч.Улаан
			61. Хувийн хэвшил, эздийн байгууллага, хөдөлмөр зохицуулалтын албатай хамтран тусгай мэргэжлийн боловсон хүчнийг гэрээ, захиалгаар сургаж, ажлын байраар хангах арга хэмжээ авна.	2001-2004	А.Цанжид, Ш.Батбаяр
			62. Тусгай мэргэжлийн сургуулиудыг бэхжүүлэхэд олон улсын байгууллагын зээл, тусламж, хамтарсан төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	А.Цанжид, Ш.Батбаяр
1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж, хүн амыг эрүүлжүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:					
21	1.2.1	Төсөвөөс эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг жил бүр нэмэгдүүлнэ.	63. Эрүүл мэндийн салбарт зарцуулах улсын төсвийн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа Ч.Улаан
			64. Эрүүл мэндийн тусламжийн санхүүгийн нөөц, хуваарилах, шалгуур, үзүүлэлт боловсруулна.	2000-2001	П.Нямдаваа Ч.Улаан

			65. Санхүүгийн нөөцийн хуваарилалтын үр ашгийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн тогтоох замаар эрүүл мэндийн суурь тусламжид зарцуулах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	2001–2004	П.Нямдаваа Ч.Улаан
22	1.2.2	Эрүүл мэндийн даатгалд хамрагдах эмчилгээ, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоох замаар төрийн өмчийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээг үнэ төлбөргүй болгож, эрүүл мэндийн даатгалыг бие даалган хөгжүүлнэ.	66. Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн боловсруулж мердүүлнэ.	2001-2002	П.Нямдаваа, Ш.Батбаяр, Ч.Улаан
			67. Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоо бий болгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа Ш.Батбаяр Ч.Улаан Ц.Нямдорж
			68. Төрийн өмчийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээг үнэ төлбөргүй болгох журмыг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлнэ.	2001-2002	П.Нямдаваа, Ч.Улаан
23	1.2.3	Эрүүл мэндийн суурь тусламжийг өрхийн эмнэлгээр үзүүлэх тогтолцоонд шилжүүлнэ.	69. Өрхийн ба сумын эмнэлгийн түвшинд үзүүлэх Эрүүл мэндийн суурь тусламжийн багцыг тодорхойлсны үндсэн дээр суурь тусламж үзүүлэх тогтолцооны эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2001-2002	П.Нямдаваа, Ц.Нямдорж
			70. Эрүүл мэндийн суурь тусламжийн багцын өртөг зардлыг тогтоож, санхүүжүүлэх стандарт боловсруулна.	2001-2002	П.Нямдаваа, Ч.Улаан
			71. Өрхийн ба сумын эмнэлгийг нэг хүнд ногдох зардлаар санхүүжүүлэх ажлыг өргөжүүлж, бүх эмнэлгийг хамруулна.	2000-2004	П.Нямдаваа
			72. Эрүүл мэндийн суурь тусламжийг хүн амд өрхийн болон сумын эмнэлгээр үзүүлэх тогтолцоог төлөвшүүлнэ.	2003	П.Нямдаваа
24	1.2.4	Дархлаажуулалтын санг байгуулж, тарилгаар урьдчилан сэргийлэгдэх халдварт өвчний тархалтыг шат дараалан бууруулах, улмаар устгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	73. Дархлаажуулалтын санг өмчийн бус хэвшлийн аж ахуйн нэгж, олон нийтийн болон олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулж, сан бүрдүүлэх, зарцуулах журмыг баталж мердүүлнэ.	2000-2002	П.Нямдаваа, Ч.Улаан
			74. Тарилгатай халдварт өвчнийг устгах арга замыг судлах чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын захиалга боловсруулан хэрэгжүүлнэ.	2002	П.Нямдаваа
			75. Тарилгатай халдварт өвчнийг тандах идэвхтэй тандалтын иж бүрэн сүлжээ нэвтрүүлнэ.	2002-2004	П.Нямдаваа
			76. Улаан бурхан өвчнийг эрс бууруулан устгах зорилгоор хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2001	П.Нямдаваа
			77. Халдварт саа өвчний устгалыг баталгаажуулах арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа
25	1.2.5	Нийгмийн эмэгэг бүлэгт хамрагдах өндөр настан, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, насанд хүрээгүй	78. Эмэгэг бүлэгт хамрагдах иргэдэд үзүүлэх байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээний одоогийн байдлын талаар судалгаа хийж, үнэлгээ дүгнэлт өгнө.	2000-2001	П.Нямдаваа

		хүүхдүүд, тахир дутуу иргэдэд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлнэ.	79. Эмээг булгийн хүмүүст эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх, эм олгох журам боловсруулан тагтаж мөрдүүлнэ.	2001	П.Нямдаваа
			80. Нийгмийн эмээг бүлэгт үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаархи хөтөлбөр, төслийг өргөжүүлэн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2000-2004	П.Нямдаваа Ш.Батбаяр
			81. Нийгмийн эмээг бүлэгт хамрагдах хүн ам, халамжийн төвүүд, хүүхэд асран хүмүүжүүлэх байранд байгаа хүүхэд, өндөр настан зэрэг хүмүүсийн бодит хэрэгцээг судалж, холбогдох арга хэмжээ авна.	2001	П.Нямдаваа Ш.Батбаяр Д.Насанжаргал
26	1.2.6	Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг багасгах хөтөлберийг хэрэгжүүлж, төрөөс зардлыг нь санхүүжүүлнэ.	82. Эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд үнэлгээ өгөх замаар өнөөгийн нөхцөлд нийцүүлэн үр дүнтэй нэгдсэн цогц бодлого явуулна.	2000-2001	П.Нямдаваа
			83. Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах стратегийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	2001	П.Нямдаваа
			84. Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийг оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа Ч.Улаан
			85. Бүх баг, сумын эмнэлгийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн багаж, хэрэгслээр хангана.	2000-2004	П.Нямдаваа
			86. Жирэмсэн, төрөхийн хүндрэлийн улмаас орон нуттаас ирсэн эхчүүдэд дориулсан амрах байрыг Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвийн дэргэд байгуулж ажиллуулна.	2001 оноос	П.Нямдаваа
			87. Анагаах ухааны коллежуудад эх баригч-бага эмч бэлтгэх тусгай анги нээн ажиллуулна.	2002 оноос	П.Нямдаваа, А.Цанжид
			88. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх болон гэр бүл төлөвлөлтийн талаархи хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа, А.Цанжид
			89. Хүүхдийн дунд зонхилон тохиолдож байгаа өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлберүүдийг шинэчлэн боловсруулж, санхүүжилтийг төрөөс хариуцан хэрэгжүүлэх арга хэрэглүүр бий болгоно.	2000–2004	П.Нямдаваа
			90. Хүүхдийн өвчнүүд, жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийн оношлогоо, эмчилгээний жишгийг (стандарт) боловсруулан хэт, хэдэегийн бүх эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад мөрдүүлнэ.	2001	П.Нямдаваа
			91. Эх, хүүхдийн хоол тэжээлийн өнөөгийн байдлыг судалж, түүнийг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр боловсруулан мөрдүүлэх, хүн амын дунд сурталт, суртачилгаа явуулах арга хэмжээ авна.	2000-2001	П.Нямдаваа

27	1.2.7	Эмийн нэгдсэн бодлогын хүрээнд эм тариллын хангамжийг сайжруулж, чанарын хяналтыг хүчтэй болгоно. Хэвтэн эмчлүүлэгсдийн эм тариа болон түргэн тусламжийн автомашины шатахууныг иргэдээс гаргуулдаг гажуудлыг арилгана.	92. Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тесөл боловсруулан шийдвэрлүүлнэ.	2000-2001	П.Нямдаваа
			93. Эмийн үндэсний бодлогын баримт бичгийг баталж хэрэжүүлнэ.	2000-2001	П.Нямдаваа
			94. Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийг импортын татвараас чөлөөлүүлэх, түүнийг сонгон шалгаруулалтаар нийлүүлэх замаар үнийг хямдруулах арга хэмжээ авна.	2001	П.Нямдаваа Ч.Улаан
			95. Эмийн үйлдвэрийн хяналтын (GMP) болон Эмийн чанарын баталгаажуулалтын хяналтын дүрмийг боловсруулан баталж мөрдүүлнэ.	2001-2002	П.Нямдаваа
			96. Эмийн үндэсний бүртгэлд орсон эмийн чанарыг давтан баталгаажуулах, зарим эмийн давхацлыг арилгах.	2001-2002	П.Нямдаваа
			97. Эмийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, гадаадаас эм импортлогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, хууль бусаар гадаадаас эм, бэлдмэл оруулах явдлыг таслан зогсоох арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа Ч.Ганзориг
			98. Төрийн өмчийн эмнэлгүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийг сонгон шалгаруулалтаар нийлүүлэх дүрэм, журмыг гаргаж мөрдүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа
			99. "Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг" НҮБ-ын 1988 оны нэгдсэн конвенцид нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.	2000-2004	П.Нямдаваа
			100.Хүн ам, эмнэлгийн мэргэжилтэнд хүргэх эмийн мэдээллийг тогтмолжуулах, хүн амд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа
28	1.2.8	"Эрүүл мэндийн технологи" үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэжүүлнэ.	101. Эрүүл мэндийн технологийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч технологийн эрэлт хэрэгцээг тогтооно.	2000-2001	П.Нямдаваа
			102. "Эрүүл мэндийн технологи" үндэсний хөтөлбөр боловсруулж өртөг зардал багатай, үр дүнтэй технологийн бодлого хэрэгжүүлнэ.	2001	П.Нямдаваа Ч.Ганзориг
			103. Эрүүл мэндийн байгуулагуудын технологийн стандартыг боловсруулна.	2001-2002	П.Нямдаваа
29	1.2.9	Оношлогоо, эмчилгээний төвүүдийг эдийн засгийн бүсүүдэд байгуулж, орчин үеийн тоног төхөөрөмж, нарийн мэргэшлийн эмч мэргэжилтнээр хангана.	104. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэнгамж, ашиглалтын нэгдсэн бодлого боловсруулна.	2000-2001	П.Нямдаваа
			105. Оношлогоо, эмчилгээний бүсийн төвд шаардагдах эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээг судалж, захиалах, хангах арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа
			106. Бүсийн төвд ажиллах эмч, мэргэжилтний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, тэдэнд эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж ашиглах болон оношлогоо, эмчилгээний стандарт эзэмшүүлэх сургалтуудыг зохион	2001-2004	П.Нямдаваа

			байгуулна.	2001-2004	П.Нямдаваа
			107. Бусийн төвүүдийн эрүүл мэндийн байгууллагуудын барилгыг засварлах, өргөтгөх арга хэмжээ авна.		
			108. Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Дорно-говь аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэжүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа
			109. Халдвартын клиникийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэжүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа
30	1.2.10	Эмнэлгийн түргэн тусламжийн авто-машины парк шинэч-лэлтийг сумдад 40-өөс доошгүй хувьд, аймаг, нийслэлд 60 хувьд хүргэнэ.	110. Нийслэлийн болон аймгуудын төвийн түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлтийн төлөвлөгөө, тесвийг боловсруулж, үе шаттайгаар хэрэжүүлнэ.	2000-2004	П.Нямдаваа Ч.Улаан
			111. Сумын эмнэлгийн түргэн тусламжийн эдэлгээний норм дуусан авто машины парк шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэжүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа Ч.Улаан
31	1.2.11	Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг эмнэлгийн зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангах, эмч, эмнэл-гийн ажилтны мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, хөшүүргийг бий болгох замаар хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж, чанарыг сайжруулна.	112. Сумын эмнэлгийн одоогийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэжүүлэх арга хэмжээ авна.	2000-2002	П.Нямдаваа
			113. Шаардлагатай сумдын эмнэлгийг зориулалтын байраар хангах, байрыг засварлах арга хэмжээг үе шаттай хэрэжүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа
			114. Сумын эмнэлгийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэжүүлнэ.	2001-2004	П.Нямдаваа
			115. Сумын эмнэлгийн эмч, дунд мэргэжилтний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авна.	2000–2004	П.Нямдаваа
			116. Сумын эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах урамшууллын тогтолцоог судлан шийдвэрлэнэ.	2001-2004	П.Нямдаваа Ч.Улаан Ш.Батбаяр
32	1.2.12	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа нөхөн сэргээх эмчилгээнд рашаан сувиллын үйлчилгээг өргөнөөр ашиглах зорилтыг хэрэжүүлнэ.	117. Рашаан сувиллын ашиглалт, хэмжилтийн байдалд судалгаа явуулан дүгнэлт хийж, рашаан сувиллын үйл ажиллагаанд нэгдсэн зохицуулалтаар хангах арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа П.Нямдаваа
			118. Рашаан сувиллын үндэсний хөтөлбөрийн хэрэжилтийн байдалд үнэлгээ өгч, нөхөн сэргээх эмчилгээний аргуудтай хослон хэрэглэх чиглэлээр эл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулна.	2000–2001	
			119. Рашаан сувиллуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Өргөл рашаан сувиллыг тушиглэн Рашаан судлалын төвийг байгуулж үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.	2001-2003	П.Нямдаваа
			120. Айл, өрөх нутаг дахь онцгойн усны орд газрын ариун цэвэр, хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож, ашиглаж байгаа болон цашид ашиглах рашаанын паспортжуулах ажлыг зохион байгуулна.	2000-2002	П.Нямдаваа У.Барсболд
33	1.2.13	Хувийн хэвшлийн	121. Эрүүл мэндийн байгууллагыг хувьчлах	2000-2004	П.Нямдаваа

		эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээг дэмжих, тэдгээрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хүрээг өргөтгөнө.	арга, чиглэлийг тодорхойлж, холбогдох байгууллагад тавьж шийдэрлүүлнэ.		
			122. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжих чиглэл, стратегийг шинэчилж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	П.Нямдаваа
			123. Магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2001	П.Нямдаваа
34	1.2.14	Эрүүл мэндийн байгууллага, эмч нарын магадлан итгэмжлэлийг чанаржуулан хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тус-ламжийн чанарын баталгаагаат сайжруулна.	124. Эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл болон эрүүл мэндийн магадлан итгэмжлэл олгохтой холбогдсон тогтолцоог сайжруулах чиглэлээр Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж шийдвэрлүүлнэ.	2000-2001	П.Нямдаваа
			125. Эрүүл мэндийн байгууллагуудын шатлалд тохирсон бүтэц, үйл ажиллагааны стандарт бий болгоно.	2000-2001	П.Нямдаваа
			126. Төрийн өмчийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжилнэ.	2001 оноос	П.Нямдаваа
			127. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	2002-2004	П.Нямдаваа
			128. Магадлан итгэмжлэл, зөвшөөрлийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэж, давтан сургах арга хэмжээ авна.	2000-2004	П.Нямдаваа
35	1.2.15	Их спортыг төрийн инвээлд байлгана. Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өргөн хөгжүүлнэ.	129. Биеийн тамир, спортын барилга, байгууламж шинээр барих, тохижуулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэсэн санаа санаачлагыг дэмжих, урамшуулах үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2001	П.Нямдаваа Ч.Улаан
			130. Хүүхэд, залуучудын ба үндэсний спортын наадам, бүх ард түмний спартакиадыг улс орон даяар зохион байгуулна.	2001-2004	П.Нямдаваа
			131. Биеийн тамир, спортын арга хэмжээг иввээн тэтгэсэн байгууллагуудыг сурталчлах ажлыг өргөжүүлж, таднийг урамшуулах арга хэрэглүүр бий болгоно.	2001-2002	П.Нямдаваа
			132. Архи, тамхины онцгой татварын сангаас хүн амыг чийрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2001-2002	П.Нямдаваа
			133. Төв, орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, үйл ажиллагаагаа нь эрчимжүүлэх арга хэмжээ авна.	2000-2001	П.Нямдаваа
			134. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2004	П.Нямдаваа

1.3. Монгол Улсын үндэсний соёл, уламжлал дэлхийн соёлын нийтлэг ололт, үнэт зүйлс, дорнын соёлын өвөрмөц онцгой аястай уялдуулан эрчимтэй хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

36	1.3.1	Соёл, урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлж, удирдлагыг сайжруулна.	135. Соёл, урлагийн салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, сум хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон түүх соёлын бодит бүс өөрийг хамгаалах, ном, хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих, соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалт, гааль, татварын тааламжтай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн хуулиудын төслийг боловсруулан батлуулна.	2000-2002	А.Цанжид Ц.Нямдорж Ч.Улаан
			136. Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг зах хэзээлэн харилцаа, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсронгуй болгох арга хэмжээ авна.	2001-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			137. Соёл, урлагийн зарим байгууллагыг удирдлагын гэрээний хувьчлалд хамруулах замаар уран бүтээлийн чанар, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ.	2001-2003	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
			138. Соёл, урлагийн байгууллагын ажилтан, уран бүтээлчдийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлнэ.	2001-2004	А.Цанжид
			139. Монгол Улсын түүхийг баримтжуулан үлдээх, хадгалж хамгаалах, мэдээлэл хуримтлуулах, сурталчлах үүрэг бүхий Баримтат кино, гэрэл зургийн нэгдсэн төв байгуулна.	2001-2002	А.Цанжид
37	1.3.2	Үндэсний уламжлалт соёл, урлагийг сонгодог болон орчин үеийн урлаг-тай хослуулан хөг-жүүлнэ. Эх хэл, бичиг, соёлоо судлах, сурталчлах, эрхэмлэн дээдлэх, хүмүүсийн соёлтой харилцааны нийтлэг хэм хэмжээг төлөвшүүлнэ.	140. Ардын уламжлалт урлагийг дэмжих болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж, хамгаалах Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	2000-2004	А.Цанжид
			141. Урлагийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх зохистой орчин бүрдүүлнэ.	2000-2004	А.Цанжид
			142. Түүх, соёлын үнэт, хосгүй үнэт дурсгалт зүйл хадгалагдаж буй байгууллагуудыг дохионолын сүлжээнд бүрэн хамруулж, улсын хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсийг тогтоож, хамгаалах арга хэмжээ авна.	2000-2002	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
			143. Музей хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.	2001-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			144. Соёлын өв, оюуны өлөлтыг харилцан дэлгэрүүлэх, соёлын үнэт зүйлсийг хамтран бүтээх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөтгөж, дэлхийн соёлын үнэт зүйлс, дэвшилт олонлыг иргэдийн хүртээл болгох арга хэмжээ авна.	2000-2004	А.Цанжид, Л.Эрдэнэчулуун
			145. Эх хэлний тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина	2001-2002	А.Цанжид Ц.Нямдорж
			146. Монгол бичгийн үсэг, дүрэм хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч, цаашдын зорилтыг тодорхойлно.	2002-2003	Л.Эрдэм, Ч.Улаан
			147. Ёс суртахуун, гоо зүй, соёлын	2000-2004	А.Цанжид

			хүмүүжил олгох, соёлтой харилцааны ниитлэг хэм хэмжээг эзэмшүүлэхэд чиглэсэн цуврал арга хэмжээнүүдийг холбогдох байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулна.		аймаг, нийслэлийн Засаг дарга
38	1.3.3	Хархорум болон Монгол дахь Түрэгийн үеийн зэрэг зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах төслийг хэрэгжүүлнэ.	148. Монголчуудын ардын уламжлалт утга соёлын өвөөс сонгон "Дэлхийн утга соёлын шилдэг өвийн жагсаалт"-д, Монголын соёлын болон байгалийн өвөөс сонгож "Дэлхийн өвийн жагсаалт"-д тус тус бүртгүүлэх арга хэмжээ авна. 149. "Дэлхийн өв" төслийг хэрэгжүүлнэ.	2000-2004 2000-2003	А.Цанжид, Л.Эрдэнэчулуун У.Барсболд А.Цанжид
39	1.3.4	Сонгодог болон хүүхэд зориулсан уран, ном хэвлэлийг төрийн нөхцөлд авч, тэдгээрийн уран бүтээлчдийг олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах, мэргэжил дээшлүүлэхэд төрөөс үзүүлэх санхүүгийн тусламжийг нэмэгдүүлнэ.	150. "Сонгодог уралг" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. 151. Номын санг мэдээллийн төв болгох, мэргэжлийн уралгийн байгууллагуудыг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглох чиглэлээр төслүүд боловсруулан гадаадын хөрөнгө оруулалт, тусламжид хамруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна. 152. Хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. 153. Уран бүтээлчдийг олон улсын хэмжээний уралдаан, тэмцээн, үзэсгэлэнд бэлтгэж оролцуулах, мэргэжил дээшлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна.	2001-2003 2001-2004 2001 оноос 2001-2004	А.Цанжид А.Цанжид, А.Цанжид А.Цанжид, Ч.Улаан
40	1.3.5	Сумдын соёлын төвүүд, номын сангийн үйл ажиллагаог сэргээж, хөдөөгийн хүн амын соёл, уралг, мэдээллийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөтгөнө.	154. Сумдын соёлын төвийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, тэдгээрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд оруулах хөрөнгийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр гадаадын зээл тусламжийн тодорхой хэсгийг зарцуулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ. 155. Сумдын номын сангуудын үйлчилгээг сэргээн сайжруулж, номын сангийн сан хөмрөгийг шинэчлэн баяжуулна. 156. Сумдын соёлын төвийн үйл ажиллагааг сэргээн хөгжүүлэх чиглэлээр "Соёлын төв" төслийг боловсруулан хэрэгжүүлнэ.	2001-2004 2000-2004 2002-2004	А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга А.Цанжид, Аймаг нийслэлийн Засаг дарга
41	1.3.6	Хүүхдийн номын ордон байгуулна.	157. Улаанбаатар хотод Хүүхдийн номын ордон байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.	2001-2004	А.Цанжид
42	1.3.7	Уралг, спортын гоц авьяастныг урамшуулах зэрэг, хэлбэрийг өргөжүүлэх арга хэмжээ авна.	158. Уралг, спортын гоц авьяастныг урамшуулах арга, хэлбэрийг өргөжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	А.Цанжид П.Нямдаваа
43	1.3.8	Иргэдийн шүтлэг бишрэлийн чөлөөт байдлыг хангахын зэрэгцээ Монголын ард түмний соёл, мэдлэг, зан суртахууны өв болсон уламжлалт шашныг судлах, шашны урлагийг сэргээх, өвлөх, хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.	159. Уламжлалт шашны урлагийг судлан дотоод, гадаадад сурталчлах арга хэмжээ авна. 160. Уламжлалт шашныг судлах, сурталчлан таниулах, хүн хүмүүжүүлэх өв уламжлалыг сэргээн хөгжүүлэх ажлыг өргөжүүлнэ.	2002-2004 2002-2004	А.Цанжид А.Цанжид Ц.Нямдорж

44	1.3.9	Монголчуудын оюун санааны амьдралд үндэсний эрхэм үламжлалыг дэдлэх, ахмад үеэ хүндлэх, өвөг дээдсийнхээ хүлэг зан сурта-хууныг даган баримтлах үзэл сэт-гэлгээ төлөвшүүлэхэд бүх шатны сургууль, соёл, шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ.	161. Хүүхэд залуучуудыг ахмад үеэ хүндэлдэг, эв нэгдлийг эрхэмлэдэг, төрт ёс, эх орон, үндэсний соёл, дэвшилт уламжлалаа хайрлан дээдэлдэг болгон хүмүүжүүлэх, өвөг дээдсийн хөдөлмөрч уламжлалыг өвлүүлэх, хүлэг зан суртахууныг даган баримтлах үзэл сэтгэлгээ төлөвшүүлэх чиглэлээр бүх шатны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тодотгол оруулна.	2001-2004	А.Цанжид
			162. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг залуу үеийнхний оюун санаанд төлөвшүүлэх соёл гэгээрэл, мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөжүүлнэ.	2000-2004	А.Цанжид
1.4. Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг дээшлүүлэн хөгжлийн хэрьцангуй шинэ давуу тал олж авах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэмтэд, судлаачдын бүтээлийн үнэлэмжийг өсгөх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:					
45	1.4.1	Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үрт хугацааны үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.	163. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан батална.	2001	А.Цанжид
			164. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг нь зохион байгуулна.	2001-2004	А.Цанжид
46	1.4.2	Хөгжлийн үрт хугацааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан өөрийгөө санхүүжүүлдэг шинжлэх ухаан-боловс-рол, үйлдвэрлэлийн бие даасан цогцол-борыг байгуулан ажиллуулна.	165. Цогцолборт хамруулах эрдэм шинжилгээ, сургалт, бизнесийн байгууллагын талаар судалгаа гаргаж, цогцолборын эрх зүйн болон техник-эдийн засгийн үндэслэлийг тодорхойлно.	2001-2004	А.Цанжид
			166. Өөрийгөө санхүүжүүлдэг шинжлэх ухаан-боловсрол-үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулан ажиллуулна.	2002-2004	А.Цанжид
47	1.4.3	Уламжлалт техно-логи, биотехнологи, шинэ материал, мэ-дээллийн технологи, эрчим хүчний шинэ эх үүсвэр зэрэг судалгааны ажлын тэргүүлэх чиглэлээр өгөх улсын захиал-гыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлд нэвт-рүүлэх ажлыг дэмжин урамшуулна.	167. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд улсын захиалгаар гүйцэтгэх судалгаа, туршилтын ажлыг нэмэгдүүлж, шинжлэх ухаан техникийн төслийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид, холбогдох сайд нар
			168. Судалгаа, туршилтын ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, жижиг, дунд үйлдвэр байгуулах асуудлыг салбарын бодлого болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэл, төсөвт тусган хэрэгжүүлнэ.	2001-2004	А.Цанжид, холбогдох сайд нар
			169. Тэргүүлэх чиглэлийн судалгааны ажлыг дэмжих, үйлдвэрлэлд нэвтрүүлэх эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэхэд түлд шинжлэх ухаан техникийн арга хэмжээнд зориулсан улсын төсвийн хөрөнгийн хэмжээг жил тутам нэмэгдүүлнэ.	2001-2004	А.Цанжид, холбогдох сайд нар
			170. Ангийн мах, загас, самар, жимс, мөөг, тослог ба чөрт үргамал зэрэг байгалийн баялгийг уламжлалт арга, дэвшилтэт технологиор боловсруулж, гадаадын жүүлчид, экспортын хэрэгцээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлнэ.	2001-2004	Д.Насанжаргал Ч.Ганзориг

			171. Импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, сав, баглаа, боодлыг сайжруулах, техник технологийг нэвтрүүлж буй аж ахуйн нэгжийг дэмжинэ.	2001-2004	Д.Насанжаргал Ч.Ганзориг
48	1.4.4	Шинжлэх ухаан техникийн тэргүүлэх чиглэлээр гадаад, дотоодод судлаач, эрдэмтэд бэлтгэх хэмжээг нэмэгдүүлнэ.	172. Гадаад, дотоодод бэлтгэх мэргэжлийн чиглэлийг тодорхойлж, тусгай төлөвлөгөө, захиалгын дагуу хэрэгжүүлэх журмыг шинэчилнэ.	2001-2004	А.Цанжид
49	1.4.5	Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бий болгож, эрдэм шинжилгээний номын сангуудын сан хөмрөгийг баяжуулан ашиглалтыг сайжруулна.	173. Эрдэм шинжилгээний байгууллагуудыг мэдээллийн "Эрдэмнэт" сүлжээнд холбоно. 174. Эрдэм шинжилгээний номын сангуудын сан хөмрөгийг судалгаа шинжилгээний бүтээл, ном, сэтгүүл, электрон номоор баяжуулна. 175. Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бий болгоно.	2001-2002 2001-2004 2001-2002	А.Цанжид А.Цанжид А.Цанжид
50	1.4.6	Эрдэм шинжилгээний байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж, материалын хангамжийг нэмэгдүүлнэ.	176. Тоног төхөөрөмж, урвалж, материалын хангамжийн судалгаа, тооцоог хийсний үндсэн дээр төсөл боловсруулж, хандивлагч орон, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаа авах ажлыг өргөжүүлнэ. 177. Улсын төвлөрсөн төсвийн хэмжээг жил бүр өсгөх замаар тоног төхөөрөмж, урвалж, материалын хангамжийг сайжруулна.	2001-2004 2001-2004	А.Цанжид А.Цанжид
51	1.4.7	Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн байгууллагуудын үйл ажилгагаар үядруулан зохистой хослолыг бий болгон оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэн, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	178. Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн байгууллагуудын хооронд харилцан үядсан үйл ажилгаа явуулах зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. 179. Оюуны бүтээлийг үнэлэх, урамшуулах дүрэм, журмыг боловсруулж мөрдөнө.	2002-2004 2001-2004	А.Цанжид А.Цанжид
52	1.4.8	Олон улсын байгууллага, гадаад орнуудтай шинжлэх ухаан, технологийн салбарт идэвхтэй хамтран ажиллаж хамтарсан лаборатори, төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	180. Олон улсын байгууллага, гадаад орнуудтай шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, төлөвлөгөөг шинэчлэх, шинээр байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийж, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ. 181. Гадаад орнуудтай хамтарсан болон байгуулагатай дундын лаборатори, төв байгуулах санал боловсруулж, хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажилгаа явуулна.	2001-2004 2002-2004	А.Цанжид, Л.Эрдэнэчулуун А.Цанжид
1.5. Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг оновчтой болгож, ард иргэдийн амьжиргааны түвшингийн уналтыг зогсоон, нийгмийн доторхи орлогын ялгаат багасгаж, түйлын ядуурлыг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:					
53	1.5.1	Өрхийн амьжиргаа доройтохоос урьдчилан сэргийлэх нийгэм, эдийн засгийн	182. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хянан сайжруулж, гадаадын хандивлагчдын	2001-2004	Ш.Батбаяр

		цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх үндэсэн дэлхэ амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн тоог 1999 оныхоос 2 дахин бууруулна.	тусламжтайгаар хэрэгжүүлнэ.		
			183. Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг ажлын байраар хангах арга хэмжээ авна.	2001-2004	Ш.Батбаяр
			184. Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой иргэдийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд үзүүлэх халамж, үйлчилгээг өргөжүүлэх чиглээр асуудал боловсруулж шийдвэрлүүлнэ.	2001-2002	Ш.Батбаяр Ч.Улаан
54	1.5.2	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг энэ оноос эхлэн эзлэх дараатай нэмэгдүү-лэн 2000 оны эхэн үеийнхээс 3 дахин өндөр түвшинд хүргэнэ.	185. Тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоосон хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	2000 оноос	Ш.Батбаяр Ч.Улаан
			186. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2000 онд 18000, 2001 онд 24750, 2002 онд 36000 төгрөгт хүргэх арга хэмжээ авна.	2000-2002	Ш.Батбаяр Ч.Улаан
55	1.5.3	Төсвийн байгууллагын ажилтны цалинг 2001 оноос эхлэн жил бүр нэмэгдүүлж, одоогийнхоос 2 дахин өсгөнө.	187. Төсвийн байгууллагын ажилтны цалинг 2001 оноос эхлэн үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр Ч.Улаан
			188. Төсвийн байгууллагын ажиллагчдын бүтээл, ажлын чанар, үр дүнг харгалзан цалин хөлс олгох шинэ жүрмыг туршиж нэвтрүүлнэ.	2001 оноос	Ш.Батбаяр Ч.Улаан
			189. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах ажилтны цалин хөлсийг байгууллагынх нь үр дүнтэй холбож олгох журамд шилжинэ.	2001 оноос	Ш.Батбаяр Ч.Улаан
56	1.5.4	Төрийн ажилтны ажиллах, амьдрах нөхцөл, хангамжийг сайжруулж, хувьдаа орон сууц барихад нь түүнээ зориулгоор хөнгөлөлттэй зээлийн сан байгуулна.	190. Зээлийн сангийн дүрэм, холбогдох эрхийн актуудыг боловсруулан мөрдүүлж сангийн эх үүсвэрт зориулан жил бүр улсын төсөвт тодорхой хэмжээний хөрөнгө тусган зарцуулж байна.	2001-2004	Ш.Батбаяр Ч.Улаан Б.Жигжид
			191. Орон сууц хөгжүүлэх сангийн тодорхой хэсгийг төрийн албан хаагчдын орон сууцны хангамжид зориулах дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2004	Б.Жигжид, Ч.Улаан
57	1.5.5	Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, багш, эмч нарт тусгай нэмэгдэл олгодог болно.	192. Алслагдсан болон говьд хамаарагдах нутгийн жагсаалт гаргаж, тэнд ажилладаг төрийн албан хаагчид, багш, эмч нарын судалгааг гаргана.	2000-2001	А.Цанжид, П.Нямдаваа, Ш.Батбаяр
			193. Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, багш, эмч нарт тусгай нэмэгдэл олгох журам боловсруулан мөрдөнө.	2001-2004	А.Цанжид, П.Нямдаваа, Ш.Батбаяр, Ч.Улаан
58	1.5.6	Нийгмийн хамгаалллын үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, чадавхийг нь дээшлүүлнэ.	194. "Нийгмийн хамгаалллын хөгжлийн хөтөлбөр" төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр, Ч.Улаан С.Чулуунбат
			195. Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн байгууллагын чадавхийг дээшлүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр, Ч.Улаан
59	1.5.7	Нийгмийн даатгалын хэрилцаг боловсронгуй болгож, үр хүүхэд, гэр бүл, төрөл садныа даатгалд хамруулах	196. Үр хүүхэд, гэр бүл, төрөл саданғаа нийгмийн даатгалд хамруулах талаар гадаад орнуудын туршлагыг судалж өөрийн орны онцлогт тохирох хувилбарыг сонгон хэрэгжүүлнэ.	2001 оноос	Ш.Батбаяр

		замаар эрсдэлээс хамгаалах боломцоог бий болгоход чиглэ-сэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.			
60	1.5.8	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг ирэх жилээс эхлэн нэмэгдүүлж 2 дахин өсгөнө.	197. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг жил бүр тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлж 2004 онд одоогийнхоос 2 дахин өсгөнө.	2001-2004	Ш.Батбаяр
61	1.5.9	Тэтгэврийн насанд хүрээгүй нөхөн олговор авагч иргэдийн нөхөн олговрыг тэтгэврийн доод хэмжээнд хүргэж нэмэгдүүлнэ.	198. Тэтгэврийн насанд хүрээгүй нөхөн олговор авагч иргэдийн нөхөн олговрын хэмжээг тэтгэврийн доод хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2000-2004	Ш.Батбаяр, Ч.Улаан
62	1.5.10	Тэтгэврийн даатгалын нөрийн данс нээлгэх бүрэн нэвтрүүлнэ.	199. Тэтгэврийн нөрийн данс нээлгэх даатгуулагчдын хамралтыг 100 хувьд хүргэж, нөрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ, хүүг даатгуулагчид мэдээлэх тогтолцоо бүрдүүлнэ.	2000-2004	Ш.Батбаяр
63	1.5.11	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэл хураамжийг хугацааны бүрэн төлөх хариуцлагыг дээшлүүлж, нийгмийн даатгалын сангуудын өөрийгөө санхүүжүүлэх чадварыг дээшлүүлнэ.	200. Шимтгэл төлөөгүй байгууллага, шимтгэл төлөгчдийн хариуцлагыг дээшлүүлж, авлага барагдуулах арга хэмжээ авна. 201. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж , шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	2001-2002 2001-2004	Ш.Батбаяр, Ч.Улаан, Ц.Нямдорж Ш.Батбаяр
64	1.5.12	Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг шинэчлэн мөрдүүлнэ.	202. Одоогийн мөрдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хянан үзэж, шинэчлэх арга хэмжээ авна. 203. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн эхний үе шатны хэрэгжилтийг дүгнэж, дараагийн үе шатны (2001-2005 оны) хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2000 оноос 2001-2004	Ш.Батбаяр Ш.Батбаяр
65	1.5.13	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын үлмээс тахир дутуу болсон иргэдийн тахир дутуугийн тэтгэвэр авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэл болон тэдний асрах, сувилах, эмчлэх зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлөх журмыг шилжинэ.	204. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах замаар тахир дутуу болсон иргэдийн тахир дутуугийн тэтгэвэр авах хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэл болон тэдний асрах, сувилах зардлыг шийдвэрлэнэ. 205. 1999 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө тахир дутуу болсон иргэдийн тэтгэврийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх арга хэмжээ авна.	2001 2001	Ш.Батбаяр Ш.Батбаяр, Ц.Нямдорж
66	1.5.14	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж.	206. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын тусгай хэлбэрт хамруулах буюу заавал даатгалд хамруулах асуудал	2001 оны I хагаст	Ш.Батбаяр

		тэдний нийгмийн хамгаллыг сайжруулна.	боловсруулж шийдвэрлүүлнэ.		
			207. Малчид, иргэдээс нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг барагдуулах арга зам, оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр
67	1.5.15	Залуу гэр бүлийг суудгай болоход нь зориулан урт хугацаатай зээл олгох журам тогтоож хэрэгжүүлнэ.Байгууллагын мэдлийн орон сууцыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлнэ.	208. Залуу гэр бүлд орон сууцны урт хугацаатай зээл олгох журам боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2001 оноос	Ш.Батбаяр, Ч.Улаан, Б.Жигжид
			209. Төмөр замын болон байгууллагуудын орон сууцыг хувьчлах ажлыг үе шаттайгаар эсхийн байгуулж хэрэгжүүлнэ.	2001-2004	Б.Жигжид, Ч.Улаан
68	1.5.16	Ахмад дайчдад үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	210. Ахмад дайчид, алдар цолтонд үзүүлэх туслалцааний хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2001–2003	Ш.Батбаяр, Ч.Улаан
			211. Ахмад дайчдын гэрээр үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.	2001 оноос	Ш.Батбаяр
69	1.5.17	Ядуу болон тахир дутуу иргэд, олон хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ.	212. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны өртөнгийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.	2001 оноос	Ш.Батбаяр, Ч.Улаан
			213. Нийгмийн халамжийн хүүльд өөрчлөлт оруулж, хүүхэд асарсны тэтгэмжийг бүх эхчүүдэд олгоно.	2001 оноос	Ш.Батбаяр, Ч.Улаан
			214. Асрамжийн үйлчилгээний тогтолцоог шинэчлэн, үйлчилгээний чанарыг сайжруулах, хамрах хүрээг оновчтой болгох арга хэмжээ авна.	2002 оноос	Ш.Батбаяр, П.Нямдаваа
			215. Олон хүүхэдтэйн тэтгэмжийн хэмжээг амьжиргааны түвшингийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.	2002-2004	Ш.Батбаяр, Ч.Улаан
70	1.5.18	Иргэдийг ажил эрхлэх боломлогоор хангах үүлдлбор арга хэмжээ авах замаар шинээр ажлын байр бий болгох санаачлагыг дэмжин урамшуулна. Жижиг зээлийн санхүүжил-тийн аргыг өргөн нэвтрүүлнэ.	216. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан үлс, орон нутгийн төсөв, ажилгүйдлийн даатгалын шимтгэл, дотоод, гадаадын байгууллагаас олгох зээл, тусламж, хандивын хөрөнгийг төвлөрүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулна.	2001-2004	Ш.Батбаяр Ч.Улаан О.Чулуунбат
			217. Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөлгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байр бий болгосон иргэд, ажил олгогчдыг дэмжих зэрэг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр
			218. Хөдөлмөр зохицуулалтын албаны тогтолцоог боловсронгуй болгох, боловсон хүчин, санхүүгийн хувьд бэхжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	Ш.Батбаяр
			219. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг батлуулна.	2001	Ш.Батбаяр
			220. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн талаар судалгаа зохион байгуулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авна.	2001-2002	Ш.Батбаяр
			221. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу тахир дутуу иргэдийг ажлын байраар хангах арга	2001-2004	Ш.Батбаяр

			хэмжээ авна.		
			222. Банк бус санхүүгийн байгууллага байгууллах замаар ажлын байр бий болгохоо зориулан жижиг зээл олгох арга хэмжээг бүх талаар дэмжинэ.	2001-2002	Ш.Батбаяр, Ч.Улаан
71	1.5.19	Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээнд оролцох боломжийг бүрдүүлнэ.	223. Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг мэргэжил олгох сургалтанд хамруулах арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ авна. Ажилгүйдлийн даатгалын хуулинд өөрчлөлт оруулна.	2002 оноос	Ш.Батбаяр, Ч.Улаан А.Цанжид
			224. Хөдөлмөрийн багтаамж ихтэй, нийтийг хамарсан ажилд /дэд бүтэц, байгаль экологи зэрэг/ ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулах замаар түр ажлын байраар хангана.	2001-2004	Ш.Батбаяр Ч.Улаан Б.Жигжид У.Барсболд
72	1.5.20	Хараа хяналтгүй хүүхдүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг аль болох гэр бүлд нь төвлөрүүлж, тэдний орон гэртээ хүмүүжих нөхцөлийг нь бүрдүүлэхэд анхаарна.	225. Хүүхдийг хөгжүүлэх ... үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд хараа хяналтаас гарсан хүүхдүүдийг гэрт нь буцаах арга хэмжээг үргэлжлүүлнэ. Хүүхдийг хөгжүүлэх талаар 2010 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулан гаргаж, түүнд зориулан жил бүрийн улсын төсөвт тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж байна.	2001 оноос	Ш.Батбаяр аймаг, нийслэлийн Засаг дарга
			226. Хараа хяналтгүй хүүхдүүдийн асуудлыг бүрэн шийдвэрлэх, цаашид таслан зогсоох талаар цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2000 оноос	Ш.Батбаяр
73	1.5.21	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын чиглэл, үйл ажилла-гааг боловсронгуй болгоно.	227. Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын тухай хууль батлуулах замаар мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилнэ.	2001-2004	А.Цанжид Ш.Батбаяр
			228. Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын XXI зууны үзэл баримтлалд нийцүүлэн мэргэжлийн сургалт-үйлдвэр-лэлийн төвүүдийн үйл ажилла-гааны чиглэл, сургалтын агуулгын стандартыг шинэчилнэ.	2001-2004	А.Цанжид Ш.Батбаяр
			229. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүү-дийг төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, ажил, хөдөлмөр эрхлэлтээр нь үнэлдэг журам тогтоон мөрдүүлнэ.	2002-2004	А.Цанжид, Ш.Батбаяр
74	1.5.22	Орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөг-жүүлэх, тариалан, төмс,хүнсний ногоо, жимс жимсгэнэ,тахиа шувуу, эвгий зэрэг аж ахуй эрхлэхийг дэмжих зээлийн сан байгуулна.	230. Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэх зээлийн санг байгуулж, ажиллуулах журмыг батална мөрдүүлнэ.	2001 оноос	Ч.Улаан, Д.Насан-жаргал, Ч.Ганзориг
			231. Сангийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгах болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээ авна.	2002 оноос	Ч.Ганзориг Ш.Батбаяр Ч.Улаан
			232. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутагт ажлын байр нэмэгдүүлнэ. Жижиг, дунд үйлдвэрийн санг өөрчлөн зохион байгуулж, үйл ажиллагаагаг өргөжүүлнэ.	2000-2004	Ч.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга
			233. ХБНГУ-ын техникийн хамтын	2000-2003	Ч.Ганзориг

			ажиллагааны хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар, удирдлагыг сайжруулах, зах зээлийг өргөжүүлэх зорилт бүхий "Жижиг, дунд үйлдвэрт зөвлөлгөө өгөх алба" теслийг хэрэгжүүлнэ.		
			234. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зах зээлийн мэдээллээр хангах тогтолцоог бүрдүүлж, боловсронгуй болгоно.	2000-2004	Ч.Ганзориг
75	1.5.23	Гадаадад ажиллаж байгаа иргэдийн эрхийг хамгаалах, гадаадад ажиллах хүч гаргах, гадаа-даас ажиллах хүч авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	235. Гадаадад ажиллаж байгаа иргэдийн эрхийг хамгаалах, гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлнэ.	2001 оноос	Ш.Батбаяр
76	1.5.24	Хүн амын шилжих хөдөлгөөний талаар төрөөс бариментлах бодлогыг бүс нутгийн хөгжилтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.	236. Хүн амын шилжих хөдөлгөөнийг нийгэм эдийн засаг, хүн ам зүй, экологийн хүчин зүйлээр судлах ажлыг НҮБ-ын хүн амын сангийн туслажтайгаар хийнэ.	2000-2001	Ш.Батбаяр
			237. Хүн амын шилжих хөдөлгөөн ихтэй бүс нутгуудад шилжих хөдөлгөөнийг сааруулах арга хэмжээг бүсийн болон орон нутгийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлж ажилнэ.	2001 оноос	Ш.Батбаяр, Ч.Улаан, П.Нямдэваа, А.Цанжид

Хоёр. **ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

Макро эдийн засгийн тогтворжилтыг бататгаж экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурлсан бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх үндэсн дээр эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангана. Үүл үүрхэй, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах түвшинг ахиулах, экспортын үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгнө.

2.1. Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах хүрээнд:

77	2.1.1	Эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлж 2004 он гэхэд жилийн 6 хувьд хүргэнэ.	238. Эдийн засгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан уе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
			239. Дотоодын аж үйлдвэрийг сэргээх замаар эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлнэ.	2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
78	2.1.2	Төгрөгийн бодит ханшийг тогтвор-жуулж, инфляцийг эдийн засаг, үйлд-вэрлэл, хөрөнгө оруулалтыг урам-шуулах оновчтой түвшинд байлгана.	240. Монгол Улсын гадаад өрөөлдөх чадвар, макро эдийн засгийн тэнцвэрт байдалд тогтмол дүн шинжилгээ хийж, ханшны огцом хэлбэлзлийг тогтворжуулах арга хэмжээ тухай бүр авна.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			241. Гадаад валютын цэвэр албан нөөцийг импортын барааны 12-оос доошгүй долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд байлгана.	2001 оноос	Ч.Улаан, О.Чулуунбат
			242. Төгрөгийн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр төлбөр тооцоо хийх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			243. Төсөв, мөнгөний зохистой бодлого явуулах замаар инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгана.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
79	2.1.3	Төсвийн алдагдлыг бууруулна.	244. Төсвийн үр ашигтүй зарлагыг бууруулах, орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх замаар төсвийн алдагдлыг дорвитой бууруулна	2000-2004	Ч.Улаан
			245. Төсвийн урсгал тэнцлийг ашигтай байлгах бодлогын арга хэмжээ авна.	2001-2004	Ч.Улаан
80	2.1.4	Ажилгүйдлийг 50-иас доошгүй хувиар бууруулна.	246. Ажил эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийг батлан мөрдүүлнэ.	2001-2004	Ш.Батбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга

			247. Албан ба албан бус ажил эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдлийг бууруулах арга хэмжээ авна.	2001-2004	Ш.Батбаяр
			248. Албан ба албан бус ажил эрхлэлтийн мэдээллийн тогтолцоо бүрдүүлнэ.	2001-2002	Ш.Батбаяр
81	2.1.5	Гадаад худалдаат алдагдалгүй болгох зорилтыг хэрэгжүүлнэ.	249. Эдийн засгийн гадаад орчны өөрчлөлтийн серег нөлөөллийг бууруулах зохицуулалтыг сайжруулна.	2001-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			250. Төлбөрийн тэнцлийн статистик мэдээллийн чанарыг дээшлүүлнэ.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			251. Экспортыг урамшуулах, өсөлтийг хангах цогцолбор бодлого явуулна.	2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
			Гадаад худалдааны эргэлтэд экспортын хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр:		
			252. Ноос, ноолуур, арьс шир, эрдэс баялаг, махан бүтээгдэхүүний экспортыг хөгжүүлэх стратегийн үйл ажиллагааны хэтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2002	Ч.Ганзориг, Д.Насанжаргал
			253. Экспортыг дэмжих хөтөлбөрийг салбар тус бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	Ч.Ганзориг
			254. Экспортын үйл ажиллагаат дэмжих сан байгуулна.	2001-2002	Ч.Ганзориг
			255. Дотоодын үйлдвэрлэл, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн импортын тарифын бодлогыг үе шаттайгаар боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2003	Ч.Ганзориг, Ч.Улаан
			256. Экспортын чиглэлтэй үйлдвэрүүдэд үзүүлэх гадаадын зээл тусламжийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	2000-2004	Ч.Ганзориг
			257. Оюуны багтаамж ихтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2001 оноос	А.Цанжид, Ч.Ганзориг
			258. Экспортын гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах хэлэлцээг үргэлжлүүлэн явуулна.	2000-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
			259. Монгол Улсын гадаад худалдааны үзэл баримтлалыг боловсруулна.	2002	Ч.Ганзориг
			260. ОХУ, Хятадтай худалдаар либералчлах яриа хэлэлцээг үргэлжлүүлэх, түүний дотор барааны тарифын болон тарифын бус хориг хязгаарыг цөөрүүлэх, хөрш болон дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн гадаад таатай орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллана.	2000-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
			261. Хөгжингүй орноос Монголын экспортын бараанд үзүүлж буй худалдааны хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдлэх арга хэмжээ авна.	2000-2004	Ч.Ганзориг
			262. Монголын экспортын шинэ зах зээл нээх, ноолуур, мах зэрэг бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр ажиллана.	2000-2004	Ч.Ганзориг, Д.Насанжаргал
			263. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг сайжруулна.	2001 оноос	Ч.Ганзориг, Д.Насанжаргал
			Үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөнгөвчлөх чиглэлээр:		
			264. Гадаад худалдааны бодлого, үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаат зохицуулсан хууль тогтоомжийн ил тод байдлыг хангана.	2000-2004	Ч.Ганзориг
			265. Гаалийн мэдээлэл, бүрдүүлэлтийн автоматжуулалтын түвшинг дээшлүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад	2001 оноос	Ч.Улаан

			орны дэмжлэгийг авна.		
			266. Олон улсын ачаа тээврийн хөделгөөний мэдээллийг автоматжуулах чиглэлд гадаадын зээл, тусламжийг ашиглана.	2000-2004	Б.Жигжид
			267. Гаалийн баримт бичгийн бүрдүүлэлтийг хялбарчилна.	2000-2004	Ч.Улаан
			268. Үйлдвэрлэл, худалдаа эрхлэхэд терийн зохицуулалтын оролцоог зохистой болгох, хүнд суртал, шат дамжлагыг багасгаж, зөвшөөрлийг цөөрүүлнэ.	2000-2004	Ч.Ганзориг
			269. Гадаад худалдааны статистикийнн аргачлалыг боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэнэ.	2000-2004	Ч.Ганзориг, Ч.Даваасүрэн
			270. Үйлчилгээний арилжааны статистикийг гадаад худалдааны статистикийн бүрэлдэхүүн хэсэг болгох чиглэлээр ажиллана.	2001 оноос	Ч.Ганзориг
			271. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад цахим худалдаат нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулна.	2001 оноос	Ч.Улаан, Ч.Ганзориг
82	2.1.6	Далд эдийн засгийг арилгах эрх зүй, эдийн засгийн цогц арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлнэ.	272. Албан бус салбарын үйл ажиллагаг ил болгох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	2001-2003	Ч.Улаан
			273. Далд эдийн засгийн нөхцөл, байдлын судалгаа явуулж, арилгах арга хэмжээ авна.	2001-2004	Ч.Улаан
83	2.1.7	Статистикийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, албан ёсны статистикийн мэдээллийн төгтолцоог боловсронгуй болгон мэдээллийн ил тод байдлыг хангана.	274. Статистикийн төв, орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийг боловсронгуй болгоно.	2001-2003	Ч.Улаан, Ч.Даваасүрэн
			275. Албан ёсны статистик мэдээллийн үзүүлэлтийн төгтолцоог хянан үзэж, байгаль орчин, байгалийн нөөцийн статистик үзүүлэлтийг төгтооно.	2001-2004	Ч.Улаан, Ч.Даваасүрэн, У.Барсболд
			276. Үндэсний тооцооны нэгжийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан, Ч.Даваасүрэн
			277. Статистикийн мэдээллийн үндэсний сан байгуулах, статистикийн мэдээллийн сулжээг төр, засгийн үндсэн хэрэглэгчидтэй холбох ажлыг үе шаттайгаар хэрэжүүлнэ.	2000-2004	Ч.Улаан, Ч.Даваасүрэн
			278. Олон улсын валютын сангаас боловсруулсан мэдээллийг тараах ерөнхий журмыг нэвтрүүлнэ.	2000-2004	Ч.Улаан, Ч.Даваасүрэн, О.Чулуунбат
			279. Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах арга хэмжээ авна.	2001-2004	Ч. Улаан
		Татварын талаар:			
84	2.1.8	Татварын баазыг өргөтгөн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр боловсронгуй болгож, татвар цуглуулах үйл ажиллагааг эрс сайжруулна. Татварын албыг бэхжүүлэх цогцолбор арга хэмжээ авна.	280. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай, Хот суурин газрын нохойн албан татварын тухай, Зочид буудлын албан татварын тухай, Гадаадад зорчигчдын албан татварын тухай хуулиудыг батлуулан мөрдүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
			281. Импортын бух төрлийн тамхи, дарсанд нөгдүүлэх онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, архинд тусгай тэмдэг /акцизын марк/ олгох арга хэмжээ авна.	2001	Ч.Улаан
			282. Албан татвар төлөгчдийн хамрах хүрээг тэлэх замаар ачааллыг бууруулах арга хэмжээ авна.	2001-2004	Ч.Улаан
			283. Татварын бодлогоор хувийн хэвшлийг дэмжих арга хэрэглүүрийг боловсронгуй болгоно.	2001-2004	Ч.Улаан
			284. Татварын албаны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, түүний материаллаг баазыг боловсон хүчний чадавхийг бэхжүүлнэ.	2000-2004	Ч.Улаан

			285. Хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу хувь хүнээс бараа, материал, түүний эд хөдлөлөн авсан үнийн дүнгээс 3 хувиар тооцож төлбөг татварт бөлэн мөнгөөр түүний эд бэлтгэдэг аж ахуйн нэгж, хөдөлдөө эрхлэгчийг хамруулах арга хэмжээ авна.	2001	Ч.Ганзориг, Ч.Улаан
			286. Гадаадын хөрөнгө оруулалттай нөөс, ноо-луурын анхан шатны боловсруулах үйлдвэ-рүүдийг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварт хамруулах арга хэмжээ авна.	2001-2002	Ч.Ганзориг, Ч.Улаан
			287. Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн татвараас зайлсхийх явдалд таних хяналтыг сайжруулж, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт тавина.	2001-2004	Ч.Ганзориг, Ч.Улаан
85	2.1.9	Татвар ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайж-руулж, татварын ер бусын бараг-дуулах удирдлагыг боловс-ронгуй болгож, эрх зүйн зохицуу-лалтыг чангатгана.	288. Татварын хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлж, энэ ажилд хууль хяналтын байгууллагуудыг оролцуулна.	2000-2004	Ч.Улаан
			289. Орлогоо нуух, татвар төлөхөөс зайлсхийгсэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, татварын ер бусын, татвараа төлөхгүй байх явдлыг таслан зогсооно.	2000-2004	Ч.Улаан
86	2.1.10	Татвар, хураамжийн давахаздлыг цэцэглэн нэг мөр болгож нийтэд ил тод мэдээлэх. Татварын хөнгөлөлт, чөлөө-лөлтийг багасгана.	290. Иргэд, байгууллагаас авах хураамжийг цөөрүүлж тодорхой болгон нийтэд зарлана.	2001-2004	Ч.Улаан
			291. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээг судалж тогтоосно.	2001-2004	Ч.Улаан
87	2.1.11	Бүс нутгуудад, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг урамшуу-лах гааль, тат-варын зарлагдсан үлдэгдэл хэсгийг шилжүүлэх.	292. Бүс нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах гааль, татварын урамшуулалын бодлого хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
			293. Компаниудын орон нутгийн салбар нэгжид ноогдох ашиг орлого, нэмэгдсэн өртгийн татвар, хөрөнгийн татварыг тухайн орон нутгийн төсөвт үлдэхээ аргэ хэмжээг судлан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2002-2004	Ч.Улаан
			294. Алслагдсан аймгуудын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжүүдэд тухайн аймгийн дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал, үсрэнгүй хөгжлөөс зөрөг үйлдвэрлэл эрхлэхэд чухал нөлөөг үзүүлдэг хүчин зүйлүүдийг харгалзан орлогын албан татвараас чөлөөлөх, татварын зарлагдсан хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авна.	2002-2004	Ч.Улаан, Б.Жигжид
			295. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготоор гадаадаас түүхий эд, материал оруулан ирж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн туслан гүйцэтгэгч дотоодын үйлдвэрүүдийг нэмэгдсэн өртгийн татварын холбогдох хэсгээс чөлөөлөх арга хэмжээг судалж шийдвэрлэнэ.	2001	Ч.Улаан, Ч.Ганзориг
			296. Үгаасан нөөс, боловсруулсан арьс, шир экспортолж буй аж ахуйн нэгжийг Хүн амын орлогын албан татварын тухай хуульд заасан орлогын холбогдох татвараас чөлөөлөх арга хэмжээ авна.	2001	Ч.Ганзориг, Ч.Улаан
88	2.1.12	Хөдөө орон нутагт согтуурулах үндаа үйлдвэрлэх, худалдан борлуулахаас бусад чиглэлээр	297. Шинээр хөрөнгө оруулах замаар орон нутагт ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг судалж, хэрэгжүүлнэ.	2002-2003	Ч.Улаан

		ажлын байр бий болгосон хөренгө оруулагчдыг тодорхой хугацаагаар орлогын албан татвараас хөнгөлнө.	298. Хедөө орон нутагт сотгууруулах үндаа үйлдвэрлэх, худалдахаас бусад чиглэлээр ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийн эхний жилд нь аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварас бүрэн, хоёр дахь жилд нь 50 хувь челөөлж, гурав дахь жилээс 100 хувь төлөх эрх зүйн орчин бүрдүүлж мөрдүүлнэ.	2001-2003	Ч.Улаан, Ч.Ганзориг
89	2.1.13	Бага орлоготой иргэдээс авах орлогын албан татварыг бууруулах дээ дараатай арга хэмжээ авна.	299. Цалин, хөдөлмөрийн хөлсний өсөлттэй уялдуулан хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх орлогын доод хэмжээг нэмэгдүүлнэ.	2002-2004	Ч.Улаан
90	2.1.14	Импортын барааны гаалийн татварыг дунджаар 10 хувиар тогтооно.	300. Импортын барааны гаалийн татварыг барааны нэр, төрлээс хамааруулан ялгавартай тогтооно.	2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
			301. Үйлдвэрлэл, экспортыг дэмжих хүрээнд зохих тооцоо, судалгаат үндэслэн дотоодод үйлдвэрлэж байгаа ижил төрлийн зарим барааны импортын гаалийн татварыг нэмэгдүүлнэ.	2001-2002	Ч.Улаан, Ч.Ганзориг
91	2.1.15	Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг үйлдвэрүүдэд тоног төхөөрөмж, түүхий эд, материалыг импортлоход нь татварын хөнгөлөлт үзүүлнэ.	302. Экспортын зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаадад гаргадаг аж ахуйн нэгжийн шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд, материалыг импортын татвараас хөнгөлөх хувь хэмжээг судалж, үе шаттай шийдвэрлэнэ.	2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг
92	2.1.16	Гаалийн татвар ногдуулалт, хөнгөлөлт, челөөлөлтийн бүртгэл, татвар төлөлтийн талаархи мэдээллийг нийтэд ил тод болгоно.	303. Иргэдэд нэн шаардлагатай гаалийн зарим мэдээллийг тусгай төвхимол болгон гаргаж, нийтийн хүртээл болгоно.	2001-2004	Ч.Улаан
			304. Гаалийн татварын хөнгөлөлт, челөөлөлтийн тухай мэдээллийг нийтэд ил тод болгоно.	2001-2004	Ч.Улаан
		Төсвийн талаар:			
93	2.1.17	Төсвийн орлогын эх үүсвэрийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	305. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг судалж, тухай бүр зохицуулах арга хэмжээ авна.	2001-2004	Ч.Улаан
			306. Төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх суурийг өргөтгөх, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
94	2.1.18	Төсвийг дунд болон урт хугацааны макро эдийн засгийн бодлоготой уялдуулан төлөвлөж, төсвийн санхүүжилтийг боловсронгуй болгож, үр дүнгээр нь санхүүжүүлэх тогтолцоонд үе шат-тайгаар шилжинэ.	307. Төсвийн төлөвлөлтийн арга, техникийг боловсронгуй болгож, төсвийн тэнцэл, төсвийн орлого, зарлагыг макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдтэй нягт уялдуулан дунд болон урт хугацаанд төлөвлөнө.	2000-2004	Ч.Улаан
			308. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоог бодлогын хүрээнд шийдвэрлэж, түүнд шилжих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
95	2.1.19	Төсвийн зарлага санхүүжилтийн норм, нормативын	309. Төсвийн зарлага санхүүжилтийн норм, нормативын үндэслэлийг зардлын зүйл бүрээр хянан үзэж, үе шаттайгаар шинэчилнэ.	2001-2004	Ч.Улаан

		үндэслэлийг сайжруулна.	310. Улсын төвлөрсөн төсвөөс орон нутагт олгох татвасыг тогтвортой мөрдөх нормативт үндэслэн тогтоох замаар айман, нийслэл эдийн засгаа бие даан хөгжүүлэх сонирхлыг хөхиүлэн дэмжинэ.	2002-2004	Ч.Улаан
96	2.1.20	Төрийн сангийн багын мөнгөний удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлнэ.	311. Засгийн газрын бүртгэл, мэдээллийн тогтолцоог олон улсын жишигт хүргэх арга хэмжээ авна. 312. Төрийн сангийн багын мөнгөний нөөцийг бүрдүүлэх, оновчтой байршуулах удирдлагыг сайжруулна.	2001-2004 2001-2004	Ч.Улаан Ч.Улаан
97	2.1.21	Алт, зэс, нооллуур, нефть зэрэг стратегийн гол бүтээгдэхүүний үнийн эрсдлээс хамгаалах механизмыг бий болгоно.	313. Алт, зэс, нооллуур зэрэг стратегийн гол бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг үнийн эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан
98	2.1.22	Тусгай зориулалтын сангуудын эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой болгож, тэдгээрийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ил тод байдлыг хангана.	314. Тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагааг ил тод, тодорхой болгож, зохион байгуулалтыг сайжруулна. 315. Жижиг, дунд үйлдвэрийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, эргэн төлөлтийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.	2001-2004 2001-2004	Ч.Улаан Ч.Ганзориг
99	2.1.23	Орон нутаг төсөөе бие даан бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авна.	316. Орон нутгийн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрхийг өргөтгөх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ. 317. Орон нутаг төсөөе бие даан бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	2001-2004 2001	Ө.Энхтүвшин, Ч.Улаан Ч.Улаан
2.2. Банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх хүрээнд:					
100	2.2.1	Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, арилжааны банкуудыг хувьчлах, удирдлагыг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар банкны эрүүл тогтолцоог бүрдүүлнэ.	318. Банкны салбарт гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өрсөлдөөнийг дэмжих хууль эрх зүйн орчин бий болгоно. 319. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг олон улсын нэр хүндтэй, банкны үйл ажиллагааны туршлагатай стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчилна. 320. Банкны хамтын удирдлагын зарчмыг нэвтрүүлж, удирдлага, боловсон хүчний ур чадварыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.	2001-2004 2001-2004 2001-2004	О.Чулуунбат Ч.Улаан, О.Чулуунбат О.Чулуунбат
101	2.2.2	Арилжааны банкуудын олгосон зээлийг эргэж төлүүлэхэд зээлдэгч, зээл олгогчдын хариуцлагыг өндөржүүлэх эрх зүйн зохицуулалтыг чангатгана.	321. Банкны тогтолцоон дахь чанаргүй зээлийг төлүүлэх ажлыг эрчимжүүлнэ. 322. Эдийн засгийн салбаруудын хооронд бий болсон өр авлагын дараалыг шийдвэрлэнэ. 323. Санхүү, төлберийн сахилга батыг чангатгаж, санхүүгийн гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэлбэрэлтгүй биелүүлдэг жүрмыг хэвшүүлэхэд төр, засаг, банк, санхүү, хууль хяналтын байгууллагуудын оролцоо, хариуцлагыг өндөржүүлнэ. 324. Санхүүгийн сахилга батыг хангах чиглэлээр	2000-2004 2000-2004 2000-2004 2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат Ч.Улаан, Б.Жигжид, Ч.Ганзориг Ч.Улаан, О.Чулуунбат Ч.Улаан,

			мөрдөгдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.		О.Чулуунбат
			325. Банкны ер бусын үйлдлийг илрүүлэх, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон журам батлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
102	2.2.3	Хөдөө аж ахуйн банкийг Хөгжлийн банк болгон бэхжүүлж, өрсөлдөх чадварыг нь дэмжиж ажиллуулна.	326. Хөдөө аж ахуйн банкны үйлдвэрлэгч, зохион байгуулагч, худалдаачин, банкны үйлчилгээ, үйл ажиллагаа олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээ авна.	2000-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			327. Хөгжлийн томоохон төслүүдийг урт хугацаанд санхүүжүүлэх чиглэлээр Хөдөө аж ахуйн банкны үйл ажиллагаа өргөтгөнө.	2002-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
103	2.2.4	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа дэмжих, даатгалын компаниудын хөрөнгийн чөлөөт үл-дэгдлийг ашиглах боловсронгуй механизмыг бий болгохтой холбогдсон хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.	328. Хадгаламж болон хөрөнгө оруулалтын хэрэгцээт хангах чадвар бүхий банк бус санхүүгийн байгууллагууд хөгжих эрх зүйн болон хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	2000-2004	О.Чулуунбат
			329. Даатгалын болон бусад сангуудын үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалтын зорилуулалтаар ашиглах эрх зүйн орчин бий болгоно.	2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг, Ш.Батбаяр
			330. Жижиг, дунд үйлдвэрийн сангуудыг банкны бус санхүүгийн байгууллага болгон өөрчлөн зохион байгуулж, удирдлагыг олон улсын төвшинд өөртүүлж, үр ашгийг дээшлүүлнэ.	2001 оноос	Ч.Ганзориг, О.Чулуунбат
104	2.2.5	Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих менгө, хэзлийн уян хатан бодлого явуулна.	331. Хадгаламжийн банкийг арилжааны хэлбэрт аажмаар шилжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан, О.Чулуунбат
			332. Инфляцтай уялдуулан хэзлийн хүүг дэс дараатай бууруулахын зэрэгцээ бодит хэзлийн хүүг эерэг түвшинд байгуулна.	2000-2004	О.Чулуунбат, Ч.Улаан
			333. Банкнаас хэзл авах боломжийг нэмэгдүүлэх, хэзл олгоход тавих хяналт, шаардлага, судалгаа шинжилгээг сайжруулахын зэрэгцээ банкны удирдлага, ажилтнуудын ёс зүй, үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.	2000-2004	О.Чулуунбат, Ч.Улаан
			334. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, түүнд оруулах хөрөнгө оруулалтыг менгө, хэзлийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих уян хатан бодлого явуулж, төсөл, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.	2001-2004	Ч.Улаан, Д.Насанжаргал
105	2.2.6	Үнэт цаасны зах хэзлийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж, хүүгээ нь нэмэгдүүлэн, мэдээлэл, суртапчилгааг өргөжүүлнэ.	335. Үнэт цаасны тухай хуулийг шинэчлэхийн хамт холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.	2000-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал
			336. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг батлуулан хэрэгжүүлнэ.	2000-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал
			337. Тэтгэвэр, даатгал, хувийн хуримтлалыг үнэт цаасны зах хэзлээ рүү татан оруулах арга хэрэгслийг бий болгоно.	2000-2004	Ч.Улаан
			338. Бүх төрлийн үнэт цаас /Засгийн газрын бонд, компаний үнэт цаас, вексель, хувьцаа/ гаргах замаар хувийн салбарын болон төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замыг дэмжинэ.	2000-2004	Ч.Улаан
			339. Үнэт цаасны зах хэзлийг либералчилж, сонгодог үгтаар нь хөгжүүлэх үндсийг тавьж, Хөрөнгийн биржийг хувьчилна.	2001-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал
			340. Үнэт цаасны зах хэзлийн дэд бүтцийг хөгжүүлэх, үнэт цаасны тухай мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг шинэ шатанд гаргана.	2001-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал
106	2.2.7	Үнэт цаасны зах хэзлийн	341. Үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлөх аливаа оролдлогыг гаргахгүй байх, үнэт	2001-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал

		харилцаанд оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, хувь нийлүүлэчид нөгөдөл ашиг хуваарилах, олгох механизмыг боловс-ронгуй болгож, тэдний эрх ашгийг хамгаална.	цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэгч-дийг гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна. 342. Төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцооны газрыг салган зохион байгуулж, үнэт цаасны арилжаатай холбоотой үйл ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулна. 343. Үнэт цаасны арилжааны шимтгэл бодит байдалд нийцэж байгаа эсэхэд судалгаа явуулж, холбогдох арга хэмжээ авна.	2001-2004 2001-2004	Ч.Улаан, С.Гүндэнбал Ч.Улаан, С.Гүндэнбал
107	2.2.8	Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг нь олшруулна. Хадгаламж харилцагчийн даатгалүүлэх арга хэмжээ авч, нийтэд ил тод мэдээлнэ.	344. Мал аж ахуйн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авахын хамт холбогдох хууль эрхийн актыг хянан сайжруулна. 345. Хадгаламж зээмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.	2001-2003 2001-2004	Ч.Улаан, Д.Насанжаргал Ч.Улаан
2.3. Хувьчлалыг үргэлжүүлэн үр ашгийг дээшлүүлэх хүрээнд:					
108	2.3.1	Хувьчлалын гажуудлыг арилгаж, хуулийг чанд сахин хэрэгжүүлэх харилцагчыг өндөржүүлнэ.	346. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өмч хувьчлах арга хэрэгслүүдийг боловсронгуй болгоно. 347. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж, удирдлагын нэгдсэн тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлнэ.	2001-2004 2001-2004	Ч.Улаан Ч.Улаан
109	2.3.2	Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн удирдлагыг сайжруулах, эцэйн үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарна.	348. Компанийн тухай хуульд нийцүүлэн үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах бодлого явуулж, түүнд чиглэсэн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ. 349. Хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газрын удирдлага, даамал, эрхлэгч нарт зориулан үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, санхүү, төлөвлөлтийн талаар сургалт, семинар зохион байгуулна.	2001-2004 2001-2004	Ч.Улаан, Ч.Ганзориг Ч.Улаан, Ч.Ганзориг
110	2.3.3	Аж ахуйн нэгжийг хувьчлахдаа хуулиар зөвшөөрөгдсөн олон арга-гуудаас онцөчтойг нь сонгон ашиглаж, хувьчлалыг эрчимжүүлнэ.	350. Үйлдвэр, аж ахуйн газрыг гэрээгээр ус шаттай хувьчлах, удирдлагыг гэрээгээр хувьчлах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн олон арга-гуудаас онцөчтой хэлбэрийг сонгон хэрэглэж, хувьчлалыг эрчимжүүлнэ. 351. Тухайн салбарын онцлог, эдийн засгийн үр ашгийг харгалзан хувьчлалын аргыг сонгодог журам тогтоож мөрдүүлнэ.	2001-2004 2001-2004	Ч.Улаан Ч.Улаан
111	2.3.4	Эдийн засгийн үр ашиг, үнэдэгний ажлуудыг байдлыг хангах шаардлагад нийцүүлэн үнэ цэнэ бухий томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчилна.	352. Үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчлах төсөл боловсруулахад дотоодын болон гадаадын байгуулагын судалгаа, дэмжлэг, зөвлөгөө авах, хувьчилсны дараа үүсч болох сөрөг үр дагаврыг урьдаас сайтар судлах, холбогдох байгуулагатай зөвшилцөх журмыг тогтоож мөрдүүлнэ. 353. Томоохон аж ахуйн нэгж бүрийн хувьчлалын үзэл баримтлалыг гаргаж, бэлтгэлийг хангасны дараа гадаадын хөрөнгө оруулагчдыг түлхүү оролцуулах замаар хувьчилна.	2001-2004 2001-2004	Ч.Улаан Ч.Улаан, Ч.Ганзориг
112	2.3.5	Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлтийг хийж, төрийн болон төрийн өмчийн оролцоотой түлш, эрчим хүч, үүл үүрхайн салба-рын аж ахуйн нэгжүүдийн төрийн өмчид ногдох хэс-	354. Үүл үүрхайн томоохон үйлдвэрүүдийн бэлтгэлийг ханган, холбогдох арга хэмжээ авсны дараа хувьчлалыг хэрэгжүүлнэ. 355. Эрчим хүчний тухай хууль, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн батлан мөрдүүлэх замаар эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хэрэглээг хамгийн их үр өгөөжтэй хэлбэрээр зохион байгуулах, үйлдвэрлэл,	2001-2004 2001	Ч.Улаан, Ч.Ганзориг Б.Жигжид

		гийг үе шаттайгаар хувьчилна.	хэрэглээний бүх шат дамжлагад гарч буй бодит зардлыг нөхөж, өөрийгөө хөгжүүлэхүйц нөхцөлийг бүрдүүлэх, эрчим хүчний салбарт үндэсний аюулгүй байдал, улс орны хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзсан төрийн зохицуулалтын тогтолцоотой эрх зүйн орчин бүрдүүлнэ.		
			356. Зохих эрх зүйн орчин бүрдүүлсний дараа бүтцийн задаргаа хийж, түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийг арилжааны хэлбэрээр бие даан ажиллуулна.	2001	Б.Жигжид
			357. Түлш, эрчим хүч, уул уурхайн салбарт судалгаа явуулах үндсэн дээр бүтцийн өөрчлөлт хийж, үлмаар тодорхой нэгж хэсгийг хувьчлах арга хэмжээ авна.	2001-2004	Б.Жигжид, Ч.Улаан
113	2.3.6	Нийгмийн салбарын хувьчлалын эрх зүйн үндсийг бүрдүүлж, хувьчилна.	358. Нийгмийн салбарын хувьчлалын хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, хувьчлалыг эхлүүлнэ.	2001-2004	Ч.Улаан, Ш.Батбаяр, А.Цанжид, П.Нямдаваа
114	2.3.7	Өмч хувьчлалаас орох орлогыг хөрөнгө оруулалтад зарцуулах зарчим баримтална.	359. Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах замаар өмч хувьчлалын орлогыг эвэхэн хөрөнгө оруулалтад зарцуулдаг журам тогтооно.	2001-2002	Ч.Улаан
2.4.Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, экспортыг дэмжих бодлогын хүрээнд:					
		Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар:			
115	2.4.1	"Ноолуур" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын ноолууран бүтээгдэхүүний экспортыг өсгөж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	360. Ноолууран бүтээгдэхүүний экспортыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	2004	Ч.Ганзориг
			361. Ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний чанар, технологийн түвшинд үнэлэлт, дүгнэлт гарган аттестатчилах замаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2000-2001	Ч.Ганзориг,
			362. Ноолуур боловсруулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийн шаардлагын стандартыг шинэчлэн батлаж мөрдүүлнэ.	2001	Ч.Ганзориг
			363. Монгол ноолуурыг олон улсын чанар, худалдааны тэмдэгтэй болгох, олон улсын мэдээллийн сүлжээнд бүртгүүлэх ажлыг зохион байгуулна.	2001-2003	Ч.Ганзориг
			364. Ноолууран бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг олшруулах, салбарын шинжлэх ухааны байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл боловсруулж хэрэжүүлнэ.	2001-2004	Ч.Ганзориг, А.Цанжид

(үргэлжлэл бий)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны нэгдүгээр сарын 15 №2 (189)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

8. Дагвын Лувсаншаравт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 173 31
9. Эрээдэрийн Лувсандагвад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай Дугаар 174 32
10. Аюурын Дулмаад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 175 32
11. Наранхүүгийн Сосорт Монгол Улсын Гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 176 32
12. Товуугийн Батсүхэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 177 32
13. Батчулууны Сарантуяад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 178 33
14. Гомбожавын Буян-Өлзийд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 179 33
15. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 180 33

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

16. Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолын хавсралтын үргэлжлэл (Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай) 36

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 173** **Улаанбаатар хот**

Дагвын Лувсаншаравт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллан мэргэжлийн удирдлагаар хангаж зохион байгуулах, үндэсний бүжгэн болон хөгжимт жүжиг, дуурь, ниитийн дуу, магтуу, киноны хөгжмийн томоохон бүтээл олныг туурвиж монголын орчин цагийн хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь үнэлж Улсын ардын дуу, бүжгийн чуулгын зөвлөх удирдагч, хөгжмийн зохиолч Дагвын Лувсаншаравт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 174 Улаанбаатар хот

Эрээдэрийн Лувсандагвад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн эмчилгээ, оношлогооны шинэлэг аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж, олон мянган хүүхдийг эмчлэн эдгээрүүлж, нялхсын эндэгдлийг бууруулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн зөвлөх эмч Эрээдэрийн Лувсандагвад Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 175 Улаанбаатар хот

Аюурын Дулмаад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж монголын нууруудын шим бодис үүсэн бүрэлдэх зүй тогтол, энергийн солилцоог судлах, загасны нөөцийг тогтоож, нутагшуулан өсгөж үржүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж практикт нэвтрүүлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, гидробиологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн гидробиологи-загас судлалын лабораторийн эрхлэгч Аюурын Дулмаад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 176 Улаанбаатар хот

Наранхүүгийн Сосорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургууль олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтад дэвшилтэт аргууд нэвтрүүлэн, сурагчдад гүн бат мэдлэг олгох, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх, залуу багш нарыг дадлагажуулан сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Шавь" цогцолбор сургуулийн бага ангийн багш Наранхүүгийн Сосорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 177 Улаанбаатар хот

Товуугийн Батсүхэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Анагаах ухааны их сургууль, коллежид олон жил багш, хичээлийн эрхлэгч, захирлаар үр бүтээлтэй ажиллаж сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, сургалт хүмүүжлийн ажлыг сайжруулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны коллежийн захирал Товуугийн Батсүхэд Монгол улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Батчулууны Сарантуяад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж монгол ардын урт, богинын болон зохиолын дуунуудыг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, ардын урлагийг өвлөн эзэмших, түгээн сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин Батчулууны Сарантуяад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Гомбожавын Буян-Өлзийд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил удирдах ажил хийж санаачилга, үр бүтээлтэй ажиллан эмнэлгийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, бүтээц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмнэлгийн тусламжийн хүртээмж, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэн хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Солонгосын хамтарсан "Ионсей-Найрамдал" эмнэлгийн ерөнхий захирал Гомбожавын Буян-Өлзийд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, шүүх, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Рэнцэнгийн Лхагвасүрэн - Дархан-Уул аймаг дахь Техникийн коллежийн захирал
2. Цэдэнгийн Нямдорж - Нийслэлийн харшил, арьс өнгөний "Гран При" хувийн эмнэлгийн захирал

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Цэвэлсаны Алгаа - Нийслэлийн Багануур дүүргийн "Галын мандал" ТӨҮГ-ын ерөнхий инженер
2. Давгын Алтангэрэл - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Монгол дээвэр" ХХК-ийн захирал
3. Жанчивын Амгалан - Нийслэлийн хэвлэлийн "Адмон" ХХК-ийн дизайнерч
4. Дангаасүрэнгийн Ариунаа - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин
5. Лувсанцэрэнгийн Базарваань - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын хөөмийчин
6. Сандагсүрэнгийн Батболд - Санхүү, эдийн засгийн яамны Сорьцын улсын хяналтын албаны технологич-инженер

7. Лхагважавын Батжаргал	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол бүжигчин
8. Осорхүүгийн Батменх	- Өвөрхангай аймгийн Засаг дарга
9. Баттөмөрийн Батсүрэн	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол бүжигчин
10. Жамбалын Батхуяг	- Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн зөвлөх эмч, тасгийн эрхлэгч
11. Түмэнжаргалын Баяраа	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин
12. Сэнгээгийн Баярменх	- "Сэрүүлэг" сонины ерөнхий эрхлэгч
13. Батхүүгийн Бунд	- Нийслэлийн худалдаа, зуучлал, үйлдвэрлэлийн "Монгол ньюс" ХХК-ийн бизнес, мэдээллийн албаны дарга
14. Балчингийн Галсанцэрэн	- Нийслэлийн үйлчилгээ, худалдаа, жуулчлалын "Аянчин" ХХК-ийн захирал
15. Дамбын Гантөмөр	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол хөгжимчин
16. Дүгэржавын Готов	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн шадар туслах, ахлах референт
17. Чимэддагвын Гүрбадар	- Увс аймгийн Хянан шалгах хорооны ахлах хянан байцаагч
18. Дуламсүрэнгийн Гэндэнпунцаг	- Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
19. Нямын Даваа	- Засгийн газрын хэрэгжүүлэгч МОНЦАМЭ агентлагийн гадаадад мэдээлэх редакцийн хариуцлагатай редактор
20. Цэрэнбалжирын Даваажав	- Засгийн газрын хэрэгжүүлэгч МОНЦАМЭ агентлагийн гадаад мэдээний редакцийн хариуцлагатай редактор
21. Дорждэрэмийн Дагвадорж	- Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн "Монэнэзим" нэгдлийн ажилчин
22. Усны-Эхийн Далантай	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин
23. Төнгөөгийн Дарьжав	- Орхон аймгийн Хүүхэлдэйн театрын "Эрдэнэт" чуулгын дуучин
24. Отгоны Дарийжав	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бичээч-өлгүүлагч
25. Бат-Өлзийн Догсом	- Техникийн их сургуулийн Инженерийн суурь боловсролын сургуулийн багш
26. Цэнддоржийн Долгорсүрэн	- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Тогос интертрейд" ХХК-ийн ерөнхий захирал
27. Дүйнхэржавын Доржсүрэн	- Хөдөө аж ахуйн их сургуулийн тэнхмийн эрхлэгч
28. Норовын Доржсүрэн	- Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын хангамжийн мэргэжилтэн
29. Замбагын Дэмбэрэл	- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өндөр настан
30. Буяндэлгэрийн Жавзан	- Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн үйлчилгээний ахлагч
31. Ядамын Жавзан	- Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн буфетын худалдагч
32. Жамбын Жаргалсайхан	- Санхүү, эдийн засгийн яамны эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
33. Цэвэгмидийн Зоригтбаатар	- Сүхбаатар аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Талын гал" ХК-ийн экскаваторчин
34. Өлзийбатын Мухлааш	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Авто-18" ХХК-ийн жолооны багш
35. Шагдарын Одонтуяа	- Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол бүжигчин
36. Баасанхүүгийн Очир	- Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн компанийн жолооч
37. Борхүүгийн Оюунцэцэг	- "Монголын үндэсний мэдээ" сонины сурвалжлагч
38. Гэндэнсүрэнгийн Оюунцэцэг	- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
39. Сүхийн Сайрах	- Нийслэлийн "АПУ" ХК-ийн пивоны үйлдвэрийн ахлах технологич
40. Дэчиндоогийн Сандагжав	- Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын Монгол телевизийн ерөнхий нягтлан бодогч
41. Гэндэнгийн Сосорбарам	- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ханбүргэдэй" ХХК-ийн хүнсний дэлгүүрийн эрхлэгч
42. Чойдорын Сүрэнцэцэг	- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ажилчин залуучуудын эзэлжийн сургуулийн монгол хэл- уран зохиолын багш
43. Лхагважавын Сэнгээ	- Нийслэлийн 4 дүгээр дунд сургуулийн захирал
44. Чойдогжамцын Тогоо	- Монголын улаан загалмайн нийгэмлэгийн Хөвсгөл аймгийн хорооны нарийн бичгийн дарга
45. Шархүүгийн Тогооч	- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төлөвэр, зуучлалын "Алтай

транс" ХХК-ийн захирал

46. Гамбаагийн Хашбаатар - Засгийн газрын тохируулагч агентлаг-Худалдаа, үйлдвэрийн улсын хяналтын албаны ахлах түшмэл
47. Гүнсэнгийн Хаянхярваа - Санхүү, эдийн засгийн яамны салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын орлогч дарга
48. Бэгзийн Цогзолмаа - Нийслэлийн 76 дугаар дунд сургуулийн захирал
49. Дэмбэрэлдоржийн Цэгмид - Нийслэлийн тээвэр үйлчилгээний "Авто аян" ХХК-ийн захирал
50. Самдангийн Цэрэндорж - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин
51. Ёндоогийн Цэрэндэжид - Монгол Улсын Дэд шүүхийн ахлах мэргэжилтэн
52. Цэрэндондовын Цэрэнхорлоо - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол хөгжимчин
53. Будын Цэцгээ - Санхүү, эдийн засгийн яамны Сорьцын улсын хяналтын албаны сорьц дарагч-лаборант
54. Очирын Эрдэнээ - Нийслэлийн алт хайгуул, олборлолтын "Монголын алт" ХХК-ийн дэд ерөнхийлөгч

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

Хаянхярваагийн Оюунгэрэл - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын тоо бүртгэлийн тасгийн дарга, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэрэнбатын Бат-Эрдэнэ - Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэргэжилтэн
2. Будрагчаагийн Будболд - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын хөгжимчин
3. Батжаргалын Галсан - Нийслэлийн Багануур дүүргийн "Галын мандал" ТӨҮГ-ын засварчин
4. Догоосүрэнгийн Дулмаа - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын хувцасны эрхлэгч
5. Лувсандоржийн Дэлгэрцэцэг - Үндэсний төв архивын орчин үеийн баримтын төвийн эрхлэгч
6. Банзрагчийн Жадамба - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Улаанбаатар хивс" ХК-ийн гүйцэтгэх захирал
7. Зондуугийн Ланзай - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын хувцасны эрхлэгч
8. Лувсанцэндийн Намжилмаа - Улсын ардын дуу бүжгийн чуулгын хөгжимчин
9. Бадамдоржийн Наранцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
10. Ёндонгийн Пүрэвдорж - Сүхбаатар аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Талын гал" ХК-ийн бульдозерчин
11. Халтарын Пүрэвсүрэн - Нийслэлийн Багануур дүүрэг дэх шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга, хурандаа
12. Хунгаагийн Оюундэлгэр - Санхүү, эдийн засгийн яамны ахлах мэргэжилтэн
13. Сүхбаатарын Оюунсүрэн - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол хөгжимчин
14. Хорлоогийн Оюунсүрэн - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн орос хэлний багш
15. Даваагийн Өөдес - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр дунд сургуулийн хими-биологийн багш
16. Дуламсүрэнгийн Рэнцэндорж - Засгийн газрын хэрэгжүүлэгч МОНЦАМЭ агентлагийн гэрэл зургийн редакцийн хариуцлагатай редактор
190	3.34	Нүүрсний уурхайнуудын техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүү-лэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө орон нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.	581. Багануурын уурхайд нэг бүр нь жилд 2 сая тонн нүүрс боловсруулах чүчин чадал бүхий нүүрс ангилан ачих байгууламж хоёрыг шинээр суурилуулна.	2000-2002	Б.Жигжид
			582. Шивээ-Овоогийн уурхайд жилд 2 сая тонн нүүрс боловсруулах чүч чадалтай нүүрс ангилан ачих байгууламж нэгийг барьж, өндөр чүчин чадалтай алхаарч экскаватор нэгийг шинээр үгсарч, үйлдвэрийн талбайн бусад барилга байгууламжийн хамт ашиглалтад оруулна.	2000-2003	Б.Жигжид
			583. Баянтээг, Тавантолгой, Адуунчулуун, Тэвшийн говь, Талын гал. Хартарваатай зэрэг орон нутгийн нүүрсний уурхайнуудын техник технологийг шинэчилнэ.	2001-2004	Б.Жигжид

			584. Сайн чанарын нүүрсний ордыг шинээр эзэмших, Шарын голын уурхайн орчимд хайгуул хийж нөөцийг өсгөх замаар Дархан, Эрдэнэтийн бүс нутгийн нүүрсний хангамжийг сайжруулна.	2001-2004	Б.Жигжид
			585. Налайхын нүүрсний ордын ашиглагдаагүй хэсэгт бага хүч чадлын нүүрсний уурхай байгуулна.	2001-2004	Б.Жигжид
		Баруун бүсэд:			
191	3.35	Дөргөн, Улаанбоом, Үенчийн Усан цахилгаан станцыг барих, баруун бүсийн эрчим хүчний сүлжээг дотоодын эх үүсвэртэй болгох арга хэмжээ авна.	586. Улаанбоомын Усан цахилгаан станцыг барьж байгуулна.	2001–2004	Б.Жигжид
			587. Үенчийн Усан цахилгаан станцыг барьж байгуулна.	2002-2003	Б.Жигжид
			588. Дөргөний Усан цахилгаан станцыг барьж байгуулна.	2002-2003	Б.Жигжид
192	3.36	Ховд, Өлгийн нисэх буудлыг шинэчлэн тохи-жуулна.	589. Ховд, Өлгийн нисэх буудлын онгоц хөөрч, буух зурвасыг засварлах, нисэх буудлын барилга шинээр барих, засварлах, холбоо навигацийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх арга хэмжээ авна.	2001-2004	Б.Жигжид
193	3.37	Ховд-Улаангом-Ханд-гайт, Өлгий–Цагаан-нуурын авто замыг үргэлжлүүлэн барьж, Арвайхээр-Баянхонгорын авто замыг Говь-Алтай-Ховд-Увс-Баян-Өлгийн авто замтай холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Цэцэрлэг-Тосонцэнгэл-Улиастай, Ховдын Булган-Ярантын авто замыг барьж эхэлнэ.	590. Баруун чиглэлийн гол зам Цэцэрлэг-Тосонцэнгэл, Арвайхээр-Баянхонгор, Говь-Алтай–Ховдын чиглэлд хэсэгчилсэн хайрган хучилттай авто замыг үргэлжлүүлэн тавина.	2001-2004	Б.Жигжид
			591. Ховд–Улаангом-Хандгайт,Өлгий-Цагаан-нуур, Тосонцэнгэл-Улиастай, Ховдын Булган-Ярантын боомтын авто замын зарим хэсгийг барьж эхэлнэ.	2001-2004	Б.Жигжид
194	3.38	Баянхонгор,Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудын төвд сансрын холбооны ВиСАТ станц суурилуулах арга хэмжээ авна.	592. Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгийн төвд сансрын холбооны ВиСАТ сүлжээг суурилуулж АТС, кабель шугамын өргөтгөл хийнэ.	2000-2002	Б.Жигжид
			593. Увс, Завхан аймгийн төвд АТС, кабель шугамын өргөтгөл хийнэ.	2000-2002	Б.Жигжид
195	3.39	Бүсийн радио релейн шугам, Завхан, Увс, Хөвсгөл, Архангай аймгийн төвийг холбосон дамжуулах байгууламжийг тоон технологид шилжүүлнэ.	594. Завхан, Увс, Хөвсгөл, Архангай чиглэлийн дамжуулах байгууламжийг тоон технологид шилжүүлэх	2000-2004	Б.Жигжид

			төслийг хэлэлцэж дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.		
		Хангайн бүсэд:			
196	3.40	Чаргайтын Усан цахилгаан станцыг барьж, Эгий голын Усан цахилгаан станцыг барих хөрөнгийн эх үүсвэрийг идэвхийлэн эрэлхийлнэ. Баянтээгийн нүүрсний ордыг түшиглүүлэн Дулааны цахилгаан станц барьж, Баянхонгор аймгийн төвийг эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбоно.	595. Чаргайтын Усан цахилгаан станцын ТЭЗҮ-ийн судалгаа хийж, олон улсын санхүүгийн байгууллага, хэлэлцэлцүүлнэ. 596. Эгийн голын Усан цахилгаан станцыг барих талаар олон улсын хэмжээнд сурталчилгаа явуулж, хэлэлцүүлнэ. 597. Баянтээгийн дулааны цахилгаан станцыг Олон улсын Санхүүгийн байгууллага, хэлэлцэлцүүлнэ.	2001-2004 2001-2004 2001-2004	Б.Жигжид Б.Жигжид Б.Жигжид
197	3.41	Эрдэнэт-Булган-Мөрөн-гийн чиглэлийн авто замыг барьж эхэлнэ. Хархорин-Цэцэрлэгийн авто замыг ашиглалтад оруулна.	598. Эрдэнэт-Булган-Мөрөнгийн чиглэлийн авто замын зураг төслийг хийж, Хархорин-Цэцэрлэгийн авто замыг ашиглалтад оруулна.	2001-2002	Б.Жигжид
198	3.42	Архангай, Хөвсгөл аймгийн төвд АТС, кабель шугамын өргөтгөл, шинэтгэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.		2000-2002	Б.Жигжид
		Төвийн бүсэд:			
199	3.43	Даланзадгадын Дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулна.		2000	Б.Жигжид
200	3.44	Дархан-Эрдэнэт, Налайх-Маанът-Чойрын хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. Чойр-Сайншанд-Замын-Үүдийн авто замыг барьж эхэлнэ.	599. Дархан-Эрдэнэтийн чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулна. 600. Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Авто зам II төслийн хүрээнд Налайх-Маанът-Чойрын чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж гүйцэтгэнэ. 601. Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлийн авто зам барих хөрөнгийг шийдэрлэн эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, замын зарим хэсгийг эхлүүлнэ.	2001 2000-2003 2003-2004	Б.Жигжид Б.Жигжид Б.Жигжид
201	3.45	Төв, Сэлэнгэ аймгийн сумдыг нэг цэгээс олон цэгт радио холбооны сүлжээгээр холбоожуулах арга хэмжээ авна.		2000-2003	Б.Жигжид
202	3.46	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн төвд сансрын холбооны ВиСАТ станцыг суурилуулах арга хэмжээ авна.	602. Дундговь, Өмнөговь аймгийн төвүүдэд ВиСАТ станц суурилуулж, АТС, кабель шугамын өргөтгөл хийнэ. 603. Говь-Сумбэр, Дорноговь аймгийн төвийн АТС, кабель шугамын өргөтгөл хийнэ.	2000-2002 2000-2002	Б.Жигжид Б.Жигжид

		Зүүн бүсэд:			
203	3.47	Чойбалсангийн Дулааны цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг дуусган бүсийн хэрэг-лэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэ-рээр хангаж, хамрах хүрээг нь өргөтгөнө.	604. Чойбалсангийн Дулааны цахилгаан станцын зуухны өргөтгөлийг хийж, үндсэн ба туслах тоноглолуудыг сэргээн шинэчилж дуусгана.	2002	Б.Жигжид
204	3.48	Эрдэнэ сум–Багануур - Өндөрхаан-Чойбалсан-гийн авто замыг үргэлжлүүлэн барина.	605. Эрдэнэ сум-Багануурын чиглэлийн замыг дууссан, Багануур-Өндөрхаан-Чойбалсан-гийн чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн барина.	2001-2004	Б.Жигжид
205	3.49	Чойбалсан, Баруун-Уртын нисэх буудлыг шинэчлэн тохижуулна.	606. Нисэх буудлын барилгыг Чойбалсанд шинээр барих, Баруун-Уртад засварлах, холбоо навигацийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх ажлыг гадаадын зээл тусламж, өөрийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэнэ.	2001-2004	Б.Жигжид
206	3.50	Хэнтий, Сухбаатар, Дорнод аймгийн төвийг холбосон шилэн кабелийн сүлжээ бай-гуулж, өйрөлцөөхи сум, суурин газрудын хол-бооны тоног төхөө-ремжийг тоон техно-логиор өргөтгөн шинэчилнэ.	607. Засгийн газар хоёрондын зээлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. 608. Хэнтий, Сухбаатар, Дорнод аймгийн төвийн АТС, кабель шугамыг өргөтгөн шинэчилж, өйрөлцөөхи сум, суурин газрудын холбооны тоног төхөөрөмжийг тоон технологиор өргөтгөн шинэчилнэ.	2000-2004 2000-2002	Б.Жигжид Б.Жигжид
		Нийслэлд:			
207	3.51	Улаанбаатар хотын цахилгаан, дулаан, усан хангамжийн сүлжээний техник, технологи нэвтрүүлэх замаар хэрэглэгдийг найдвартай хангана. Улаанбаатар хотын өрөнхий төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлж эхэлнэ.	609. Улаанбаатар хотын цахилгаан, дулаан, усан хангамжийн сулжээнд шинэ техник, технологи нэвтрүүлнэ. 610. Улаанбаатар хотын IY цахилгаан станцын тоног төхөөрөмжийг шинэчлэх, бусад цахилгаан станцуудын нам даралтын зуухнууд /нийт 15/-ыг шинэчилнэ. 611. Улаанбаатар хотын өрөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхэлнэ.	2000-2004 2000-2004 2000-2004	Б.Жигжид нийслэлийн Засаг дарга Б.Жигжид Б.Жигжид нийслэлийн Засаг дарга
208	3.52	Орон сууц барих сан бүрдүүлж иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхийн хамт нийслэл төрийн албан хаагчид, залуучуудад зориулсан 1000 айлын орон сууцны цогцолбор барина.	612. Орон сууцны салбарын санхүүжилт, зээлийн төслийн хүрээнд Орон сууц хөгжүүлэх сангийн бүтэц, зохион байгуулалтыг шийдвэрлэнэ. 613. Орон сууц хөгжүүлэх сан байгуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2001 оны I улирал 2001-2004	Б.Жигжид. Б.Жигжид. нийслэлийн Засаг дарга
209	3.53	Хотын замын сангийн хөрөнгөөр авто зам, гүүрийн шинэчлэлт, засварын ажил хийхээс гадна орон сууцны хорооллын доторхи авто замыг иж бүрнээр засаж сайжруулах ажлыг гүйцэтгэнэ.	614. Улаанбаатар хотын Авто замыг хөгжүүлэх өрөнхий төлөвлөгөөний дагуу нийслэлийн замыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. 615. Хотын замын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн холбогдох дүрэм, журмыг боловсруулна.	2001-2004 2001-2004	Б.Жигжид Б.Жигжид

210	3.54	Улс хоорондын станцыг өргөтгөнө.	616. Улс хоорондын станцыг номер 7 дохиоллоор өргөтгөх ажлыг холбогдох талтай тохиролцон гэрээ байгуулж, уралдаан зарлан дүгнэж хэрэгжүүлнэ.	2000-2001	Б.Жигжид
211	3.55	Гэр хорооллыг нэгдсэн бодлого, бүдүүвчийн дагуу хөгжүүлж, усан хангамж,холбоо,тээвэр, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулна. Газар зээмших эрхийг баталгаажуулан тогт-вор суурьшлыг байх нөхцөлийг хангаж, тус-лах аж ахуй эрхлэх боломж бүрдүүлнэ.	617. Улаанбаатар хотын гэр хороолуудыг үндны усаар хангах, дэд бүтцийг сайжруулах цогц арга хэмжээ авна.	2000-2002	Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга
			618. Гэр хорооллын нөхцөл байдлыг сайжруулах төлөвлөлтийн шинэ арга зүй, хандлагыг хөгжүүлж, Дархан, Зуунмод, Улаанбаатар хотод загвар төсөл боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2000-2004	Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
			619. Бусад хот суурин газрудын гэр хорооллыг шинэчлэн сайжруулах төлөвлөл-түүдийг үе шаттайгаар боловсруулан хэрэгжүүлнэ.	2002-2004	Б.Жигжид, аймгийн Засаг дарга

Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Байгалийн баялгийг түүний даац, чадавхитай нь нийцүүлэн зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экологийн баримжаатай эдийн засгийн хөгжлийг хангах, орон нутгийнхаа байгалийн баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон иргэний эрх, үүргийг тодорхой болгож, байгаль орчныг ард иргэд өөрсдөө хамгаалах механизмыг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

212	4.1	Тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байгаль орчны урт хугацааны бодлого, хөтөлбөрийг бус нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	620. Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг тодотгон шинэчилж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2001-2004	У.Барсболд
			621. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндэсэн чиглэл, төлөвлөгөөнд байгаль орчны хөтөлбөрүүдийн зорилтыг хангах арга хэмжээ тусган хэрэгжүүлнэ.	2001-2004	У.Барсболд Ч.Улаан
			622. Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2001-2004	Д.Насанжаргал, У.Барсболд, Б.Жигжид
			623. Экологийн тогтвортой байдлыг хангах зарчмыг бүсчилсэн хөгжлийн эрх зүйн баримтлалд тусган баталгаажуулна.	2001-2003	Ч.Улаан, У.Барсболд
			624. Химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулсны үндэсэн дээр химийн хортой, аюултай бодисын үндэсний бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.	2001-2002	У.Барсболд
			625. Байгалийн гамшгаас сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын зүгээс түүнд тавих хяналтыг хүчтэй болгох арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			626. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдэд нөхөн үнэлгээ хийлгэх, орон нутаг дахь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авна.	2000-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			627. Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн оролцоог өргөтгөнө.	2000-2004	У.Барсболд
213	4.2	Байгаль орчны бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам, нутгийн захиргаад, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааны нэгдмэл байдыг хангах чиглэлээр эрх зүйн	628. Байгаль орчны хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар байгаль орчны болон бусад нийгэм-эдийн засгийн харилцаат зохицуулах эрх зүйн уялдаа холбоог сайжруулна.	2001-2004	У.Барсболд, Ц.Нямдорж
			629. Бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах шинжлэх ухаан, эрх	2001-2004	А.Цанжид, У.Барсболд

		зохицуулалтыг боловсронгуй болгоно.	зүйн мэдлэг олгох ажлыг бүх шатны сургуулиудад зохион байгуулна.		
			630. Байгаль орчныг хамгаалах, иргэдийн санаачилга үйл ажиллагааг дэмжин зохицуулах аймаг, нийслэлийн олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагаат тогтмолжуулна.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			631. Төв, орон нутаг дахь байгаль орчны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авна.	2000-2001	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
214	4.3	Байгаль орчинд халгүй дэвшилтэд техно-логи нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хөхиүлэн дэмжинэ.	632. Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгж, иргэнийг шагнаруулан урамшуулж, суртачлахаа арга хэмжээ авна.	2000-2004	У.Барсболд, Ч.Ганзориг
			633. Бүтээгдэхүүнд "Экологийн цэвэр бүтээгдэхүүн" тэмдэг олгох журам тогтоож мөрдүүлнэ.	2000-2002	У.Барсболд, Ч.Ганзориг
			634. Үйлдвэрлэлийн хэрэгцээний усыг хэмнэлттэй зарцуулах технологи нэвтрүүлэх, тоолууржуулах замаар усны үргүй алдагдлыг багасгана.	2002-2004	Б.Жигжид, У.Барсболд
215	4.4	Байгаль орчин, түүний гол нөөц, баялгийн экологи-эдийн засгийн болон хэмдэлийн өртөөний үнэлгээ, үзүүлэлтийг тогтоож, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн стандартыг батлан мөрдүүлнэ.	635. Байгалийн зарим нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно.	2001-2004	У.Барсболд
			636. Агаар, ус, хөрсний стандартуудыг хянан, шинэчлэх, хог, хаягдлын стандартуудыг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд
			637. Байгаль орчны өртөөний үнэлгээний арга зүйг сайжруулж, байгаль орчны хэмдэлдэлыг тооцсон эдийн засгийн үзүүлэлтүүдийг Үндэсний тооцоонд нэвтрүүлнэ.	2002-2004	У.Барсболд, Ч.Улаан, Ч.Даваасүрэн
216	4.5	Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөр болон байгаль орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийг шинэчлэн тогтоож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сан-хүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгоно.	638. Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн хэмжээг хянан үзэж, шинэчлэн тогтооно.	2001-2004	У.Барсболд, Ч.Улаан, Ч.Ганзориг
			639. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлэх байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулж, хэрэжилтэд хяналт тавина.	2001-2004	У.Барсболд, Ч.Улаан, Ш.Батбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга
			640. Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг батлуулан мөрдүүлнэ.	2001-2002	У.Барсболд, Ц.Нямдорж
217	4.6	Ойн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлнэ. Ойн тухай үндэсний хөтөлбөрүүдийн эхний үе шатны зорилтыг хэрэжүүлэх ажлыг зохион байгуулна.	641. Тарьц, суулгацын тогтвортой нөөцийг бий болгох замаар жилд 10-аас доошгүй мянган га-д ой нөхөн сэргээх ажил гүйцэтгэнэ.	2000-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			642. Ойн аж ахуй, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл, ой судлалын шинжлэх ухааны байгууллагуудын зохистой бүтцийг бүрдүүлнэ.	2001-2003	Ч.Ганзориг, У.Барсболд, А.Цанжид
			643. Тарьц, суулгац үргүулах ажлын техник, гар багаж дотоодод үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжинэ.	2001-2004	Ч.Ганзориг, У.Барсболд
			644. Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, шуурхай мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, материаллаг баазыг, хангамжийг сайжруулна.	2004	У.Барсболд, Ц.Нямдорж
			645. Дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны олоотыг нэвтрүүлэх замаар ой зохион байгуулалтын ажлыг жил бүр 800 мянган га—гаас доошгүй талбайд явуулна.	2001-2004	У.Барсболд
			646. Ой, ургамлын мужуудад селекцийн үнэлгээ	2001-2004	У.Барсболд А.Цанжид

			хийж, үр бэлтгэх ажлыг шинжлэх ухааны үндэстэйгээр зохион байгуулна.		
			647. Ойн үндэсний хөтөлбөр болон ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, түүнийг чиглэлээр байгуулагдсан хот, тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний тухай хөтөлбөрийг дэс дараатай хэрэжүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	Ш.Батбаяр, У.Барсболд, Ч.Ганзориг, Ч.Улаан
			648. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийг аттестатчилж, техник, технологийн түвшинг тодорхойлж, үнэлгээ өгнө.	2001-2002	Ч.Ганзориг
			649. Модны боловсруулалтын түвшингийн зааг, ялгаа нарийвчлан тодорхойлох үндэсэн дээр бараат тодорхойлох, кодлох журамд зөв оноосон нэрийн код өгөх өөрчлөлт оруулна.	2000-2001	Ч.Ганзориг
			650. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн техник, технологийг боловсронгуй болгох чиглэлээр төсөл хэрэжүүлэх, зээл тусламжид хамаарулах, хамтарсан судалгаа шинжилгээ, суралцалт зохион байгуулахад гадаад орнуудтай хамтын ажиллагаагаг өргөжүүлнэ.	2000-2004	Ч.Ганзориг А.Цанжид
			651. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн шинжлэх ухааны байгуулагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна.	2000-2002	Ч.Ганзориг, А.Цанжид
218	4.7	Ашигт малтмалын ор-дыг байгальд халтүй технологиор ашиглах эрх зүй, хяналт, урамшуулын тогтол-цоог бий болгоно.	652. Газрын хэвлийн ашиглалтын явцад байгаль орчны доройтлыг аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн сэргээлгэх эрхзүй, эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлнэ.	2001-2004	У.Барсболд, Ч.Ганзориг, Б.Жигжид
			653. Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна.	2001-2003	У.Барсболд, Ч.Ганзориг, Б.Жигжид
			654. Газрын хэвлийн баялгийн ашигт малхбодийн хэмдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн техник, технологийн сонголтыг үндэслэн лицэнз олгох журамд шилжинэ.	2001-2004	У.Барсболд, Ч.Ганзориг
			655. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицэнз эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсронгуй болгож, хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд, Ч.Ганзориг
219	4.8	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн, хамгаалалтын удирд-лагыг сайжруулна. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бусийн иргэдийн амьдрал, ахуйн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэм-жээг хэрэжүүлнэ.	656. Монгол орны байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой нөлөө бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулна.	2000-2004	У.Барсболд
			657. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бусийг тогтвортой хөгжлийн загвар нутаг болгон хөгжүүлэхэд орчны бусийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн ниймийн асуудлыг шийдвэрлэхэд бодитой дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			658. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэхэд анхаарч, мэргэжлийн удирдлагаар ханган, хамгаалалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	2000-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			659. Дэлхийн байгаль соёлын өв, Дэлхийн шим мандлын нөөц газар болон Олон улсын ач холбогдол бүхийус намгархаг газрын жагсаалтад зарим тусгай хамгаалалттай газар нутгийг хамруулах санал үндэслэлийг боловсруулна.	2000-2004	У.Барсболд
			660. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргадыг бэхжүүлж, байгаль хамгаалагчдыг дүрэмт хувцас, техник хэрэгслээр	2001-2003	У.Барсболд

			хангах арга хэмжээ авна.		
220	4.9	Ховор, нэн ховор амьтан, ургамлыг өсгөн үржүүлэх арга хэмжээ авна.	661. Монгол Улсын улаан номд орсон амьтан, ургамлыг хамгаалах дүнд хуулцааны хэтэлбэр боловсруулан хэрэжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, ховор амьтдын жагсаалтыг шинэчлэн тогтоохо.	2002	У.Барсболд
			662. Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэжүүлэх ажлын хүрээнд нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, сэргээн нутагшуулах арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд
			663. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай, Олон улсын ач холбогдол бүхийус, намгархаг газар, ялангуяа усны шувуud олиогр амьдардаг орчны тухай, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүудийг хамгаалах тухай, Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай конвенциудыг хэрэжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд
221	4.10	Байгаль орчны хязгалт-тын тогтолцоог бо-ловсронгуй болгож, ажлын үр дүнг сайжруулна. Ус, цаг уур, орчны болон бохирдол, цац-рагийн хязгалт-шин-жилгээний тогтолцоо, техник, технологийг шинэчилнэ.	664. Байгаль орчны хязгалтын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхэд чиглэдсэн цэгцтэй арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2001-2004	У.Барсболд
			665. Байгаль орчныг хамгаалах уламжлалт ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг эрчимжүүлж, Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны студи байгуулж ажиллуулна.	2001-2003	У.Барсболд
			666. Байгаль орчны хязгалтын сүлжээг бэхжүүлэх замаар улсын хэмжээнд гарч байгаа нийт зөрчлийн тоог бууруулах арга хэмжээ авна.	2000-2004	У.Барсболд
			667. Ус, цаг уурын мэдээ боловсруулах, дамжуулах, цаг агаарын урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээ гаргах техник, технологийг боловсронгуй болгож, нийтэд зориулсан мэдээний чанарыг дээшлүүлнэ.	2001-2003	У.Барсболд
			668. Улаанбаатар хот, бусад суурин газрын агаарын бохирдлыг хянах харуулын сүлжээг өргөтгөж, орчны хязгалтын 5 харуул нэмж байгуулна.	2000-2004	У.Барсболд
			669. Озон задалдаг бодисын зэлжит тооллого явуулж, түүний импорт, хэрэглээ, мэдээллийн сүлжээнд хязгалт тавих тогтолцоо бүрдүүлэх, зарим бодисын хэрэглээг хязгаарлах, хориглох арга хэмжээ авна.	2000-2004	У.Барсболд, Ч.Ганзориг
			670. Ус, цаг уур, агаар судлалын станцад технологийн шинэчлэл хийнэ.	2001-2004	У.Барсболд
			671. Орчны цацрагийн хязгалтын сүлжээг автомат болон нарийвчлал сайтай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, хэмжлийн чанарыг сайжруулна.	2001-2004	А.Цанжид, У.Барсболд
			672. Гадаргын болон гүний усны хязгалт шинжилгээний сүлжээг өргөтгөнө.	2002-2004	У.Барсболд
222	4.11	Байгаль орчны мэ-дээллийн сангийн болон статистик мэдээллийн тогтол-цоог олон улсын жишигт хүргэнэ.	673. Байгаль орчны мэдээллийн санг баяжуулж, мэдээллийн сүлжээг бэхжүүлэх арга хэмжээ авна.	2002	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			674. Өөрийн орны онцлогт тохирсон байгаль орчны статистик мэдээллийн тогтолцоог бий болгож, тэдгээрийн үзүүлэлтийг олон улсын арга зүйн дагуу боловсронгуй болгоно.	2001-2004	У.Барсболд Ч.Даваасүрэн
223	4.12	Иргэдийн газар эзэм-ших, ашиглах эрхийг өргөтгөж, хэрэгжих нөхцөлийг бата-гажүүлснаар эзэм-шигчид газрын	675. Иргэний хууль, Газрын тухай, Банкны тухай, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар газрыг аж ахуйн эргэлтэд оруулах эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх	2001-2004	У.Барсболд, Ц.Нямдорж

		үржил шимийг удаан хугацаанд тогтвортой хуртэх эрх зүйн үндсийг бэлтэрсэнгүй болгоно.	хэмжээг өргөжүүлэн хэрэгжилтийг хангана.		
			676. Нийслэлийн ба төвийн бүсийн аймгийн иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газрын кадастрыг хийнэ.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			677. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаат хот тосгон, бусад суурин, бэлчээр болон улсын тусгай хэрэглээний зарим газарт тодорхой үе шаттайгаар хийж дуусгана.	2000-2004	У.Барсболд
			678. Иргэдийн хувийн гэр, орон сууц, хашааны газар болон хадлан, тариалангийн газар эзэмшиж, ашиглагдын газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах арга хэмжээ авна.	2000-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
224	4.13	Газрыг аж ахуйн эргэлтэд оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах чиглэлээр иргэд, байгууллагуу-дад удаан хугацаа-гаар баталгаатай эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	679. Газар ашиглалт, эзэмшилтийн байдлаас шалтгаалан газрын төлбөрийг ялгаваргүй тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	2001	У.Барсболд, Ч.Улаан, аймаг, Нийслэлийн Засаг дарга
			680. Газрыг аж ахуйн эргэлтэд оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах чиглэлээр олон жил ашиглаагүй газрыг дахин хувааршлах арга хэмжээ авна.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
225	4.14	Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, тэдгээрийн тогтвортой үйл ажиллагаа хангахаар газрыг урт хугацаагаар түрээслүүлэх хөшүүргийг боловсронгуй болгож хэрэжүүлнэ.	681. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг тодорхой болзоотойгоор удаан хугацаагаар гэрээгээр түрээслүүлэн ашиглуулах нөхцөл боломжийг судалж, эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	2001-2002	Ц.Нямдорж, У.Барсболд, Ч.Ганзориг
			682. Гадаадын аж ахуйн нэгжид ашиглуулах газрын судалгааг гаргаж, урт хугацаагаар түрээслэх хөшүүргийн журам тогтоож мөрдүүлнэ.	2001-2004	У.Барсболд, Ч.Улаан, Ч.Ганзориг
226	4.15	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цөлжилтийн явцын судалгааг олон улсын байгуул-лага, төслийн хүрээнд гүнзгий-рүүлэн судалж, цөл-жилт, хөрсний эвд-рэлтэй газрыг тогтоно.	683. Монгол орны цөлжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, түүнтэй тэмцэх арга замыг боловсруулах чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг өргөтгөнө.	2001-2004	У.Барсболд
			684. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд говийн бүсийн зарим аймгийн нутагт "Цөлжилтөөс сэргийлэх нэгдсэн удирдлага" төслийн эхний үе шатыг хэрэжүүлнэ.	2001-2004	У.Барсболд
			685. Ган, цөлжилтийн нөлөөг бууруулах, түүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх Азийн бүсийн сүлжээнд нэгдэн орно.	2003	У.Барсболд, Л.Эрдэнэчулуун
227	4.16	Газрын хөрсийг эвдрэлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үргац нэмэгдүүлэх, хүн хүч хүрэх боломжгүй газар гарсан ой, хээрийн түймрийг үнтраах зорилгоор тунадас нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөнгөөс хамгаалах арга хэмжээ авна.	686. Хөрсний элэгдэл, эвдрэлийн зэрэглэлийг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр тогтоож, хамгаалалт болон нөхөн сэргээлтийн арга хэмжээг тодорхой үе шаттайгаар төлөвлөж хэрэжүүлнэ.	2001-2004	У.Барсболд
			687. Тэг болон цомхотгосон эдлэншүүлэлтийн технологийг мөрдөж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.	2001-2004	Д.Насанжаргал
			688. Цаг агаарт зориулагж нөлөөлж тунадас нэмэгдүүлэх бодис, төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.	2001-2004	У.Барсболд
			689. Ой, хээрийн түймрийг үнтраах, хөрсний чийг хангамжийг нэмэгдүүлэх, үргамлыг мөнгөөс хамгаалах ажилд цаг агаарт зориулагж нөлөөлөх зэрэг онооч-той арга технологийг нэвтрүүлж, үр өгөөжийг дээшлүүлнэ.	2001-2004	У.Барсболд
228	4.17	Байгаль орчинд хал-гүй ерга, техно-логиор бэлчээр, ойн хортон хөнөөлт шавьж мэрэгчидтэй тэмцэх бэлчээрийн	690. Үлийн цагаан оготной нэрэхэздэн бэлчээр, хадлан, тариалангийн талбайд байгаль орчинд халгүй технологиор тэмцэх ажлыг жил бүр 380-490 мянган га-д гүйцэтгэнэ.	2001-2004	Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга

		хорт ургамлын тархалтыг багасгах ажлыг зрчимжүүлж, үлийн цагаан огоотнотой тэмцэх талбайг 2000 оныхоос 1,5 дахин нэмэгдүүлнэ.	691. Ойн хөнөөлт шавьжийн тархалтын судалгаат зрчимжүүлэн шавьжтай тэмцэх ажлын цар хүрээг нэмэгдүүлж, үр нөлөөг сайжруулна.	2001-2004	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
			692. Даац хэтэрсэн, талхлагдсан нутаг бэлчээрийг амраах, өнжөөх зэрэг бэлчээр сэлгээлтийг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан хэрэгжүүлнэ.	2001-2004	У.Барсболд, Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга
229	4.18	Улаанбаатар хотын хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах, байгаль орчинд халгүйгээр боловсруулах үйлдвэр байгуулж ашиглалтад оруулах асуудлыг цогцолбороор шийдвэрлэнэ. Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон суурин газрын хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлын эхний ээлжийн багтаглэлийг хангана.	693. Улаанбаатар хотод хог, хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулж, хог, хаягдлыг дарж устгах зорилалтын байгууламжийг бий болгоно.	2002-2004	У.Барсболд, нийслэлийн Засаг дарга
			694. Эрдэнэт, Дархан, Чойбалсан хотод хог, хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй байдлаар зайлуулах, дарж устгах арга хэмжээ авна.	2002-2004	Б.Жигжид, У.Барсболд, Аймгуудын Засаг дарга
			695. Эрдэнэтийн үйлдвэрийн хаягдлаас гарч буй цагаан тоосыг дарах арга хэмжээг судлан шийдвэрлэнэ.	2001-2004	У.Барсболд, Орхон аймгийн Засаг дарга
			696. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялгаж, зориулалтын хогийн цэгт хаядаг технологи, журмыг нэвтрүүлнэ.	2001-2002	У.Барсболд, Б.Жигжид, Ц.Нямдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга
			697. Хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эдийн засгийн урамшууллын хөшүүргийг бүрдүүлнэ.	2002	Ч.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга
230	4.19	Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах зориллогор айл өрхийг бүрэн шаталт-тай, түлш бага хэрэглэдэг эуухаар дэс дараатай хангах ажлыг зохион байгуулна.	698. Бүрэн шаталттай гэрийн эуух үйлдвэрлэгчдэд болон хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах замаар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.	2002-2004	У.Барсболд, Ч.Ганзориг, нийслэлийн Засаг дарга
			699. Шинэ ба шинэчлэн сайжруулсан эуухны давуу тал, үр дүн, ашиглах арга ажиллагааны талаар суртачилгааны хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2000-2003	У.Барсболд, нийслэлийн Засаг дарга
			700. Гэр хороололын ядуу айл өрх, өндөр настанд зээл болон бүцалтгүй тусламжаар эуух олгох, ердийн эууханд нэмэлт тоноглол тавьж сайжруулах үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.	2000-2004	У.Барсболд, Ч.Улаан, П.Нямдаваа, Нийслэлийн Засаг дарга
			701. Бүрэн шаталттай Г-2 эуухыг жил бүр 5000 ширхэгээс доошгүйг үйлдвэрлэж Улаанбаатар хотын хэрэглэгчдэд нийлүүлнэ.	2000-2004	Ч.Ганзориг, У.Барсболд
231	4.20	Байгаль орчны хоёр талын болон олон талын хамтын ажиллагаанд өргөжүүлнэ. Экологийн тулгамдсан асуудлыг шийдвэр-лэхэд гадаад орон, олон улсын байгуул-лагын тусламж дэмж-лэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	702. Гадаадын улс орнуудтай байгаль орчны салбарт хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн көгжүүлнэ.	2001-2004	У.Барсболд, Л.Эрдэнэчулуун
			703. Зарим аюултай химийн бодис, пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж эввшилцөх журмын тухай, Задралд удаан ордог химийн зарим органик бодисын тухай конвенц болон Биологийн төрөл зуйлийн тухай конвенцийн биологийн аюулгүй байдлыг хангах тухай Картагенагийн протоколд нэгдэн орно.	2003-2004	У.Барсболд, Л.Эрдэнэчулуун
			704. Зуун хойд Азид байгаль орчны хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй уйл ажиллагаа явуулна.	2001-2004	У.Барсболд, Л.Эрдэнэчулуун
			705. Гадаад улс орнуудтай байгуулсан хэлэлцээрүүдийг хэрэжүүлэх, түүнчлэн хөрш орнуудтай хамтран хил дамжсан тусгай хамгаалалттай газруудыг шинээр байгуулах арга хэмжээ авна.	2004	У.Барсболд, Л.Эрдэнэчулуун

Тав. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

51. Монгол Улсын батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо, цэргийн шинэчлэлийн бодлогыг төрийн цэргийн бодлогын үндсийн дагуу туушгах хэрэгжүүлж, энэ салбарт суулийн жилүүдэд гарсан гажуудал, бэрхшээлийг арилгах арга хэмжээ авна. Энэ зорилтын хүрээнд:

232	5.1.1	Батлан хамгаалах тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаанд иргэний хяналт тавих арга, хэлбэрийг тусган мөрдүүлнэ.	706. Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албан хаагчид гадаад оронд энхийг сахиулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэх тухай, Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай хуулийн төслүүдийг боловсруулж өргөн барина.	2001	Ж.Гуррагчаа, Ц.Нямдорж
			707. Агаарын орон зайн тухай, Аврагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудын төслийг боловсруулж өргөн барина.	2001-2002	Ж.Гуррагчаа, Ц.Нямдорж
			708. Зэвсэгт хүчинд ажиллаж буй энгийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж өргөн барина.	2003	Ж.Гуррагчаа, Ц.Нямдорж
			709. Батлан хамгаалах салбарт ажиллаж буй захиргааны хяналтын нэгжүүдийг нэгтгэх замаар хяналтын нэгдсэн алба байгуулна.	2000	Ж.Гуррагчаа
			710. "Батлан хамгаалах салбарын хяналтын тогтолцоо" төсөл, Дотоодын хяналтын журам боловсруулж мөрдөнө.	2000-2001	Ж.Гуррагчаа
			711. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэний хяналтад ил тод байлгах зорилгоор хэвлэл, олон нийттэй харьцах үүрэг бүхий бүтцийг Батлан хамгаалах маманд бий болгоно.	2000	Ж.Гуррагчаа
233	5.1.2	Зэвсэгт хүчин,хилийн цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэлийг тогтоож эхний шатыг хэрэгжүүлнэ.	712. Цэрэг-техникийн оновчтой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга зам, аргачлалыг тодорхойлно.	2000-2001	Ж.Гуррагчаа
			713. Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг, холбоо, тагнуулын зэвсэглэл, техник хэрэглэлийг тэргүүн эгэлээнд бүсэд техникийг дараагийн эгэлээнд үе шаттайгаар хэсэгчлэн шинэчлэн сайжруулах ойрын болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
			714. Зэвсэглэл, техникийг сэргээн сайжруу-лах, техникийн үйлчилгээг явуулах санхүү, материалын боломж бүрдүүлж хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
			715. Тухайн үйлдвэрлэгч орон нь үйлдвэрлэхээ больсон, салбагийн новшуй, маяаг нөхцөлд тохиромж муутай зарим зэвсэг, техникийг хүдалдаж борлуулах арга хэмжээ авна.	2000-2004	Ж.Гуррагчаа
			716. Зэвсэглэл, техникийн засвар-үйлдвэрлэл-тушиитын бааз бий болгох, дотоод нөөц боломжоо сондгоо тулгуурлан зарим жижиг эд анги сэнбэгийг үйлдвэрлэх, техник, технологийн боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	2000-2003	Ж.Гуррагчаа
			717. Зарим төрлийн зэвсэглэл, техникийг өөрийн орны нөхцөлд сайжруулан шинэчлэх, технологи-үйлдвэрлэлийн баазыг гадаад хамтын ажиллагаанд тулгуурлан бий болгох техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлнэ.	2003-2004	Ж.Гуррагчаа
			718. Зэвсэглэл, техникийн салбэг хэрэгсэл үйлдвэрлэх жижиг болон дунд үйлдвэрийг хөгжүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг ашиглах боломжийг судлан, хамтран ажиллах таатай нөхцөл бүрдүүлэхээр чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
			719. Цэргийн салбарт ОХУ-тай хамтын ажиллагаа сэргээж, зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах чиглэлд хамтын ажиллагаа өргөжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа, Л.Эрдэнэчулуун
			720. Агаарын орон зайд нислэг хийлгэх, цэргийн зарим нисэх буудлыг гадаад оронд түрээсээр ашиглуулах замаар хөрөнгө төвлөрүүлж, түүнийг зэвсэглэл, техникийг шинэчлэхэд зарцуулах боломжийг судалж хэрэгжүүлнэ.	2001-2004	Ж.Гуррагчаа

(үргэлжлэл бий)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны нэгдүгээр сарын 22 №3 (19

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

17. Гэрээ соёрхон батлах тухай (2001-1-11-ний хууль) 64
18. Гэрээ соёрхон батлах тухай (2001-1-11-ний хууль) 64
19. Конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсныг соёрхон батлах тухай (2001-1-11-ний хууль) 64
20. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-1-11-ний хууль) 64

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

21. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүнийг томилох тухай Дугаар 01 64
22. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүний сарын цалингийн хэмжээ тогтоох тухай Дугаар 02 65
23. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 03 65
24. Засгийн газрын гишүүн байсан хүмүүсийн тэтгэмжийн тухай Дугаар 04 65
25. Санхүүгийн улсын хяналт шалгалтын үйл ажиллагааны тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 05 65
26. Орон даяар гашуудал зарлах тухай Дугаар 06 66

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

27. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 01 66
28. ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 03 66

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

29. Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолын хавсралт (Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай) 67

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын Экспорт-Импорт банк /Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан/-ны хооронд 2000 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Даланзадгадын дулааны цахилгаан станцын төслийн нэмэлт Зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2000 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгчийн газрын тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай конвенцид Монреалийн Протоколын 9 дүгээр хуралдаанаас оруулсан нэмэлт, өөрчлөлтэд нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр — **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалтыг "9/бүрэн эрхийнхээ хугацаа дуусснаас эхлэн Ерөнхий сайдаар ажилласан хугацаатай нь дүйцэхүйц, гэхдээ нэгэн бүрэн эрхийнхээс илүүгүй хугацаагаар Улсын Их Хурлаас тогтоосон хангамж эдэлж, төрийн тусгай хамгаалалтад байна." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс емнө Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүмүүст Улсын Их Хурлаас тогтоосон хангамж, хамгаалалтын хугацааг энэ хуульд хамааруулсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр — **Дугаар 01** — **Улаанбаатар хот**

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5.1, 5.6 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сүрэнгийн Цэрэндоржийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргаар, Гүүширийн Далайжамцыг гишүүнээр тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 11–ний өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүний сарын цалингийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 22.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын сарын цалингийн хэмжээг 96000 төгрөгөөр, гишүүний сарын цалингийн хэмжээг 91000 төгрөгөөр тус тус тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 11–ний өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албыг байгуулах, төсвөө зохих журмын дагуу батлуулах, үйл ажиллагаатайгаа холбогдсон дүрэм, журам, заавар боловсруулах зэрэг арга хэмжээг энэ оны эхний улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга /С.Цэрэндорж/-д даалгасугай.

2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл /байр, холбоо, техник хэрэгсэл, унаа/-ийг бүрдүүлж, түүнд шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн төсвөөс гаргахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь байнгын туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ц.Шаравдорж/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 11–ний өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

Засгийн газрын гишүүн байсан хүмүүсийн тэтгэмжийн тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан А.Баттөр, С.Сонин, Я.Очирсүх, Н.Туяа, Д.Ганболд, С.Мэндсайхан, Ш.Түвдэндорж, Г.Батхүү, Ч.Содномцэрэн нарт тодорхой ажил, албан тушаал эрхлэхээгүй нөхцөлд Улсын Их Хурлын 2000 оны 10 дугаар тогтоолоор тогтоосон цалин, хууль тогтоомжоор тогтоосон бусад нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг 6 сарын хугацаагаар тооцож олгохыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 12–ны өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Санхүүгийн улсын хяналт шалгалтын үйл ажиллагааны тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Санхүүгийн улсын хяналт шалгалтын үйл ажиллагааны тухай хуулийн төслийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэлэлцэн батална дараагаар уг хуультай уялдуулан дахин боловсруулах, төрийн болон санхүүгийн хяналт шалгалтын заагаар ялгаг тодорхой болгох нь зүйтэй гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 17–ны өдөр Дугаар 06 **Улаанбаатар хот**

Орон даяар гашуудал зарлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2001 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зудын гамшгийн байдлыг тодорхойлох зорилгоор Завхан, Увс аймагт ажиллаж байсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын ажлын хэсэг, албаны хүмүүсийн сууж явсан нисдэг тэрэг осолдсоноос Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын хөдөлмөрийн баатар Шагдарын Оттонбилэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын ажилтан, гамшгийг үнэлэх, зохицуулах төвийн ажлын хэсгийн гишүүд, Монгол Улс болон гадаад улсын зарим иргэд албан үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар амь үрэгдсэнтэй холбогдуулан 2001 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 18.00 цагаас 19-ний өдрийн 18.00 цаг хүртэлх хугацаанд орон даяар гашуудал зарласугай.

2.Гашуудлын ёслол үйлдэх түр журам тогтоож, хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2001 оны 1 дүгээр сарын 18, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан хуралдахгүй болсныг зарласугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 11–ний өдөр Дугаар 01 **Улаанбаатар хот**

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Баасанжавын Нансалмаагаар Хөвсгөл аймгийн сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 15–ны өдөр Дугаар 03 **Улаанбаатар хот**

ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын дор дурдсан иргэдийг одон, медалиар шагнасугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

Станислав Степанович Набойченко -ОХУ-ын Екатеринбург хотын Уралын техникийн их сургуулийн ректор

"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:

1. Владимир Иванович Глызин - ОХУ-ын Екатеринбург хотын Уралын техникийн их сургуулийн ахмад багш
2. Леонардо Леонардович Богатырев - Мөн сургуулийн автоматжуулсан цахилгаан системийн тэнхмийн профессор
3. Григорий Церенович Пюрбеев - ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №1,2-т нийтлэгдсэн

234	5.1.3	Цэргийн байгууллагыг боловсронгуй болгож шинэчлэлийг гүнзгийрүүлж, цэргийн чадавхийг дээшлүүлнэ.	721. Цэргийн байгууллагыг 2000-2005 онд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
			722. Нэгттэл, анги, салбаруудад мэргэжлийн зэрэгтэй цэргийн албан хаагчдыг дэмжих замаар Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг хандлагатай болгон хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
			723. Зэвсэгт хүчний тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг түүний гүйцэтгэх үүрэг, дайны үед дэлгэн байгуулах боломж, улс орны эдийн засгийн чадавхи, бүс нутгийн аюулгүй байдлын төлөв байдалд нийцүүлэн оновчтой болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2000-2001	Ж.Гуррагчаа
			724. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төлөвшүүлэхтэй холбогдсон удирдлага, эдийн засаг, зохион байгуулалтын багц асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлнэ.	2000	Ж.Гуррагчаа
			725. Батлан хамгаалах төсвийн ангилал, төлөвлөлт, хуваарилалтыг олон улсын жишиг нийцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2001	Ж.Гуррагчаа
			726. Шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үндсэн чиглэлийг шинэчлэн тодорхойлж, ойрын болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2002	Ж.Гуррагчаа
			727. Батлан хамгаалах салбарын "Мэдээллийн сан" төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мэдээллийн сан байгуулах ажлыг удирдлага, санхүү, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, Батлан хамгаалах яамны мэдээллийн дотоод сүлжээний хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэн мэдээллийн үйлчилгээг эрс сайжруулах арга хэмжээ авах замаар төрийн мэдээллийн сүлжээнд холбогдоно.	2001-2002	Ж.Гуррагчаа
			728. Монгол Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж мөрдөнө.	2002	Ж.Гуррагчаа
			729. Улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж Засгийн газарт оруулна.	2002	Ж.Гуррагчаа
			730. Аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг Засгийн газраас тогтоон өгч, дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх арга хэмжээ авна.	2002-2003	Ж.Гуррагчаа
			731. "Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн"-ийг нутаг дэвсгэрийн журмаар бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.	2001-2003	Ж.Гуррагчаа, аймаг, нийслэлийн Засаг дарга
			732. Цэргийн дайчилгааны нөөцийг тодотгох, солих, нөхөн хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гуррагчаа
235	5.1.4	Сайн дурын үндсэн дээр цэргийн албыг гэрэзгээр хаах нөхцөлийг сайжруулж нэмэгдүүлэх замаар мэргэжлийн анги, салбарын бие бүрэлдэхүүний мэргэшлийн түвшинг дээшлүүлнэ.	733. Мото буудлагын мэргэжлийн ангийг шинээр нэмж байгуулах, түүнийг гэрээт цэргээр хангах, гэрээт цэрэг бүхий салбарын тоог нэмэгдүүлэх.	2001-2004	Ж.Гуррагчаа
			734. Гэрээт цэргийн сургалтын тогтолцоог бий болгоно.	2000-2001	Ж.Гуррагчаа
			735. Цэргийн албыг гэрээгээр хаах, орчин нөхцөлийг сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авна.	2000-2003	Ж.Гуррагчаа
			736. Гэрээт цэргийн мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн материаллаг баазыг сайжруулах, урамшууллын шинэ хэлбэрийг бий болгох арга хэмжээ авна.	2000-2003	Ж.Гуррагчаа
236	5.1.5	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн агуулгыг өнөөгийн	737. Цэргийн сургалтад агуулга, стандартын өөрчлөлт хийх, эрчимжсэн арга, технологийг нэвтрүүлэх, цэргийг уламжлалт үүрэгт нь сургахын зэрэгцээ ард иргэдэд хэрэгтэй тусламж үзүүлэх,	2001-2002	Ж.Гуррагчаа

		зорилт, шаардлагатай нийцүүлэн өөрчилж боловсронгуй болгохын зэрэгцээгээр үндсэн үүргээсээ гадна байгалийн гамшиг, үйлдвэрийн ослын хор уршгийг арилгах, иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр сургаж дадлагажуулна.	байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын хор уршгийг арилгах арга техникт сургах цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ. 738. Цэргийн сургалтын материаллаг баазыг эдийн засгийн үр ашиг бүхий шинэчлэх ухаан, технологийн орчин үеийн олоттыг тусгасан чиглэлд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан, гадаад туршлыг дэмжлэг, өөрийн нөөц болоцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гүррагчаа
			739. Офицер, ахлагч нарын онолын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн тасралтгүй, шаталсан сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгоно.	2002-2003	Ж.Гүррагчаа
			740. Цэргийн нарийн мэргэжлээр гадаадын өндөр хөгжилтэй орнуудад боловсон хүчин бэлтгэх тоог нэмэгдүүлнэ.	2001-2004	Ж.Гүррагчаа
			741. Батлан хамгаалахын их сургуулийн сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын хүрээг өргөтгөх, багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2002	Ж.Гүррагчаа
			742. Цэргийн нэгтгэл, ангиудыг хүмүүнлэгийн болон байгалийн гамшгийн хор уршгийг арилгах, батлан хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн бүтээн байгуулалтад оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.	2000-2001	Ж.Гүррагчаа
237	5.1.6	Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг байгалийн гамшиг, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх тэд-нартэй тэмцэх үйл ажиллагааны тодорхой чиглэлээр сургаж дадлагажуулна.	743. Цэргийн дүйцүүлэх албаны сургалтын хөтөлбөрийг байгалийн гамшиг, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үйл ажиллагаанд чиглүүлэн өөрчилнө.	2002-2003	Ж.Гүррагчаа
			744. Цэргийн албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр дуйцүүлэн хаах журмыг шинэчлэн батална.ажүулж, хэрэгжүүлэх арга хэрэгүүрийг бий болгоно.	2001-2003	Ж.Гүррагчаа
238	5.1.7	Зэвсэгт хүчний алба хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангулан хэрэг-жүүлж эхэлнэ.	745. Энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд бэлтгэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан холбогдох анги, байгууллагад хэрэгжүүлнэ.	2000-2001	Ж.Гүррагчаа
			746. НҮБ-ын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцохтой холбогдсон зарим асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ.	2000-2001	Ж.Гүррагчаа, Л.Эрдэнэчулуун
			747. НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоход цэргийн салбар, ангиудыг цэгцтэй бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2000-2004	Ж.Гүррагчаа
5.2. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт бие даасан байдлыг хамгаалах, иргэдийн аюулгүй тайван амьдрах орчныг бүрдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:					
			957. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тайлан мэдээнд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүнг нийт иргэдэд мэдээлдэг журам тогтоно.	2001-2004	Ө.Энхтүвшин
			958. Жил бүр нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	2001-2004	Ө.Энхтүвшин
			959. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, бүх шатны Засаг дарга нарын сургалт семинарыг зохион байгуулан хийлгэж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	2001-2004	Ө.Энхтүвшин
290	6.1.10	Төрийн бус бай-гуулагыг дэмжиж, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд болон	960. Засгийн газрын гишүүд, сайдын эрхлэх ажлын хүрээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын жагсаалтыг шинэчлэн гаргаж Засгийн газрын 1995 оны 111 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	2000-2001	Бүх сайд нар

		ялангуяа ниймийн салбарт оролцоог нь өргөжүүлнэ.	961. Үйл ажиллагааных нь чиглэлээр төрөлжүүлэн төрийн бус байгууллагуудын ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, ниймийн салбарт тэдний оролцоог идэвхжүүлнэ. 962. Төрийн тодорхой чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх явдлыг өргөтгөнө.	жил бүр 2001-2004	Ц.Нямдорж Бух сайд нар
291	6.1.11	Засаг даргын дэргэдэх зарим газар, хэлтэс, агентлагийн орон нутаг дахь салбарыг нэгдсэн эхион байгуулалтад оруулж Засаг даргад харьяалуулна.	963. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, агентлагуудын бүтцийг шинэчлэн батална. 964. Сумдыг томсгох замаар захиргааны орон тоо, зардлыг хямдруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2000 2000-2004	Ө.Энхтувшин Ө.Энхтувшин
292	6.1.12	Засгийн газар, үйлдвэрчний байгууллага,ажил олгогчдын нэгдсэн холбооны гурван талт тунштэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх болон төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах үндсэн дээр төрийн зарим ажил, үйлчилгээг тэдгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.	965. Монгол Улсын Засгийн газар, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны хооронд байгуулсан Хөдөлмөр, нийгмийн эвсэлтийн гурван талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Засгийн газраас хүлээсэн үүргийг холбогдох яамд, агентлагуудын хүчээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 966. Эдийн засгийн болон хөдөлмөр, нийгмийн холбогдолтой асуудлаар хуулийн төсөл боловсруулах шатанд ниймийн түншүүдийн судалгаа, саналыг хэлэлцүүх журам тогтооно. 967. Ниймийн эвсэлийн гурван талт тунштэлийн хүрээнд бизнесийн орчныг сайжруулах чиглэлийг хэлэлцэж, шийдвэр гаргахад санал солилцох ажиллагааг боловсронгуй болгоно. 968. Хөдөлмөр, нийгмийн эвсэлийн гурван талт Үндэсний хорооны үйл ажиллагаат хэвийн явуулахад Засгийн газраас санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. 969. Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах үндсэн дээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний чиглэл, жагсаалт, жүрмыг батлаж мөрдүүлнэ. 970. Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсний үнэ тариф тогтоож, тесвийг зохих жүрмын дагуу батлуулан санхүүжүүлэх байна. 971. Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах үндсэн дээр төрийн зарим ажил, үйлчилгээг тэдгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.	2000-2004 2000-2004 2000-2004 2000-2004 2000-2004 2001-2004	Ө.Энхтувшин Ө.Энхтувшин Ө.Энхтувшин Ш.Батбаяр Ө.Энхтувшин Ш.Батбаяр Ө.Энхтувшин Ш.Батбаяр Ө.Энхтувшин Ч.Улаан Ө.Энхтувшин
293	6.1.13	Хараа хяналтгүй хүүхэд, гэр орон-гүй хүмүүс, архаг архичдын талаар тусгай бодлого боловсруулж, тэднийг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	972. Хүүхдийн болон түүний эрэгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 973. Хүүхдийн үйлдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах үндэсэн дээр тэдний үйлдэж буй танхай, хулгайн хэргийн өсөлтийг бууруулах арга хэмжээ авна. 974. Хүүхдийн үйлдэж байгаа гэмт хэргийг саруулах, таслан зогсоох ажил хийнэ. 975. Тэнэмэл хүүхэд, гэр орончгүй хүмүүсийн судалгааг улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж хэрэзн шийдвэрлэх талаар санал боловсруулна. 976. Хараа хяналтгүй хүүхэд болон гэр орончгүй хүмүүсийг төрийн ивээлд авах, тэднийг иргэний бичиг баримттай болгох асуудлыг холбогдох төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. 977. Улсын хэмжээнд буй архаг архичдын бүрэн судалгааг гаргаж, тэдний асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулна.	2000-2004 2001-2003 2003-2004 2000 2000-2001 2000	Ц.Нямдорж Ц.Нямдорж Ц.Нямдорж Ц.Нямдорж, Ш.Батбаяр Ц.Нямдорж, Ш.Батбаяр Ц.Нямдорж, П.Нямдаваа,

			978.	Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх, хөдөлмөрлүүлэх газрыг бүсчлэн байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.	2000-2004	Ш.Батбаяр Ц.Нямдорж, П.Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга
294	6.1.14	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх, цагдаагийн эргүүл, зохицуулалтын үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгон уналга, техник хэрэгслийг шинэчлэнэ.	979.	Хөдөлгөөний аюулгүй байдлын эрэгт гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2000-2004	Ц.Нямдорж
			980.	Улаанбаатар хотын гудамжны хөдөлгөөнийг зохицуулах, явах замын хэрэглэл тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ.	2000	Ц.Нямдорж, Б.Жигжид, нийслэлийн Засаг дарга
			981.	Нийслэл хотыг шөнийн эргүүлэгт болгох асуудлыг боловсруулж, орон тоо, цалинг батлуулах, цагдаагийн офицержуулах ажлыг шийднэ.	2001оноос	Ц.Нямдорж
			982.	Цагдаагийн байгууллагын автомашины паркыг шинэчлэх тесел боловсруулж хэрэгжүүлнэ.	2000-2004	Ц.Нямдорж
			983.	Цагдаагийн байгуулагад болон албан хаагчдыг холбоо, галт зэвсэг, сум, тусгай хэрэгслээр хангах, компьютержүүлэх теслийг хэрэгжүүлнэ.	2000-2004	Ц.Нямдорж
295	6.1.15	Хот, суурин газрын цагдаагийн эргүүл, жижүүрийн хүр-тээмж, шуурхай байдлыг сайжруулж ирэгдийн амгалан тайван, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж ирэгд-цагдаагийн бай-гууллагын хамтын ажиллагаа өргөжүүлнэ.	984.	Улаанбаатар хотын орон сууц, гудамжны хороо нэг бүрийг гурван эелжийн цагдаатай болгон 24 цагаар ажиллуулах асуудлыг шийдвэрлүүлнэ.	2001-2002	Ц.Нямдорж
			985.	Японы үндэсний Цагдаагийн газрын туршлагаар орон сууц, гэр хороополд цагдаагийн хэсгийн барилгыг байцаагчийн орон сууцны хамтаар барьж, ирэгдэд хүрч ажиллах туршилтыг дэс дараатай шийдвэрлэнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			986.	Цагдаагийн албаа хаагчдын цалин хангамжийг нэмэгдүүлэх, цагдаа, дотоодын цэргийн албаа хаагчдыг батлагдсан нормативын өвөл, зуны хувцаар хангах арга хэмжээ авна.	2001-2004	Ц.Нямдорж
			987.	Цагдаагийн албаа хаагчдын орон сууц барих тесел боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			988.	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.	2000-2001	Ц.Нямдорж
			989.	Нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх болон галын онц аюултай хий, бодис материалыг улсын хилээр оруулах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, үйлдвэрлэх, худалдан борлуулах зэрэг үйл ажиллагааны галын аюулгүй байдлыг хангах олон улсын жишиг нийцсэн дүрмийг боловсруулан батлаж мөрдүүлнэ.	2001	Ц.Нямдорж
			990.	Галын аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай орчин үеийн гал унтраах техник зэвсэглэмж, тоног төхөөрөмж, холбоony хэрэгслээр хангана.	2001-2004	Ц.Нямдорж
6.2. Төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулан, нэр хүндийг өргөж, чадваржуулна.						
296	6.2.1	Төрийн ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх хэрэгцээг тодорхойлж, уг хэрэгцээг хангах сөнөүүжилтийн эх үүсвэр шаардах-гүй сургалтын шинэ хэлбэрүүдийг	991.	Төрийн захиргааны бүх шатны байгууллагын төрийн албан хаагчын мэдлэг, чадваржуулах дээшлүүлэх хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйг нэвтрүүлнэ.	2000-2004	Ө.Энхтувшин
			992.	Төрийн ажилтныг гадаадад дипломын дараахь сургалтад хамруулах хэрэгцээг тодорхойлж, хандивлагч орон, олон улсын байгууллагатай тохиролцон хөтөлбөр,	2000-2004	Ө.Энхтувшин

		нэгтгүүлэхийн зэрэгцүүр таднийг дотоод, гадаадын дипломын дараахь сургалтад тодорхой бодлого, чиглэл-тэйгээр хамруулж, төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлнэ.		төсөл, арга хэмжээний дагуу таднийг гадаадын сургалтад хамруулах арга хэмжээ авна.		
			993.	Төрийн захиргааны бүх шатны байгууллагын сургалтын хөтөлбөрийг үндэслэн төрийн ажилтныг дипломын дараахь дотоодын сургалтад хамруулах ажлыг жил жилийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.	2001-2004	Ө.Энхтувшин
297	6.2.2	Улс төрийн бүх албан тушаалтан болон төр, засгийн өндөр албан тушаалд ажиллах хүмүүсийн өмч, орлогын бүртгэлийг сайжруулж, авил-галтай тэмцэх гэ-рээтэй ажиллуулна.	994.	Авилгалтай тэмцэх гэрээний загварыг батлуулан хэрэгжүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			995.	Улс төрийн болон төр, засгийн өндөр албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах журмыг боловсронгуй болгоно.	2001	Ц.Нямдорж, Ө.Энхтувшин
			996.	Яам, агентлагуудын удирдах албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавьж, дун шинжилгээ хийнэ.	2001-2004	Ө.Энхтувшин
			997.	Яам, агентлагуудын удирдах албан тушаалтантай авилгалтай тэмцэх гэрээ байгуулах журам тогтоно.	2001	Ө.Энхтувшин, Ц.Нямдорж,
298	6.2.3	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, мэргэжлийн төрийн албан хаагчийн албан ажилгүй улс төрийн дарамт шахалтаас хамгаалах ур ашигмал механизм бүр-дүүлж, бүх шатны төрийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, ажлын чиг үүргийг нарийвчлан тогтоож дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.	998.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, мэргэжлийн төрийн албан хаагчийн эрх ашигийг улс төрийн дарамт шахалтаас хамгаалах ур ашигтай тогтолцоо бүрдүүлнэ.	2001	Ө.Энхтувшин
			999.	Төрийн албаны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох эрх зүйн актыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлнэ.	2001-2004	Ө.Энхтувшин
			1000.	Бүх шатны төрийн ажилтны ажлын байрны шинжилгээ, тодорхойлолт, үнэлгээ хийх арга зүйг боловсронгуй болгож үүнтэй холбогдсон зааварт, журмыг боловсруулан батална мөрдүүлнэ.	2002	Ө.Энхтувшин
			1001.	Төрийн захиргааны бүх шатны байгууллагын зохион байгуулалтын бүтэц, нэгжүүдийн үйл ажиллагаа /бизнес/-ны стратеги, албан тушаалын орон тоог шинэчлэн баталж, ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан тогтоож, төрийн ажилтны ачаалтыг жигдрүүлэх, ажил үүргийн давхардал, хийдэгдлийг арилгах арга хэмжээ авна.	2000-2004	Ө.Энхтувшин
			1002.	Бүх шатны төрийн захиргааны байгууллагын ажлаа төлөвлөх, тайлагнах, үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлэх, дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох журмыг улаанбаатар хотын захиргаа, дүүргийн засаг-дын даргын тамгын газар, хэлтэс, алба, нэгжийн дүрэм, ажлын байрны тодорхойлолтод тусган, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулна.	2000-2004	Ө.Энхтувшин
299	6.2.4	Төсвийн орлогын бүрдүүлэлт, зар-цуулалт, төрийн өмчийн ард хөрөн-гийн ашиглалт, хадгалалт, төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд тавих хяналтыг чангатган ур нөлөөг нь дээш-лүүлж, төсвийн байгууллагын үйл ажиллагааны ур дүн, санхүүгийн тайлагнал хэндлэн-гийн хяналт хийж баталгаажуулдаг журмыг хэвшүүлнэ.	1003.	Төсвийн орлого бүрдүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал, хариуцлагын тогтолцоо бий болгож түүнийг эрх зүйн баримт бичгээр баталгаажуулна.	2001	Ч.Улаан Ө.Энхтувшин
			1004.	Бүх төрлийн төлбөр, хураамжийн орлогыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлэх замаар төсөвт байгууллагуудыг зөвхөн төсөвөс санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлнэ.	2002-2003	Ч.Улаан
			1005.	Бизнесийн болон төсөвт байгууллагын банкуудад байршуулсан дансанд тооллого явуулж байх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	2001-2002	Ч.Улаан
			1006.	Худалдаа, үйлчилгээнд балэн бус тооцооны хэрэгслүүдийг төлбөрт ашиглах, кассын аппарат хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгон мөрдүүлнэ.	2002-2003	Ч.Улаан Ч.Ганзориг
			1007.	Төсөвт байгууллагын зардлыг үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг	2001-2002	Ч.Улаан

			үндэслэн төлөвлөх, санхүүжүүлэх, түүний гүйцэтгэлийг хянах, үнэлэх тогтолцоо бүрдүүлнэ.		
			1008. Төрийн өмч ашиглалтын үр ашигтай норматив тогтоох, ашиглагдаагүй буюу дутуу ашигласан хөрөнгөд төлбөр ногдуулах замаар төрийн өмчийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлнэ.	2001	Ч.Улаан
			1009. Төрийн өмчийн хадгалалт, хамгаалалтад байгаын хяналт тогтоох, үзлэг, шалгалтыг хүчтэй болгоын зэрэгцэх төрийн өмчийн ашиглалтын мэдээллийг ил тод болгоно.	2001-2004	Ч.Улаан
			1010. Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийг батлуулан хэрэгжүүлнэ.	2001	Ц.Нямдорж Ө.Энхтувшин
			1011. Төрийн хяналтын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар Төрийн хянан шалгах хороог төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланд хөндлөнгийн хяналт тавьдаг чиг үүрэгтэй болгоно.	2001	Ч.Улаан Ө.Энхтувшин
300	6.2.5	Төрийн захиргааны болон төрийн үйл-чилгээний байгууллагаас иргэд, хэ-рэглэгчидийг да-раатлах, монополь байдлаа бүрүүгаар ашиглах аливаа илрэлтэй тэмцэх, энэ зорилгоор те-рийн байгуулла-гаас иргэдийн тавьсан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хяналт тавих нийтийн гэрээний журамтай болгоно.	1012. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн дагуу Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба байгуулан ажиллуулна.	2001	Ц.Нямдорж
			1013. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна.	2001	Ц.Нямдорж
6.3 Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулна.					
301	6.3.1	Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг судалж,хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тог-толцоог бий бол-гоно.	1014. Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг судлах нэгжийг бий болгон ажиллуулна.	2001	Ц.Нямдорж
			1015. Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авна.	2001-2004	Ө.Энхтувшин Ц.Нямдорж
302	6.3.2	Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаат боловсронгуй болгоно.	1016. Хорих ял эдлүүлэх болон шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.	2000-2001	Ц.Нямдорж
			1017. Шийдвэр биелүүлэх албаны сургалтын төв байгуулан түүнд офицер, ахлагч нарыг даватан сургах, мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээ авна.	2000 оноос	Ц.Нямдорж
			1018. Шийдвэр биелүүлэх албаны офицер, ахлагч нарын нийгмийн хамгаалал, ялангуяа алслагдсан хөдөө нутагт ажиллаж байгаа албан хаагчдад хоногийн хүнсний хангалт олгох, нийт бие бүрэлдэхүүний цалин хангамжийг нэмэгдүүлэх, орон сууц барихад нь туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.	2000-2004	Ц.Нямдорж
			1019. Хорих ял эдлүүлэх тогтолцоог дэлхий нийтийн чиг хандлагатай харьцуулан судалж, хорих байгууллагыг аль болох нэлээтгэх болгох, хорих ял эдлэх байгаа эгэздийг нийгэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргийн үргшгаар хохирсон хүмүүст хохирлоо гаргуулан авахад нь туслалцаа үзүүлэх чиглэлээр тусгайлсан төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			1020. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн таатай орчин	2001	Ц.Нямдорж

			бүрдүүлэх үүднээс холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.		
			1021. Хорих ял эдлэх байгаа хоригдлын нас баралтыг бууруулах, ялангуяа сурьеэ өвчтэй хоригдлыг тусгаарлан эмчлэх тусгай эмнэлэг, сувиллын газар байгуулах арга хэмжээ авна.	2000-2001	Ц.Нямдорж
			1022. Хорих ял эдэлж байгаа эгэзэгийн талаас шинээр гэмт хэрэг үйлдэх, оргох явдлыг таслан зогсоохоо чиглүүлэн хорих анги,удын дохиоллол, хамгаалалтын ажилагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн төгөлдөржүүлэх арга хэмжээ авна.	2000-2001	Ц.Нямдорж
			1023. Хорих ял эдлүүлэх газрын хоригдлын тоо буртгэлийг цахим санд оруулна.	2000-2001	Ц.Нямдорж
			1024. Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажилагаанд санхүүгийн буртгэл, хяналтын журмыг бүрэн нэвтрүүлнэ.	2000-2002	Ц.Нямдорж
			1025. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль болон НҮБ-аас батаслан эрх зүйн хэм хэмжээний стандартад нийцсэн үлгэр жишээ хорих газар байгуулах бүоу аль нэг хорих ангийг дүйцүүлэн шинэчлэн тохижуулах арга хэмжээ авна.	2001-2003	Ц.Нямдорж
			1026. Хоригдлын хөдөлмөрийн орлогыг тэдний ахуй нөхцөлийг сайжруулах, гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхэд зарцуулдаг журамтай болгох эрхзүйн үндсийг бүрдүүлнэ.	2001	Ц.Нямдорж
303	6.3.3	Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл шинэчлэх үндсэн чиглэлийг боловсруулан батлуулна. Их Хуралд оруулж батлуулна.	1027. Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэх үндсэн чиглэлийг боловсруулан батлуулна.	2000-2001	Ц.Нямдорж
			1028. Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд Эрүүгийн байцаан шийтэх тухай, Иргэний тухай, Иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиудыг багцлан боловсруулж батлуулна.	2000-2001	Ц.Нямдорж
304	6.3.4	Хүний эрхийн үндэсний байгууллага бий болгож, хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авна.	1029. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулж, түүний дагуу Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулж ажиллуулна.	2001-2004	Ц.Нямдорж
			1030. Нийгмийн зөвшлийн үндсэн дээр Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулж мөрдүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			1031. Иргэдийн эрхийн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийн талаарх баримт бичгийг тайлбарлан таниулах, түүний хэрэжилтийг хангах тогтолцоог бүрдүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			1032. Хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээ авна.	2001-2002	Ц.Нямдорж
			1033. Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг ХБНГУ, АНУ-тай байгуулна.	2001	Ц.Нямдорж, Л.Эрдэнэчулуун
			1034. Гадаадад хүвийн хэргээр зорчиж байгаа Монгол Улсын иргэдийг манай улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт буртгэж, мэдээлдэг болгох тогтолцоог бүрдүүлнэ.	2002-2004	Ц.Нямдорж, Л.Эрдэнэчулуун
305	6.3.5	Хууль эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлыг хангана.	1035. Хууль эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлыг хангах чиглэлээр байцаан шийтгэх хуулиудад холбогдох өөрчлөлт оруулна.	2002	Ц.Нямдорж
306	6.3.6	Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг	1036. Төрийн архивын ажлын үндсэн зааварт, төрийн архивт байнга хадгалах баримт бичгийн нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг архивын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн мөрдүүлнэ.	2001-2002	Ц.Нямдорж

		бүрдүүлэх, төрийн албан хэрэг хөтлөлтийг эмх цэгцтэй, боловсронгуй болгох арга хэмжээ авна.	1037.	Архивын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн улсын зөвлөх үзлэг явуулна.	2004	Ц.Нямдорж
			1038.	Архивын хосгүй үнэт баримтыг судлан илрүүлэх, тоо бүртгэл хөтлөх, хамгаалалтын хувьтай болгох ажлыг зохион байгуулна.	2001-2004	Ц.Нямдорж
			1039.	Үндэсний төв архивын зарим сан хөмрөгийг орчин үеийн зориулалтын нягтруулсан тавиур, шүүгээгээр хангаж, галын дохиоллын сүлжээг шинэчилнэ.	2001-2004	Ц.Нямдорж
			1040.	Сэлбэн засах лабораторийг өргөтгөн бэхжүүлж, архивын баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх орчин үеийн арга технологийг нэвтрүүлнэ.	2001	Ц.Нямдорж
			1041.	Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх эрх зүйн актуудыг шинэчлэн боловсруулж, төрийн байгууллагуудад хэрэглэх хэвлэмэл хуудсыг стандартад нийцүүлэн нэгдсэн журмаар хэвлүүлнэ.	2000-2001	Ц.Нямдорж
			1042.	Удирдлагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдөж буй мэдээллийн эрэлт, хайлт, ашиглалтын хөтөлбөр хангамжийг боловсруулж, мэдээллийн сүлжээнд оруулна.	2001-2004	Ц.Нямдорж
			1043.	Цахим баримт бичгийг боловсруулах, хадгалах, ашиглах, төрийн архивт шилжүүлэх журмыг шинээр боловсруулж мөрдүүлнэ.	2001	Ц.Нямдорж
			1044.	Аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх Галын аюулгүйн дүрмийг шинээр боловсруулж мөрдүүлнэ.	2001	Ц.Нямдорж
307	6.3.7	Оюуны өмчийн эзэмшүүлэлтыг дэлхийн жишигт нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, оюуны өмчийн холбогдолтой хууль тогтоомжуудыг олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлнэ. Үндэсний болон уламжлалт оюуны бүтээл, технологийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	1045.	Монгол үндэсний уламжлалт технологи, үндэсний бүтээлийн талаар эрх зүйн хамгаалалтын тогтолцоог тодорхойлох арга хэмжээ авна.	2001-2003	Ц.Нямдорж
			1046.	Дэлхийн оюуны өмчийн байгууллагад мэргэжилтнүүдийг ажилуулах, дадлагажуулах ажлыг зохион байгуулна	2001-2004	Ц.Нямдорж
			1047.	Интернэт дэх мэдээллийн зохиогчийн эрхийг хамгаалах талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж
308	6.3.8	Төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, үйлдвэ холбоо, хөрөнгө оруулагчдыг сайжруулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.	1048.	Төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, албан хэргийн удирдлагын өнөөгийн байдалд нэгдсэн удирдамжийн дагуу үзлэг хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авна.	2001	Ө.Энхтүвшин
			1049.	Төрийн байгууллагуудын ажлын үзлэдаа холбоог сайжруулах, сайд нарын 7 хоног тутмын үүлзалт, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамдын газар, хэлтсийн дарга, агентлагийн дарга нарын ажил хэргийн үүлзалт, зөвлөлгөөн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, бусад удирдах ажилтны бүсчилсэн ажил хэргийн үүлзалт, зөвлөлгөөн зохиох тогтолцоог бүрдүүлж, тэдгээрийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2000-2004	Ө.Энхтүвшин
			1050.	Засгийн газрын тулгамдсан зорилтыг боловсруулах, цаг үеийн чухал арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажлын хэсгүүдийг удирдлагын бүх түвшинд байгуулан ажиллуулах практикийг өргөн ашиглаж, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг ажлын хэсэгт оролцсон хүмүүсийн харицуулагыг тодорхойлох нэгэн үзүүлэлт	2000-2004	Ө.Энхтүвшин

			болгож ажилпана.		
			1051. Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг гаргаж, түүнийг ажлын төлөвлөлт, тайлагналт, үйл ажиллагааных нь үр дүнг үнэлэн дүгнэхэд харгалзан үзэх журам тогтоон мөрдүүлнэ.	2000-2004	Ө.Энхтүвшин
			1052. Төрийн захиргааны байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах, хариуцлагыг дээшлүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлнэ.	2000-2004	Ө.Энхтүвшин
			1053.Засгийн газар, төрийн захиргааны байгууллагын үйл ажилллагаатай холбогдсон мэдээллийг иргэд хүлээн авах, иргэд санал, хүсэлтээ гаргах хоёр талын урсгал бүхий сувгийг чөлөөтэй ажиллуулж төр, засгийн бодлого, шийдвэр, түүний биелэлтийн явц, үр дүнг олон нийтэд мэдээлэх, сургалтлах ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах зэрэгт Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.	2000-2004	Ө.Энхтүвшин
6.4. Авилгал, хээл хахууль, гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэж, тэдгээрийн бий болох хөрсийг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ.					
309	6.4.1	Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	1054. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулна.	2000	Ц.Нямдорж
			1055. Авилгалтай тэмцэх ажлыг хариуцсан бүтэц бий болгоно.	2001	Ц.Нямдорж
			1056. Авилгалын эсрэг хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	2001	Ц.Нямдорж
			1057. Авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай үндэсний багц хурал зохион байгуулна.	2001	Ц.Нямдорж
310	6.4.2	Зөвсөөрт дээрэм, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, борлуулах, мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэн гүйлгээнд оруулах зэрэг шинэ төрлийн онц нөөцтой гэмт хэрэгтэй илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажилагаат сайжруулна.	1058. Зохион байгуулалттай, онц нөөцтой гэмт хэргүүдийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний өрөнхий чиглэл гаргаж ажиллана.	2000-2002	Ц.Нямдорж
			1059. Хар тамхи, мансууруулах бодисыг таних, илрүүлэх лаборатори байгуулах, хил, гаалийн албаны зориулалт бүхий мэргэшсэн ажилтан, мэргэжилтэн бэлтгэх, багаж хэрэгсэл, үнэрч нохойгоор хангах, таднийг сургалтад хамруулах, гарын авлага, хэргэлгэдэхүүнээр хангах арга хэмжээ авна.	2000-2004	Ц.Нямдорж, Ч.Улаан
			1060. Зохион байгуулалттай шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаа, Татнуул, Хил, Гаалийн байгуулагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	2000-2004	Ц.Нямдорж
			1061. Зохион байгуулалттай хүнд, онц хүнд гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хүчний байгууллагудын шуурхай ажиллагаа, бэлэн байдал, ажлын уялдаа хангах (төрийн нууцын зэрэгт хамаарах) арга хэмжээний төлөвлөгөө, хуваарь гаргаж ажиллана.	2000-2002	Ц.Нямдорж, Ж.Гүррагчаа
311	6.4.3	Орлогын татвар, гаалийн үнэлгээ, татвар ногдуулалт, лиценз, зөвшөөрөл олгох зэргээр төрийн үйлчилгээ үзүүлснийтөлөө авилгал,шан харамж авах явдлыг таслан зогсооно.	1062. Гааль, татварын болон лиценз, зөвшөөрлийн хяналт шалгалтыг стандартжуулах, хариуцлагч иргэд, аж ахуйн нэгжид мэдээлэл олж авах боломжийг өргөтгөн хялбаршуулна.	2001-2002	Ч.Улаан
			1063.Татвар, гаалийн болон лиценз, зөвшөөрөл олгодог албаны байцаагчдын тавьсан торгууль, төлбөрийн хууль зүйн үндэслэлийг сайжруулах, хууль зүйн үндэслэлтэй торгууль, төлбөр дараагийн шатанд ямар нэг хэлбэрээр өөрчлөгдөг дүгнэлтыг таслан зогсоох, улсад оруулсан торгууль, төлбөрийн тодорхой хувиар байцаагчдыг урамшуулдаг журам тогтоож мөрдүүлнэ.	2000-2001	Ч.Улаан
312	6.4.4	Хувьчлал, гааль, татвар, банк, мөрдөн байцаах үйл	1064. Хувьчлал, гааль, татвар, банкны үйл ажилагаатай холбоотой удаашруч байгаа хэргүүдийг хууль хяналтын байгууллагууд	2000-2002	Ц.Нямдорж

		ажиллагаатай холбоотой бүдгэрч байгаа хэргүүдийг шалган тогтоож, үр дүнг иргэдэд ил тод мэдээлж байна.	шат шатандаа нягтлан шалгаж, шаардлагатай бол сэргээх арга хэмжээ авах зэмвэр гэм буруутай хүмүүст хуулийн дагуу хариуцлага ногдуулна.		
			1065. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, хариуцлага хүлээсэн гэм буруутай хүмүүсийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд цаг тухайд нь мэдээлж байна.	2000-2004	Ц.Нямдорж
313	6.4.5	Шүүгчдийн сахилга, ёс зүйн байдалд олон нийтээс тавих хяналтын тогтолцоог бий болгож, шүүгчийг эгүүлэн татах, огцруулах, тэдэнд хариуцлага хүлээлгэх механизмыг төлөвшүүлнэ.	1066. Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах, шүүгчдийн сахилга, ёс зүйн байдалд олон нийтээс тавих хяналтын тогтолцоог бий болгохтой холбогдсон хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлийг боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.	2000-2002	Ц.Нямдорж
			1067. Шүүгчийг томилох, эгүүлэн татах, огцруулах, тэдэнд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгоно.	2000-2002	Ц.Нямдорж
			1068. Хууль сахиулах байгууллагын ажилтны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн боловсруулж батлуулна.	2000-2004	Ц.Нямдорж
			1069. Монгол Улсын шүүхийн гадаад харилцаг өргөжүүлж, хөрш болон бусад орны ижил төрлийн байгууллагуудтай ажил хэргийн байгуулын холбоо тогтооно.	2000-2004	Ц.Нямдорж
314	6.4.6	Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1070. Шүүх засагчлалын стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагаас үзүүлэх туслалжийг үр дүнтэй ашиглах арга хэмжээ авна.	2002	Ц.Нямдорж
			1071. Шүүхийн удирдлагын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, байцаан шийтгэх ажиллагааны болон шүүхийн захиргааны удирдлагын заагт ялгаат хуулиар тодорхойлно.	2001-2004	Ц.Нямдорж
			1072. Дагнасан шүүх ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлж, Захиргааны хэргийн шүүх байгуулан ажиллуулна.	2001-2004	Ц.Нямдорж
			1073. Шүүхийн ажлын нөхцөл, албан өрөө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг эн тэргүүнд сайжруулах арга хэмжээ авна.	2002	Ц.Нямдорж
			1074. Шүүхийн хараат бус, шударга, хариуцлагатай бөгөөд мэдрэмж, хүртээмж, бүтээмжтэй байх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн дэс дараатай арга хэмжээ авна.	2000-2004	Ц.Нямдорж
			1075. Шүүгчийн ахуй хангамж, нийгмийн баталгаог хангах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, орон сууцаар хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2001-2004	Ц.Нямдорж

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (191)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Айлгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай*
- *Зудын цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны нэгдүгээр сарын 30 №4 (191)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

30. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 06 92

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

31. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоо, бүтцийг батлах тухай Дугаар 180 92
32. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 181 92
33. Ардын урлагийн их наадам зохион байгуулах тухай Дугаар 182 93
34. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 183 94
35. Хөтөлбөр батлах тухай Дугаар 184 95
36. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 185 97
37. Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай Дугаар 186 99
38. Үндэсний хороог шинэчлэн байгуулах тухай Дугаар 187 102
39. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай Дугаар 188 106
40. Зудын цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 189 113

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 19–ний өдөр **Дугаар 06** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадам-Очирын Должинцэрэнг өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Агваандоржийн Цолмонг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 22–ны өдөр **Дугаар 180** **Улаанбаатар хот**

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоо, бүтцийг батлах тухай

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, дотоодын цэргийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газарт дарга 1, дэд дарга 1 байхаар тогтоосугай.

2. Цагдаагийн ерөнхий газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай.

а/ Эрүүгийн цагдаагийн алба;
б/ Мөрдөн байцаах алба;
в/ Хэв журмын алба;
г/ Замын цагдаагийн алба;
д/ Санхүү төлөвлөлт, үйлчилгээ хангамжийн алба;
е/ Цагдаагийн академи;
ж/ Криминалистик шинжилгээний төв;
з/ Цагдан хорих төв;
и/ Холбооны хэлтэс;
к/ Дүн шинжилгээ, мэдээллийн төв;

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдлагад дотоодын цэрэг /штаб/ ажиллуулахаар тогтоосугай.

4. Цагдаагийн ерөнхий газрын төв аппаратын орон тооны дээд хязгаарыг офицер, улирагч 42, энгийн орон тооны ажилчин, албан хаагч 14, бүгд 56 хүнтэй байхаар тогтоосугай.

5. Архидалттай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх, түүнчлэх авилгал, эдийн засгийн шинжтэй гэмт хэргийг илрүүлэн шалгах үүрэг бүхий нэгжийг батлагдсан орон тоондоо багтаан зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга Ч.Амарболдод үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоо, бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 22–ны өдөр **Дугаар 181** **Улаанбаатар хот**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

-Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /архивын тасагтай/;
-Хууль зүйн хэлтэс;
-Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс;

-Үйлдвэр, худалдаа, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хэлтэс;
-Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг давхар хариуцуулсугай.

3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс шалтгаалан Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрыг 60 хүртэл, Архангай, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 55 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 35 хүртэл орон тоотой байхаар батлсугай.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан хэлтэс, албад байхаар тогтоосугай:

-Татварын хэлтэс;
-Гаалийн алба;
-Санхүүгийн хяналт шалгалтын алба;
-Статистикийн хэлтэс;
-Цэрэг, иргэний хамгаалалтын штаб;
-Цагдаагийн хэлтэс /газар/;
-Шүүхийн шийдвэр биелүүлэх алба;
-Гал түймэртэй тэмцэх алба;
-Эрүүл мэндийн газар /Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвтэй/;
-Нийгмийн даатгалын хэлтэс;
-Нийгмийн халамж, үйлчилгээний төв;
-Хөдөлмөр зохицуулалтын алба;
-Боловсрол, соёлын төв;
-Хүүхдийн төлөө төв;
-Биеийн тамир, спортын хороо;
-Хөдөө аж ахуйн газар;
-Мэргэжлийн хяналтын алба;
-Стандартчилал, хэмжил зүйн төв;
-Байгаль орчны алба /Ус, цаг уур, орчны шинжилгээний төвтэй/;
-Нийтлэг үйлчилгээний газар.

5. Хуульд заасан эрх хэмжээний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс болон Засаг даргын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлон хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 264 дүгээр тогтоолын 2,3,6 дугаар зүйл, "Төрийн архивын харьяаллын тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 207 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 116 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 182** **Улаанбаатар хот**

Ардын урлагийн их наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ардын хувьсгалын 80 жилийн ойг угтан Ардын урлагийн их наадмыг зохион байгуулсугай.

2. Ардын урлагийн их наадмыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлсугай.

3. Ардын урлагийн их наадмыг бэлтгэх, түүнийг зохион байгуулах арга хэмжээнд зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 20,5 /хорин сая таван зуун мянга/, Соёл урлагийн сангаас 40,2 /дөчин сая хоёр зуун мянга/, аймгуудын төсвөөс 14,3 /арван дөрвөн сая гурван зуун мянга/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 3,0 /гурван сая/ сая төгөрөг тус тус гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Ардын урлагийн их наадмыг сайтар зохион байгуулж бэлтгэл ажилд төрийн бус байгууллагуудыг татан оролцуулахыг Үндэсний хорооны дарга А.Цанжидад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 182 дугаар тогтоолын хавсралт

АРДЫН УРЛАГИЙН ИХ НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.ЦАНЖИД
Орлогч дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга Л.ЭРДЭНЭЧИМЭГ
Нарийн бичгийн дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны ахлах мэргэжилтэн Ц.ЖАРГАЛСАЙХАН
Гишүүд:	-Санхүү, эдийн засгийн дэд сайд Л.ЭНХТАЙВАН; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд Д.ТЭРБИШДАГВА; -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.ЭНХБОЛД; -Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.ГАНБОЛД; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга П.ГАНСҮХ; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга Ц.ЭНХБАТ; -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын дарга Г.НЯМСАМБУУ; -Соёл урлагийн сангийн гүйцэтгэх захирал Н.БЯМБАЖАВ; -Улсын дуурь бүжгийн академик театрын уран сайхны удирдагч, найруулагч Л.ЭРДЭНЭБУЛГАН.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 183** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "42. "Ардын авьяастан" хүндэт тэмдэг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Дугаар 184 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Эрчим хүчний шинэ эх үүсвэрээр хэрэглэгчдийг тасралтгүй ханган зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. «Шингэрүүлсэн шатдаг хий» хөтөлбөрийг хавсралт ёсоор батална.

2. «Шингэрүүлсэн шатдаг хий» хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2000 оны 184 дугаар тогтоолын хавсралт

"ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙ" ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

1. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах орчин үеийн шаардлагад зохицуулан XXI зууны шингэрүүлсэн шатдаг хийг ахуйн хэрэглээ болон карбюраторт хөдөлгүүртэй автомашинд өргөнөөр ашиглахыг эрмэлзэх болсон дэлхий нийтийн хандлагыг харгалзан эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох зорилгоор ахуйн хэрэглэгчид болон карбюраторт хөдөлгүүртэй автомашиныг шингэрүүлсэн шатдаг хийгээр ханган, ажил, үйлчилгээний сүлжээг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн ач холбогдол

2. Ой модны нөөц багатай манай орны нөхцөлд модыг түлшинд хэрэглэхийг багасгаж, байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалахад түлхэц болох эрчим хүчний харьцангуй хямд эх үүсвэр шинээр бий болно.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хот, хөдөөгийн хүн амд хоол унд бэлтгэх, дулаан гаргах, халуун ус зэрэг ахуйн хэрэгцээгээ хангана.

4. Карбюраторт хөдөлгүүрт автомашин бензинтэй зэрэгцүүлэн шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглэх боломж бүрдэж тээвэрийн ертөг буурч, ажил үйлчилгээний үнэ тариф хямдарч, хүн амыг ядуурлаас гаргах нэг нөхцөл бүрэлдэх болно. Мөн бензиний шаталтаас байгаль орчныг бохирдуулагч бүтээгдэхүүн агаарт хаягдах нь буурч, хортой үр дагавар багасна.

5. Хөдөөгийн хүн амын ахуйн нөхцөлийг сайжруулахад зөрэг нөлөө үзүүлнэ.

Гурав. Шингэрүүлсэн шатдаг хий хэрэглэж байгаа байдал

6. Олон оронд шингэрүүлсэн шатдаг хийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглаж байна. Сүүлийн жилүүдэд карбюраторт хөдөлгүүртэй автомашиныг шингэрүүлсэн шатдаг хийнд шилжүүлэн ажиллуулж байна.

7. Манай улсад шингэрүүлсэн шатдаг хийг ахуйн хэрэглээнд зориулан бага хэмжээгээр импортлон хэрэглэж байна.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

8. Шингэрүүлсэн шатдаг хийг хадгалах, тээвэрлэх, түгээх, ашиглах үед мөрдөх улсын стандарт, техникийн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлан гаргах /Дэд бүтцийн яам, Стандарт, хэмжил зүйн үндэсний төв/.

9. Шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны улсын хяналтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах (Дэд бүтцийн яам).

10. Шингэрүүлсэн шатдаг хийгээр улс орныг хангах сүлжээний схемийг боловсруулж, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх (Аж ахуйн нэгжүүд).

11. Шингэрүүлсэн шатдаг хийн барилга байгууламж (хий шахах станц, хий шахах төв, автомашинд шингэрүүлсэн шатдаг хий түгээх суурин ба хөдөлгөөнт станц, автомашиныг шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэх төв, шингэрүүлсэн хийн агуулах)–үүдыг холбогдох мэргэжлийн байгууллагаар зариулж, тоног төхөөрөмжийн

үгсралтыг хийлгэх (Аж ахуйн нэгжүүд).

12. Хийн аж ахуйг шаардагдах техник, тоног төхөөрөмж, автомашин, хэмжилтийн багаж хэрэгслээр хангах (Аж ахуйн нэгжүүд).

13. Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилчдыг бэлтгэх (Аж ахуйн нэгжүүд).

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

14. Улсыг хамарсан шингэрүүлсэн шатдаг хийн сүлжээний схемийг боловсруулах (2000 оны 12 дугаар сар).

15. Аж ахуйн нэгжүүд шатдаг хийн барилга байгууламж (хий шахах станц, хий шахах төв, автомашинд шингэрүүлсэн шатдаг хий түгээх суурин ба хөдөлгөөнт станц, автомашиныг шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэх төв, шингэрүүлсэн хийн агуулах)-ийн техникийн даалгаврыг боловсруулах (2000 оны 12 дугаар сар).

16. Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйг ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, техникийн нормативыг боловсруулж батлан мөрдөх (2001 оны эхний хагас).

17. Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйн иж бүрдэл, тоног төхөөрөмжийн сонголтыг хийж захиалах, худалдаж авах (2001 оны эхний хагас).

18. Дор дурдсан шингэрүүлсэн шатдаг хийн барилга байгууламжийн ажлыг 2001 оны II хагаст эхлүүлэх:

а/Улаанбаатарт шингэрүүлсэн шатдаг хий савлах станц барих;

б/Увс аймгийн Улаангом, Хэнтий аймгийн Өндөрхаанд шингэрүүлсэн шатдаг хий түгээх төв барих;

в/Улаанбаатар, Увс аймгийн Улаангомд автомашиныг шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг болгон шилжүүлэх төв байгуулах;

г/Улаанбаатар, Увс аймгийн Улаангом, Хэнтий аймгийн Өндөрхаан, Баянхонгорт авто хий түгээх суурин станц, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Завхан аймгийн Улиастай, Өмнөговь аймгийн Даланзадгадад авто хий түгээх хөдөлгөөнт станц барих;

д/Өвөрхангай аймгийн Арвайхээр, Завхан аймгийн Улиастай, Баянхонгор, Өмнөговь аймгийн Даланзадгад, Хэнтий аймгийн Өндархаанд баллонтай хий нөөцлөх агуулах барих.

19. Бусад аймгуудад шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйг байгуулах (2002-2005 онуудад).

20. Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйн сүлжээний барилга байгууламжийг хүлээн авч ашиглалтад оруулах (2001 оны IY улирал-2002 оны эхний хагас).

21. Ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, гадаадын мэргэжилтний сонголтыг хийж, гэрээгээр ажиллуулж эхлүүлэх (2001 оны I улирал).

Зургаа. Хөтөлберийн санхүүжилт

22. Хөтөлбөрийн санхүүжүүлэлтийг шингэрүүлсэн шатдаг хийн ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүд хариуцна.

Долоо. Үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлага

23. Шингэрүүлсэн шатдаг хийг тээвэрлэх, хадгалах, ашиглахад галын болон техникийн аюулгүй ажиллагааны онцгой шаардлага, нөхцөлийг харгалзан энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид Засгийн газрын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгоно.

24. Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуй, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Дэд бүтцийн сайдын эрхлэх ажлын хүрээн дэх агентлаг 5-аас доошгүй жилийн хугацаагаар олгоно.

25. Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуй, ажил, үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж доорхи үндсэн шаардлагуудыг хангасан байна:

а/шингэрүүлсэн шатдаг хийг

тээвэрлэх, хадгалах, ашиглах тэргүүний техник технологийг нэвтрүүлэх боломжтой байх;

б/шингэрүүлсэн шатдаг хийн ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийн ашиглах техник технологи нь батлагдсан техник технологийн нормативт хэмжээ, техникийн болон галын аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;

в/ажиллах боловсон хүчин, мэргэшсэн ажилчдыг урьдчилан бэлтгэсэн байх;

г/шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэхэд тухайн аж ахуйн нэгжид мөрдөх дүрэм, журмыг боловсруулан эрх бүхий байгууллагаар хянуулж баталсан байх;

д/шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйн тоног төхөөрөмж, шугам хоолой, савны үзэралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх гэрээ байгуулсан байх.

26. Хөтөлбөр хэрэгжсэнээр шингэрүүлсэн шатдаг хийгээр ахуйн хэрэглэгч болон карбюраторт хөдөлгүүр бүхий автомашиныг хангах сүлжээ бий болж, үйлчилгээний үйл ажиллагаа бүрэн хэмжээгээр явагдана.

27. Шингэрүүлсэн шатдаг хийг ахуйд өргөн хүрээтэй хэрэглэснээр эрчим хүчний шинэ нэр төрлийн эх үүсвэр бий болохын хамт хүн амын амьдрал, ахуйн нөхцөл улам сайжирна. Мөн ойн нөөцийг хамгаалж, байгаль орчны бохирдол багасгах болно.

28. Шингэрүүлсэн шатдаг хийг авто тээвэрт хэрэглэснээр хот хоорондын тээврийн өртөг хямдарч, ажил, үйлчилгээний үнэ, хөлс буурна.

29. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний газарт эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, тэдгээрийн үйл ажиллагаа тогтвортой явагдах нөхцөл сайжирна.

Найм. Хөтөлберийн үр дүн

30. Ажлын байр шинээр бий болгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 185** **Улаанбаатар хот**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1,3, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

а/ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;

б/ Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс;

в/ Санхүүгийн бодлогын хэлтэс;

г/ Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс;

д/ Хууль зүйн хэлтэс;

е/ Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг давхар хариуцуулсугай.

3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараахь байдлаар тогтоосугай:

а/ Инженерийн байгууламжийн хэлтэс;

б/ Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс;

в/ Хот тохижилтын хэлтэс;

г/ Мэргэжлийн хяналтын хэлтэс.

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 55 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг

43 хүртэл, нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-уул, Чингэлтэй дүүрэгт 42 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт 38 хүртэл, Багахангай дүүрэгт 23 хүртэл /үйлчилгээний орлогоос цалиньдаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ байхаар тогтоосугай.

5. Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай тохиролцсоны үндсэн дээр тогтоон мөрдүүлэхийг нийслэлийн Засаг даргад бөгөөд Улаанбаатар хотын Захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

6. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дараахь хэрэгжүүлэгч агентлагуудыг ажиллуулахаар тогтоосугай:

а/ Татварын газар;
б/ Өмчийн харилцааны газар;
в/ Хот байгуулалт, газрын харилцааны газар;
г/ Цагдаагийн газар;
д/ Цэрэг-иргэний хамгаалалтын штаб;
е/ Эрүүл мэндийн газар /Эрүүл мэндийн хяналтын албатай/;
ж/ Боловсролын газар;
з/ Соёлын газар;
и/ Санхүүгийн хяналт шалгалтын газар;
к/ Статистик, мэдээлэл, судалгааны газар;
л/ Нийгмийн даатгалын газар;
м/ Байгаль орчин, экологийн хяналтын газар;
н/ Биеийн тамир, спортын хороо;
о/ Хөдөлмөр, нийгмийн хамгаллын алба;
п/ Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
р/ Нийтлэг үйлчилгээний газар;
с/ Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн;
т/ Архивын алба;
у/ Гаалийн газар;
ү/ Мал эмнэлэг, хяналтын газар;
ф/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
х/ Гал түймэртэй тэмцэх хэлтэс.

7. Улаанбаатар хотын Захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд дараахь байгуллагуудыг ажиллуулахаар тогтоосугай:

а/ Ус суваг ашиглалтын газар;
б/ Орон сууц, нийтийн аж ахуйн газар;
в/ Хөрөнгө оруулалтын газар;
г/ Тээврийн газар;
д/ Халаалтын зуухны ашиглалтын газар;
е/ Үндэсний соёл амралтын хүрээлэн;
ж/ Иргэдэд үйлчлэх "Буян" компани;
з/ "Улаанбаатар зам засвар" компани;
и/ "Гэрэлтүүлэг-чимэглэл" компани;
к/ "Нөөц" компани;
л/ "Цэцэрлэгжилт" компани;
м/ "Улаанбаатар-ус" компани.

8. Нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, Захирагчийн харъяа газруудын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолын 2,3,5 дугаар зүйл, "Бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоол, "Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, "Төрийн архивын харьяалалын тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр тогтоол, "Тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2000 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 186** **Улаанбаатар хот**

Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн төв, нийслэлийн сургуулиудын нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг 1 дүгээр хавсралт, байршил хэв шинжээс нь хамааруулан бусад сургуулиудын нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тооцох итгэлцүүрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дотуур байранд амьдрах ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны /8 дугаар анги төгсөөд элссэн/ ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн 120589 төгрөгөөр, үүнээс хоолны зардал нь 105668 төгрөг байхаар тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн болон сурагчдын дотуур байрны цахилгаан, дулаан, ус, тээврийн зардлыг тухайн сургуулийн байршил, хэв шинжийг харгалзан орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг үндэслэн сургуулийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж байхыг төсвийн захирагч нарт даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 144 дүгээр тогтоол, "Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 97 дугаар тогтоолын 2,4 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 186 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨВ, НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛИУДЫН НЭГ СУРАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

	Нэг сурагчид ногдох хувьсах зардал /төгрөгөөр/		
	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Архангай	54794	66912	75004
Баян-өлгий	58150	72754	76138
Баянхонгор	55062	67194	75279
Булган	54794	66912	75004
Говь-алтай	55519	67644	75733
Дорноговь	54845	67844	75050
Дорнод	55062	67194	75279
Дундговь	54448	66568	74654
Завхан	55519	67644	75733
Өвөрхангай	54448	66568	74654
Өмнөговь	55012	68015	75217
Сүхбаатар	55062	68063	75279
Сэлэнгэ	54516	66634	74718
Төв	54259	66388	74465
Увс	55839	68845	76045
Ховд	55839	68845	76045
Хөвсгөл	55106	67225	75308
Хэнтий	54677	66789	74883
Дархан-уул	54063	66174	74260
Улаанбаатар	52966	65079	73167
Орхон	54163	66294	74364
Говьсүмбэр	54337	66451	74539

Тайлбар: "Аймгийн төв, нийслэлийн сургуулиудын нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээ"-нээс цалингийн сангийн эзлэх хэмжээ нь 74,5 хувь байна.

Засгийн газрын 2000 оны 186 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ТӨВ, НИЙСЛЭЛИЙНХЭЭС БУСАД СУРГУУЛИЙН НЭГ СУРАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИНГЭЦЧУУР

Аймгийн төв, нийслэлд байрладаг	Аймгийн төвөөс алслагдсан байдал			Сумын төвөөс алслагдсан байдал			Дээж эрхтэний болон олуул үхэлтэй суг үеийг тусган сурлуулиа
	50 хүртэлх км	50-150 км	150-аас дээш км	30 хүртэлх км - г орших газрын өвчлөлөөр онцлогийн бэлэнтэлийн сурлуулиа	30-аас дээш км - г орших газрын өвчлөлөөр онцлогийн бэлэнтэлийн сурлуулиа		
I бүс	II бүс	III бүс	IV бүс	V бүс	VI бүс		VII бүс
1,0	1,016	1,048	1,083	1,121	1,300		2,955

Тайлбар: Нийслэлийн Багаханай, Налайх, Гачуурт, Жаргалант, Сонгино, Биокомбинат, Төрхурах, Гавьяжийн шанд дахь сургуулиуд 2 дугаар бүсэд хамаарна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 187 | Улаанбаатар хот

Үндэсний хороог шинэчлэн байгуулах тухай

Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх талаархи Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах, үүнд салбар хоорондын үйл ажиллагаа, оролцоог чиглүүлэх зорилго бүхий Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороог шинэчлэн байгуулж бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хорооны ажиллах журам, Үндэсний хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

2. Дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх арга зэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, гадаад орон, олон улсын байгууллага, иргэдийн дэмжлэг туслалцаа, өргөн оролцоонд түшиглэн зохион байгуулж, үр дүнг жил тутам Засгийн газарт мэдээлж ажиллахыг Үндэсний хороонд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай" Засгийн газрын 1997 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 217 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2000 оны 187 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үндэсний хорооны дарга

-Монгол Улсын Ерөнхий сайд

Үндэсний хорооны орлогч дарга

- Эрүүл мэндийн сайд

Үндэсний хорооны нарийн бичгийн дарга

-Эрүүл мэндийн дэд сайд

Үндэсний хорооны гишүүд:

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;

-Батлан хамгаалахын дэд сайд;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;

-Гадаад хэргийн дэд сайд;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;

-Санхүү, эдийн засгийн дэд сайд;

-Үйлдвэр, худалдааны дэд сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;

-Гаалийн ерөнхий газрын дарга;

-Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга;

-Монголын Ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;

Засгийн газрын 2000 оны 187 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ, ХОРООНЫ ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо /цаашид Үндэсний хороо гэнэ/ нь дархлалын олдмол хомсдол өвчин /ДОХӨ/ болон бэлгийн замын халдварт өвчин /БЗХӨ/-өөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг гүйцэтгэх бөгөөд энэ ажилд яамд, холбогдох бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлнэ.

2. Үндэсний хорооны ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн яам гүйцэтгэнэ.

3. Дархлалын олдмол хомсдол өвчин болон бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх ажлыг аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий аймаг, нийслэлийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга батална. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг Үндэсний хороо батална.

4. Үндэсний хорооны хуралдааныг улирал тутам зохион байгуулна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Үндэсний хорооны гишүүдийн саналыг үндэслэн ажлын алба төлөвлөнө. Шаардлагатай үед ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулж болно.

5. Үндэсний хорооны хуралдаанаас дүгнэлт, зөвлөмж гаргах бөгөөд шаардлагатай асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлж болно.

Хоёр. Үндэсний хорооны эрх, үүрэг

1. Үндэсний хороо нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин болон бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үндэсний бодлого, стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд салбар хоорондын болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх;

б/ дархлалын олдмол хомсдол өвчин болон бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үндэсний бодлого, стратегийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх;

в/ дархлалын олдмол хомсдол өвчин болон бэлгийн замын халдварт өвчний байдлын талаар Засгийн газар, Монгол Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулах;

г/ дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэрэгцээг тодорхойлох, үүнд улсын төсвийн санхүүжилт, гадаад, дотоодын хандивлагчдын тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэх;

д/ дархлалын олдмол хомсдол өвчин болон бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх үндэсний чадавхийг сайжруулах арга хэмжээ авах.

2. Үндэсний хороо нь дараахь эрхийг эдэлнэ:

а/ дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай Монгол Улсын хууль, дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх талаарх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажилд холбогдох байгууллагуудыг хүлээсэн чиг үүргийн дагуу татан оролцуулах;

б/ шаардлагатай мэдээллүүдийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

в/ дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байгаа байгуллага, хувь хүмүүст хариуцлага хүлээлгэх талаар хууль хяналтын байгууллагад санал гаргах.

Гурав. Үндэсний хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарь

3. Үндэсний хорооны дарга, орлогч дарга нар дараахь үүрэг хүлээнэ:

а/ Үндэсний хорооны хуралдааны бэлтгэлийг хангуулж зарлан хуралдуулах, хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх талаар удирдамж, чиглэл, мэдээлэл өгөх;

б/ Үндэсний хорооны гишүүд болон аймаг, нийслэлийн салбар хороодын дарга нарт Үндэсний хорооны шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар үүрэг даалгавар өгч түүний биелэлтэд хяналт тавих;

в/ Үндэсний хорооны гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

г/ Үндэсний хорооны даргын эзгүйд орлогч дарга Үндэсний хорооны даргын үүргийг гүйцэтгэх.

4. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга

дараахь үүрэг хүлээнэ:

а/ Үндэсний хорооны ажлын төлөвлөгөөг гишүүдийн саналыг үндэслэн боловсруулж Үндэсний хорооны хуралдаанаар батлуулах, түүний хэрэгжилтийг гаргаж, Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх;

б/ Үндэсний хорооны хуралдааны зарыг хорооны гишүүдэд мэдэгдэж, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг хуралдаан эхлэхээс ажлын 3 өдрийн өмнө тэдэнд хүргүүлэх;

в/ хуралдааны тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэрийг Хорооны гишүүд, салбар зөвлөлүүдэд хүргэх;

г/ Үндэсний хорооны өдөр тутмын бичиг хэргийн ажлыг эрхлэн гүйцэтгэх.

5.Эрүүл мэндийн дэд сайд:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөрийг бусад холбогдох салбарын оролцоотойгоор боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах;

б/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

в/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, энэ чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх;

г/ гадаад орон, олон улсын байгууллагатай дээрх чиглэлээр идэвхитэй хамтын ажиллагаа өрнүүлэх;

д/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлийг удирдах;

е/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчний байдлын талаархи мэдээллээр Үндэсний хорооны гишүүд, хэвлэл мэдээллийн байгууллагыг хангах.

6. Батлан хамгаалахын дэд сайд:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлага олгох сургалтыг зохион байгуулах асуудлыг нэгтгэл, ангиудын цэргийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрт тусгах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

б/ хугацаат цэргийн албан хаагч, нийт бие бүрэлдэхүүнийг дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх;

в/ нэгтгэл, ангиудын эмч нарыг энэ чиглэлийн сургалтад хамруулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх түүнтэй тэмцэх асуудлаар хийгдэх судалгаа, шинжилгээний ажлын хүрээг өргөжүүлэх;

б/ бүх шатны сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн дагуу дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр заагдаж байгаа хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавих;

в/ сургууль завсардсан хүүхдүүдийг эрүүл мэндийн сургалт, сурталчилгаанд хамруулах арга хэмжээ авах;

г/ гадаадад суралцдаг оюутан сурагчдад дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замаар халдварлах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохиох, мэдээлэл өгөх ажлыг жил бүр зохион байгуулах.

8. Гадаад хэргийн дэд сайд:

а/ хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/-ийн халдвар илрүүлэх шинжилгээгээр сэжигтэй буюу халдвар авсан нь нотлогдсон, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн гадаадад түр болон удаан хугацаагаар амьдарч байгаа Монголын иргэд, манай оронд амьдарч байгаа гадаадын иргэдийн талаар харилцан мэдээлэх асуудлыг гадаад улсуудтай хийх гэрээ, хэлэлцээрт тусгаж, мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

б/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан болон дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн байж болзошгүй гадаадад амьдарч байгаа Монголын иргэдийн талаархи мэдээллийг мэргэжлийн байгууллагад хүргүүлэх.

9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд:

а/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан болон дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүмүүсийн нийгмийн хамгаллын асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах;

б/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар тээгч, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчлөгсдэтэй хамт ажиллаж байгаа болон тэдгээрт нийгмийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, нийгмийн хамгаллын баталгааг хангах эрх зүйн орчин бүрдүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

в/ гадаадад ажиллах хүч гаргах, гаднаас ажиллах хүч авах асуудлыг зохицуулахдаа хүний дархлал хомсдолын вирусийн болон бэлгийн замын өвчний халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан хүмүүст үйлчилгээ үзүүлэх асуудлыг холбогдох журам, зааварт тусган хэрэгжүүлэх.

10. Санхүү, эдийн засгийн дэд сайд:

а/ дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль, холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд болон хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, бэлгийн замын халдварт өвчнийг оношлох, эмчлэх, судлах зориулалтын оношлуур, эм, багаж хэрэгсэл авахад шаардагдах хөрөнгийг улс орныг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөө, төсөвт тусган шийдвэрлэж байх;

б/ гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөс дээрх арга хэмжээнд олгох боломжийг нэмэгдүүлэх талаар анхаарал тавих.

11. Худалдаа, үйлдвэрийн дэд сайд:

Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээнд шаардагдах багаж, тоног төхөөрөмж, сорьцын эталоныг импортоор оруулах болон худалдан авахад дэмжлэг үзүүлэх.

12. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд:

а/ Садар самуун явдалтай тэмцэх, дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг хянах үйл ажиллагааг сайжруулах;

б/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар тээгч, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн иргэний болон түүнтэй хамт ажиллагсад, түүнд үйлчилгээ үзүүлэгсдийн эрх үүрэг, нийгмийн хамгаллын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

в/ манай оронд амьдарч байгаа гадаадын иргэдийг шаардлагатай үзлэг, шинжилгээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэх;

г/ хорооны гишүүдийг энэ талаархи мэдээллээр хангах.

13. Гаалийн ерөнхий газрын дарга:

а/ хил, гаалиар хүний дархлал хомсдолын вирусийн халдвартай цус, цусан бүтээгдэхүүн болон мансууруулах бодис нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээ авах;

б/ мансууруулах бодистой холбоотой мэдээллээр хорооны гишүүдийг хангах.

14. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга:

Дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, эдгээрээс учирч болох аюулаас өөрийгөө хамгаалах талаар олон нийтэд системтэй мэдлэг олгохуй чиглэсэн сургалт, сурталчилгаа, мэдээллийн цагийг радио, телевизийн хөтөлбөрт нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

15. Цагдаагийн ерөнхий газрын дарга:

а/ дархлалын олдмол хомсдолын халдвар тараасан буюу халдвар авсан байж болох сэжигтэй этгээдийг эрэн сурвалжилж илрүүлэх;

б/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх тандалт, үзлэг шинжилгээнд дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замаар халдварлах өвчинд өртөх, тэдгээрийг тараах болзошгүй этгээдтэй бүлгийн хүмүүсийг оруулах, шаардлагатай бол албадан шинжлэхэд эрүүл мэндийн байгууллагад туслалцаа дэмжлэг үзүүлэх.

16. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх талаархи хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

б/ хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авах, өндөр эрсдэл бүхий бүлгийн хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, тэднийг үзлэг, шинжилгээнд өргөнөөр хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

17.Монголын Ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал:

а/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх ажилд төрийн бус байгууллага, олон нийтийн идэвхтэй оролцоог дэмжих, туслах;

б/ дархлалын олдмол хомсдол өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаархи мэдээлэл, сурталчилгааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 188** **Улаанбаатар хот**

Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Макро эдийн засгийн тогтворжилтыг бататгах, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, ерөнхий чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гадаад худалдааны хэлбэлзлийн хамаарлыг багасгах, удирдлагыг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батална.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2000 оны 188 дугаар тогтоолын хавсралт

ГАДААД ХУДАЛДААНЫ ХЭЛБЭЗЛИЙН ХАМААРЛЫГ БАГАСГАХ, УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөнхий зорилго

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний гол зорилго нь Монгол Улсын экспорт, импортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, үналт, гадаад худалдааны нөхцөлийн гэнэтийн өөрчлөлт, тэдгээрийн тус улсын эдийн засаг, нийгэм, хүн амын амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар Засгийн газраас богино (энэхүү төлөвлөгөө батлагдсаны дараахь 1 жилийн дотор) болон урт (энэхүү төлөвлөгөө батлагдсаны дараахь 4-5 жилийн дотор) хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгахад оршино.

Энэхүү төлөвлөгөө хэрэгжсэнээр Монгол Улсын макро эдийн засгийн тогтворжилтыг бататгах, зээлийн үнэлгээ дээшлэх, бизнесийн илүү таатай орчин бүрдэх, Монголын өрсөлдөх чадвар нэмэгдэхийн зэрэгцэх хүн амын амьжиргааны түвшин дээшлэх болно.

Үндэслэл

Монгол Улс цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанаас ихээхэн хамааралтай орон билээ. Монголын нийт экспорт (435 ам.доллар)-ын 58 хувийг зөвхөн гурван нэр төрлийн бүтээгдэхүүн эзэлж байна. Тухайлбал 1999 оны нийт экспортод эзэлэх баяжмал 25,9 хувь, мөнгөжөөгүй алт 22,2 хувь, ноолуур 10,0 хувийг тус тус эзэлж байна. Одоогоор Монгол Улс дэлхийн ноолуурын нийт үйлдвэрлэлийн 20 орчим хувийг эзэлж, сайн чанарын арьс шир, ноос болон мал аж ахуйн гаралтай бусад түүхий эдийг экспортолдог. Нефтийн бүтээгдэхүүн тус улсын импортын гол нэр төрөл бөгөөд 1999 оны байдлаар нийт импортын 16 хувийг эзэлж байна.

Экспортын цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн, нефтийн импорт болон гадаад худалдааны байгууллагуудын оновчтой бус зохион байгуулалтаас шалтгаалан 1998-1999 оны гадаад худалдааны нөхцөл нэлээд муудсан нь манай орны эдийн засгийн өсөлтийг сааруулж, хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлсэн.

Зэсийн үйлдвэрээс улсын төсөвт орууллаг албан татварын орлого ДНБ-ий 3 хувийг эзэлдэг байснаа 1998-1999 онуудад тэг хувь болон буурснаар үл барам зэсийн үйлдвэр өөрийн хэрэглээсэн үйлчилгээ, хангамж (эрчим хүч, тээвэр)-ийнхаа үнийг холбогдох байгууллагуудад нь төлөх чадваргүй болж эдгээр газрууд нь улсын төсөвт төлөх ёстой татвар, ногдол ашгаа төлж чадахгүй, бие биеэсээ хамаарсан өрийн сүлжээг үүсгэсэн. Ингэснээр 1997 онд ДНБ-ий 8,6 хувийг эзэлж байсан төсвийн алдагдал 1998 онд 11,7 хувь болж өссөн. Энэ нь дэд бүтцийг көгжүүлэхэд чиглэсэн улсын хөрөнгө оруулалтын чадавхийг бууруулан, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгоход хүндрэл учруулж, нийтийг хамарсан бусад арга хэмжээг санхүүжүүлэхэд зарим бэрхшээлүүдийг бий болгов. Төсвийн их хэмжээний алдагдал нь зээлийн хүүг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээг хумих, санхүүгийн салбарын хямрал (арилжааны банкны зээлийн 40 орчим хувь нь чанаргүй байна) үүсэхэд нөлөөлсөн. ДНБ-д гадаад худалдааны алдагдлын эзлэх хувь 1997 онд бага хэмжээтэй байсан бол 1998 онд 17,1 хувь, 1999 онд 10,1 хувь болж тус тус өссөн.

Импортын хувьд 1999 онд нефтийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ бараг хоёр дахин өссөнөөс шалтгаалан Монгол Улсын төөвэр болон газар тариалангийн салбар ихээхэн бэрхшээлтэй тулгарав. Үүнээс шалтгаалаад 1998 онд 6 хувь болж буурсан инфляцийн түвшин 1999 оны эцэст 10 хувь болж өссөн.

Монголын эдийн засгийн явцуу бааз суурь нь тус улсын зээлийн зэрэглэлд нөлөөлөв.

Зорилтууд

I. Бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн нөлөөллийг бууруулах зорилгоор санхүүгийн удирдлагыг сайжруулах.

П. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн орлого, зарлагыг тогтворжуулах, нэмэгдүүлэх.

Ш. Монголын экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.

IY. Экспорт болон төсвийн орлогын баазыг өртөтгөн тогтворжуулах зорилгоор Монголын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

Байгууллагуудын зохион байгуулалт

Үйл ажиллагааны энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах ажлыг Санхүү, эдийн засгийн яам зохицуулна.

Төр, засгийн үүрэг, оролцоо

Монголын эдийн засаг, төсвийн орлого нь экспортын цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс ихээхэн хамараалтайг төр, засаг анхааралдаа авч эрсдэлийг бууруулах талаар зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байх болно.

Зорилт нэг. Санхүүгийн удирдлагыг сайжруулах

Санхүүгийн удирдлагыг сайжруулснаар бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн нөлөөллийг бүрэн арилгана гэсэн үг биш юм. Гагцхүү дээрх арга хэмжээг иж бүрэн, цогц байдлаар хэрэгжүүлснээр төсвийн орлогын эх үүсвэрийг тогтвортой байлгаж, дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлд хэт мэдрэмтгий байдлыг багасгана.

Үр дүн 1.1. Төсвийн төсөл боловсруулах явцыг сайжруулах

Арга хэмжээ 1.1.1. Дэлхийн зах зээлийн үнийн хэтийн төлөвийг харгалзан төсвийн орлогын хэмжээг тооцох

Төсвийн төслийг боловсруулахдаа гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн хандлага, гадаадын санхүүжилтийн урсгал зэргийг аль болох үнэн бодитойгоор тооцож төсвийн орлогын хэмжээг зөв тодорхойлж, санхүүгийн хүндрэлээс хамааран хамгийн наад захын зайлшгүй санхүүжилтийг хасах, төлбөр хойшлуулсаар өр хуримтлуулах, мөнгийг их хэмжээгээр нийлүүлэх зэрэг бэрхшээлтэй тулгарахгүй байдлаар зарлага буюу санхүүжилтийг зөв зохистойгоор төлөвлөх нь чухал юм. Төсвийн төслийг боловсруулахдаа үнийн ямар түвшинг, ямар эх сурвалжаас ашигласан, мөн гадаад санхүүжилтийг нарийвчлан тусгаж, аль болох орлого, зарлагын санхүүжилтийг тэнцвэржүүлж, банкны байгууллагаас авах зээлийн хэмжээг хязгаарлах бодлого баримтална. Одоогоор банкнаас Засгийн газрын авсан зээлийн хэмжээ ДНБ-ийн 3 хувьтай тэнцэх буйг тэглэхийг зорино.

Арга хэмжээ 1.1.2. Төсвийн зарлагыг улирал тутам шинэчлэн тооцож байх зарчим, арга механизмыг нэвтрүүлэх

Богино хугацааны буюу улирлын үнийн хэтийн тооцоо нь жилийнхээс илүү бодитой байдаг. Одоогоор жилд нэг удаа төсөв боловсруулж байгаа нь үнийн нөлөөллийг тэр болгон бодитой тусгаж чадахгүй байна. Иймээс гол нэр төрлийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн улирлын хэлбэлзэл дээр үндэслэн төсвийн орлогын хэмжээг тооцон тодорхойлж, харин зарлагыг орлоготой нь уялдуулан төлөвлөх механизмыг бүрдүүлж хянаж байх тогтолцоо нэвтрүүлэх нь чухал юм. Ингэснээр төсөвт үзүүлэх үнийн нөлөөллийн хэмжээг аль болох бага дээр нь засах боломжийг олгоно.

Арга хэмжээ 1.1.3. Өмч хувьчлалын Trust Сан

Одоогоор өмч хувьчлалаас орж буй нийт орлого (ДНБ-ий 1,8 хувьтай тэнцэх)-ыг төсвийн дансанд төвлөрүүлэн зарцуулж байна. Гэхдээ өмч хувьчлалын орлого байнга биш, татварын орлого энэхүү эх үүсвэрийг нөхөх боломжгүйг харгалзан улсын төсвийн ирээдүйн тогтвортой байдал, санхүүжилтийг

хангах зорилгоор Өмч хувьчлалын Trust сан байгуулах нь зүйтэй юм. Энэхүү сангийн анхны эх үүсвэрийг өмч хувьчлалын орлогоос бүрдүүлж, зарцуулалтыг Засгийн газар шийдвэрлэж байна. Хэрэв энэхүү сангийн хөрөнгийг гадаадад байршуулбал төсвийн орлогын бие даасан байдал, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс хамаарах хамаарлыг багасгах болно. Одоогоор нэлээд олон томоохон аж ахуйн нэгжүүд улсын мэдэлд байгаа бөгөөд энэ асуудлыг Засгийн газар дунд хугацаанд судалж шийдвэрлэнэ.

Үр дүн 1.2. Татварын тогтолцоог хялбаршуулж, татварын суурийг өргөтгөх

Арга хэмжээ 1.2.1. Татварын чөлөөлөлтийг багасгах

Одоогийн мөрдөж буй татварын хуулиуд нь татварын олон төрлийн хөнгөлөлт чөлөөлөлтийг олгодог бөгөөд эдгээр нь тэр болгон шаардлагатай биш юм. Дээрх чөлөөлөлтийг багасгах, төсвийн орлогын эх үүсвэрийг тогтворжуулах, татварын дарамтыг татвар төлөгчдийн дотор аль болох тэгш хуваарилах зорилгоор одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийг дахин хянах нь чухал юм. Гэхдээ эцсийн шийдвэрийг гаргахдаа нэлээд хянамгай хандаж бусад хууль, тогтоомжтой уялдуулах нь чухал.

Арга хэмжээ 1.2.2. Татвар цуглуулалтыг сайжруулж, аж ахуйн нэгжийн албан татварын бүтцийг боловсронгуй болгох

Одоогийн мөрдөж буй аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь 15 ба 40 хувь гэсэн хоёр шатлалтай байна. Энэхүү татварын их ялгаа нь цөөн тооны татвар төлөгчдийн нуруун дээр тохогдож байгаа. Энэ байдлаас зайлсхийх зорилгоор аж ахуйн нэгжүүд олон жижиг компани, аж ахуйн нэгжид хуваагдан татвар цуглуулах ажлыг хүндрүүлдэг. Иймээс төр, засгийн зүгээс улс, орны санхүүгийн ерөнхий чадавхид тохирсон, татвар төлөгчдийн хэтэрхий их ялгааг багасгахад чиглэсэн арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Арга хэмжээ 1.2.3. Татварын суурийг өргөтгөх

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад албан бус салбар өсч байна. Тэдгээрийн зарим нь жижиг хувийн бизнес эрхлэх хүрээнээс халин аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх хэмжээний бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна. Хэдийгээр тэдгээрийг бүртгэж татвар авахад бэрхшээлтэй боловч эдгээр аж ахуйн нэгжийг орлогын албан татвар төлөх хэмжээнд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ авах нь чухал юм. Ингэхдээ нөгөө талаас хамгийн түргэн хөгжиж, олон хүнийг ажлын байраар хангаж буй хувийн жижиг албан бус салбарыг татвараар боогдуулахгүй байх талаар анхаарах нь зүйтэй юм.

Арга хэмжээ 1.2.4. Татвар төлөгч томоохон аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцсан захиргааны нэгжийг байгуулах

Төвлөрсөн болон орон нутгийн төсөвт татвар төлөгчдийн төвлөрлийг сааруулах асуудал Төсвийн тухай хуульд тусгагдсан. Татаасыг бөөнөөр олгодог санхүүжилтийн өнөөгийн тогтолцооны үед глобаль татварын орлогын төвлөрсөн хяналт-шинжилгээ тэр бүр байхгүй болно. Үндэсний татварын ерөнхий газарт татвар төлөгч томоохон аж ахуйн нэгжийн хэлтсийг байгуулснаар орон нутгийн болон Засгийн газрын хооронд гардаг элдэв маргааныг шийдвэрлэхээс гадна татварын байцаагч нарын хоорондхи харилцааг сайжруулж улмаар татвар хураалтыг эрчимжүүлнэ.

Үр дүн 1.3 Татварын албыг бэхжүүлэх

Арга хэмжээ 1.3.1. Татварын хяналтын албыг хүчтэй болгох

Ил тод, тогтвортой байдал, албадлагыг бий болгосноор татварын тогтолцооны утга агуулгыг өндөржүүлж, улмаар төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ 1.3.2 Татвараас зайлсхийх явдалтай тэмцэх

Татвар хураалтыг сайжруулснаар

төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Үндэсний татварын ерөнхий газрын хүчин чадлыг нэмэгдүүлж татварын байцаагч нарт урамшуулал үзүүлснээр татвар хураалтыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ 1.3.3 Компьютерийн программ техник хангамжийг сайжруулах, татвар, гаалийн байгууллагуудын хооронд мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх

Мэдээллийн солилцоо дутмаг, мэдээллийг боловсруулах чадварын дорой байдал нь татварын албаны хүчин чадлыг нэмэгдүүлсэн ч татвар хураалтыг сайжруулж, татвараас зайлсхийх бололцоог хааж чадахгүй байна. Мөн тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал нь Үндэсний татварын ерөнхий газрын үйл ажиллагааг сулруулж байна. Хэдийгээр сүлжээ байгуулах ажил эхлэн тодий байгаа ч цаашид Үндэсний татварын ерөнхий газрын нэгдсэн сүлжээг байгуулах үйл ажиллагаанд илүү их анхаарал тавих нь чухал юм.

Зорилт хоёр. Гол нэр төрлийн барааны орлого, зарлагыг тогтворжуулах, нэмэгдүүлэх нь

Зэс, алтны уурхай болон ноолуурын үйлдвэрлэл нь дунд хугацааны гадаад худалдаа, бараа солилцооны гол эх үүсвэр хэвээр байх болно. Нөгөө талаас гол зарлага нь нефть бүтээгдэхүүний импорт байхаар байна. Засгийн газар зах зээлийн хамгийн ашигтай арга хэрэглэх замаар барааны үнийн өөрчлөлтийн төсөвт учруулах нөлөөллийг багасгах ёстой. Мөн түүнчлэн үр ашиггүй ажиллаж байгаа томоохон улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах хэрэгтэй юм. Ноолуурын үйлдвэрлэлийн салбарт нэмүү өртгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь эрхэм зорилго болж байна.

Үр дүн 2.1 Экспортын барааны үнийн хэлбэлзлийн эрсдлийг багасгах оновчтой арга замыг хэрэжүүлэх

Арга хэмжээ 2.1.1. Зах зээлийн аргууд

Засгийн газруудын болон Олон улсын санхүүгийн компаниуд экспортын барааны орлого болон зарлагыг тогтворжуулахын тулд зах зээлд үндэслэсэн арга хэрэгслүүдийг авч хэрэглэсээр ирсэн билээ. Цаашид Монголын нөхцөлд бүх төрлийн эрсдэл, зардал, ашгийг хамарсан арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх боломжийг Засгийн газрын зүгээс судлах нь зүйтэй юм.

Арга хэмжээ 2.1.2. Олон улсын шилдэг туршлагууд

Монгол Улс бол цөөн нэрийн экспортын барааны орлогоос хамааралтай цорын ганц орон биш юм. Экспортын цөөн нэрийн барааны орлогоос ихээхэн хамааралтай бусад орнуудад хэрэглэдэг орлогын менежментийн аргуудтай Засгийн газар танилцаж, тэдгээр орнуудын амжилттай хэрэглэж буй төрөл бүрийн арга хэрэгслүүдийг авч хэрэглэх, боломжийг судлах хэрэгтэй юм.

Арга хэмжээ 2.1.3. Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх

Засгийн газрын ажилтнууд, Эрдэнэт болон эдгээр арга хэрэгслүүдийг хэрэжүүлж болох бизнесийн хүрээнд хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх замаар боломжит эрсдэл, зардал, ашгийн төрөл бүрийн арга хэрэгслүүдийн талаар илүү их ойлголт, мэдлэгтэй болох шаардлагатай байна. Одоогийн орлогын менежментийн арга хэмжээнүүдийг улам боловсронгуй болгохын тулд ажилтнуудыг сургах нь зайлшгүй чухал юм.

Үр дүн 2.2 Экспортын барааны салбар дахь улсын үйлдвэрийн газрын үр ашиг ба ил тод байдлыг дээшлүүлэх

Арга хэмжээ 2.2.1. Улсын үйлдвэрийн газрыг хувьчлах

Улсын том үйлдвэрийн газруудад бүрэн хэмжээний аудит хийлгэх нь тэдгээрийн үр ашгийг дээшлүүлэх, хувьчлалд бэлдэх эхний алхам болно. Цаашдын зорилго нь улсын үйлдвэрийн газруудыг бүрэн хувьчлах явдал юм.

Арга хэмжээ 2.2.2. Олон улсын зөвлөх компанийг сонгож Эрдэнэт үйлдвэрийн үр ашиг, менежментийн үнэлгээг тодорхойлох

Эрдэнэт үйлдвэр нь манай эдийн засагт чухал нөлөөтэй тул менежмент болон үйлдвэрлэлийн үр ашгийг шалгаж, үнэлж өгснөөрөө ил тод байдлыг сайжруулж цаашдын үр ашгийг нэмэгдүүлэх юм.

Үр дүн 2.3 Нэмүү өртгийн өсөлтийг дэмжих

Арга хэмжээ 2.3.1 Монголын ноолуурын чанарыг дээшлүүлэх

Нийлүүлэлтийн бүх түвшин дэх ноолуурын чанарын сайжралт нь энэ сүлжээнд оролцож буй бүх оролцогчдын орлогыг нэмэгдүүлнэ. Чанарыг дээшлүүлэхийн тулд төрөл бүрийн арга хэрэглэж болох ба сургалт явуулах шаардлагатай юм. Чанарыг сайжруулах үйл ажиллагааны гол нь ноолуурын стандартыг мөрдөж, нийлүүлэлтийн бүх шатанд чанарын хяналтын баталгааг нэвтрүүлэх явдал чухал юм.

Арга хэмжээ 2.3.2. Дэлхийн зах зээл дээр Монголын ноолуурыг таргах

Дэлхийн зах зээл дээр Монголын ноолуурыг улам их хэмжээгээр гаргахын тулд зах зээлийн зөв зохистой бодлого явуулж, дэлхийн зах зээл дээрх нэр хүндийг нь дээшлүүлснээр ноолуурын салбараас орох орлогыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ 2.3.3. Хөрөнгө оруулалтын урамшууллын өнөөгийн системийн талаар дэлгэрэнгүй тойм бэлтгэх

Ноолуур нь зөвхөн улсад нэлээд хэмжээний орлого оруулдаг тедийгүй бас хүн амын нэлээд хэсгийг ажлын байраар хангаж байдаг стратегийн чухал салбар юм. Нэг талаас малчид өөрсдийн түүхий эдийг өндөр үнэ хүргэх нээлттэй худалдааны орчин байгаа нь чухал боловч нөгөө талаас энэ нь ноолуурын үйлдвэрлэл хөгжихөд ихээхэн хохирол учруулж байгаа юм. Иймд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрлэгчдэд Засгийн газар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар дотоодын ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих нь чухал юм.

Зорилт гурав. Монгол Улсын экспортын нэр төрлийг олшруулах

Эдийн засгийн явцуу бааз суурийг өргөтгөснөөр орлогын хязгаарлагдмал эх үүсвэрт тулгуурласан төсвийн хараат байдал багасна. Үүнд, экспортын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий болгохыг дэмжих, экспортын чиглэлтэй үйлдвэрүүдийг шинэ зах зээл рүү чиглүүлэх явдал юм.

Үр дүн 3.1 Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Арга хэмжээ 3.1.1 Монгол Улсын харьцангуй давуу талыг нягт судалж зөвлөмжийг боловсруулан гаргах

Монгол Улс байгалийн асар их нөөцтэй юм. Гэвч Монгол Улс дэвшин хөгжихөд байгалийн нөөц баялгаас гадна аялал жуулчлал, боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний салбарын потенциалыг бүрэн үнэлж, дүгнэн илүү их судалгаа хийх шаардлагатай байна.

Арга хэмжээ 3.1.2 Экспортыг дэмжих нэгжийг байгуулах

Монгол Улсын тухай мэдээлэл хомс байгаа нь тус улсын экспортын өсөлтийг сааруулж байна. Иймээс бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжийг олон улсын байгууллагатай холбож мэдээллээр хангах зорилготой Экспортыг дэмжих нэгжийг Засгийн газар бий болгоно.

Үр дүн 3.2 Зах зээлийг шинээр нээх

Арга хэмжээ 3.2.1 Чанарыг сайжруулах

Экспортын бүтээгдэхүүний чанарыг сайжруулах арга хэмжээ нь хоёр талын чиглэлтэй. Нэгд, олон улсын стандартын шаардлагын дагуу бүтээгдэхүүний чанарт мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гаргах, нөгөө талаас бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад зохих урамшууллын хөшүүрэг хэрэглэх хэрэгтэй.

Экспортын чанартай бүтээгдэхүүн гэсэн шагналыг бий болгох, мах, махан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, чанар

шалгагчдыг сургалтанд хамруулах, салбар бүрт бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг баталгаажуулах Засгийн газрын албыг бий болгох (ялангуяа мах боловсруулах салбар), үүний дотор аялал жуулчлалын салбарт төрөл бүрийн сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

Зорилт дөрөв. Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

Харьцангуй давуу талаас өрсөлдөөнт давуу тал руу шилжихдээ Монгол Улс бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэлхийн томоохон хөөрөх зах зээл болох Орос, Хятад улстай хөрш зэрэгцдээ оршиж байгаа байдлыг ашиглах шаардлагатай байна.

Эдийн засгийн үйл явц, экспорт, хөрөнгө оруулалт, санхүүгийн салбар, бодлогын орчин, шинжлэх ухаан, технологи, дэд бүтэц, боловсон хүчний нөөцийн салбар дахь өрсөлдөөнийг тодорхойлдог олон үзүүлэлтүүдээрээ Монгол Улс хамгийн доод буюу доогуур байр эзэлдэг байна. Банкны тогтолцооны тогтвортой бус байдлаас шалтгаалан Монгол Улс нэлээд доогуур байр эзэлж байна. Нээлттэй байдлаараа Монгол Улс нэлээд дээгүүр орж, эрдэмтэн, инженерүүдээрээ дундаж хэмжээнээс бага зэргээр дээгүүр байгаа юм.

Үр дүн 4.1. Өрсөлдөөнийг сайжруулах арга барилыг тодорхойлох

Арга хэмжээ 4.1.1. Монгол Улсын өрсөлдөх чадварын өнөөгийн байдлыг дэлгэрэнгүй судалж, түүнийг сайжруулах арга замыг тодорхойлох

Засгийн газар Монгол орны бизнесийн өнөөгийн орчныг дахин хянаж бусад орнуудынхтай харьцуулалт хийнэ. Үүний үндсэн дээр тус улсын өрсөлдөх чадварыг эрчимжүүлэх арга замыг тодорхойлно.

Үр дүн 4.2 Нээлттэй байдал

Арга хэмжээ 4.2.1 Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжуудыг дахин нарийвчлан хянаж үзэх

Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулснаар Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэн шинэ зах зээл, ноу хау, санхүүжилт, хөрөнгө оруулалт болон бусад боломжууд бүрдэж улмаар өөрийн зах зээлийг дэлхийн зах зээлтэй холбож өгөх болно.

Үр дүн 4.3 Бизнесийн орчныг сайжруулах

Арга хэмжээ 4.3.1 Эрчим хүчний салбарын шинэчлэлт

Эрчим хүч үйлдвэрлэж, дамжуулах явдлыг зах зээлийн харилцаанд оруулах, Эрчим хүчний удирдах газарт хуваарилалтын болон хяналтын бие даасан алба зохион байгуулах зэрэг эрчим хүчний салбарын шинэчлэлт нь бизнесийн орчныг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой. Жишээлбэл, эрчим хүч (цахилгаан, дулаан)-ний тогтвортой, найдвартай хангамж, боломжийн үнэ нь одоо эрхэлж буй бизнесийн тогтвортой байдлыг бататгаж, аз турших шинээр бизнес эрхлэх гэсэн тэдний бэлэн байдалд зохих дэмжлэг үзүүлэх болно.

Арга хэмжээ 4.3.2 Бизнесийн байгууллагын мэдээллийн хангамжийг сайжруулах

Цахилгаан, холбооны үйлчилгээ, мэдээллийн хангамжийг сайжруулснаар эдийн засгийн чухал салбаруудад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ 4.3.3 Газрын судалгаа явуулах, холбогдох мэдээллийг хэвлэх

Ашигт малтмалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ашигт малтмалын нөөц, тусгай хамгаалалтад авсан газрын судалгаа, мэдээллийн хомсдол ихээхэн саад учруулж байна.

Үр дүн 4.4 Зохион байгуулалт

Арга хэмжээ 4.4.1 Авилгалтай тэмцэх

Засгийн газар аливаа асуудлыг шийдвэрлэхэд авилгал нь дэмжлэг болох бус харин хүндрэл учруулах эхлэл болдог.

Авилгалтай тэмцэх үйл ажиллагаат Засгийн газар бүхий л шатандаа явуулах болно.

Арга хэмжээ 4.4.2 Засгийн газрын байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх

Засгийн газар нь сургалт, дахин сургалтыг нэмэгдүүлж, урамшуллын системийг дэмжих замаар хүний нөөцийн хөгжлийг хангах тодорхой төлөвлөгөөг авч хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ 4.4.3. Хууль, эрх зүй, удирдлага, шүүх тогтолцоог боловсронгуй болгох

Засгийн газар нь бодлого болон зохицуулалтын уялдааг хангана. Мөн макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх, түүнчлэн худалдааны зохицуулалтыг хангахын зэрэгцээгээр олон улсын худалдааны тогтолцоо, түүний туршлагатай уялдуулна. Бодлогын уялдаа, хяналт нь тогтвортой, тууштай байна.

Арга хэмжээ 4.4.4. Экспорт болон эдийн засгийг хөгжүүлэхэд саад болж буй захиргааны бэрхшээлүүдийг устгах

Аливаа үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл авах ажилд нэлээд хүндрэл, чирэгдэл учирдаг. Иймээс энэ чиглэлийн үйл ажиллагаанд боловсронгуй болгоно.

Үр дүн 4.5. Санхүүгийн салбарыг бэхжүүлэх

Энэхүү асуудалтай холбогдох арга хэмжээ нь Санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд явагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 189** **Улаанбаатар хот**

Зудын цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Төвийн болон баруун зарим аймгийн нутагт зуд болж, мал өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд ДААЛГАХ НЬ:

а/ улсын нөөцөд төвлөрүүлэх өвс, тэжээлийг мал өвөлжилтийн байдал хүндэрч байгаа аймгуудын саналыг үндэслэн зохих графикийн дагуу тээвэрлэн байршуулах, тэдгээрийг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр хуваарилан хүргүүлэх арга хэмжээ авч байсугай;

б/ зарим аймагт мал өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан малын эм бэлдмэл, био идэвхт болон сүү орлох тэжээлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад захиалга өгч үйлдвэрлүүлэн шаардлагатай аймгуудад хүргүүлсүгэй;

в/ өвөлжилтийн байдал хүндэрсэн аймгуудад улсын нөөцөөс эхний ээлжинд өвс, тэжээлийг урьдчилан үнэгүйгээр хүргүүлж, уг нөөцийг тусламжийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлсүгэй.

2. Зудтай байгаа аймаг, сумдын хүн эмнэлгийг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн материалын нөөцтэй болгох, малчдад үзүүлэх эмнэлгийн тусламжийн үйлчилгээг сайжруулах, сум, багийг богино долгионы холбооны хэрэгслээр хангах ажлыг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

3. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын оюутгай комиссын дарга Ж.Гүррагчаад ДААЛГАХ нь:

а/ туулах чадвар сайтай машин механизмын цуваа, хүн хүчийг 12 дугаар сарын 10-наас эхлэн тодорхой хугацаагаар дайчлан гаргаж, өвөлжилтийн байдал хүндэрсэн нутгаас малчдыг нүүлгэн

ашилжүүлэх, түлш шатахуун, өвс, тэжээл тээвэрлэх, зам гарц гаргах болон малчдад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд туслуулахаар Увс, Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймагт ажиллуулсугай;

б/ өвөлжилт хүндэрсэн аймаг, сум, малчдад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажилд Монголын улаан загалмайн нийгэмлэг, түүний орон нутгийн байгууллагыг татан оролцуулах арга хэлбэрийн талаар тохиролцон хэрэгжүүлсүгэй.

4. Авто тээврийн зарим зам, даваа хаагдсанаас мал өвөлжилтийн байдал хүндэрч байгаа аймгуудад баталгаатайгаас бусад замаар түлш, шатахуун, өвс, тэжээл тээвэрлэн хүргүүлэх, байршуулах, хүн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, нүүдэл хийх, түүнчлэн зам, даваанд гарц гаргахад зарцуулсан нэмэгдэл хөрөнгийг холбогдох яамд, аймгуудаас гаргасан тооцоо, ажлын гүйцэтгэл, бусад баримтыг үндэслэн зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

5. Аймгийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

а/ орон нутгийнхаа мал өвөлжилтийн байдалд бодитой дүгнэлт хийж, отор нүүдлийг оновчтой зохион байгуулсугай;

б/ инженерийн болон энгийн, уурхайн худгийг арчлах, хамгаалах, дулаалах, ялангуяа отрын нутгууд дахь усны хангамжийг сайжруулах арга хэмжээг дотоод нөөц болопцоогоо дайчлан шуурхай авч хэрэгжүүлсүгэй;

в/ мал тооллогын үеэр өвөлжилт хүндэрсэн сум, багт бодитой мэдээлэл хүргэх, тэднээс мэдээлэл авах, иргэдэд бүх талын дэмжлэг, тусламж үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

г/ тусламжаар үнэгүй олгож байгаа болон улсын нөөцөөс худалдах өвс, тэжээлийг цаг хугацааны ялгаатайгаар хуваарилан хүргүүлэх, энэ талаар малчдад сайтар таниулан ойлгуулах арга хэмжээ авсугай.

6. Манай оронд тохиолдож байгаа өвөлжилтийн хүндрэл, түүнээс хүлээж болзошгүй хохирлыг арилгах, урьдчилан сэргийлэхэд зориулан хандив, тусламж авах хүсэлтийн талаар Монгол Улсаас гадаад оронд суугаа, мөн гадаад орноос манай улсад суугаа Элчин сайдын яамд болон НҮБ-аас манай оронд суугаа Суурин төлөөлөгчийн газраар дамжуулан гадаад орон, олон улсын байгууллагуудад уламжлахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

7. Зудын хор уршиг, хохирлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дотоод, гадаадад бодитой мэдээлэл өгч байхын зэрэгцээгээр цагийн байдал хүндэрсэн үед мал сүргийг арчлах, хамгаалах, тэжээж тэнхрүүлэх зэрэг арга технологи, уламжлалын талаар цуврал хичээл, сургалт явуулахыг Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

8. Зуданд нэрвэгдэж байгаа аймаг, сумд, малчдад туслах хөдөлгөөнийг нийслэл дэх нутгийн зөвлөл, аж ахуйн нэгж, байгууллагын шугамаар хэрэгжүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны хоёрдугаар сарын 5 №5 (2322)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

41. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай (2001-1-25-ны хууль) 115
42. Гэрээ соёрхон батлах тухай (2001-1-25-ны хууль) 116
43. Конвенцид нэгдэн орох тухай (2001-1-25-ны хууль) 116

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

44. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 07 116
45. Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай Дугаар 08 116
46. Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай Дугаар 09 116
47. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 10 117
48. Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 11 129

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

49. Ган, зуд, ус, цаг агаарын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 190 129
50. Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 191 134
51. Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын VIII хуралдааны дүнгийн тухай Дугаар 192 140

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын 2 дахь догол мөрний өмнө дор дурдсан агуулгатай өгүүлбэр шинээр нэмсүгэй:

"Банкны зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцно."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. 1998 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, СОС Киндердорф Интернациональ олон улсын байгууллагын хооронд "СОС хүүхдийн хотхон" байгуулахтай холбогдсон төслүүд хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр — **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. 1988 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Вена хотноо батлагдсан "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг" Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсныг соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр — **Дугаар 07** — **Улаанбаатар хот**

Байгуын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ц.Өөлдийн хүсэлтийг харгалзан Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр — **Дугаар 08** — **Улаанбаатар хот**

Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, төсвийн цаг зуурын хүндрэлийг давах, төсвийн алдагдлын тодорхой хэсгийг дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх зорилгоор 2001 оны санхүүгийн жилд улирал тутам 10.0 /арав/ хүртэл тэрбум төгрөгийн бонд гаргаж, нийтэд санал болгон худалдахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр — **Дугаар 09** — **Улаанбаатар хот**

Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай

Монгол Улс хөрш зэрэлдээ болон бүс нутгийн орнуудтай хамгийн дөт замаар харьцах, далайд гарцтай болох боломж бүрдүүлэх, дотоодын дэд бүтцийн нэгдмэл сүлжээ бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн автозам буюу Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийг хавсралт ёсоор батлалсугай.

2. Мянганы зам барихад дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг ашиглах, хандивлагч орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагын дэмжлэг туслалцааг авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3. Мянганы зам барих ажлыг бүх ард түмний үйл хэрэг хэмээн үзэж иргэн бүр хувь нэмрээ оруулахыг уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 09 дүгээр тогтоолын хавсралт

НЭГ. УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨНДЛӨН ГОЛ ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМ БУЮУ МЯНГАНЫ ЗАМЫН ЧИГЛЭЛ

Баруун чиглэл:

Улаанбаатар-Лүн-Дашинчилэн-Өгийн доод гүүр-Батцэнгэл-Хануйн гүүр-Тариат-Цахир-Загастайн зүүн эхний даваа-Идэр-Яруу-Эрдэнэхайрхан-Завхан-Тээлийн бэлчир-Дөргөн-Мянгад-Өлгий-Цагааннуур-Улаанбайшинт.

Зүүн чиглэл:

Улаанбаатар-Налайх-Баяндаваа-Эрдэнэ-Багануур-Өндөрхаан-Хэрлэнгийн гүүр-Наран саран-Хургалж ухаа овоо-Адаг дулаан-Сүмбэр.

ХОЁР. ДЭД БҮТЦИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН ЧИГЛЭЛ

1. Боршоогийн боомтоос Улаангом, Ховдыг дамжин Ярантайн боомтоор гарах тэнхлэг

2. Ханхын боомтоос Мөрөн, Улиастай, Алтайг дамжин Бургастайн боомтоор гарах тэнхлэг.

3. Бага-Илэнхийн боомтоос Булган, Хархорин, Арвайхээрийг дамжин Баянхонгорыг хамран Шивээ хүрэнгийн боомтоор гарах тэнхлэг

4. Алтанбулагийн боомтоос Сүхбаатар, Дархан, Улаанбаатар, Чойрыг дамжин Мандалговь-Тавантолгой-Даланзадгадыг хамран Сайншанд, Замын-Үүдийн боомтоор гарах тэнхлэг

5. Эрээнцавын боомтоос Чойбалсан, Баруун-Уртаар дамжин Бичигтийн боомтоор гарах тэнхлэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр **Дугаар 10** **Улаанбаатар хот**

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлалсугай.

2.Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхтэй холбогдон дараахь арга хэмжээ авч, Улсын Их Хуралд 2001 оны эхний хагас жилд багтаан танилцуулахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

а/өмч хувьчлалын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалгаж, холбогдох арга хэмжээ авах;

б/тодорхой нөхцөлийн дагуу хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх.

3. Нийгмийн салбарын хувьчлалын асуудлыг зохицуулахтай холбогдсон хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд 2001 оны 3 дугаар сард багтаан өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо/Т.Очирхүү/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ 2001-2004 ОНД ХУВЬЧЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн өмч хувьчлалын зорилго

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн зорилго нь өмч хувьчлалыг улам эрчимжүүлж, хувийн өмчийн оролцоог нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өсөлтийг хангах, улмаар хүн амын аж амьдралыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл нь хувьчлалын талаар баримтлах төрийн бодлого, энэ ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх зарчим, арга хэлбэрийг тодорхойлж байгаа стратегийн шинж чанартай, Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, агентлаг болон бусад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд дагаж мөрдвөл зохих баримт бичиг мөн.

1.2.Төрийн өмчийг хувьчлахад баримтлах нийтлэг зарчим

Төрийн өмчийг хувьчлахад дараахь нийтлэг зарчмыг баримтална:

-эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх үндсэн дээр үйлдвэрлэлийн үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хувьчлалын дараа төсвийн орлогыг бууруулахгүй байх;

-тухайн салбарт байгаа дангаар нөөрхох байдлыг задлах, шударга өрсөлдөөн үүсэх нөхцөлийг бүрдүүлэх;

-гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг эдийн засгийн талаар хангах;

- төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд оролцох явдлыг багасгах, улсын төсвийн бүтцийг оновчтой болгох, үр өгөөжийг нь дээшлүүлэх;

-төрийн зохицуулалтын үүргийг аж ахуйн үйл ажиллагаанаас тусгаарлах, зохицуулах үүрэг бүхий байгууллагын хараат бус байдлыг хангах;

-хувьчлалын үр дүнд гарч болох нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон сөрөг үр дагаврыг багасгах;

-байгаль орчин, аюулгүй байдлыг хамгаалах;

-өр, зээлийг баталгаажуулах, шаардлагатай бол зарим өрийг тусгаарлах, өр төлбөрийг төлөх хуваарийг шинэчлэн баталгаа гаргаж, хэрэгжүүлэх;

1.3.Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт

Энэхүү Үндсэн чиглэлийг дараахь бүтэц, зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ:

- Үндсэн чиглэлийн дагуу хувьчлалын явц, үр дүнгийн байдалд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хяналт тавина. Улсын Их Хурал Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын талаар жил бүр Засгийн газрын тайланг хэлэлцэж, чиглэл өгөх;

-хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, энэхүү жагсаалтад орсон хөрөнгө /объект/-ийг хувьчлах арга, хэлбэрийг Засгийн газар жил бүр батлан гаргах ,Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;

-хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтад орсон аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийг /объектыг/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хувьчлах ажлыг Төрийн өмчийн хороо эрхлэн явуулж, дүнг Засгийн газарт хагас жил тутам тайлагнах;

-энэхүү Үндсэн чиглэлд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагыг удирдлагын, гүйцэтгэлийн болон түрээсийн гэрээгээр ажиллуулах тухай Засгийн газрын шийдвэрийг Төрийн өмчийн хороо тухайн чиглэлийн / салбарын/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлж явц, үр дүнг тодорхой хугацаанд хянан үзэж, Засгийн газарт мэдээлэх;

-аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн өөрчлөлтийн асуудлыг Төрийн өмчийн хороо тухайн чиглэлийн /салбарын/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэж, энэ тухайгаа Засгийн газарт мэдээлэх.

1.4.Өмч хувьчлалын арга, хэлбэр

Өмч хувьчлалд хэрэглэж байсан дуудлагаар худалдах, уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/, төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах, төрийн өмчийн хуулийн этгээдийг хамтрэсэн хэлбэрээр өөрчлөн байгуулах, татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах, давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах, менежментийн үр дүнг харгалзан хувьчлах зэрэг уламжлалт аргуудыг хэрэглэхийн зэрэгцээ олон улсын төндер /уралдаант шалгаруулалт/, удирдлагын гэрээ гүйцэтгэлийн гэрээ, түрээсийн гэрээ зэрэг арга,

хэлбэрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын онцлогт нь тохируулан дангаар буюу хослуулан хэрэглэнэ.

Төрийн эзэмшлийн хувьцааг шаардлагатай хэмжээгээр багцлан худалдах, нэмэлт хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, алдагдалтай, цаашид ашигтай ажиллах боломжгүй аж ахуйн нэгжийг татан буулгах, эд хөрөнгийг нь худалдах зэрэг өмч хувьчлалын арга, хэлбэрийг тухайн аж ахуйн нэгжийн онцлогт тохируулан хэрэглэнэ.

1.5.Өмч хувьчлалын талаархи мэдээлэл

Өмч хувьчлалын талаархи мэдээллийг нийтэд адил тэгш, хүртээмжтэй хүргэж, өмч хувьчлалыг ил тод явуулна. Өмч хувьчлалд оролцогч, хувьцаа эзэмшигч, сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээллээр ханган, сонголтоо үндэслэлтэй хийх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг Төрийн өмчийн хороо тогтмол явуулна.

Төрийн өмчийн хувьчлалын талаархи мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн орчин үеийн техник, технологи ашиглан олон нийтэд өргөнөөр мэдээлэх ажлыг Төрийн өмчийн хороо зохион байгуулна.

Төрийн өмчийн хороо өмч хувьчлалыг сурталчлах, зах зээлийн үнийн баримжааг тодорхойлох, уралдаант шалгаруулалтын нөхцөл, бичиг баримтыг боловсруулах, ирүүлсэн саналыг дүгнэж хөрөнгө оруулагчдыг шалгаруулах, уралдаант шалгаруулалтад ялагчтай гэрээ, хэлцэл хийх зэрэгт зөвлөгч болон зуучлагчдыг шалгаруулан авч ажиллуулж болно.

1.6.Өмч хувьчлалын эрх зүйн орчин

Өмч хувьчлалын талаар мөрдөж байгаа эрх зүйн актыг хувьчлалын талаар баримтлах төрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох ажлыг дараахь чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ:

-орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналт, хувьчлалтай холбогдсон эрх зүйн харилцааг боловсронгуй болгох. Ингэхдээ орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг өргөтгөх, өмчийн удирдлага, бүртгэл, хяналт, хувьчлалын талаар нэгдсэн бодлого, зохицуулалтыг оновчтой болгох;

-дэд бүтэц, нийгмийн салбар дахь төрийн зохицуулалтыг аж ахуй, үйлчилгээний үйл ажиллагаанаас тусгаарлах, зохицуулах үүрэг бүхий байгууллагын хараат бус байдлыг ханган;

-санхүүгийн олон төрөлт, уян хатан зах зээлийг бүрдүүлэх;

-аж ахуйн гэрээний эрх зүйн үндсийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

-аж ахуй эрхлэгчээс төрийн байгууллагатай харилцан үр ашигтай хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлэх.

ХОЁР. Тодорхой салбар, аж ахуйн нэгжийн хувьчлал, өөрчлөн байгуулалт

2.1.Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьчлал, өөрчлөн байгуулалт

Тухайн салбарт голлох байр суурь эзэлдэг, эдийн засгийн стратегийн ач холбогдолтой, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц аж ахуйн нэгжийг үнэ цэнэтэй аж ахуйн нэгж гэнэ. Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьчлалд гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдыг түлхүү оролцуулах замаар техник, технологийг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэн шинэчлэх, аж ахуйг олон улсын хэмжээнд хөтлөн явуулах удирдлагын арга барилыг Монгол Улсад нэвтрүүлэх, аж ахуйн нэгжийн дангаар нөөрхох байдлыг задлах, Монгол Улсын олон талт үүрт гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлыг эдийн засгийн хувьд хангах явдлыг урьдал болгоно. Эдгээр зарчмыг хувьчлах нөхцөл, хувьчлалын гэрээ зэрэг баримт бичигт тусган хэрэгжүүлнэ. Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийг хувьчлахдаа түүний үйлдвэрлэлийн онцлог байдал, улсын эдийн засагт гүйцэтгэж байгаа үүрэг, ач холбогдлыг бууруулахгүй байх нөхцөлийг харгалзан үзнэ.

2.1.1.Худалдаа хөгжлийн банк ХХК

Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, улс хоорондын банкны үйл ажиллагааны туршлага хуримтлуулсан дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид төрийн эзэмшлийн хувьцаанаас тэдгээрийн сонирхох хэмжээний багцыг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-тус банкны үйл ажиллагааг өргөтгөх, банкны секторт түүний эзэлж байгаа байр суурийг хадгалж, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай болгох;

-олон улсын туршлага, стандартад нийцэхүйц орчин үеийн банкны мэдээллийн технологи, удирдлагын арга барил /ноу-хау/ нэвтрүүлэх;

-санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөх,

үйлчилгээний дэвшилтэт арга, хэлбэр, эрсдлийг багасгах шинэ арга барилыг нэвтрүүлэх.

2.1.2.Нефть импорт концерн ХК

Нефть импорт концерн ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаанаас энэ чиглэлийн бизнес эрхэлдэг бөгөөд олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид түүний сонирхох хэмжээний багцыг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-Монгол Улсын апслагдсан аймаг, сум дахь шатахуун түгээх станцыг нефть бүтээгдэхүүнээр хангах талаар шинэ өмчлөгчийн зүгээс хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор Засгийн газар алтан хувьцааг 5 жилийн хугацаатай гаргах;

-нефть бүтээгдэхүүний импортын эх үүсвэрийг өргөжүүлэх, түүний хангамжийг найдвартай болгох, бүтээгдэхүүний өртгийг бууруулах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;

-нефтийн барилга байгууламж, үндсэн хөрөнгийг олон улсын стандартад хүргэхэд зориулж хөрөнгө оруулалт хийх;

-нефтийн бүтээгдэхүүний технологийн болон шатахуун түгээх станц, нефтийн агуулахын стандартад тавих хяналт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх;

-нефтийн бүтээгдэхүүний улсын нөөцийг зах зээлийн үеийн механизмын үндсэн дээр бүрдүүлэх;

-нефтийн бүтээгдэхүүний импортод хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан Нефть импорт концерн ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахын өмнө бүтээгдэхүүний чанарын лабораторийн сүлжээг тоног төхөөрөмжийн хамт тусгаарлан зохион байгуулж, нийтэд үйлчилдэг болгох.

2.1.3."Говь" ХК

Монгол ноолууранд үр ашигтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх урт хугацааны стратегийг хэрэгжүүлэх чадвартай, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, санхүүгийн чадавхтай гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид тэдгээрийн сонирхох хэмжээний хувьцааны багцыг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-компанийн боловсруулах хүчин чадлыг шинэчлэн өргөтгөх хөрөнгө оруулалт хийх;

-бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, боловсруулалтыг гүнзгийрүүлэх замаар үйлдвэрлэсэн үнэ цэнэ бүхий эцсийн бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэх;

-орчин үеийн удирдлага, технологийн ноу-хауг нэвтрүүлэх замаар монгол ноолуурын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, салбарын тогтвортой хөгжлийг хангах.

2.1.4.Төрийн өмчит даатгалын компани

Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, санхүүгийн чадавхтай, даатгалын үйл ажиллагааг амжилттай явуулж ирсэн туршлагатай дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид даатгалын компанийн төрийн эзэмшлийн хувьцааны тодорхой хэсгийг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-даатгалын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгийн зах зээлд үр ашигтай байршуулах үйлчилгээг нэвтрүүлэх, энэ талаархи эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

-даатгалын үйл ажиллагааг олон улсын хэм хэмжээнд хүргэж, компанийг хөрөнгөжүүлэх;

-даатгалын үйл ажиллагааны болон компанийн удирдлагын шинэ, боловсронгуй арга барилыг нэвтрүүлэх;

-даатгалын компанийн үйл ажиллагааг өргөтгөж, даатгалын төрлийг нэмэгдүүлэх замаар бизнес эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх.

2.1.5.Монголын иргэний агаарын тээвэр ТӨҮГ

Иргэний агаарын тээврийн салбарын өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ:

-Монголын иргэний агаарын тээвэр ТӨҮГ-ын харьяалалд ажилладаг дундын үйлчилгээний зориулалт бүхий газрын үйлчилгээний багц төхөөрөмж, газар дээрх зарим үйлчилгээ /хоол, шатахууны сумлалт г.м/-г тусгаарлан зохион байгуулж Монгол Улсад нислэг үйлддэг иргэний болон бусад авиакомпани, нисэх онгоцонд ялгаваргүй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ээлж дараалалтай хувьчлах;

-Монголын иргэний агаарын тээвэр ТӨҮГ-ыг салбаруудын нь хамт нэг багц болгох, хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа, үйлчилгээг нь сайжруулах нөхцөлтэйгээр олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий гадаадын авиакомпанид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэл баримтлах;

-иргэний агаарын тээврийн салбарт хувийн хэвшлийн үүрэг өсч байгаатай холбогдуулан техникийн бүрэн бүтэн байдал, нислэгийн аюулгүй байдлын хяналтын системийг боловсронгуй болгох.

2.1.6.Монгол-Оросын хамтарсан Монросцветмет ХХК, Эрдэнэт ХХК-ийн өөрчлөн байгуулалт

Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө болон эдгээр компанийн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн өнөөгийн байдал зэргийг нь харгалзан Монгол-Оросын хамтарсан Монросцветмет ХХК, Эрдэнэт ХХК-ууд дахь өөрийн хувийг Монгол Улс ойрын жилүүдэд хувьчлах бодлого баримтлахгүй болно.

Эдгээр компанид орчин үеийн удирдлагын арга барил нэвтрүүлэх, өртөг зардлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтыг гүнзгийрүүлэх талаар сонирхогч этгээд /ялангуяа олон улсын байгууллага/-тэй хамтран ажиллана.

2.1.7.Хөтөл дахь цемент шохойн үйлдвэр ТӨҮГ

Цемент, шохойн төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн, төрийн эзэмшлийн тодорхой хэгийг хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-цементийн үйлдвэрлэлийн техник, технологийг орчин үеийн түвшинд шинэчлэн сайжруулж, Монгол Улсын экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах чиглэлээр ажиллах /адаадын хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар зарлан хувьчлах;

-уралдаант шалгаруулалтын нөхцелд үйлдвэрийн орчны экологи болон Хөтөл тосгоны нийгмийн асуудлаар тодорхой /хувьчлалд шууд саад болохгүй/ шаардлага тавих.

2.1.8.Хар төмөрлөгийн ТӨҮГ

Хар төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлт, санхүүгийн байдал хүнд байгааг харгалзан түүнийг өөрчлөн байгуулах талаар дараахь арга хэмжээ авна:

-хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр үйлдвэрийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх. Удирдлагын гэрээгээр үйлдвэрийн эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй.

-удиодлагын гэрээгээр ажилах этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулах.

2.1.9 Монгол-Болгар-Гео ХХК

Монгол-Болгар-Гео ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахын өмнө Монголын талын оруулсан хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох;

-компанийг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах;

-Монголын тал өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа нөгөө талтай тохиролцсоны үндсэн дээр багцлан худалдах.

2.1.10 Монгол –Амикаль ХХК

Монгол–Амикаль ХХК-гийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-Монголын талаас хөрөнгө оруулахтай холбогдон үүссэн өрийн асуудлыг шийдвэрлэх;

-Монголын тал өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа нөгөө талтай тохиролцсоны үндсэн дээр багцлан худалдах.

2.1.11. Архи, пиво,ундаа ХК

Архи, пиво,ундаа ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

-хувьчлахын өмнө Ургамлын тосны үйлдвэр байгуулахтай холбогдон байгуулсан охин компани болон Энэтхэг Улсаас авсан зээлийг эргэн төлөх зэрэг маргаантай байгаа өр, авлагын асуудлыг шийдвэрлэх;

-төрийн эзэмшлийн хувьцааны тодорхой хэгийг битүүмжилсэн дуудлага худалдаагаар багцлан худалдах замаар хувьчлах.

2.2.Дэд бүтцийн салбарт хийгдэх хувьчлал, өөрчлөн байгуулалт

Дэд бүтцийн салбарт хамрагдах төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ихэнх нь аж ахуйн үйл ажиллагааны зэрэгцээ салбарынхаа хэмжээнд төрийн зохицуулах үүргийг гүйцэтгэж байна. Иймд уг салбарт хувьчлал, өөрчлөн байгуулалтыг хийхдээ төрийн зохицуулалтын тогтолцоог зах зээлийн үед байвал зохих арга хэлбэрт шилжүүлэх явдлыг урьдал болгоно.

Дэд бүтцийн салбарт хувьчлал явуулахдаа хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөнийг өрнүүлэх, гадаадын хөрөнгө

оруулалтыг дэмжих бодлогыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулан явуулахыг иш үндэс болгоно.

2.2.1.Эрчим хүчний салбар

Эрчим хүчний салбарын өөрчлөн байгуулалтыг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Нэгдүгээр үе шатанд эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, удирдлагын өнөөгийн тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн дараахь байдлаар арилжааны хэлбэрт шилжүүлнэ:

-Эрчим хүчний удирдах газрын гүйцэтгэж байгаа төрийн эзэмшлийн үүргийг Эрчим хүчний хуульд заасны дагуу эзэмшуулагч байгуулагад шилжүүлэх;

-эрчим хүч үйлдвэрлэгч, эрчим хүч дамжуулагч, эрчим хүч түгээгч аж ахуйн нэгж бүрийг компанийн хэлбэрт шилжүүлж, үйл ажиллагаа нь зах зээлийн харилцаанд шилжүүлэх;

-цахилгаан станц болон дамжуулах сүлжээний их засвар хийдэг нэгж, хэсгийг тусгаарлан хувьчлах;

-Эрчим хүчний удирдах газрыг системийн хэмжээнд өнөөдрийг хүртэл үүссэн өр авлагыг барагдуулах нэгж болгон зохион байгуулах.

Хоёрдугаар үе шатанд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр нэгдүгээр үе шатанд өөрчлөн байгуулагдсан эрчим хүч үйлдвэрлэгч болон түгээгч компаниудыг уралдаант шалгаруулалтын аргаар стратегийн хөрөнгө оруулагчид үе шаттайгаар хувьчлах ажлыг хэрэгжүүлж эхлэх;

-үйлдвэрлэгчээс түгээгчид эрчим хүчийг хүргэх үүрэг бүхий үндсэн сүлжээнд хамрагдаг цахилгаан эрчим хүч дамжуулах компанийг төрийн өмчид үлдээх.

2.2.2.Автозам

Монгол Улсын автозамын салбарт хийгдэж байгаа хувьчлал, өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж, дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-Улаанбаатар хот дахь Автозамын засвар, арчлалтын нэгдэл ХК-ийг Төвийн болон Баруун бүсийн автозамын засвар, арчлалтын нэгтгэл болгон хуваж, Дорнод аймаг дахь Автозам ХК-ийг Зүүн бүсийн автозам засвар, арчлалтын компани болгон тус тус өөрчлөн зохион байгуулж төрийн мэдэлд үлдээх;

-Автозам Архангай ХК, Алтайн зам ХК, Эрдэнэт-Автозам ХК, Хөвсгөл-Автозам ХХК, Улбаа ХК зэрэг компанийн замын засвар, арчлалтын үйл ажиллагааны хэсгийг өнөөгийн мөрдөж байгаа хуулийн хүрээнд хуваж, шинээр байгуулагдах автозамын засвар, арчлалтын Зүүн, Төв, Баруун бүсийн толгойлох компанийн бүрэлдэхүүнд шилжүүлэх;

-автозамын барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг компануудын төрийн эзэмшлийн хувьцааг тодорхой хэмжээгээр багцлан Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах;

-Эрдэнэ Зам ТӨҮГ-ыг компанийн хэлбэрт шилжүүлж, хувьцааг нь багцлан битүүмжилсэн дуудлага худалдаагаар хувьчлах;

-замын аюулгүй байдал, шинэчлэл, засвар, арчилгаа болон зам тойрсон үйлчилгээний цогц байдлыг хангах үүднээс Замын цагдаагийн газрын холбогдох үүргийг Автозамын газрын бүтцэд шилжүүлэх;

-гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаар автозам барих ажиллагааг төрөөс дэмжиж, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

2.2.3.Харилцаа холбооны салбар

Холбооны салбарыг өөрчлөн байгуулах, хувьчлах талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-шуудан, цахилгаан холбооны газраас үйлчилгээний түгээх зөвшөөрөл олгох, үнэ, тарифыг хянах, үндсэн сүлжээний холболтын нөхцөлийг тодорхойлох, үйлчилгээний чанар, стандартын биелэлтэд хяналт тавих зэрэг төрийн үүргийг тусгаарлаж, эдгээр үйл ажиллагаг зохицуулах албыг бие даасан хэлбэрээр зохион байгуулах;

- харилцаа холбооны суурь сүлжээний улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бусад хөрөнгийг дахин үнэлж, Монголын цахилгаан холбоо ХК-д шилжүүлж, төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг нэмэгдүүлэх;

-нарны зайн үйлдвэрийг төрийн өмчийн компанийн хэлбэрт шилжүүлж, хувьчлах чиглэл баримтлах;

-Монголын цахилгаан холбоо ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа нэмэгдэж байгаатай холбогдуулан төрийн эзэмшлийн хувьцааны тодорхой хэсгийг стратегийн хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

-шуудангийн үйлчилгээг төрийн өмчийн компанийн хэлбэрээр үргэлжлүүлэн ажиллуулах;

-хөдөөгийн холбоожуулалтыг сайжруулах зорилгоор холбооны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн

нэгжүүдийн орлогоос тусгай сан байгуулж ашиглах.

2.2.4.Нүүрсний салбар

Эрчим хүчний нэгдсэн сүлжээг түлшээр хангах үүрэг бүхий компанийн талаар дараахь бодлого баримтална:

-Багануур ХК, Шивээ Овоо ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Дэлхийн банк болон Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа техникийн шинэчлэлийг дуусгах хүртэл хугацаанд хувьчлахгүй байх;

-Шарын гол ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах асуудлыг тухайн бүсийн нүүрсний судлагдсан нөөцийн хэмжээ, уурхайн ирээдүйн чиглэл, тосгоны нийгмийн асуудалтай уялдуулан шийдвэрлэх;

-Хотгор ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг дуудлага худалдаагаар хувьчлах;

-уул уурхайн салбарын олонхи аж ахуйн нэгж хувийн хэвшилд бүрэн шилжиж байгаатай холбогдуулан урьд үүссэн байгаль орчны эвдрэлийг нөхөн сэргээх асуудлыг Засгийн газраас тусгайлан авч үзэж, хувьчлагдсан аж ахуйн нэгжтэй хамтран шийдвэрлэх чиглэл баримтлах.

2.2.5.Төмөр зам

Улаанбаатар төмөр зам ХК-ийг Монгол Улсад мөрдөж байгаа Компанийн тухай болон холбогдох бусад хуулийн дагуу өөрчлөн байгуулж, бие даасан хэлбэрээр ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.

Монгол-Оросын хамтарсан Улаанбаатар төмөр зам ХК-ийн Монголын талын эзэмшиж байгаа хувьцааг ойрын жилүүдэд хувьчлах бодлого баримтлахгүй болно.

Төмөр замын үйлчилгээний шуурхай, уян хатан байдлыг сайжруулах, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх үүднээс Засгийн газар шаардлагатай гэж үзвэл ачаалыг болон суудлын вагон, зүтгүүрийн зарим хэсгийг түрээсийн хэлбэрээр ашиглуулах асуудлыг компанийн эрх бүхий байгуулагад тавьж шийдвэрлүүлнэ.

Өрсөлдөөн бий болгох зорилгоор гадаад, дотоодын хуулийн этгээдээс өөрийн эзэмшлийн ачааны болон суудлын вагон, зүтгүүр ашиглан монголын төмөр замаар ажил, үйлчилгээ явуулах боломжийг бүрдүүлнэ;

Япон болон бусад донор орноос Монгол Улсын Засгийн газарт олгосон бүцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, Монголын талын хөрөнгөөр төмөр замын салбарт бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, цаашид иймэрлийн хөрөнгө оруулалтыг хийхдээ өмчлөлийн асуудлыг хамтад нь шийдвэрлэж байх журамд шилжинэ.

2.2.6.Геодези, зураг зүйн салбар

Геодези, зураг зүйн салбар нь техник технологийн хувьд хоцрогдолд орсныг харгалзан тус салбарт дараахь бодлого баримтална:

-Аэрогеодезийн ТӨҮГ, Зураг зүйн ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх нөхцөлөөр нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар хувьчлах;

-хөрөнгө оруулалт хийх этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулах;

-геодези, зураг зүйн мэдээллийн санг төрийн өмчид үлдээж, нийтлэг журмаар ашиглах боломжоор хангах.

2.2.7.Дэд бүтцийн бусад салбар

Дэд бүтцийн салбарт хамаарагдах автотээвэр, барилга, аялал жуулчлал, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа сайжруулах, өөрчлөн байгуулалтаа хийхэд нь төрөөс туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.

Нийтийн аж ахуй, үйлчилгээний салбарт хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага нь орон нутгийн өмчид шилжсэн тул тус салбар дахь хувьчлал, өөрчлөн байгуулалтын асуудлыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан Засгийн газраас батална хөтөлбөр, чиглэлийг баримтлан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэрлэн явуулна.

2.3.Санхүүгийн салбарын өөрчлөн байгуулалт, хувьчлал

2.3.1.Арилжааны банкны хувьчлал, өөрчлөн байгуулалт

Банкны салбарт хийх хувьчлалын зорилго нь дотоод, гадаадын санхүүгийн чөлөөт эх үүсвэрийг төвлөрүүлэн үр ашигтай байршуулж, бодит секторын хөгжлийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг хангах, өрсөлдөх чадвар бүхий банкны тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний олон хэлбэрийг бий болгох, банкны үйл ажиллагааны шинэ технологи нэвтрүүлэхэд оршино.

Банкны хувьчлал, өөрчлөн байгуулалтад Улсын Их Хурлаас 1999 онд батална Банкны

хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл болон Засгийн газраас 2000 онд батална Банкны хувьчлалын хөтөлбөрийг үндэс болгоно.

Төлбөрийн чадваргүй болон санхүүгийн хүндрэлтэй банкуудад хийгдэж эхэлсэн өөрчлөн байгуулалтын ажлыг цаашид үргэлжлүүлэн ойрын үед дуусгах арга хэмжээ авна.

Хөдөө аж ахуйн банкийг Засгийн газрын зүгээс дахин хөрөнгөжүүлж, гадаадын менежментийн багийг удирдлагын гэрээгээр ажиллуулж, үйл ажиллагааг нь сайжруулсны үндэсэн дээр хувьчлах эсэх асуудлыг тусгайлан авч үзнэ.

Хадгаламж банкийг санхүүгийн зах зээл төлөвшин тогтворжих, хадгаламжийн даатгалын тогтолцоо бүрдэх хүртэл төрийн өмчид үлдээнэ.

Арилжааны бусад банк дахь төрийн эзэмшлийн хувьцаат хууль тогтоомжийн дагуу шинэчлэн тогтоосны үндэсэн дээр хувьчлалын асуудлыг нэг бүрчлэн шийдвэрлэнэ.

2.3.2.Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны зах зээл, хөрөнгийн биржийн ажиллагааг хөнгөн шуурхай, уян хатан, өрсөлдөөнтэй болгох арга хэмжээ авна:

-биржийн үйл ажиллагаанаас үнэт цаасны арилжааны клиринг, хадгаламжийн үйл ажиллагааг тусгаарлан зохион байгуулж, энэ ажиллагаанд банк болон мэргэжлийн бусад байгууллагуудаас оролцох боломжийг бүрдүүлэх;

-биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүр хувьчлагдах компаниудын худалдах хувьцаанаас тодорхой хувийг нь /200.00 сая төгрөгөөс доошгүй/ биржийн арилжаагаар дамжуулан худалдах;

-биржийн үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор өөрийгөө зохицуулах тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авах;.

-биржийн арилжаагаар хувьцаанаас бусад төрлийн үнэт цаас худалдах боломжийг нэмэгдүүлэх;

-биржийн үйлчилгээний тарифыг эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн оновчтой болгох;

-биржээр хувьцаагаа арилжих компанид тавигдах шаардлагын стандартыг тогтоох замаар бирж дээр арилжаалагдах хувьцааны нэр хүндийг дээшлүүлэх, хувьцаагаа биржээр дамжуулан худалдах сонирхлыг нэмэгдүүлэх. Ингэснээр компанийн үйл ажиллагааг нийтэд ил тод болгож, санхүү бүртгэлийн системээ сайжруулах шаардлагыг өндөржүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид сонголтоо зөв хийх боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр олох магадлалыг нэмэгдүүлэх. Энэ чиглэлээр биржийн ажиллагааг сайжруулахад нь төрөөс туслалцаа үзүүлэх;

-Үнэт цаасны тухай хуулийг өнөөгийн шаардлага, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн шинэчлэн гаргаж төрийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай, идэвхтэй, шударга болгон өөрчлөх;

-үнэт цаасны биржээс гадна үнэт цаас арилжаалах алтернатив зах зээл бий болгох, үүнтэй холбогдуулан тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

-аж ахуйн нэгжүүдээс төрөл бүрийн үнэт цаас гаргах ажиллагааг дэмжиж, энэ ажилд нь төрөөс арга зүйн туслалцаа үзүүлэх;

-эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын санг аажмаар арилжааны хэлбэрт оруулж хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгон хувиргаж, өөрөө үржин өрвиждаг болгох ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх;

-эрүүл мэндийн болон нийгмийн сайн дурын даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

-хувьчлагдах аж ахуйн нэгжийн хувьцааны тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн цэнхэр тасалбараар худалдах, дуудлага худалдааны аргаар хувьчлагдах аж ахуйн нэгж, эд хөрөнгийн төлбөрийн 10 хүртэл хувьд хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбарыг оруулан тооцох замаар ирэх 4 жилд багтаан хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн цэнхэр, ягаан тасалбарыг хөрөнгөөр баталгаажуулах ажлыг хийж дуусгах.

2.4.Нийгмийн салбарын өөрчлөн байгуулалт, хувьчлал

Нийгмийн салбарт хийгдэх өөрчлөн байгуулалт, хувьчлалын гол зорилго нь өрсөлдөөнийг дэмжих, төрийн зохицуулалтыг зааглаж, тодорхой болгох үндсэн дээр салбарын удирдлага, санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар үйлчилгээний чанарыг сайжруулж, жигд, хүртээмжтэй болгоход оршино.

2.4.1.Эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарын өөрчлөн байгуулалт, хувьчлалын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-Засгийн газраас шаардлагатай гэж үзсэн

клиникийн буюу тусгай мэргэжлийн зарим эмнэлгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсэгт гадаад, дотоодын нэмэлт хөрөнгө оруулалт хийж, хамтарсан байгууллага байгуулах замаар хувьчлах. Хөрөнгө оруулагчдыг тодорхой нөхцөлөөр уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулах;

-Засгийн газраас шаардлагатай гэж үзсэн хот, хөдөөгийн зарим эмнэлгийн удирдах үйл ажиллагаат удирдлагын гэрээгээр; эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эмнэлгийн биш туслах үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр; эмнэлгийн зарим байр, тоног төхөөрөмж, лабораторийг түрээсийн гэрээгээр ашиглуулах;

Гэрээгээр ажиллах этгээдийг төрийн бус мэргэжлийн байгууллага, дотоод, гадаадын хувийн өмчийн хуулийн этгээд, хувь хүмүүсийн дунд уралдаант шалгаруулалтаар сонгоно. Эдгээр гэрээгээр эд хөрөнгө, хөрөнгийн эрхийг хувийн өмчид шилжүүлэхгүй.

Удирдлагын гэрээний үндсэн нөхцөл нь зардлаас давсан орлогыг тухайн эмнэлэгт хөрөнгө оруулалт хийх, удирдлагыг нь сайжруулан урамшуулахад зарцуулах бөгөөд эдгээр нөхцөл, хэмжээг удирдлагын гэрээнд тодорхой заана.

Гүйцэтгэлийн гэрээний үндсэн нөхцөл нь гүйцэтгэгчийн зүгээс эмнэлгийн зарим төрлийн үйлчилгээг стандартын түвшинд чанартай гүйцэтгэхэд оршино. Гүйцэтгүүлэгч нь тухайн үйлчилгээний эцсийн үр дүнгийн талаархи хариуцлагыг хүлээнэ.

Түрээсийн гэрээгээр эмнэлгийн үндсэн биш үйлчилгээ явуулах байр, тоног төхөөрөмж, лабораторийг ашиглах үндсэн нөхцөл нь уг үйлчилгээг чанартай явуулж, эд хөрөнгийг зориулалтын дагуу гэрээнд заасан нөхцөлөөр ашиглаж түрээсийн төлбөрийг түрээслэгчид төлж байхад оршино.

-эмийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, энэ чиглэлийн төсөл хөрөнгүүлэх шаардлагад нийцүүлэн Эмийн үйлдвэр компанийг төрийн өмчид хэвээр үлдээх;

-улсын хэмжээний үйлчилгээтэй Хужирт, Шаргалжуутын рашаан сувиллыг төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, цаашид үйлчилгээний чиглэлийг өөрчлөхгүйгээр хувьчлах эд хөрөнгийг зориулалтаар нь ашиглаж үр ашгийг дээшлүүлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжлийн болон хөрөнгө оруулалт, технологийн шаардлагыг хангах, сайжруулах нөхцөлтэйгээр хувьцааны тодорхой хэсгийг уралдаант шалгаруулалтын аргаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид хувьчлах;

-Оргил рашаан сувиллын үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөж, улсын хэмжээний рашаан сувиллын эмч, мэргэжилтэнг сургаж бэлтгэх, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий рашаан судлалын үндэсний төв болгон өөрчлөн зохион байгуулах;

-Монгол-Солонгосын хамтарсан Монсам ХХК нь нэг удаагийн зүү, тариураар дотоодын зах зээлийг бүрэн хангадаг стратегийн ач холбогдолтой, Солонгос Улсаас авсан зээлийн өрөө төлж эхэлж байгаа зэргийг харгалзан Монголын талын эзэмшлийн хувьцааг ойрын жилүүдэд хувьчлахгүй чиглэл баримтлах;

-ахуйн шавьж, хортон мэрэгчдийг устгах үйлчилгээ болон Улаанбаатар хотын эмийн сангууд хувьчлагдсантай холбогдуулан тэдгээрийн үйлчилгээний чанарт тавих мэргэжлийн хяналтын тогтолцоо, ажлын байрны стандартыг бий болгож, найдвартай байдлыг хангах;

-орон нутаг дахь нийгмийн халамж, үйлчилгээний төвийн үйл ажиллагаат гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.

2.4.2.Боловсролын салбар

Боловсролын салбарт дараахь өөрчлөн байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий гадаадын сургуулийн салбарыг Монголд байгуулах, эсхүл их сургуулиудтай хорших, гадаад, дотоодын нэмэлт хөрөнгө оруулалт хийж, хамтарсан сургууль байгуулах, дэлхийн жишигт нийцсэн ноу-хауг боловсролын салбарт нэвтрүүлэх санааналгаа гэж үзэн дэмжиж энэ ажлын хүрээнд Засгийн газраас зарим сургуулийг сонгон авч дэмжлэг үзүүлэх;

-төрийн өмчийн их сургуулиуд, багш, соёл урлагийн мэргэжлийн дээд боловсрол эзэмшүүлдэг коллежийг төрийн өмчид үлдээх;

-зарим шаардлагатай техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага, коллежийн удирдах үйл ажиллагаат удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх. Удирдлагын гэрээгээр ажиллуулах гол нөхцөл нь тухайн боловсролын байгууллагын үндсэн үйл ажиллагааны чанар, үр ашгийг дээшлүүлэх, төрөөс үзүүлэх санхүүжилтийг багасгахад орших бөгөөд гэрээгээр тухайн байгууллагын эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй. Удирдлагын гэрээгээр ажиллах этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулах.

-ерөнхий боловсролын сургуулиас бусад төрийн өмчийн боловсролын байгууллагад тєсвөөс

олгох санхүүжилт, их сургууль, коллежид суралцагсдад олгох сургалтын төлбөрийн зээл, тусламжийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шууд олгох чиглэлээр эрх зүйн орчныг өөрчлөх;

-ашгийн төлөө бус боловсролын байгууллагын эд хөрөнгийн эрх зүйн байдлыг тогтоох;

-магадлан итгэмжлэл авсан ашгийн бус, төрийн өмчийн бус дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчаар нь дамжуулан төрөөс дэмжлэг үзүүлэх;

-их сургуулийн ээлжмшил газрын хэмжээг тогтоон өгч цаашид өргөтгөх, сургуулийн хотхон үүсгэх нөхцөл бололцоог бүрдүүлэх.

2.4.3.Шинжлэх ухааны салбар

Шинжлэх ухааны салбарт дараахь өөрчлөн байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа өнөөгийн нөхцөлд хувийн хэвшлээс шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих санхүүэдийн засгийн чадавхи сул байгаа болон шинжлэх ухаан, технологийн гүйцэтгэх үүрэг, нөлөө улам өсөн нэмэгдэж байгаа нийтлэг хандлагыг харгалзан Монгол оронд нэгэнт бий болсон чадавхийг хадгалах зайлшгүй шаардлагад нийцүүлэн төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг ойрын үед хувьчлахгүй чиглэл баримтлах. Харин Шинжлэх ухааны академи, их сургууль, төрийн захиргааны төв байгууллагын харъяа хүрээлэн, төвүүдийг төрийн өмчит төсөвт байгууллагын, шинжлэх ухаан-технологи-үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/-ийг төрийн өмчит компанийн хэлбэрээр ажиллуулах тогтолцоог боловсронгуй болгох;

-шинжлэх ухааны салбарт бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн нэгдлийг хангах эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн эрх зүйн байдал, шинжлэх ухаан-технологи-үйлдвэрлэлийн нэгдлийн удирдах зөвлөлийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, эрх зүйн хувьд баталгаажуулах;

-судалгаа шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон хамтарсан өмчит шинжлэх ухаан-боловсрол-үйлдвэрлэлийн цогцолборууд бий болгох асуудлыг цаашид судлан үзэж шийдвэрлэх;

-Засгийн газар шаардлагатай гэж үзсэн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн корпорацийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид тодорхой нөхцөлтэйгээр хувьчлах.

2.4.4.Соёл, урлагийн салбар

Соёл, урлагийн салбарт дараахь өөрчлөн байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-Монголын үндэсний уламжлалт урлагийг өвлөн уламжлуулах, дэлхийн сонгодог урлагийг өөрийн оронд хөгжүүлэх, өсвөр үеийнхний оюуны эрэлт хэрэгцээг хангах, гоо зүйн хүмүүжил олгох, оюуны өв сан, түүх, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Улсын ардын дуу, бүжгийн чуулга, Сонгодог урлагийн академик театр, Үндэсний жүжгийн академик театр, Улсын хүүхэлдэйн театр, Улсын филармони, Улсын төв номын сан, Үндэсний түүхийн музей, Чойжин ламын сүм музей, Уран зургийн галерей, Театрын музей, Соёлын өвийн төвийг төрийн өмчид үлдээн төсөвт байгууллагын хэлбэрээр үргэлжүүлэн ажиллуулах;

-Засгийн газар шаардлагатай гэж үзсэн соёл, урлагийн дээр дурьдсанаас бусад байгууллагын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх. Удирдлагын гэрээгээр ажиллах этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулна. Удирдлагын гэрээний үндсэн нөхцөл нь зардлаас давсан орлогыг тухайн байгууллагын менежментийг сайжруулан урамшуулах, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх, уран бүтээлчдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд зарцуулна. Удирдлагын гэрээгээр эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй.

-Үнэт цаас ХХК-ийг дуудлагын худалдаагаар хувьчлах;

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтелбөрт нийцүүлэн хөдөөгийн хүн амыг соёлын үйлчилгээгээр хангах зорилгоор орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагыг /аймгийн театр, чуулгуудын суурин дээр/ бүсийн театр болгон өөрчилж үйл ажиллагаат нь зохион байгуулах бодлого баримтлах. Ингэхдээ уг асуудлыг орон нутгийн удирдлагуудтай зөвшилцөн шийдвэрлэх.

2.4.5.Биеийн тамир, спортын салбар

Биеийн тамир, спортын салбарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-биеийн тамир, спортын Төв ордныг зориулалтынх нь дагуу ашиглах нөхцөлөөр удирдлагын гэрээгээр ажиллуулах. Удирдлагын гэрээгээр эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй;

-биеийн тамир, спортын заал, танхимуудыг

мэргэжлийн клубуудын дунд зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөлтэйгээр ураддаант шалгаруулалтын аргаар хувьчлах.

2.5.Бусад аж ахуйн нэгж, байгууллага, үл хөдлөх эд хөрөнгийн хувьчлал

Дээр дурьдсанаас бусад салбарт төрийн өмчийг хувьчлахад дараахь зарчмыг удирдлага болгоно:

-хувьчлалд хамрагдах аж ахуйн нэгж, эд хөрөнгийн нэр төрөл, хэмжээ, хувьчлах арга, хэлбэрийг үйл ажиллагааных нь онцлог байдал, улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан Засийн газар шийдвэрлэх;

-тухайн жилд хувьчлах аж ахуйн нэгжийг сонгохдоо улсын төсөвт оруулах орлого, хувьчлах бэлтгэл ханган гдсан байдлыг үндэслэх;

-гадаад орнуудаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлсэн тусламж, хөнгөлөлттэй зээлээр үйлдвэр, аж ахуйн газарт оруулсан хөрөнгө оруулалтын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэсний дараа хувьчлалын асуудлыг шийдвэрлэх. Цаашдаа хөрөнгө оруулалтыг хийхэд өмчлөл болон хувьчлалын асуудлыг хамтад нь шийдвэрлэж байх журамд шилжих;

-төрийн өмчит үйлдвэрийн газрыг Компанийн тухай хуулья заасны дагуу хувьцаат компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулсаны үндэсн дээр хувьчлах.

ГУРАВ. Хувьчлалын нийгэм, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нөхцөл, шаардлага

3.1.Өрсөлдөөнийг өрнүүлэх, зах зээл дэх шударга бус үйл ажиллагаат хязгаарлах

Зах зээлийн хэвийн, өрсөлдөөнтэй орчныг бүрдүүлэх нь өмч хувьчлалын эдийн засаг, нийгмийн үр ашгийг дээшлүүлэх үндсэн нөхцөл гэж үзнэ.

Өмч хувьчлалын ажлыг хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, аж ахуйн үйл ажиллагаа, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, шударга өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжихэд чиглүүлнэ.

Холбоо, эрчим хүч, автозам, төмөр зам зэрэг зүй ёсны дангаар нөөрхох салбаруудад хувьчлал явуулахдаа бүтцийн өөрчлөлт хийн дангаар нөөрхох байдлыг саармагжуулах, өрсөлдөөнийг төрийн бодлогоор дэмжих, дангаар нөөрхох байдлын эсрэг төрийн зохицуулалтыг хүчтэй болгох эрх зүйн болон зохион байгуулалтын орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна.

Зарим бүтээгдэхүүний зах зээлд давамгайлах байдалтай хувийн өмчийн аж ахуйн нэгж төрөн гарч, хуулиар хориглосон шударга бус үйл ажиллагаа явуулах болж байгааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглүүлэн Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Зах зээл дэх шударга бус үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлж, ийм үйл ажиллагаатай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлж сайжруулна.

3.2.Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих

Өмч хувьчлалыг гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгод нийцүүлж дараахь арга хэмжээ хэрэгжүүлнэ:

-үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн төрийн эзэмшлийн тодорхой хэгийг олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг найдвартай явуулах туршлагатай, санхүү, эдийн засгийн боломжтой гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид хувьчлах;

-Монгол Улсын өмч хувьчлалын бодлого, хэрэгжилтийн талаархи мэдээллийг олон улсын хэмжээнд түгээх;

-хувьчлагдах аж ахуйн нэгжийн тухай мэдээллийг өргөн хүрээтэй түгээх, сонирхож болох гадаадын хөрөнгө оруулагчдын жагсаалтыг гарган шууд харилцах арга хэмжээ авах.

3.3.Нийгмийн хамгаллын зорилттой уялдуулах

Энэхүү Үндсэн чиглэлд заасан хувьчлал, өөрчлөн байгуулалтын явцад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдон гарч болзошгүй сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх дараахь арга хэмжээ хэрэгжүүлнэ:

-төрийн өмчийг хувьчлах бүрд нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар үүсэх сөрөг үр дагаврыг тусгайлан авч үзэж хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

-шинэ ажил олгогчийн санаачлагаар хувьчлал, өөрчлөн байгуулалтын эхний жилд ажлаас халагдагсдад энэ тухай хоёроос доошгүй сарын өмнө мэдэгдэж, халах үедээ 1 сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг компаниас олгох, эсхүл нэгээс доошгүй жил ажлын байраар баталгаатай хангаж байх журамд шилжих. Үүнээс гадна халагдсан ажилтны 6 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг орон нутгийн хөдөлмөрийн албанд шилжүүлж, халагдсан

ажилтны талаар хөдөлмөрийн албанд мэдээлэл хүргэх;

-хувьчлал, өөрчлөн байгуулалтын хүрээнд хийгдэж байгаа арга хэмжээний улмаас ажлаас чөлөөлөгдөх ажилчдыг давтан сургах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, ажлын байр бий болгох зэрэг арга хэмжээ авах;

-хувьчлагдсан компанийн удирдлагаас ажилтанд компанийхаа хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд дэмжих;

-хувьчлагдах үйлдвэрийн газрын ажилтныг өмч хувьчлалын зорилго, үр ашиг, хугацааны талаар үнэн зөв, найдвартай мэдээллээр хангах арга хэмжээ авах.

3.4.Байгаль орчныг хамгаалах, ашиглах байдлыг хангах

Хувьчлалын үр дүнд экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчны төлөв байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтыг хангах үүднээс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-үйлдвэр, аж ахуйн нэгжийг хувьчлахдаа шаардлагатай гэж үзвэл байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг өөрчлөн байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх;

-үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, үл хөдлөх эд хөрөнгийг хувьчлахдаа тухайн хуулийн этгээдийн байршиж байгаа газрыг ашиглах, эзэмших эрхийг батлагаажуулсан эсэхийг нягталж, Газрын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх;

-байгаль орчинд үлэмж нөлөө үзүүлдэг үйлдвэрүүдийг байгаль орчны мэргэжлийн боловсон хүчин, орчны хяналт, шинжилгээний лабораторитой болгох асуудлыг дэс дараатайгаар шийдвэрлэх арга хэмжээ авах.

ДӨРӨВ.Хувьчлал, өөрчлөн байгуулалтыг дэмжих үйл ажиллагаа

4.1.Зөвлөгөө өгөх тогтолцоо бий болгох

Зөвлөгөө өгөх, зуучлалын үйл ажиллагаагаа оюуны хөрөнгө оруулалт болохын хувьд хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа сайжруулахад чиглүүлэн дэмжиж дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-хувьчлалыг үр дүнтэй болгох, хувьчлагдсан аж ахуйн нэгжийн цаашдын үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах зорилгоор орчин үеийн санхүү, аудит, хууль, удирдлага, маркетинг болон бусад чиглэлээр зөвлөгөө өгөх үндэсний тогтолцоо бүрдүүлэх;

-банк, санхүүгийн байгууллага болон их сургуулиудын дэргэд дээр дурдсан зөвлөгөө өгөх төвүүд байгуулан ажиллуулахыг дэмжихийн зэрэгцээ тэдгээрийг тодорхой теслүүдэд үндэсн болон туслан гүйцэтгэгчээр оролцуулах явдлыг дэмжих. Энэ ажилд гадаадын бүцалтгүй туслламж, хөнгөлөлттэй зээл болон дотоодын эх үүсвэрийг ашиглах, гадаадын болон олон улсын чиглэлийн байгууллагын туслалцаа авах, дотоодын мэргэжилтэн нарынхаа чадавхийг дээшлүүлэн өрсөн ашиглах чиглэл баримтлах.

4.2.Хувьчлалын дараахь өөрчлөн байгуулалтыг дэмжих

Хувьчлагдсан компаниудын өмнө эргэлтийн хөрөнгийн хомсдолыг гэтлэн давах, санхүүгээ удирдаж сурах, маркетингийн орчин үеийн арга барил эзэмших, зах зээлд шинэ бараа, үйлчилгээ нэвтрүүлэх, зарим тохиолдолд хуучин бараа үйлчилгээнээсээ татгалзах зэрэг өмнө нь байгаагүй шинэ зорилт тулгарч байна. Иймд шинэ өмчлөгчдөөс аж ахуйдаа дараахь өөрчлөн байгуулалт хийхэд нь тэрээс бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлнэ:

-техник, технологийг өөрчлөн шинэчлэх, зарим тохиолдолд хуучин эрхэлж байсан үр ашигүй ажил, үйлчилгээний чиглэлийг өөрчилж, ашиг өгөх чиглэл рүү шилжих /өөрчлөлтийн бизнес төлөвлөгөө/;

-эрсдэлгүй системийн удирдлагыг эрсдэлтэй, хөдөлгөөнтэй, өөрчлөлттэй системийн удирдлага болгон өөрчлөх /менежментийн өөрчлөлт/

-өрсөлдөөнт зах зээлд ажиллах стратеги /маркетинг/-ийн бодлогод шилжих;

-захиргаадалтын нэгт хэвийн санхүүгийн удирдлагыг олон талт, эрсдэлтэй санхүүгийн удирдлагад шилжүүлэх /бэлэн мөнгөний, өрийн,эрсдлийн удирдлагын арга барил эзэмших/-ийн тулд дараахь системийг нэвтрүүлэх:

-хөрөнгө үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн системийг өөрчлөх;

-нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт;

-удирдлагын мэдээллийн систем;

-чанарын удирдлагын систем ;

-олон улсын стандартын систем;

-ажиллах хүчний төлөвлөгөөт хуваарилалтаас хөдөлмөрийн өрсөлдөөнт зах зээлийн үеийн хүний нөөцийн удирдлагад шилжих;

-төсөл зохиох, зээл хүсэх, төлөвлөгөө боловсруулах, гэрээ байгуулах зэрэг баримт бичиг боловсруулах арга зүйд суралцан дадлагажих;

-үйл ажиллагаа явуулах ерөнхий соёлоо өөрчлөх;

-дотоод бүтэц, зохион байгуулалтаа өөрчлөх;

-үйл ажиллагааны тавих хяналтын тогтолцоогоо өөрчлөх.

4.3.Давтан сургалтын тогтолцоо бий болгох

Хувьчлалын дараахь өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлагыг ажлын мэргэшүүлэх сургалт, дадлагын үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Хувьчлал, бүтцийн өөрчлөлтийн улмаас ажлын байрнаас чөлөөлөгдсөн хүмүүсийг давтан сургах, дахин мэргэшүүлэх тогтолцоо бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

4.4.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг цөөрүүлэх

Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хууль тогтоомж, зах зээлийн нийтлэг дэг жаягт тохируулан чөлөөтэй явуулах боломжийг олгох үүднээс аж ахуйн үйл ажиллагааг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог боловсронгуй болгож, зөвшөөрлийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, аль болох нэг цэгт төвлөрүүлэх чиглэлээр өөрчлөн сайжруулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 11 **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс хувьчилж үл болох зөвхөнгийн жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтын "Зургаа. Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын салбар" гэсэн бүлэгт "Халдварт өвчин судлалын төв", "Сүрьеэгийн үндэсний төв"; "Долоо. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг" гэсэн бүлэгт "Улаанбаатар төмөр зам ХК" гэж тус тус нэмсүгэй.

2. Төрийн өмчөөс хувьчилж үл болох зөвхөнгийн жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.Эрүүл мэнд, боловсрол,соёл үргалгийн байгуулагуудыг хувьчлах асуудлыг нийгмийн салбар дахь хувьчлалыг зохицуулсан хууль батлагдсаны дараа шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсүгэй."

3.Мөн тогтоолоор баталсан жагсаалтаас "Хоёр. Дэд бүтцийн салбар" гэсэн бүлгийн 3-ын "Улсын геодези зураг зүйн газрын Аэрогеодезийн үйлдвэр, зураг зүйн үйлдвэр," "Тав. Соёл, боловсролын салбар" гэсэн бүлгийн 1-ийн "Их сургуулиуд" гэснийг тус тус хассугай.

4.Мөн тогтоолын 3 дахь хэсэг; хавсралтын "Хоёр. Дэд бүтцийн салбар" гэсэн бүлгийн 2, 4, 7, 9; "Зургаа. Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын салбар" гэсэн бүлгийн 4,5,6,7,8,9; "Долоо. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг" гэсэн бүлгийн 1-5, 8-18-ийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Дугаар 190 **Улаанбаатар хот**

Ган, зуд, ус, цаг агаарын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Ган, зуд, ус, цаг агаарын гэнэтийн аюул, гамшгаас улс оронд учирч байгаа хохирол, хор уршгийг багасгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ган, зуд болох эсэх тухай мэдээллийг 6 сараас доошгүй хугацааны өмнө, ус, цаг агаарын

аюултай болон гамшигт үзэгдлийн тухай мэдээллийг тухай бүр аймаг, сумын нутаг дэвсгэрээр нарийвчлан гаргаж, тэдгээрээс хамгаалах бэлтгэл хангахуйц хугацааны өмнө урьдчилан мэдээлж байх арга хэмжээг 2001-2003 онд үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболд, уг ажилд шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл авах хөрөнгийн гадаад, дотоод эх үүсвэрийг жил жилийн төвлөрсөн төсөвт тусгах замаар шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

2. Ган, зуд, ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн талаар шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, энэ чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах асуудлыг шийдвэрлэж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

3. "Ган, зуд, ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, "Нийтийн хэрэгцээнд зориулсан сэрэмжлүүлэх мэдээнд орох цаг агаарын аюултай үзэгдлийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор, "Нийтийн хэрэгцээнд зориулсан урьдчилан сэргийлэх мэдээнд орох цаг агаарын нэн аюултай буюу гамшигт үзэгдлийн жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлэсугай.

4. Хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийх, ноцтой бэрхшээл учуулах, түүнчлэн иргэдийн амь нас, эд хөрөнгө хохироод хүргэж болох цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай сэрэмжүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг холбоо, хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр шуурхай дамжуулан нийт иргэд, төр, засгийн бүх шатны удирдлагад хүргэж байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Орон нутгийн оршин суугчид, түүний дотор малчид, тариаланчид, тээвэрчдийг бага оврын радио хүлээн авагч, зай тэжээлээр зах зээлийн зарчмын дагуу хангах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Аймаг, сумдын ус цаг уурын салбаруудыг эрчим хүчний бие даасан эх үүсгүүр, харилцаа холбооогоор найдвартай хангах, түүнчлэн ган, зудын байдал, байгалийн аюул гамшгийн хохирлыг газар дээр нь судлан тодорхойлох, бэлчээрийн гарц, таримал ургамлын ургацыг нарийвчлан тогтоох зэрэг ажилд шаардагдах унаа, шатахууны болон бусад зардлыг жил бүрийн төсөвт нь тусгах арга хэмжээ авч байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Бэлчээрийн ургацыг баг, сум бүрээр тодорхойлсны үндсэн дээр жил бүрийн 9 дүгээр сард багтаан бэлчээрийн багтаамжийг тооцоолон сум, аймгийн болон улсын хэмжээгээр мал өвөлжилт, хаваржилтыг зохион байгуулах, тариаланчид, тээвэрчид, оторчдод зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх шуурхай төлөвлөгөө боловсруулан мөрдүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Байгаль орчны сайд У.Барсболд, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

8. Гамшигт үзэгдлийн мэдээллийн сан байгуулах, ган зуд, ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, түүнээс учирсан хохирол, байгаль, цаг уурын ховор үзэгдлийн тухай мэдээлэл, гэрэл зураг, дурс бичлэг бүхий материалыг байгуулагч, иргэдээс худалдан авч, уг санг баяжуулж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Байгаль, цаг агаарын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад хэргийн сайд **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Байгаль орчны сайд **У.БАРСБОЛД**

Засгийн газрын 2000 оны 190 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАН, ЗУД, УС, ЦАГ АГААРЫН АЮУЛТАЙ БОЛОН ГАМШИГТ ҮЗЭГДЛИЙН ТУХАЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭ ДАМЖУУЛАХ ЖУРАМ

1. Хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саатал, ноцтой бэрхшээл учруулах, түүнчлэн хүний амь нас, эд хөрөнгө хохироход хүргэж болох ус, цаг агаарын үзэгдлийг түүний учруулах хор хөнөөлийнх нь байдлаар аюултай, нэн аюултай буюу гамшигт үзэгдэл гэж ангилна.

2. Цаг агаарын аюултай, нэн аюултай буюу гамшигт үзэгдлийн жагсаалтыг Засгийн газар батална.

3. Ган, зуд, түүнчлэн ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээллийг мэргэжлийн байгууллагууд-Ус, цаг уурын хүрээлэн, аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв хариуцан гаргана.

4. Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээллийг хариуцан гаргасан байгууллага нь телефон, факс, электрон шуудангаар Засгийн газрын болон Улсын иргэний хамгаалалтын газрын зохих алба, хэвлэл, мэдээллийн байгууллагад энэ тухай нэн даруй дамжуулна. Радио, телевизийн байгууллага аюултай үзэгдлийн тухай сэрэмжлүүлгийг Засгийн газрын 2000 оны 26 дугаар тогтоолын дагуу, цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тухай мэдээг 15 минутын дотор тухайн үеийн нэвтрүүлгийн дундуур оруулан "Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ" гэсэн толгойтой, "Харанга" дохиотойгоор эфирт цацна. Радио, телевизийн нэвтрүүлэг зогссон цагаар гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг Улсын иргэний хамгаалалтын газар, түүний орон нутгийн салбараар дамжуулан олон нийтэд түгээнэ.

5. Ус, цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ зарласан үед аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга иргэний хамгаалалтын бэлэн байдлын аль нэгэн зэрэгт шилжихэд бэлэн байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулна. Ус, цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ зарласан болон урьдчилан зарлаагүй боловч гамшигт үзэгдэл эхэлсэн, эсвэл сэрэмжлүүлэх мэдээнд өгсөн үзэгдэл нь гамшгийн хэмжээнд хүрэхээр болсон үед аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, сум, дүүргүүдэд уг мэдээг өөрийн шугамаар яаралтай дамжуулах ба сумдын Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний өртөө, харуулын эзлэжийн техникч, ажиглагч нар сум, дүүргийн Засаг дарга, түүнийг орлох албан тушаалтанд уг мэдээг дамжуулан өгнө. Сум, дүүргийн Засаг дарга уг мэдээг хүлээн авмагц Тамгын газартаа байнгын жижүүр томилон урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулын үед ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.

6. Засаг дарга гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг хүлээн авмагц өөрийн харьяа нутаг дэвсгэрт мэдээллийг иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулахын зэрэгцээ гамшигт үзэгдлийн өрнөл, учруулсан хохирлын тухай иргэдийн мэдээллийг нэгтгэн дээд шатны Засаг дарга болон Ус, цаг уурын ойролцоохи өртөө, харуулд байнга мэдээлж байна.

7. Тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тохиолдсон ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, түүнээс учирсан хохирлын тухай шуурхай мэдээллийг Ус, цаг уурын өртөө, харуул "Аюул" мэдээгээр Ус, цаг уурын хүрээлэнд тухай бүр мэдээлж, хөдөө аж ахуйн цаг уурын 10 хоногийн мэдээлэлд заавал тусгаж байна.

8. Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаар нэгдсэн дүгнэлт гаргуулж аймаг, нийслэлийн Засаг дарга (Байнгын онцгой комисс), Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд 3 хоногийн дотор, аймгийн Байнгын онцгой комиссоос Улсын иргэний хамгаалалтын газарт, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс Ус, цаг уурын хүрээлэнд 7 хоногийн дотор тус тус ирүүлнэ.

9. Улсын иргэний хамгаалалтын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар дээрх мэдээллийг улсын хэмжээгээр нэгтгэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Улсын байнгын онцгой комисст илтгэнэ.

Засгийн газрын 2000 оны 190 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

НИЙТИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛСАН СЭРЭМЖЛҮҮЛЭХ МЭДЭЭНД ОРОХ ЦАГ АГААРЫН АЮУЛТАЙ ҮЗЭГДЛИЙН ЖАГСААЛТ

№	Цаг агаарын үзэгдлийн нэр	Эрч хүч /өртөө, харуул дээр/	Үргэлжлэх хугацаа
1	**Салхины их хурд**	16 м/с ба түүнээс их	3 цаг, түүнээс дээш
2	**Цасан шуурга**	Салхины хурд 12 м/с ба түүнээс их үед алсын бараа 2000 м-ээс бага болох	3 цаг, түүнээс дээш
3	**Шороон шуурга**	Салхины хурд 16 м/с ба түүнээс их	3 цаг, түүнээс дээш
4	**Бороо**	30 мм ба түүнээс их	12 цаг, түүнээс доош
5	**Цас, нойтон цас**	5 мм ба түүнээс их	12 цаг, түүнээс доош
6	**Аадар бороо**	30 мм ба түүнээс их	3 цаг, түүнээс доош
7	**Мөндөр**	Голч нь 10 мм хүртэл	Хугацаа хамаарахгүй
8	**Усны үер**	Гол мөрний ус үерийн түвшинд хүрэх	Хугацаа хамаарахгүй
9	**Хүйтэн бороо** (хонь хяргах үед)	Агаарын температур 11°С ба түүнээс бага, салхины хурд 6 м/с ба түүнээс их үед бороо үргэлжлэн орох	12 цаг, түүнээс дээш
10	**Цочир хүйтрэлт** /таримлын ургалтын хугацаанд/	Хөрсний гадаргын температур 0°С ба түүнээс бага	Хугацаа хамаарахгүй
11	**Ой, хээрийн түймэр**	Ангиллын 4 дүгээр зэрэгт хүрэх	Хугацаа хамаарахгүй
12	**Халуун, хуурай салхи**	Салхины хурд 8 м/с ба түүнээс их, агаарын харьцангуй чийгшил 30%-иас бага	2 хоног, түүнээс дээш
13	**Бэлчээр мөсжих**	Цасан бүрхүүлтэй үед дулаарсны дараа цас хайлмагтан мөсөн давхарга үүсэх	7 хоног, түүнээс дээш
14	**Замын мөстөлт** /хот суурингаар/	Цас, нойтон цас орж замын гадарга дээр мөсөн бүрхүүл үүсэх	Хугацаа хамаарахгүй
15	**Их хүйтэн болох**	Агаарын хамгийн бага температур Идэр, Тэс, Завхан голын хөндий, Увс, Дархадын хотгороор –50°С, Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр –35°С, бусад нутгаар -40°С-аас хүйтрэх	Хугацаа хамаарахгүй
16	**Их халуун болох**	Агаарын хамгийн их температур говийн нутгаар +40° С, хээрийн бүсэд +36° С, бусад нутгаар +32° С-аас давж халах	Хугацаа хамаарахгүй
17	**Эрс хүйтрэлт**	Агаарын хамгийн бага температур 20°С ба түүнээс ихээр буурах	Дараалсан 2 хоног

Засгийн газрын 2000 оны 190 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

НИЙТИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛСАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭНД ОРОХ ЦАГ АГААРЫН НӨН АЮУЛТАЙ БУЮУ ГАМШИГТ ҮЗЭГДЛИЙН ЖАГСААЛТ

№	Аюултай үзэгдлийн нэр	Эрч хүч /өртөө, харуул дээр/	Үргэлжлэх хугацаа
1	**Салхины их хурд**	28 м/с ба түүнээс их	Хугацаа хамаарахгүй
2	**Цасан шуурга**	Салхины хурд 16 м/с ба түүнээс их, алсын бараа 2000 м-ээс бага болох эсвэл цас орж байгаа эсэх нь мэдэгдэхгүй нүдгүй шуурах	6 цаг, түүнээс дээш
3	**Бороо**	50 мм ба түүнээс их	12 цаг, түүнээс доош
4	**Цас, нойтон цас**	10 мм ба түүнээс их эсвэл орсон цасны зузаан ойт хээрийн бүсэд 30 см, хээрийн бүсэд 26 см, Алтайн уулсаар 20 см, говийн нутгаар 15 см-ээс давах	12 цаг, түүнээс доош (цасны зузааны хувьд нэмэгдсэн дүнгээр)
5	**Аадар бороо**	30 мм ба түүнээс их	1 цаг, түүнээс доош
6	**Мөндөр**	Голч 10 мм ба түүнээс их	Хугацаа хамаарахгүй
7	**Хүйтэн бороо** (хонь хяргах үед)	Агаарын температур +8°С ба түүнээс бага, салхины хурд 6 м/с ба түүнээс их үед 5 мм-ээс их бороо үргэлжлэн орох	12 цаг, түүнээс дээш
8	**Цочир хүйтрэлт** /таримлын ургалтын хугацаанд/	Хөрсний гадаргын темпера-тур –5° С ба түүнээс бага	Хугацаа хамаарахгүй
9	**Усны үер**	Гол мөрний ус эргээсээ халих буюу аюултай түвшинд хүрэх	Хугацаа хамаарахгүй
10	**Уруйн үер**	Хүчтэй аадар борооны ус гуу жалга, хэвгий дагаж шавар, шороо, чулуутай холилдож хүйлран урсах	Хугацаа хамаарахгүй

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 13–ны өдөр **Дугаар 191** **Улаанбаатар хот**

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, түс яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 28 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад хэргийн сайд **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Дэд бүтцийн сайд **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2000 оны 191 дүгээр тогтоолын хавсралт

ДЭД БҮТЦИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.0. Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Дэд бүтцийн сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ егөх асуудлыг хамарсан Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", "Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН /94/102 тоолийн хүрээнд боловсруулсан "Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөр дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

Монгол Улсын Үндэсн хууль:
Монгол Улсын Засгийн газрын тухай хууль:
Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль:
Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль:
Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль:
Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль:
Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль:
Монгол Улсын Барилгын тухай хууль:
Монгол Улсын Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль:
Монгол Улсын Хот байгуулалтын тухай хууль:
Монгол Улсын Орон сууцны тухай хууль:
Монгол Улсын Орон сууц хувьчлах тухай хууль:
Монгол Улсын Орон сууц хувьчлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
Монгол Улсын Авто тээврийн тухай хууль:
Монгол Улсын Далай ашиглах тухай хууль:
Монгол Улсын Газрын бүртгэл, кадастрын зураглалын тухай хууль:
Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хууль:
Монгол Улсын Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулль:
Монгол Улсын Радио долгионы тухай хууль:
Монгол Улсын Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хууль:
Монгол Улсын Геодези, зураг зүйн тухай хууль:
Монгол Улсын Авто замын тухай хууль:
Бусад хууль тогтоомж

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага: үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт, дахин инженерчлэл: байгууллагын өөрчлөлтийн болон энэхүү бүтцээр ажиллах хугацаанд хуримтлагдсан арга зүй, мэдээллийг ашиглав.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Дэд бүтцийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Дэд бүтцийн сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Дэд бүтцийн яам нь салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс ерөнхий хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Дэд бүтцийн яам нь Засгийн газрын дэд бүтцийн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Дэд бүтцийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

ДЭД БҮТЦИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Дэд бүтцийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Дэд бүтцийн сайд, дэд сайд Засгийн газрын Танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн төвөгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Дэд бүтцийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.0.Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн

чанар

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Дэд бүтцийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Дэд бүтцийн яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Түлш, эрчим хүч, зам, тээвэр, байгалийн аялал жуулчлал, харилцаа холбоог хөгжүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, эдийн засгийн өсөлтийг хангахуйц дэд бүтцийн суурьзөвийг үндсийг бий болгох:

2. Дэд бүтцийн салбарын үдирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх:

3. Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийг дэмжих:

4. Дэд бүтцийн салбарт өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох:

5. Орон нутгийн эрдэс, түүхий эдэд тулгуурласан барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих:

6. Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйд ач холбогдол өгч улмаар түүний материаллаг баазыг бэхжүүлэх, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх:

7. Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго:

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Дэд бүтцийн яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Дэд бүтцийн салбарын стратегийн төлөвлөлт, бодлого, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамжаар хангах:

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах:

3.Дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Дэд бүтцийн яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана.

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1 Дэд бүтцийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах:

1.2 Дэд бүтцийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах.

1.3 Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах:

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах:

2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах:

2.3. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц дэд бүтцийн суурьзөвийг хөгжүүлэх

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Бодлого, төлөвлөгөө,хөтөлбөр, төсөл хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /Мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх:

3.2. Дэд бүтцийн салбарын мэдээллийн сүлжээ хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.


2.6. Үйл ажиллагааны зорилт

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны гол зорилт бол тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Дэд бүтцийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ДЭД БҮТЦИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3.0.Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим /тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр

нь аль нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим / байгууллагын нэр, бүтцээс туахйн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал ямны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим /тухайн ямны төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн /гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх/

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим /байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/


6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /Тухайн ямны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөл автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх/ -

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Дэд бүтцийн ямны үйл ажиллагаа /бизнес/-ны загварыг үндэслэн тус ямны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

ДЭД БҮТЦИЙН ЯМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3 Зохион байгуулалтын бүтэц

Дэд бүтцийн ямны үйл ажиллагаа /бизнес/ -ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус ямны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжийг санал болгож байна.

1. Стратегийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгжүүд нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, тесөл боловсруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндэсн үүргийг хүлээж, дэд бүтцийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, тесөл боловсруулах бодлогын хэрэгжилт зохицуулах

үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжүүд байна.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Дэд бүтцийн сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангах асуудлыг хариуцна.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай тунshiйн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Дэд бүтцийн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь дэд бүтцийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Дэд бүтцийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

Энэ нэгжийн үйл ажиллагааны хүрээнд түлш, эрчим хүч: зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал жуулчлал: барилга, хот байгуулалтын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн чиглэлийн газруудаж ажиллана.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган, гадаад хамтын ажиллагаог өргөжүүлэх үндсэн үүргийг хүлээж, ямны үйл ажиллагааанд удирдлагын шилдэг тэрүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, хамтын ажиллагаог зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны иэргэшсэн албаны хүчээр ямны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг ханган хангах чиглэнэ.

Энэ нь Дэд бүтцийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад болон ямны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Дэд бүтцийн сайд, дэд сайд, ямны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгуулага байна.

3.Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/хийж, үнэлж дүгнэх нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, дэд бүтцийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр ханган зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг ханган, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаог сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр үзүүлэх тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчигээний үндсэн хэрэглэгч нь Дэд бүтцийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгуулага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 13–ны өдөр **Дугаар 192** **Улаанбаатар хот**

Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын ҮШ хуралдааны дүнгийн тухай

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын ҮШ хуралдааны Протоколыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын ҮШ хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Төлөвлөгөөний биелэлтийн явцын талаар Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэгт мэдээлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад хэрэгийн сайд **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Дэд бүтцийн сайд **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2000 оны 192 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ-ОРОСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССЫН VIII ХУРАЛДААНЫ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Монголын экспортын барааны оросын талаас ногдуулж байгаа импортын татварыг бууруулах, төмөр замын тарифыг хөнгөлөх, тарифын бус хязгаарлалтуудыг зөөлөвчлөх зэрэг иж бүрэн асуудлыг хоёр талын худалдааг либералчлах хамтарсан ажлын хэсгийн хүрээнд болон ОХУ-ыг ДХБ-д нэгдэн оруулах асуудлаархи ДХБ-ын ажлын хэсгийн хэмжээнд хэлэлцэх

2001 онд
ҮХЯ Ч.Ганзориг, ГХЯ Л.Эрдэнэчулуун, СЭЗЯ Ч.Улаан,
УГЕГ Х.Баатар, "УБТЗ" Р.Раш

2. ОХУ-д мах импортлоход мал эмнэлгийн хяналтыг хөнгөвчлөх талаар Оросын талд өгсөн саналын дагуу ажиллах

2001 оны I улирал
ХХАА Я Д.Насанжаргал
ҮХЯ Ч.Ганзориг

3. Үл хөдлөх хөрөнгийн асуудлаар байгуулагдсан ажлын хэсгийг шинэчлэн ойрын хугацаанд хуралдуулах

2001 оны эхний улиралд
ГХЯ Л.Эрдэнэчулуун,
ҮХЯ Ч.Ганзориг

4. Гаалийн бүртгэл хийх аргачлал, дүрмийн талаар зөвлөлдөх уулзалт хийх

2001 оны эхний хагаст
УГЕГ Х.Баатар
ҮХЯ Ч.Ганзориг

5. Алтанбулаг-Кяхтын боомтын Монголын талын хэсгийг барих ажлыг түргэтгэж дуусгах талаар арга хэмжээ авах

2001 онд
ДБЯ Б.Жигжид
УГЕГ Х.Баатар

6. Цагааннуур-Ташант, Арцсуурь-Цагаантолгой, Тэс-Шарсуурь, Боршоо-Хандгайтын хилийн боомтуудыг тохижуулах, боомтуудын барилгын ажлын явцтай танилцах Талуудын мэргэжилтнүүдийн уулзалтыг зохион байгуулах

2001 онд
СЭЗЯ Ч.Улаан, ХЗДХЯ Ц.Нямдорж, ҮХЯ Ч.Ганзориг,
УГЕГ Х.Баатар, Хилийн цэргийн удирдах газар П.Сүндэв

7. Хил орчмын бүсэд гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

2001 оны эхний хагаст
БОЯ У.Барсболд, ГХЯ Л.Эрдэнэчулуун, ХЗДХЯ-ны харьяа Гал түймэртэй тэмцэх

газар

8. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын хүрээнд түлш, эрчим хүчний цогц асуудлаар ажлын хэсэг байгуулах

2001 оны эхний хагаст
ДБЯ Б.Жигжид
ҮХЯ Ч.Ганзориг

9. Нүүрсний аж үйлдвэрийн талаархи ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх

2001 онд
ДБЯ Б.Жигжид

10. Эрчим хүчний объектуудын шинэчлэл, засвар хийхэд хамтран ажиллах талаар Оросын талын хүсэлтийг судалж санал солилцох

2001 оны эхний хагаст
ДБЯ Б.Жигжид

11. Оросын талаас 2000 онд багтааж Монголд нийлүүлж буй цахилгааны эрчим хүчний тарифыг бууруулах талаар ОХУ-ын холбогдох байгууллагуудтай хэлэлцээр хийж тохиролцох

2000 онд багтааж
ДБЯ Б.Жигжид, ЭХУГ Т.Энхтайван

12. Монголоос ОХУ-д шөнийн цагаар нийлүүлж буй эрчим хүчний төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх талаар ОХУ-ын холбогдох байгууллагуудтай ярилцаж тохиролцох арга хэмжээ авах

2001 оны эхний хагаст
ДБЯ Б.Жигжид, ЭХУГ Т.Энхтайван

13. Үрийн болон таваарын буудайг Оросын талаас авах захиалгыг холбогдох журмын дагуу өгөх

2001 оны I улиралд
ХХААЯ Д.Насанжаргал

14. Төмс, хүнсний ногоо, тэжээлийн чиглэлийн хамтарсан аж ахуй байгуулах боломжийг судлах, усны аж ахуйн салбарын хамтын ажиллагаагаг тодорхой чиглэлүүдээр сэргээх чиглэлээр ажиллах

2001 он
ХХААЯ Д.Насанжаргал, ГХЯ Л.Эрдэнэчулуун

15. БНМАУ, ЗХУ-ын Засгийн газар хоорондын "УБТЗ"-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Хэлэлцээр, дүрмийг шинэчлэх талаар хийгдэж байгаа яриа хэлэлцээг түргэтгэх

2001 оны эхний улиралд
ДБЯ Б.Жигжид, "УБТЗ" Р.Раш

16. "УБТЗ" нийгэмлэгийн засварын бааз болон зүтгүүр, зам, зорчигч тээврийн аж ахуйг бэхжүүлэх талаар санал боловсруулах

2001 оны эхний улиралд
ДБЯ Б.Жигжид, "УБТЗ" Р.Раш

17. 1991-2000 онд хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр болон "Монголросцветмет" нийгэмлэгийн газар болон газрын хэвлийг ашигласны төлбөрийг ам.долларааp тогтоох чиглэлээр ажиллах

2001 оны эхний хагаст
ҮХЯ Ч.Ганзориг, БОЯ У.Барсболд

18. ОХУ-д төлөх урсгал өрөнд 2000 онд 3 сая ам.долларын, 2001 онд 8 хүртэл сая ам.долларын хайлуур жоншны баяжмал нийлүүлэх асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох арга хэмжээ авах

2000-2001 онд
ҮХЯ Ч.Ганзориг
СЭЗЯ Ч.Улаан

19. Хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр болон "Монголросцветмет" нэгдлийг байгуулах тухай Засгийн газар хоорондын 1991.06.05-ны өдрийн Хэлэлцээрүүдийн 14 дүгээр зүйлийн дагуу тэдгээрт нийлүүлэгдэж байгаа бараа, материал, шатах тослох материалыг импортын татвараас чөлөөлөх арга хэмжээ авах

2001 онд
СЭЗЯ Ч.Улаан, ҮХЯ Ч.Ганзориг

20. Хоёр орны хооронд чөлөөт худалдааны талаар Засгийн газар хоорондын Хэлэлцээр байгуулах боломжийг судалж санал боловсруулах

2001 онд
ҮХЯ Ч.Ганзориг, ГХЯ Л.Эрдэнэчулуун

21. Бүс нутаг, хилийн хамтын ажиллагааны дэд комиссын ээлжит хуралдаан хийх

2000 онд
ГХЯ Л.Эрдэнэчулуун, ҮХЯ Ч.Ганзориг

22. Хилийн бүс нутгийн эрх зүйн байдал болон түүний үйл ажиллагааны зарчмыг

тодорхойлсон хилийн бүс нутгийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах

2001 онд
ГХЯ Л.Эрдэнэчулуун
ҮХЯ Ч.Ганзориг

23. Улсын хил дээр гарч буй малын хулгай болон бусад ахуйн чанартай хилийн зөрчилтэй тэмцэх талаар хобогдох бичиг баримтуудад гарын үсэг зурах чиглэлээр ажиллах

2000 онд
ГХЯ Л.Эрдэнэчулуун, ХЗДХЯ Ц.Нямдорж

24. ЗСБНХУ-аас БНМАУ-д шилжих рублиэр олгосон зээлийн асуудлыг зохицуулах ажлын хэсгийн Монголын талын бүрэлдэхүүнийг шинэчлэн хэлэлцэх хийх

2001 оны эхний хагаст
СЭЗЯ Ч.Улаан

25. ОХУ-аас Хятад болон Зүүн хойд Ази руу тавих нефть, байгалийн хийн хоолой болон цахилгаан эрчим хүчний шугамыг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайруулах асуудлыг Оросын талтай үргэлжлүүлэн ярих

2001 онд
ГХЯ Л.Эрдэнэчулуун, ДБЯ Б.Жигжид, ҮХЯ Ч.Ганзориг

26. Шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, спортын салбарт хамтран ажиллахаар тохиролцсоны дагуу Монголд орос хэлний сургалт, арга зүйн төв, техникийн чиглэлийн боловсролын төв байгуулах, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааны Протоколыг шинэчлэх, номын сангийн болон биеийн тамир спортын хамтын ажиллагаа сэргээх, ОХУ-д сурч байгаа монгол иргэдэд олгож буй тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх, сурапцагсдын тоог 200 хүргэх, боловсролын үнэмлэх, эрдмийн зэрэг цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээр байгуулах зэрэг чиглэлээр ажиллах

2001 онд
БСШУЯ А.Цанжид, ЭМЯ П.Нямдаваа, ГХЯ Л.Эрдэнэчулуун

27. Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд 1996 онд байгуулсан Геологийн судалгаа, газрын хэвлийг эзэмших салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээрийн дагуу тус салбарын цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг боловсруулах

2001 онд
ҮХЯ Ч.Ганзориг

28. Одоогийн үйлдвэрлэлийн бааз, мэргэжлийн боловсон хүчнийг оновчтой ашиглан Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, Чойбалсан хотын хивсний үйлдвэрүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, цаашид тогтвортой ажиллуулах талаар судлан үзэж санал боловсруулах

2001 онд
ҮХЯ Ч.Ганзориг

29."Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай" 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газар хоорондын Хэлэлцээрт хөнгөлөлттэй нөхцөлөөр сургалтад хамаарагдах, техник, багаж авах тухай нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллах

2001 онд
ГХЯ Л.Эрдэнэчулуун,
Иргэний хамгаалалтын газар О.Үржин

30.Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах

2001 онд
ДБЯ Б.Жигжид

31.Засгийн газар хоорондын Комиссын IX хуралдааны бэлтгэлийг ханган оролцох

2001 оны IY улиралд
ЗГХК-ын Монголын хэсэг.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (193)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын Төрийн ордны тухай*
- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай*
- *Эрчим хүчний тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *"Монгол Улсын гавьяат малчин" цол бий болгох тухай*
- *Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медаль бий болгох тухай*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль товлон зарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны хоёрдугаар сарын 14 №6 (193)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

52. Гэрээ соёрхон батлах тухай (2001-1-26-ны хууль) 144
53. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-2-1-ний хууль) 144
54. Монгол Улсын Төрийн ордны тухай (2001-2-1-ний хууль) 146
55. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (2001-2-1-ний хууль) 149
56. Эрчим хүчний тухай (2001-2-1-ний хууль) 154
57. Эрчим хүчний тухай хууль (1995 оны) хүчингүй болсонд тооцох тухай (2001-2-1-ний хууль) 166
58. Гэрээ соёрхон батлах тухай (2001-2-2-ны хууль) 166
59. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-2-2-ны хууль) 166
60. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-2-2-ны хууль) 167
61. Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай (2001-2-2-ны хууль) 168
62. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-2-2-ны хууль) 168

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

63. Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнийг томилох тухай Дугаар 12 168
64. Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 13 168
65. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 14 169
66. Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 15 169
67. Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, зааг тогтоох

тухай	Дугаар 16	169
68. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 17	170
69. Эрчим хүчний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 18	170
70. Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 19	170
71. "Монгол Улсын гавьяат малчин" цол бий болгох тухай	Дугаар 20	171
72. Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медаль бий болгох тухай	Дугаар 21	171
73. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль товлон зарлах тухай	Дугаар 22	173
74. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай	Дугаар 23	173
75. 2001 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 24	174

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын Экспорт-Импорт банк /Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан/-ны хооронд 2000 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Төрийн холбооны сүлжээг өргөтгөн шинэчлэх төслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр — **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 24, 28, 33 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/ 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Саналын хуудас хэвлэгдсэнээс хойш нэр дэвшигч нэрээ татахыг хориглоно."

2/ 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Нэр дэвшигч, түүний шадар туслагч, ухуулагч, талархан дэмжигч этгээд, нам, хамтарсан намууд сонгогчдын санал худалдаж авах, сонгогчид, тэдний хүүхдүүдэд эд, мөнгөний тусламж олгох, худалдаа, ахуй болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлагийн тоглолт зохиох, шашны зан үйлийг ашиглах, сонгуульд үл хамаарах ажил, үйлчилгээ явуулахыг хоригломо.

Зөвхөн нэр дэвшигчийн сурталчилгааг орон даяар эхлэх, дуусахад зориулж нийслэл, аймгийн төвүүдэд урлагийн тоглолтыг нэр дэвшүүлсэн намаас зохион байгуулж болно."

3/ 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Саналын хуудсыг сонгуулийн хэсэгт ирүүлснээс хойш санал авах өдөр дуусах хүртэлх хугацаанд сонгогч түр шилжин явахад хүрвэл сонгуулийн хэсгийн хороонд ирж саналын хуудас авч, саналаа нууцаар тэмдэглэж, дугтуйлаад, битүүмжлэн үлдээж болно. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчийн битүүмжлэн үлдээсэн саналын нууцыг чандлан хадгална."

2 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "нэр дэвшиг" гэсний дараа "сонгогч" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь догол мөр, 8 дугаар зүйлийн 3, 28 дугаар зүйлийн 3, 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь догол мөр:

"Нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс сонгуульд зориулж өргөсөн хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс 10 сая, иргэдээс 5 сая төгрөгөөс хэтэрч болохгүй."

2/ 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Сонгогчдоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хороо, түүний гишүүнээс үүргээ гүйцэтгэх, санал хураах, тоолох ажилд саналтайгаар саад хийсэн, бусдыг төлөөлж санал өгсөн, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгууллагад 200000-250000, иргэнд 40000-50000 төгрөгийн торгуульд шүүх ногдуулна."

3/ 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Сонгуулийн ерөнхий хороо нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, хамтарсан намууд, нэр дэвшигч Монголын үндэсний радио, телевизээр телбертэй болон төлбөргүй явуулах нэвтрүүлгийн хугацаа, боломж нь адил байхаар тооцон, хуваарь хийж, санал авах өдрийг товлон зарласнаас хойш 15 хоногийн дотор батална. Ерөнхийлөгчид хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг нэг субъект гэж үзнэ.

Монголын үндэсний радио, телевизээр Сонгуулийн ерөнхий хорооны батлансан хуваарьт зааснаас өөр төлбертэй ба төлбөргүй нэвтрүүлэг явуулж үл болно."

4/ 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Саналын хуудас олгосныг сонгогчдын нэрийн жагсаалтад, сонгогч саналаа өгснийг сонгогчийн үнэмлэхэд тэмдэглэж, сонгуулийн хэсгийн хорооны тэмдэг дарна. Мөн Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон тусгай тэмдэг тавьж болно."

4 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн "нэг сарын дотор" гэснийг "21 хоногийн дотор"; "гурван сарын дотор" гэснийг "хоёр сарын дотор"; 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "1000-10000" гэснийг "4000-50000"; мөн зүйлийн 5 дахь хэсгийн "2000-20000" гэснийг "4000-50000"; мөн зүйлийн 6 дахь хэсгийн "2000-10000" гэснийг "4000-60000"; мөн зүйлийн 7 дахь хэсгийн "50000-100000" гэснийг "100000-250000"; мөн зүйлийн 8 дахь хэсгийн "1000-20000" гэснийг "2000-50000"; "2000-40000" гэснийг "4000-60000"; мөн зүйлийн 9 дэх хэсгийн "2000-10000" гэснийг "4000-20000"; мөн зүйлийн 10 дахь хэсгийн "2000-10000" гэснийг "4000-20000"; 9 дүгээр зүйлийн "75-аас" гэснийг "60-аас"; 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "70 хоногийн" гэснийг "55 хоногийн"; 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "65 хоногийн" гэснийг "50 хоногийн"; 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "60 хоногийн" гэснийг "45 хоногийн"; 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "55 хоногийн" гэснийг "40 хоногийн"; 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "50 хоногийн" гэснийг "30 хоногийн"; мөн зүйлийн 4 дэх хэсгийн "45-аас" гэснийг "30-аас"; 20 дугаар зүйлийн "7" гэснийг "5"; "15" гэснийг "5"; 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "25 хоногийн" гэснийг "13 хоногийн"; 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "саналаа хураахаас" гэснийг "санал хураах өдрөөс"; 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "30 хоногийн" гэснийг "15 хоногийн"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "60 хоногийн" гэснийг "30 хоногийн" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн байгууллагын харьяалал бүхий", 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "нэр дэвшигчийн нэмтар", мөн зүйлийн 8 дахь хэсгийн "төрийн төв", 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 3 дахь заалтын "санал огт тэмдэглээгүй, эсхүл" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1–ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн ордон /цаашид "Төрийн ордон" гэх/-ы эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний хамгаалалт, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын Төрийн ордны тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Төрийн ордны тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэр

3.1.Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болон төрийн төрүүн, гүйцэтгэх дээд байгууллага байнга байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа барилгыг Төрийн ордон гэнэ. Эдгээр байгууллагуудын түр байрлаж байгаа барилгыг Төрийн ордонтой адилд үзнэ.

3.2.Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг Монгол Улсын Их Хурал тогтооно.

4 дүгээр зүйл.Төрийн ордонд байрлах байгууллага

4.1.Төрийн ордонд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, тэдгээрийн Тамгын газар, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус тус байрлаж үйл ажиллагаагаа явуулна.

4.2.Төрийн ёслол, үйлчилгээ, хамгаалалтын асуудал эрхэлсэн байгууллага Төрийн ордонд байрлаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төрийн ордны эрх зүйн байдал, дотоод зохион байгуулалт

5 дугаар зүйл.Төрийн ордны эрх зүйн байдал

5.1.Төрийн ордон халдашгүй дархан байна.

5.2.Төрийн ордны халдашгүй дархан байдлыг энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хамгаалалт, үйлчилгээний тусгай журмын дагуу хангана.

6 дугаар зүйл.Төрийн ордны дотоод зохион байгуулалт

6.1.Төрийн ордны дотоод зохион байгуулалт, өрөө, тасалгааны хуваарилалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай санал солилцсоны үндэсэн дээр Улсын Их Хурлын дэд дарга ажлын байрны жишиг шаардлагад нийцүүлэн тогтооно.

6.2.Төрийн ордон нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхим, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны танхим, Засгийн газрын хуралдааны танхим, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны хуралдааны танхим болон бусад хурал, зөвлөлгөөн, уулзалтын танхимтай байна.

6.3.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхим, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны танхим, Засгийн газрын хуралдааны танхимд зөвхөн Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, Засгийн газрын хуралдааныг тус тус хийнэ.

6.4.Энэ зүйлийн 3-д зааснаас бусад танхимд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас зохион байгуулж байгаа хурал, зөвлөлгөөн, уулзалт, бусад арга хэмжээ явуулах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга тус тус зохицуулан шийдвэрлэнэ.

6.5.Төрийн хүндэтгэлийн өрөө, уулзалтын өрөөнд явуулах төрийн ёслолын арга хэмжээг Төрийн ёслолын алба хариуцна.

6.6.Төрийн хүндэтгэлийн тасалгаанд төрийн далбаа, сүлд, соёмбо болон төрийн хүндэтгэлийн бусад зүйлийг хуульд заасны дагуу байрлуулна.

6.7.Төрийн тугийг Төрийн бэлгэ[1] тэмдгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Төрийн ордонд байрлуулна.

[1]Төрийн бэлгэ тэмдгийн тухай - "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны №6-д нийтлэгдсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээ

7 дугаар зүйл.Төрийн ордны хамгаалалт

7.1.Төрийн ордон нь дотоод болон гадуур байнгын хамгаалалттай байна. Төрийн ордныг Төрийн тусгай хамгаалалтын тухай[1] хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар Төрийн ордны хамгаалалтын алба 24 цагаар тасралтгүй хамгаална.

7.2.Төрийн ордон нь түүнд байрлаж үйл ажиллагаа явуулдаг байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.

7.3.Төрийн ордны гадуур хамгаалалт нь Улсын Их Хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүхэлд нь хариуцна.

7.4.Төрийн ордонд шалган нэвтрүүлэх, аюулгүй байдал, дэг журмыг хангах асуудлыг дотоод хамгаалалт хариуцна.

7.5.Төрийн ордонд аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай хяналтын техник, хэрэгслийг суурилуулах бөгөөд Төрийн ордны хамгаалалтын албаны ажилтан үзэлг хийх нэг бүрийн хэрэгслээр хангагдсан байна.

7.6.Төрийн ордны хамгаалалтад тохирсон хүч хэрэгслийн хэмжээ, тэдгээрийг хамгаалалтын тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэглэх журмыг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хэрэжүүлнэ.

7.7.Иргэд, байгууллагын тодорхой үйлдлийн улмаас Төрийн ордонд байрладаг байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын саналыг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр Төрийн ордныг хүч нэмэгдүүлэн хамгаалж болно.

8 дугаар зүйл.Төрийн ордонд нэвтрэх

8.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас бусад хүмүүс Төрийн ордонд нэвтрэхдээ үнэмлэх, нэвтрэх хуудсаа шалгуулж орох үүрэгтэй.

8.2.Төрийн ордонд байрладаг төрийн байгууллагын ажилтан эрх бүхий албан тушаалтнаас олгосон байнгын үнэмлэхээр Төрийн ордонд нэвтэрнэ.

8.3.Төрийн ордонд нэвтрэх бусад хүмүүс хамгаалалтын албаны эрх бүхий албан тушаалтнаас олгосон байнгын буюу тур үнэмлэхээр түүнд заасан хаалгаар орж гарна.

8.4.Төрийн ордонд гадаад улсын төлөөлөгчдийг нэвтрүүлэх журмыг төрийн ёслолын асуудал хариуцсан байгууллага тогтоож мөрдөнө.

8.5.Албан ажлын шаардлагаар ажлын бус цагт Төрийн ордонд нэвтрэх журмыг ордны хамгаалалтын алба Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн зөвшөөрлийг үндэслэн тогтооно.

8.6.Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн ордны хамгаалалтын албанаас тогтоосон журмын дагуу иргэдийг Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулж болно.

9 дүгээр зүйл.Төрийн ордны үйлчилгээ

9.1.Төрийн ордны үйлчилгээ нь түүнд байрлаж байгаа байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулах, ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийн жишиг шаардлагыг хангасан байна.

9.2.Төрийн ордонд үйлчилгээ явуулах болон засвар хийх журмыг Төрийн ордны үйлчилгээ хариуцсан байгууллага Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн ордны хамгаалалтын албатай зөвшилцөн тогтоож, мөрдөнө.

10 дугаар зүйл.Төрийн ордонд тавих шаардлага

10.1.Төрийн ордны агаар, чийгшил, дулаан нь ариун цэвэр, эрүүл ахуйн жишиг шаардлагыг хангасан байна.

10.2.Төрийн ордон нь төрийн дээд байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулахад зориулагдсан техник, тоног төхөөрөмж, инженерийн байгууламжаар тоноглогдсон байна.

10.3. Төрийн ордон, түүний инженерийн байгууламж нь газар хөдлөлт, гал, усны аюулаас найдвартай хамгаалагдсан байх бөгөөд мэргэжлийн албадын байнгын хяналтад байна.

[1]Төрийн тусгай хамгаалалтын тухай - "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны №7-д нийтлэгдсэн.

10.4.Төрийн ордны цахилгаан, дулааны эрчим хүч, холбоо, усан хангамжийг түдгэлзүүлж үл болно.

10.5. Төрийн ордон нь галын мэргэжлийн албаны байнгын харуул, хамгаалалт, гал унтраах болон галын дохиоллын техник хэрэгсэлтэй байна.Төрийн ордны галын мэргэжлийн албаны харуул хамгаалалт, галын аюулгүй байдлын дэг журмыг Төрийн ордны үйлчилгээ хариуцсан байгууллагын дарга, галын аюулгүй байдлын улсын хяналтын ерөнхий байцаагчийн хамтарсан шийдвэрээр зохицуулна.

10.6.Төрийн ордны өнгө төрх, засал чимэглэл, тавилга бусад зүйлийн хийц, загварын талаар баримтлах бодлогыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар тогтоно.

10.7.Төрийн ордонд ажилладаг албан хаагч нь ажлын байрандаа албаны хувцастай байна.

10.8.Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний ажилтан нь тус бүрийн ажлын онцлог, шаардлагад тохирсон нэг ижил хийц, загварын ажлын хувцастай байна.

11 дүгээр зүйл.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт хориглох зүйл

11.1.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт дор дурдсан зүйлийг хориглоно:

11.1.1.энэ хуульд зааснаас бусад байгууллага Төрийн ордонд байрлах;

11.1.2.Төрийн ордны хурал, зөвлөлгөөн, уулзалтын танхим, албан тасалгаанд энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа явуулах;

11.1.3.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийн дагуу цэргийн жагсаал, баяр ёслол үйлдэх болон хуульд заасан үндэслэл бий болсны улмаас Төрийн ордныг хамгаалах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд Төрийн ордны нутаг дэвсгэрт цэрэг, цагдаагийн хүч, байлдааны зэвсэг, техник хуралдуулах;

11.1.4.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлэх, Төрийн ордонд нэвтрэгчид саад хийх;

11.1.5.Төрийн ордны нутаг дэвсгэрт Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих, хамгаалалтын албаны зөвшөөрөлгүйгээр засварын ажил хийх, газар ухах;

11.1.6.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт энэ хуулийн 9.2.-т заасан журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад үйлчилгээ явуулах.

11.2.Төрийн ордонд нэвтрэгчид дор дурдсан зүйлийг хориглоно:

11.2.1.тэсэрч дэлбэрэх, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, хордуулах, мансууруулах болон цацраг идэвхт бодис, зэвсэг хэрэгсэл авч орох;

11.2.2.зохих журмын дагуу олгосон нэвтрэх үнэмлэхэд зааснаас өөр хаалгаар нэвтрэх, үнэмлэхэд заасан хугацаар хэтрүүлэх, бусдын үнэмлэхийг ашиглах;

11.2.3.Төрийн ордон дахь эд хөрөнгө, хүндэтгэлийн зүйлийг гэмтээх;

11.2.4.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт согтуугаар нэвтрэх, төрийн ёслолын чанартай арга хэмжээнээс бусад тохиолдолд соггуруулах ундаа хэрэглэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

12 дугаар зүйл.Төрийн ордны санхүүжилт

12.1.Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээ, засвар, хангалтын зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.

13 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13.1.Монгол Улсын Төрийн ордны тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий албан тушаалтан зөрчилийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

13.1.1.энэ хуулийн 10.5 –д заасныг зөрчсөн иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 30000-60000 төгрөг, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

13.1.2.энэ хуулийн 11.1.2-д заасныг зөрчиж Төрийн ордны хурал, зөвлөлгөөн, уулзалтын танхим, өрөө, албан тасалгааНд энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа явуулсан албан тушаалтныг 20000-60000 төгрөг, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

13.1.3.энэ хуулийн 11.1.4-д заасныг зөрчиж Төрийн одон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсөлөн, суулт хийх зэргэр шаардлагаа илэрхийлсэн, Төрийн одонд нэвтрэгчид саад хийсэн иргэнийг 20000-50000 төгрөг, албан тушаалтныг 20000-60000 төгрөг, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

13.1.4.энэ хуулийн 11.1.5-д заасныг зөрчиж Төрийн ордны нутаг дэвсгэрт Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барьсан, хамгаалалтын албаны зөвшөөрөлгүйгээр засварын ажил хийсэн, газар ухсан иргэнийг 20000-50000 төгрөг, албан тушаалтныг 20000-60000 төгрөг, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгож, хийж байгаа ажлыг нь зогсоон нутаг дэвсгэрийг хэвийн байдалд сэргээлгэнэ;

13.1.5.энэ хуулийн 11.1.6-д заасныг зөрчиж Төрийн ордны нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөнөөс бусад үйлчилгээ явуулсан иргэнийг 20000-50000 төгрөг, албан тушаалтныг 20000-60000 төгрөг, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгож, уг зүйлийг хураах;

13.1.6.энэ хуулийн 11.2.1-д заасныг зөрчиж тэсэрч дэлбэрэх, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах хордуулах, мансууруулах болон цацраг идэвхт бодис, хэвсэг хэрэгсэл авч орсон буюу орохыг завдсан албан тушаалтан, иргэнийг 20000-50000 төгрөгөөр торгож, эд зүйлийг хураах;

13.1.7.энэ хуулийн 11.2.3-д заасныг зөрчиж Төрийн ордон дахь эд хөрөнгө, хүндэтгэлийн зүйлсийг гэмтээсэн иргэнийг 5000-50000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг зохих журмын дагуу төлүүлнэ;

13.1.8.энэ хуулийн 11.2.4-д заасныг зөрчиж Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт согтуугаар нэвтэрсэн, төрийн ёслолын чанартай арга хэмжээнээс бусад тохиолдолд согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг 5000-20000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагаат эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж

2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай[1], Газрын хэвлийн тухай[2], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай[3], Байгалийн ургамлын тухай[4], Ан агнуурын тухай[5], Амьтны аймгийн тухай[6], Ойн тухай[7], Усны тухай[8] хуулиар тус тус зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан үтгаар ойлгоно:

3.1.1." аж ахуйн үйл ажиллагааны

[1] Газрын тухай –"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 2 дугаарт нийтлэгдсэн.
[2] Газрын хэвлийн тухай –"Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл" сэтгүүлийн 1988 оны № 11 дугаарт нийтлэгдсэн.
[3] Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай –"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 2 дугаарт нийтлэгдсэн.
[4] Байгалийн ургамлын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.
[5] Ан агнуурын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.
[6] Амьтны аймгийн тухай –"ТМ" сэтгүүлийн 2000 оны № 19 дугаарт нийтлэгдсэн.
[7] Ойн тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.
[8] Усны тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.

тусгай зөвшөөрөл" /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ –гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;

3.1.2. "тусгай зөвшөөрөл хэмжигч " гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн агуулга

4.1.Тусгай зөвшөөрөлд дор дурдсан зүйлийг тусгана:

4.1.1. тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

4.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;

4.1.3. эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл;

4.1.4.тусгай зөвшөөрлийн хугацаа;

4.1.5.тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

4.1.6. тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;

4.1.7.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ

5.1. Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.

5.2. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн бүртгэх байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

6.1.Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

6.2.Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.

6.3. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацаа сунгана.

6.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахгүй.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам

7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.

7.2.Бүх төрлийн хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоолны үйлчилгээг үйлдвэрлэлийн нөхцөл, технологийн ажиллагаа, бүтээгдэхүүнийхээ дээжийг зохих хяналтын байгууллагад шалгуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

7.3.Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

7.4. Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

8.1.1.хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах;

8.1.2.садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

8.1.3.казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны зарааар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим ,шаардлага

9.1. Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараахь зарчмыг баримтална:

9.1.1. улс орныг батлан хамгаалах

болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

9.1.2. аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;

9.1.3. ил тод, шуурхай байх ;

9.1.4. зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох .

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллагын эрх

10.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараахь эрхтэй :

10.1.1. хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох;

10.1.2. тусгай зөвшөөрлийг буртгэх;

10.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

10.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

10.1.5. тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

11.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ :

11.1.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;

11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5.тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;

11.1.6.энэ хуулийн 15.5.7; 15.5.8; 15.6.1-15.6.3; 15.6.5; 15.8.3; 15.8.8; 15.8.18; 15.8.20; 15.10.4.-15.10.6; 15.11.2; 15.12.1-15.12.6-д. заасан аж ахуйн үйл ажиллагаагүй эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авсан байна.

11.2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

12.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12.2.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

12.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

12.4.Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацаа 14 хоногоор сунгаж болно.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

13.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.2. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

13.3.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

14.1.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

14.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

14.1.2. хуулийн этгээд татан буугдсан;

14.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон ;

14.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн;

14.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

14.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.1.Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

15.2.Банкны үйл ажиллагааны чиглэлээр:

15.2.1.банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх.

15.3.Үнэт цаастай холбоотой аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр:

15.3.1. андеррайтер, брокер, дилер, хөрөнгийн бирж, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, хөрөнгө оруулалтын сан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

15.3.2.компани үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах.

15.4. Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

15.4.1. нийгмийн болон арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.2. аудитын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.3. үнэт цаас үйлдвэрлэх;

15.4.4. эд мөнгөний хонжворт сугалаа гаргах.

15.4.5. татваргүй барааны дэлгүүр ажиллуулах;

15.4.6. гаалийн итгэмжлэгдсэн төвөрлэгчийн үйлчилгээ эрхлэх;

15.4.7. гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.4.8. гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх.

15.5.Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр:

15.5.1.хөрөнгийн үнэлгээ хийх ;

15.5.2. шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны орчуулгын ажил эрхлэх;

15.5.3. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;

15.5.4. нотариатын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.5. Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээллээс бусад/ хэвлэх;

15.5.6.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх;

15.5.7. төлбөрт таавар, боодоот тоглоомын үйл ажиллагаа явуулах;

15.5.8. галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах;

15.5.9. зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах;

15.5.10. патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах.

15.6. Байгаль орчны чиглэлээр:

15.6.1. озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

15.6.2. байгаль орчин буюу хүний эрүүл мэндэд онцгой аюултай хорт хог хаягдал бухий үйлдвэрлэл эрхлэх;

15.6.3. химийн онцгой хорт бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах, ашиглах, устгах;

15.6.4. газрын кадастрын судалгаа хийх;

15.6.5. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;

15.6.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх.

15.7.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

15.7.1. их сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн сургууль байгуулах;

15.7.2. магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;

15.7.3. түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;

15.7.4. дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах.

15.8. Дэд бүтцийн чиглэлээр:

15.8.1.цөмийн эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр барьж байгуулах, ажиллуулах;

15.8.2.төмөр замын шугам барих;

15.8.3. эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах;

15.8.4. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;

15.8.5.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

15.8.6. төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.8.7. харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;

15.8.8. автозам, замын байгууламжийг барих, засварлах ;

15.8.9. автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

15.8.10. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх;

15.8.11. улс хоорондын болон хот хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;

15.8.12. нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх;

15.8.13. кадастрын зураглал хийх;

15.8.14. цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

15.8.15. зуух, дараптат сав, шугам хоолойн угсралт засвар, үйлчилгээ эрхлэх;

15.8.16. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.8.17. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

15.8.18. шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ эрхлэх;

15.8.19. иргэний агаарын хөлгийг бүтээх, түүнд өөрчлөлт сайжруулалт хийх;

15.8.20. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх.

15.9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

15.9.1. гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар иргэдэд зуучлах үйлчилгээ эрхлэх.

15.10.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:

15.10.1. одон, медаль, тамга, тэмдэг үйлдвэрлэх;

15.10.2. үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх;

15.10.3. мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх хорт бодис худалдах;

15.10.4. тэсэрч дэлбэрэх бодис худалдах ;

15.10.5. ашигт малтмалын хайгуул хийх;

15.10.6. ашигт малтмал ашиглах;

15.10.7. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.10.8. хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах;

15.10.9. хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх;

15.10.10. чанарын баталгаажуулалтын үйлчилгээ эрхлэх;

15.10.11. газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах.

15.11.Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

15.11.1. тамхины үргамал тарих, тамхи үйлдвэрлэх;

15.11.2. сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтуурууллах ундаа үйлдвэрлэх;

15.11.3. таримал үргамлын үр үйлдвэрлэх;

15.11.4. малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;

15.11.5. малын өвчин үүсгэгчийг үргуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх;

15.11.6. үргамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;

15.11.7. шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан мал, амьтны эм, үр, үр хөврелийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах, үржлийн мал, амьтныг гадаадад гаргах;

15.11.8. мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг хувираа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, үйлдвэрлэх.

15.12. Эрүүл мэндийн чиглэлээр:

15.12.1. мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх;

15.12.2. хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах;

15.12.3. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;

15.12.4. мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн үгтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх;

15.12.5. улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

15.12.6. өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;

15.12.7. эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Цацрагийн хяналтын албанаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл

16.1.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Цацрагийн хяналтын алба тусгай зөвшөөрөл олгоно:

16.1.1.цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх;

16.2. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.2.1. аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх ;

16.2.2. эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

16.2.3.хортой, бага хортой химийн бодис үйлдвэрлэх, импортлох, устгах;

16.2.4. ерөнхий боловсролын сургууль байгуулах;

16.2.5.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

16.3. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.3.1.агаарт бохирдуулах бодис

гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;

16.3.2.орон нутагт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх /энэ заалт дүүргийн Засаг даргад хамаарахгүй/;

16.3.3. цэцэрлэг байгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэх

17.1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

18.1.1. энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагаат тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хураож, гэм буруутай иргэнийг 20000 - 50000, хуулийн этгээдийг 100000 – 250000 төгрөгөөр торгох ;

18.1.2. энэ хуулийн 7.2-ыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хураож, гэм буруутай иргэнийг 20000–50000, хуулийн этгээдийг 100000–250000 төгрөгөөр торгох;

18.1.3.энэ хуулийн 5.3-ыг зөрчсөн иргэнийг 230000-50000, албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

18.1.4. хуурамч бичиг баримт бүрдүүлж тусгай зөвшөөрөл авсан бол хууль бусаар олсон орлогыг хураож, гэм буруутай иргэнийг 20000 – 50000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

18.1.5. энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 12.4, 13.2, 14.2-ыг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Улаанбаатар хот**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүсэн харилцаог зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хууль тогтоомж

2.1. Эрчим хүчний тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "аж ахуйн харилцааны дүрэм" гэж хангагч, хэрэглэгчийн хоорондын гэрээний нөхцөл, шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөрийн нөхцөлийг тусгасан хэм хэмжээ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг;

3.1.2. "дулаан дамжуулах сүлжээ" гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг;

3.1.3. "дулаан түгээх сүлжээ" гэж дулаан хуваарилах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг;

3.1.4."эрчим хүчний зохицуулалттай хангалт" гэж энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эрчим хүчний зохицуулах газраас /цаашид "Зохицуулах газар" гэх/ баталж нийтлэсэн тариф /цаашид "зохицуулалттай тариф" гэх/-аар хэрэглэгчид эрчим хүч худалдахыг;

3.1.5. " эрчим хүчний зохицуулалттүй хангалт" гэж гэрээний үнээр хэрэглэгчид эрчим хүч худалдахыг;

3.1.6. "нэгдсэн сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш аймгийн төвийг хамран цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг;

3.1.7. "нэгдсэн сүлжээний дүрэм" гэж нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсгүүдийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг;

3.1.8. "тариф" гэж үйлдвэрлэгчийн үнэ, диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Зохицуулах газраас батлан нийтлэсэн үнийг;

3.1.9. "төвлөрсөн дулаан хангамж" гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг эрчим хүчний эх үүсвэрээс болон 100 МВт-аас дээш хүчин чадалтай дулааны эх үүсвэрээс хэрэглэгчийг дулааны шугам сүлжээгээр диспетчерийн зохицуулалттайгаар дулаанаар хангах үйл ажиллагаа;

3.1.10. "төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм" гэж төвлөрсөн дулаан хангамжийн бүрэлдэхүүн хэсгүүдийн техникийн үйл ажиллагаа зохицуулсан хэм хэмжээг;

3.1.11. "халаалтын улирал" гэж барилга, байгууламжийг дулаанаар хангах шаардлагатай, хүний ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор олон жилийн цаг агаарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон хугацаа;

3.1.12. "эрчим хүчээр хангагч" гэж эрчим хүчний зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.13. "хэрэглэгч" гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчийг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг;

3.1.14. "хэрэглэгчийн зөрэглэл" гэж эрчим хүчээр хангах гэрээний нөхцөл болон эрчим хүчний хэрэглээний хэмжээ, хугацааныхаа хамаарууллан хэрэглэгчийг ангилахыг;

3.1.15. "цахилгаан дамжуулах сүлжээ" гэж цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кв, түүнээс дээш хүчдлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдлийн шугам, дэд станцыг;

3.1.16. "цахилгаан түгээх сүлжээ" гэж цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэх шугам, дэд станцыг;

3.1.17. "эрчим хүчний барилга байгууламж барих" гэж эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станцыг барьж байгуулах, технологийн үндсэн тоноглолд техникийн шинэчлэл хийх, сэргээн засварлах, өргөтгөх үйл ажиллагаог эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхийг;

3.1.18. "эрчим хүчний нөөц" гэж эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар эрчим хүчний эх үүсвэрт ашиглаж болох түлш болон нөхөн сэргэх эх үүсвэрийг;

3.1.19. "эрчим хүч" гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг;

3.1.20. "эрчим хүчний эх үүсвэр" гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1. Улсын Их Хурал эрчим хүчний талаарх төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

5.1. Засгийн газар эрчим хүчний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. эрчим хүчний талаарх төрийн бодлого, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. эрчим хүчний зохицуулах газрыг байгуулах, дүрмийг нь батлах;

5.1.3. цахилгаан, дулаан хэрэглэх болон эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, дамжуулах сүлжээний хамрах хүрээг тогтоох.

6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.1.2. эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаарх төрийн бодлогыг боловсруулах;

6.1.3. тусгай зөвшөөрөл үзэмшигчийн эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлш болон тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам батлах;

6.1.4. байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд эрчим хүчний хангамжийн

талаар мөрдөх журам батлах;

6.1.5. тусгай зөвшөөрөл олгох журам, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үгсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам батлах, хэрэглэгчийн зэрэглэлийг тогтоох;

6.1.6. тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах;

6.1.7. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах, хот, тосгон, бусад суурины нийтийн хэрэгцээнд эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар түлш импортлох, экспортлох зөвшөөрөл олгох.

6.2. Эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн емчийн болон төрийн емч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлагыг томилоход эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэжүүлнэ.

7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга бус нутгийн цаг уурын байдалд тохируулан халаалтын улирлын эхлэх, дуусах хугацаог тогтооно.

8 дугаар зүйл. Зохицуулах газар

8.1. Зохицуулах газар нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна.

8.2. Зохицуулах газрыг гурван зохицуулагчийн бүрэлдэхүүнтэй зохицуулагчдын зөвлөл удирдана.

8.3. Зохицуулагчдын зөвлөлийн дарга, зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 6 жилийн хугацаагаар, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жилийн зөрөөтэйгээр дуусгавар болж байхаар томилно. Томилолтын хугацаог нэг удаа сунгаж болно.

8.4. Зохицуулагч эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн эрхтэй байна.

8.5. Зохицуулагчдын зөвлөлийн дэргэд хэрэглэгч, түгээй зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн, зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулж болно.

8.6. Зохицуулах газар нь түгээй зөвшөөрөл олгохтой холбогдсон болон түгээй зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжинэ.

8.7. Зохицуулах газар нь зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төсвөө Засгийн газраар батлуулж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүнд жил бүр тайлагнана.

8.8.Зохицуулах газар санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж нийтэлнэ.

9 дүгээр зүйл. Зохицуулах газрын бүрэн эрх

9.1. Зохицуулах газар нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшихэд тавигдах шаардлагыг тогтоох;

9.1.2. энэ хуульд заасны дагуу түгээй зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

9.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;

9.1.4. тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг хянаж батлах, шалгах, нийтлэх;

9.1.5. эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох;

9.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх;

9.1.7. хэрэглэгчийн зэрэглэлтэй уялдуулан эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, хангагчаас хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний түвшинг тодорхойлох, хэрэгжилтийг хянах;

9.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, өөрчлөх, тэдгээрийг өмчлөх эрхээ шилжүүлэх, барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх;

9.1.9. тусгай зөвшөөрөлд заасан үйл

ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах;

9.1.10. зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчтэй байгуулсан гэрээг буртгэх;

9.1.11. аж ахуйн харилцааныдүрэм батлах;

9.1.12. аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

9.1.13. тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч цахилгаан, дулаан нийлүүлэх, авах зорилгоор цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдоход шаардагдах санхүү, техникийн нөхцөлийг тусгасан холболтын зааврыг батлах;

9.1.14. Зохицуулах газрын дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

9.2. Зохицуулах газар нь шийдвэрлэх асуудлаа зохицуулагчдын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ. Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч дагаж мөрдөнө.

10 дугаар зүйл. Диспетчерийн үндэсний төв

10.1. Диспетчерийн үндэсний төв нь эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх бөгөөд дараахь эрх, үүрэгтэй байна:

10.1.1 эрчим хүчний талаархи ойрын болон хэтийн бодлого, чиглэлд үндэслэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.2. эрчим хүчний талаархи бодлого хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

10.1.3. эрчим хүчний салбарын боловсон хүчнийг дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл

11.1. Аймаг, нийслэлд эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ.

11.2. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь орон тооны бус гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журмыг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.3. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь энэ хуулийн 9.1.6, 9.1.7, 9.1.8, 9.1.9, 9.1.10-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

11.3.1. энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг тудгэлзүүлэх, хүчингүй болгох;

11.3.2. тухайн орон нутагт олгосон тусгай зөвшөөрлийнхөө нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах.

11.4. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан зардлаа тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлснөөс санхүүжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

12 дугаар зүйл. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох

12.1. Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндэсн дээр эрхэлнэ:

12.1.1. цахилгаан үйлдвэрлэх;

12.1.2. дулаан үйлдвэрлэх;

12.1.3. цахилгаан дамжуулах;

12.1.4. дулаан дамжуулах;

12.1.5. диспетчерийн зохицуулалт хийх;

12.1.6. цахилгаан түгээх;

12.1.7. дулаан түгээх;

12.1.8. эрчим хүчээр зохицуулалттай хангах;

12.1.9. эрчим хүчээр зохицуулалттүй хангах;

12.1.10. цахилгаан импортлох, экспортлох;

12.1.11. эрчим хүчний барилга байгууламж барих.

12.2. Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах газар олгоно.

12.3. Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг эрчим хүчний эх үүсвэр барих, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд энэ хуулийн 12.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зохицуулах газар олгоно.

12.4. Энэ хуулийн 12.2, 12.3-т зааснаас бусад тохиолдолд 12.1-д заасан тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл олгоно.

12.5. Иргэн, хуулийн этгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор 1.5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.

13 дугаар зүйл. Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл

13.1. Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэж, эрчим хүчний эх үүсвэрийг цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох эрх олгоно.

13.2.Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан худалдах үнэ, нөхцөлийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах газраар хянуулж батлуулна:

13.2.1. зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэх;

13.2.2. экспортлох зорилгоор нэгдсэн сүлжээнд холбогдохгүйгээр цахилгаан үйлдвэрлэх;

13.2.3. гэрээний үнээр цахилгаан, дулаан худалдах.

14 дүгээр зүйл. Цахилгаан, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл

14.1. Цахилгаан, дулаан дамжуулах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулааны дамжуулах сүлжээг ашиглан цахилгаан, дулаан дамжуулах үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.

14.2. Цахилгаан, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь эрх, үүрэгтэй:

14.2.1. цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагааг болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах, дамжуулах сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх үйл ажиллагаа эрхлэх;

14.2.2. энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын зааврыг боловсруулах, батлуулах, мөрдөх;

14.2.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийг тэгш эрхтэйгээр дамжуулах сүлжээнд холбогдох нөхцөлийг бүрдүүлэх.

14.3. Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүчээр хангагч байж болохгүй.

15 дугаар зүйл. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл

15.1. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлөөр диспетчерийн үндсэний төвд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг шуурхай зохицуулж, үйлдвэрлэлийг хэрэглээтэй тэнцвэржүүлэх эрх олгоно.

15.2. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь эрх, үүрэгтэй:

15.2.1. цахилгаан, дулааныг стандартын шаардлагад нийцүүлэн найдвартай хангах зорилгоор цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн шуурхай зохицуулах;

15.2.2. байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан, дулааны хангамжийг таслах, хязгаарлах, сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

15.2.3. цахилгаан, дулаанаар хангах гэрээг Зохицуулах газраас тогтоосон жүрмын дагуу бүртгэх;

15.2.4. диспетчерийн зохицуулалтаар бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчид нийлүүлэх, тэднээс авч болох цахилгаан, дулааны нөөц, чадал, бусад үйлчилгээг төлөвлөх, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн нэгдмэл үйл ажиллагааг хангах, горим тогтоож хянах;

15.2.5. нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн цахилгаан, дулааны хэрэглээний урт хугацааны урьдчилсан таамаглалыг жил бүр гаргах;

15.2.6. бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр нэгдсэн сүлжээний дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэх;

15.2.7. импортлох, экспортлох зорилгоор цахилгаан дамжуулах үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

15.3. Цахилгаан, дулааны диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчид цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, эрчим хүчээр зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл олгохгүй.

15.4. Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрмийн хүрээнд диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан шийдвэрийг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч биелүүлэх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл

16.1. Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд тухайн тодорхой нутаг дэвсгэрт цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа явуулах эрх олгоно.

16.2. Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн бүх хэрэглэгчийг түгээх сүлжээнд холбох үүрэгтэй.

16.3. Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэгтэй:

16.3.1. тухайн нутаг дэвсгэрт энэ хуульд заасан шаардлагыгханган хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжийг цахилгаан, дулаан түгээх шугам, тоног төхөөрөмжид холбох;

16.3.2. энэ хуулийн 9.1.13.-т заасан холболтын зааврыг боловсруулах, батлуулах, мөрдөх;

16.3.3. эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цахилгаан, дулааны тоолуураар хэрэглэгчийг ханган, тоолуурыг холболтын цэгт суурилуулах;

16.3.4 цахилгаан, дулаан түгээх сүлжээгээр дамжуулан зохицуулалттай, эсхүл зохицуулалттүй ханган эрхлэх тэнцүү боломжийг эрчим хүчээр хангагч нарт олгох;

16.3.5. цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, эрчим хүчээр зохицуулалттай, эсхүл зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаа болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах

16.3.6. түгээх сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх;

16.3.7. энэ хуулийн 9.1.13.-т заасан холболтын зааврын шаардлага ханган хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбох;

16.3.8. үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу урьдчилан төлбөр хийсний үндсэн дээр цахилгаан, дулааныг худалдан авах;

16.4. Энэ хуулийн 16.3.3-т заасан тоолуур нь цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч байна.

16.5. Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүчээр зохицуулалттай ханган түгээх зөвшөөрөл эзэмшигч байх бөгөөд эрчим хүчээр зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрөл эзэмшигч байж болно.

17 дугаар зүйл. Эрчим хүчээр зохицуулалттай ханган түгээх зөвшөөрөл

17.1. Эрчим хүчээр зохицуулалттай ханган түгээх зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх түгээх зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах эрхийг олгоно.

17.2. Эрчим хүчээр зохицуулалттай ханган түгээх зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэгтэй:

17.2.1. түгээх зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн хэрэглэгчийг цахилгаан, дулаанаар ханган;

17.2.2. цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх түгээх зөвшөөрөл эзэмшигчтэй хүрэлцээтэй хэмжээний цахилгаан, дулааны чадал авах, дамжуулах тухай тохиролцох;

17.2.3 цахилгаан, дулаан дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөрийг төлөх;

17.2.4. бизнес харилцааны дүрэм боловсруулах, батлуулах.

18 дугаар зүйл. Эрчим хүчээр зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрөл

18.1. Эрчим хүчээр зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх түгээх зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авч, Зохицуулах газраас тогтоосон хэрэглэгчид худалдах болон цахилгаан экспортлох эрхийг олгоно.

18.2. Зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэгтэй.

18.2.1. цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх түгээх зөвшөөрөл эзэмшигчидтэй хүрэлцээтэй хэмжээний цахилгаан, дулааны чадал авах, дамжуулах тухай тохиролцох;

18.2.2. аж ахуйн харилцааны дүрэм боловсруулах, батлуулах.

19 дүгээр зүйл. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл

19.1. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд зохицуулалттүй ханган түгээх зөвшөөрөл эзэмшигчийн өмч байна.

19.2. Нэгдсэн сүлжээгээр цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийг тухайн сүлжээний дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгоно.

19.3. Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлөөр импортлох цахилгааны хэмжээг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага тогтооно.

19.4. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан импортлох, экспортлох хугацаа, техникийн нөхцөлийг диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тохиролцоно.

20 дугаар зүйл. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл

20.1. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхтай, уг барилга байгууламжийг барих хүсэлт гаргасан хуулийн этгээдэд олгож болно.

20.2. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж хянуулсан байна.

20.3. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсний үндсэн дээр олгоно.

21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах

21.1. Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө Зохицуулах газар бүюу аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд гаргана.

21.2 Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөөс эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараахь бичиг баримтыг хавсаргана:

21.2.1. техник, эдийн засгийн үндэслэл;

21.2.2. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа;

21.2.3. үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

21.2.4. үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;

21.2.5. үйлчлэх хүрээ, эзэмшлийн заагт, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;

21.2.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

21.2.7. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

21.2.8. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи;

21.2.9. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

21.2.10. мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага.

21.3. Зохицуулах газар, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл, түүнд хавсаргасан баримтын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээч томилж болно.

21.4. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргана.

21.5. Хэрэв өргөдөл, түүнд хавсаргасан баримтыг шаардлага хангаагүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор өргөдөл гаргагчид буцаана.

21.6. Зөвшөөрөл олгосон шийдвэр буюу олгохоос татгалзсан тухай үндэслэлийг нийтэлнэ.

21.7. Тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой хуулийн этгээдэд олгоно.

21.8. Нэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч хуулийн этгээд өргөдөл гаргасан бол сонгон шалгаруулах замаар олгоно.

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

22.1. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрлийн хугацаа 5-25 жил, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацаа 5 хүртэл жил, бусад тусгай зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл жил байна.

22.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлсэн бөгөөд техник, технологийн хувьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, боломжтой гэж тусгай зөвшөөрөл олгогч үзвэл тусгай зөвшөөрлийн хугацааг 25 хүртэл жилээр сунгана.

22.3. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

22.4. Тусгай зөвшөөрөл нь түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

23 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх

23.1. Тусгай зөвшөөрөл олгосон нөхцөл өөрчлөгдсөн, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрөл олгогч тусгай зөвшөөрлийг шинэчлэх буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

24.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ

хууль болон тусгай зөвшөөрөлд заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгоч зөрчлийг арилгах тухай хугацаатай үүрэг өгнө.

24.2. Заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол эрчим хүчний хяналтын улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих шийтгэл ногдуулж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаагаа зогсоох үндэслэл болохгүй.

24.3. Тусгай зөвшөөрөл олгоч дараахь үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно:

24.3.1. тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

24.3.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, дампуурсан;

24.3.3. тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж эзэмшсэн нь тогтоогдсон;

24.3.4. энэ хуулийн 24.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн боловч зөрчлийг хугацаанд нь арилгаагүй;

24.3.5. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн;

24.3.6. хуульд заасан бусад үндэслэл.

24.4. Тусгай зөвшөөрөл олгоч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид өгснөөс хойш 30 хоногт багтаан хүчингүй болгосон шийдвэр гаргана.

24.5. Тусгай зөвшөөрлийн хүчингүй болсон нь түүнийг эзэмшигч хуулийн этгээдийн байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

24.6. Тусгай зөвшөөрөл олгоч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх найдвартай ажиллагаа хангах, хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчээр энэхүү үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

25.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ:

25.1.1. тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх;

25.1.2. хууль тогтоомж, эрчим хүчний техникийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөх;

25.1.3. санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр, тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх;

25.1.4. аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр гаргаж өгөх;

25.1.5. нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрмийн дагуу цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах;

25.1.6. энэ хуулийн 9.1.8-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгогчид мэдэгдэх, зөвшөөрөл авах;

25.1.7. тусгай зөвшөөрөл олгогчийн эрх бүхий ажилтнаас эрх мэдлийнхээ хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх, өөрийн байр, байгууламжид нэвтрүүлэх, ажил үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангах;

25.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техник, эдийн засгийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөд шаардлагатай мэдээллийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын шаардсанаар цаг тухайд нь үнэн зөвөөр гаргаж өгөх;

25.1.9. цахилгаан, дулаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, талаар 3 - 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцагч бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авч, тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр тодотгож мэдэгдэх;

25.1.10. үйл ажиллагаагаа эрчим хүчний хангамжид нөлөө үзүүлэхүйц байдлаар тодорхой хугацаагаар зогсоох шаардлагатай бол тусгай зөвшөөрөл олгогчид 6-аас доошгүй сарын өмнө мэдэгдэх;

25.1.11. үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх;

25.1.12. холбогдох дүрэм, журам, норм, стандарт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах, үйл ажиллагаагаа технологийн горимын дагуу осол аюулгүй, техникийн өндөр түвшинд явуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНЭ, ТАРИФ

26 дугаар зүйл. Тариф тогтоох зарчим

26.1. Тарифыг цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх болон хангах үйл ажиллагаа тус бүрээр тогтооно.

26.2. Тариф тогтоохдоо дараахь зарчмыг баримтална:

26.2.1. үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;

26.2.2. цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн зэрэглэл тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;

26.2.3. эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;

26.2.4. үнийн тогтвортой байдлыг хангах;

26.2.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх;

26.2.6. цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;

26.2.7. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;

26.2.8. өртөг нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх бөгөөд зардлын бүтцэд ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардалд бодогдох элэгдэл, хорогдлыг оруулахгүй байх.

26.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тооцож гаргасан өртөг, зардлын үндэслэл, үнэн зөв байдалд Зохицуулах газар үнэлгээ өгөх үүрэгтэй бөгөөд шаардлага хангахгүй тохиолдолд дахин боловсруулахаар буцаана. Зохицуулах газар нь өөрийн санал, тооцоогоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнөөс үнэлгээ, тооцоог нөхөж гүйцэтгэхгүй.

26.4. Зохицуулах газар нь тарифыг тодорхойлох аргачлал болон тариф хянах, шалгах журмыг гаргаж нийтэлнэ.

27 дугаар зүйл. Тариф, гэрээний үнэ

27.1. Зохицуулах газар, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хангагчаас үзүүлж байгаа үйлчилгээний нөхцөл, тарифыг жил бүр, хангагч хүсэлт гаргасан тохиолдолд хагас жилд нэг удаа хянана.

27.2. Хэрэглэгч нь зохицуулалттай хангалтын төлбөрийг нийтлэгдсэн тарифаар, зохицуулалттүй хангалтын төлбөрийг гэрээний үнээр төлнө.

27.3. Зохицуулах газар нь зохицуулалтгүй хангалтаар үйлчлүүлж болох хэрэглэгчийг тэдгээрийн цахилгаан, дулааны хэрэглээг үндэслэн тогтооно. Эдгээр хэрэглэгч нь зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалтын алинаар үйлчлүүлэхээ сонгох эрхтэй.

27.4. Зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тариф өөрчлөх саналаа зардлын бүтцийн зүйлчилсэн жагсаалтын хамт Зохицуулах газарт өгнө.

27.5. Зохицуулах газар нь эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

27.6. Тариф болон гэрээний үнэ нь эрчим хүчний хангамжийн дараахь үзүүлэлт болон бусад хүчин зүйлээс хамааран тодорхой бүлэг хэрэглэгчийн хувьд ялгаатай байж болно:

27.6.1. захиалсан дээд чадал, гэрээнд заасан хэрэглээ;

27.6.2. ачааллын горим;

27.6.3. хэрэглэгчийн ачааллаа зохицуулах чадвар буюу эрчим хүчний тасралтыг хүлээн зөвшөөрөх боломж;

27.6.4. хангагчийн харьяалах нутаг дэвсгэр;

27.6.5. гэрээний хугацаа;

27.6.6. бусад хүчин зүйлс.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХАНГАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХАРИЛЦАА

28 дугаар зүйл. Эрчим хүчээр хангах гэрээ

28.1. Эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн харилцааг Иргэний хуулийн 226 дугаар зүйл, энэ хууль, аж ахуйн харилцааны дүрэм, эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

28.2. Иргэнтэй байгуулах эрчим хүчээр хангах гэрээнд хэрэглэх эрчим хүчний хэмжээ, чанар, төлбөр, тооцооны журам, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, хариуцлага тооцох журам, шаардлагатай бусад асуудлыг тусгана.

28.3. Хуулийн этгээдтэй байгуулах эрчим хүчээр хангах гэрээнд энэ хуулийн 28.2-т зааснаас гадна эрчим хүчний хэрэглээний горим, сар бүрийн хуваарь, хэрэглэгч хуулийн этгээдийн харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа болон шаардлагатай бусад асуудлыг тусгана.

28.4. Эрчим хүчээр хангагч нь хэрэглэгчийн төлбөрийн чадварын талаар харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгааг үндэслэн эрчим хүчээр хангах гэрээг байгуулж болно.

28.5. Хэрэглэгч энэ хуулийн 27.5-д заасны

дагуу мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор хангагчтай байгуулсан гэрээндээ зохих өөрчлөлт оруулах бөгөөд гэрээндээ өөрчлөлт оруулаагүй нь энэхүү өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

29 дүгээр зүйл. Эрчим хүчээр хангагчийн эрх, үүрэг

29.1. Эрчим хүчээр хангагч нь Иргэний хуулийн 228 дугаар зүйл, энэ хуулийн 25 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

29.1.1. стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах;

29.1.2. эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;

29.1.3. гэрээнд заасан үйлчилгээний түвшинг хангах;

29.1.4. гэрээнд заасан хугацаанаас эхлэн эрчим хүчээр хангах;

29.1.5. эрчим хүчийг тасласан шалтгаан арилсан даруй эрчим хүчний хангамжийг сэргээх;

29.1.6 эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан ажил, үүргийн шаардлагаар хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, энэ зорилгоор орон байранд нэвтрэх;

29.1.7. хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчидийг эрчим хүчээр хангах гэрээг цуцлах, энэ хуулийн 33.1-д заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах;

29.1.8. энэ хуулийн 32.2-т заасны дагуу хэрэглэгчийн эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлэх;

29.2. Эрчим хүчээр хангагч нь хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахыг хориглоно.

30 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

30.1. Хэрэглэгч нь Иргэний хуулийн 227 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй.

30.1.1. эрчим хүчээр хангагдах;

30.1.2. эрчим хүчний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;

30.1.3. техникийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх;

30.1.4. эрчим хүчээр хангагчийн төлөөлөгчийг үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангах;

30.1.5. эрчим хүчээр хангагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс эрчим хүч дутуу нийлүүлсэн, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангагчийн бол эрчим хүчний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

30.1.6. энэ хуулийн 32.2., 32.3.-т зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

30.1.7. эрчим хүчний тоолуур, хэмжүүрийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;

30.1.8. өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг ханган;

30.1.9. байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гэрээнд заасан эрчим хүчийг авахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа эрчим хүчээр хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэх;

30.1.10. түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах;

30.1.11. өөрийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан эрчим хүч бусдад дамжуулах, түгээх, тухайн хангагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах.

30.2. Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хүний амь нас, улсын эрх ашиг, хэрэглэгчийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учирч болох онцлогтой хэрэглэгч өөрийн нөөц цахилгааны эх үүсвэртэй байна. Эдгээр хэрэглэгчийг зэрэглэлд нь үндэслэн Зохицуулах газар, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл тогтооно.

31 дүгээр зүйл. Эрчим хүчний төлбөр хийх, торгууль ногдуулах

31.1. Эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн хооронд хийх эрчим хүчний хэрэглээний тооцоог эрх бүхий байгууллагын батлагаажуулсан тоолуурын заалтыг үндэслэн мөрдөгдөж байгаа тариф, гэрээний үний дагуу тооцно.

31.2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэрэглэгч нь нийлүүлээгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн 5.0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг эрчим хүчээр хангагчаас нэхэмжлэх эрхтэй.

31.3. Эрчим хүчээр хангагч нь гэрээнд заасан хугацаанд эрчим хүчний төлбөрөө төлөөгүй буюу зохих ёсоор төлөөгүй хэрэглэгчид хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хүртэл хувьтай тэнцэх алданги ногдуулна.

31.4. Энэ хуулийн 31.2, 31.3-т заасан торгууль, алданги нь хэмжээ нийлүүлээгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн буюу

төлөөгүй төлберийн 50 хувиас хэтэрч болохгүй.

32 дугаар зүйл. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлэх

32.1. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч дараахь тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим тоног төхөөрөмжийн ашиглалтыг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

32.1.1. үйлдвэрлэлийн осол гарах болон хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулахуйц нөхцөл байдал бий болсон;

32.1.2. эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон;

32.1.3. үйлдвэрлэн гаргаж байгаа эрчим хүч нь стандарт, чанарын шаардлага хангахгүй байгаа;

32.1.4. эрчим хүчний хяналтын улсын байцаагчаас тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй;

32.2. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан дараахь тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

32.2.1. эрчим хүч хэрэглэсний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй;

32.2.2. эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагаат алдагдуулсан;

32.2.3. тоолуургүй тохиолдолд гэрээнд тусгагдаагүй хэлбэрээр эрчим хүч хэрэглэсэн;

32.2.4. хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээнээс өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан;

32.2.5. байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн, түлшний хомсдол бий болсон, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан, хүний амь нас, эд хөрөнгөд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл үүссэн;

32.2.6. хэрэглэгч өөрийн байранд нөөртэн үзлэг хийх боломжийг хангагчийн эрх бүхий ажилтанд олгоогүй.

32.3. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч энэ хуулийн 32.2.-т зааснаас гадна дараахь тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

32.3.1. хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон;

32.3.2. эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөлийг зөрчсөн;

32.3.3. гэрээгээр тогтоосон цахилгаан чадлын хэрэглээг хэтрүүлсэн.

32.4. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх болсон тухайгаа тусгай зөвшөөрөл олгогчид урьдчилан, хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлсэн тухайгаа эрчим хүчээр хангагчид тус тус мэдэгдэнэ.

32.5. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч, эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх болсон талаар тэдэнд 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэж, шийдвэртээ түдгэлзүүлэх болсон үндэслэлийг тодорхой заажи, тоног төхөөрөмж, тоолуур, хэмжүүр болон шаардлагатай бусад хэрэгслийг битүүмжилнэ. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хүний амь нас, улсын эрх ашиг, бусад хэрэглэгчийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учирч болохүйц байдал бий болсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг урьдчилан мэдэгдэхгүйгээр түдгэлзүүлж болно.

32.6. Эрчим хүчний хэрэглээ, үйл ажиллагаат нь түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан тухайгаа түдгэлзүүлсэн эрчим хүчний хяналтын улсын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтанд мэдэгдэж шалгуулахаас өмнө битүүмжилсэн тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглахыг хоригдоно.

32.7. Энэ хуулийн 32.1, 32.2, 32.3-т заасны дагуу эрчим хүчний хэрэглээ, үйл ажиллагааг түдгэлзүүлсэн нь хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл, гэрээний нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрхийг хөндөхгүй.

33 дугаар зүйл. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас

33.1. Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хоригдоно.

33.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг тогтооно.

33.3. Хамгаалалтын зурвасын дотор тарьсан, ургасан мод, бут нь шугам сүлжээнд гэмтэл учруулахаар буюу үзлэг, үйлчилгээ хийхэд саад болохоор бол мод, бутны өмчлөгч, эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй.

33.4. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч, эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан нь шугам сүлжээнд үзлэг, үйлчилгээ хийх, хяналт зэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх, өмчлөгч, эзэмшигч нь энэ хуулийн 33.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг мод, бутыг шилжүүлэн суулгуулах, хэрэв боломжгүй бол тайрч огглуулах арга хэмжээ авах эрхтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

34 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

34.1. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтэд эрчим хүчний улсын хяналтын байгууллага, улсын байцаагч дараахь чиглэлээр мэргэжлийн хяналт тавина:

34.1.1. эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үгсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчид хяналт тавих;

34.1.2. эрчим хүчийг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэхэд болон шугам сүлжээг хамгаалах шаардлагыг мөрдүүлэхэд хяналт тавих;

34.1.3. эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжид гарсан осол, аваарийг судалж дүгнэлт гаргах, осол аваариас урьдчилан сэргийлэх;

34.1.4. зуух, даралтат сав, шугам хоолой, цахилгаан, механик тоног төхөөрөмжийг бүртгэлд хамруулан холбогдох норм, дүрэмд заасан хугацаанд нь техникийн туршилт, магадлалт хийн баталгаажуулж, ашиглах зөвшөөрөл олгох;

34.1.5. 0.07 МПа-аас дээш даралттай уурын, 115 C^0–ийн хэмээс дээш халуунтай усны шугам хоолой, зуух, даралтат савны үгсралт, засварын ажил гүйцэтгэх зөвшөөрлийг олгож, үгсралт, засварын ажлын чанарын баталгаажилтыг хангуулах.

34.2. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, мөрдөж байгаа үнэ, тарифын үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

35 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

35.1. Зохицуулах газар, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэнэ.

35.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь эрх бүхий байгууллага, ажилтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

36 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх

36.1. Эрчим хүчээр хангагч гэрээний үүргээ биелүүлээгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрчим хүчийг тасалдуулсны улмаас хэрэглэгчид учирсан шууд хохирлыг нөхөн төлнө. Хохирлын хэмжээг эрчим хүчээр хангагч, хэрэглэгч хамтран тогтоож, актаар баталгаажуулсан байна.

36.2. Энэ хуулийн 29.1.6-д заасан үйл ажиллагаа явуулах үед эрчим хүчээр хангагч нь хэрэглэгчид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлнө.

36.3. Энэ хуулийн 29.1.2-д заасны дагуу эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэн байхад хэрэглэгч өөрийн буруугаас хохирол хүлээсэн бол хохирлыг эрчим хүчээр хангагч хариуцахгүй.

37 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрэгүй бол шүүгч болон эрчим хүчний хяналтын улсын байцаагч дор дурдсан зохиргааны шийтгэл ногдуулна:

37.1.1. тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл тусгай зөвшөөрлөө бусдад шилжүүлсэн буюу бусдын тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулсан, эрх бүхий байгууллагаас хяналт батлагдаагүй өөр үнэ, тарифаар эрчим хүчийг борлуулсан бол олсон борлуулалтын орлогыг хураах, албан тушаалтныг 3000 – 60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

37.1.2. эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн шаардлага, өгсөн үүргийг биелүүлээгүй, хяналт, шалгалт хийхэд саад учруулсан, бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах журам зөрчсөн, санаатайгаар худал ташаа мэдээллэн гаргаж өгсөн иргэнийг 5000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 3000 – 60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

37.1.3. энэ хуулийн 30.1.-д заасан болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэнийг 5000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 10000–60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 – 250000 төгрөгөөр торгох;

37.1.4. хууль тогтоомж, гэрээ, тусгай зөвшөөрөлд заагаагүй нөхцөл, шаардлага

тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарласан, энэ хуулийн 32.1, 32.2, 32.3-т зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлсэн албан тушаалтныг 5000 – 50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 80000 – 250000 төгрөгөөр торгох;

37.1.5. эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсэн буюу хэвийн ажиллагаа нь алдагдуулсан, зөвшөөрөлгүйгээр эрчим хүч хэрэглэсэн, шугам сүлжээг хамгаалах, цахилгаан, дулаан хэрэглэх дүрмийг зөрчсөн бол хууль бусаар хэрэглэсэн эрчим хүчний үнэ, учруулсан хохирлыг нөхөн төлүүлж буруутай иргэнийг 10000 – 50000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 80000 – 250000 төгрөгөөр торгох;

37.1.6. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, энэ хуулийн 25.1.3, 25.1.4, 25.1.6, 25.1.7, 25.1.9, 25.1.10-т заасан үүрэг, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгуулалж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны норм, стандарт, дүрэм, журам, Зохицуулах газрын тогтоолыг зөрчсөн, үйлдвэрлэлийн осол, аваар гаргасан, эд хөрөнгийн хохирол учруулсан, техникийн гэмтэл гарахад хүргэсэн бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж буруутай иргэнийг 5000 – 50000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000–60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 – 250000 төгрөгөөр торгох.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

38.1. Энэ хуулийг 2001 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Улаанбаатар хот**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ (1995 ОНЫ) ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Эрчим хүчний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрчим хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын Экспорт-Импорт банк /Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан/-ны хооронд 2000 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Хөдөөгийн цахилгаан холбооны төслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Улаанбаатар хот**

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1,3 дахь хэсгийн "олгох ээлэ", 3 дахь хэсгийн 3 дахь заалтын "олгосон ээлэ", гэсний дараа" ээлэлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Монголбанк тогтооно."

3 дугаар зүйл. Банкны тухай хуулийн дараахь зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн дүрмийн сангаас, хувь нийлүүлэгчид нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээдэг, бүсдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо зэрэг санхүүгийн зуучлалын ажил үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаагаа Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг банк гэнэ."

2/ 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Банкны хүдалдан авах үнэт цаасны зээмшлийн нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төвбанкнаас гаргасан аливаа үнэт цаас хамаарахгүй."

3/ 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:

"6/банкны хянан шалгагч /хянан шалгагчдын зөвлөл/-ийн асуудлыг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн дагуу зохицуулна."

4/ 27 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн эхний өгүүлбэр:

"9. Банкны хувь нийлүүлэгч дүрмийн санд оруулсан хөрөнгөө Монголбанкны зөвшөөрлөөр худалдах, өв залгамжлах, бэлэглэх, гэрээслэхээс өөрөөр бусаж авахыг хоригломо."

Хувь нийлүүлэгч дүрмийн санд оруулсан хөрөнгөө худалдах, өв залгамжлуулах, бэлэглэх, гэрээслүүлэхээр байгуулсан гэрээ нь хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон бол Монголбанк зохих зөвшөөрлийг олгохгүй байх эрхтэй.

4 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн "хөндлөнгийн хяналтын байгууллага" гэснийг "аудитын байгууллага", 31 дүгээр зүйлийн 1 хэсгийн 4 дэх заалтын "торгууль" гэснийг "энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан захиргааны шийтгэл" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Улаанбаатар хот**

МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, БАНКНЫ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дараахь зүйл, хэсэгт дор дурдсан агуулгатай хэсэг, өгүүлбэр нэмсүгэй:

1/ 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Банк дараахь тохиолдолд дансыг хааж болно:

1/харилцагч данс хаалгах хүсэлтээ бичгээр гаргасан;

2/ харилцагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцөл биелэгдсэн;

3/хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр."

2/ 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт :

"Банк найдвартай гэж үзвэл зээлдэгчийн үйл ажиллагаанаас олох орлого, үр шимийг гэрээ, батлан даалтын үндсэн дээр зээлийн барьцаанд авч болно. Зээлдэгчийн үйл ажиллагаанаас олох орлого, үр шимийг зээлийн барьцаанд авах журмыг Монголбанк тогтоно."

2 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"9 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн баталгаа

Хадгалагч дампуурах буюу татан буугдах тохиолдолд мөнгөн хадгаламж, түүний хүүг Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан дараалал баримтлан олгоно."

3 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн "38 " гэснийг "8 " гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 2–ны өдөр **Улаанбаатар хот**

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 12 дахь заалт нэмсүгэй:

"12/ төлберийн чадваргүй болсон банкинд томилогдсон банкны бүрэн эрхт төлөөлөгч, банкны эрх хүлээн авагч нараас гаргасан нэхэмжлэл."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 368 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

"6. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны эд хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд тусгайлан заасан бол тухайн эд хөрөнгийг гэрээний хугацаа дууссан едреес эхлэн банк ба банк бус санхүүгийн байгууллага захиран зарцуулах эрхтэй."

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 368 дугаар зүйлийн 6,7,8 дахь хэсгийн дугаарыг "7,8,9" болгон тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 12** **Улаанбаатар хот**

Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5.1, 5.6, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жадамбын Дашдоржийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 2 дугаар сарын 1-ний едреес эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 13** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэл тогтоох тухай Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлсан хавсралтын "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаатай адилтгах албан тушаалын зэрэглэл"-ийн "ТӨ-V/А"-ийн тусгай албан тушаалд "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга", "ТӨ-VIА"-ийн тусгай албан тушаалд "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр — Дугаар 14 — **Улаанбаатар хот**

Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр батлуулсугай.

1/ Сонгуулийн ерөнхий хорооны дарга
-Ж.Ядамсүрэн

2/ Нарийн бичгийн дарга
-Ж.Сүхбаатар

Гишүүд:

3/ Үндэсний статистикийн газрын дарга
-Ч.Даваасүрэн

4/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын орлогч
-Д.Намсрай

5/ Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч бөгөөд хуулийн хэлтсийн дарга
-Ж.Нарантуяа

6/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
-Л.Хангай

7/ Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
-Н.Түмэндэмбэрэл

8/ Цагдаагийн ерөнхий газрын дарга
-Ч.Амарболд

9/ Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга
-Д.Эрдэнэчулуун

10/ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
-Г.Маналжав

11/ Төрийн бус байгууллагын төлөөлөл
/Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн/
-Р.Бурмаа

2.Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны дэг, зохион байгуулалттай холбогдсон заавар, журмыг боловсруулж, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахыг Сонгуулийн ерөнхий хороо /Ж.Ядамсүрэн/-нд даалгасугай.

3.Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүний шинэчлэн томилсонтой холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр — Дугаар 15 — **Улаанбаатар хот**

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Төрийн ордны тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Засгийн газар / Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ холбогдох журам, зааврыг энэ хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;

2/ Төрийн ордонд байрлаж байгаа энэ хуульд зааснаас бусад байгууллагуудыг 2001 оны 6 дугаар сарын 1-ний дотор нүүлгэн шилжүүлэх;

3/ Төрийн ордны ашуулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгийг 2001 онд багтаан шийдэх;

4/ Төрийн ордны засвар, үйлчилгээ явуулахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусгаж хуваарилах;

5/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ордонтой болох асуудлыг судалж, хөрөнгийн эх үүсвэрийг нь шат дараалан шийдвэрлэсний үндсэн дээр Ерөнхийлөгчийн ажлын албыг аажмаар шилжүүлэх;

6/ Төрийн ордонд өргөтгөл хийх замаар Парламентын чуулганы хуралдааны танхим бүхий шинэ хэсэг барих асуудлыг судалж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр — Дугаар 16 — **Улаанбаатар хот**

Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, зааг тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төрийн ордны тухай хууль

батлагдсантай холбогдуулан Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг дор дурдсанаар тогтоосугай:

1/ Монгол Улсын Төрийн ордноос зүүн, баруун зүгт тус бүр 33 метр;

2/ Монгол Улсын Төрийн ордноос урд, хойд зүгт тус бүр 80 метр хүртэлх орчин, нутаг дэвсгэрийг Төрийн ордны нутаг дэвсгэрт тооцох.

2.Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг тогтоосонтой холбогдуулан аюулгүй байдал, хамгаалалтын асуудлыг зохион байгуулахыг Засгийн газар / Н.Энхбаяр /-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 17** **Улаанбаатар хот**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар / Н.Энхбаяр /-т даалгасугай.

1/ Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг энэ хуулитай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/ Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар Засгийн газар болон төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг энэ хуулитай нийцүүлэх;

3/ Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуулитай уялдуулан хянан үзэж, тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ;

2. Энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээг 2001 оны 5 дугаар сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Засгийн газар / Н.Энхбаяр /-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 18** **Улаанбаатар хот**

Эрчим хүчний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрчим хүчний тухай хуулийн дагуу эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг 2001 онд багтаан хийх, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн эрчим хүчний үйлдвэр зэрэг татаас авдаг аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт, түүнийг олгохтой холбогдсон асуудлыг зохицуулан шийдвэрлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Т-Очирхүү/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 19** **Улаанбаатар хот**

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт нарт Улсын Их Хурлаас тогтоосон хамгаалалт, хангамжийн хугацааг 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөр, Р.Амаржаргалд Улсын Их

Хурлаас тогтоосон хамгаалалт, хангамжийн хугацааг 2001 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөр тус

тус дуусгавар болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 20** **Улаанбаатар хот**

"Монгол Улсын гавьяат малчин" цол бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын гавьяат малчин" цол бий болгосугай.

2."Монгол Улсын гавьяат малчин" цол хүртээх дүрмийг хавсралт ёсоор батлуулсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 136 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Улсын Их Хурлын 2001 оны 20 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ МАЛЧИН" ЦОЛ ХҮРТЭЭХ ДҮРЭМ

1."Монгол Улсын гавьяат малчин" цолыг мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн онцгой, тогтвортой амжилт гаргасан хувийн аж ахуй эрхэлж байгаа болон мал бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн малчинд хүртээнэ.

2."Монгол Улсын гавьяат малчин" цол хүртээлгэхээр нэр дэвших малчин нь мал сүргийн тоо толгойг төлөөр нь өсгөж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн малын арчилгаа, маллагааны ажилд уламжлалт болон шинэ арга барил нэвтрүүлэн, түүнээ залуу малчдад зааж сургадаг, төсөвт оруулах татвар, хураамжийг хуульд заасан хугацаанд бүрэн төлдөг, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, байгаль хамгаалах зэрэг салбарыг ивээн тэтгэх, нутаг орноо хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг, нэр хүнд сайтай иргэн байвал зохино.

3."Монгол Улсын гавьяат малчин" цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж хүртээнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 21** **Улаанбаатар хот**

Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медаль бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медаль бий болгосугай.

2.Монгол Ардын Хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалийн хийц, хэмжээ, тодорхойлолт, түүний дүрмийг хавсралт ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Улсын Их Хурлын 2001 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛЫН 80 ЖИЛИЙН ОЙН ХҮНДЭТ МЕДАЛИЙН ДҮРЭМ

1.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалиар Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж шагнана.

2.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалиар дор дурдсан хүмүүсийг шагнаж болно:

а/хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн;

б/аж ахуй, нийгэм, соёлын салбар, төрийн болон төрийн бус байгууллагад 20-иос доошгүй жил идэвх, санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүс;

в/аж ахуй, нийгэм, соёлын салбар, төрийн болон төрийн бус байгууллагад идэвх,

санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан, тахир дутуугийн группт байгаа хүмүүс.

3.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалиар шагнуулах хүмүүсийн нэрийн жагсаалтыг овог, нэр, эрхэлдэг ажил, ажилласан жил, нас гэсэн үзүүлэлтээр гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батална "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-д заасан эрх бүхий хүмүүс Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалиар хүмүүсийг тухайн онд нь багтаан шагнана.

5.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойгоор улсын цол хүртсэн, одон, медалиар шагнагдсан хүмүүсийг ойн хүндэт медалиар давхар шагнаж болно.

6.Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойн хүндэт медалийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүд, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батална "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-д заасан эрх бүхий хүмүүс гардуулна.

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛЫН 80 ЖИЛИЙН ОЙН ХҮНДЭТ МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А.Бэлгэдэл утгын товч тайлбар

Медалийн дээд хэсэг:

1. Медалийн дээд хэсэг буюу зүүлт нь гурвалжин зохиомжтой. Гурвалжин нь бат бэх чанарыг, түүний дотор орой нь доошоо харсан гурвалжин монголчуудын хиян зориг санаагаа илэрхийлэх тул түүнийг медалийн толгой хэсэг болгож, ард түмнийхээ сарнишгүй эв нэгдлийг бэлгэдэв.

2. Медалийн дээд хэсгийн өнгийн хослол бүхэлдээ Монгол Улсын төрийн далбааг бэлгэдэнэ.


а/ улаан өнгийг ялалтын өнгө гэж үзэн өвөг дээдсийнхээ бүтээсэн гавьяа зүтгэл, үр хойчдоо үлдээж өгсөн улс орны эрх чөлөө, тусгаар тогтнолыг бэлгэдэв;


б/ зүүлтний доторх 8 ширхэг цацраг бүхий хөх судлаар монголынхоо огторгуйг бэлгэдэж, улс орон маань цаашид эв найртайгаар мандан бадрахыг илэрхийлэв.

Медалийн доод хэсэг:

Медалийн доод хэсэг нь дугариг. Энд цэлмэг тэнгэрт мандаж байгаа тоо томшгүй цацраг бүхий Нарыг бэлгэдэн дүрслэв. Нарын төв хэсэгт түүний ивээлд байх Алтан Соёмбо оруулав. Холбогдох түүхэн үйл явдал -Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойг соёмбыг тойруулж бичсэн "Ардын хувьсгал" гэсэн үг "1921-2001" гэсэн тоогоор илэрхийлэв.

Б.Медалийн хийц, хэмжээ





Медалийн дээд хэсэг

1. Дээд хэсгийн толгойн өргөн 38 мм, өндөр 32 мм, гаднах хөвөө нь өөрөөсөө товойж гарсан байх бөгөөд дээд талаараа задгай байна. Хөвөөний өргөн 2 мм, алтлаг шар өнгөтэй байна.

2.Дээд хэсгийн хэсгийн голын 8 ширхэг хөх цагирагийг талст байдлаар хийж паалантдана. Цацрагийн талстууд нь ,дээшлэх тусам өргөсөж төгсгөлдөө нийт 16 мм байна.

3. Багц цацрагийн баруун, зүүн талын гурвалжин хэсгийг улаан паалангаар өнгөлнө.

Медалийн доод хэсэг:

1. Медаль нь хамгийн урт цацраг бүхий гаднах хүрээ хэсгээрээ 38 мм диаметртэй байна.

2. Соёмбо, мөн "Ардын хувьсгал", "1921-2001" гэсэн дүрс, үг, тоо болон тэдгээрийг хүрээлсэн 1 мм өргөн дугуй нуух зэргийг үндсэн металлаар товойлгож хийнэ. Дүрс, үг, тоо, хүрээ нуух нь алтан шармал, тэдгээрийн дэвсгэр голын дугариг нь 26 мм диаметртэй, цагаан өнгөөр паалантдана.

3. Нарны цацрагийг дүрсэлсэн талстууд гэрэл сүүдэр гаргасан товгор байна. 8 урт цацраг нь 6мм, 16 богино цацраг нь 5мм урттай байх бөгөөд гадагшлах тусам налуу болж үзүүр хэсгээрээ 1мм зузаантай байна.

4.Медиалийн дээд,доод хэсгийг зурагт зааснаас холбоно.

Медиалийн хэмжээг бүхэлд нь үзвэл тууш өндөөрөө 75 мм, зузаанаарая 2мм байна.

Медиаль дээд хэсгийнхээ ард хувцсанд тогтоох зүүтэй байна.

В. Медалийг хийх материал:

Медалийг бүхэлд нь гуулиар хийж өнгөлнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 22** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2001 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалтыг 2001 оны 5 дугаар сарын 20-ны өдөр явуулахаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 23** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 462534.0 мянган төгрөгөөр тогтоож, сонгуулийн зардлыг санхүүжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 24 **Улаанбаатар хот**

2001 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байгууллын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2001 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2/Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3/Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4/Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл;

7/Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл;

8/Авилгалын эсрэг хуулийн төсөл;

9/Иргэний хуулийн төсөл;

10/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

11/Эрүүгийн хуулийн төсөл;

12/Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн төсөл;

13/Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

14/Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн төсөл;

15/Хувийн хамгаалалтын тухай хуулийн төсөл;

16/Галт зэвсгийн тухай хуулийн төсөл;

17/Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;

18/Хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төсөл;

19/Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл;

20/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөл:

21/Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн төсөл;

22/Нийгмийн салбарт хувьчлал явуулах тухай хуулийн төсөл;

23/Газрын багц хуулийн төсөл;

24/Зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

25/Бусад.

2.Улсын Их Хурлаас өмнө өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль тогтоомжийн төслийг хаврын ээлжит чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтсугай.

3.Улсын Их Хурлын 2001 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан Засгийн газраас өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг 3 дугаар сарын 20-ны дотор өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

4.Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан боловч 2001 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хурлаас өргөн мэдүүлээгүй хуулийн төслийг хаврын чуулганаар хэлэлцэхгүй байхаар тогтсугай.

5.Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлыг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган хаврын Байгууллын хороодын дарга нарт болон Тамгын газар /Б.Энэбиш/ -т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 7 (194)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Зудтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *2001 оныг "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил" болгох тухай*
- *"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны хоёрдугаар сарын 20 №7 (194)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

76. Авидхаааны Стамбулд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 07 176
77. Түмэнбаярын Дашцэдэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 08 176
78. Дэндэвийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 09 176
79. Жигжидсүрэнгийн Алтангэрэлд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 10 177
80. Галсангийн Дашзэвэгт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 11 177
81. Жамсрангийн Өлзий-Оршиход Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 12 177
82. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 13 177
83. Аюушийн Отгонжаргалыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 14 180
84. Цэвэгийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 15 180
85. Шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 18 180
86. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 19 180
87. Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай Дугаар 20 181
88. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай Дугаар 21 181

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

89. Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны нэр, тоог тогтоох тухай Дугаар 193 181
90. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 194 182
91. Комисс байгуулах тухай Дугаар 195 182
92. Чанга дэглэмтэй зарим хорих ангийн хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай Дугаар 196 183
93. Иргэний бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 198 183

94. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 199	184
95. Зудтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 200	188
96. Журам батлах тухай	Дугаар 201	190
97. 2001 оныг "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил" болгох тухай	Дугаар 203	193
98. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх тухай	Дугаар 204	193

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 07 — Улаанбаатар хот

Авидхааны Стамбулд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт БелАЗ, Комацу машины жолоочоор олон жил үр бүтээлтэй ажиллаж эзэмшсэн техникийн хүч чадлыг бүрэн ашиглах, уулын цул тэсэвэрлэх даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, үйлдвэрлэлийн жигд ажиллагаат хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж тус үйлдвэрийн БелАЗ машины жолооч Авидхааны Стамбулд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 08 — Улаанбаатар хот

Түмэнбаярын Дашцэдэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Төр, боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж оюутан залуучуудыг сурган хүмүүжүүлэх, үндэсний үсэг бичгийг нийтэд дэлгэрүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Монгол судлалын сургууль-ийн хэл шинжлэлийн тэнхмийн профессор Түмэнбаярын Дашцэдэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 09 — Улаанбаатар хот

Дэндэвийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж дээд боловсролын сургалтыг өөрчлөн шинэчлэх хөгжүүлэх, сургуулийнхаа материаллаг баазыг бэхжүүлэх, бүтээц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, инженер техникийн дээд боловсролтой мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Техникийн их сургуулийн ректор Дэндэвийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 10 — Улаанбаатар хот

Жигжидсүрэнгийн Алтангэрэлд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуулиудад хичээлийн эрхлэгч, захирлаар олон жил үр бүтээлтэй ажиллаж удирдсан сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, сургах арга зүйг боловсронгуй болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Завхан аймгийн Улиастай сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн захирал Жигжидсүрэнгийн Алтангэрэлд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 11 — Улаанбаатар хот

Галсангийн Дашзэвэгт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж эрүүлийг хамгаалах төрийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, салбарын мэргэжлийн болон эрдэм шинжилгээний боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Эрүүл мэндийн салбарын хөгжил" хөтөлберийн зөвлөх Галсангийн Дашзэвэгт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 12 — Улаанбаатар хот

Жамсрангийн Өлзий-Оршиход Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Дугуйн спортоор дэлхий, тив, олон улсын болон Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, 2000 онд дэлхийн шигшээ багийн бүрэлдэхүүнд Ази тивээс шалгаран орж спортын өндөр амжилт үзүүлэн эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяат нь үнэлж Төв аймгийн "Төв зам" дугуйн спорт аяллын клубийн тамирчин Жамсрангийн Өлзий-Оршиход Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр — Дугаар 13 — Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Очирын Бат-Эрдэнэ -Монгол телевизийн "ММ" агентлагийн зураглаач
2. Бадамын Дагвасамбуу -"НИК" концернийн Баянхонгор аймаг дахь нефть хангамжийн баазын дарга
3. Нямын Мишигдорж - Монгол Улсаас ОХУ-ын Улаан-Уд хотноо суугаа ерөнхий консул

4.Самдангийн Норов	- Улсан багшийн их сургуулийн Багшийн коллежийн математикийн багш

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Халийн Авхий	- Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын дунд сургуулийн захирал
2. Жанчивсэмбийн Алтангэрэл	- Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын зөвлөх
3. Чойн Алтанцэцэг	- Улаанбаатар хотын төв номын сангийн орлогч захирал
4. Базарын Аюуш	- Үнэт цаасны хорооны бүртгэл, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
5. Лувсанчимэдийн Баатар	-МАХН-ын Баянхонгор аймгийн Богд сумын үүрийн дарга
6. Буянтогтохын Багаа	- Өмнөговь аймаг дахь Даатгалын салбарын захирал
7. Лхүндэвийн Бадамрагчаа	- Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуй эрхлэх газрын харьяа Төрийн ордны зоогийн газрын зөөгч нарын ахлагч
8. Ёндонгийн Басан	- Увс аймгийн Ирэгдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
9. Сугарын Батсайхан	- МАХН-ын Сүхбаатар аймгийн хорооны улс төрийн ажилтан
10. Жанчивын Батаа	- Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлгийн факультетийн багш
11. Гуржавын Батнасан	- Үндэсний дуу, бүжгийн "Түмэн эх" чуулган гоцлол хөгжимчин
12. Насанбуянгийн Баянсайхан	- Нийслэлийн барилга, хөрөнгийн үнэлгээний "Баярсонтракшин" ХХК-ийн ерөнхий захирал
13. Дэжидийн Вандан-Очир	- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "ВЦ" ХХК-ийн дэд захирал
14. Пүрэвийн Гомбоо	- Завхан аймгийн Сонгино сумын Баян-Айраг багийн Засаг дарга
15. Зэнэмидэрийн Гулиражаа	- Улсын багшийн их сургуулийн Гадаад хэлний факультетийн декан
16. Гэндэнгийн Даваасамбуу	- Нийслэлийн 52 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш
17. Аюурзанын Дамцагдорж	- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга
18. Долгорын Дариймаа	- Бүх цэргийн дуу, бүжгийн чуулган гоцлол дуучин
19. Лхаасүрэнгийн Дашцэрэн	- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн дарга
20. Бэгзийн Дүгэржанцан	- Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн барилга, техник хяналтын хэлтсийн ахлах инженер
21. Гармаагийн Жадамбаа	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч
22. Дашзэгвийн Ирина	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Есөн эрдэнэ" худалдааны төвийн гүйцэтгэх захирал
23. Наваанзундуйн Ишдорж	- Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын орлогч дарга
24. Гүррагчаагийн Лхагваа	- Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Хүнсний үйлдвэр" ХХК-ийн ерөнхий захирал
25. Жанчивдоржийн Ломбо	- Монгол Улсаас БНСУ-д суугаа элчин сайдын яамны зөвлөх
26. Моломдагвын Магнайдорж	- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын аж ахуйн тасгийн дарга
27. Сугарсүрэнгийн Мөнхтогтоо	- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн ажилчин
28. Жамъянхорлоогийн Мягмар	- Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн ерөнхий инженер
29. Нямдоржийн Олзвой	- Дархан-Уул аймгийн Шарын гол сумын үйлдвэрлэл, үйлчилгээний "Дээд Баянбулаг" ХХК-ийн захирал
30. Монхорын Оюунчимэг	- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн ажилчин
31. Дашбалигийн Сангидорж	- Орхон аймгийн Дулааны цахилгаан станцын материал хангамж, аж ахуйн хэлтсийн дарга
32. Лхамжавын Сандаг	- Орхон аймгийн Дулааны цахилгаан станцын засварчин
33. Чойжилын Санжаадорж	- Нийслэлийн 4 дүгээр дунд сургуулийн багш
34.Рүүрагчаагийн Содномдаржаа	- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал
35.Маамын Тогоо	-Барилгын коллежийн шугам зургийн багш
36.Баанийн Пүрэв	– Улсын багшийн их сургуулийн физикийн факультетийн багш

37.Жавхлангийн Цэвэлмаа – МАХН ын Увс аймгийн хорооны улс төрийн ажилтан
38.Галсангийн Цэвээндорж – Худалдаа, үйлдвэрийн дээд сургуулийн проректор
39.Равдангийн Цэнд-Аюуш – Тер, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Төрийн ордны зоогийн газрын буфетын эрхлэгч
40.Ширсэдийн Цэнд-Аюуш – Утга зохиолын дээд сургуулийн захирал
41.Рэгзээгийн Цэцэгжаргал – Нийслэлийн Баянзүрх дүүргийн 129 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
42. Лувсанцэрэнгийн Шагдар – Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах " Эрдэнэт" үйлдвэрийн мах боловсруулах үйлдвэрийн дарга
43. Буянжаргалын Энхбулаг – Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын II нарийн бичгийн дарга
44. Гомбын Эрдэнэшарав – Нийслэлийн 41 дүгээр дунд сургуулийн түүх газар зүйн багш
45. Үлэмжийн Юнрэн – Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны түшмэл
46. Базаагийн Ядмаа - Баянхонгор аймгийн "Шаргалжуут" рашаан сувиллын захирал
47. Равдангийн Янжмаа - Гадаад хэргийн яамны Европ, Араб, Африкийн газрын 1 нарийн бичгийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэрэнпилийн Банзрагч - Орхон аймгийн Дулааны цахилгаан станцын түлш тээврийн цехийн дарга
2. Бадарчийн Батжаргал - Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын уран сайхны удирдаач, хөгжмийн багш
3. Эрдэнэсүрэнгийн Бүрэнтэгш - Улаанбаатар хотын төв номын сангийн ном бүрдүүлэгч
4. Отгоны Дамбийнаям - Гадаад хэргийн яамны Эрхзүй, консулын газрын хилийн тасгийн даргын үүрэг гүйцэтгэгч
5. Халтархүүгийн Жаргалсайхан - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер
6. Дугарын Майдар - Нийслэлийн алтны хайгууль, олборлолтын "Хайлааст" ХК-ийн ажилчин
7. Баадайн Мандшир - Орхон аймгийн үйлдвэрлэл худалдааны "Эрдэнэт-Хүнс" ХК-ийн мастер
8. Ажмаагийн Мандах - Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг дарга
9. Пэрэнлэйн Мэндбилэг - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн ажилчин
10. Намдагчагнаагийн Намжил - Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн мах боловсруулах үйлдвэрийн чанар шалгагч
11. Ордашийн Нигмет - Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын дунд сургуулийн биеийн тамирын багш
12. Бархасын Нямхүү - "Монголболгаргео" ХХК-ийн Баянхонгор аймаг дахь Жаргалантын алтны уурхайн инженер-геологич
13. Содномын Отгонсүрэн - МАХН-ын Дархан-Уул аймгийн хорооны бичээч
14. Шунүгийн Оюунчимэг - МАХН-ын Сүхбаатар аймгийн хорооны бичээч
15. Найдангийн Сандагдулам - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн нярав
16. Очирын Төрмөнх - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн ажилчин
17. Бярваагийн Туяажаргал - Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хүнсний үйлдвэрийн дарга
18. Дамдинсүрэнгийн Цэдэндорж - Орхон аймгийн Дулааны цахилгаан станцын үйлдвэрлэлийн албаны дарга
19. Дэмбэрэлийн Цэрэнхишигт - Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн зохион байгуулагч
20. Дандрайн Цэрэнбатаа - Завхан аймгийн Засаг дарын Тамгын газрын татварын хэлтсийн улсын байцаагч
21. Пунцагийн Чулуунбаатар - Увс аймгийн Мэргэжлийн хяналтын албаны байцаагч
22. Батмөнхийн Энхбаяр - Геологийн судалгааны товчооны Баянхонгор аймгийн Баянбулаг сум дахь Төгрөгийн ангийн төслийн удирдагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот

Аюушийн Отгонжаргалыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас иргэдийн амь нас, мал сүргийг аварч, иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлсэн Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын нийтлэг үйлчилгээний газрын гэрээт малчин Аюушийн Отгонжаргалыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот

Цэвэгийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн уснаас хүмүүсийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3 дугаар дүнд сургуулийн багш Цэвэгийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 18 | Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Хишгээгийн Байгалмаагаа Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 19 | Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Жадамбын Дашдоржийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 07–ны өдөр **Дугаар 20** **Улаанбаатар хот**

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Шүүн таслах ажиллагаанд удаа дараалан дутагдал гаргаж сахилгын шийтгэл дахин хүлээсэн Жигдэнгийн Энхтуяаг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, удаа дараа ажлын цагаар архидан согтуурч шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчиж сахилгын шийтгэл дахин хүлээсэн Норовын Хүрэлбаатарыг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 07–ны өдөр **Дугаар 21** **Улаанбаатар хот**

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 63 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Будрагчаагийн Сарантуяаг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татаж шалгах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 13–ны өдөр **Дугаар 193** **Улаанбаатар хот**

Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны нэр, тоог тогтоох тухай

Ан агнуурын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тусгай төлбөртэйгээр 2001 онд үгалз 44, тэх 280, хар суүл зээр 60, халиун буга 75, баавгай 2, бор гөрөөс 30, цагаан зээр 50, гахай 5, чоно 150, агнуурын шувуу 1200 хүртэл толгойг агнуулах, мануул 6 толгойг амьдаар бариулахаар тус тус тогтоосугай.

2. Агнуурын ан амьтны олзворын жишиг үнэ, тусгай зориулалтаар агнуулах ан амьтны төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох талаар санал боловсруулж 2001 оны П улиралд багтаан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. АНУ-ын Лас-Вегас хотноо 2001 оны 2 дугаар сарын 14-17-нд болох Олон улсын аргаль сангийн эзэлжит хурлын үеэр явагдах ан агнах эрхийн дуудлага худалдаанд Монгол Улсаас угалз, тэх зэрэг агнуурын зарим амьтан агнах эрхийг дуудлагад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 194** **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг төр, олон нийтийн төлөөлөлтэйгээр шинэчлэн байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн статусын тухай" Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 195** **Улаанбаатар хот**

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинэ мянган, шинэ зууныг угтах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	А.ЦАНЖИД
Гишүүд:	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	М.ЭНХБОЛД;
	-Батлан хамгаалахын дэд сайд	Ц.ТОГОО;
	-Санхүү, эдийн засгийн дэд сайд	Л.ЭНХТАЙВАН;
	-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд	С.ЧИНЗОРИГ;
	-Дэд бүтцийн дэд сайд	У.УЛАМБАЯР;
	-Гадаад хэргийн дэд сайд	С.БАТБОЛД;
	-Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга	Б.ГАНБОЛД;
	-Цагдаагийн ерөнхий газрын дарга	Ч.АМАРБОЛД;
	-Ерөнхийлөгчийн улс төрийн бодлогын зөвлөх /зөвшилцсөнөөр/;	Б.ДАШ-ЁНДОН
	-Ерөнхийлөгчийн Мэдээлэл харилцааны албаны дарга /зөвшилцсөнөөр/.	С.ОДХҮҮ
Нарийн бичгийн дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга	Л.ЭРДЭНЭЧИМЭГ

2. Шинэ мянган, шинэ зууныг угтах ажлыг аж ахуйн нэгж, төр, олон нийтийн байгууллагуудыг татан оролцуулж өргөн олныг хамруулан ёслол төгөлдөр төмдэглэн өнгөрүүлэхийг тус комисс болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 18–ны өдөр | Дугаар 196 | Улаанбаатар хот

Чанга дэглэмтэй зарим хорих ангийн хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гянданбалон хугацаагүй хорих тусгай салбар, Говьсүмбэр аймаг дахь чанга дэглэмтэй хорих анги, Улаанбаатар хот дахь Цагдан хорих тевийн дэргэдэх чанга дэглэмтэй хорих ангийн гаднахь харуул хамгаалалтыг зохион байгуулахад Дотоодын цэргэт шаардагдах албан хаагчдын орон тоог 1 дүгээр хавсралт ёсоор батална.

2. Засгийн газрын 2000 оны 32 дугаар тогтоолын хавсралтад батална Дотоодын цэргэт 2000 оны хоёр дахь эзлэхинд татагдах цэргийн тоог 110-аар нэмэгдүүлсүгэй.

3. Хугацаат цэргийн албанд татагдах цэргийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан тэдний хүнс, хувцасны зардалд 23276,0 мянга, нэмэгдэж байгаа хамгаалалтын ажилд шаардлагатай байгаа 2 дугаар хавсралтад дурдсан автомашин, холбооны техник хэрэгсэл худалдан авахад зориулж 15860,0 мянга, нийт 39136,0 (гучин есөн сая нэг зуун гучин зургаан мянга) мянган төгрөгийг 2000 оны улсын төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлаас олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 196 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШИНЭЭР ОБЪЕКТУУД ХАМГААЛАЛТАД АВАХАД ШААРДАГДАХ АВТОМАШИН, ХОЛБООНЫ ХЭРЭГСЛИЙН ҮНИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөг/

№	Техник хэрэгсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Харуулын цэрэг тээвэрлэх автомашин ЗИЛ-130	ш	1	8000,0	8000,0
2	Холбооны хэт богино долгионы холбогч станцууд	ком	3	2220,0	6660,0
3	Дотуур ярианы байгууламж	ш	3	400,0	1200,0
	Бүгд				15860,0

/Арван таван сая найман зуун жаран мянга/

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 26–ны өдөр | Дугаар 198 | Улаанбаатар хот

Иргэний бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын тевийг 2001 оны 1 дүгээр сард багтаан цагдаагийн бие бүрэлдэхүүнээс гаргаж, иргэний байгууллага болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтэс /газар/-ийн иргэний бүртгэл, мэдээллийн албаны ажилтан болон Засаг даргын Тамгын газрын иргэний гэр бүлийн бүртгэл, шилжих хөдөлгөөний асуудал хариуцсан ажилтныг орон тоо, тесев, цалингийн сан, холбогдох үндсэн хөрөнгийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтэст шилжүүлэн ажиллуулсугай.

3. Иргэний бүртгэл, мэдээллийн албыг иргэний байгууллага болгон өөрчлөн зохион байгуулж байгаатай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а/зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлт гаргавал түүнийг иргэний бүртгэл, мэдээллийн албанд эрхэлж байсан албан тушаал, цалинг нь бууруулахгүйгээр цагдаагийн байгууллага ажлаар хангах арга хэмжээ авах;

б/цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлт гаргасан албан хаагчдад ажил олгох боломжгүй бол тэдгээрийг ажлаас чөлөөлж, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дахь заалтад заасан төрийн захиргааны албан хаагчтай адилтган үзэж 6 сар хүртэл албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас олгох;

в/иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагад байцаагч, мэргэжилтэн, түүнээс дээш албан тушаал эрхэлж байгаад энгийн болж шилжин ажиллах хүсэлт гаргасан цагдаагийн офицерыг Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамааруулах;

г/цагдаагийн албан хаагчаар тасралтгүй 22, түүнээс дээш жил ажилласан боловч цэргийн албан хаасны тэтгэвэр тогтоолгох хугацаа нь болоогүй, цэргийн жинхэнэ албан хаах насны дээд хязгаарт хүрээгүй албан хаагч иргэний бүртгэл, мэдээллийн албанд үргэлжлүүлэн ажиллах хүсэлт гаргавал түүнийг цэргийн албан хаасны тэтгэвэр тогтоолгох нас хүртэл нь үргэлжлүүлэн ажиллуулж энэ хугацаанд төрийн тусгай албан хаагчтай адилтган үзэж байх;

д/иргэний бүртгэл, мэдээллийн албанд ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч нь "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар цэргийн албан хаасны, эсхүл цэргийн албан хаасны тэтгэвэрийг хувь тэнцүүлэн тогтоолгож энгийн албан тушаал эрхлэх хүсэлт гаргавал түүнийг цаашид ажиллах боломжтой эсэхийг харгалзан шийдвэрлэж өгөх;

е/иргэний бүртгэл, мэдээллийн албан нь иргэний байгууллага болон өөрчлөн зохион байгуулагдах явцад орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр халагдсан төрийн албан хаагчид "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, "Журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг тус тус үндэслэн зохих тэтгэмжийг олгох.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 199** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хэтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийг сэргээх, экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ноолуур" хэтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний үндэсн чиглэлийг 1 дүгээр хавсралт, хэтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажилд шаардлагатай зардлын хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хэтөлбөрийн явцад хяналт тавьж, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хэтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолын 2, 3, 4 дүгээр зүйл, мөн тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

"НООЛУУР" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Заалтын дугаар	Хөтөлберт заасан зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилтийг зохицуулах, биелэлтэд хяналт тавих байгууллага
				Хэмжээ /сая төг/	Эх үүсвэр	
	I. Ямааны үүлдэр угсаа, нооллуурын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд:					
1.	Ямаан сүргийн тоолгого явуулж, монгол үүлдрийн ямааны омог хэвшлийн тоо, хувийн жин, сүргийн бүтэц, тархалтын хүрээ, ямааны үүлдэрлэг байдлыг сум бүрээр тодорхойлох	1/ Аймаг, сумдад ямаат үүлдэр, омгоор нь яг таварлан тоолох ажлыг Үндэсний статистикийн газрын тоолгогын ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах;	2001			ҮСГ, ХХААЯ
		2/ Тоолгогын ажлын хэсэгт оруулах төлөөлөгчдийг томилж тоолгогод сронцлох нөхцөлөөр хангах.	2001	9.5	Улсын төсөв	ХХААЯ
2.	Үржлийн шилмэл ямааны цэм сүргийг бүрдүүлж бүртгэлжүүлэх, шилмэл сүргийн бүс нутгийг тогтоох, мэдээллийн сүлжээ бий болгох.	1/ Шилмэл үүлдэр, омгийн үржлийн ямаат сайжруулагчаар ашиглах бүс нутгийг тогтоож шийдвэр гаргах;	2001			ХХААЯ
		2/ Үржлэд зориулж худалдах шилмэл сүргийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэх радио биржээр ажиллуулах.	2001-2004	1.2	Улсын төсөв	ХХААЯ
		3/ Үржлийн шилмэл сүргийн тухай байнын төвхимол сэтгүүл гаргаж, малчид, иргэдийг мэдээллээр хангах.	2001-2004	0.6	Улсын төсөв	ХХААЯ
3	Стандартын шаардлага хангасан үржлийн хэлтэгч, хэлтүүлэгчийг цэм сүргээ түшиглэж бойжуулах иргэн, хуулийн этгээдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих.	1/ Олон улсын байгууллагаас Монгол улсад хэрэгжүүлэх буй төслийн хүрээнд шилмэл сүргийн цэм үржүүлэх буй иргэд, байгууллагад дэмжлэг үзүүлэх;	2001-2004	-	-	ХХААЯ
		2/ "Говийн саналчилга", "Фермерээс фермер", "Өрөөлдөх чадвар" зэрэг АНУ-ын техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих буй төслөөр бий болсон банкны бус санхүүгийн байгууллагаар дамжуулан малчид, иргэд, байгууллагад олгох хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгийг ерөнхийлөх.	2001-2004	-	-	ХХААЯ
4	"Говьгурвансайхан", "Улаан бор" ямааны селекцийн бодлогыг тодорхойлж, тэдгээрийн цэм сүргийг сайжруулах арга хэмжээ авах	1/ Говьгурвансайхан, Улаан бор үүлдэр, Өнжүүл үржлийн хэсэг, Баянөндөлгөө, Өлгий, Эрчим, Буурал, Залаажинстийн цагаан ямааны цэм сүргээ үзэлгэ, ангилал хийж 1-ээс дээш ангийн хэстийг үржлийн албаны бүртгэлд оруулах.	2001	-	-	ХХААЯ

5	Түүхий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх	1/ Түүхий эд бэлтгэлд оролцож буй иргэд, байгууллагуудын үйл ажиллагаат зохицуулах журам боловсруулж мөрдүүлэх; 2/ Түүхий эдийн бирж ажиллуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулах; 3/ Дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эдээ худалдсан малчдад урамшуулал үзүүлэх тогтолцоог бий болгох; 4/ Хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу хувь хүнээс бараа, материал, түүхий эд худалдан авсан үнийн дүнгээс 3 хүвиар тооцож төлдөг татварт бэлэн мөнгөөр түүхий эд бэлтгэдэг аж ахуйн нэгж, худалдаа эрхэлсэгчийг хамруулах арга хэмжээ авах.	2001 2001-2004 2001 2001	- - - -	- - - -	ҮХЯ ҮХЯ, ХХААЯ ҮХЯ ҮХЯ, СЭЗЯ
	II. Эдгээх, сүлжих, нэхэх хүч чадлыг нэмэгдүүлэх замаар түүхий эдийг дотооддоо боловсруулж эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилтын хүрээнд:					
6	Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн бодлогыг хэрэгжүүлэх	1/ Түүхий эдийн нөөц сан байгуулж, сангийн ажиллах журам боловсруулж мөрдүүлэх; 2/ Зээрмэл үйлдвэрлэх хүч чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын асуудлыг Япон улсаас олгох 2 шаттай хөнгөлөлттэй зээлд хамруулах; 3/ Түүхий эд бэлтгэлийн үеэр арилжааны банкнаас олгож буй зээлийн хүүгээр нэмэгдүүлэх, нэг зээлдэгчид түхайн банкны хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй хэмжээний зээл олгодог жүрмыг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийн хувьд хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр банкны хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.	2001 2002-2004 2001	- 59600.0 -	- Япон улс, бусад хандивлагч орнууд -	ҮХЯ, СЭЗЯ ҮХЯ, СЭЗЯ Монгол банк, СЭЗЯ, ҮХЯ
7	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад түслах материалыг импортлох үйл ажиллагааг эдийн засгийн аргаар дэмжих	Дотоодын үйлдвэрүүдийн нооluуран сүлжмэл, нэхмэл болон бусад төрлийн эцсийн бүтээгдэхүүнтэй ижил импортын барааны татварыг нэмэгдүүлэх асуудлыг судалж санал боловсруулах	2001	-	-	ҮХЯ, СЭЗЯ
8	Зээрмэл, нэхмэл, сүлжмэлийн иж бүрдэл үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжид эдийн засгийн хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	1/ Гадаадын хөрөнгө оруулалттай анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг аж ахуйн нэгж байгуулагын орлогын албан татварт хамруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх; 2/ Анхан шатны боловсруулах үйлдвэрийн хүч чадал, түүхий эдийн нөөцийн зохистой харьцаагаг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд тавих хязалтыг сайжруулах	2001 2001	- -	- -	ҮХЯ, СЭЗЯ ҮХЯ, ХЗДХЯ
9	Эх орны нооluурын үйлдвэрүүдийн хүч чадлыг сэргээх, ашиглах, нэмэгдүүлэх үйл ажиллагааны түхайн үеийн байдалд нийцүүлж түүхий нооluурын экспортыг үзэн хатан байдлаар зохицуулах, шаардлагатай үед тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судалж шийдвэрлэх	1/ Түүхий эдийн экспортод тавих хөндлөнгийн хязалтыг сайжруулах арга хэмжээ авах; 2/ Түүхий нооluурыг экспортлосон иргэн, аж ахуйн нэгж байгуулагыг нэмэгдсэн өртгийн албан татварт хамруулах; 3/ Экспортын бүтээгдэхүүний жишиг үнийг тогтоох жүрмыг шинэчлэн боловсронгуй болгох.	2001 2001-2004 2001	6.4 - -	Улсын төсөв - -	ҮХЯ, ХЗДХЯ, УГЕГ, мэргэжлийн байгууллагууд ҮХЯ, СЭЗЯ ҮХЯ, УГЕГ

III. Бүтээгдэхүүний чанар, заавар хийцийг сайжруулан нэр төрлийг олшруулах, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

10	Нөөлүүр боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх	1/Нөөлүүр боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх журам боловсруулж батлуулах 2/Техник, технологийн түвшинг үнэлэх ажлын групп байгуулах.	2001	-	-	УХЯ
			2001	-	-	УХЯ
11	Дараахь чиглэлээр үндэсний стандарт боловсруулан мөрдүүлэх: -Нөөлүүран зэрмэлийн техникийн нөхцөл, -Нөөлүүран сулжмэл эдэлгийн техникийн нөхцөл, -Нөөлүүран хэмэл эдэлгийн техникийн нөхцөл, -Нөөлүүран гүйцэтгэн боловсруулах технологийн шаардлага: -Сав, хэлтэс боловсруулах техникийн нөхцөл, -Нөөлүүр боловсруулах үйлдвэрийн ажлын байрны зөрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийн техникийн шаардлага.	1/Тухайн чиглэлүүдээр холбогдох судалгаа хийж, дүгнэлт гаргах; 2/ Стандартын төсөл боловсруулах; 3/ Стандартын төсөлд холбогдох байгууллагаас санал авах. Техникийн хороогоор хэлэлцүүлэх. 4/ Стандартын төслийг СХҮТ-ийн зөвлөлөөр хэлэлцүүлэх. Батлуулах.	2001 2002 2003			УХЯ, ЭМЯ, НХҮЯ, СХҮТ, Нэхэмэлийн хүрээлэн
12	Нөөлүүрын бүтэц, шинж чанарын нэгдсэн судалгаа явуулж олон улсын медээллэл, стандартын дагуу бүртгэлд хамруулж, суртачилах. чанарын тэмдэгтэй болгох	Монгол нөөлүүрын бүтцийн судалгаа хийж, олон улсын стандарт, медээллийнх сүлжээнд хамруулах. чанарын тэмдэгтэй болгох зорилго бүхий төслийг хандивлагч орон, гадаадын техникийн туслалцаанд хүрээнд хүрээнгүүлэх	2001-2004	2670.0	Хандивлагч орны эзэд, туслэмж	УХЯ, БСШҮЯ, Оюуны өмчийн газар
13	Эрдэм шинжилгээний байгууллалын техник, тоног техеремжийг шинэчлэх.	Нөөлүүр боловсруулах салбарын эрдэм шинжилгээний байгууллатын тоног техеремж, техникийг шинэчлэх асуудлыг олон улсын зээл, туслэмжийн хүрээнд шийдвэрлэх.	2001-2004	600.0	Хандивлагч орны эзэд, туслэмж	УХЯ, СЗЗЯ, БСШҮЯ
14	Оны шилдэг зарлаг, бүтээгдэхүүн, заавар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шагналуулж урамшуулах	1/ Оны шилдэг зарлаг, заавар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шагналуулах ажлыг зохион байгуулах; 2/ Бүтээгдэхүүний хийц, загварыг сайжруулах, чанарыг дээшлүүлэхэд үр бүтээл гаргасан ирээд, үйлдвэрлэгчдийг урамшуулах эдийн засгийн тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх.	2001-2004 2001-2004	-	-	УХЯ, МХАҮТ УХЯ
	ДҮН:	Улсын төсөв		17.7		
	Үүнээс:	Гадаадын зээл, туслэмж		62870.0		

"Ноолуур" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын төсөв

№	Зардлын төсөв		Төсөв /мян.төг/		
			2002	2003-2004	Дүн
1.	Хэрэгжүүлэх арга үйл ажиллагаа суралцчилах		1120.0	3360.0	4480.0
	Үүнээс	Хэвлэлд 1 удаа өгөх нийтлэлийн үнэ /мян.төг/	80.0		
		Нийтлэлийн давтамжийн тоо /жилээр/	4.0		
		Хэвлэлээр нийтлэх зардлын дүн	320.0		
		Радио нийтлэлийн 1 удаагийн үнэ /мян.төг/	100.0		
		Нийтлэлийн давтамж /жилээр/	4.0		
		Радио нийтлэлийн зардлын дүн	400.0		
		Телевизийн 1 удаагийн нэвтрүүлгийн үнэ	400.0		
		Нийтлэлийн давтамж	1.0		
		Телевизийн нэвтрүүлгийн зардлын дүн	400.0		
2.	Сурталчилгааны материал бэлтгэх зардал /1 хэвлэлийн хуудсаар/		600.0	1800.0	2400.0
	Үүнээс	Нийт бэлтгэх хэвлэлийн хуудасны тоо	400.0		
		1 хэвлэлийн хуудсанд гарах зардал	1500.0		
3.	Семинар зөвлөлгөөн зохион байгуулах зардал		450.0	1350.0	1800.0
	Үүнээс	Нэг удаагийн семинар, зөвлөлгөөний дундаж	450.0		
		Давтамж	1.0		
		Нийт зардал	2170.0	6510.0	8680.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 200 Улаанбаатар хот

Зудтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

1999-2000 оны зун, өвөл тохиолдсон ган, зудад манай орны нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь буюу 13 аймгийн 157 сумын 450,0 мянга гаруй хүн, 7,1 сая мал нэрвэгдэж, зөвхөн хорогдсон малыг зах зээлийн үнээр тооцвол улсын жилийн төсвийн бараг гуравны нэгтэй тэнцэх буюу 91,7 тэрбум шахам төгрөгийн хохирол учирсан байна.

2000 оны зун манай орны нийт нутаг дэвсгэрийн 60 хувьд нь ган болж, энэ өвөл 90 хувьд нь цасан бүрхүүл тогтон уулархаг бүс нутгаар олон жилийн дунджаас илүү цас унаснаас Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн нуруунд өндөр даваануудаа хаагдан мал өвөлжилтийн байдал хүндэрлээ. Нутгийн баруун болон төв, зүүн бүсийн ихэнх нутагт 10 дугаар сарын эхнээс эхлэн олон удаа цас орж, зарим газарт хайлж, хайлмагтан хөлдөж, нам дор газартаа 15-20 см, уулархаг хэсэгтээ 40-60 см, гуу жалгаараа түүнээс ч илүү зузаараи хатуурчээ. Цас зудын хүндрэлтэй бүсэд 15 аймгийн 90-ээд сумын нутаг хамрагдан зудын гамшигт олон аймаг, сум дахин нэрвэгдэхэд хүрээд байна.

Мал өвөлжилт эрс хүндэрсэн эдгээр бүс нутагт малчин өрхийн 26,6 хувь, нийт малын 29,2 хувь (9,1 сая мал) байгаа бөгөөд 5784 өрхийн 2387,1 мянган мал 100-500 км нүүж өөр аймаг, сумын нутаг, улсын тусгай хамгаалалттай газар, хилийн зурваст отроор өвөлжиж, зарим өрх 2-3 тасран амьдарч байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад мал өвөлжилт хүндэрч, зудад нэрвэгдэхэд хүрсэн бүс нутагт байгаа өрхийн тоо нэлээд нэмэгдэж, малын тоо 28,2 хувиар өссөнөөс үзэхэд улсын эдийн засагт учрах хохирол энэ онд үлэмж ихсэх магадлалтай байгааг тэмдэглэж Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгах нь:

а/мал өвөлжилт хүндэрч, зудын гамшигт нэрвэгдэхэд хүрээд байгаа бүс нутгийн цагийн байдалд Байгаль орчны болон Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран аймаг, сум бүрээр үнэлгээ өгч, тэдгээрийн гамшигийн эрсдэлийг бодитойгоор тогтоож тусламжаар болон улсын нөөцөөс олгох өвс, тэжээл, хүнс, өргөн хэрэглээний бараа, эмийн хуваарилалт, тээвэрлэлт, хүргэлтийг холбогдох яам, байгууллагатай хамтран зохицуулж байсугай;

б/зудад нэрвэгдэхэд хүрсэн аймаг, сум, иргэдэд өвс, тэжээл, хүнс, өргөн хэрэглээний бараа тээвэрлэн хүргэх ажилд Зэвсэгт хүчний анги, байгууллагын тээврийн хэрэгслийн цуваар дайчлан ажиллуулах арга хэмжээ авсугай.

2. Улсын байнгын онцгой комисстой тохирч зохицуулах замаар улсын нөөцөөс гаргах эм, тусламжийн хүнсний барааны хуваарийг яаралтай гаргаж, зудад нэрвэгдэхэд хүрсэн аймаг, сум, малчдад хүргүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

3. Зудад нэрвэгдэхэд хүрсэн бүс нутгийн малчдын хэрэгцээнд зориулан улсын нөөцөөс гаргасан эмийг 2001 оны эхний хагас жилд багтаан тусламжийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт үүрэг болгосугай.

4. Зудад нэрвэгдэхэд хүрсэн бүс нутагт Улсын байнгын онцгой комиссын томилолтоор ажиллах эмч, эмнэлгийн ажилтан нарт Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу олгох нэмэгдэл хөлсийг гадаад орон, олон улсын байгууллага, манай орны аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгөөс гаргахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад зөвшөөрсүгэй.

5. Зудад нэрвэгдсэн аймаг, сум, малчдад өвс, тэжээл, хүнс, өргөн хэрэглээний бараа, эм, тариа тээвэрлэн хүргэх, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах шатахууны үндсэн нормыг Улсын байнгын онцгой комиссоос тогтоосон эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан нэмэгдүүлэн тогтоож өгөхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

6. Зудын цагийн байдал хүндэрсэн аймаг, сумын Засаг дарга нарт даалгах нь:

а/тусламжаар болон улсын нөөцөөс олгосон өвс, тэжээл, хүнс, өргөн хэрэглээний бараа, эмийг зудад нэрвэгдсэн малчдад шуурхай хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч байсугай;

б/зудтай нутгийн болон отроор явсан малчдын эмнэлгийн үйлчилгээ, малчдад тавих анхаарал халамжийг сайжруулахад байнга анхаарч шуурхай арга хэмжээ авч байсугай;

в/өөр аймаг, сумаас отроор ирж өвөлжиж байгаа малчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, тэдэнд аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, хууль тогтоомж зөрчин татвар, хураамж, төлбөр авах зэрэг зохисгүй байдал гаргахаас сэрэмжлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 201 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор батлаж, 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Төрийн албан хаагчийн гэр бүлийн оюутны сургалтын төлбөрийг санхүүжүүлэх хөрөнгийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төвлөрүүлэн зарцуулж байхыг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 194 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2000 оны 201 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ГЭР БҮЛЭЭС СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Өмчийн бүх хэлбэрийн их сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд төрийн албан хаагчийн гэр бүлээс өдрийн ангид элсэн суралцаж байгаа нэг хүүхэд /цаашид оюутан гэнэ/-ийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

2. Төрийн албан хаагчийн гэр бүл гэж Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалын ангилал, төрлийг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалыг хашиж байгаа эцэг, эх /цаашид төрийн албан хаагч гэнэ/-ийг хэлнэ.

3. Төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн зөвхөн нэг оюутны сургалтын төлбөрийг төрөөс олгоно. Төрийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд оюутны сургалтын төлбөрийн санхүүжилтийг зээлийн буюу бусад хэлбэрт шилжүүлнэ.

4. Оюутан дипломын шатлалд суралцах бол 90 кредит цагийн, бакалаврын шатлалд суралцах бол 120 кредит цагийн сургалтын төлбөрийг төр хариуцан санхүүжүүлнэ.

5. Оюутан нь их сургууль, коллежид элсэн суралцах эрхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу авсан байна.

Хоёр.Оюутны сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд төрийн албан хаагчийн бүрдүүлэх материал

6. Төрийн албан хаагч нь ажиллаж буй төсөвт байгууллагадаа доорхи материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

а/оюутны сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхийг хүссэн өргөдөл;

б/өөрийн хүүхдийг их сургууль, коллежид оюутан элсүүлэх журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичгийн хуулбар;

в/эцэг, эх нь хоёулаа төсөвт байгууллагад ажилладаг бол нөгөө байгууллагад ажилладаг эцэг /эх/-ийн ажлын газраас оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлээгүй тухай байгууллагын тодорхойлолт;

г/оюутны сургуулиас ирүүлсэн сургалтын төлбөрийн нэхэмжлэл;

д/оюутан нь улиралд 12-оос доошгүй кредит цагийн ачаалалтай, улирлын голч дүн нь 2-оос дээш байгаа нөхцөлд гэрээг сунгана.

7. Төрийн албан хаагч хүүхдээ их сургууль, коллежид элсэн суралцсан эхний жилд энэ журмын 6 дугаар заалтын а, б, в, г-д заасны дагуу материал бүрдүүлнэ.

8. Төрийн албан хаагч хүүхдээ их сургууль, коллежид үргэлжлүүлэн суралцах үед энэ журмын 6 дугаар заалтын а, б, г, д -д заасны дагуу материал бүрдүүлнэ.

Гурав.Сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх

9. Төрийн албан хаагч хүүхдээ их сургууль, коллежид элссэнээс хойш нэг сарын дотор энэ журмын 6 дугаар заалтад заасан материалыг ажиллаж буй байгууллагадаа бүрдүүлэн өгч, сургалтын төлбөрийн гэрээг тухайн төсөвт байгууллагатайгаа байгуулж, нотариатаар баталгаажуулна. Уг гэрээний загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10. Төрийн албан хаагчийн ажиллаж буй төсөвт байгууллага нь энэ журмын 6 дугаар заалтад заасан материалыг хянан үзэж, төлбөрийн гэрээг үндэслэн оюутны сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай тушаал гаргаж, дор дурдсан байгууллагад хүргүүлнэ:

а/орон нутгийн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллага нь жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор аймаг, дүүргийн Засаг даргад;

б/төвлөрсөн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллага нь жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор Сургалтын төрийн санд.

11. Аймаг, дүүргийн Засаг дарга нь төсөвт байгууллагаас ирүүлсэн тушаалуудыг нэгтгэж захирамж гарган холбогдох материалын хамт жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор Сургалтын төрийн санд ирүүлнэ.

12. Сургалтын төрийн сан нь төсөвт байгууллагын тушаалыг үндэслэн, сургалтын төлбөрийг эхний

хагас жилийн хичээлийн жил эхэлснээс хойш нэг сарын дотор, сүүлийн хагас жилийн сургалтын төлбөрийг хичээлийн жилийн П улирал эхэлснээс хойш нэг сарын дотор тус тус тухайн сургуулийн дансанд шилжүүлнэ.

13. Давтан үзэх хичээлийн сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна. Тухайн хичээлийн жилд цуглуулбал зохих кредитээс илүү гаргаж сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна.

14. Их сургууль, коллежид суралцаж байгаа оюутны төлбөрийг санхүүжүүлэхдээ дотоодын төрийн өмчийн их сургууль, коллежийн адилтгах мэргэжлийн дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийн зардлын хэмжээг баримтална.

15. Оюутан нь Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын их сургууль, коллежид суралцсан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн энэ журмын 9 дүгээр заалтад заасан гэрээнд "сургалтын төлбөрийг төр хариуцсан" гэсэн тэмдэглэгээ хийж, сургалтын төлбөрийн гэрээг дуусгавар болсонд тооцно.

16. Төрийн албан хаагч хүүхдийнхээ сургалтын төлбөрийг өөрөө төлсөн тохиолдолд энэ журмын 6 дугаар заалтад заасан материал, мөнгө тушаасан баримтыг үндэслэн ажиллаж буй байгууллагаар нь дамжуулан Сургалтын төрийн сангаас сургалтын төлбөрийг нөхөн олгоно.

17. Оюутан зохих журмын дагуу чөлөөтэй байсан хугацааны сургалтын төлбөрийн санхүүжилтийг түр түдгэлзүүлэх бөгөөд үргэлжлүүлэн суралцах үед нь сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.

Дөрөв.Бусад асуудал

18. Оюутан сургалтын төлбөрийн талаар хуурамч материал бүрдүүлсэн, сургуулиас хасагдсаныг нуун дарагдуулсан, төлбөрийг нь давхардуулан авсан, илүү олгосон зэрэг зөрчил гаргасан тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу дээд боловсролын, төсөвт байгууллага болон аймаг, дүүргийн Засаг дарга, Сургалтын төрийн сангийн холбогдох албан тушаалтан, төрийн албан хаагчдад хариуцлага хүлээлгэнэ.

19. Хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүссэн тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.

20. Оюутны сургалтын төлбөрийн санхүүжилттэй холбоотой талуудын хооронд гарсан маргааныг боловсролын хяналт эрхэлсэн байгууллага гомдлыг нь хүлээн авсанаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

21. Их сургууль, коллежид төрийн зардлаар суралцаж байгаа оюутан сургуулиас хасагдсан, өөр сургуульд шилжин суралцсан тохиолдолд төрийн албан хаагчийн бусад хүүхдэд сургалтын төлбөрийг шилжүүлж олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 203** **Улаанбаатар хот**

2001 оныг "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих,хөгжүүлэх жил" болгох тухай

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тэмдэглэж Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Орон даяар 2001 оныг "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил" болгон зарласугай.

2. 2001 оныг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил болгосонтой холбогдуулан салбарын мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт үүрэг болгосугай.

3. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх бодлогын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж байсугай;

б/улсын эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах үйлдвэр, аж ахуйн газрын техник, технологийг шинэчлэх, үйлдвэрлэлийг ергежүүлэх төслийг гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах арга хэмжээ авсугай.

4. Дотоодын болон гадаадын зах зээлээс тааламжтай нөхцөлөөр хөрөнгө дайчилж эргэлтийн хөрөнгө бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэр төвлөрүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх арга хэмжээ авахыг Монгол банкны ерөнхийлөгч О.Чулуунбатад зөвлөсүгэй.

5.Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг бүх шатны банкны болон төрийн бус байгууллага, олон нийтэд уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 204** **Улаанбаатар хот**

"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын нийгэм-эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, хөрш зэрэлдээ болон бүс нутгийн орнуудтай авто замаар холбох, далайн гарцад хамгийн дөт замаар холбогдоход ирээдүйд ач холбогдолтой хэвтээ тэнхлэгийн гол замыг барьж байгуулахтай холбогдсон "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэд бүтцийн яам, Улсын Их Хурлын ажлын хэсгийн хамтран боловсруулсан "Мянганы зам" төслийг сайшааж, авто замын сүлжээний хэвтээ тэнхлэгийн замыг Улаанбаатараас баруун чиглэлд Лүн-Баяннуур-Дашинчилэн-Батцэнгэл-Ханүйн төмөр бетон гүүр-Тариат-Цахир-Идэр-Завханмандал-Дөргөн-Эрдэнэбүрэн-Толбо-Өлгий-Цагааннуур-Улаанбайшинт,Улаанбаатар-раас зүүн чиглэлд Багануур-Өндөрхаан-Сүмбэр чиглэлээр тогтоосугай.

2. Босоо тэнхлэгийн замуудын чиглэл, байршил, барих дарааллыг нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн бүсчилэлтэй холбогдуулан хэвтээ тэнхлэгийн замтай уялдуулан шийдвэрлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

3. Монгол Улсын эдийн засгийн болон бүс нутгийн хөгжлийг хурдасгах, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалан хамгаалах, төв суурин руу тэмүүлсэн нүүдлийг зогсооход ач холбогдол бүхий "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлуулсай.

4. Дэд бүтцийн сайд бөгөөд Үндэсний хорооны дарга Б.Жигжидэд даалгах нь:

а/"Мянганы зам" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэхтэй холбогдсон техник-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөг жил, таван жилээр боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

б/төслийн ач холбогдол, явцыг ард түмэнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн

сурталчилж, тэдний зүгээс дэмжлэг, туслалцаа авах, уг төслийг хэрэгжүүлэхэд ажил эрхлэгүй иргэд, хугацаат цэрэг, хөнгөн ялтай хүмүүсийг ерөнхөөр оролцуулсугай;

в/төслийг анх дэмжиж мөнгөн хандив өргөсөн ахмад тээвэрчин Д.Тэгшбуянтын санаачилгыг сайшааж, уг төслийг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хөрөнгө мөнгө, эд хөрөнгийн хандив өргөх санаачилгыг тухай бүр дэмжиж хандивын данс нээж ажиллуулсугай.

5. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхэд дотоодын хүч хөрөнгийг төвлөрүүлэн татан оролцуулах, гадаадын хандивлагч орон, санхүүгийн байгууллагуудын зээл, туслamжийг өргөн ашиглаж ажиллахыг Дэд бүтцийн сайд бөгөөд Үндэсний хорооны дарга Б.Жигжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт үүрэг болгосугай.

6. Шинэ мянганы их бүтээн байгуулалтын үйл хэрэг "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх ажилд яам, орон нутгийнхаа хүч боломжийг дайчлан ашиглаж, бүх нийтийн үйл ажиллагаа болгон зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2000 оны 204 дүгээр тогтоолын хавсралт

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД

Дарга -Дэд бүтцийн сайд Б.Жигжид

Гишүүд:
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Л.Хангай;
-Санхүү, эдийн засгийн дэд сайд Л.Энхтайван;
-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
-Гадаад хэргийн дэд сайд С.Батболд;
-Батлан хамгаалахын дэд сайд Ц.Тогоо;
-Байгаль орчны дэд сайд А.Болат;
-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Мөнх-Оргил;
-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд Д.Тэрбишдагва;
-Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл;
-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Түмэндэмбэрэл;
-Дэд бүтцийн яамны Зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Ж.Сэрээтэр;
-Авто замын газрын дарга Р.Буд;
-Авто тээврийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэ;
-Хөдөлмөр зохицуулалтын газрын дарга Д.Ганхүү;
-Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга Ц.Амгаланбаяр;
-Улаанбаатар хотын ерөнхий менежер, Нийслэлийн захирагчийн ажлын албаны дарга Т.Бадамжунай.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (195)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны хоёрдугаар сарын 27 №8 (195)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

99. Дипломат цол олгох тухай Дугаар 24 195

100. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай Дугаар 25 195

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

101. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 202 199

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 09-ний өдөр **Дугаар 24** **Улаанбаатар хот**

Дипломат цол олгох тухай

Монгол Улсын гадаад харилцааны салбарт үр бүтээлтэй ажиллаж, улс орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд оруулж ирсэн хувь нэмрийг нь үнэлж Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Лувсандоржийн Баяртад Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 25** **Улаанбаатар хот**

Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсад "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтын, ажиллах журмыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн батлуулсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 6 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд

Орлогч дарга: -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Нарийн бичгийн дарга: -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга

Гишүүд: -Дэд бүтцийн хөгжлийн сайд

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

-Санхүү, эдийн засгийн дэд сайд

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд

-Үйлдвэр, худалдааны дэд сайд

-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Төрийн хяналт шалгах хорооны ерөнхий нарийн бичгийн дарга

-Тагнуулын ерөнхий газрын дарга

-Цагдаагийн ерөнхий газрын дарга

-Хилийн цэргийг удирдах газрын дарга

-Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга

-Гаалийн ерөнхий газрын дарга

-Үндэсний татварын ерөнхий газрын дарга

-Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга

-Улсын ерөнхий прокурорын туслах бөгөөд хэрэг бүртгэлд хяналт тавих хэлтсийн дарга

-Улсын дээд шүүхийн дэргэдэх судалгааны төвийн захирал

-Монголын хүүхдийн төлөө үндэсний төвийн дарга

-Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн захирал

- Монголын ахмадын холбооны дарга

-Монголын залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга

-Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах монголын нийгэмлэгийн тэргүүн

-Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тэргүүн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлд зааснаар улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

3. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөгч, эрдэмтдийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулна.

4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралдаанд оролцож байгаа бол түүнийг хүчинтэйд тооцно.

Хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүн, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажил, Зөвлөл, түүний Ажлын албанаас хийсэн шалгалтын дүнг хэлэлцэнэ.

5. Зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гарах бөгөөд түүнд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар зөвлөмж гаргаж болно. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд хариу мэдэгдэх

үүрэгтэй.

6. Зөвлөл нь ажлын албатай байна. Ажлын албаны дүрэм, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг Зөвлөлийн дарга батална.

Ажлын албаны даргын үүргийг "Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

7. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, банкинд харилцах данстай байна.

8. Зөвлөлийн орлогч, нарийн бичгийн дарга, гишүүд нь Зөвлөлийн даргын гарын үсэг бүхий үнэмлэхтэй байна

Хоёр. Зөвлөлийн үүрэг, эрх

1. Зөвлөл нь дор дурьдсан үүрэгтэй:

1. Яам, агентлаг, төрийн бус байгууллагууд, аймаг, нийслэлийн засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон нутгийн салбар зөвлөл, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн амчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах;

2. Төрийн захиргааны болон хууль сахиулах байгуллагуудын удирдах ажилтны зөвлөлгөөнийг тодорхой хугацаанд зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх;

3. Иргэдийн амь нас, эрүүл мэнд, бусдын өмч хөрөнгөнд халдах, хулгайлах, архидан согтуурах, танхайрах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх болон авилгалын эсрэг арга хэмжээг хүчтэй болгоход бүх нийтийн хүч, анхаарлыг чиглүүлэх;

4. Дангаараа буюу шүүх, прокурорын байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний төсөл боловсруулан төр, засгийн дээд байгууллагад оруулах;

5. УИХ, Засгийн газраас батлагдан нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, тэдгээр хөтөлбөрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах, сахилга, зохион байгуулалтыг сайжруулах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан санал, хүсэлтийг судлан түүний мөрөөр асуудал боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах;

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэн, төрийн бус байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжин тэднийг энэ ажилд өргөнөөр татан оролцуулах, туслалцаа үзүүлэх;

8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар шүүх, прокурор, төрийн хянан шалгах байгууллагуудаас зохиох хамтын ажиллагааг зөвлөлийн ажилтай уялдуулан зохицуулах;

9. Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцлийн талаархи статистик мэдээг авч нэгтгэн судлах, дүгнэлт хийх;

10. Гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг судлах, арилгах, таслан зогсоох арга хэмжээний чиглэлийг тогтоох;

11. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлого, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал бэлтгэх;

12. Аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлах, чиглэл өгөх;

13. Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

14. Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас эрх хэмжээний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зөвлөлд өгсөн үүрэг, хариуцуулсан ажлыг хэрэгжүүлж, дүнг танилцуулах;

2. Зөвлөл нь дор дурдсан эрхтэй:

1. Яам, агентлаг, төрийн бус байгууллага, аймаг, нийслэлийн салбар зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулан авах;

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомж, Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийн биелэлтийг яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн харъяалал харгалзахгүйгээр шалгах, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж чиглэл өгөх;

3. Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны зардлыг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хуваарилах, зарцуулах;

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх;

5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах;

6. Эрх хэмжээний асуудлаар улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөлгөөн, семинар зохион байгуулах;

7. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангах ажилд идэвхитэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулах, шагнаж урамшуулахаар төр засгийн дээд байгууллагад уламжлах;

8. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтны талаар холбогдох байгууллагад нь албан ёсоор танилцуулж хариу авах;

9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагад өгч яаралтай нийтэлж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3. Зөвлөлийн гишүүний бүрэн эрх:

Зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/ зөвлөлийн хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

б/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийг яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцах;

в/ аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөлийн ажлыг шалган туслах;

г/ Зөвлөлийн гишүүний үүргээ биелүүлэх үедээ өмчийн хэлбэр, харъяалал харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжийн албан байранд тогтоосон журмын дагуу нэвтэрч холбогдох мэдээ, баримт, материал гаргуулан авах;

4. Зөвлөлийн даргын бүрэн эрх:

Зөвлөлийн дарга нь Зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/ зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг товлох, даргалах,

б/ зөвлөлийн Ажлын албаны дүрэм, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлаж, Албаны дарга, ажилтныг томилох, чөлөөлөх

в/ зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих

г/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын бүрэн эрх:

Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/ зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

б/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Зөвлөлийн болон Ажлын албаны хүрээнд шуурхай зохицуулж байх;

в/ аймаг, нийслэлийн Зөвлөлийг байнгын удирдлагаар хангаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

г/ Зөвлөлийн дарга, орлогч даргаас өгсөн үүрэг, хариуцуулсан ажлыг хэрэгжүүлэх.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

1. Зөвлөлийн дэргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохицуулахад зарцуулах зориулалт бүхий "Сан"-тай байна. Сангийн мөнгөн хөрөнгө нь "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн зохих хэсэг, төсвөөс баталж өгсөн хөрөнгө болон дотоод, гадаадын байгууллага, иргэдийн өгсөн хандив, төслийн хөрөнгөөс бүрдэнэ.

2. Сангийн дүрмийг Санхүү, эдийн засгийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран батална.

3. Зөвлөл нь түүний ажлын албаны үйл ажиллагааны шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах үндсэн дээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санхүүжүүлнэ.

Дөрөв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргэгт тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон нутгийн салбар зөвлөл /цаашид "Салбар зөвлөл" гэх/ зохицуулна.

2. Салбар зөвлөл нь 7-15 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

3. Салбар зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг тусгасан журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулан мөрдөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулахтай холбогдсон хууль тогтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

4. Орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, бусад үйлчилгээг тухайн Засаг даргын Тамгын газар хариуцах бөгөөд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 202 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Төлөвлөгөөнд тусгасан ажлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндэсн чиглэл, Улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт даалгасугай.

3. Улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнд тулгуурлан жижиг, дунд үйлдвэр байгуулах ажлыг төсөл сонгон шалгаруулах замаар, онолын суурь судалгаа явуулах ажлыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулагыг санхүүжүүлэх, грант олгох хэлбэрээр тус тус гүйцэтгэхийг холбогдох сайд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2000 оны 202 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙГ 2010 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны өнөөгийн байдал

Оюун ухааныхаа хүчээр нийгмийн баялгийг хэрхэн бүтээж, ашиглаж байгааг өнөөдөр аливаа улс орны хөгжил дэвшлийн илэрхийлэл гэж үзэж, шинжлэх ухаан, технологийн чадамжаар нь тухайн орны хөгжлийн түвшинг хэмждэг болжээ.

Шинжлэх ухаан, технологийн чадамж гэсэн ойлголтын дор өндөр мэргэшил бүхий эрдэмтэд, судлаачид, судалгаа, туршилтын аажлын багаж, материал, мэдээллийн хангамж, оюуны бүтээлийн сан хөмрөг, түүний ашиглалт, үр өгөөж, оюуны өмчийн баталгаажуулалт, хамгаалалт, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны эрх зүй, эдийн засгийн зохицуулалт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо зэрэг хүчин зүйлийг цогц байдлаар уялдуулан авч үзэж байна.

Дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага нь байгаль, нийгмийн шүтэлцээнд тулгуурласан, хүний өдөр тутмын өсөн нэмэгдэж буй оюуны болон эд материалын хэрэгцээг бүрэн хангах, экологийн тэнцвэрийг хадгалах, сэргээх, энерги, ресурсийг дээд зэргээр хэмнэхэд чиглэгдсэн, шинжлэх ухааны багтаамж ихтэй үйлдвэрлэл, технологийг бий болгоход оршиж байна. Иймээс ч сүүлийн 10 жилийн байдлаас үзэхэд авсаархан, хөнгөн, эрчим хүч, материалын хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн автоматжисан, компьютерийн удирдлага бүхий электроникийн технологи асар их хурдтай хөгжиж иржээ. Өндөр температурын хэт дамжуулалтын материал судлал, биотехнологи, генийн инженерчлэл, квант оптикийн зарчимд тулгуурласан электрон хэрэгслийн зохион бүтээлт гэх мэт шинжлэх ухааны чиглэл орчин үеийн судалгаа, туршилтын ажлын гол жинг татаж байна.

Иймд манай орны хувьд шинжлэх ухаан, технологийн чадамж, хөгжлийн түвшингээрээ дэлхийн улсуудын нийтлэг жишигт уялдаж, тэдгээс хэт хоцрохгүй байхын тулд дэлхий нийтийн мэдээллийн глобалчилалд хамрагдан, шинжлэх ухааны салбар дахь олон улсын хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх шаардлага аяндаа урган гарч байгаа билээ.

1998 оны байдлаар хүрээлэн, төв, корпораци зэрэг бие даасан буюу тусдаа санхүүжилт бүхий эрдэм шинжилгээний 40 байгууллагад нийтдээ 2936 хүн ажиллаж байгаагаас 2623 нь судалгаа, туршилтын үндсэн ажилд хамрагдаж байна. Манай оронд 1918 эрдэмтэн бэлтгэгдсэний дотор шинжлэх ухааны доктор 237, дэд доктор 1681 байгаа бөгөөд эрдэмтдийн 46,4 хувь буюу 890 нь эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд ажиллаж байна. Гэвч манай улсад эрдэм шинжилгээний ажилтны тоо сүүлийн 10 жилд 1,5 дахин буурч, дундаж нас 40 гарч, 30 хүртэлх насны залуу ажилтны эзлэх хувийн жин 20 хувьд хүрчээ.

Мөн оны судалгаанаас үзэхэд манай эрдэм шинжилгээний байгууллагуудад лабораторийн шинжилгээ, туршилт-үйлдвэрийн зориулалттай 1.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 2000-аад нэр төрлийн 3000 орчим тоног төхөөрөмж суурилагдсан боловч эдгээрийн 50-иад хувь нь 1950-1980 онд, 30 гаруй хувь нь 1981-1990 онд, 18 хувь нь 1991 оноос хойшхи хугацаанд тус тус ашиглалтад оржээ.

Эрдэмтэд, судлаачид явуулж буй судалгаа шинжилгээнийхээ ажлын талаар гаднаас мэдээлэл авах, гадагш мэдээлэх ажлыг өнөөгийн шаардлагын түвшинд хүргэж шуурхай бөгөөд цэгцтэй явуулах боломж төдийлэн сайн бүрдээгүй байна.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн ам

нь тарууу сийрэг манай орны хувьд бүсчилсэн хөгжлийн бодлого чухал ач холбогдолтой бөгөөд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа ч мөн үүнд уялдаж, тухайн бүс нутагтаа үйлчилж байх учиртай. Гэтэл манай эрдэм шинжилгээний байгууллагууд үндсэндээ улсынхаа нийслэл хотод төвлөрч, гагцхүү ХААИС-ийн харьяанд буюу бүтцэд байгаа, бусийн шинж чанартай 8 салбар, стаңц мал аж ахуй, газар тариалан, мал эмнэлгийн чиглэлээр судалгаа, туршилтын зарим ажил явуулж байгаа боловч улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө хүрэлцэхгүй байгаагаас болж тэдний ажлын цар хэмжээ бага, хөрөнгө, санхүүгийн чадавхи хомс байгаа болно.

Манай улсад эрдэм шинжилгээний ажлыг 1991 оноос эхлэн гэрээ, захиалгын үндсэн дээр, шинжлэх ухаан, технологийн төслийн хэлбэрээр явуулж, жилд дунджаар 3-5 жилийн хугацаа бүхий 300 гаруй төслийн хүрээнд судалгаа, туршилтын ажил гүйцэтгэж байгаа бөгөөд эвхэн сүүлийн гурван жилд буюу 1997-1999 онд дууссан ажлын хүрээнд гэхэд 80-аад технологи, 100 гаруй шинэ нэрийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж бий болгож, 900-гаад ном, товхимол, арга зүй, эвлөмж гаргасан боловч хөрөнгө хүчний хомсдол, захиалагч, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан судалгаа, туршилтын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажил үндсэндээ хийгдэхгүй, үүнд нийцсэн эдийн засгийн нөхцөл бүрдээгүй байна.

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг зах зээлийн харилцаанд нийцүүлж хөгжүүлэх, түүний чадамжийг дээшлүүлэхийн тулд төр, засгаас сүүлийн жилүүдэд нэлээд арга хэмжээ авсан болно. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас "Патентын тухай" /1993/, "Зохиогчийн эрхийн тухай" /1993/, "ШУА–ийн эрх зүйн байдлын тухай" /1996/, "Шинжлэх ухаан, технологийн тухай" /1998/ , "Технологи дамжуулах тухай" /1998/ хуулиуд болон Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлан гаргасан юм.

Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, технологийн түвшинд үнэлгээ өгөх, технологи дамжуулах, эрдэм шинжилгээний байгууллага байгуулж буртгүүлэх, тэдгээрийн шинжлэх ухаан, технологийн чадавхийг үнэлэх, эрдэм шинжилгээний ажлыг тайлагнах, шинжлэх ухааны докторын зэрэг олгох гэх мэт харилцааг зохицуулсан нэлээд хэдэн журам, дүрэм, зааврыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас гарган мөрдүүлж байна.

Түүнчлэн боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдлийг хангах асуудал тус орны өөрчлөлт шинэчлэлтийн хүрээнд томоохон байр суурийг эзэлж байгаа юм. Тухайлбал, 1995 онд шинэчлэн батална "Боловсролын тухай", "Дээд боловсролын тухай" хуулиудад шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлж боловсролын зорилгыг хэрэгжүүлэх, суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологийн тодорхой чиглэлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд дээд боловсролын агуулгыг чиглүүлэх, дээд боловсролыг дипломын, бакалаврын, магистрын, доктор(Ph.D)-ын зэрэглэлтэй болгож, докторын зэргийг их сургууль олгож байх, сургалт, судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний цогц үйл ажиллагаа бүхий дээд боловсролын байгууллагыг нэгдэл хэлбэрээр байгуулах, дээд боловсролын байгууллага нь эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх эрхийг хэрэгжүүлэх зэрэг заалтууд тусгагдсанаас гадна Засгийн газрын 1997 оны 31 дүгээр тогтоолоор эрдэм шинжилгээний 70 гаруй байгууллагыг 22 хүрээлэн, төв болгож өөрчлөхдөө тэдгээрийн тэн хагасыг их сургуулиудын харьяалалд оруулсан болно.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны хууль зүйн орчин бүрдүүлэх, менежментийг боловсронгуй болгох талаар ийнхүү зарим эхлэл байгаа боловч эдийн засгийн баталгаа, санхүү, урамшуулын хөшүүрэг бий болгох, үүнтэй холбогдсон

харилцааг зохицуулах асуудал үндсэндээ шийдэгдээгүй байгаа юм.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

1. Монгол Улсын Их Хурлын 1998 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого"-д уг бодлогын зорилгыг тодорхойлохдоо "экспортод чиглэсэн зах зээлийн эдийн засагтай, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах, улмаар түүний тогтвортой хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болохуйц түвшинд хүртэл нь шинжлэх ухаан, технологийн чадавхийг хөгжүүлэхэд оршино" гэж заасан.

2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Нэг"-ийн 4-т "Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг дээшлүүлэн хөгжлийн харьцангуй шинэ давуу тал олж авах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэмтэд, судлаачдын бүтээлийн үнэлэмжийг өсгөх зорилтыг хэрэжүүлнэ" гэж тусгагдсан.

3. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны өнөөгийн байдлаас үзэхэд шинжлэх ухааны салбарын зах зээлийн харилцааг гүнзгийрүүлэх, бүтцийг боловсронгуй болгож хавсарга судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл рүү чиглүүлэх, улмаар уг салбарт өөрийгөө санхүүжүүлэх үйл ажиллагааны тогтолцоог бий болгож төлөвшүүлэх шаардлага гарч байна.

Иймд Монголын шинжлэх ухаан, технологийн өнөөгийн байдлыг харгалзан, шинжлэх ухааны талаархи төр, засгийн бодлого, зорилтыг хэрэжүүлэх үүднээс "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)"-ийг дэвшүүлэн тавьж байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

1. Байгалийн эрдэс баялаг, амьтан, ургамлын гаралтай түүхий эдийн арвин их нөөц, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах өргөн уудам газар нутаг, хүн амын боловсролын харьцангуй өндөр түвшин зэрэг үндэсний давуу талуудад тулгуурлан, ардын уламжлалт арга, шинжлэх ухааны орчин үеийн ололтод түшиглэсэн үндэсний дэвшилт технологи, шинэ бүтээгдэхүүн бий болгох, гадаад орны тэргүүний технологийг эх орны байгаль, эдийн засгийн нөхцөлд тохируулж үр өгөөж сайтай ашиглах замаар экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулахад чиглэгдсэн үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд оюуны хүчийг дайчилж хөгжлийн харьцангуй шинэ давуу тал олж авах.

2. Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааг зохистойгоор хослуулах, өөрийнхөө хөрөнгө хүчээр шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг явуулж чадахуйц бүтцийг бий болгож хөгжүүлэхийн зэрэгцээгээр иргэдийн танин мэдэхүй, амьдрах ухааныг дээшлүүлэх, дэлхийн шинжлэх ухааны мэдлэгийн хүрсэн түвшинг ахиулахад онолын суурь судалгааны ажлыг чиглүүлэх.

3. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийг 2010 он гэхэд улс орны эдийн засгийг тогтворжуулан сэргээх, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн түүний экспортын баримжаат төлөвшүүлэхэд нөлөөлж чадахуйц түвшинд хүргэх.

Дөрөв. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх судалгаа, туршилтын ажлыг дараахь тэргүүлэх чиглэлд голлон төвлөрүүлж явуулна. Үүнд:

- монгол орны амьтан, ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн нөөц баялаг;
- ардын уламжлалт болон үндэсний дэвшилт технологи;
- биотехнологи;
- химийн технологи;

- электроник, мэдээллийн технологи;
- шинэ материал, машин үйлдвэрлэлийн технологи;
- эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр ашиглах технологи;
- монгол хүний хөгжил, шинжлэх ухааны боловсрол;
- онолын суурь судалгаа.

Тав. Хөтөлбөрийн үндсэн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл бүрийн хүрээнд дараахь үндсэн зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- "Монгол орны амьтан, ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн нөөц баялаг" чиглэлээр:

-манай орны амьтан, ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн байршил, нөөц, үнэлгээ, экологийн онцлог, хөдлөл зүйг тодорхойлох, түүнийг зохистой ашиглах арга, хэлбэр, боловсруулах чиглэл, байгаль хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах, сэргээх үндэслэлийг тогтоох;

-түүхий эдийн нөөцөд тулгуурлан бүс нутгийг хөгжүүлэх стратегийн үндэслэл болон нөөцийг олборлох, ашиглах, нөхөн сэргээх, арвижуулах арга замыг тодорхойлох.

- "Ардын уламжлалт болон үндэсний дэвшилт технологи" чиглэлээр:

-мал, ургамлын гаралтай түүхий эд боловсруулан хүнс, ахуйн зориулалттай бүтээгдэхүүн хийж байсан ардын уламжлалт аргад шинжлэх ухааны үнэлэлт, дүгнэлт өгч, түүнийг баталгаажуулах, сэргээх дэлгэрүүлэх, шинжлэх ухаан, техникийн орчин үеийн ололттой хослуулан үндэсний дэвшилт технологи бий болгож үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

-гадаад орны тэргүүний технологи, техник хэрэгсэл, ноу-хауг авч ашиглахаас гадна тэдгээрийг эх орны байгаль, эдийн засгийн нөхцөлд тохируулан нутагшуулах замаар үндэсний технологи болгож ээлжлэн;

-ноос, ноолуур, арьс, шир зэрэг стратегийн ач холбогдол бүхий уламжлалт түүхий эдийг дотооддоо гүн боловсруулж дэлхийн түвшинд хүрсэн үндэсний технологиор экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох.

- "Биотехнологи" чиглэлээр:

-мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эдийг ферментаци, биохими, эсийн болон генийн инженерчлэлийн зэрэг аргаар боловсруулж хүн, мал эмнэлгийн зориулалттай эм, биобэлдмэл, хүнс, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох, импортыг орлуулах;

-эсийн болон генийн инженерчлэлийн аргаар өндөр ашиг шимтэй мал, амьтан, таримал ургамал гарган авч, өсгөж үржүүлэх;

-бичил биетнийг өсгөвөрлөх замаар уураг, амин дэмийн агууламж ихтэй бактер, ферментийн бэлдмэл бий болгон хөнгөн, хүнсний үйлдвэрлэлд ашиглах;

-автоматжисан горимын уян технологи бүхий дэлхийн стандартын жижиг үйлдвэр (Pilot Plant) байгуулан эх орны түүхий эдэд тулгуурласан эм, биобэлдмэл үйлдвэрлэж гадаад зах зээлд шууд гарахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологийн чадавхи, олон улсын эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх.

- "Химийн технологи" чиглэлээр:

-нефть, нүүрс, эрдэс чулуулгийн үнэлгээ боловсруулалт бүхий бүтээгдэхүүн, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай шинэ бодис бий болгож үйлдвэрлэх.

- "Электроник, мэдээллийн технологи" чиглэлээр:

-эрчим хүчний удирдлага, хяналтын электрон техник, мэдээллийн электрон

хэрэгсэл, сансрын холбоог ашиглах багаж төхөөрөмж зэргийг зохион бүтээж нэвтрүүлэх;

-шинжлэх ухаан, боловсролын мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан байгуулах, мэдээллийн технологийг боловсронгуй болгож олон улсын нийтлэг жишигт хүргэх, эрдэм шинжилгээний бүх байгууллагыг интернетийн сүлжээнд хамруулах;

-ном дамжуулах компьютерийн систем бүхий эрдэм шинжилгээний зориулалттай төвлөрсөн номын сан (Digitel Library), квант оптикийн зарчмаар ажилладаг супер компьютерийн төв байгуулах.

· "Шинэ материал, машин үйлдвэрлэлийн технологи" чиглэлээр:

-үнэт, өнгөт, холимог, ховор металл, жонш, газрын ховор элементийн хүдрийг баяжуулах, цэвэршүүлэх;

-электроникийн болон цахилгаан техникийн зориулалттай керамик, оптикийн чиглэлийн шинэ материал гаргаж үйлдвэрлэх;

-металл эдлэл, машины эд анги, хялбар хийц, хөдөө аж ахуйн техникийн сэлбэг хэрэгсэл, механикжуулалтын тоног төхөөрөмж зохион бүтээж үйлдвэрлэх, бага оврын трактор үгсрах, улмаар үйлдвэрлэх.

· "Эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр ашиглах технологи" чиглэлээр:

-нар, салхи, ус, биохий зэрэг эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэрийн нөөцийг бүсчилэн судалж, тухайн газар орны байгаль, экологийн нөхцөлд тохирсон техник, тоног төхөөрөмж зохион бүтээж үйлдвэрлэх замаар төв, орон нутгийн жижиг хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангах.

· "Монгол хүний хөгжил, шинжлэх ухааны боловсрол" чиглэлээр:

-монгол хүний геном, түүний онцлог, монголчуудын боловсрол, хүмүүжлийн түүхэн уламжлал, оюун ухаан, авъяас билэг, хүмүүнлэг сэтгэлгээний төлөвшил, биологи-экологийн уялдаа шүтэлцээг судласны үндсэн дээр монгол оронд эрүүл чийрэг бие бялдартай, оюуны өндөр чадавхитай, авъяас төгөлдөр иргэнийг үв тэгш хөгжүүлэх хүчин зүйлүүдийг тодорхойлох;

-байгаль, үзэгдэл, юмсын зүй тогтолд тулгуурласан монгол хүний танин мэдэхүйн сэтгэлгээний уламжлалыг сэргээн хүүхэд ахуйгаас нь төлөвшүүлж хөгжүүлэх, манай иргэдэд шинжлэх ухааны цэгцтэй мэдлэг олгох үйл ажиллагааны арга, хэлбэрийг амьдралын зорилго, сонирхол, нас, хүйс, орчны онцлогт нь нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэл сайтай тогтоох;

-шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгох, оюутан, сурагчдын дундаас тодорхой үе шатанд нь сонголт хийж шавь сургалт явуулах, бусад дэвшилт арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар дотоод, гадаадын нэр цуутай эрдэмтдийн халаа залгамжийг бэлтгэх асуудлын онол, арга зүйн үндсийг бүрдүүлэх, уг асуудлыг хэрэгжүүлэх.

· "Онолын суурь судалгаа" чиглэлээр:

-иргэдийн танин мэдэхүй, мэдлэгийн түвшин, амьдрах ухааныг хөгжүүлэхэд суурь судалгааны үүргийг дээшлүүлэх;

-үзэгдэл, юмсын зүй тогтол буюу жам ёсыг илрүүлж тогтоох, шинэ онол, мэдлэгийг бий болгох;

-тухайн шинжлэх ухааны болон судлагдахууны онолын өмнө тулгарч байгаа зарчмын шинж чанартай асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж, мэдлэгийн хүрсэн түвшинг ахиулах.

Зургаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээний чиглэл

Хөтөлбөрийн зорилго, үндсэн

зорилтуудыг хангахад чиглэгдсэн нийтлэг шинж чанартай дор дурдсан чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

А. Шинжлэх ухаан, технологийн чадамж, удирдлагын тогтолцоо

-шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, хөрөнгө, хүчийг хөтөлберийн тэргүүлэх чиглэлүүдээр явуулах судалгаа, туршилтын ажилд голлож төвлөрүүлэх (Судалгаа, боловсруулалтын ажлын цаашдын чиглэлийг нэгдүгээр, магистрант, докторантурт суралцуулах замаар шинжлэх ухааны салбарт шинээр бэлтгэх боловсон хүчний жагсаалтыг хоёрдугаар, шинээр байгуулах, өргөтгөх дундын ашиглалт бүхий лаборатори, төвийн жагсаалтыг гуравдугаар хавсралтад тус тус жишиг болгож үзүүлэв);

-хавсарга судалгааг гэрээ захиалгын дагуу явуулж нийгмийн эрэлт хэрэгцээг ханган үр дүн гаргах, түүнд тулгуурлан үндэсний жижиг, дунд үйлдвэр байгуулж хөгжүүлэх замаар шинжлэх ухааны салбарт технопарк, технополисын бүтцийг бий болгох (Судалгаа, туршилтын ажлын үр дүнд тулгуурлаж байгуулах жижиг, дунд үйлдвэрийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтад жишиг болгож үзүүлэв);

-шинжлэх ухаан, үйлдвэрийн байгуулагуудын хооронд мэдээллээр зуучилдаг, тэдэнд хууль эрх, эдийн засаг, менежментийн талаар зөвлөлгөө өгдөг, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр санхүү, эдийн засгийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг, сургалт явуулдаг байгууллага бий болгох, түүний үйл ажиллагааг төрөөс дэмжих арга замыг тодорхойлох;

-томоохон үйлдвэр, аж ахуйн газрууд өөртөө хэрэгтэй судалгаа, туршилтын ажлыг өөрийнхөө хөрөнгө хүчээр явуулж байж чадахуйц салбар дундын шинж чанартай шинэлэг бүтцийг бий болгож хөгжүүлэхэд чиглэгдсэн эрх зүй, эдийн засаг, урамшууллын тогтолцоо бий болгох;

-хавсарга судалгаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагыг лаборатори, туршилтын баазыг нь бэхжүүлэх замаар зохих хэмжээний үйлдвэрлэл явуулж орлого, ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар өөрийгөө санхүүжүүлэх чадавхитай болгох;

-улсын захиалгаар буюу Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг бизнесийн хүрээнийхэнд сурталчлах, технологи дамжуулах хэлбэрээр үйлдвэрлэгчдэд борлуулах, гэрээгээр шилжүүлэх, жижиг, дунд үйлдвэр байгуулах ажлыг төсөл захиалагч яамд болон Шинжлэх ухаан, технологийн сан зохих хууль тогтоомжийн дагуу гардан зохион байгуулдаг байх;

-шинжлэх ухааны боловсон хүчнийг гадаад, дотоодод бэлтгэх, дадлагажуулах ажлыг өргөжүүлэх, шинжлэх ухааны боловсрол эзэмшүүлэх шинэлэг арга хэлбэрүүдийг бий болгож нэвтрүүлэх, шинжлэх ухааны салбарт ажиллагч эрдмийн зэрэгтэй боловсон хүчний тоог 2005 онд 2600, 2010 онд 3000-аас доошгүйд хүргэх;

-эрдэм шинжилгээний ажилтны статусыг хуульчилж тодорхойлох, оюуны үнэлэмжийг дээшлүүлэх, эрдэмтдийн эдийн засаг, төр, бизнесийн үйл ажиллагаан дахь оролцоог өргөтгөх, эрдэмтэд, судлаачдын нийгмийн хамгааллыг сайжруулж, тэдний цалин хөлсний өсөлтийг тогтвортой хангах;

-улс орныг бүсчилж хөгжүүлэх үзэл баримтлалд уялдуулан шинжлэх ухаан, технологийг бүс нутагт хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, одоогийн бааз болон орон нутгийн хүч хөрөнгөд тулгуурлаж бүс нутгийн мэдлийн судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн цогцолборууд байгуулах, тэдгээрийг бүс нутгийн захиалга, санхүүжилтээр ажиллуулах, улмаар өөрийгөө санхүүжүүлдэг болгох, бүс нутагт

судалгаа, туршилтын ажлын үр дүнг нэвтрүүлэхэд зориулсан аймаг, хот дундын болон бүс хоорондын сан байгуулах;

-шинжлэх ухааны салбарт хувьчлал явуулах боломж, онцлог нөхцөлийг судалж, хувьчлах арга хэлбэр, тавих шаардлага, болзлыг тогтоох, уг үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, хувьчиллыг хэрэгжүүлэх;

-хувийн хэвшлийн салбарт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх сонирхол төрүүлэхүйц эдийн засаг, урамшууллын хөшүүрэг бий болгох замаар уг үйл ажиллагааг төрөөс дэмжих;

-судалгаа, сургалт, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны зохистой хослол бий болгох зорилгоор энэ чиглэлийн байгууллагуудыг зуучилж холбохоос гадна тэднийг хамтын гэрээ, тохиролцооны үндсэн дээр ажиллуулах, сонирхогч байгууллагуудын баазад тулгуурласан цогцолбор бий болгох, иймэрцогц үйл ажиллагаатай нэгжийг шинээр байгуулах.

Б. Шинжлэх ухааны салбарын зах зээлийн харилцаа, санхүүжилт

-шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг явуулахдаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэхийн зэрэгцээгээр төрийн зохицуулалт, дэмжлэг болон эрэлт-нийлүүлэлт, шударга өрсөлдөөний зарчимд тулгуурлах;

-үйлдвэр, аж ахуйн нэгжийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг татварын ялгавартай тарифаар дэмжих;

-шинжлэх ухааны үр дүн, ололт, дэвшилт технологи нэвтрүүлэх ажлыг дэмжих, урамшуулах чиглэлээр банк-зээлийн тогтолцоо бий болгож хөгжүүлэх;

-судалгаа, туршилтын зориулалтаар явуулсан банк-санхүүгийн үйл ажиллагааны орлогын тодорхой хувийг шинжлэх ухааны салбарын санхүүжилтэд зарцуулах;

-гадаадаас оруулж байгаа техник, тоног төхөөрөмжид дэвшилт технологийн шаардлагыг хангуулах, технологийн хамгаалалт, гаалийн хяналтыг сайжруулах, гадаадаас үйлдвэрлэл, техник, технологи оруулах төсөл, тооцооны хянан магадлагаанд эрдэмтдийн оролцоог өргөтгөх;

-технологийн түвшинг тодорхойлох замаар технологи дамжуулах үйл ажиллагаанд хяналт, зохицуулалт хийж байх үнэлгээ-мониторингийн алба байгуулж ажиллуулах;

-шинжлэх ухааны салбарын урсгал зардалд зориулж улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5-аас багагүй хувьд хүргэх зорилтыг дэс дараатай хэрэгжүүлэх, тухайлбал энэхүү харьцааг 2002-2005 онд 0.6-1.5, 2006-2010 онд 1.6-2.0 хувь болгох;

-шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтыг тухайн жилийн шаардлагад нийцүүлж уг салбарын урсгал зардалд зориулсан улсын төсвийн хөрөнгийн 15-30 хувьд хүргэх.

-хандив, тусламж, зээл, өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг төсвийн бус эх үүсвэрийн хөрөнгө хуримтлуулах ажлыг Шинжлэх ухаан, технологийн сангаас улсын хэмжээнд жил бүр уялдуулан зохицуулж, уг хөрөнгийн нийт хэмжээг шинжлэх ухааны салбарын тухайн жилийн урсгал зардалд зориулсан улсын төсвийн хөрөнгийн 20-иос багагүй хувьд хүргэхээр зохион байгуулж байх;

-бүс нутагт явуулах шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг орон нутгийн төсөв хөрөнгөөр санхүүжүүлдэг эдийн засаг, санхүүгийн тогтолцоог бий болгох;

-шинжлэх ухаан, технологийн хөгжилд зориулж хандив, тусламж үзүүлсэн дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд,

импортоор нийлүүлэх эрдэм шинжилгээний ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодис, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа, туршилтын зориулалттай мал, газар зэргийг холбогдох татвар, төлбөрөөс чөлөөлүүлэх, хөнгөлүүлэх, оюуны бүтээлийг үнэлэх, борлуулах, үр өгөөжийг нь тооцож урамшуулах, зохиогч, патент эзэмшигчийн эрхийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

-төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудын туршилтын үйлдвэрлэлээс олсон орлогыг тухайн байгууллагад төсвийн бус орлогын хэлбэрээр үлдээж байх;

В. Шинжлэх ухааны мэдээлэл хангамж

-шинжлэх ухаан, технологи, боловсролын мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан байгуулах, шинжлэх ухаан, боловсролын салбарын дотоод, гадаад мэдээллийг боловсруулах, дамжуулах, ашиглах, түгээх үйл ажиллагааны технологийг боловсронгуй болгөөд шуурхай болгон сайжруулж олон улсын нийтлэг жишигт хүргэх;

-шинжлэх ухааны академийн хэмжээнд эрдмийн мэдээллийн сүлжээ, сан, эрдэм шинжилгээний супер компьютерийн төв байгуулах, эрдэм шинжилгээний бүх байгууллагыг интернетийн локаль сүлжээнд хамруулах;

-эрдэм шинжилгээний төв номын санг байгуулж, гадаадаас ном, сэтгүүл, тайлан, бусад эх материалыг ном дамжуулах компьютерийн үйлчилгээ, факс, микрозөөгчөөр захиалан авдаг үйлчилгээтэй болох;

-эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллагыг тойм, лавламж, тоо баримтат мэдээллээр үйлчлэх төрөлжсөн үйлчилгээг бий болгох;

-батлан хамгаалах салбарт явуулах судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлж, ашуулгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх.

Г. Гадаад хамтын ажиллагаа

-Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд гадаад орон, олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа авах, гадаад хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж өргөжүүлэх зорилгоор энэ чиглэлийн цогц үйл ажиллагааг хамруулсан мастер төлөвлөгөөг хөгжилтэй орны экспертүүдтэй хамтран олон улсын эрх зүйн хэм хэжээнд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх, уг асуудлыг хандивлагч орнууд, олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

-Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас үзүүлэх зээл, хандив, тусламжийн хөрөнгөөр судалгаа, туршилтын ажлын үр дүнд тулгуурласан жижиг, дунд үйлдвэр, гадаадтай хамтарсан болон байгууллага дундын ашиглалт бүхий лабораторийг, төв байгуулах асуудлыг тухай бүр үндэслэл, тооцоо сайтай тавьж шийдвэрлүүлж байх;

-олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтарч судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, олон улсын шилдэг /экселент/ лабораторийг, төв, ажиглалтын станц зэргийг хамтран байгуулж ажиллуулах буюу тэдний үйл ажиллагаанд өргөн оролцох, гаднын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

-олон улсын академи хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, түүний агуулга, төрлийг гүнзгийрүүлэх;

-эрдэмтэд, судлаачдыг гадаад орон, олон улсын байгууллагын шугамаар зохиож байгаа хурал, семинар, уулзалтад оролцуулах, мэргэжилтэн солилцох, түр болон удаан хугацааны томилолтоор гадаадад ажиллуулахад зориулсан зардлыг нэмэгдүүлж, байгууллагын төсвийн 8-10 хувьд хүргэх.

Долоо. Хөтөлбөрийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

Хөтөлбөрийг дор дурдсан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:

1. шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтэд зориулан батлагдсан улсын төсвийн хөрөнгө;

2. шинжлэх ухаан, технологийн салбарын хөрөнгө оруулалтын зардал;

3. төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага буюу Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг борлуулсны орлого, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашигласны эхний 3 жилийн дундаж үр ашгийн 15 хүртэлх хувь;

4. орон нутгийн төсөв;

5. дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зориулан олгосон хөрөнгө, хандив, тусламж;

6. Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны орлого.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, арга хэлбэр

1. Хөтөлбөрийг 2001-2010 онд хэрэгжүүлнэ.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаа, хөрөнгө санхүү-гийн хувьд 2001-2005, 2006-2010 он гэсэн хоёр үе шаттайгаар дүгнэж авч үзнэ.

3. Салбар дундын шинж чанартай буюу эрх зүй, эдийн засаг, менежментийн ерөнхий зохицуулалт хийх шаардлага бүхий нийтлэг арга хэмжээг Засгийн газрын төлөвлөгөөгөөр, шинжлэх ухаан, технологийн салбарын хэмжээнд гүйцэтгэх, цаг хугацаа, хөрөнгө зардлын хувьд нарийвчилж тооцсон ажлуудыг ямны төлөвлөгөөгөөр тус тус зохион байгуулж хэрэгжүүлнэ.

4. Засгийн газрын төлөвлөгөөг хөтөлбөрийн хамт Засгийн газар батална.

5. Ямны төлөвлөгөөг хөтөлбөр батлагдсаны дараагаар түүнд уялдуулж эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдэл зэрэг байгууллагын түвшинд нарийвчлан боловсруулж нэгтгэсэд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батална.

6. Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч хөтөлбөр болон тухайн шатны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал уг асуудлыг Засгийн газар болон Засгийн газрын эрх бүхий гишүүн шийдвэрлэнэ.

Ес. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүнгийн үндсэн шалгуур нь Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн түвшний дараахь үзүүлэлтүүд байна. Үүнд:

-хүний нөөцийн чадавхи, сорилт, туршилт, үйлдвэрлэлийн бааз, мэдээллийн хангамж, нийт зардал зэрэг шинжлэх ухаан, технологийн чадавхийн өсөлт;

-шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд зарцуулж байгаа хөрөнгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь;

-шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлснээс олсон үр ашгийн өсөлт;

-хөтөлбөрийн үндсэн зорилтуудын хүрээнд гүйцэтгэсэн нийт ажлын цар хэмжээ, эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн ач холбогдол.

СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Физик, математик, химийн салбарт

Физик:

- хатуу бие, хагас дамжуулагч материал, түүхий эдийн физик шинж чанар, технологи;
- биополимерийн бүтэц, физик шинж чанар, харилцан үйлчлэл, өвөрмөц шинж чанартай микро ба нанометрийн хэмжээтэй агрегат төлөв, онцлог чанар;
- цөмийн физикийн онол, бодисын бүтэц, найрлага, цөмийн цацраг, хэт ягаан туяаны тархалт, үйлчлэл, байгаль орчны бохирдлыг тодорхойлох цөм, атом, молекулын спектроскопийн аргууд;
- физик электроник, радиофизикийн судалгаа;
- физикийн шугаман бус үзэгдлийн онол;
- дэлхийн байнгын соронзон орон, орчны цахилгаан соронзон төлөвүүдийн зүй тогтол онцлог;
- монгол нутагт тохиолдсон газар хөдлөлтийн мэдээллийг ашиглан дэлхийн царцдасын дотоод бүтцийг нарийвчлан тогтоох судалгаа;
- дэлхийн өргөрөг, уртрагийн өөрчлөлт, наран дээр явагдах физик үзэгдэл, нар-дэлхийн холбоо;
- мэдээлэл, түүнийг алсад дамжуулахад сансрын техникийг ашиглах судалгаа.
- агаар мандлын тунгалаг чанар, нарны цацрагийн спектр бүтэц, агаар мандалд гэрэл зөөгдөх процесс;
- дэлхийн байнгын соронзон орон, орчны цахилгаан соронзон төлөвүүдийн зүй тогтол;
- сейсмотектоник, соронзон хувьсал, гүний радиоидэвхт бодис зэрэг хүчин зүйлийн цогцолбор судалгаагаар газар хөдлөлтийг прогнозлох арга;
- монгол нутгийн сейсмомужлалын зураг болон зарим томоохон хот, суурин газрын микросейсмийн мужлал;
- сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр (нар, салхи, ус г.м)-ийг ашиглах техник, технологи;
- дулааны эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох техник, технологи;
- ган, ширэм үйлдвэрлэх ардын аргад тулгуурласан орчин үеийн технологи;
- электронжуулалт, автоматжуулалтын техник, технологи;
- машин, механизмын эд ангийг хатууруулах, элэгдлийг сэргээх плазмын технологи;
- хөнгөн, электроник, машины үйлдвэрийн салбарын лазерын технологи;
- электролизын аргаар төрөл бүрийн материалд алт, мөнгөн хучилт хийх технологи;
- уламжлалт технологийг гүнзгийрүүлэн судалж ган, ширэм үйлдвэрлэх ардын технологитой хосолсон орчин үеийн технологи;

Математик:

- алгебрийн цагирагийн цогцос, бүтцийн онол, санамсаргүй процесс бүлэг болон Ли алгебрийн асуудал, операторын онол, шугаман операторын спектрийн судалгаа;
- дифференциал тэгшитгэлийн шийд болон хувийн утгыг өндөр нарийвчлалтай ойролцоо бодох тоон арга;
- их хэмжээст тооцоолох бодлогуудыг бодох математик арга, загвар, алгоритм;
- шугаман бус динамик системийн математик загвар, тоон туршилт явуулах арга зүй.
- мэдээлэл боловсруулах математик программын сан;
- мэдээллийн технологийн математик загвар, алгоритм, программын сан;
- богино, дунд, урт хугацааны прогноз зохиох математик загвар, алгоритм;
- тодорхой асуудал баримжаалсан математик загваруудын хэрэглээний программын сан;
- тогтвортой хөгжлийг хангахад хүрээлэн буй орчны үнэлгээнд математик статистик, магадлалын онол, математик загварчлал, бусад арга;
- тодорхой чиглэлүүдээрх математик загварын хэрэглээний программын сан;

шинжлэх ухаан, боловсролын мэдээллийн технологи (супер компьютер)-ийн төв.

Хими:

нефтийн физик-хими технологи, нефть-химийн синтезийн судалгаа;
үнэт, ховор металлын түүхий эдийг гүн боловсруулах хими-технологийн судалгаа;
эрдэс, биологийн гаралтай шинэ болон өөгдсөн шинж чанар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх хими-технологи;
биологийн идэвхт шинэ нэгдлүүдийн молекулын бүтэц, байгууламж;
монгол орны биологийн гаралтай түүхий эдийн найрлага, нөөцийн судалгаа;
полимерийн химийн судалгаа;
нүүрс, занарын бодисын найрлага, бүтэц, задралын бүтээгдэхүүний хими-технологи;
байгаль орчны хими-технологи;
эмчилгээ, оношилгоо, спортын анагаах ухаанд биохимийн аргыг хэрэглэх үндэслэл;
үйлдвэрийн биологийн гаралтай хаягдлаар материал үйлдвэрлэх хими технологи;
фосфорын болон азот, фосфорын холимог бордоо үйлдвэрлэх технологи;
ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн (цэвэрлэх, тослох, угаах, дүүргэх, гоо сайхны г.м) -ий үйлдвэрлэлийн технологи;
ургамал, амьтан, эрдсийн гаралтай төрөл бүрийн эм бэлтгэх технологи;
силикат материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи;
полимер, нийлэг материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи;
химийн биоидэвхжүүлэгч, хүнсний ингредиент, эмнэлгийн бэлдмэл, наах, цардас, тослох материал, цаас, целлюлоз, будаг, пигмент үйлдвэрлэх технологи;
биологийн идэвхт бодис гаргах, эм, биобэлдмэл үйлдвэрлэх мембраны технологи;
өндөр цэвэршилттэй металл, нэгдлийг биоуусгалт, хандлалт, шингээлт зэрэг экологийн цэвэр технологиор гарган авах шинэ технологи.

Геологи, газар зүй, экологийн салбарт

Геологи:

монгол орны хэмжээн дэх дэлхийн царцдасын үүсэл, хөгжлийн геодинамик загвар;
монгол орны давхаргазүй, магматизм, тектоникийн судалгааг гүнзгийрүүлж, тулгуур зүсэлтүүд ба эталон объектуудыг дэвшүүлэх;
монгол орны хэмжээнд нээгдсэн төрөл бүрийн ашигт малтмалын орд, илрэлүүдийн тархалт, байршлын зүй тогтлыг нарийвчлан судалж ихээхэн нөөц бүхий далд ордуудыг илрүүлэх прогноз;
Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологи, тектоник, ашигт малтмал, геоэкологийн болон металлогенийн төрөлжсөн зургууд;
геологийн төрөл бүрийн зургийг тоон хэлбэрт шилжүүлэн боловсруулах;
геологийн суурь судалгааны чиглэлүүдээрх төрөлжсөн мэдээллийн сан;
эрдэс, чулуулгийн бүрэлдэхүүн, бүтэц, найрлагыг судлах дэвшилт техник, технологи.

Газарзүй, геоэкологи:

хөрсний үйл явц, горимын биоэнергетикийн судалгаа;
улсын астрономи, геодезийн сүлжээг GPS-ийн технологиор сайжруулах, улсын нивелирийн I ангийн сүлжээ байгуулах, геодезийн тоон зураглалын технологи;
уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн прогнозын загвар;
уур амьсгалаас хамаарч экологи, нийгэм, эдийн засгийн салбарт гарч болох өөрчлөлтийн загварчлал;
озон, нарны хэт ягаан туяаны байгуулын хяналт, хүний эрүүл мэнд, экотоголцоонд тэдгээрийн үзүүлэх нөлөөллийн судалгаа;
газрын элэгдэл, эвдрэл, доройтолд нөлөөлж буй байгалийн болон хүний хүчин зүйлийн судалгаа, газрыг хамгаалах, сэргээн сайжруулах арга технологи;
байгаль орчин, түүний хэвлийг нөхөн сэргээх технологи;
ган, цөлжилтийн хурдац, орчны өөрчлөлтийн хяналт-шинжилгээ;
гол мөрний сав нутгийн экотоголцоо, усны эхийг хамгаалах, бэлчээр намагших, гол горхи ширгэхээс сэргийлэх, цэнгэг усны нөөцийг тогтоох, хамгаалах, нэмэгдүүлэх;

- ашигт малтмал, газрын тос, байгалийн хийг олборлох, боловсруулах;
- үйлдвэрлэлийн үйл ажиллагаан дахь технологийн хяналт, норм, стандарт;
- тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн судалгаа.
- монгол орны газарзүйн мэдээллийн систем /ГМС/;
- ландшафтын геохимийн мэдээллийн нэгдсэн сан;
- агаар, ус, хөрсөнд бохирдуулах бодис тархах явцын математик загвар;
- бохирдуулах бодис, түүний дотор цацраг идэвхт тоос алс зайд, улс дамжин тархах явцыг шуурхай прогнозлох, хүчиллэг тундасны эх үүсвэрийн улсын хэмжээний тооллого явуулж Дорнод Азийн хүчиллэг тундасны тооцооны төсөлд оролцох;
- хур тундасны прогнозын чанарыг сайжруулах үндсэн дээр уруйн болон голын үерийн прогнозын математик загвар;
- бүс нутагт хөргөлтийн зоорь барих технологи;
- геодезийн үйлдвэрлэлийн тоон зураглалын технологи;

Палеонтологи:

- эртний шим ертөнцийн орон зай-цаг хугацааны тархалт, түүхэн хөгжлийн зүй тогтол, тив хоорондын харьцуулалт;
- монгол орны фанерозойн үе шатны чулуулгийн геологийн харьцангуй нас тогтоолт, олон улсын харьцуулалт, палеонтологийн үндэслэл;
- эртний газарзүйн орчин, экологи, олдворт газрыг хамгаалах арга, зарчим;
- эртний амьтан, ургамлын суурь цуглуулгын баяжуулалт;
- эртний амьтан, ургамлын олдворыг боловсруулах, сэргээн засварлах технологи;
- эталон цуглуулгын бүртгэл, судалгааг олон улсын нэгдсэн сүлжээнд хамруулах;
- эртний амьтан, ургамлын олдворыг боловсруулах сэргээн засварлах, хэв хийж олшруулах лабораторин.

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарт

Монголын түүх, монгол судлал:

- монголын археологи, угсаатны зүй, монголчуудын угсаа гарал;
- монголчуудын угсаа гарал;
- нэн эртний ба эрт, дундад зууны түүх;
- XX зууны монголын түүх;
- монголын гадаад харилцааны түүх, уламжлал, геополитик;
- олон улс судлал, өмнөд, хойд хөрш ба түүнш орнуудын харилцаа, бодлого;
- нийгэм, хүний танин мэдэхүйн тулгуур мэдлэг, иргэншил, хүмүүнлэгийн ухааны судалгаан;
- монгол улсын хөгжлийн үзэл баримтлал;
- глобалчлалын нөхцөл дэх монголын соёл, иргэншлийн загвар;
- монголын археологийн олдвор, хэрэглэгдэхүүнийг хадгалах, хамгаалах, судлах орчныг бүрдүүлсэн лаборатори;
- монголын түүх, гүн ухаан, соёл, шинжлэх ухаан, шашны сурвалж судлалын мэдээллийн сан;
- Монгол Улсын хөгжлийн түүхэн замнал, цаашдын үзэл баримтлал;
- монгол иргэншил, боловсрол, шинжлэх ухаан, урлаг, соёлын хөгжлийн харьцуулалт;
- монголын аман зохиолын чуулган, философийн түүх;
- монгол иргэншил, урлаг соёлын харьцуулсан судалгаа;
- монголын шинжлэх ухааны онол, түүх, арга зүй;
- боловсролын харьцуулсан судлал, чанарын асуудал;
- Нууц товчооны цогцолбор /"Түүх, соёл, хэл, утга зохиол"/ судалгаа

Хэл шинжлэл, утга зохиол судлал:

- монгол хэл шинжлэл, үндэсний утга зохиолын хэлний түүх, бүтэц, тогтолцоо;
- монгол хэл, өрнө, дорнын хэлний харьцаа, алтайн хэлнүүдийн судалгаа;
- монголын утга зохиол, аман зохиол, бурхан шашны уран зохиол;
- шинэ үсгийн зөв бичгийн дүрмийн сайжруулалт.

Гүн ухаан, социологи судлал:

- монголын гүн ухааны сэтгэлгээний төлөвшил, түүний онцлог шинж, уламжлал, хөгжлийн түүхэн замнал, орчин үеийн байдал;
- монголын гүн ухааны сэтгэлгээг судлах,

сэргээх, сайжруулах, өвлүүлэх арга зам;
- монголын нийгмийн социаль өөрчлөлтийн чиг хандлага;
- монгол хүний нийгмийн харилцааны өөрчлөлт, нийгмийн давхраажилт, нийгмийн сэтгэлгээний социологи.

Эдийн засаг судлал:
- хөгжлийн эдийн засаг, өрсөлдөх чадвар;
- дэлхийн мэдээллийн глобалчилал, монголын эдийн засаг, тогтвортой хөгжилд түүний үзүүлэх үр нөлөө;
- зах зээл судлал.

Эрхзүй, улс төр судлал:

- эрхзүйт төрийн онол, монголын эрхзүйн шинэчлэл;
- тогтвортой хөгжлийн эрхзүйн орчин;
- хөдөлмөр-бизнес, иргэний эрхзүйн шинэчлэл;
- шүүх засаглалын эрхзүй;
- монголын уламжлалт төр ёс, улс төрийн харилцаа, ардчилсан тогтолцоо;
- монголын ардчиллын өрнөл, хөгжил;

Монгол иргэншил, соёл, урлаг судлал:

- нүүдэлчдийн соёл иргэншил, нийгмийн хөгжлийн зүй тогтол;
- монголчуудын аж ахуй эрхлэх уламжлалт арга технологи;
- уран сайхны соёлын хөгжил, монголчуудын соёл-уран сайхны сэтгэлгээ;
- соёл, гоо сайхны төлөвшил, соёлын менежмент, маркетинг, театр, дүрслэх урлал.

Боловсрол, шинжлэх ухаан судлал:

- сургуулийн өмнөх насны боловсролын тогтолцоо, бага, дунд, дээд боловсролын шинэчлэл, маркетинг;
- мэргэжлийн сургалтын дээд боловсролын агуулга, мониторинг;
- монгол хүний хөгжил, боловсрол, хүмүүжлийн түүхэн уламжлал, онцлог шинжүүд;
- монголын шинжлэх ухааны чадавхи, менежмент;
- шинжлэх ухаан-төр, боловсрол, бизнесийн холбоо, түүний стратеги.

Цэргийн шинжлэх ухаан судлал:

- цэргийн урлаг, зэвсэгт хүчний байгуулалт, сургалт;
- батлан хамгаалах бодлого, орон нутгийн хамгаалалтын тогтолцоо;
- хүмүүнлэгжүүлэх, энхийг сахиулах, иргэний хамгаалалтад цэргийн үйл ажиллагааг чиглүүлэх;
- аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах нэгдсэн мэдээллийн систем;
- цэргийн түүх, социологи;
- цэргийн техник зохион бүтээх, турших, үйлдвэрлэх технологи.

Биологи, хөдөө аж ахуйн салбарт

Биологи:

- монголын хүн амын этногенез, антропологи;
- монгол хүний биологид үзүүлж буй байгалийн хүчин зүйлүүдийн нөлөөлөл, хүн амын хөгжлийн прогнозод түүний онцлог, давтамж, хувьсал, өөрчлөлтийг харгалзах;
- монгол орны мал, амьтан, ургамлын генетикийн онцлог, малын ашиг шим, ургамлын ургацыг нэмэгдүүлэх арга технологи, нэн ховор, ховордсон амьтан, ургамлын тархац, нөөц, анатоми, морфологи, физиологи, эмбриологийн судалгаа, экологи-эдийн засгийн үнэлгээ, тэдгээрийг хамгаалах, үржүүлэх генетикийн үндэслэл, генийн сан;
- монгол орны ургамлын аймгийг ангилал, таксономи, систематикийн үүднээс задлан шинжлэх, зарим бүлгүүдийн полиморфизм, хувьсах зүй тогтол, гарал үүслийн асуудлыг шийдвэрлэж олон жилийн судалгааны дүнг нэгтгэн дүгнэх;
- бүс нутгийн хэмжээнд биологийн төрөл зүйлийг ангилах, судлах, ашиглах, хамгаалах асуудлын онол-аргазүйн үндэс;
- байгалийн ашигт ургамлын генофонд, тархац, генетикийн нөөцийг ургамлын интродукци, нутагшуулалт ба шинэ таримал бий болгоход ашиглах арга технологи;
- хүнсний төрөл бүрийн халдвар үүсгэгч ген, тэдгээрийн үйл ажиллагааны молекул, механизм, хавдар үүсэх шалтгаан, түүнээс сэргийлэх, хавдрыг эрт оношлох молекул арга, хүн ам дахь хавдрын генийн тархалт, В-гепатитийн вакцинаас

зайлсхийх мутаци ба давтамж;
- ойн экосистемийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга технологи, түүний тэнцвэрт байдлыг хангах, мониторингийн сүлжээ байгуулах;
- бичил биетний тархацын зүй тогтол, экологи, бичил биетний гаралтай биологийн идэвхт бодисын судалгаа;
- экологийн урт хугацааны мониторингийн судалгаагаар эхлүүлж, бүс нутгийн байгалийн экосистемийн төлөв байдалд экологи-эдийн засгийн иж бүрэн үнэлгээ өгч, урьдчилан прогноз хийх, доройтсон орчныг нөхөн сэргээх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах;

Хөдөө аж ахуй:

- Мал, тэжээвэр амьтны удамшил, ашиг шимийг батжуулан сайжруулж шинэ үүлдэр, хэвшил, удам бий болгох, өндөр ашиг шимтэй мал, амьтныг бүс нутгийн хэмжээнд эрчимжсэн арга технологиор өсгөж үржүүлэх, сүргийн чанарыг сайжруулах;
- монгол малын биологи, тэсвэрт чанар, зан араншин, омог, хэвшил, үүлдрийн удам зүйн ялгаат байдлыг тогтоох судалгаа;
- нутгийн мал, түүний зэрлэг төрлийн генофондыг хамгаалах, сайжруулах үндэслэл;
- Малын мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир зэрэг үндсэн бүтээгдэхүүний гарц, биологийн чанарыг селекцийн үр дүнтэй холбон ариун цэвэр, эрүүл ахуйн үүднээс нарийвчлан тогтоож, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх үндэслэл;
- монгол малын цитогенетик, иммунологийн маркерийг тодорхойлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах селекци-генетикийн арга зам;
- монголын агроэкологийн системд дасан зохицсон хөдөө аж ахуйн шинэ таримал, сорт бий болгож нутагшуулах генетикийн болон агротехникийн үндэслэл, үрийн аж ахуй;
- байгалийн экоситем, зохиомол фитоценозын нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах биосоциологи, эдийн засгийн загвар;
- малын үр хөврөлийг шилжүүлэн суулгах, гүн хөлдөөх, микроманипуляцийн аргаар хуваах, түүний чанар, хүйсийг тодорхойлох, ооцитыг олноор гадагшлуулах, ялган авах, "инвитро" нөхцөлд үр тогтоох арга технологи;
- малыг эрүүлжүүлэх, өвчин, эмгэгээс сэргийлэх, малд дархлаа тогтоох, бактер, вирусын гаралтай болон паразит өвчнийг оношлох дэвшилт арга технологи, үржлийн физиологи, даавар судлал;
- мал эмнэлгийн халдварт вируст, халдваргүй өвчин, паразит, эгэл биетэн, эм, хор, төлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга;
- монголын нүүдлийн мал аж ахуйн нийгэм, эдийн засаг, биоэкологийн судалгаа, малчид, хөдөөгийн хүн амын нийгмийн асуудал;
- бэлчээрийн менежмент, мониторингийг боловсронгуй болгох, экологийн тэнцвэрийг хадгалах, сэргээх, газрын өгөөжийг нэмэгдүүлэх, байгалийн гамшгаас сэргийлэх;
- мал, амьтан, үргамлын үржил-селекц, ХАА-н үйлдвэрлэлд биотехнологийг хэрэглэх;
- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын экосистемийн динамикт үнэлгээ өгөх, түүнийг прогнозлох, хүн-мал-газрын уялдаа шүтэлцээ, байгаль-эдийн засгийн зохистой нөхцөлд тулгуурлаж хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх онол, арга зүйн үндэслэл;
- хөдөө аж ахуйн экологийг хөгжүүлэх үндэслэл;
- хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн концепци;
- фермерийн аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засаг, менежментийн орчин;
- төрөл бүрийн малын мах, сүү зэрэг үндсэн бүтээгдэхүүний гарц, найрлага, биологи чанарыг ариун цэвэр, эрүүл ахуйн үүднээс нарийвчлан тогтоож, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндэслэл;
- ураг, энерги ихтэй тэжээлийн эх сурвалжийг илрүүлж, эрэлт хэрэгцээ, хадгалалт, чанар сайтай тэжээл, биобэлдмэл бий болгох, үйлдвэрлэх технологи;
- бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, талхлагдсан бэлчээрийг сэргээн сайжруулах, хөрсний эвдрэл, элсний нүүлтийг зогсоох оновчтой арга технологи;
- тэжээлийн ураг, амин хүчил, ургамал хамгаалах хэрэгсэл, бактерийн бордоо, антибиотик, фермент зэрэг биобэлдмэл,

эмийн үйлдвэрлэлийн хаягдалгүй технологи;
- мал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэх технологи;
- бүс нутгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн биологийн нөөц (мал, амьтан, ургамал, хөрс, ус г.м.)-ийн үндсэн үзүүлэлтүүдийн электрон сан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүс нутгийн прогноз;
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, маркетингийн мэдээллийн технологи;
- тариалангийн талбайг боловсруулах техникийн цомхотгосон үйл ажиллагаа бүхий хэмнэлттэй технологи;
- хөдөө аж ахуйн машин, техникийн сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх технологи.
- хөдөө аж ахуйд зах зээлийн харилцааг гүнзгийрүүлж, төлөвшүүлэх концепци;
- хөдөө аж ахуйн таримал, ашигтай зэрлэг ургамлын генийн нөөцийг хадгалах, хамгаалах, селекцид ашиглах, ургамлын генийн нөөцийн банк.

Анагаах ухааны салбарт

Био-анагаах ухаан:

- эрүүл монгол хүний насны зонхилох булгүүдийн морфологи, физиологи, клиник-биохимийн полиморфизм, тэдгээрийн зонхилох хувилбар, хүн амын генофондын гүнзгийрүүлсэн судалгаа, өвчний эмгэг жамын механизм, удамшлын болон бусад болзошгүй эмгэгээс урьдчилан сэргийлэх арга;
- хүний дархлааны тогтолцооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, насыг уртасгах, чихрийн шижинг эмчлэх эмийн бодисуудыг илрүүлэх, амьтны гаралтай феромонт нэгдэл, эрдсийн гаралтай эмүүдийн дотроос кали, селен, хоёр валентат төмрийг ялгах зорилгоор эх орны ургамал, амьтан, эрдсийн түүхий эд, уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж байсан эмт бодисыг гүнзгийрүүлэн судлах;
- вирус, бактери, хүн, амьтны био-идэвхит бодис, тэдгээрийн удамшлын материалын өргөжүүлсэн судалгаа, оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, ген заслын зориулалттай биобэлдмэл бий болгох, үйлдвэрлэх биотехнологи, генийн инженерчлэлийн арга;

Эмнэлзүйн анагаах ухаан:

- цусны эргэлтийн тогтолцооны эмгэг, хорт хавдар, элэг-цөс, ходоод-гэдэс, бөөр, мэдрэл-сэтгэц, дотоод шүүрлийн эмгэгүүдийн эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, сэргийлэлт, нөхөн сэргээлт;
- өсвөр үе /хөвгүүд, охид/, эмэгтэйчүүдийн бие бялдар, нөхөн үржихүйн үзүүлэлтүүдийн хөдлөл зүй, хувьсал, хүүхдэд зонхилон тохиолдох эмгэг, амь тэнссэн үеийн үзүүлэлтүүдийн судалгаа, эмэгтэйчүүдийн эмгэг, төрөх үеийн эрсдэлийг эрт оношлох, үр дүнтэй эмчлэх, сэргийлэх, эх, нярайн эндэгдлийг бууруулах арга зам;
- уламжлалт анагаах ухааны оношлох, эмчлэх, сэргийлэх аргууд, ургамал, амьтан, эрдсийн гаралтай оношилгоо, эмчилгээ, сэргийлэлтийн зориулалттай шинэ эм, бэлдмэл бий болгох, үйлдвэрлэх технологи;
- эрүүл мэндийн төрийн ба хувийн хэвшил, төрөлжсөн болон ерөнхий мэргэжлийн тусламжийн монгол орны нөхцөл дэх зохимжит харьцаог бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны болон эдийн засгийн менежментийг боловсронгуй болгох арга зүй;
- эд эрхтэн нөхөн сэргээх, шилжүүлэн суулгах, дурангийн бичил мэс заслын аргууд;
- эрүүл мэндийн оношилгоо, зайны оношилгоо, эмчилгээний эксперт систем;
- бактери, вирусийн эсрэг болон дархлааны нөлөөлөх шинэ бэлдмэлүүдийг халдварт өвчин хийгээд нян тээгчийн эмчилгээнд хэрэглэх аргууд;
- ургамал, амьтан, эрдсийн түүхий эдээс гаралтай орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, сэргийлэлтийн шинэ эм бэлдмэлийн технологи үйлдвэрлэх;
- анагаах ухаан, эрүүл мэндийн мэдээлэл, эрэл хайлтын зохимжтой сүлжээний загвар.

Нийгмийн эрүүл мэнд:

байгаль, цаг уурын онцлог, газар зүйн байршил, хүн амын нягтрал, зан заншилд уялдсан эрүүл мэндийн менежментийг төлөвшүүлэх, эрүүл хүнийг өвчин, эмгэгээс хамгаалах, эрүүл аж төрөх орчин бүрдүүлэх;

байгалийн хүчин зүйлээс шалтгаалан макро, микро орчин дахь физик, химийн үзүүлэлтүүдийн өөрчлөлт хүний эрүүл мэндэд үзүүлж буй болон үзүүлж болзошгүй нөлөөллийг судлан тогтоох, серег үр дагаврыг арилгах, сэргийлэх, эрүүл ахуйн үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох;

хүнсэн дэх тэжээллэг бодисын хувирлыг тогтоох, хүнсний аюулгүй байдалд өгөх үнэлгээний арга зүй, үзүүлэлтийг боловсронгуй болгох, хүнс тэжээл болон хооллоттой холбоотой өвчлөлийг бууруулах, сэргийлэх арга;

хүн амын нас, хүйсийн бүлэглэлүүдийн эрүүл мэндийн холбогдолтой зан үйлийн онцлогийг судлах, эрсдэл бүхий зан үйлийг засах орчин цагийн болон уламжлалт анагаахын арга;

хүн амын бүтэц, бүрэлдэхүүний хөдлөл зүй, нөлөөлөх хүчин зүйлсийн хэтийн төлөв, манай нөхцөлд тохирсон эрүүл насжилтын дэглэм;

полиомиелит, улаанбурхан өвчнийг устгах, сахуу, хөхүүл ханиад, татран, В вирус гепатитын халдварыг бүрэн хяналтад авах, гахай хавдар, салхин цэцэг, улаануул, С вирус гепатит, пневмококт халдвар болон бактерит мэнэнгийн эсрэг вакцинуудын үр дүнг монголын нөхцөлд судлан тогтоох;

томуу болон амьсгалын замын цочмог халдвар, тарваган тахал, бруцеллез зэрэг манай орны нөхцөлд нутагшмал зооноз халдварууд, бэлгийн замаар тархах халдваруудын тархалтын зүй тогтол, онцлог, үүсгэгчийнх нь биологийн шинж, эсрэгтөрөгчийн хувирал, дэгдэлтийг урьдчилан тооцох судалгаа, таслан зогсоох, тэмцэх, сэргийлэх оновчтой арга;

монгол орны байгаль дахь нянгийн тойрог эргэлт, дэлхийн бусад оронд эрчимтэй тархаж буй (emerging) нянгуудын монгол дахь экологийн онцлог, эрүүл мэндийн холбогдол, сурьеэгийн нянгийн эмэнд дасах механизм болон эрсдэлт бүлгийн хүн амын дотор тархах зүй тогтол, идэвхитэй эмчлэн эдгэрүүлэх арга.

Техник-технологийн салбарт

Уул уурхай:

үйлдвэрийн технологийн явцад ялгарсан хий, шингэн, хатуу хуурай, хорт хаягдлын иж бүрэн судалгаа;

ашигт малтмалын ордуудын өрөмдлөг, олборлолтын бүсчлэл, ангилал, эх орны ашигт малтмал (өнгөт, үнэт, ховор металл гм)-ын эрэл хайгуул, олборлолт, баяжуулалт, цэвэршүүлэлт, төрөлжүүлэлт;

уурхайн олборлолтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга, уул уурхайн эдэлбэр газрын кадастр;

өөрийн орны түүхий эдийн онцлогт тохирсон бага оврын тоног төхөөрөмж;

нефтийн супер компьютерийн судалгаа, нефть нэрлэгийн тунгалаг бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх технологи;

газрын хэвлийн баялгийг ээзэмших техник хэрэгслийг төгөлдөржүүлэх, шинээр бүтээх оновчтой арга;

нүүрсийг энерготехнологийн болон химийн түүхий эдийн чиглэлээр ашиглах технологи;

эрдэс баялгийн экотехнологийн судалгаа, үусган баяжуулах SX-EW технологи;

нүүрснээс утаагүй шахмал түлш, шатах хий болон шингэн түлш гарган авах үйлдвэрлэлийн техник, технологи;

нүүрс, шатдаг занарын орд илрүүлэх эрэл хайгуулын судалгаа;

алтны шороон ордуудыг ашиглаж буй үйлдвэрүүдийн хаягдал, балансын бус нөөцийг эргүүлэн ашиглаж, байгаль орчны бохирдлыг багасгах, жижиг ширхэгтэй тоосонцор алтыг ялган авах технологи;

холимог металлын зарим ордыг түшиглүүлэн кабель, аккумуляторын батарей, цайрдсан нимгэн төмөр үйлдвэрлэх технологи;

Цагаансуваргын зэс, Асгатын мөнгө, Төмөртийн-Овооны цайр, Өвөр Маратын хөнгөн цагааны орд газруудыг түшиглэн дунд зэргийн хүч чадалтай үйлдвэр байгуулах технологи.

Хүнс:

бэлчээрийн малын махны хими, биохими, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн

- технологид тэдгээрийн үзүүлэх нөлөө;
- хүнсний үйлдвэрлэлийн биотехнологийн аргууд;
- хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлэх математик, эдийн засгийн загвар;
- хүнсний охь, будаг, эссенци, хоол амтлагч, гоо сайхны зүйл үйлдвэрлэх судалгаа;
- хүнсний түүхий эд, хагас бэлэн болон бэлэн бүтээгдэхүүний шинж чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах судалгаа;
- бэлчээрийн малын мах, сүү, тэдгээрийн дагавар түүхий эдийг боловсруулах ардын уламжлалт арга, гүн боловсруулах хаягдалгүй технологи;
- байгалийн ба таримал ургамлын гаралтай түүхий эдийг иж бүрэн боловсруулж хүнсний бүтээгдэхүүн, туслах материал үйлдвэрлэх технологи;
- хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг механикжуулах, автоматжуулах, бүтээгдэхүүний савлагаа, баглаа боодлын эх загвар, тоног төхөөрөмж;
- хүнсний аж үйлдвэрт биотехнологийн аргаар шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи;
- хүнсний аж үйлдвэрийн дэд салбаруудын техник, технологийг боловсронгуй болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх (загас, давс, жимс, хүнсний ногоо, жан, цуу, пиво, ундаа, мөөг, самар, халиар, жуущай г.м);
- хүнсний аж үйлдвэрт хөдөлмөрийн бүтээмж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх удирдлага, технологийн процесс, төлөвлөлт, бүртгэл тооцооны ажлыг механикжуулах, автоматжуулах.

Металл боловсруулалт:

- металл боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйлдвэрлэлт, борлуулалтыг зохицуулах технологи;
- барилгын төмөр материалыг үйлдвэрлэх технологи;
- төмөрлөгийн үйлдвэрүүдийн техник, технологид бүрэн дүүрэн үнэлгээ өгөх.

Хөнгөн үйлдвэр:

- хөнгөн үйлдвэрийн шинэ нэр төрлийн түүхий эд, материалын судалгаа;
- хөнгөн үйлдвэрийн зориулалттай импортын материалыг орлуулахуйц, эх орны түүхий эдэд тулгуурласан шинэ материал бий болгох, үйлдвэрлэх технологи;
- модны үйлдвэрийн үртэс, зоргодос, хэрчим, зах өөдөс зэрэг хаягдлыг ашиглаж чанаржуулсан шинэ материал бий болгох, шингэн түүхий эдийг гүнзгий боловсруулах, өргөн хэрэглээний мебель, модон эдлэл үйлдвэрлэх дэвшилт технологи;
- хөнгөн үйлдвэрийг өөрийн орны түүхий эдийн баазад тулгуурлан, түүнийг гүн боловсруулах чиглэлээр хөгжүүлэх технологи;
- мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах ардын уламжлалт аргын судалгаа түүний түвшинг сайжруулах технологи, төхөөрөг хэрэгсэл;
- мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах ардын уламжлалт аргад тулгуурласан дэвшилт технологи бий болгох, тоног төхөөрөмж үйлдвэрлэх;
- хөнгөн үйлдвэрийн эх орны түүхий эдийн бүтэц, шинж чанар, онцлогт тохирсон, байгаль орчинд халгүй, эрчим хүч, ус хэмнэхэд чиглэсэн технологи;
- хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний дизайн, загвар хийцийн сайжруулсан стандарт;
- хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай шинэ нэр төрлийн түүхий эд, материал.

Барилга:

- монгол орны байгаль, эдийн засаг, экологийн онцлогт уялдсан хот байгуулалт, барилгын архитектур төлөвлөлт, орон зайн оновчтой бүтэц, зохион байгуулалт;
- барилгын металл хийц, материалыг үйлдвэрлэх технологи;
- барилгын инженер геологи, хөрсний механик ба суурь байгуулалт, барилгын цаг уурын хүчин зүйл, барилгын физик, барилга байгууламжийн судалгаа;
- барилгын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээний дэвшилт техник технологи;
- барилга, замын машины засвар, техникийн үйлчилгээний технологи;
- эх орны байгаль, цаг уурын онцлогт

зохицсон, газар хөдлөлтөд тэсвэртэй, дулаан тусгаарлах чадвартай, үндэсний шинэ материал, эдэлхүүн бий болгох, үйлдвэрлэх;
- баруун болон зүүн бүс нутагт барилгын барьцалдагч материал, цементийг хуурай буюу хагас хуурай аргаар үйлдвэрлэх технологи;
- нүх, хөндийтэй, жин хөнгөнтэй, томруулсан болон өнгөлгөөний тоосго, элемент, түүнчлэн хөнгөн бетон эдэлхүүн үйлдвэрлэх технологи;
- орон нутгийн түүхий эдээр барилгын гадна, дотно хана, дээврийн материал үйлдвэрлэх технологи;
- үгсармал орон сууцны дулааны алдагдлыг багасгах, эрчим хүчийг хэмнэх технологи;
- барилгын үйлдвэрийн баазуудыг жижиг, дунд үйлдвэрийн технологи нэвтрүүлж сэргээн босгох, барилгын норм, норматив, стандартыг зах зээлийн харьцаанд зохицуулан боловсронгуй болгох.

Эрчим хүч:

- эрчим хүчний нэгдсэн системийн горим, ажиллагааны өргөжүүлсэн судалгаа;
- монголын эрчим хүчний эх үүсгэвүүдийн бүтцийг атомын эрчим хүч ашиглан төгөлдөржүүлэх, атомын дулаан, цахилгаан станцуудыг ашиглах технологи;
- сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, ус, биомасс)-ний үүсгэврийн нөөц, үр ашигтай ашиглахад чиглэсэн судалгаа, технологи;
- эрс тэс уур амьсгалтай нөхцөлд тохирсон дулаанжуулалтын системийн оновчтой горим;
- эрчим хүчний системийн өндөр хүчдэлийн сүлжээний хүчдэлийн түвшинг тогтворжуулах, дамжуулах сүлжээний оновчтой бүтэц;
- эрчим хүчний том нэгдэлд гарах аваари, саатлын каскад өрнөлтөөс сэргийлэх реле хамгаалах, аваари эсэргүүцэх автомат систем;
- монгол гэр, ахуйд тохирсон түлш хэмнэх, халаалт дулаацуулга, шаталтын тохируулгатай боловсронгуй зуух үйлдвэрлэх технологи;
- нүүрсийг янз бүрийн хийцийн зууханд үр ашигтай шатаах горим, технологи, нүүрсийг хийжүүлэх ба хийг метанжуулах технологи;
- хөдөө аж ахуйн цахилгаанжуулалтын ерөнхий схем, хэтийн хөгжлийн чиг, хандлагыг бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлог, байршил, хэрэгцээнд тохируулан тодорхойлсон шинжлэх ухаан, техник, технологи, эдийн засаг, экологийн үндэслэл;
- дулааны цахилгаан станцын утааны хийн байгаль орчны бохирдуулалтыг багасгах технологи;
- түлш, эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах техник, технологи;
- эрчим хүчний одоогийн үйлдвэрүүдийг шинэчлэх чиглэл;
- усан цахилгаан станц ба хийн, хий-агрегат станцуудыг барьж ашиглах оновчтой хувилбар;
- хөдөөгийн төв, суурин газрууд, айл өрхийн түлш, эрчим хүчний хэрэгцээг хангахад сэргээгдэх эрчим хүч болон дизель төхөөрөмжийг хослон ашиглах техник, технологи;
- нүүрсний хийгээр ажилладаг дулааны цахилгаан станцын техник, технологи;
- эрчим хүчний боломжтой эх үүсвэрийг ашиглан цахилгаан станц барьж ажиллуулах оновчтой хувилбар;
- эрчим хүчний эх үүсвэрүүдээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл (бохирдолт)-ийг багасгах, түлш, эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах техник, технологи.

Хөдөө аж ахуйн техник, технологи

- ХАА-н техникийн нэг бүс, олон зориулалтаар үгсрагдан ажилладаг цомхотгосон буюу нийтлэг зориулалттай машин техник, багаж хэрэгслийн судалгаа;
- ХАА-н үйлдвэрлэлийн нөхцөлд хүн, машины тогтолцоог оновчтой бүрдүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэгдсэн техник, технологийн судалгаа;
- ХАА-н таримлыг ургуулах агротехникийн, техник технологийн удирдлагын компьютерийн системийг бүрдүүлэх;
- газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн дэд бүтцийг боловсронгуй болгох зорилгоор “Агротехнопарк” болон “Техникийн засвар, үйлчилгээний диллерийн тогтолцоо, сүлжээ”-г бүрдүүлэх;
- ХАА-н үйлдвэрлэлийн технологийн процессыг хянах, удирдах электрон

систем, цахилгаан технологи;
ХАА-н техникийн сэлбэг хэрэгсэл, техник, багаж тоноглолыг дотооддоо үйлдвэрлэх технологи;
триботехнологийн ололтод тулгуурласан засвар, үйлчилгээний технологи, багаж хэрэгсэл.

Электрон техник, машин судлал:

тогтвортой бус системээс эгшин зуурын хугацаанд бодит мэдээлэл авч боловсруулах, системийн ажиллагааг хянах, удирдах нөхцөл бололцоонд үнэлэлт өгөх судалгаа;
эх орны түүхий эдээс электрон техник, машин үйлдвэрлэлд ашиглах шинэ материал гарган авах судалгаа;
монгол орны цаг уурын болоод ашиглалтын нөхцөлд зохицсон технологийн шинэ шийдэл бүхий микропроцессорт систем;
эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх удирдлага, хяналтын электрон техник зохион бүтээх;
металл боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, түгээмэл хэрэгцээний техник, төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх технологи;
байгаль орчин, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн найдварт ажиллагаа, техник ашиглалтын шаардлага хангасан тээврийн үйлчилгээ явуулах технологи;
экологийн болон хөдөлгөөний аюулгүйн шаардлага хангасан зам, тээврийн үр ашигтай суурьсэг боловсруулах;
судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл үйлчилгээний ажлыг электронжуулах, мэдээллийн электрон хэрэгсэл, сансрын холбоог ергөөр ашиглах багаж төхөөрөмж зохион бүтээх.

Холбоо, мэдээлэл:

геологи, геофизикийн тандан судалгаа болон байгалийн гамшгийг урьдчилан тодорхойлоход сансрын мэдээллийг ашиглах арга технологи;
монгол орны тухай мэдээлэл, мэдлэгийн өгөгдлийн сан, сүлжээ;
холбоо, мэдээллийн глобальжсан сүлжээний тополог, схем, ерөнхий синхрончлол, дохиолол;
малчдын холбоо, мэдээллийн систем (радио, телевиз, телефон, телетекс, хөдөлгөөнт холбоо), түүнийг ахуй, үйлчилгээ (сургалт, алсын оношилгоо, экспертизийн систем, зайн тандалт зэрэг)-нд ашиглах шинэ технологи;
холбоо, мэдээллийн системийг ахуй, үйлчилгээнд (сургалт, алсын оношилгоо, экспертизийн систем, зайн тандалт зэрэг) ашиглах шинэ технологи;
хөдөө нутгийг интернетийн мэдээлэл, электрон шуудангаар үйлчлэх технологи;
холбооны сувгийн нэвтрүүлэх (дамжуулах) чадварыг дээшлүүлэх технологи;
монгол хэлний яриа таних, яриаг компьютерт оруулах систем;
холбоо мэдээллийн системийн үр ашиг, менежмент, маркетингийн зохимжтой хувилбар;
дамжуулах системийн оновчтой технологи (оптик, тоон радиорелей, сансрын зэрэг).

Зам тээвэр:

монгол улсын нутаг дээгүүр олон улсын тээврийн үйлчилгээ явуулах техник-эдийн засгийн үндэслэл;
Улаанбаатар хот болон хот орчмын зорчигч үйлчилгээний оновчтой хүрээг тогтоох, тээврийн хэрэгслийн оновчтой паркийг бүрдүүлэх, шинжлэх ухаан экологийн бодлого;
төмөр зам, агаарын тээврийн аюулгүй үйл ажиллагааны үндэслэл боловсруулах оновчтой чиглэл;
монгол улсын авто замын нэгдсэн сүлжээг хөгжүүлэх зорилгоор шинээр зам тавих, томоохон гол мөрөнд бетон гүүр барих оновчтой зураг төсөл, шинэ технологи;
зам тээврийн салбарт олон улсын байгууллага, хөрш зэргэлдээ оронтой хамтран ажиллах, зам тээврийн чиглэлийн олон улсын төрөлжсөн байгууллагад нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох эрх зүйн үндэслэл.

(Төгсгөл нь даралгийн дугаарт)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (196)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай*
- *Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай*
- *Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны гуравдугаар сарын 6 №9 (196)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

102. Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 202 дугаар тогтоолын хавсралтууд (Төгсгөл. Түрүүч нь №8-д) 219

103. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 2 229

104. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан мод бэлтгүүлэхийг зөвшөөрөх тухай Дугаар 3 237

105. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 6 237

106. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 7 245

Хоёрдугаар хавсралт

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 202 дугаар тогтоолын төвсгөл. Түрүүч нь тус эзхтгэлийн №8-д бий

МАГИСТРАНТ, ДОКТУРАНТ СУРАЛЦУУЛАХ ЗАМААР ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРТ ШИНЭЭР БЭЛТГЭХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ЖАГСААЛТ

№	Мэргэжлийн чиглэл	Боловсон хүчний тоо			Зардал (сая.төг)		
		Бүгд	2001-2005	2006-2010	Бүгд	2001-2005	2006-2010
1	Физик	25	12	13	166	72	94
2	Математик	25	10	15	168	60	108
3	Хими	20	10	10	132	60	72
4	Биологи	18	8	10	120	48	72
5	Ургамал судлал	9	4	5	60	24	36
6	Газарзүй, геоэкологи	12	5	7	80	30	50
7	Хэл шинжлэл	18	8	10	120	48	72
8	Түүх	9	5	4	60	30	30
9	Эдийн засаг	6	3	3	40	18	22

Уншигчдын анхааралд

"Төрийн мэдээлэл" эзхтгэлийн 2001 оны зургадугаарт нийтлэгдсэн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн гуравдугаар бүлэг, 18 дугаар зүйлийн 1-ийн 3-т (18.1.3) <... 230000-50000 ...> гэж ташаарсныг <... 20000-50000 ...> гэж залруулан уншина уу.

Эзхтгэлийн зөвлөл

10	Гүн ухаан, улс төр, эрх зүй, сурган хүмүүжүүлэх	20	10	10	132	60	72
11	ХАА-н мэргэжил	20	10	10	132	60	72
12	Анагаах ухаан	43	20	23	285	120	165
13	Палеонтологи	8	3	5	54	18	36
14	Геологи, уул уурхай	10	5	5	66	30	36
15	Одон орон судлал	6	3	3	40	18	22
16	Газар зүйн мэдээлэл	6	3	3	40	18	22
17	Дүрс боловсруулалт	4	2	2	26	12	14
18	Уул уурхайн техник, технологи	13	5	8	88	30	58
19	ХАА-н техник, технологи	22	8	14	42	14	28
20	Барилга, архитектур	15	6	9	43	17	26
21	Хөнгөн үйлдвэрийн техник, технологи	14	5	9	32	12	20
22	Сэргээгдэх эрчим хүчний техник, технологи	15	6	9	44	18	26
23	Эрчим хүчний техник, технологи	12	5	7	29	13	16
24	Хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи	15	7	8	32	13	19
25	Электрон техник, машин судлал	14	6	8	44	18	26
26	Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл	24	10	14	40	14	26
27	Цэргийн мэргэжил	100	40	60	600	240	360
Нийт дүн		503	219	284	2715	1115	1600

Гуравдугаар хавсралт

ШИНЭЭР БАЙГУУЛАХ, ӨРГӨТГӨХ ДҮНДЫН АШИГЛАЛТ БУХИЙ ЛАБОРАТОРИ, ТӨВ

№	Лаборатори, төв	Үйл ажиллагааны чиглэл	Үндэслэл	Хугацаа (он)	Зардал (сая.төг)
1	Бодис, эрдэсийн аналитик судалгааны төв	Геологи, биологийн гаралтай түүхий эд, бүтээсдэхүүнийг найрлага, бүтцийн ижд бүрэн судалгаа хийх	Объектын физик, хими, технологийн шинж чанарыг орчин үеийн түвшинд судлах, эталон тогтоох, лицензэ олгох шаардлагатай	2006-2010	5700
2	Төв Азийн байгаль судлалын төв /exe-lence төв/	Байгалийн баялгийн нөөц, тархац, геологи, газарзүй, цаг уур, цаазжилт, элсний нүүлт, бохирдолт, гамшиг хэрэг асуудлыг судлах дүгнэлт гаргах	Дэлхий нийтээ болж буй глобаль үзэгдлийг ижд бүрнээр судалж түүнд холбогдох арга хэмжээг тооцоолон хэрэгжүүлэх шаардлагатай	2006-2010	2000
3	Эрдэм шинжилгээний багаж техникийн /хэрэгсэл/ засвар, үйлчилгээ, үгсралтын төв	Эрдэм шинжилгээний багаж техникийг найдвартай ажиллагаатай хангах, түүнд засвар, үйлчилгээ хийх, туршилтын үйлдэрүүдийн тоног техникийг үгсрах, суурилуулах	Судалгаа, мэдээллийн олон төрлийн багаж, техникийг ашиглаж байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээрийг засварлах, үгсрах мэргэшлийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулах шаардлагатай	2002-2005	1000

4	Эрдэс боловсруулах шинэ технологийн лаборатори	Эрдэс түүхий эдийн шинж чанар, ангилал, ашиглалтын чиглэлийг тогтоох	Одоогоор хэрэглэж байгаа багаж төхөөрөмж хуучирч ашиглах боломжгүй болсон	2001-2003	500
5	Хэмжилт, тооцооллын цогцолбор	Судалгаа, туршилтын ажлын мэдээллийн сан бий болгох, харгалзах математик загвар, программ хангамж бүрдүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагуудыг локаль, интернет сүлжээнд холбох	Судалгаа, туршилтын ажлыг гадаад, дотоодын мэдээллээр шуурхай хангах, судалгааны үр дүнг өндөр түвшинд боловсруулахад чухал ач холбогдолтой	2002-2004	100
6	Геоинформатикийн лабораторийн өргөтгөл	Хиймэл дагуулын синтетик апертур радарын болон олон түвшний мэдээллийг ашиглаж байгалийн нөөц, эрдэс баялгийг товлоход чиглэсэн судалгаа, дүгнэлт хийх, байгалийн нөөц, геологи, ашигт малтмал, агаар сансрын зураг олшруулах, олон талын зориулалттай геомэдээллийн систем бий болгох	Нэгэнт хуримтлагдсан агаар сансрын олон түвшний мэдээллэд иж бүрэн боловсруулалт хийж байгалийн нөөц, эрдэс баялгийг товлох аргачлал зохиох, монгол орны геодинамик геологи, ландшафт, экологитой холбогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд дээрхи мэдээллийг ашиглах шаардлагатай	2001-2005	90
7	Эртний амьтан, ургамлын олдвор боловсруулах лабораторийн өргөтгөл	Эртний амьтан ургамлын олдворыг чулуулгаас ялгаж боловсруулах, сэргээн засварлах, хадгалах, хэв хийж олшруулах, үзмэр бэлтгэх, сурталчлах, сургалт явуулах	Лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хуучирч, өнөөдрийн шаардлага хангахгүй болсноос гадна хүчин чадал нь хүрэлцэхгүй байгаа	2001-2003	10
8	Хөрс, ландшафт, биогеохими, эртний газарзүй, нуур шинжлэлийн нэгдсэн лаборатори	Эх орны ландшафтын геохимийн сан бүрдүүлэх, томоохон хот суурингийн экогеохимийн төлөв, орчны бохирдолтын түвшинг тогтоох, нуурын усны масс -энергийн солилцооны математик загвар боловсруулах, нуурын эртний газар зүй, уур амьсгалын хувьсал өөрчлөлтийг үр тоос, диатомийн анализаар сэргээн тодотгох	Энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иж бүрэн явуулах зайлшгүй шаардлагатай	2001-2005	45
9	Цэвдэг судлал, мониторингийн лаборатори	Уур амьсгалын дулааралт, аж ахуйн нөлөөллөөс мөнх цэвдэг хэрэхэн өөрчлөгдөж байгааг тогтоох, цэвдгийн олон улсын сүлжээнд нэгдэх	Эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иж бүрэн явуулж, дэлхийн мэдээлэлд уялдуулах шаардлагатай	2001-2005	15
10	Монгол орны нэн ховордсон зарим амьтдын генийн сан лаборатори	Дэлхийд болон манайд ховордсон хавтгай, тахь, худэр, цаа бугa, монгол бөхөнгийн генийн санг бүй болгож, чанар байдлыг нь шалгах, сэргээх	Эдгээр амьтдын тоо толгой хэт цөөрч, зарим нь устаж үгүй болохын ирмэгт тулж байна	2001-2005	10

11	Ой модны хими, туршилт, үйлдвэрлэлийн лаборатори	Ой модыг нөхөн сэргээх, хамгаалах шинэ технологи, модон түүхий эдийг иж бүрэн боловсруулах эрчим хүч хэмнэсэн, хаягдалгүй технологи бий болгох, туршик, нэвтрүүлэх	Түймэрт ой мод сүйрч, технологийн хоцрогдлоос модон материалын зарцуулалт буурахгүй байна. Уг асуудлыг шийдвэрлэхэзд туршилт, үйлдвэрлэлийн нэгдсэн лаборатори байгуулах шаардлагатай	2001-2005	30
12	Барилгын материал, бүтээц туршилтын лаборатори	Барилгын орон нутгийн түүхий эд, материалын физик-механик, хими, дулааны шинж чанарыг тодорхойлох, туршик, хийц, бүтээцийн найрлага, технологийн чанарыг шинжлэх, сорик, материал, түүхий эдийн бэх батын болон дулаан, технологийн үндэсэн үзүүлэлт, чанарын стандартын хэм, хэмжээг тодорхойлох, газар хөдлөлтөд тэсвэртэй материал, хийц, бүтээцийн шинжилгээ, сорилт хийх	Барилгын материалын хийц, бүтээцийн чанар, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадвар нь дэлхийн түвшингээс доогуур, түүхий эдийн орц, эрчим хүч, дулаан, хөрөнгийн зарцуулалт их байна. Иймд эрчим хүч, материал хэмнэсэн шинэ хийц, бүтээц үйлдвэрлэхэд орчин үеийн тоног төхөөрөмж, арга хэрэгслэд тулгуурласан лабораторитой байх шаардлагатай.	2001-2005	190
13	Эсийн өсгөврийн лаборатори	Түгээмэл тохиолдлог хорт хавдруудын эсрэг эх орны шинэ эм, бэлдмэлийн үйлдлийг судлах	Дурдсан үйлдлийг судлахад эсийн өсгөврийн дэвшилт арга хэрэглэх шаардлагатай	2001-2002	10
14	Мэдрэлийн өвчний удам зүйн молекул генетикийн шинжилгээний лаборатори	Мэдрэлийн удамшлын өвчүүдийг молекулын түвшинд, өндөр нарийвчлалтай оношлох	1997-1999 онд хэрэгжүүлсэн "Мэдрэлийн эмгэг" төслийн хүрээнд мэдрэлийн удамшлын өвчний тархалт манай оронд өндөр байгааг тогтоосон ба судлаачид одоогоор 17 нэршилийн өвчнийг оношлоод байна	2001-2003	300
15	Ураг нярайн эмгэгийн оношилгооны лабораторийн өргөтгөл	Ураг нярайн эмгэгийг эрт илрүүлэх чанд авианы орчин үеийн оношилгооны арга, хромосомын ба бодисын солилцооны эмгэгийг илрүүлэх вирус судалын шинжилгээний дэвшилт аргуудыг шинээр нэвтрүүлэх	Манай оронд ураг нярайн эндэгдэл 24 промиль орчимд тогтвортой байгаа нь бусад орнуудынхаас өндөр бөгөөд ураг нярайн эмгэгийг эрт илрүүлэх оношилгооны түвшин доо-гуур байгаатай холбоотой	2001-2004	35
16	Халдварт өвчин судлалын лабораторийн өргөтгөл	Манай хүн амын дунд тархмал халдварт өвчний шинэ хэлбэрүүд болон дэлхийд шинээр бүрттэгдэж буй халдварт өвчнүүдийг өөрийн орны нөхцөлд шинжлэх, оношлох	Манайд халдварт өвчний тархалт өндөр (10000-д 123.05) бөгөөд ахуй, эмчилгээн дэх химийн бэлдмэлүүдийн хэрэглээ нэмэгдсээр байгаа тул халдварт өвчин үүсгэгчийн шинж төрх өөрчлөгдөж, одоогийн түвшинд оношлоход түвэгтэй болсон	2001-2005	110
17	Эрүүл зүй судлалын лабораторийн өргөтгөл	Хүний эрүүл мэндэд гадаад орчны бохирдлын үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судалж, орчныг эрүүлжүүлэх нөхцөлийг тогтоох	Хүний амьдралын гадаад, дотоод орчны эрүүл зүйн үзүүлэлтүүд, хоол хүнсний найрлага, бохирдлын байдлыг байнга судалж тодорхойлох шаардлагатай	2001-2005	100
18	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарын хяналтын нэгдсэн лаборатори	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг шинжилж хянах, мал, үргамлын гаралтай хүнсний түүхий эд, материалын экологийн үзүүлэлт, чанар, стандартыг тогтоох, сав баглаа боодлын материалд сорилт шинжилгээ хийж, чанар, аюулгүй байдлын үнэлгээ өгөх	Импортын болон дотооддоо үйлдвэрлэж буй хүнсний зүйлийн аюулгүй байдлын баталгаа өнөөдөр манайд үндэсндээ байхгүй бөгөөд энэ нь хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн, хүрцаар тавигдаж буй, салбар дундын шинж чанартай томоохон асуудлуудын нэг болж байна.	2001-2005	25

19	Тусгай хамгаалалттай дархан цаазтай, байгалийн цогцолборт газар дахь экологийн судалгааны лабораторийн өргөтгөл	Хөвсгөл нуурын тусгай хамгаалалттай газар, Говийн их дархан цаазат газар, Дорнодын дархан цаазат газар, Хар-ус нуурын байгалийн цогцолборт газарт экологийн хувьсал, өөрчлөлтийн иж бүрэн судалгааг байгуулах явуулах, дээж, сорьц авч шинжилж байх	Дурдсан газруудад байгалийн хувьсал, өөрчлөлт, биологийн төрөл зүйлийг байнга ажиглан судалж, мэдээлж байх талаар Байгаль орчны сайд, ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2000 оны 56/86 тоот хамтарсан тушаал гарсан	2001-2005	40
20	Зөвсөгт хүчний стандартчилал, хэмжил зүйн нэгдсэн лаборатори	Зөвсөгт хүчинд ашиглагдаж буй радио электроник, цахилгаан, өндөр даралтын, цулын, хий шингэн эзлэхүүний нягтрал, бүтүүмжлэлийн хэмжил зүйн багаж хэрэгслийг шалгах, стандартчилах, засварлах	Хэмжил зүйн багаж хэрэгслийн хэмжлийн стандартыг олон улсын жишиг нийцүүлэх,эдгээр багаж хэрэгслийг засварлах, аттестатчилах, хэмжил зүйн нэгдсэн байдлыг хангах шаардлагатай	2006-2010	1000
21	Зөвсөгт хүчний зөвсөгслэл, техникийн туршилт, шинжилгээний төв	Цэргийн зөвсөгслэл, техникийн заримэд ангийг зохион бүтээх, турших, зөвсөгслэл, техникийн заримтоноглол, зориулалтыг өөрчлөх, сэргээн сайжруулах технологи боловсруулах, хадгалалт, ашиглалт, үйлчилгээнд үнэлэлт өгөх	Цэргийн зөвсөгслэл, техникийн эд ангийн нөхөн хангалт зогсонги байдалд орсон, заримэд ангийн ашиглалтын хугацаа дууссан, эд ангийн хангалт гадаад орноос хамааралтай, гадаад зах зээлд олдоцүй болсон	2001-2005	500
22	Эрдэм шинжилгээний номын сан, хэвлэлийн цогцолбор	Гадаадын байгууллагуудтай мэдээлэл солилцох, эрдэмтдийн бүтээлийг хэвлэх, компьютерээс авсан мэдээллээр хангах	Мэдээллийг шуурхай олж авах, бусдад түгээх үйл ажиллагаа өнөөдөр технологийн шаардлагад хүрээгүй байна	2001-2004	500
23	"Эрдэм" банк	Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг санхүүжүүлэх, оюуны бүтээлийг урамшуулах, шинжлэх ухаан, технологийн салбарын хөрөнгө, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх	Эрдэм шинжилгээний бүтээл туурвих, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн банк-санхүүгийн үйл ажиллагааны тогтолцоо бүрдээгүй байна.	2004-2005	500
24	Эрдэм судлалын төрөлжсөн "Интернет" төв	Эрдэм судлалын ажлыг онол, арга зүйн мэдээллээр хангах, эрдэмтдийн тухай мэдээллийг гадаад, дотоодод түгээх, харилцан солилцох	Эрдэм шинжилгээний ажилтнууд хийж буй судалгааныхаа чиглэлээр онол, арга зүйн хувьд мэдээлэл солилцох тогтолцоо өнөөдөр бүрдээгүй байна	2006-2010	2000
25	Петрологийн лаборатори	Эрдэс чулуулгийн бүрэлдэхүүн, бүтэц, найрлагыг судлах	Эрдэс чулуулагт задлан шинжилгээ хийх, бүтэц найрлагыг судлахад зориулалтын багаж төхөөрөмжийн хүрэлцээ муу байгаа	2001-2003	10
26	Археологийн судалгааны төв	Археологийн олдвор, хэрэглэгдэхүүнийг судлах, хамгаалах, сэргээх, хувилах	Түүхийн ач холбогдол бүхий олдворыг нарийвчлан судлах, сэргээх ажлыг өнөөдөр дотоододоо хийх боломжгүй байна	2001-2005	148

27	Төв Азийн үргамал, амьтны аймгийн биологи, экологийн мэдээлэлийн төвлөрсөн сан	Төв Азийн үргамлын аймаг болон хөхтөн, шувуу, загас, шавьж, хоёр нутгатан, мөлхөгч зэрэг амьтдын талаарх олон жилийн судалгааны хуримтлагдсан материалыг нэгтгэн дүгнэж, төрөлжсөн компакт дискүүд гаргах, хэвлэх, гадаад, дотоодод мэдээлэх	Энэ чиглэлийн ажил одоогоор манайд хийгдэж эхлээгүй бөгөөд иймэрхүү мэдээлэл нь манай орны болон дэлхийн шинжлэх ухаанд чухал ач холбогдолтойгоос гадна зах зээлийн эргэлтэд оруулах боломжтой юм	2001-2005	40
28	Трибологийн лаборатори	Машин, техникийн эвдрэлийг задлалгүйгээр оношлох, тосолгооны материалын улсын хяналт, стандарт тогтоох	Энэ чиглэлийн ажил манайд нэвтэрч эхлээгүй байна	2001-2005	50
29	Антропологи, хүн ам судлалын төв	Монгол хүний үүсэл гарал, хөгжлийн зүй тогтлыг судлах, тогтвортой хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тогтоох	Монгол хүний хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд иймэрхүү судалгаа зайлшгүй шаардлагатай	2001-2005	100
30	Эрчим хүчний туршилтын лаборатори	Эрчим хүчний эх үүсвэрийн нөөцийг бүсчилж судлах, тухайн газар нутгийн экологид тохирсон эрчим хүч ашиглах тоног төхөөрөмжийг бий болгох, турших	Өнөөдөр манайд зохион бүтээж, туршиж байгаа тоног төхөөрөмж нь газар бүрийн байгаль, цаг уурын нөхцөлд тэр бүр тохирохгүй байна	2001-2005	39

Бүгд: 15197
2001-2005 онд 4497
2006-2010 онд 10700

Дөрөвдүгээр хавсралт

СУДАЛГАА, ТУРШИЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНД ТУЛГУУРЛАЖ БАЙГУУЛАХ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР

№	Байгуулах үйлдвэр	Үйл ажиллагааны чиглэл	Үндэслэл	Хугацаа (он)	Зардал (сая.төг)
1	Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодисын үйлдвэр	Мембраны технологи нэвтрүүлэх замаар эм, уураг-витамин биобэлдмэл, биологийн идэвхит бодис үйлдвэрлэх	Амьтан, үргамлын гаралтай, эх орны шинэ бүтээгдэхүүн бий болгож үйлдвэрлэн эмнэлэг-биологийн чиглэлээр ашиглаж импортыг орлуулах, улмаар экспортлох боломжтой	2002-2005	350
2	Полимерийн туршилт, сав баглаа боодлын үйлдвэр	Полимер материал боловсруулах, турших, хуванцар материал, сав баглаа боодол үйлдвэрлэх	Хүнс, ахуй, техникийн зориулалттай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын явцад зайлшгүй шаардлагатай, өнөөдрийн байдлаар хангалттүй байгаа нь бүтээгдэхүүний чанар, хадгалалтад муугаар нөлөөлж байна	2006-2010	1000
3	Нийлэг полипептидэд тулгуурласан "ЭЛИЗА" цомгийн үйлдвэр	Нийлэг пептидийг плейтэнд холбох, коньюгат бэлдэх, жилд 50000 оношилгоо хийх, хэдэн орон нутагт явуулсан зарим оношилгоог молекул биологийн лабораторид хянах	Манай хүн амын 30 гаруй хувь нь гепатит С вирус тээгчид бөгөөд энэ технологийг нэвтрүүлснээр доторх дээр оношлуур үйлдвэрлэх нөхцөл бүрдэж, С вирусын халдвар, элэгний хавдраас урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ. Боловсон хүчин, лабораторийн зарим бэлтгэл хангагдсан	2001-2003	53
4	Нэн ховор, ховордсон, гоц ашигт үргамлыг тариалжуулан нутагшуулах цэцэрлэг	Хүнс, эм, чимэглэлийн зориулалттай, гоц ашигт үргамлын генийн сан бий болгох, тэдгээрийг үржүүлэх, консервацлах, борлуулах	Нэн ховор, ховордсон, гоц ашигт үргамлын үйлдвэрлэл, борлуулалт явуулснаар олон улсын Ботаникийн цэцэрлэгийн консервацид нэгдэж, улсын эдийн засаг, байгаль хамгаалалтад ихээхэн үр нөлөөтэй байх болно	2001-2005	10

5	Биологийн бордооны үйлдвэр	ХАА-н таримал ургамлын ургацыг нэмэгдүүлэх үйлчилгээтэй, байгаль орчинд хортой биологийн бордоо жилд 5-10 тн-ыг үйлдвэрлэх	Өөрсдийн технологиор дотоодын түүхий эдэд тулгуурлан үйлдвэрлэсэн биологийн бордоог хэрэглэснээр хөрсний агаарын шингэлтийг га-д 26-96 кг, таримлын ургацыг 14-28 хувь нэмэгдүүлж, химийн гаралтай импортын бордоог орлуулна	2001-2004	7
6	Биотехнологийн аргаар гарган авсан ХАА-н таримал ургамлын үр, суулгац үржүүлэх төв (МААХ ба УГТХ-д)	Вирусын өвчинд тэсвэртэй, хадгалалт, чанар сайтай төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэрэг таримал ургамлын үр, суулгац үржүүлэх, борлуулах	Биотехнологийн чиглэлээр явуулсан судалгаа, туршилтын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх, түүнийг дэмжих талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан	2001-2005	150
7	Оношилгооны бэлдмэл (тайпингийн эсрэг бие)-ийн үйлдвэр	Жилд 30-40 орчим сая төгрөгийн үнэ бүхий тайпингийн хавсарга НІА эсрэг бие үйлдвэрлэж дотоод, гадаадын дархлал судлалын лаборатори-ундаа нийлүүлэх	Эх орны нөхцөлд тугалын цус болон жирэмсэн эхийн эхсийн цуснаас эд нийлүүлэн оношилгооны зориулалттай тайпингийн эсрэг бие ялгах технологи бий болгосон бөгөөд үйлдвэр байгуулах зардлаа 2 жилийн дотор нөхөх боломжтой гэсэн тооцоо гарсан	2001-2003	30
8.	Вакцин, сийвэн, иммүдсийн үйлдвэр	В гепатитын эсрэг вакцин, сийвэн, иммүдэс үйлдвэрлэж эх орны хэрэгцээг хангахаас гадна гадаад зах зээлд нийлүүлэх	Биотехнологийн аргаар В гепатитийн эсрэг вакцины загвар гарган авч эмнэл зүйн туршилт хийсэн ба хүн эмнэлгийн зориулалттай сийвэн, иммүдэс бэлтгэх технологи бий болгосон	2001-2002	150
9	Дархлаа сэргээх эмийн үйлдвэр	Жилд 10 сая орчим төгрөгийн үнэ бүхий дархлаа сэргээх, элэг хамгаалах, вирусын эсрэг үйлдэлтэй шинэ эм үйлдвэрлэж дотоодоо хэрэглэх, гадаадад борлуулах	Хавдар судлалын ажлын хүрээнд дархлаа сэргээх болон хавдрын эсрэг үйлдэлтэй эмүүдийг гарган авч, стандарт, технологийг нь нэгэнт батлуулсан	2002-2005	50
10	Мал эмнэлгийн зориулалттай шинэ эм, бэлдмэлийн туршилтын үйлдвэр	Малын халдварт паразит болон халдварүй дотрын өвчнүүдийг анагаах, сэргийлэх шинэ эм , бэлдмэлүүдийг турших, үйлдвэрлэх	Эх орны түүхий эдэд тулгуурлан үндэсний шинэ технологиор бий болгосон шинэ эм , бэлдмэлүүдийг үйлдвэрлэлд шууд нэвтрүүлэх ажил өнөөдөр тохирсон тоног төхөөрөмжгүйгээс хийгдэхгүй байна	2001-2004	300
11	Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн үйлдвэр	Нар, салхи, биохийн эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэж, орон нутаг дахь жижиг хэрэглэгчдийг эрчим хүч, дулаанаар хангах	Нар, салхи, биохийн эрчим ашиглах зориулалттай 40 гаруй техник хэрэгслийн загвар, зураг төсөл зохиож туршиж хийсэн нь ур дүн сайтай байгаа боловч тоног төхөөрөмжийг олноор үйлдвэрлэх хүчин чадал бүрдээгүй	2001-2005	160
12	Барилгын шинэ материал, эдлэхүүний үйлдвэр	Дулаан тусгаарлах чадвар сайтай, газар хөдлөлтөд тэсвэртэй барилгын шинэ нэр төрлийн материал, бүтээц эдлэхүүн бий болгож үйлдвэрлэх	Өнөөгийн хэрэглээ буй барилгын материал, эдлэхүүн нь ашиглалтын үеийн дулааны алдагдал ихтэй, эрчим хүчний зарцуулалт өндөр, барилгын дулаан, техникийн болон газар хөдлөлийн олон улсын норм, стандартын шаардлага хангахгүй байна	2006-2010	100

13	Хөдөө аж ахуйн машин, сэлбэгийн үйлдвэр	Морин хадуур, тармуур, тракторын эд анги , анжисны ир, суман хошуу зэрэг сэлбэг хэрэгсэл, улмаар бага оврын трактор үйлдвэрлэх	1992-1995 онд 15 м.х. чадалтай жижиг трактор 160, морин хадуур, тармуур 135-ыг угсарч, анжисны ир, суман хошуу жилд 1500-3000- ыг хийсэн нь эралт сайтай байгаа боловч дотоодын хэрэгцээг хангах хүчин чадал бүрдээгүй байна	2001-2002	50
14	Газар тариалангийн үйлдвэрлэлийн “Агро-технопарк”	Цомхотгосон болон тэглэх боловсруулалт, шууд тариттын техник хэрэгсэл бий болгож үйлдвэрлэх, технологийн сорилт туршилт хийх, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, лизинг үйлчилгээ явуулах	Одоогийн байдлаар нийт эргэлтийн талбайн 50 -иад хувь ашиглагдахгүй, ургац 2-3 дахин буурсан, ХАА-н машин техникийн 70-80 хувь нь элэгдэж хуучирсан байна. Машин техникийн шинэчлэлт, ашиглалт, засвар, үйлчилгээ, боловсон хүчин , дэвшилт технологийн удирдлагыг мэргэжлийн цогц байгууллагад төлөрүүлэх шаардлагатай болсон	2003-2005	150
15	Галд тэсвэртэй магнезитан эдлэлийн үйлдвэр	Цахилгаан станц, төмөрлөгийн үйлдвэрийн шатаах зуухны доторлогоонд хэрэглэдэг тоосго, нунтгийг үйлдвэрлэх, экспортлох	Дурдсан тоосго, нунтгийг гаднаас 1 тн-ыг нь 500-700 ам. доллараар авдаг. 1999 онд 3000 тн-ыг авчээ. Тэдгээрийн түүхий эд бухий орд Говь-Алтайн Бидэрийн голд бий, түүнийг ашиглахад хөрөнгө оруулаттаа 0,6-1,6 жилд нөхөх тооцоотой. Нөөцийг нь улсын комисс тогтоосон. БНАСАУ, Румынд үйлдвэрлэлийн туршилт хийсэн	2006-2010	3200
16	Цэргийн галт хэрэгслийн үйлдвэр	Цэргийн галт хэрэгсэл үйлдвэрлэж зэвсэгт хүчний дотоод хэрэгцээг хангах	Цэргийн галт хэрэгслийн зарцуулалт их, импортын үнэ өндөр, нөөц бага, хангалт нь гадаад зах зээлээс хамааралтай	2006-2010	1000
17	Хуягт танкийн аккумляторын батарейн үйлдвэр	Хуягт танкийн аккумляторын батарей үйлдвэрлэж додоод хэрэгцээг хангах	Хуягт танкийн техникийн бэлэн байдалд онцгой үүрэгтэй, олдоц муу, хангалт нь гадаад зах зээлээс хамааралтай	2002-2005	500
18	Цэргийн туслах тоноглолын үйлдвэр	Цэргийн туслах тоноглол үйлдвэрлэж дотоод хэрэгцээг хангах	Импортын тоноглол өндөр үнэтэй, түүнийг монгол хүний биеийн төрх, цаг уурын онцлогт нийцүүлэх шаардлагатай	2001-2005	300
19	Микропроцессорын тоног төхөөрөмжийн үйлдвэр	Дулааны цахилгаан станцын эрчим хүчний тоног төхөөрөмжийг микропроцессорын удирдлага, хяналттай болгох	Инженэнэр дулааны эрчим хүчийг ашиглах хэмжилттэй, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ	2001-2005	100

Бүгд:	7660
2001-2005	2360
2006-2010	5300

Засгийн газрын 2000 оны 202 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙГ 2010 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцагч
	I.Хөтөлбөр, түүний хэрэгжилтийг сурталчлах, төлөвлөх, мэдээлэх талаар		
1	Хөтөлбөр болон түүний хэрэгжилтийн явцыг хэвлэл мэдээллээр тогтмол сурталчлах	2001 оноос	БСШУЯ, ШУА
2	Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлыг эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, шинжлэх ухаан, үйлд-вэрлэлийн нэгдэл зэрэг байгууллагын түвшинд нарийвчлан тодорхойлж, яамны нэгдсэн төлөвлөгөө гарган мөрдүүлэх, биелэлтийг нь жил бүр дүгнэж байх	2001 оны I улиралд	БСШУЯ, ШУА
3	Хөтөлбөрийн хэрэгжилтийг төв, орон нутагт зохион байгуулж явц, үр дүнг жил бүрийн эхний улиралд багтаан Засгийн газарт мэдээлж байх	2001 оноос	БСШУЯ, ШУА
	II.Хөтөлбөрийн санхүүжилт, шинжлэх ухаан, бизнесийн холбоог сайжруулах талаар		
1	Шинжлэх ухаанд зориулж хөрөнгө нийлүүлсэн, хандив, тусламж үзүүлсэн байгууллага, иргэдийг энэ зориулалтаар гаргасан хөрөнгийн нь хэмжээгээр татвар, төлбөрөөс чөлөөлж, туршилтын үйлдвэрлэлээс орсон орлогыг шинжлэх ухааныг санхүүжүүлэхэд зориулж байх асуудлыг түс түс боловсруулж шийдвэрлүүлэх	2001-2003	ХЗДХЯ, СЭЗЯ, БСШУЯ
2	Хувийн хэвшлийн салбарт шинжлэх ухаан, технологийг өөрийн хөрөнгөөр хөгжүүлэх сонирхол бий болгохуйц эдийн засгийн тогтолцоо бий болгох	2001-2003	Засгийн газар
3	Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг татварын ялгавартай тарифаар дэмжих журам гаргах	2001-2002	СЭЗЯ, ҮТЕГ, БСШУЯ
4	Импортын техник, тоног төхөөрөмжид дэвшилт технологийн шаардлагыг хангуулах, технологийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор гаалийн хяналтыг хүчтэй болгох, гадаадаас үйлдвэр, технологи, техник оруулж ирэх төсөл, тооцоо, импортын үйл ажиллагаанд эрдэмтдийн оролцоо, хяналтыг өргөжүүлэх	2001 оноос	БСШУЯ, ГХЯ, СЭЗЯ, УГЕГ
5	Шинжлэх ухааны ололт, үр дүн, дэвшилт технологи нэвтрүүлэх асуудлыг бизнесийнхний үйл ажиллагааны нэг шалгуур үнэлгээ болгож хэвшүүлэх	2001 оноос	БСШУЯ, ХХААЯ, ҮХЯ, ДБЯ

6	Хөтөлбөрийг санхүүжүүлэх төсвийн болон төсвийн бус хөрөнгийн эх үүсвэрийг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн жил жилийн үндсэн чиглэл, төсөвт тусгаж хэрэгжүүлэх	2001-2010	СЭЗЯ, БСШУЯ, ГХЯ
7	Хүрээлэн, корпораци, их сургуулийн лабораторийн тоног төхөөрөмжийн хангамж, чанарын байдалд үнэлгээ өгч, шинэчлэлтийг дэс дараатай хийх	2001-2003	БСШУЯ, СЭЗЯ, ГХЯ
	Ш.Шинжлэх ухааны эрх зүйн орчин, мэдээлэл хангамжийг сайжруулах талаар		
1	Эрдэм шинжилгээний ажилтны эрх зүйн байдлын тухай хууль гаргуулах	2001-2002	БСШУЯ, ХЗДХЯ, ШУА, НХХЯ
2	Судалгаа, туршилтын ажлын тухай мэдээлэл солилцох, ашиглах, борлуулах үйл ажиллагааг өргөжүүлэх, түүний эрх зүйн үндэс, технологийг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээний бүх хүрээлэнг интернетийн сүлжээнд холбох, эрдэм шинжилгээний зориулалттай тусгай номын сан, супер компьютерийн төв байгуулах	2001-2003	БСШУЯ, ШУА, СЭЗЯ, ГХЯ
	IУ.Шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлэх, менежмент, бүтцийг сайжруулах талаар		
1	Эрдмийн зэрэгтэй боловсон хүчнийг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэх, гадаад хамтын ажиллагааны хүрээнд боловсон хүчний мэдлэг чадвар, дадлага туршлагыг дээшлүүлэх, тэдгээрийг мэргэшүүлэх, олон улсын түвшинд сертификатжуулах ажлыг хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, үндсэн зорилтуудад уялдуулж зохион байгуулах	2001-2010	БСШУЯ, ШУА, СЭЗЯ, ГХЯ
2	Судалгаа,сургалт,үйлдвэрлэл,бизнесийг зохистой хослуулж явуулах зорилгоор холбогдох байгууллагуудын дунд зуучлан үйлчилдэг үйл ажиллагааны тогтолцоог бий болгох, боломж бүхий байгууллагуудын баазад тулгуурлан, түүнчлэн шинээр төв, орон нутагт цогцолборууд байгуулж ажилуулах, шинжлэх ухаан, технологийг бүс нутагт хөгжүүлэх арга хэмжээг улс орны бүсчилсэн хөгжлийн бодлогод уялдуулан зохион байгуулж хэрэгжүүлэх	2001-2010	БСШУЯ, СЭЗЯ, ШУА, төв, орон нутгийн холбогдох бусад яам, байгууллага
3	Томоохон үйлдвэр, аж ахуйн газрууд өөртөө хэрэгтэй судалгаа, туршилтын ажлыг өөрийнхөө хөрөнгө хүчээр явуулж байж чадахуйц салбар дундын шинж чанартай шинэлэг бүтцийг бий болгож хөгжүүлэхэд чиглэгдсэн эрх зүй, эдийн засаг, урамшууллын тогтолцоо бий болгох	2001-2003	БСШУЯ, ҮХЯ, СЭЗЯ, ШУА

4	Хавсарга судалгаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагыг лаборатори, туршилтын баазыг нь бэхжүүлэх замаар зохих хэмжээний үйлдвэрлэл явуулж орлого, ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар өөрийгөө санхүүжүүлэх чадавхитай болгох;	2001-2010	БСШУЯ, СЭЗЯ, ШУА
5	Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнд тулгуурлан үндэсний жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, байгууллага дундын ашиглалт бүхий судалгаа, туршилтын лаборатори, төв байгуулах замаар манай оронд технопарк, технополисын бүтэц бий болгох	2001-2010	БСШУЯ, СЭЗЯ, ГХЯ, ДБЯ,ХХАЯ, ҮХЯ
6	Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн банк-санхүүгийн тогтолцоо бий болгож төлөвшүүлэх	2001-2005	Холбогдох яам, байгууллага
7	Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд гадаадын орон, олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаа авах, гадаад хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж өргөжүүлэх зорилго бүхий мастер төлөвлөгөө боловсруулах асуудлыг хандивлагч орнууд, олон улсын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	2001-2002	ГХЯ, СЭЗЯ, БСШУЯ, ШУА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр **Дугаар 2** **Улаанбаатар хот**

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. "Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 174 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2001 оны 2 дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Эрүүл мэндийн сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" УИХ-ын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоол, "Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2000 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоол, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад холбогдох баримт бичгийг үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол улсын Үндсэн хууль
- Монгол улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол улсын Төрийн албаны тухай хууль
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
- Монгол улсын Эмийн тухай хууль
- Монгол улсын Ариун цэврийн тухай хууль
- Монгол улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Монгол улсын бусад хууль тогтоомж

1.4. Арга зүй

Байгууллагын хөгжил, хүний нөөц, бодлогын хэрэгжилт, түүний зохицуулалт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ, төрийн байгуулагын стратеги төлөвлөлт, бизнес төлөвлөгөөний сургалтын гарын авлагыг удирдлага болгон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн арга зүйг хэрэглэв.

1.5. Эрүүл мэндийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Эрүүл мэндийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл мэндийн яам нь стратегийн бодлого, төлөвлөлт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэрт харьцаа, уялдаа холбоог хангах асуудалд өргөн цар хүрээтэй хандаж, зөв зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлнэ. Эрүүл мэндийн яам нь Засгийн газрын эрүүл мэндийн зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохион байгуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Эрүүл мэндийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.



Эрүүл мэндийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, Засийн газрын танхим байна. Эрүүл мэндийн яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Эрүүл мэндийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүргийг төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Эрүүл мэндийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Эрүүл мэндийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын танхимд үзүүлэх зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэгийн үр дүнг сайжруулах;

2. Эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн боловсронгуй болгох;

3. Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаа тогтоож, хувийн хэвшлийг бүх талаар дэмжин хөгжүүлэх;

4. Эрүүл мэндийн суурь тусламжийг хүн амд жигд хүргэх, тэдгээр эрүүл мэндээ хамгаалах, бэхжүүлэх арга зүйд сургах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, нөөцийг тэгш хуваарилах чадавхийг бүрдүүлэх.

2.3. Эрхэм зорилго

Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд ойртуулж, хүн амыг эрүүлжүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлэх.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Эрүүл мэндийн яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Эрүүл мэндийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад цаг үеэ олсон зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3. Эрүүл мэндийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

4. Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд эдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1.Салбарын хөгжлийн урт, дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах;

1.2.Хөрөнгө нөөцийг бүрдүүлэх;

1.3.Салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

1.4.Гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх, уялдуулан зохицуулах;

1.5.Салбарын хүний нөөцийг төлөвлөх, оновчтой байршуулах, удирдлагын чадавхийг хөгжүүлэх.

2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, сайд болон аппаратад шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон мэргэшлийн дэмжлэг үзүүлэх;

2.2. Удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх;

2.3. Сайд болон аппаратыг шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах;

2.4. Төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх.

3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Салбарын хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүгийн болон хүний нөөцтэй уялдуулан зохион байгуулж, түүний тогтвортой, жигд, тасралтгүй байдлыг хангах;

3.2. Эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд түлхүү анхаарч бусад үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

3.3. Эм, эмнэлгийн багаж, хэрэгсэл, техник хангамж, технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Хүн амын эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, асуудал дэвшүүлэх;

4.2. Эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, нөөцийн байдалд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

4.3. Эдийн засаг, санхүүгийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, тараах, үнэлгээ хийх;

4.4. Удирдлагын шийдвэр гаргах түвшинд эрүүл мэндийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн сүлжээ, сан байгуулах, программ хангамжаар үйлчлэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна.

Эрхэм зорилго

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үйл ажиллагааны гол зорилт

Үйл ажиллагааны зорилт

Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулж,хүн амыг эрүүлжүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлэх

- Эрүүл мэндийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад цаг үеэ олсон зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх
  - Салбарын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулж, хөрөнгө нөөцийг бүрдүүлж, бүтээц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох
  - Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх хөгжүүлэх, уялдуулан зохицуулах
  - Салбарын хүний нөөцийг төлөвлөх, оновчтой байршуулах, удирдлагын чадавхийг хөгжүүлэх
- Төрийн захиргааны удирдлагын мэргэжлийн хангах
  - Төрийн захиргааны албан хаагчдын удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган сайд, дэд сайд болон аппаратад шийдвэр боловсруулахтай холбогдсон эрх зүйн үйлчилгээ үзүүлэх
  - Сайд, дэд сайд болон аппарат тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлэх
  - Яамны үйл ажиллагаат олон нийтэд сурталчилах, мэдээлэх, тэдний санал бодлыг судлах, олон нийттэй харьцах үйл ажиллагааг зохицуулах
- Эрүүл мэндийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах
  - Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах
  - Хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг зохицуулах
  - Салбарын техник, технологийн бодлогын хэрэгжилт, хангамжийн асуудлыг зохицуулах
- Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх
  - Салбарын бодлого, төлөвлөлт, төслийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагын шийдвэр гаргахад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.
  - Эрүүл мэндийн салбарын сан, дотоод сүлжээ байгуулах

3. Эрүүл мэндийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцооны боловсруулалтад баримталсан зарчим:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь ань нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохүйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, тухайн яамны бүтцийн нэгжийн нэр нь яамны үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн / гурваас илүүгүй/ шат дамжлагатай байх);

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үүрэг хариуцлагыг жигд хуваарилах боломжийг бүрдүүлсэн байх);

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /танхим/, бусад үйлчлүүлэгч буюу улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлж байх);

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (бүтцийн ерөнхий загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг дараахь байдлаар тогтоов.



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж гарч байна.

1. Стратеги төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, эрүүл мэндийн бодлого, урт, богино хугацааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр, төсөл боловсруулах, гадаад хамтын ажиллагаанд хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Засгийн газар (Танхим), Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг төрүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлэх, хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, өргөдөл, гомдлыг барагдуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, жигд, хэвийн ажиллагаар хангахад чиглэнэ.

Эрүүл мэндийн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон мэргэшлийн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, төрүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг нь сайжруулах чиглэлээр энэ нэгж үйл ажиллагаагаа явуулна. Энэ нэгжийн бүтэд аппаратын аж ахуй, үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаа хамаарна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол

түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, гадаад орон, олон улсын байгууллага байна.

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд энэ нэгж нь эрүүл мэндийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангаж, Засгийн газар, Эрүүл мэндийн сайдын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах, зохион байгуулан хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилан бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, иргэд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, түүнчлэн олон улсын болон төрийн бус зарим байгууллага байна.

4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, эрүүл мэндийн бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, норм, норматив, стандартын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлж мэдээллээр үйлчлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд энэ үйлчилгээг шууд бус хэлбэрээр хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | **Дугаар 3** | **Улаанбаатар хот**

Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан мод бэлтгүүлэхийг зөвшөөрөх тухай

Ойн нөөцийг зохистой ашиглах, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн хүч чадал, ажлын байрны ашиглалтыг сайжруулах, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, улсын эдийн засгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ойн сангийн нөөцөд хийсэн ой зохион байгуулалтын дүнг харгалзан Архангай, Төв, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дэх ашиглалтын бүсийн ойгоос 2001 онд экспортын зориулалтаар 250,0 мянган шоо метр хэрэглээний мод бэлтгүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

2. Модыг зохих технологи, хууль тогтоомжийн дагуу бэлтгэх, нөөцийг зохистой бүрэн ашиглахад экологийн хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболдод, бэлтгэсэн модыг гадаад худалдааны хамгийн ашигтай нөхцөлөөр экспортлож, орлогыг нь улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт тус тус даалгасугай.

3. Мод бэлтгэх, экспортлоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гарган өгч, сонгон шалгаруулалтын үндсэн дээр үйлдвэрлэгчтэй гэрээ хийх, орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавин ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Энэ тогтоолын дагуу мод бэлтгэсэн 6500 га талбайг сэргээн ойжуулахад шаардагдах нийт зардлын 50 хувь болох 350,0 сая төгрөгийг 2001 онд багтаан Байгаль орчны яамны төсөв дээр нэмж олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр | **Дугаар 6** | **Улаанбаатар хот**

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 6 дугаар тогтоолын хавсралт

ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл:

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын ХЭГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "ХААҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлт загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

- Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:
- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль
- Монгол Улсын Газрын тухай хууль
- Монгол Улсын Газрын төлбөрийн тухай хууль
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол Улсын Хүнсний тухай хууль
- Монгол Улсын Таримал үр, сортын тухай хууль
- Монгол Улсын үр тарианы даатгалын тухай хууль
- Бусад хууль тогтоомж

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага; өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хүнс, хөдөө аж ахуйн асуудлын чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болохын хувьд Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Хүнс, хөдөө аж ахуйн яам нь Засгийн газрын хүнс, хөдөө аж ахуйн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь салбарын бодлогын төлөвлөлт, төсвийн зарцуулалт, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хүнс, хөдөө аж ахуйн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Хүнс, хөдөө аж ахуйн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг үндэсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч, хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Удирдлагын орчин үеийн дэвшилтэт арга барил, туршлагыг нэвтрүүлэх, үндэсний технологийг хөгжүүлэх, шинжлэх ухааны ололт, бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хувийн хэвшлийг дэмжиж, хувьчлагдсан аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулж үр дүнг дээшлүүлэх.

2. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний дотор газар тариалангийн үйлдвэрлэлийн техник технологийг шинэчлэн уналтыг зогсоож, үр үйлдвэрлэлийг тууштай сэргээх, хүнсний хангамжийг нэмэгдүүлж хэрэглээний аюулгүй байдлыг хангах.

3. Малын тоо толгойг өсгөж мал сүргийг эрүүлжүүлэх, чанаржуулах, удмын санг хамгаалахын зэрэгцээ мал сүргийг байгалийн гамшгаас сэргийлэх, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх.

4. Бэлчээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон даацыг нэмэгдүүлэх, бэлчээр усжуулах арга хэмжээг эрчимжүүлэн, уст цэгийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулах.

5. Хоршоо хөгжүүлэх санаачилга хөдөлгөөнийг өрнүүлж ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох, үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр хоршоо байгуулахад тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.

6. Хөдөөд зах зээлийн чадавхийг нэмэгдүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг

дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан хүний нөөцийн манлайллыг хангах

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн таатай орчин бүрдүүлэх

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь үйл ажиллагааныхаа эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх.

2. Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, яамны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаат дэмжих.

3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах

4. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн хүнс, хөдөө аж ахуйн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, хөтөлбөр, төсөл боловсруулах.

1.2. Салбарын гадаад хамтын ажиллагаат хөгжүүлэх.

2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах.

2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

2.3.Яамны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа болон нийтлэг үйлчилгээг зохицуулах

3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Мал эмнэлэг, үржлийн ажлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, мал сүргийг байгалийн гамшгаас сэргийлэх, хамгаалах ажлыг зохицуулах.

3.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоох, техник, технологи, үрийн талаар явуулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

3.3. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалт, усан хангамжийн бодлогыг зохицуулах.

3.4. Хүн амын хүнсний хангамжийн бодлого, хүнсний хэрэглээний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах

3.5. Мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт, импортыг дэмжих, зохицуулах.

3.6. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын сангуудын үйл ажиллагаат зохицуулах.

4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.

4.2. Салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

2.6. Үйл ажиллагааны зорилт


Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/БИЗНЕС/-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ , ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим:

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав.Үүнд:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй тухайн яамны үйл ажиллагааны стратегийг уялдуулсан байх;

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/;

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх /байгууллагын нэр, бүтцээс түүний үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал тухайн яамны бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/;

4. Бүтцийн хувьд энгийн байх /тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл 3-аас дээшгүй шат дамжлагатай байх/ ;

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох / тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/;

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх /тухайн яамны төрийн захиргааны албан хаагчнь тухайн сайд, дэд сайд, Засгийн газрын Танхим, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх/;

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийг дараахь байдлаар тогтоов:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Стратегийн төлөвлөлт, бодлогын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээж хүнс, хөдөө аж ахуйн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган, хөтөлбөр, төсөл боловсруулах, гадаад хамтын ажиллагаагаар хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган, хэрэгжилтийг дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр ханган хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд хөдөлмөрчид байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг арга барил, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр ханган, байгууллагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат ханган хангах замаар хэрэгжинэ. Яамны аппаратыг байр, холбоо, техник хэрэгсэл, шаардлагатай зүйлээр ханган, ажиллах орчныг бүрдүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүү, эдийн засгийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллагууд байна.

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар,

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн зохицуулалтын байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ. Үр дүн нь бодит ажил хийгдсэн байна.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаанд бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь аж ахуйн нэгж, байгууллага, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам болон бусад чиглэлийн яамд байна.

4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх болон бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрэлдүүлэх үндсэн үүргийг хүлээж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, үйл ажиллагааны үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнах тогтолцоог бүрдүүлэх, үр ашиг өгөөжийг дээшлүүлэх, нөөц илрүүлэх, ашиглахад чиглэгдсэн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх, орчин үеийн шинэ дэвшилтэт техник технологид тулгуурласан мэдээллийн найдвартай сүлжээ байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг нь хангах, сүлжээний болон ажлын программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх, салбарын мэдээ, мэдээллийн төрөлжсөн сан байгуулах, төрийн мэдээ, мэдээллийн нээлттэй үйлчилгээг төлөвшүүлэх замаар яамны бодлого, үйл ажиллагаа олон нийтэд хүргэх, ил тод байдлыг хэвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаа нь яамны бүтцийн нэгжүүд болон бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, удирдан зохион байгуулах үйл ажиллагаанд оролцож байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг захиалсан мэдээ, мэдээллээр хангах, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн боловсруулсан, тавьсан зорилтын эцсийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн зөвлөгөө, дэмжлэгийг цаг тухайд нь үзүүлэх замаар хэрэгжинэ.

Тус нэгж нь яамны үйл ажиллагааны эцсийн үр дүнгийн талаар өөрийн үйл ажиллагаанд хийх бодит үнэлгээ, дүгнэлтийг хийх ба ажлын үр дүн нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн ахиц дэвшил, үр нөлөө, үр өгөөжийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрээр тодорхойлогдоно.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Дугаар 7 **Улаанбаатар хот**

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2001 оны 6 дугаар тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Оршил

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэнэ/-т Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын болон Засгийн газрын Тэнхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, түүнд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, ур дүнд нь үнэлгээ өгөх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг хамарсан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ямны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3 Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль;
- Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж;
- Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4 Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгуулагын өөрчлөлт зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5 Чиглэлийн ямны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Чиглэлийн ямны нэг болох Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Засгийн газрын Тэнхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь салбарын бодлого, төлөвлөлт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, үүрэг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн ямны нэг болох Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь Засгийн газрын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус ямны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:



Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Засгийн газрын Танхим байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэглээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцаог зохицуулахад чиглэнэ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлотод нарийвчлан тусган хэрэгжүүлнэ.

Хоёр. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна:

2.2.1. Хүний хөгжлийг хангах нийгмийн тэгш орчин бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;

2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

2.2.3. Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлэх, тэтгэврийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой тогтоон хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалах;

2.2.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг эрс дээшлүүлэх.

2.3 Үйл ажиллагааны эрхэм зорилго

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго
Хүн бүр үр бүтээлтэй хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох.

2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь эрхэм зорилтынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.4.2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.4.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.4.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ / мониторинг/ хийж, үнэлгээ өгөх;

2.4.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажилана:

Үйл ажиллагааны стратегийн 2.4.1 дүгээр зорилтын хүрээнд:

1/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах.

Үйл ажиллагааны стратегийн 2.4.2 дугаар зорилтын хүрээнд:

1/ Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2/ Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах.

Үйл ажиллагааны стратегийн 2.4.3 дугаар зорилтын хүрээнд:

1/ Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах;

2/ Нийгмийн хамгааллын төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

Үйл ажиллагааны стратегийн 2.4.4 дүгээр зорилтын хүрээнд:

1/ Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ / мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;

2/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын мэдээллийн сүлжээг хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэгтэлэгчидийг мэдээллээр хангах.

Үйл ажиллагааны стратегийн 2.4.5 дугаар зорилтын хүрээнд:

1/ Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

2/ Гадаад орон, олон улсын байгууллагаас нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийг уялдуулан зохицуулах.


2.6 Үйл ажиллагааны зорилт

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7 Үйл ажиллагааны стратегийн загвар

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загвар



Гурав. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

- Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх /тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/;
- Эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/;
- Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх /байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/;
- Бүтцийн хувьд энгийн байх /тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн, 3-аас дээшгүй шат дамжлагатай байх/;
- Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох / байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/;
- Улс төрийн хувьд төвийг сахисан байх /Тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар, /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан, өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх/
- Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагаатай байх /үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/.

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагаа / бизнес/-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийг дараахь байдлаар тогтоов:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3 Зохион байгуулалтын бүтэц

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон бүтцийн өөрчлөлт тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байхаар тогтоов:

3.3.1. Стратегийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.1 дүгээр зорилтын хүрээнд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах үндсэн үүргийг хүлээнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Засгийн газрын Танхимыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээний гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

Энэ нэгжийн бүтцэд нэг газар, түүний дотор хүн амын бодлогын хэлтэс ажиллана.

3.3.2.Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, ямны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр ямны тасралтгүй, хэвийн жигд ажиллагаат хангахад чиглэнэ.

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, ямны Төрийн нарийн бичгийн даргад болон ямны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, төрүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, ямны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагч байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн бүтцэд нэг газар, түүний дотор захиргааны хэлтэс ажиллана.

3.3.3.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны 2.4.3 дугаар зорилтын хүрээнд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын стратегийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, нийгмийн хамгааллын төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын бодлогыг хэрэгжүүлэх, салбарын нөөц, төсвийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэнэ.

Энэ нь бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа байгууллагатай түншийн харилцаа тогтоож, түүний үйл ажиллагаат бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн бүтцэд нэг газар түүний дотор нийгмийн хамгааллын болон хөдөлмөрийн гэсэн 2 хэлтэс ажиллана.

3.3.4. Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, түүний үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгж болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

Энэ нэгжийн бүтцэд нэг газар ажиллана.

3.3.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.5 дугаар зорилтын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулах үндсэн үүрэг хүлээж, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, яам, салбарын хэмжээнд гадаад орон, олон улсын байгууллагын оролцоо дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг уялдуулан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар дахь уламжлалт харилцаатай гадаад орон, олон улсын байгууллагатай идэвхитэй хамтран ажиллах, шинээр хамтын ажиллагаа өрнүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргыг холбогдох мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, олон улсын байгууллага, гадаад орны оролцоо дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн уялдаа, зохицуулалтыг хангах, яамны тэргүүлэх чиглэлд нийцсэн шинэ хөтөлбөр, төслүүдийг сонгож дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байна.

Энэ үйл ажиллагааны гол түнш нь Гадаад хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, гадаад орон, олон улсын байгууллага байна.

Энэ нэгжийн бүтцэд нэг хэлтэс ажиллана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (197)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Онцгой албан татварын тэмдгийн тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Улаанбаатар хот 2001 оны гуравдугаар сарын 13 №10 (197)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

107. Навааанмөнхийн Дэрийлаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай Дугаар 26 252
108. Пүрэвийн Жигжидэд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай Дугаар 27 252
109. Жанаагийн Хаянхярваад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 28 252
110. Таржидын Лхамсүрэнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээх тухай Дугаар 29 252
111. Цэвэгмидийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 30 252
112. Ганжуурын Цэрэндоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 31 253
113. Цамбын Түвшинтөгсөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 32 253
114. Чойжилын Гэгээнжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 33 253
115. Төмөрийн Намжимд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 34 253
116. Пүрэвийн Даваасамбууд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 35 253
117. Цэгээндоржийн Ойдовт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 36 254
118. Гончигзундуйн Алтанцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 37 254
119. Очирбатын Цогтгэрэлд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай Дугаар 38 254
120. Зарлм хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 39 254

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

121. Онцгой албан татварын тэмдгийн тухай Дугаар 8 257
122. Хөтөлбөр батлах тухай Дугаар 9 257

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19-ний өдөр — **Дугаар 26** — **Улаанбаатар хот**

Нааанмөнхийн Дэрийлаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, удирдсан хоршооныхоо эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, хөдөөгийн хүн ам, малчдын ахуй амьдралыг дээшлүүлэх, нийгэм соёлын асуудлыг шийдвэрлэх, шинэ маягийн хоршоог хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хэнтий аймгийн Галшар сумын "Буянт-Оргилбулаг" хоршооны дарга Нааанмөнхийн Дэрийлаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19-ний өдөр — **Дугаар 27** — **Улаанбаатар хот**

Пүрэвийн Жигжидэд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай

Барилгын байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлд шинэ бүтээл, оновчтой саналууд нэвтрүүлэн хөдөлмөр хөнгөвчлөх, арвилан хэмнэлт гаргах, талаар амжилт олж, олон барилгын сантехник үгсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж барилгын сантехник, автоматик үгсралтын үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн бэлдэцийн үйлдвэрийн бригадын дарга, гагнуурчин Пүрэвийн Жигжидэд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19-ний өдөр — **Дугаар 28** — **Улаанбаатар хот**

Жанаагийн Хаянхярваад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Авто тээврийн байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажиллаж, машин техникийн засвар үйлчилгээг чанартай хийж эдэлгээний хугацааг уртасган, арвилан хэмнэлт гаргаж, шатахуун тээвэрлэх даалгаврыг тогтмол давуулан биелүүлж хөдөө орон нутгийн шатахууны хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж авто тээврийн "Монголтээх" ХК-ийн жолооч Жанаагийн Хаянхярваад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19-ний өдөр — **Дугаар 29** — **Улаанбаатар хот**

Таржидын Лхамсүрэнд Монгол Улсын Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн материал техникийн хангамжийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөө аж ахуйн байгууллагуудад машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, үйлдвэрлэлийн техникийн хэрэгцээг шуурхай хангах, улс орныхоо нөхцөлд техник үгсрах, тохируулага хийх, ажиллагааг зэммшин залуу үедээ зааж сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Агротехимпекс" ХК-ийн мэргэжилтэн Таржидын Лхамсүрэнд Монгол Улсын Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19-ний өдөр — **Дугаар 30** — **Улаанбаатар хот**

Цэвэгмидийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, дээд боловсролтой улс төрийн болон түүхийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж, залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Гурван - Эрдэнэ" багшийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч Цэвэгмидийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр — Дугаар 31 — Улаанбаатар хот

Ганжуурын Цэрэндоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсрол, биеийн тамир, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хүүхэд залуучуудад бие бялдрын хүмүүжил олгох чиглэлээр сургалтын арга зүй, биеийн тамирын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг судалж өнөөгийн тогтолцоог бүрдүүлэх, биеийн тамирын багш, дасгалжуулагч бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бөхийн "Аварга" коллежийн дэд захирал Ганжуурын Цэрэндоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр — Дугаар 32 — Улаанбаатар хот

Цамбын Төвшинтөгсөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Монголын хүүхдийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн байгуулагын үйл ажиллагаат хөгжүүлэн бэхжүүлэх, хүүхдийн эрх, хөгжил, хамгаллын тогтолцоог өөрчлөн шинэчлэх, хүүхдийн байгууллагын ажилтныг бэлтгэх, өсөвр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын хүүхдийн төлөө үндэсний хорооны ахлах ажилтан Цамбын Түвшинтөгсөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр — Дугаар 33 — Улаанбаатар хот

Чойжилын Гэгээнжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачилга, үр бүтээлтэй багшилж сургалтад шинэ санаачилга, орчин үеийн дэвшилтэт арга нэвтрүүлэн, сурагчдад гүн бат мэдлэг олгох, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш Чойжилын Гэгээнжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр — Дугаар 34 — Улаанбаатар хот

Төмөрийн Намжимд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Төрийн болон шинжлэх ухаан, боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монгол улсад тээврийн салбарын эрдэм судлалыг үндэслэн байгуулах, улс орны эдийн засаг, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршил, хэтийн төсөөллийн цогцолбор судалгааг боловсруулахад идэвхтэй оролцон Зүүн хойд Азийн бүс нутгийн асуудлыг судлах талаар олон дорвитой бүтээл туурвиж монголын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Шинжлэх ухааны академийн Зүүн хойд Ази судлалын төвийн эрдмийн зөвлөлийн гишүүн Төмөрийн Намжимд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр — Дугаар 35 — Улаанбаатар хот

Пүрэвийн Даваасамбууд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёлын байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж, материаллаг баазыг нь бэхжүүлэх, Монгол Улсад музей хөгжүүлэх, Монголын үндэсний бахийн холбоог байгуулах, монгол бөхийн өргөөг барих, түүнийг спорт-урлагийн төв болгон зохион байгуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын үндэсний бөхийн холбооны дэд тэргүүн Пүрэвийн Даваасамбууд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 36** **Улаанбаатар хот**

Цэвээндоржийн Ойдовт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж уран зураг, сийлбэр, хөөмөл, баримал, бичвэр зургийн төрлөөр олон зуун бүтээл туурвиж монголын дүрслэх урлагийг хөгжүүлэхэд болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Киноны дээд сургуулийн багш Цэвээндоржийн Ойдовт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 37** **Улаанбаатар хот**

Гончигзундуйн Алтанцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын болон зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, драм, дуулалт жүжгийн дүрүүдэд амжилттай тоглож, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг соёлоор үйлчлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул аймгийн "Залуучууд" театрын гоцлол дуучин Гончигзундуйн Алтанцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 38** **Улаанбаатар хот**

Очирбатын Цоггэрэлд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Бөхийн самбо барилдааны дэлхий, тив, олон улсын болон Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцож дэлхийн аварга болж, улмаар мэргэжлийн чадвартай тамирчин бэлтгэж дэлхий дахинаа Монгол Улсын нэрийг дуурсгахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бөхийн самбо барилдааны улсын шигшээ багийн дасгалжуулагч Очирбатын Цоггэрэлд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 02 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 39** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, шүүх, прокурор, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

1.Цэдэвийн Банди -Олон улсын худалдааны "Нарантуул" төвийн үйлчилгээ, аж ахуйн албаны дарга

2.Цэдэнбалын Батсуурь -Улсын багшийн их сургуулийн сургалт эрхэлсэн проректор

3.Намжилцэрэнгийн Даш-Өлзий-Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Өлзийт Төв" ХХК-ийн захирал

4.Түвдэнгийн Очирхүү -Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга

5.Ишцэдэнгийн Төмөрбат- Монголын ардчилсан социалист залуучуудын холбооны улс төрийн ажилтан, "Гурван үе" чуулгын уран сайхны удирдагч

6.Раднаагийн Пүрэвсүрэн –Нийслэлийн III цахилгаан станцын зөвлөх инженер

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1.Довжоогийн Аюуш -Нийслэлийн геологийн үйлдвэрлэл, шинжилгээний "Моншандас" ХХК-ийн ахлах геологич

2.Таягийн Баасанхүү -Ховд аймгийн Жаргалант сумын "Алтайн зам" ХК-ийн захирал

3.Жигжидийн Бадамгарав -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан

4.Түнжингийн Бадамжунай –Улаанбаатар хотын ерөнхий менежер

5.Бомборын Батжаргал -Геологийн төв лабораторийн захирал

6.Дарамын Батсүрэн -Ховд аймгийн хөгжимт драмын театрын дарга

7.Хавааны Бахтияр -Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч

8.Бадрахын Бямбасүрэн -Үнэт цаасны хорооны ахлах мэргэжилтэн

9.Наранцэцэгийн Дарам -"НИК" ХК-ийн ажилчин

10.Самдангийн Дашдондог -Нийслэлийн 71 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

11.Сэржээгийн Домид -Ховд аймгийн Жаргалант сумын өндөр настан, ахмад жүжигчин

12.Моломжамцын Доржпалам -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Өнгөт хэвлэл" ХК-ийн ерөнхий инженер

13.Жаграагийн Доржсүрэн -Нийслэлийн 97 дугаар дунд сургуулийн биологийн багш

14.Цагаанайн Жамсран -Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл

15.Тугалын Жанлав -Монгол улсын их сургуулийн математик, компьютерийн сургуулийн захирал

16.Нямжавын Жанчивдорж -Говь-Алтай аймгийн Засаг дарга

17.Цэрэнгаваагийн Жигдэн -Монголын Аудиторуудын холбооны ерөнхийлөгч

18.Цэрэнхүүгийн Лхагвасүрэн -Анагаах ухааны их сургуулийн захирал

19.Дамбын Мандал -Техникийн их сургуулийн Эрчим хүчний инженерийн их сургуулийн багш

20.Дамбын Махвал -Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эрчимт эмчилгээний тасгийн ахлах сувилагч

21.Тэшигийн Мөнхжаргал -Монгол улсын их сургуулийн Хууль зүйн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч

22.Дамбын Оюунцэцэг -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн"Ирээдүй" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч

23.Загдын Рагчаабазар -Ховд аймгийн Мөст сумын Засаг дарга

24.Лувсанжамбаагийн Сарантуяа-Нийслэлийн "АПУ" ХК-ийн Пивоны үйлдвэрийн ажилчин

25.Цэрмаагийн Саранцэцэг -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш

26.Хөхийн Сүрэнхор -Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын малчин, Монгол Улсын манлай уяач

27.Гэлэгчүлтэмийн Төмөрбат - М Ү Э - үүдийн холбооны ерөнхий зөвлөлийн зохион байгуулагч

28.Долгорын Түмэнцэрэг -Улаанбаатар хотын Нефть хангамжийн газрын дарга

29.Каманы Улыкпан -Монгол улсын их сургуулийн Биологийн факультетийн экологийн лабораторийн эрхлэгч

30.Чимэд-Ойдовын Пүрэвдорж -Монголын хэвлэлийн хүрээлэнгийн нягтлан бодогч

31.Жамьяндоржийн Пүрэвсүрэн -Булган аймгийн Булган сумын 2 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

32.Цогбадрахын Пүрэвхүү -Үндэсний дуу бүжгийн "Түмэн эх" чуулгын уран сайхны удирдагч, хөгжмийн зохиолч

33.Дэмидийн Халимаг -Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

34.Гүпээгийн Хасаг -Нийслэлийн "Автобус-2-компанийн тасалбар түгээгч

35.Рэнцэндоржийн Цогтбаатар - М о н г о л Улсын Их Хурлын гишүүн

36.Доржийн Цэдвээ - Завхан аймгийн Булнай сумын соёлын төвийн бүжгийн багш

37.Чойжавын Цэдэвжав -Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

38.Даваагийн Цэдэнбалжир -Газрын тосны Хэрэг эрхлэх газрын ахлах ажилтан

39.Самдангийн Цэдэндамба -Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

40.Чойндонгийн Цэенхүү -Нийслэлийн Хан-Уул дүүргийн "Буянт-Ухаа" цогцолбор сургуулийн бага ангийн багш

41.Балжийн Цэмбэл -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын сантехникч

42.Шинэннагаагийн Цэндсүрэн – Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн зураг хөдөлмөрийн багш

43.Нямын Цэрэндолгор -Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр дунд сургуулийн орос хэлний багш

44.Жигжавын Цэрэндорж - Хөвсгөл аймгийн Прокурорын орлогч прокурор

45.Мэндбаярын Чүлтэмдорж -Нийслэлийн зам засвар, арчлалтын "Интер-сейкшн" ХХК-ийн ахлах инженер

46.Пагважавын Шүрчулуу -Үндэсний бүтээмж, хөгжлийн төвийн захирал

47.Цэрэндоржийн Янсанжав -Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын орлогч дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1.Тангадын Баасан -Нийслэлийн "Сэргэлт-Автозам" ТӨҮГ-ын захирал

2.Мядагийн Бадамжав -Нийслэлийн 99 дүгээр цэцэрлэгийн тогооч

3.Намсрайн Бадарч -ХХАА-ны харьяа Сонгино дахь "Биоком бинат" УҮГ-ын жолооч

4.Цэгмидийн Батдаваа -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Дипломат байгуллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын сантехникч

5.Гомбодоржийн Батчулуун -Монгол Улсын Дээд шүүхийн жолооч

6.Түвдийн Баяраа -Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга

7.Ширээбаатарын Гантөмөр -Нийслэлийн "Автобус-2" компанийн жолооч

8.Мөнхөөгийн Даваа -Үргамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

9.Бадам-Очирын Дамдин -Дархан-Уул аймгийн "Өргөө-Од" ХХК-ийн Спиртийн үйлдвэрийн механикч

10.Тамжидын Дулмаа -Нийслэлийн 39 дүгээр дунд сургуулийн багш

11.Ёндонгийн Лайлан -Нийслэлийн гүүр, зам засварын "Гангүүр" ХХК-ийн гараашийн эрхлэгч

12.Надмидын Моломжамц -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Өнгөт хэвлэл" ХК-ийн ажилчин

13.Дамбын Нанжидсүрэн -Нийслэлийн "Автобус-2" компаний тасалбар түгээгч

14.Сааралын Нэргүй -Баянхонгор аймгийн Хянан шалгах хорооны дарга

15.Содномдаржаагийн Нямхүү -ХХАА-ны харьяа Сонгино дахь "Биокомбинат" УҮГ-ын биобэлдмэлч

16.Лувсанпүрэвийн Оюунгэрэл - Газрын тосны Хэрэг эрхлэх газрын фондын эрхлэгч

17.Данзангийн Пүрэвдорж -Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

18.Пүрэвийн Хөмсөө -Нийслэлийн 34 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

19.Сандэйжавын Цэгмид -Нийслэлийн 119 дүгээр цэцэрлэгийн багш

20.Чүлтэмийн Чулуунжав -Үргамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

21.Баатарын Шашмаа -Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын бичээч

22.Цэвэгсүрэнгийн Энхээ -Олон улсын худалдааны "Нарантуул" төвийн байцаагч

23.Дашийн Эрдэнэчимэг -Нийслэлийн 67 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

24.Дамдинсүрэнгийн Янсүрэн -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 17–ны өдөр Дугаар 8 **Улаанбаатар хот**

Онцгой албан татварын тэмдгийн тухай

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийг хэрэжүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт архи, тамхийг хууль бусаар үйлдвэрлэж, борлуулахаас урьдчилан сэргийлэх, онцгой албан татварын төлөлтөд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэн борлуулж байгаа экспортод гаргахаас бусад архи, хүнсний спирт, коньяк /бренди/, жимс болон ургамлын гаралтай түүхий эдээр хийсэн дарс, ликёр, тамхи (савны хэлбэр, багтаамжаас шалтгаалан тэмдэг наах боломжгүй бэлэг дурсгалын зориулалтаар савлагдсан архи, дарснаас бусад)-нд тэдгээрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэн борлуулж, онцгой албан татвар төлсөн болохыг нотлох зорилгоор 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн онцгой албан татварын тэмдэг заавал хэрэглэдэг журамд шилжүүгэй.

2. Онцгой албан татварын тэмдгийн тодорхойлотыг 1 дүгээр хавсралт, загварыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

3. Архи, тамхийг борлуулахдаа онцгой албан татварын тэмдгийг зохих журмын дагуу нааж байхыг архи, тамхи үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн удирдлагад үүрэг болгосугай.

4. Онцгой албан татварын тэмдгийг захиалах, хэвлүүлэх, хадгалах, олгох, бүртгэх, тайлан гаргахтай холбогдсон журмуудыг баталж мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. Онцгой албан татварын тэмдгийн ерөнхий захиалагчийн үүргийг Үндэсний татварын ерөнхий газарт хариуцуулж, уг тэмдгийг борлуулах үүргийг үндэсний татварын төв болон орон нутгийн албадад зөвшөөрсүгэй.

6. Онцгой албан татварын тэмдгийг хэрэглэх болсонтой холбогдуулан тэмдгийг хэвлүүлэх, архи, тамхи үйлдвэрлэгч байгуллагуудад хүргэх, түүнийг хадгалах, олгох болон хэрэглэхэд хяналт тавихтай холбогдсон зардлыг төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

7. Онцгой албан татварын тэмдэгтэй архи, тамхинд тавих чанар стандарт, эрүүл ахуйн хяналтыг хүчтэй болгохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 18–ны өдөр Дугаар 9 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын Худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор, "Хөтөлбөрийг хэрэжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 2 дугаар хавсралт ёсоор, хөтөлбөрийг хэрэжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Хөтөлбөрийг хэрэжүүлэхэд шаардагдах дотоод эх үүсвэрийг 2001-2003 оны төсвийн төвлөрсөн арга хэмжээний зардалд тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэжүүлэхэд шаардагдах гадаад эх үүсвэрийг гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын тусламжаар санхүүжүүлэх боломжийг судалж, саналаа гадаадын холбогдох улс, байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хэрэгжилтийн явцын талаар жил бүр Засгийн газарт тайлагнаж, хэрэжүүлэх арга хэмжээний талаарх саналаа танилцуулж байхыг Үндэсний зөвлөлд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 9 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ДУНД ХУГАЦААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Засгийн газрын худалдан авах ажиллагааны системийн өнөөгийн байдал

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр улсын секторын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд зохицуулах зах зээлийн эдийн засагт нийцсэн систем хөгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж 1999 оноос АХБ-ны техник туслалцааны хүрээнд олон улсын стандартад нийцсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг 2000 оны 4 дүгээр сард УИХ-аас батлан мөрдөж байна. Хуулийг хэрэгжүүлэх "Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам", "Зөвлөхийг сонгоход баримтлах тусгай журам", "Худалдан авах ажиллагаанд оролцогч төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" зэрэг үндэсэн журмууд Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан. Эдгээр хууль, тусгай журмуудыг амьдралд хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тендерийн жишиг бичиг баримт, гэрээний жишиг загвар, бусад заавар, журмуудыг ойрын хугацаанд боловсруулж мөрдүүлнэ.

Түүнчлэн Засгийн газрын шийдвэрээр Санхүү, эдийн засгийн яаманд худалдан авах ажиллагаатай холбогдсон хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон жишиг бичиг баримт, бусад зааврыг боловсруулж мөрдүүлэх, хэвлүүлэх, сурталчлах, төрийн албан хаагчдын дунд өргөн хүрээтэй сургалт явуулах, зөвлөгөө өгөх үүрэг бүхий алба байгуулагдан ажиллаж байна.

1999 оны 11 дүгээр сараас 2000 оны 10 дугаар сарын хооронд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн онцлог, зарчим, үндсэн журмуудыг УИХ, Засгийн газар, яам, агентлагууд болон аймаг, нийслэлийн 360 гаруй удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад танилцуулж, тэдгээрийг семинар ярилцлагад хамруулсан. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн бүх байгууллагуудыг[1] хамарсан улсын хэмжээнд нэвтрүүлж буй шинэ системийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд бэлтгэгдсэн байх боловсон хүчний дөнгөж 2,0 орчим хувь болж байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааны хууль болон журамд "self-policing" буюу "хуулийн өөрөө хэрэгжих зарчим" гэж нэрлэгддэг үндсэн онцлог байдаг. Засгийн газрын худалдан авах ажиллагааны харилцаанд оролцогч хувийн хэвшлийнхэн хуулийг зөв, шударгаар хэрэгжүүлэх хамгийн их сонирхолтой байдаг бөгөөд төрийн албан хаагчдын зүгээс зөрчил гаргасан эсэхэд хатуу хяналт тавьж байдаг нь хуулийн хэрэгжилтийг баталгаажуулах нэг механизм болдог. Иймд хувийн хэвшил, олон нийтийн байгууллагад зориулсан сургалтын тусгай хөтөлбөр гаргаж тэдгээрийн хүсэлтээр сургалт, семинар, зөвлөгөө өгөх нь шинээр бий болж буй худалдан авах ажиллагааны системийг бүрэн утгаар нь ур ашигтай хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

Хэдийгээр төсвийн буюу төр, орон нутгийн байгууллагын хөрөнгийг зарцуулж буй ажилтнуудыг аль болох богино хугацаанд сургах шаардлага тулгараад байгаа ч байгууллагуудын үйл ажиллагааны онцлогийг тусгасан сургалтын тусгай хөтөлбөрийн дагуу хөрөнгө, цаг хугацааны боломжтой уялдуулан тодорхой үе шаттайгаар явуулах сургалтын стратегийг боловсруулж хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, нийгэм эдийн засгийн шаардлага

Татвар төлөгчдийн буюу нийтийн хөрөнгийг ур ашигтай, хэмнэлттэй, ил тод, шударгаар зарцуулах, зарцуулалтыг харилцан тайлагнах,

[1] *Судалгаагаар 4703 байгууллагыг хөтөлбөрт хамруулсан.*

хариуцлагын зарчмыг сайжруулах асуудал нийгмийн амьдралын бүх хэрээг хамарч олон нийтийн зүй ёсны хүсэлт, шаардлагатай тулгараад байгаа юм.

Улсын секторын худалдан авах ажиллагаагэнэхүү шаардлагын хэмжээнд зохицуулах эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж байгаа боловч хуучин социалист системээс шилжиж буй бусад орны нэгэн адил худалдан авах ажиллагааны хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, зааврыг хэрэгжүүлэх уламжлалт арга барил, туршлага, бэлтгэгдсэн үндэсний боловсон хүчний чадавхи байхгүй байна. Үүний улмаас заавар, журмыг буруу ойлгож хэрэгжүүлэх буюу огт хэрэгжүүлэхгүй байх, ашиглаж чадахгүй зэрэг байдал гарч гүйцэтгэгчийг буруу сонгох, зардлыг нэмэгдүүлэх, Засгийн газрын аливаа төслийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаасаа хэтрэх, олон нийтийн дунд засгийн газрын байгууллагын нэр хүнд унах, санаатай буюу мэдлэг чадвар дутсанаас хууль тогтоомжийг зөрчихөд хүрч байгаа юм.

Түүнчлэн төсвийн зарцуулалт хариуцсан ажилтнуудыг олон нийт, хувийн хэвшлийн зүгээс буруутгах, үүний улмаас мэдэхгүй, ойлгохгүйгээс төрийн албан хаагчдын дунд хуулийн зарчим, журмын талаар эсрэг санал, дүгнэлтэд хүрч, ач холбогдлыг үгүйсгэх явдал гарч болзошгүй байна.

Иймд улсын секторын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд /ихэвчлэн төсвийн зарцуулалт хариуцсан ажилтнууд/, холбогдох удирдах албан тушаалтнуудыг богино хугацаагаар худалдан авах ажиллагаатай холбогдсон хууль, жишиг бичиг баримтыг амьдралд хэрэгжүүлж, ашиглах чадварыг эзэмшүүлж үе шаттай сургалтад яаралтай хамруулах асуудал хурцаар тавигдаж байгаа юм.

Төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, бүх шатны төсөвт байгууллагаас гадна төр, орон нутгийн өмчит болон төр, орон нутгийн өмч давамгайлсан үйлдвэрийн газруудын удирдлага, холбогдох ажилтнуудыг сургах шаардлагатай.

Хөрөнгийн зарцуулалт хариуцсан төрийн албан хаагчдыг нэгэнт сургасан тохиолдолд тэдний зүгээс худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг чанд биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, хариуцлага тооцдог механизм бүрэн үйлчилж байх ёстой. Иймээс засгийн газрын болон төрийн хяналтын байгууллагын ажилтнууд, шүүгч, прокуроруудад худалдан авах ажиллагааны зарчим, онцлог, хууль журмын талаар тусгайлсан сургалт явуулах зайлшгүй шаардлагатай болно.

Судалгаанаас харахад хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын ажилтныг оруулахгүйгээр 4700 гаруй төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын ядаж 1-3 гол мэргэжилтнийг /удирдах ажилтныг оруулаад/ сургахын тулд 3 жилийн хугацаанд 7132 хүнийг сургалтад хамруулан 349 удаагийн семинараар /гадаад сургалтыг оруулахгүйгээр/ давхардсан тоогоор 10315 хүнийг шаталсан сургалтад хамруулах тооцоо гарч байна / Сургалтын хөтөлбөрийн нэгдүгээр хавсралт/.

Эхний жил анхан шатны сургалтад 5992 хүн, 2 дахь шатны сургалтад 196 хүн сургахын тулд жилийн турш долоо хоногт нэг семинар хийх замаар нийт 195 семинар зохион байгуулна. Хоёр дахь жилд нийт 2895 хүнд 96 семинар, 3 дахь жилд 1232 хүнд 58 семинар зохион байгуулж 2 болон 3 дахь шатны сургалтад хамруулна гэж тооцоход Засгийн газрын зүгээс нэлээд хүн хүч, хөрөнгө, цаг хугацаа, нарийн зохион байгуулалт шаардагдах болно.

Иймд Засгийн газрын зүгээс энэ ажилд өндөр ач холбогдол, тэргүүлэх чиглэл өгч хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө, хүн хүчний дэмжлэг авах зорилгоор олон улсын байгууллага, донор орнуудад хандаж тэдгээрийн туслалцааг энэхүү хөтөлбөрийн зорилтуудыг хангахад чиглүүлэх нь чухал юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Санхүү, эдийн засгийн яамны худалдан авах ажиллагааны хэсгийг мэргэжлийн бие даасан алба болгон бэхжүүлж, Засгийн газрын ажилтнуудыг тогтмол сургах, давтан сургах чадвартай болгох, үндэсний мэргэжилтэн, багш нар бэлтгэх, их сургуулийн сургалтын програмд худалдан авах ажиллагааны хичээлийг оруулах зэрэг асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, үе шат, хамрах хүрээ

1.Хөтөлбөрийн зорилго:

Уг хөтөлбөрийн үндсэн зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын Тамгын газрууд, төвлөрсөн болон орон нутгийн төсөвтэй харьцдаг байгууллагууд, төр, орон нутгийн өмчийн болон төр, орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдэд энэ хууль, түүнийг дагалдаж гарсан журам, зааврууд ыг хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэхэд оршино.

2.Хөтөлбөрийн үе шат

Хөтөлбөрийг 2001-2003 оны хооронд бүрэн хэрэгжүүлж дуусах бөгөөд сургалтыг анхан шатны, 2 дахь шатны, 3 дахь шатны болон гадаад сургалт гэж ангилан хамрагдах байгууллага, ажилтны үйл ажиллагааны ач холбогдол, сургалтын стратеги, төрүүлэх чиглэлийг харгалзан зохих хуваарийн дагуу явуулна.

3.Хөтөлбөрийн хамрах хүрээ:

Энэхүү сургалтын хөтөлбөрийн хүрээнд худалдан авах ажиллагааны үндсэн ойлголт, зарчим, үндсэн журмууд, хууль тогтоомж, бусад заавар, жишиг бичиг баримт, тэдгээрийг хэрэглэх асуудлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 11 яам, Засгийн газрын 17 тохирууллагч болон 30 хэрэгжүүлэгч агентлаг[2], аймаг, нийслэл, сум дүүргийн 363 Засаг даргын Тамгын газар болон төвлөрсөн төсөвтэй харьцдаг 200 төсөвт байгууллага, аймаг, хотын төсөвтэй шууд харьцдаг 661 байгууллага, сум, дүүргийн төсөвтэй харьцдаг 2715 төсөвт байгууллага[3], 109 төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрууд, 468 орон нутгийн өмчийн үйлдвэрийн газруud[4] зэрэг нийтдээ 4703 байгуллага, аж ахуйн нэгжийн 7132 ажилтныг анхан шатны сургалтад бүрэн хамруулах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны онцлог, тэргүүлэх чиглэлээс хамааран 2 болон 3 дахь шатны сургалт, гадаад сургалтад хамруулна. / Сургалтын хөтөлбөрийн нэг, хоёрдугаар хавсралт/.

Гурав.Санхүүгийн төлөвлөгөө ба зардлын тооцоо

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт **1,0** тэрбум төгрөг буюу 0,9 сая ам доллар[5] шаардлагатай юм. Төсөвт ертгийн 17,0 хувь буюу **174,2** сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Хөтөлбөрийн анхан шатны сургалтад 194,5 сая төгрөг, 2 дахь шатны сургалтад 54,4 сая төгрөг, 3 дахь шатны сургалтад 22,0 сая төгрөг, гадаад сургалтад 650,5 мянган ам.доллар буюу 728,6 сая төгрөг зарцуулна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын тооцоо

/сая төгрөгөөр/

	2001 он		2002 он		2003 он		Нийт дүн	Үүнээс:	
	Дотоод эх үүсвэр	Гадаад эх үүсвэр	Дотоод эх үүсвэр	Гадаад эх үүсвэр	Дотоод эх үүсвэр	Гадаад эх үүсвэр		Дотоод эх үүсвэр	Гадаад эх үүсвэр
Дотоод сургалт	54.8	116.7	60.7		38.6		**270.9**	154.2	116.7
Гадаад сургалт		243.0		243.0		242.6	**728.6**		728.6
Бусад арга хэмжээ			10.0		10.0		**20.0**	20.0	
Бүгд	**54.8**	**359.7**	**70.7**	**243.0**	**48.6**	**242.6**	**1019.5**	**174.2**	**845.3**

[2] *УИХ-ын 2000 оны 32 дугаар тогтоол, ЗГ-ын 2000 оны 131 дүгээр тогтоол*

[3] *Дэлхийн банкны төслийн судалгаагаар /аймаг, хот, сум, дүүргийн байгуулагууд(багууд ороогүй болно)/*

[4] *УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол*

[5] *1 ам.долларыг 1120 төгрөг буюу 2001 оны жилийн дундаж тооцооны ханшаар авав.*

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Санхүү, эдийн засгийн яамны санхүүгийн төвлөрсөн арга хэмжээний жил бүрийн төсөвт тодорхой хөрөнгө батлуулах[6]
- Олон улсын банк, санхүүгийн байгууллага, донор орнууд, гадаадын бусад байгууллагуудаас техникийн туслалцаа авах
- Байгууллагын хөрөнгөөр /төсөвт байгууллага, үйлдвэрийн газар, байгууллагын захиалга, хүсэлтээр/
- Олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын санаачилга, дэмжлэг / сургалт, семинар, зөвлөгөө авах захиалга/.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хөтөлбөрийн Үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүргийг Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлогын газар /Худалдан авах ажиллагааны хэсэг/ хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа нь улсын хэмжээнд мөрдөж байгаа хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, жишиг бичиг баримтыг төрийн албан хаагчдад танилцуулж, тэдний өдөр тутмын ажилд хэвшүүлэхэд чиглэгдэх тул Санхүү, эдийн засгийн яамны худалдан авах ажиллагааны хэсэг энэхүү хөтөлбөрт заасан бодлого, стратегийн дагуу мэргэжил, арга зүйн зохих түвшинд уг хөтөлбөрийг зохион байгуулж явуулна.

Тус хэсэг гадаад туслалцааг хөтөлбөрийн тохирох хэсэгт чиглүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн хэсгийн сургалтыг гадаадын мэргэжилтэн, техник, санхүүгийн туслалцаатайгаар хэрэгжүүлнэ.

Худалдан авах ажиллагааны хэсэг хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд болон хэрэгжилтийн явцыг сар, улирал бүр яамны удирдлагад гаргаж өгнө.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хөтөлбөрт оруулах шаардлагатай өөрчлөлтийн саналыг Санхүү, эдийн засгийн яам хагас жилд нэг удаа хөтөлбөрийн Үндэсний зөвлөлд танилцуулна.

Хөтөлбөрийн Үндэсний зөвлөл тухайн жилийн хэрэгжилтийн явц, үр дүн болон хөтөлбөрт оруулах өөрчлөлтийг жил бүрийн 12 дугаар сард Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Дотоодын сургалтыг Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд заасны дагуу хамрагдах байгууллага, албан тушаалтны тэргүүлэх дараалал, тэдгээрийн хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааны онцлог, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан явуулна.

Гадаад сургалтыг Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд заасны дагуу олон улсын байгууллага, донор орнуудын тусламж орж ирсэн тухай бүр боловсон хүчний шаардлага, энэхүү хөтөлбөрийн бодлоготой нийцүүлэн явуулна.

Сургалтын тэргүүлэх чиглэл

Цаг хугацаа, хөрөнгө, боловсон хүчний хязгаарлагдмал байдлыг харгалзан хөтөлбөрт сургалтын стратеги, тэргүүлэх чиглэлийг дараахь байдлаар тусгасан:

1. Анхан шатны сургалтыг аль болох богино хугацаанд хэрэгжүүлж холбогдох бүх хүнийг хамруулах /2001 онд 84 хувь, 2002 онд 13,6 хувь, 2003 онд 2,4 хувь/
2. Байгууллага харгалзахгүйгээр бүх

[6] *Засгийн газрын хуралдааны 2000 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 30 дугаар тэмдэглэл*

гүйцэтгэх ажилтныг 2 дахь шатны сургалтад хамруулах

- Төвлөрсөн төсвийн томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг яам, агентлагийн ажилтнуудын 2 дахь шатны сургалтыг 2001 онд багтаан дуусгах
- Сум, дүүргийн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллага болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжээс бусад бүх байгууллагын ажилтнуудын 2 дахь шатны сургалтыг 2002 онд багтаан дуусгах

3. Зөвхөн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, томоохон төсөвт байгууллагын гүйцэтгэх ажилтнуудыг 3 дахь шатны сургалтад хамруулах
   - Төвлөрсөн төсвийн томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг яам, агентлагийн ажилтнуудын 3 дахь шатны сургалтыг 2002 онд багтаан дуусгах
   - 2003 онд бүх шатны сургалтыг багтаан дуусгах
4. Гадаад сургалтын нарийвчилсан хуваарь, хөтөлбөр болон оролцогчдын тоо нь олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаанаас шалтгаалах бөгөөд зөвхөн анхан болон 2 дахь шатны сургалтад хамрагдсан ажилтнуудыг холбогдох чиглэлээр хөтөлбөрийн стратегид нийцүүлэн хамруулах

   - дунд, урт хугацааны сургалтад салбарын яамдын цөөн тооны голлох мэргэжилтэнг сургаж мэргэшүүлэх
   - богино хугацааны сургалтад яам, тохируулагч агентлаг бүрээс 1-2 хүнийг сургаж тэдний мэргэжлийг дээшлүүлэх
   - туршлага судлах, танилцах аялалд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны үндсэн байгууллагууд, томоохон төсөвт байгууллага болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын удирдах болон гүйцэтгэх ажилтнуудыг боломжийн хэрээр хамруулах.

Зургаа. Гарах үр дүн

Худалдан авах ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагчдыг дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулалттайгаар туслах хөтөлбөрийн дагуу үе шаттай сургаснаар Монгол улсад олон улсын стандарт, зах зээлийн эдийн засагт нийцсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн шинэчлэлтийг амьдралд бүрэн хэрэгжүүлэх гол нөхцөл болох боловсон хүчний чадавхийг бүрдүүлэх юм.

Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, зааврууд зөв ойлгож, улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдүүлснээр гарах нийгэм, эдийн засгийн үр ашиг асар их юм.

Үүнд:

- Монгол улс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн худалдан авах ажиллагааны системийг амьдралд бүрэн нэвтрүүлэх
- Татвар төлөгчдийн мөнгийг хамгийн зүй зохистой хэлбэрээр зарцуулж байна гэдэг итгэлийг ард түмэнд болон Засгийн газарт өөрт нь бий болгох
- Бүх шатны төсвийн зарцуулалтыг хэмнэлттэй, үр ашигтай болгох
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааг нийтэд ил тод болгох
- Авилгал, хээл хахууль гарах бодит орчин нөхцөлийг бууруулах
- Чөлөөт өрсөлдөөнийг баталгаажуулж хувийн хэвшил хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх
- Дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчдийг дэмжих
- Худалдан авах ажиллагааны үндэсний мэргэжилтэн бэлтгэх, энэ чиглэлийн боловсон хүчний хангамжийг сайжруулах

Худалдан авах ажиллагааны системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, түүнийг улам боловсронгуй болгон хөгжүүлэх.

Засгийн газрын 2001 оны 9 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ДУНД ХУГАЦААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Орлогч дарга -Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Удирдлагын академийн захирал;

-Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын дарга.

Гишүүд: -Төрийн захиргааны албаны зөвлөлийн гишүүн;

Нарийн бичгийн дарга

-Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сургалт хариуцсан ахлах референт.

Засгийн газрын 2001 оны 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургалтын арга, хэлбэр

Дотоодын сургалтын хөтөлбөрийн хуваарийг хөтөлберт хамрагдах байгууллага, албан тушаалтны тэргүүлэх дараалал, тэдгээрийн хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааны онцлог, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан боловсруулсан болно. Сургалтын хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтад дурдсан байгууллага тус бүрээс 1-3 хүн сургахаар тооцон бөгөөд байгууллагуудын дарга, нярглан бодогч, эдийн засагч, хөрөнгийн болон урсгал зардал хариуцсан мэргэжилтэн гэх мэт албан тушаалтууд хамрагдах юм.

Тэдгээрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан сургалтыг багцалж явуулах нь сургалтын хөтөлбөрийг тодорхой чиглэлд хандуулах, сургалтын явцад хөндөгдөх асуудал, оролцогчдын сонирхол зэрэг нь ижил төстэй байх давуу талтай /удирдах ажилтнууд, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд гэх мэт/.

Нэг удаагийн сургалтыг 1-3 хоногоор 30-40 хүнтэйгээр зохион байгуулах бөгөөд хөрөнгийг аль болох үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах үүднээс тухайн үеийн нөхцөл, боломжид нийцүүлэн төвлөрсөн болон бүсчилсэн байдлаар явуулна. Зардлыг нарийвчилж тооцох, семинарын байршил, түүнд оролцогчдын онцлогоос шалтгаалан А-Улаанбаатарын оролцогчдод Улаанбаатарт, Б-орон нутгийн оролцогчдод Улаанбаатарт, В-орон нутгийн оролцогчдод орон нутагт, Г-сумдын оролцогчдод аймгийн төвд тус тус зохион байгуулна.

Гадаад сургалт нь урт болон дунд хугацааны /1 бүхүү түүнээс дээш сар/, богино хугацааны /10-14 хоног/, туршлага судлах буюу танилцах аялал /7-10 хоног/ гэсэн хэлбэртэй байна. Өөрөөр хэлбэл гурван жилийн хугацаанд дотоод сургалтуудтай зэрэгцэн явагдах юм.

Хөтөлбөрийн хүрээнд төр, бизнесийн удирдлага, санхүү, эдийн засгийн мэргэжлээр төгсөгчдөд худалдан авах ажиллагаа сэдвээр үндсэн хичээлийн программ заавал дүүргэсэн байх шаардлагыг тодорхойлно. Энэхүү шаардлагыг хангахад худалдан авах ажиллагааны хэсгийн зүгээс мэргэжлийн арга зүйгээр туслах, олон улсын байгууллагын тусламжийг туршилт, судалгааны ажилд чиглүүлэх замаар Удирдлагын академи болон улсын аль нэг их сургуулийн санхүү, эдийн засгийн тэнхимтэй хамтран худалдан авах ажиллагааны сэдвийг сургалтын программд оруулан оюутнуудад заааж эхэлнэ.

Сургалтын ангилал, онцлог

Дотоодын сургалтыг хөрөнгийн эх үүсвэр, хүн хүч, цаг хугацааны боломж, хамрагдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны онцлогоос хамааран уян хатан байдлаар зохион байгуулах бөгөөд ингэхдээ сургалтын нарийвчилсан хөтөлбөр, тооцоо, хуваарийг харуулсан төлөвлөгөөг харгалзан дараахь байдлаар ангилна:

Анхан шатны сургалтаар /Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдүгээр хавсралт/ хөтөлберт хамрагдах бүх ажилтнуудад дараахь ерөнхий мэдлэгийг эзэмшүүлнэ:

- Худалдан авах ажиллагааны ерөнхий ойлголт, онцлог, үндсэн зарчим, журмуудыг танилцуулах,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тухай хуулийг танилцуулах
- Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан үндсэн журмуудыг танилцуулах

2 дахь шатны сургалтаар /Үйл ажиллагааны төлөвлөгөөний хөрдүгаар хавсралт/ зөвхөн худалдан авах ажиллагааг шууд хэрэгжүүлдэг гүйцэтгэх ажилтнуудад холбогдох ажлын чиглэлээр нь хамгийн ерөн хэрэгглэдэг ердийн бараа, ажил, үйлчилгээний жишиг бичиг баримт, журмыг хэрэн ашиглах талаар практик арга барилыг эзэмшүүлнэ:

- Томоохон ажлын тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Дунд хэмжээний ажлын тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Жижиг хэмжээний ажлын тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Бараа худалдан авах тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Жижиг хэмжээний бараа худалдан авах тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх болон суурилуулах тендерийн жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Үнийн саналын хүсэлт, түүнийг хэрэглэх
- Бараа, ажлын тендерийн үнэлгээний заавар
- Жижиг бараа, ажлын тендерийн үнэлгээний заавар
- Зөвлөх үйлчилгээний саналын урилгын жишиг маягт, түүнийг хэрэглэх
- Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ /хугацаанд үндэслэсэн төлбертэй/, түүнийг хэрэглэх
- Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ /хугацаанд үндэслэсэн төлбертэй/, түүнийг хэрэглэх
- Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ /нийт үнэд үндэслэсэн төлбертэй/, түүнийг хэрэглэх
- Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ /нийт үнэд үндэслэсэн төлбөртэй/, түүнийг хэрэглэх
- Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагааны үнэлгээний удирдамж
- Урьдчилсан сонголтын жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Тулхүүр гардуулах гэрээний жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Эм бэлдмэл худалдан авах жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Сурах бичиг худалдан авах жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Программ хангамж худалдан авах жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Компьютер, техник хэрэгсэл худалдан авах жишиг бичиг баримт, түүнийг хэрэглэх
- Гүйцэтгэгч, нийлүүлэгчийг бүртгэх, ангилах журам
- Бусад шаардлагатай бичиг баримтууд
- Худалдан авах ажиллагааны онол, олон улсын практикийн талаар гадаадын зөвлөх, мэргэжилтнүүдийн явуулах гүнзгийрүүлсэн сургалт

3 дахь шатны сургалтаар /Үйл ажиллагааны төлөвлөгөөний гуравдугаар хавсралт/ томоохон хэмжээний худалдан авах ажиллагааг байнга хэрэгжүүлдэг гүйцэтгэх ажилтнуудад холбогдох ажлын чиглэлээр нь мэргэшүүлэх зорилгоор тусгайлан боловсруулагдсан жишиг бичиг баримт, журмыг хэрэн ашиглах талаар болон онолын гүнзгийрүүлсэн мэдлэг эзэмшүүлнэ:

Гадаад сургалтын /Үйл ажиллагааны төлөвлөгөөний деревдүгээр хавсралт/ хүрээнд тусгай чиглэлээр гүнзгийрүүлэн сургалт явуулж үндэсний мэргэжилтэн бэлтгэх, цаашид сургалт явуулах, багшлах чадвар эзэмшүүлэх зорилгоор шаардлагатай ажилтнуудыг сургана:

- Засгийн газрын худалдан авах ажиллагаа
- Олон улсын худалдан авах ажиллагаа
- Барилгын ажил худалдан авах
- Бараа худалдан авах
- Зөвлөх үйлчилгээ худалдан авах
- Электрон /e-commerce/ худалдан авах ажиллагаа болон энэ чиглэлийн шинэ олоптууд
- Худалдан авах ажиллагааны систем нь ижил тестэй орнуудаас туршлага судлах, танилцах

2001 онд /Үйл ажиллагааны төлөвлөгөөний наймдугаар хавсралт/ төвийн болон орон нутгийн байгууллагуудын нийт 6188 албан хаагчийг сургахаас 5992 нь анхан шатны, 196 нь 2 дахь шатны сургалтад хамрагдана. 2002-2003 онуудад /Үйл ажиллагааны төлөвлөгөөний ес, аравдугаар хавсралт/ үндсэндээ 2 дахь болон 3 дахь шатны гүнзгийрүүлсэн сургалтууд явагдана. Энэ сургалтад худалдан авах ажиллагаа хариуцсан гүйцэтгэх ажилтнуудыг хамруулах бөгөөд үүний үр дүнд эдгэрэн ажилтнууд бие дааж тендерийн бичиг баримт боловсруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах чадвартай болно.

Үндэсний мэргэжилтэн бэлтгэх, цаашид сургалт явуулах, багшлах чадвар эзэмшүүлэх зорилгоор дээрх сургалтуудтай хамт гадаад сургалтыг /Үйл ажиллагааны төлөвлөгөөний деревдүгээр хавсралт/ зохион байгуулж явуулна.

Сургалтад хамрагдах байгууллага, ажилтны судалгаа

№	Байгууллагын нэр	ТОО	Сургалтад хамрагдах хүний тоо	Үүнээс: Удирдах ажилтан	Үүнээс: Гүйцэтгэх ажилтан	Сургалтад хамрагдах албан тушаалтан
1	Засгийн газар, төрийн яамдууд	12	54	24	30	Төрийн нарийн бичгийн дарга, хөрөнгө, санхүү хариуцсан газрын дарга, хөрөнгө оруулалт, урсгал зардал хариуцсан мэргэжилтэн
2	Засгийн газрын тохируулагч агентлагууд	17	51	17	34	
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд	30	100	30	70	Агентлагийн дарга, хөрөнгө оруулалт, урсгал зардал хариуцсан мэргэжилтэн
4	Хот, дүүргийн ЗДТГ	10	30	10	20	Засаг дарга, ТСЭЗБХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч болон бүрилга, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
5	Аймгийн ЗДТГ	21	63	21	42	
6	Сумдын ЗДТГ	332	664	332	332	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч
7	Төвлөрсөн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагууд	200	400	200	200	Байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч болон эдийн засагч
8	Аймаг, хотын төсөвтэй шууд харьцдаг байгууллага	661	1322	661	661	
9	Сум, дүүргийн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагууд	2715	3130	2715	415	
10	Төрийн өмчийн болон 50-иас дээш хувийн төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүд	109	218	109	109	
11	Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд	468	936	468	468	
12	Санхүүгийн улсын хяналт шалгалтын газар, Төрийн хянан шалгах хороо	64	100		100	Хяналт шалгалтын улсын байцаагч
13	Бүх шатны шүүх, прокурор	64	64		64	Шүүгч, прокурор нар
	Нийт дүн	**4703**	**7132**	**4587**	**2545**	

Сургалтын төрөл ба зорилгууд

№	Байгууллага, ажилтнууд	Анхан шатны сургалт		2 дахь шатны сургалт	3 дахь шатны сургалт	Гадаад сургалт
		Ерөнхий мэдлэг дээшлүүлэх	Хүүль, үндсэн журмууд	Үндсэн жишиг бичиг баримт, тусгай журам	Гүнзгийрүүлсэн сургалт, нарийчилсан жишиг бичиг баримт, тусгай журам	Бусад
1	Байгууллагын удирдах ажилтнууд	X	X			X
2	Яаманы гүйцэтгэх ажилтнууд	X	X	X	X	X
3	Засгийн газрын агентлагийн гүйцэтгэх ажилтнууд	X	X	X	X	X
4	Аймаг, хотын ЭДТГ-ын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X	X	X
5	Сум, дүүргийн ЭДТГ-ын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X	X	X
6	Төвлөрсөн төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X	X	X
7	Аймаг, хот, дүүргийн төсөвтэй шууд харьцдаг байгууллагын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X		
8	Сумын төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X		
9	Төрийн өмчийн болон 50-иас дээш хувийн төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын гүйцэтгэх ажилтнууд	X	X	X		
10	Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн гүйцэтгэх ажилтнууд	X	X	X		
11	Төрийн өмчийн хороо, Санхүүгийн хяналт шалгалтын газрын ажилтнууд	X	X			
12	Бүх шатны шүүгч, прокурор	X	X			

Анхан шатны сургалт, зардлын тооцоо

/мян.төг/

№	Байгууллагын нэр	тоо	Сургалтад хамрагдах			Семинарын		Семинарт оролцогчийн тоо	Нийт зардал	Тайлбар
- Санхүү, эдийн засгийн яам, Төрийн захиргааны албаны зөвлөл, Төрийн хянан шалгах хороо, Төрийн өмчийн хороо;
- Төвлөрсөн төсвийн байгууллагууд;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;
- Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Орон нутгийн засаг, захиргаа;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;
- Орон нутгийн төсвийн байгууллагууд.

21. Шинэчлэлийг эдгээр бүх харилцагч талын хүрээнд нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжгүй. Гэхдээ сектор бүрээр хооронд нь уялдаа холбоотойгоор хэрэгжүүлж болох юм. Тухайлбал, төвлөрсөн төсвийн байгуллага, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар, Ерөнхий сайд болон Улсын Их Хурлын байгуулагуудыг нэг бүлэг болгон авч хэрэгжүүлж болно. Үчир нь эдгээр харилцач талууд төсөв болон бусад асуудлаар хоорондоо нягт уялдах юм.

22. Засгийн газрын тогтоолоор шинэчлэлийг хэрэгжүүлэх хугацаат төлөвлөснөөс эрт буюу орой болгон зохицуулах боломжтой. Засгийн газар шинэчлэлийг хурдасгах зорилт тавьж байгаа. Гэхдээ шинэчлэлийн үйл ажиллагаа Засгийн газрын төсвийн болон тайлагналын циклтэй уялдуулан шат дараатай явуулах ёстой юм.

23. Шинэчлэлийг хэрэгжүүлэх үе шат болон цаг хугацаат дараахь байдлаар авч үзэж байна:

Харилцагч талууд; (Хугацаа)

Засгийн газар бүхэлдээ: Шинэчлэлийг аль болох өргөн хүрээнд хэрэгжүүлэх, гол нь хүрэх үр дүн, бүтээгдэхүүн болон орцод анхаарч төсвийн төлөвлөлтийг хийх (бүртгэлийн одоогийн аргаар, бүрэн нэгтгэгүй).; 2002 төсвийн жил

Бүрэн хэрэгжүүлэх (нэгтгэгдэнэ, мөн бүртгэлийн аккруэл суурьт шилжинэ); 2005

Эрхэлсэн сайд нар: Салбарын байгуллагуудынхаа төсвийг боловсруулах болон тайланг нэгтгэх (бүртгэлийн одоогийн аргаар гэхдээ бүтээгдэхүүний өртөг тооцсон байх); 2002 төсвийн жил

Төвлөрсөн төсвийн байгууллагууд: Бизнесийн стратегийн удирдамж боловсруулах, улсын хөрөнгө болон өр төлбөр, орлого ба зардлын тайлан, үр

[1] *Эрхэлсэн сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагч гэдэгт Улсын Их Хуралд өргөн баригдаад байгаа хуулийн төсөлд тусгагдсан албан тушаалтныг авч үзэв.*

дүнгийн гэрээ, жилийн тайлан бэлтгэх;

Нийт байгууллагууд [эрүүл мэнд болон боловсрол орохгүй]; 2002 төсвийн жил

[Боловсрол болон эрүүл мэндийн байгууллагууд]; 2003 төсвийн жил

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж: Зорилтын саналаа бэлтгэж түүнийгээ үр дүн болон тайлагналын үндэслэл болгон ашиглах. Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох жүрмыг өөрчлөх, Төрийн өмчийн хороо энэ ажлыг удирдана.; 2002 санхүүгийн жилээс эхэлнэ

Төрийн өмчит аж ахуйн нэгж; 2002 санхүүгийн жил

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;

2003 санхүүгийн жилээс эрчимтэйгээр эхэлнэ

Орон нутаг: Улаанбаатар хотоос эхлэн эрчимтэй хэрэгжилтийг …; 2003 санхүүгийн жилээс … [бусдыг шат дараатайгаар …?]

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЕРӨНХИЙ САЙД, ЭРХЭЛСЭН САЙД (ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ)

Оршил

24. Засгийн газар нь стратегийн зорилт (өөрөөр хэлбэл Засгийн газрын хэмжээнд болон салбарын түвшинд хүрэх үр дүн) болон уг стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн бодлогыг боловсруулах үүрэгтэй. Стратегийн зорилт нь төсвийн, эдийн засгийн болон нийгмийн талаар хүрэх үр дүнгүүдийг багтаажбайгаа билээ. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилтын үүднээс Засгийн газар Улсын Их Хурлаар дараахь бичиг баримтуудыг батлуулахаар хүргүүлнэ. Үүнд:

- Засгийн газрын стратегийн зорилтууд, төсвийн хүрээний үзүүлэлтүүдийг багтаасан, төсвийн удирдлагын зарчимд нийцсэн Төсвийн хүрээний мэдэгдэл;
- Стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн Засгийн газрын бодлого (төсвийн удирдлагын зарчим болон Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн), улсын төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох тухай хуулийн төслийг багтаасан төсвийн баримт бичиг;
- Улсын Их Хурлаар батлуулахаар өргөн барих эрхэлсэн сайд төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргасан төсвийн төсөл. Энэхүү бичиг баримт нь нөөцийг ашиглах талаар тодорхой үзүүлэлтүүдийг багтаасан байна. Тухайлбал:
  - нийлүүлэх бүтээгдэхүүн анги бүрээр;
  - улсын төсөөс үзүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад шилжүүлэг;
  - өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах зардал;
  - улсын төсөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт (өр, өмч, улсын нэрийн өмнөөс хөрөнгө худалдан авах);
  - Засгийн газрын стратегийн зорилттой хэрхэн уялдаж буйг харуулах.

25. Засгийн газар, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч), төсвийн байгууллагууд жилийн тайлан гаргахдаа дараахь чиглэлээр тайлагнана:

- УИХ-аас олгогдсон төсөв зарцуулах бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлсэн
- Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан Засгийн газрын стратегийн зорилт болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) бүрээр гаргасан төсвийн төсөлд тусгагдсан стратегийн зорилтын хэрэгжилт.

26. Шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр Ерөнхий сайд, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) өөрсдийн үүрэг, хариуцлагыг шинэ хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлага гарах юм. Ерөнхий сайд төсвийн ерөнхийлөн захирагч нарт шинэчлэгдсэн төсвийн удирдлага, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд тэдний гүйцэтгэх үүрэг, амжилттай хэрэгжүүлэхэд тэдэнд тавигдах шаардлага зэргийг энд тусгайлан авч үзэв.

Ерөнхий сайд

27. Засгийн газрын тэргүүний хувьд Ерөнхий сайд шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Ерөнхий сайд нь төлөвлөлт, санхүүгийн болон удирдлагын талаар эцсийн шийдвэр гаргагч байна. УИХ-тай ажлын уялдаа холбоог хангахад Ерөнхий сайд гол хүн нь байдаг.

28. Сайн засагчлалыг бэхжүүлэх талаар хандивлагчидтай хамтран ажиллах асуудлыг Ерөнхий сайд хариуцан зохицуулна. Шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын цар хүрээ, хязгаарыг харахад энэ нь хандивлагчдын ажлын уялдаат хангахад чиглэгдсэн "Хүний аюулгүй байдал, сайн засагчлалын хөтөлбөр"-ийн зохион байгуулалтын бүтцийн хоёр салбарыг хамарч байгаа билээ (тухайлбал "эдийн засгийн шилжилт" нь бусад асуудлын дундаас санхүүгийн асуудалтай, "засаглал" нь зарим талаараа захиргааны болон удирдлагын талаархи өөрчлөлттэй хамаатай). Иймд эдгээрийн уялдаа холбоог хангах нөхцөлийг бүрдүүлэх нь Ерөнхий сайдын анхаарах асуудал юм.

Шинэчлэлтэй холбогдон тавигдах шаардлага

29. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Ерөнхий сайдын эрх хэмжээг дараахь байдлаар тодорхойлсон байна:

- Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүлэх чиглэл, стратегийн зорилтыг тодорхойлж, төсвийн төсөл, удирдамж нь эдгээр зорилттой хэрхэн уялдаж байгааг ерөнхий хяналт тавина. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эдгээр асуудлыг тодорхой хэмжээнд тусгасан боловч энэхүү баримт бичгийг дахин хянан үзэх стратегийн зорилтыг тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бодлогоос нь ялгаж заагласн хэрэгтэй юм;
- Төсвийн удирдлагын шинэ зарчмыг хэрэгжүүлэх, эдгээр зарчим нь төсвийн төсөлд бүрэн тусгалаа олсон байдалд хяналт тавина. Эхний ээлжинд одоогийн бүртгэлийн тогтолцоотой уялдсан зарчим (мөнгөн суурьт үндэслэсэн)-ыг тодорхойлно. Мөнгөн суурьт үндэслэсэн, бүрэн нэгтгэгдээгүй[2] үндсэн

[2] *"Бүрэн нэгтгэдээгүй" гэдэг нь нэг талаас төсвийн бүх байгууллагуудын болон улсын шинжтэй ажил үүлдэзэг бүгдийг нь нэмсэн ч нөгөө талаас төвлөрсөн төсвийн байгууллагуудын хооронд (төрийн өмчит үйлдвэрийн газрыг хамрах боловч орон нутгийн төсвийн байгууллагуудыг оруулалгүйгээр) гарсан ажил үүлдэзнүүд устгаддагүй гэсэн үг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл зарим тохиолдолд орлого, зарлагыг улүү тусгасан байдаг гэсэн үг юм.*

үзүүлэлтүүд (тухайлбал, нийт орлого, зарлага, илүүдэл, дутагдал болон өр)-ийн гурван жилийн таамаглалыг энэ багтаасан байна. Засгийн газрын тайлан тэнцлийг гаргаагүй байгаа тохиолдолд цэвэр өмчийг тодорхойлох боломжгүй байдаг. Харин аккруэл (хуримтлуулсан) суурьт бүртгэлийн зарчмыг хэрэгжүүлснээр үүнийг хийх боломжтой болох юм; Төсвийн төслийг шинэ аргаар боловсруулах асуудлыг хариуцах. Төсвийн төсөлд тухайн эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -ийн эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газраас дэвшүүлж байгаа стратегийн зорилтууд, эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд авч явуулах бодлого, арга хэмжээ, эдгээр бодлого нь сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт болон Засгийн газрын стратегийн зорилттой хэрхэн уялдаж буйг тус тус харуулсан байна. Төсвийн баримт бичгийн нэг хэсэг болох төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр боловсруулсан төсвийн төслийг Ерөнхий сайд УИХ-д өргөн барина. УИХ -аас батална төсвийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -аас ямар үр дүнг хүлээж буйг тодорхойлохоо энэхүү төсвийн төсөл гэсэн баримт бичиг Ерөнхий сайдын хувьд маш чухал хэрэгсэл болж өгнө;

Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -ын ажлын гүйцэтгэлд хяналт тавих. Засгийн газрын тухайн жилийн тайланг Ерөнхий сайд УИХ-д өргөн барина. Энэхүү тайланд Засгийн газрын хэмжээнд эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) тус бүрийн ажлын гүйцэтгэлийг хураангуйлан харуулсан байна. Иймээс уучлаас УИХ-аас батална төсөвт тусгагдсан үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд Ерөнхий сайд тогтмол хяналт тавьж байх нь чухал юм;

Засгийн газраас гаргах сонгуулийн өмнөх мэдэгдлийг хариуцах. Сонгууль явагдах едрээс нэг сараас доошгүй хугацаа (2004 онд)-ны өмнө улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаарх мэдэгдлийг Засгийн газрын нэрийн өмнөөс Ерөнхий сайд УИХ-д өргөн барина;

Орон нутгийн засаг захиргаа, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргатай ажлын уялдаа хангах.

Шинэчлэлийгхэрэгжүүлэхзад гүйцэтгэх үүрэг

30. Шинэчлэлийг хэрэгжүүлэхзад Ерөнхий сайдын гүйцэтгэх үндсэн үүрэг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь баримт бичгээр дамжуулан хянахад оршино. Үүнд:

Улсын төсөв;

Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -ын төсөв;

Төвлөрсөн төсвийн байгууллагын бизнесийн стратегийн удирдамж;

Төрийн өмчит ба төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн зорилтын санал;

Төвлөрсөн төсвийн байгуллага ба бусад байгууллагууд (орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төсвийн байгуллага болон бусад)-аас хүдалдан авах бүтээгдэхүүн.

31. Санхүү, эдийн засгийн сайд болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -ын зүгээс авч явуулж буй арга хэмжээ болон өгч буй зөвлөгөө нь хэрэгжүүлэлттэй холбоотой дээрх тусгай үүрэг, хариуцлагыг гүйцэтгэхэд чухал юм. Гэхдээ энэ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон хэрэгжүүлэх явцад дээр дурдсан баримт бичгийг боловсруулах эхний үе шатанд дээрх арга хэмжээнүүдийн талаар Ерөнхий сайдын УИХ-ын өмнө хүлээх хариуцлагыг бууруулахгүй юм.

32. Ерөнхий сайдаас өргөн барих Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын төсөв, Засгийн газрын жилийн эцсийн тайлан нь эхний үед шинэчлэлийн шаардлагуудыг бүрэн гүйцэд хангах боломжгүй юм. Ялангуяа дараахь баримт бичгийн хувьд хамааралтай. Үүнд:

Аккруэл сууриар бэлтгэн нэгтгэсэн санхүүгийн тайлан,

Аккруэл суурьт үндэслэсэн төсвийн удирдлагын зарчим.

33. Харин төвлөрсөн төсвийн гол, ач холбогдол бүхий байгуллагууд болон төрийн өмчит ба төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь төсөвлөсөн болон гүйцэтгэлийн санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бэлтгэсэн, Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүрэн хэмжээний программ хангамжийг суурилуулан тохиолдолд энэ нь боломжтой юм. Дэлхийн банкнаас санхүүжүүлж буй Санхүү, эдийн засгийн яамны дэргэдэх Төсвийн техникийн туслалцаны төсөл энэхүү программ хангамжийн асуудлыг хариуцан ажилнана.

34. Ерөнхий сайд орон нутгийн түвшинд шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөлдөх, түүний хэрэгжилтэд ерөнхий хяналт тавих үүрэгтэй. Ялангуяа дараахь асуудлаар орон нутгийн захиргаа (тухайлбал аймаг, нийслэлийн Засаг дарга нар)-тай зөвлөлдөх нь чухал:

Орон нутгийн түвшинд шинэчлэлийг хэрэгжүүлэх хуваарь;

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө, орлогыг ялгаж заалгах, төсвийн байгууллагыг төвлөрсөн болон орон нутгийн гэдгээр нь ялгах;

Орон нутгаас төрд нийлүүлэх бүтээгдэхүүн (жишээ нь эрүүл мэнд, боловсролын талаар үзүүлэх үйлчилгээ) болон төвлөрсөн төсвийн байгуллагаас орон нутагт төлбертэй нийлүүлэх бүтээгдэхүүн (жишээ нь татвар хураах, аудит хийх г.м.)-ийг заалгах.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

35. Шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын гол төв нь Ерөнхий сайд байх бөгөөд түүний өмнө хэд хэдэн шаардлага тавигдах юм. Төсвийн ерөнхийлөн захирагчид (эрхэлсэн сайд) өөрсдийн үүрэг хариуцлагыг хэрхэн биелүүлснээс Ерөнхий сайдын өмнө тавигдаж буй эдгээр шаардлагууд хангагдах эсэх нь хамаарна. Тавигдах шаардлагууд:

Шинэчлэл болон түүний үр нөлөөг олон нийтэд суртал члах/танилуулахад Ерөнхий сайд тэргүүлэх үүрэгтэй байна. Олон нийтэд таниулах ажлыг улсаас үзүүлж буй үйлчилгээг хүртэг иргэд, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, төлөөлөн удирдах зөвлөл, мэргэжлийн байгууллагууд, хувийн аж ахуйн нэгжүүдэд зориулан зохион байгуулах хэрэгтэй. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар энэ ажилд тодорхой дэмжлэг үзүүлэх ёстой (энэ талаар доор дэлгэрэнгүй өгүүлэв) .

Ерөнхий сайдын идэвхи чармайлтад шууд дэмжлэг үзүүлэх. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлыг Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөхүүдийн нэгэнд хариуцуулан энэ ажилд бүрэн

орон тоогоор ажиллуулах замаар шаардагдах дэмжлэгийг үзүүлэх боломжтой. Шуурхай ажлын хэсэг нь бүрэн орон тоогоор ажиллах, чадварлаг ажилтнуудаас бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд нь Санхүү, эдийн засгийн яам, Төрийн захиргааны албаны зөвлөл (доод тал нь нэг хүн), Төрийн хяналт шалгах хороонооc тус тус хэд хэдэн хүн орохоос гадна техникийн туслалцааны төслийн багууд (тухайлбал Төрийн захиргааны шинэтгэлийн төслийн баг, Орон нутгийн техник туслалцааны төслийн баг, Төсвийн зарлагын удирдлагын Техникийн туслалцааны төслийн баг, Дэлхийн банкны Төсвийн техник туслалцааны төслийн баг)-аас бүрдэх юм. Шуурхай ажлын хэсэг нь сайдын зөвлөх, төсвийн байгууллагын төлөвлөлт, санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнтэй хамтран ажиллана. Дор дурдсанаар эдгээр нь шинэчлэлийг хэрэгжүүлэх төслийн үндэсэн багийг бүрдүүлэх юм. Энэ талаар холбогдох бүлэгт дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Ерөнхий сайдад дараахь асуудлаар (Санхүү, эдийн засгийн сайдтай хамтран) зөвлөгөө өгөх.

Үүнд: Засгийн газрын стратегийн зорилтууд, төсвийн удирдлага (ба холбогдох төсвийн үндэсэн үзүүлэлтүүд)-ын зарчим, тухайн жил болон ойрын хоёр жилийн мөнгөн сууръ үндэслэн бэлтгэсэн төсвийн үндэсэн үзүүлэлтүүд (боломжит мэдээлэл дээр үндэслэсэн)-ийн таамаглал. Төсвийн хүрээний мэдэгдлийг бэлтгэж эхлэхэд эдгээр зөвлөгөө нь зайлшгүй шаардлагатай билээ. Түүнээс гадна энэ нь 2002 оны төсвийг зохиоход стратегийн болон төсвийн үндэс суурь нь болох юм. Ерөнхий сайд нь Төсвийн хүрээний мэдэгдлийг 2001 оны 6 дугаар сарын 1 гэхэд өргөн барьсан байна. Үүний тулд 2001 оны 5 дугаар сард Засгийн газар Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж дүгнэлт гаргасан байна. Төсвийн хүрээний мэдэгдлийг бэлтгэх ажлыг Санхүү, эдийн засгийн сайд хариуцан явуулна;

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) тус бүрт Ерөнхий сайдын зүгээс тавих шаардлагыг тусгасан *баримт бичгийг* баталж, мөрдүүлэх. Баримт бичигт дараахь зүйлийг багтаасан байна: мөрдөх хугацаа, тухайн эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -ын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын ажлын үялдаа холбоо, сайд нарын ажилд үзүүлэх дэмжлэг тусламжаа;

Засгийн газрын удирдамжид тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын явц ямар байгаа талаар шуурхай ажлын хэсэг сар бүр Ерөнхий сайдад тайлагнаж байна. Хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд Ерөнхий сайдаас санал болгож буй авах арга хэмжээний талаар дээрх тайлангийн хамт Засгийн газрын гишүүдэд хүргүүлнэ;

Төв болон орон нутгийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөр, нийлүүлэх бүтээгдэхүүнийг ялгаж, заагласан талаар шийдвэр гаргахад орон нутгийн удирдлагатай зөвлөлдөх ажлыг зохицуулах талаар авч явуулах арга хэмжээг тодорхойлох. Тодорхой асуудал (тухайлбал эрүүл мэнд, боловсрол, аудит, статистик)-аар холбогдох эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нь Ерөнхий сайдад тусламжаа үзүүлнэ;

Сайн засагчаллын тогтолцоог бий болгох хөтөлбөрийн үйл ажиллагаог шинэчлэлийг хэрэгжүүлэх ажилд дэмжлэг тусламжаа үзүүлэхэд чиглүүлэх. Шинэчлэлийг хэрэгжүүлэх ажил нь энэ хөтөлбөрийн хоёр гол хэсэг (эдийн засгийн шилжилт, засаглал)- тэй холбогдож байгаа тул хэрэгжүүлэх ажил хариуцаж буй албан тушаалтан явцын талаар Ерөнхий сайд (Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарын дэмжлэгтэйгээр)-д шуудхайлгана.

36. Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн нэг үндэс бол удирдлагын шинэ тогтолцоог нэвтрүүлэхэд оршино. Энэ тогтолцоо нь зөвхөн хуулиар тавигдах шаардлагыг хэрэгжүүлэх тедийд чиглэгдсэн тогтолцоо биш, харин удирдлага, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх ниймигийн бодит шаардлагыг ханган хангах чиглэгдсэн тогтолцоо байх ёстой.

Санхүү, эдийн засгийн сайд

37. Санхүү, эдийн засгийн сайд нь дараахь асуудлыг шийдвэрлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ. Үүнд: төсөв зохиох, Засгийн газраас санхүүжүүлж буй хөрөнгө оруулалтад хяналт тавих, Засгийн газрын санхүүжилтийн ажлыг удирдана. Санхүү, эдийн засгийн сайд нь Ерөнхий сайдын нэгэн адил Засгийн газрын үйл ажиллагаа (ялангуяа бүтээгдэхүүн худалдан авах, Төсвийн хүрээний мэдэгдэл бэлтгэх бэлтгэхэд Засгийн газрын төсвийн хүрээнд санхүүжилтийг барьж байх)-нд хяналт тавихад тусламцаа үзүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаа, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөнд ерөнхий хяналт тавина.

Шинэчлэлтэй холбогдон тавигдах шаардлага

38. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Санхүү, эдийн засгийн сайдын гүйцэтгэх үүрэг:

Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах ажилд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр боловсруулсан төсвийн төсөлтэй танилцаж хянах;

Засгийн газрын санхүүгийн байдалд хяналт тавих, тогтмол тайлагнах;

Санхүүгийн удирдлагын талаар гаргасан заавар, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

Санхүүгийн болон хөрөнгийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй эсэх талаар Засгийн газрт мэдээлж байх;

Төвөлтөөлөлтийг болон хөрөнгө оруулалтын талаар бариментлах бодлогыг тодорхойлох, эдгээр бодлогыг төсвийн удирдлагын зарчим ба төсвийн хүрээнд хэрэгжүүлэхэд хяналт тавих

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн хувьцаа хэмжилгийн эрхийг Санхүү, эдийн засгийн сайд хэрэгжүүлнэ. Санхүү, эдийн засгийн сайд нийт төрийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн дүн, тэдгээрээс төсвийн байгууллагуудын санхүүгийн байдал, мөнгөн хөрөнгийн гүйлгээнд үзүүлэх нөлөөний төлөө хариуцлага хүлээнэ.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

39. Шинэчлэлтэй холбогдон Засгийн газарт хэд хэдэн шинэ үүрэг нэмэгдэж байна. Санхүүгийн ил тод байдлыг бий болгож, бодлогын тэргүүлэх чиглэл (ялангуяа нийлүүлэх бүтээгдэхүүний хувьд)-ийг илүү тодорхой болгох нь Санхүү, эдийн засгийн сайдыг эдгээр шинэ үүргийг гүйцэтгэхэд голлох үүргэтэй болгож байна. Жишээ нь, Санхүү, эдийн засгийн сайд Төсвийн хүрээний мэдэгдэл болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) бүрээр гаргасан төсвийн тесгийг Засгийн газарт хүргүүлэх хариуцлагыг хүлээнэ. Түүнээс гадна улсын хэвшлийн санхүүжилт болон санхүүгийн удирдлагыг сайжруулах талаар санал боловсруулах

болон түүнд хяналт тавихад Санхүү, эдийн засгийн сайд тэрүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Шинэчлэлийг хэрэгжүүлэх нь Санхүү, эдийн засгийн сайдын үндсэн үүрэг бөгөөд.

40. Энэ үүргийг гүйцэтгэхдээ Санхүү, эдийн засгийн яам, шуурхай ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр Санхүү, эдийн засгийн сайд болон Ерөнхий сайдтай хамтран ажиллаж, тэдний өмнө хариуцлага хүлээнэ.

Ажилттай хэрэгжүүлэх үндэс

41. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Санхүү, эдийн засгийн сайдын өмнө тавигдах шаардлага:

- Төсвийн хүрээний мэдэгдэл дээр эртнээс ажиллаж эхлэх. Төсвийн хүрээний мэдэгдлийн эхний тесплийг Засгийн газарт хүргүүлж, холбогдох саналын дагуу төсвийн хүрээний мэдэгдэлд шаардлагатай өөрчлөлтийг оруулах, 2001 оны эхний хагаст багтаан энэ мэдэгдлийн талаар эцэслэн тохирсон байна;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай бичгээр тохиролцсон байна. Үүнд:
  - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэхэд Санхүү, эдийн засгийн сайд, Санхүү, эдийн засгийн яамандз тавигдах тодорхой шаардлагуудыг биелүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний тесплийг боловсруулах. Уг төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл явцтай холбоотой бүх асуудлыг тусгасан байна. Төлөвлөгөө боловсруулахад шуурхай ажлын хэсэг дэмжлэг үзүүлнэ. Төлөвлөгөөг Ерөнхий сайдад танилцуулна;
  - Ирэх гурван жилийн санхүүгийн зорилтуудын талаар төсвийн удирдлагын зарчимд нийцсэн зөвлөгөө өгөх, эдгээр зорилтуудыг боловсруулах арга барил;
  - Ерөнхий сайдын ажлын албатай хамтран Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, байгаа нөөцийг хуваарилах;
  - 2002 оны төсвийг зохиоход нь төвлөрсөн төсвийн байгууллагуудад туслах заавар удирдамжийг шуурхай ажлын хэсэгтэй хамтран боловсруулах. Эдгээр заавар, удирдамж нь шинэчлэлийн шаардлага болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн нийцсэн байна;
  - Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -тай байгуулсан гэрээ болон Төсвийн тесэл, Бизнесийн стратегийн төлөвлөгөөний дагуу нийлүүлэгдсэн бүтээгдэхүүний төлбөрийг төсвийн болон бусад байгууллагуудад хийсэн байх нөхцөлийг хангах үүднээс эсхүүлэлтын арга хэмжээг тодорхойлох;
  - Төвлөрсөн төсвийн байгууллагуудын ерөнхий менежерийн эрх мэдэл (мөнгөн хөрөнгийн удирдлага, банкны данс нээх, хөрөнгийн удирдлага, боловсон хүчний асуудлаар)-ийг нэмэгдүүлэх талаар Санхүү, эдийн засгийн сайдад зөвлөгөө өгөх;
  - Эдийн засаг, санхүүгийн үр дагавар бүхий асуудлаар Засгийн газарт оруулах саналыг хянан үзэж, сайдад зөвлөгөө өгөх;
  - Засгийн газраас олгох санхүүжилт, хөрөнгө оруулалт, мөнгөн хөрөнгө (зээл авах, үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгсэл гаргах, зээлийг эргэн төлөх, банкны данс нээх)-ийн удирдлагын талаар зөвлөгөө өгөх;
  - Улсын шинжтэй хөрөнгө, төсвийн нөөц, санхүүгийн эрсдэлийг удирдахад чиглэгдсэн санхүүгийн удирдлагын тогтолцооны талаар зөвлөгөө өгөх;
- **Ерөнхий сайдын зүгээс тавих шаардлага**. Шинэчлэлийн шаардлага болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр боловсруулсан төсвийн төсөл, бизнесийн стратегийн удирдамж, үр дүнгийн гэрээ, төвлөрсөн төсвийн байгууллагуудын тайлан, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд үнэлгээ хийж, баримт бичгүүдийг боловсруулж дуусгах хугацаа зэрэг нь тодорхой, ойлгомжтой байх нөхцөлийг хангах үүднээс Ерөнхий сайдын оролцоотойгоор эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-тай хамтран ажиллах;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлснээр гарах өөрчлөлтийг олон нийтэд таниулах, суртал члахтай холбоотой илтгэл тавих, үг хэлэх болон бусад ярилцлага (УИХ-ын гишүүд, иргэд, мэргэжлийн болон бизнесийн байгууллагуудтай)-д оролцох;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад гарч буй асуудал (эдгээр нь Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх хүрээний асуудалтай холбоотой тохиолдолд) шаардлагатай тохиолдолд түүнийг шийдвэрлэх талаар санал, зөвлөгөөг шуурхай ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр Санхүү, эдийн засгийн яам болон Санхүү, эдийн засгийн сайдад өгч байх.

эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)

42. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нь ямагайаа шууд холбоотой ажиллах бөгөөд энэ нь шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хөдөлгөх хүч нь болох юм. Нөөц хязгаарлагдмал, бодлогын хувьд сонголт хийхэд бэрхшээлтэй нөхцөлд төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ нь чанартай, хүртээмжтэй байлгах талаарх шаардлага хамгийн их тавигдах субъект нь эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар юм. Өнөөгийн байдлаар эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын эрхлэх хүрээний асуудал (салбар)-ын түвшинд зорилго нь тийм ч тодорхой бус, мөн түүнчлэн түүнийг биелүүлэхэд чиглэгдсэн бодлого (нийлүүлэх бүтээгдэхүүний оролцуулан) нэлээд сул тодорхойлогдоогүй байна. Санал болгож буй бодлого болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийн хооронд зайлшгүй байх ёстой уялдаа холбоо сайнгүй байна. Иймээс эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар шинэчлэлийг түргэн хэрэгжүүлж эхлэх сонирхолтой байгаа юм.

Шинэчлэлтэй холбогдон тавигдах шаардлага

Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын эрх хэмжээ дараахь байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Өөрийн эрхлэх хүрээний асуудлын төсвийн тесплийн талаар мэдлэгтэй болох, боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх, мөн түүнчлэн сонгуулийн өмнөх мэдэгдэлд өөрийн оруулах хувь нэмрийг ойлгож мэдэх;
- Эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтуудыг дэвшүүлэх;
- Төсвийн ерөнхийлөн захирагч хариулах асуудлын хүрээнд удирдлагын талаар эрхийг хэрэгжүүлэхдээ төсвийн удирдлагын зарчим, энэ нь төсвийн төсөлтэй хэрхэн уялдаж байгаа болон түүнд ямар нөлөө үзүүлж буй зэргийн талаар ойлголттой байх;
- Эрхлэх асуудлын хүрээнд шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, нийгмийн бодлогын талаар баримтлах жилийн болон дунд хугацааны үзүүлэлтүүдийг боловсруулах, эдгээр нь төсвийн

ерөнхийлөн захирагч (эрхлэх сайд)-ийн төсвийн төсөлд тусгагдсан байна;

- Бизнесийн стратегийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, шаардлагатай бол зорилтын саналыг боловсруулахад тавигдах шаардлагын талаар ерөнхий менежертэй хамтран ажиллах;
- Эрхлэх хүрээний асуудлын төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны тайланг хянах;
- Төрийн захиргааны албаны зөвлөлөөс гаргасан саналыг үндэслэн ерөнхий менежерийг томилох талаар Засгийн газарт санал оруулах;
- Өөрийн эрхлэх хүрээний асуудлын байгууллагуудын жилийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар Засгийн газарт болон УИХ-д тайлагнах.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын анхаарах зүйл бол:

- Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Засгийн газар хэлэлцэхэд, ялангуяа Засгийн газрын стратегийн зорилт, шийдвэр, санхүүгийн үзүүлэлтүүд (төсвийн удирдлагын зарчим), тухайн эрхлэх асуудлын хүрээнд ирэх гурван жилд нөөцийг хуваарилах талаархи шийдвэрийн төслийг хэлэлцэхэд хувь нэмэр оруулах чадвартай байх;
- Төсвийн төслийг боловсруулахдаа эрхлэх асуудлын хүрээнийхээ стратегийн зорилт (хүрэх үр дүн)-ыг тусгаж, түүнийг Засгийн газрын стратегийн зорилттой уялдуулж, бодлого (бүтээгдэхүүнийг оролцуулан)-ыг нарийн тодорхойлсон байх, бодлого нь эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтыг биелүүлэхэд зохих хувь нэмрийг оруулахаар байх, Засгийн газраас батлагдсан төсвийн хүрээнд нөөцийг зарцуулах зэрэг асуудлыг анхаарсан байх шаардлагатай;
- Шинэчлэлтэй холбогдон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-д гаргаж өгөх тайлан, авах арга хэмжээний талаар өгөх санал зэргийг бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх удирдлага, хяналтын тогтолцоо бий болгох ажил хийгдэж буй эсэх талаар яамны Төрийн нарийн бичгийн дарга болон агентлагийн ерөнхий менежертэй хамтран ажиллах;
- Өөрийн эрхлэх хүрээний асуудлатай холбоотой төв болон орон нутгийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөр, нийлүүлэх бүтээгдэхүүнийг ялгаж, зааглах талаар гарах асуудлыг шийдвэрлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах.

Ажилттай хэрэгжүүлэх үндэс

43. Ерөнхий сайд, Санхүү, эдийн засгийн сайд болон шуурхай ажлын хэсчийн зүгээс шинэчлэлийг хэрэгжүүлэхэд нь эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-д ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Мөн түүнээс гадна яамны зүгээс эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) -д байнга дэмжлэг туслалцаа үзүүлж байна.

44. Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхэд эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын голлон анхаарах хэсэг бол:

- Хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, шинэчлэлтэй холбогдон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын өмнө тавигдах шаардлага зэргийг сайтар ойлгосон байх. Хэрэгжилтийн чухал үе шат эхлэхээс өмнө Ерөнхий сайд болон холбогдох яамны зүгээс эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ыг холбогдох мэдээллээр хангах замаар түүнд дэмжлэг үзүүлнэ;
- Өөрийн эрхлэх хүрээний асуудлын байгууллагуудад шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө (хэрэгжүүлэх стратегид тусгасан ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан) боловсруулах. Энэ төлөвлөгөөг Ерөнхий сайд, Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад танилцуулж холбогдох яамны туслалцаатайгаар боловсруулна;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь бүтээгдэхүүнийг эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-д холбогдох яам нь нийлүүлэн байх талаар бичгээр тохиролцоно. Үүнд:
  - Эрхлэх хүрээний асуудлын хүрээнд шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө;
  - Төсвийн байгууллагууд бизнесийн стратегийн төлөвлөгөө болон тайлан гаргахад хяналт тавих, түүнд дэмжлэг үзүүлэх;
  - Эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт болон түүнийг биелүүлэхэд чиглэгдсэн бодлого (стратегийн зорилт, бодлого, бүтээгдэхүүний хоорондын уялдаа холбоо)-ын талаар зөвлөгөө өгөх;
  - Засгийн газрын стратегийн зорилтод оруулж буй хувь нэмэр болон эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтын хэрэгжилтийг хэмжих системийг бий болгох болон түүний хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгөх;
  - Эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага бүрийн бодит гүйцэтгэл нь бизнесийн стратегийн төлөвлөгөөтэй харьцуулахад ямар үр дүнд хүрсэн болон энэ нь эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны үр дүнд ямар үр нөлөө үзүүлж буй талаар зөвлөгөө өгөх;
  - Сайдын тодорхойлсон бодлого нь хэр өгөөжтэй байгаа, ирээдүйд тодорхойлон гаргасан бодлого нь ямар үр дагавартай байх талаар үнэлгээ өгөх;
- Ажлын төлөвлөгөөтэй уялдсан дараахь зүйлийг нийлүүлэх талаар өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг бүрийн ерөнхий менежертэй бичгээр тохиролцох:
  - Бизнесийн стратегийн төлөвлөгөө, зорилтын саналыг боловсруулж, хянуулах, батлуулахаар хүргүүлэх;
  - Ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээний эхний хувилбарыг боловсруулах, түүнийг хэлэлцэх, батлах;
  - Санхүүгийн тайлангийн агуулга болон хуваарь;
  - Санхүү, эдийн засгийн яамны нэгтгэсэн Засгийн газрын санхүүгийн тайлангийн тогтолцоотой уялдсан бүтээгдэхүүнд суурилсан удирдлага, аккруэл буртгэлийн болон аккруэл суурь, бүтээгдэхүүнд үндэслэсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх.

Дүгнэлт

Засгийн газар шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлыг удирдан явуулна. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний яам, агентлагийн ерөнхий менежерүүд шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх үүрэг, хариуцлага, тэдэнд тавигдах шаардлагыг тодорхой болгож өгөх, тэдгээрийг биелүүлэх шаардлага тавина. Ингэхдээ шинэчлэлийн агуулга, зарчмыг мөрдлөг болгох бөгөөд энэ нь амжилттай хэрэгжүүлэх суурийг бий болгож өгнө.

Шаардлагатай тохиолдолд сургалт явуулах, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авна.

ТАВДУГААР БҮЛЭГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО БОЛОН ТӨРИЙН ХЯНАН ШАЛГАХ ХОРОО

45. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгох шинэчлэлийн хүрээнд Ерөнхий сайд, Санхүү, эдийн засгийн сайд болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нар өөрийн үүрэг, хариуцлагыг шинэ маягаар хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна. Үүнд Санхүү, эдийн засгийн яам, Төрийн захиргааны албаны зөвлөл, Төрийн өмчийн хороо дэмжлэг туслалцаа үзүүлэх юм. Үүний зэрэгцээ Төрийн хянан шалгах хороо төвлөрсөн төсвийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, Засгийн газрын санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг баталгаажуулах замаар шинэчлэлийг ерөнхийд нь гүнзийдүүлж, түс байгууллагуудын өдөр тутмын удирдлагад дэмжлэг үзүүлэх юм.

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ

46. Санхүү, эдийн засгийн яам нь Засгийн газрын стратегийн зорилт, төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар, эсхүл төрийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах явдлыг үл хайхран, зөвхөн орлого, зарлагыг хянадаг цорын ганц үүргэзэсэз татгалзах нь зүйтэй гэж үзэж байна. Яам нь улс орны эдийн засагт дунд хугацаанд томоохон нөлөө үзүүлж чадахуйц төсвийн удирдлагын зорилтуудыг бүрэн дэмжинэ. Гэвч төсөв боловсруулж, хянадаг өнөөгийн тогтолцоо нь алангуяа төсвийн хүндрэлтэй энэ үед төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар зөв зүйтэй үхаалаг шийдвэр гаргах хөшүүрэг болж чадахгүй байна. Энэ нь улсын хэвшилд хөрөнгийн ашиглалт, сайжруулалт муу, мөн чадварлаг боловсон хүчний нөөцийг бий болгох, хадгалж үлдээх боломж таарууртаас урт хугацаанд төрөөс иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чадварыг бууруулахад нөлөө үзүүлж болзошгүй юм.

47. Зарим тохиолдолд төвөөс гаргаж буй шийдвэрийг зохих мэдээлэл болон хөшүүрэг бүхий төсвийн байгууллагын түвшинд гаргах нь илүү оновчтой гэдгийг мөн хүлээн зөвшөөрч байна.

48. Эдгээр өөрчлөлт амар хялбар хийгдэх зүйл биш юм. Байгууллагын менежментэд томоохон өөрчлөлт оруулахын нэгэн адил Засгийн газрын төсвийн менежментийн өөрчлөлтийг хийхийн тулд соёл, хандлага, арга барил ихээхэн өөрчлөгдөх шаардлага гарна. Энэ нь ноуны тұрүүнд нөөц хуваарилах болон төсвийн талаар Засгийн газрын шийдвэр гаргадаг арга барилыг үндсээр нь өөрчлөхийг шаардана.

Шинэчлэлтэй холбогдон тавих шаардлага

49. Санхүү, эдийн засгийн яамны эрх хэмжээ дараахь байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Улсын төвлөрсөн төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох бодлого боловсруулах, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх;
- Засгийн газрын мөнгөний хөдөлгөөн, байршлыг удирдах;
- Хөрөнгийн төлбөрийн хувийг тогтоох, хянан үзэх;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн төсвийн байгууллагын бүртгэлийн бодлогыг тогтоох, хэрэгжүүлэх;
- Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн явцыг хянах;
- Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсвийн төсөл, түүнд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын саналыг боловсруулах–төсөв боловсруулах үе шатыг тогтоох, төсвийн баримт бичгийн загвар гаргах, холбогдох мэдээллийг гаргуулж авах, мэдээллийн үнэн зөв байдлыг хянах, бүтээгдэхүүнийг анги болгон нэгтгэх, макро эдийн засгийн болон бусад үзүүлэлтүүдийн тооцоо прогноз хийх, улсын төсөв батлах тухай (төсвийн ерөнхийлөн захирагч нарт төсөв зарцуулах эрх олгох тухай) хуулийн төсөл боловсруулах, батлагдсан хувилбарыг хэвлэн нийтлэх;
- Бүтээгдэхүүнийг тодорхойлох, өртгийг нь тооцох, бизнесийн стратегийн төлөвлөгөө боловсруулах, үр дүнгийн гэрээ байгуулах, хуралдан авах гэрээ байгуулах, зорилтын санал боловсруулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө өгөх, үнэлэх;
- Засгийн газар, төсвийн байгууллагын санхүүгийн тайланг энэхүү хуулийн шаардлагад нийцүүлэн гаргах зорилтыг хэрэгжүүлэх;
- Төсвийн байгууллагын бизнесийн стратегийн төлөвлөгөө, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн зорилтын саналыг хянах;
- Орон нутгийн төсвийг хянах;
- Бүтээгдэхүүний өртөг тооцоолох аргыг хянаж, энэ нь төсөв зохиох, тайлагналд хэрхэн нөлөөлөх талаар үнэлгээ өгөх;
- Засгийн газрын сонгуулийн өмнөх мэдэгдлийг боловсруулахад туслалцаа үзүүлэх;
- Сар бүрийн санхүүгийн тайланг хянах.

50. Яамны эдгээр эрх хэмжээ нь шинэчлэлтэй холбогдон тогтоосон Санхүү, эдийн засгийн сайдын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны түвшинд дэмжлэг үзүүлэх, чанартай зөвлөгөөгөөр хангахад оршино.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

51. Санхүү, эдийн засгийн яам нь шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хоёрдмол үүрэг гүйцэтгэнэ:

- Шинэчлэлтэй холбогдон тогтоосон Санхүү, эдийн засгийн сайдын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, зөвлөгөөгөөр хангах (Төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөл боловсруулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн (эрхэлсэн сайд) төсвийн төслийг хянах, нэгтгэх, улсын төсвийн гүйцэтгэлийг хянах, тайлагнах шаардлагууд, Засгийн газрын үлдэгдлийн тэнцлийг удирдах). Энэ нь дээрх эрх хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хийх алхмуудыг зохион байгуулж, удирдана гэсэн үг юм.
- Шинэчлэлийн дагуу төсвийн байгууллага болохын хувьд хуулийн шаардлагыг биелүүлэх, мөн зөвхөн яамтай холбоотой онцгой эрх хэмжээг хэрэгжүүлэх.

52. Энэхүү хөрдахь үүрэг нь бусад төсвийн байгууллагад үлгэр жишээ болох бөгөөд санхүүгийн удирдлагын шинэ тогтолцоог нарийвчлан төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагын үүднээс инээхэн ач холбогдолтой юм. Энэ үтааваа Санхүү, эдийн засгийн яам нь шинэчлэлийг хэрэгжүүлэгч тэргүүний байгууллага болох зорилт тавих нь зүйтэй юм. Мөн байгууллагын дотоодын менежментийн шилдэг загварыг харуулах ёстой.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

53. Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхэд Санхүү, эдийн засгийн яам дараахь зүйлийг анхаарч, хувь нэмэр оруулах юм:

- Дөрөвдүгээр бүлэгт тодорхойлсон Санхүү, эдийн засгийн сайдын шаардаж буй бүтээгдэхүүнийг нийлүүлэх, ялангуяа шинэчлэлийн санхүүгийн

менежменттэй холбоотой хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, төсвийн тухай шийдвэр болон гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах, бүтээгдэхүүнд суурилсан хяналтын тогтолцоонд багтино хугацаанд шилжих;

Дараах чиглэлээр ямны зохион байгуулалт болон чадавхийг бэхжүүлэх:

- Шинэчлэлийн үзэл санаа, тэдгээр нь Санхүү, эдийн засгийн яаманд хэрхэн нөлөөлөх талаарх ерөнхий ойлголт;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн менежментийн мэдээллийн системийг нэвтрүүлж хэрэгжүүлэх (төвлөрсөн төсвийн нэгтгэлийг хийх системийн бүрэндэхүүн хэсэг нь болох);
- төсвийн болон бусад байгууллагуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн санхүүжилтийг хийх системийг бий болгох;
- өрийг зохистой удирдах чадавхийг бэхжүүлэх, төсвийн байгууллагуудын хувьд "банкны" үүргийг гүйцэтгэх, банкны шинэ зохицуулалтаар дамжуулж менгэн хөрөнгийг зохистой удирдах:
- эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нараас ирүүлсэн хүрэх үр дүн болон бүтээгдэхүүнд суурилсан төсвийн саналыг хянах, мөн төсвийн байгууллагуудын санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаат хянахын тулд стратегийн бодлого тодорхойлох, түүнийг үнэлэх чадавхийг бэхжүүлэх;
- Санхүү, эдийн засгийн сайд, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) болон төсвийн байгууллагуудын санхүүгийн менежментийг сайжруулахад дэмжлэг болох зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.
- Санхүү, эдийн засгийн яамны бизнесийн стратегийн төлөвлөгөөг боловсруулж, түүндээ яамны шинэ ажил үүргийг (шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүтээгдэхүүнүүдийг оролцуулан) тодорхойлон, эдгээрийг хэзээ, хэрхэн яаж гүйцэтгэх, үүнтэй холбоотой чадавхийг хэрхэн бэхжүүлэх талаар дэлгэрэнгүй тусгана.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

54. Төрийн захиргааны албаны зөвлөл нь захиргааны чиг үүрэг бүхий байгууллагаас төрийн боловсон хүчний асуудлаар бодлого тодорхойлогч, зөвлөгөөгөөр хангагч байгууллага болж өөрчлөгдөх юм.

Шинэчлэлтэй холбогдон тавих шаардлага

55. Хуулийн дагуу Төрийн захиргааны албаны зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлэх болно:

- Шинэчлэлийн зорилго, агуулгад нийцүүлэн төрийн боловсон хүчний бодлогыг тодорхойлох;
- Төвлөрсөн төсвийн байгууллагуудын боловсон хүчний бодлого, практик үйл ажиллагаанд хяналт тавих;
- Төвлөрсөн төсвийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй боловсон хүчний бодлого, практик үйл ажиллагааны талаар мэдээлэл, тайлан шаардах, хүлээн авах;
- Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг тогтоох;
- Төрийн албанд ажиллах хүсэлтэй хүмүүсийн талаар судалгаа явуулж, мэдээллийн сан бүрдүүлэх, ялангуяа төсвийн байгууллагын ерөнхий менежер, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлж болох хүмүүсийн судалгааг гаргах;
- Төрийн удирдах албан тушаал, ялангуяа ерөнхий менежер болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохын өмнө сонгон шалгаруулалт хийж нэрсийн жагсаалт гаргах;
- Төрийн удирдах албан тушаалтан, түүний дотор төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдтэй хэлэлцээр хийж, хөдөлмөрийн гэрээ байгуулах санал оруулах;
- Төрийн өндөр албан тушаалтны цалингийн талаар санал боловсруулах;
- Төрийн удирдах албан тушаалтанд олгох үр дүнгийн урамшууллын талаар санал боловсруулах;
- Төрийн удирдах албан тушаалтан, түүний дотор төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гүйцэтгэлийн талаар үнэлгээ өгөх, авах арга хэмжээг тогтоох;
- Төсвийн байгууллагын ажиллагсдын түвшинд үр дүнд суурилсан боловсон хүчний удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах төлөвлөгөө, дүрэм журам боловсруулж, хэрэгжилтийг хянах;
- Ерөнхий менежерүүдтэй үүсэх хөдөлмөрийн харилцааны асуудлыг зохицуулах.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

56. Төрийн захиргааны албаны зөвлөл нь эхлээд төсвийн ерөнхийлөн захирагч (эрхэлсэн сайд) болон төсвийн байгууллагын ерөнхий менежерийн хооронд Үр дүнгийн гэрээ байгуулж, гарын үсэг зурууллахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Улмаар үг гэрээний гүйцэтгэлд үнэлгээ өгөх үүрэг чухал юм. Үүний зэрэгцээ байгууллагын түвшинд доод шатны үр дүнгийн гэрээнүүд байгуулан хэрэгжүүлэхэд ерөнхий менежер арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх шаардлага гарч болно. Энэ үттагаса менежментийн оновчтой арга барилыг нэвтрүүлэх, зөв хөшүүргийг бүрдүүлэх талаар Төрийн захиргааны албаны зөвлөл нь шийдвэрлэх үүрэгтэй байх болно.

57. Шинэчлэл гүнзгийрэхийн хэрээр Төрийн захиргааны албаны зөвлөлийн чиг үүрэг өргөжин, ерөнхий менежерийг сонгон шалгаруулах, түүнийг томилуулахаар нэр дэвшүүлэх үйл явцыг зохион байгуулна. Мөн Санхүү, эдийн засгийн сайдтай хамтран ерөнхий менежерт байгууллагын менежменттэй холбоотой эрх мэдлийг аажмаар шилжүүлэх, улмаар ерөнхий менежерүүдийг үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжих талаар санал боловсруулна.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

58. Шинэчлэлийн үйл явцтай холбогдон дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төрийн захиргааны албаны зөвлөл нь дараахь зүйлийг хийх шаардлагатай:

- Төрийн захиргааны албаны зөвлөлийн шинэ чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах;
- Хуулийн дагуу хүлээх чиг үүрэг, шаардлагын талаар гүнзгий ойлголттой болох;
- Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) болон төсвийн байгууллагуудад зориулан гарын авлага, заавар, төлөвлөгөө боловсруулах. Эдгээр баримт бичгүүд нь төсвийн байгууллагын оновчтой менежментийг бүрдүүлэх, үр дүнгийн тодрохойлт, түүний гүйцэтгэлийг үнэлэх, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) болон төсвийн байгууллагуудэд ашиглах

цогцолбор аргачлалын бүрэлдэхүүн хэсэг болох юм. Эдгээр баримт бичгүүдийг боловсруулахын тулд туршилтын таван байгууллага дээр хуримтлуулсан туршлагад үндэслэх боломжтой юм;

Санхүү, эдийн засгийн сайд, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) болон Төрийн өмчийн хороотой төсвийн байгууллагын ерөнхий менежер болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулж томилох асуудлаар нягт хамтран ажиллах;

Ерөнхий менежерүүдтэй хөдөлмөрийн харилцаа үүсгэж, зохицуулах. Энэ нь албан ёсны тогтмол харилцаа үүсгэх, ерөнхий менежерүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, ажил эрхлэлттэй холбоотой асуудлаар хамтран ажиллахыг хамарч байна;

Төрийн захиргааны албаны зөвлөлийн шинэ үүрэг хариуцлагыг хэрэжүүлэхийн тулд ямар чиглэлээр чадавхаа бэхжүүлэхийг тодорхойлох. Энэ нь олон улсын туршлага судлах, танилцах аялал хийх, тодорхой чиглэлээр зөвлөгөө авах зэрэг арга хэмжээ байна;

Бизнесийн стратегийн төлөвлөгөөг цаашид боловсронгуй болгох, улмаар шинэчлэлтэй холбогдон тавигдаж буй шаардлагыг бүрэн хэмжээнд хэрэжүүлэх;

Бизнесийн стратегийн төлөвлөгөөний биелэлтийн талаар Улсын Их Хуралд тайлагнаж, Ерөнхий сайдад холбогдох асуудlaар танилцуулга хийж, гарч буй бэрхшээл, тэдгээрийг даван туулахад авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөгөө өгөх.

Төрийн өмчийн хороо

59. Өнөөгийн байдлаар Төрийн өмчийн хороо нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаат хянаж, зохицуулах үүрэгтэй.

60. Төрийн өмчийн хороо нь Засгийн газрын тайлан тэнцэлд томоохон байр суурь эзлэх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжтэй холбоотой хэсгийн үнэлгээ болон санхүүгийн эрсдэлийн хувьд менежментийг нь сайжруулах талаар чухал үүрэгтэй юм. Энэ үүргийн хүрээнд төрийн мэдэлд байх шаардлагагүй гэж үзсэн төрийн өмчит аж ахуйн нэгжийг хувьчлах тал дээр ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

61. Зарим аж ахуйн нэгж нь цаашид ч төрийн өмчид үлдэх магадлалтай байна. Иймээс эдгээр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн хөшүүрэг бүхий хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх нь чухал юм. Энэхүү хариуцлагын тогтолцоог шинэчлэлийн шаардлага болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэх үүргийг Төрийн өмчийн хороо гүйцэтгэх юм.

62. Хороо нь төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлүүдийг чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх ажлыг Төрийн захиргааны албаны зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

63. Засгийн газрын санхүүгийн тайланг аккруэл зарчимд суурилуулан нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэх шаардлага тавигдах үед Төрийн өмчийн хороо нь төрийн эмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн төсөв болон гүйцэтгэлийн тайлан цаг хугацаандаа гарч байгаа, Санхүү, эдийн засгийн сайдын улсын шинжтэй орлого, зарлага, хөрөнгө ер төлбөрийн тайланд тусгагдах талаар хяналт тавина.

64. Эдгээр чиг үүргээ хэрэжүүлэхийн тулд Төрийн өмчийн хороо нь дараахь арга хэмжээг хэрэжүүлнэ:

- Өөрийн хүлээх чиг үүрэг, шаардлагын талаар гүнзгий ойлголттой болох;
- Шинэ үүрэг хариуцлагаа хэрэжүүлэхийн тулд ямар чиглэлээр чадавхаа бэхжүүлэхийг тодорхойлох, үүнд:
  - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд Зорилтын санал боловсруулах талаар зөвлөгөө өгч, арга зүйн удирдлагаар хангах;
  - Зорилтын саналыг үнэлэх арга, техник эзэмших;
  - Санхүү, эдийн засгийн сайдад Зорилтын саналтай холбоотой чанартай сайн зөвлөгөө өгөх чадвартай болох;
  - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх арга барил эзэмших;
  - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид төрийн төлөөллийг хэрэжүүлэхийн зэрэгцээ тэдгээрийнөдөр тутмын дотоодын үйл ажиллагаанд хутгалдахгүй байх;
- Байгууллагынхаа Бизнесийн стратегийн төлөвлөгөө боловсруулах, үүнд дараахь зүйлийг тусгах:
  - Нийлүүлэх бүтээгдэхүүн;
  - Эдгээр бүтээгдэхүүнийг хэрхэн яаж нийлүүлэх;
  - Байгууллагыг хэрхэн удирдах;
  - Гурван жилийн төсөвлөсөн санхүүгийн тайлан боловсруулах (эхний шатанд бүртгэлийн одоогийн системд тулгуурлана).
- Хорооны даргын бүюу ерөнхий менежерийн Үр дүнгийн гэрээний эхний хувилбарыг боловсруулах;
- Бизнесийн стратегийн төлөвлөгөөний биелэлтийг хангахад шаардагдах удирдлагын болон мэдээллийн системийг бүрдүүлэх.

Төрийн хЯнан шалгах хороо

65. Улсын Их Хурал болон төсвийн ерөнхийлөн захирагчийг санхүүгийн болон санхүүгийн бус найдвартай, санхүүгийн мэдээллэгээ хангах тал дээр бүх хүчин чармайлтаа төвлөрүүлнэ. Энэ нь боддогын талаар сонголт хийх, хариуцлага тооцоход шийдвэрлэх ач холбогдолтой юм. Төрийн хянан шалгах хороо, Улсын Их Хурал болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж буй санхүүгийн болон санхүүгийн бус (тухайлбал бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан) мэдээлэл нь бодит байдлыг үнэн зөвөөр тусгасан гэсэн батталгаат гаргаж өгнө. Хороо санхүүгийн хяналтын систем нь сайн гэсэн батталгаат давхар гаргах ёстой.

Шинэчлэлтэй холбогдон тавих шаардлага

66. Шинэчлэлийг бүрэн хэмжээгээр нь хэрэгжүүлэх үед Төрийн хянан шалгах хороо дараахь үүргийг хүлээнэ:

- Засгийн газрын санхүүгийн тайланд хөндлөнгийн хяналт хийж, үнэн зөвийг батталгаажулна[3]. Хяналтыг эхний шатанд өнөөгийн бүртгэлийн бодлогын хүрээнд хийж болох бөгөөд цаашдаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн

[3] *Аймаг, нийслэлийн хянан шалгах хороод орон нутгийн санхүүгийн тайланг баталгаажуулна.*

гүйцэтгэнэ;

Төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хөндлөнгийн хяналт хийж батлагаажуулна. Энэ нь үйл ажиллагааны аудитыг мөн хамарна (өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн нийлүүлэлтийн). Энэ нь мөн санхүүгийн дотоод хяналтын системийн аудитыг хамарна;

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хөндлөнгийн хяналт хийж батлагаажуулж болно. Энэ нь Зөрилтын саналын гүйцэтгэлд аудит хийнэ гэсэн үг юм;

Хөндлөнгийн хяналт (аудит) хийх горимыг тогтоох;

Хөндлөнгийн хяналт (аудит)-ын чанарыг хянах.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

67. Бүртгэлийн аккруэл зарчмыг бүрэн хэмжээгээр нэвтрүүлж эхлэхэд төсвийн байгууллага болон Засгийн газрын нээлтийн тайлан тэнцэл нь аль болох үнэн зөв байх шаардлагатай юм. Эдгээрийг төсвийн байгууллага, Засгийн газрын тайлан тэнцлийн хувьд Санхүү, эдийн засгийн яам бэлтгэх бөгөөд Төрийн хянан шалгах хороо бол нээлтийн тайлан тэнцэл нь үнэн зөв, найдвартай эсэхэд баталгаа гаргаж өгөх үүрэгтэй байна. Үүний зэрэгцүүз санхүүгийн дотоодын хяналтын систем нь шаардлагын хэмжээнд байгаа эсэх талаар үнэлэлт өгч, улмаар Улсын Их Хурал болон сайд нарт байгууллагуудын дотоод хяналт нь зохистой түвшинд байгаа талаар баталгаа гаргах юм. Мөн бүтээгдэхүүний өртгийг тооцсон аргачлал, түүнийг төсвийн байгууллагууд хэрхэн ашигласныг хянан үзэх юм.

68. Төсвийн байгууллагын хувьд Хороо өөрөө Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн шаардлагад нийцсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн гэдгийг нотлох ёстой. Төрийн хянан шалгах хорооны санхүүгийн тайланд Улсын Их Хурлаас тогтоосон хөндлөнгийн бие даасан аудитор дүгнэлт гаргана.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

69. Шинэчлэлтэй холбогдон өнөөгийн төрийн хяналт шалгалтын зарчмаас ихээхэн ялгаатай шинэ шаардлагыг тавьж байгаа. Анхан шатны гүйлгээ, баримт бичгийг нэг бүрчлэн үздэг аргаас аажмаар эрсдэлд суурилсан аудитын аргарүү шилжиж, улмаар Засгийн газрын болон төсвийн байгууллагуудын санхүүгийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд төвлөрөн ажиллах юм.

70. Иймхүү шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Төрийн хянан шалгах хороо нь дараахь арга хэмжээг авах шаардлагатай юм:

Хяналт шалгалтын өнөөгийн арга барилыг эргэн харж, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Аудитын тухай хуулиудын шаардлагад нийцэн арга барилыг гүнзгийрүүлэх талаар арга хэмжээ авах;

Аудиторуудад зориулан аудитын шинэ арга барилд нийцсэн гарын авлага, төлөвлөгөө боловсруулах;

Аудитын шинэ арга барилыг нэвтрүүлэхэд шаардагдах мэдлэг, үр чадвар, туршлагын талаар судалж Төрийн хянан шалгах хорооны бүтэц, чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулан УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулах;

2001 оны бизнесийн стратегийн төлөвлөгөөгөө хянан үзэж, шинэчлэлийн дагуу аудитад тавих шаардлагыг тусган, холбогдох өөрчлөлтийг оруулах, аудиттай холбоотой үйлчилгээг хэрхэн яаж нийлүүлэх талаар тайлбар гаргах.

Дүгнэлт

71. Энэхүү бүлэгт дурдсан төрийн төв байгууллагууд нь шинэчлэлийг хэрэгжүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй байна. Шинэчлэлийн дагуу болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) –ын зүгээс эдгээрт тавигдах шаардлагууд нь тов тодорхой байна. Эдгээр шаардлагын талаар холбогдох эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нартай, Төрийн захиргааны албаны зөвлөл болон Төрийн хянан шалгах хорооны хувьд Улсын Их Хуралтай тохиролцох хэрэгтэй юм. Шинэчлэлийн үзэл баримтлалын дагуу төрийн төв байгууллагууд нь шинэ арга барилыг хэрэгжүүлэхийн төлөө хариуцлага хүлээх юм. Чадавхи бэхжүүлэх шаардлага байгаа тохиолдолд шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг болон бусад талуудтай холбоо тогтоон, дэмжлэг туслалцаа авах болно. Шинээр хүлээх өөрчлөлт үүргээс гадна дээрх байгууллагуд нь төсвийн бусад байгууллагуудад тавих нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА

Төвлөрсөн төсвийн байгууллага гэж юу вэ

72. Төвлөрсөн төсвийн байгууллага гэдэг нь зах зээлд борлуулах бололцоотой бүтээгдэхүүн бүүу үйл ажиллагаа явуулдаггүй яам, Засгийн газрын агентлаг зэргийг хамарна. Хэрэв улсын төвлөрсөн төсвийн байгууллага нь зах зээлд борлуулах бололцоотой бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол энэ чиг үүргийг нь салгаж, төрийн өмчит үйлдвэрийн газар болгож өөрчлөн байгуулах ёстой болно. Төвлөрсөн төсвийн байгууллагад Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Тамгын газар, шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг байгууллагууд бартана.

Ерөнхий менежер гэж хэн бэ

73. Төсвийн байгууллага бүрийг ерөнхий менежер удирдана. Тэдгээр нь Төрийн нарийн бичгийн дарга, ерөнхий захирал зэрэг албан тушаалтнууд байх бөгөөд "ерөнхий менежер" гэсэн нийтлэг нэрээр тэмдэглэгдсэн болно.

Төвлөрсөн төсвийн байгууллага хэний өмнө хариуцлага хүлээх вэ

74. Төвлөрсөн төсвийн байгууллага бүр өөрийн эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-тай байна. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн

захирагч) нь зайлшгүй Засгийн газрын гишүүн байх албагүй юм.

75. Ерөнхийдөө эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) болон холбогдох яамны хооронд (бусад агентлагтай харьцуулбал) илүү шууд бөгөөд бодлогын чанартай харилцаа холбоо тогтох нь ойлгомжтой юм. Яам, агентлагийн үүрэг, хариуцлагын талаар доор тус тусад нь авч үзсэн болно.

76. Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) бус, харин төсвийн байгууллагууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх тул үүнтэй холбоотой хариуцлагыг төсвийн байгууллагууд хүлээнэ.

Яам

Төвлөрсөн төсвийн бусад байгууллагуудын нэгэн адил яамд нь эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нарт өөрийн эрхлэх асуудлаар нь бодлого боловсруулж, харьяа байгууллагуудыг удирдахад нь дэмжлэг үзүүлэх ёстой. Энэхүү дэмжлэг нь гол төлөв бодлого боловсруулах, харьяа байгууллагуудын нийлүүлж буй бүтээгдэхүүнийг үнэлдүүлэх, эдгээр байгууллагуудын санхүүгийн болон санхүүгийн бус үр дүнд төвлөрөх юм.

Шинэчлэлтэй холбогдон тавих шаардлага

77. Яамдын үүрэг хариуцлагад тодорхой хэмжээний өөрчлөлт орох юм. Яамд нь сайд нартайгаа илүү идэвхитэй харьцаж, сайдын тодорхойлох бодлого нь илүү үндэслэл сайтай болох юм. Яамдууд дараахь зүйлийг хийх болно:

- Хүрэх үр дүн, бүтээгдэхүүн, орцын менежментийн тухай шинэчлэлийн үзэл санаанд суурилсан бодлогын асуудлаар сайдад зөвлөгөө өгөх;
- Сайдад төсвийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, энэ асуудлаар Санхүү, эдийн засгийн яамтай хамтран ажиллаж, төсвийн холбогдох баримт бичгийг яамны заасан хугацаанд хүргүүлэх;
- Харьяа байгууллагуудын үр дүнгийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийхэд нь сайдад туслалцаа үзүүлэх, гарах үр дагаврыг тооцох. Үүнд эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтуудыг хангах, үүний тулд баримтлах бодлогын талаархи зөвлөгөөг хамруулна;
- Яамны бизнесийн стратегийн төлөвлөгөө боловсруулж, сайдтай тохиролцон гүйцэтгэлийн талаар тогтмол тайлагнах;
- Яамны Төрийн нарийн бичгийн дарга нь сайдтай Үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах, гэрээний гүйцэтгэлийн талаар сайдаар үнэлгээ өгүүлэх;
- Төрийн нарийн бичгийн дарга нь Төрийн захирагааны албаны зөвлөлтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;
- Холбогдох эрх мэдэл олгосны дараа Төрийн нарийн бичгийн дарга нь яамны ажиллагсдын хувьд ажил олгогч нь байж, шинэчлэлийн шаардлагын дагуу үйл ажиллагаагаа явуулах. Яамны ажиллагсадтай Үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

78. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд яамдын гүйцэтгэх гол үүрэг нь дээр дурдсан баримт бичгүүдийн төслийг боловсруулах, сайдын шаардаж буй бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд оршино.

79. Чадавхи бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж, шаардлагатай үед шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгээс зөвлөгөө авч ажиллана.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

80. Яамд шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараахь зүйлд анхаарна:

- Шинэчлэлийн үзэл санаа, яамдад тавигдах шаардлагыг сайтар ойлгосон байх, шаардлагатай үед шуурхай ажлын хэсгээс зөвлөгөө авах;
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний бүх төсвийн байгууллагуудтай хамтран ажиллаж, байгууллага бүрийн хэрэгжүүлэлтийн ажлын явцын талаар сайдад мэдээлж, зөвлөгөө өгөх;
- Бизнесийн стратегийн төлөвлөгөө (бүтээгдэхүүний тодорхойлох, бүртгэлийн өнөөгийн системд суурилан өртгийг нь тооцох, бүтээгдэхүүн нийлүүлэлт буюу үйлдвэрлэлийн процесс, өмчлөгчийн хувьд хүрэх зорилт, бүртгэлийн өнөөгийн системд суурилан гүйлан жилийн санхүүгийн төлөв боловсруулах зэргийг хамарна) боловсруулах, Үр дүнгийн гэрээ байгуулах (Төрийн захиргааны албаны зөвлөлийн хамт) зэрэг асуудлаар төлөвлөгөө хийж, түүний дагуу холбогдох баримт бичгүүдийн төслийг боловсруулж, хэрэгжилтийг хангах. Үүний үндсэн дээр сайдын төсвийн төслийг боловсруулах;
- Бизнесийн стратегийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах менежментийн тогтолцоог бүрдүүлэх, гүйцэтгэлийн талаар улирал, жилээр тайлагнах (бүтээгдэхүүн нийлүүлэлт, менежмент, санхүүгийн үр дүн), өрөнхий менежерийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх талаар төлөвлөгөө хийх, түүний дагуу ажиллах;
- Дээрх төлөвлөгөөний талаар арга зүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа авч, чадавхийг сайжруулах. Энэ дэмжлэг туслалцааг Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг, мөн бусад байгууллагууд (хувийн хэвшлийн зөвлөхүүд, хандивлагч байгууллагууд г.м.) ханган юм.

Засгийн газрын агентлаг

81. Засгийн газрын агентлаг нь сайд болон иргэдэд үйлчилгээ (бүюу бүтээгдэхүүн) үзүүлэх (бүюу нийлүүлэх) үүрэгтэй болно. Зарим тохиолдолд эдгээр үйлчилгээ нь бодлогын зөвлөгөө хамардаг. Шинэчлэлийн шаардлагын дагуу агентлаг нь ямар бүтээгдэхүүн нийлүүлэх, бүтээгдэхүүний хэрхэн нийлүүлэх талаар сайдтай тохиролцоно. Цаашид бүтээгдэхүүний тогтвортойгоор нийлүүлэх боломжийн талаар анхаарах нь зүйтэй юм.

Шинэчлэлтэй холбогдон тавих шаардлага

82. Засгийн газрын агентлагууд дараахь арга хэмжээ авна:

- Сайдтай бизнесийн стратегийн төлөвлөгөөг тохиролцож, гүйцэтгэлийн талаар тогтмол тайлагнах;
- Агентлагийн ерөнхий менежер сайдтай Үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийн талаар тайлагнаж, үнэлгээ өгөхөд тус дөхөм болох, Төрийн захиргааны албаны эвлелтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;
- Хариуцлагын тогтолцоо бүрэлдсэн тохиолдолд агентлагийн менгэн хөрөнгө, боловсон хүчин, үндсэн хөрөнгийг Санхүү, эдийн засгийн яам болон Төрийн захиргааны албаны эвлелийн шууд оролцоогүйгээр бие даасан байдлаар удирдах.

Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг

83. Засгийн газрын агентлаг нь шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Тэдгээрийн үйл ажиллагаа, үр дүнд гарсан өөрчлөлт нь шинэчлэлийн амжилтыг тодорхойлно. Иймээс агентлагийн гүйцэтгэх үүрэг нь хамгийн тодорхой болөвч хэрэгжүүлэхэд хамгийн бэрхшээлтэй нь юм:

- Сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтод агентлагийн нийлүүлэх бүтээгдэхүүн хэрхэн хувь нэмэр оруулах тухай сайдад зөвлөгөө өгөх;
- Агентлагийн нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлох (бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, цаг хугацаа, байршил, өртөг, эдгээрийн хувьд тавигдаж буй зорилтуудыг хамруулна);
- Агентлагийн үйл ажиллагааг хамгийн үр ашигтай байлгах, бүтээгдэхүүнийг зохих түвшинд нийлүүлэх, сайдын тавьсан зорилтод хамгийн их хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлж чадах менежментийн хамгийн оновчтой арга барилыг тодорхойлж сонголт хийх;
- Үр дүнгийн гүйцэтгэл болон менежментийн талаар тайлан гаргаж, сайдын стратегийн зорилгод ,бодитойгоор оруулсан хувь нэмрийн талаар илтгэх.

Амжилттай хэрэгжүүлэх үндэс

84. Засгийн газрын агентлагууд шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараахь зүйлд анхаарна:

- Бизнесийн стратегийн төлөвлөгөө (бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүртгэлийн өнөөгийн системд суурилан өртгийг нь тооцох, бүтээгдэхүүн нийлүүлэлт буюу үйлдвэрлэлийн процесс, бүртгэлийн өнөөгийн системд суурилан гурван жилийн санхүүгийн төлөв боловсруулах зэргийг хамарна) боловсруулах, Үр дүнгийн гэрээ байгуулах (Төрийн захиргааны албаны эвлелийн хамт) зэрэг асуудлаар төлөвлөгөө авч, түүний дагуу хэрэгжилтийг ханган;
- Бизнесийн стратегийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг ханган менежментийн тогтолцоог бүрдүүлэх, гүйцэтгэлийн талаар улирал, жилээр тайлагнах (бүтээгдэхүүн нийлүүлэлт, менежмент, санхүүгийн үр дүн), ерөнхий менежерийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх талаар төлөвлөгөө хийх, түүний хэрэгжилтийг ханган;
- Дээрх төлөвлөгөөнүүдийн талаар арга зүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа авч, чадавхийг сайжруулах. Ингэхдээ шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг, мөн бусад байгууллагуудаас дэмжлэг хүсэх;
- Агентлагийн бүтэц, чадавхитай холбоотой давуу болон сул талуудыг илрүүлж, чадавхи бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах, ингэхдээ санхүү, боловсон хүчин, үндсэн хөрөнгийн менежмент, үр дүнд суурилсан удирдлагын чадавхид анхаарах;
- Агентлагийн санхүүгийн менежментийн медээллийн системийг бүрдүүлэх, түүнийг яваандаа аккруэл суурьт шилжүүлэн бэхжүүлэх, Засгийн газрын нэгтгэл хийх системтэй холбох, Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгэхийн тулд шаардлагатай медээллийг өнөөгийн бүртгэлийн суурьт үндэслэн гаргаж өгөх.

Ерөнхий менежерийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

85. Засгийн газар санхүүгийн хяналтыг чухалчилдаг бөгөөд шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад бүтээгдэхүүнийг мөн зохих түвшинд нийлүүлэхийг чухал гэж үзэж байна. Өнөөгийн зардлын зүйл ангийг хянадаг арга барил нь үр дүнг сайжруулах хөшүүргийг бүрдүүлж чадахгүй байгаа ч ерөнхийдөө үр дүнтэй байгаа гэж үзэж байна.

86. Шинэчлэлийн шаардлагын дагуу үр дүнгийн гүйцэтгэлд (ялангуяа бүтээгдэхүүнд) суурилсан хяналтын системийг бүрдүүлэх юм. Гэвч зөвхөн үр дүнгийн гүйцэтгэлд суурилсан хяналтын энэхүү системийг бүрэн утгаар нь бүрдүүлсний дараа л өнөөгийн орцонд суурилсан хяналтын системийг үгүйсгэх боломжтой онцлож байна.

87. Иймээс шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад ерөнхий менежерүүдэд тодорхой эрх мэдлийг шилжүүлэх болно. Үүний дагуу Төрийн захиргааны албаны зөвлөл болон Санхүү, эдийн засгийн яам тодорхой нөхцөл хангагдсан гэж үзэн, тохиролцсоны дагуу байгууллагын ерөнхий менежерт эрх мэдлийг шат дараалалтайгаар шилжүүлнэ. Зөвлөл болон яам эрх мэдэл шилжүүлэх тухай тохиролцохын үндэс нь агентлагийн зүгээс дараахь зүйлийг харуулж чадсан эсэхтэй холбоотой байх юм. Үүнд:

- Үндсэн баримт бичгүүдийг шаардлага хангах түвшинд боловсруулсан байх;
- Менежментийн болон тайлагналтын систем нь сайн ажиллаж, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь шаардлагатай түвшинд гаргах чадвартай болсон байх;
- Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг

урьдчилан тодорхойлж, түүний гүйцэтгэлийн талаар тайлангаас систем бүрэлдсэн.

88. Төрийн захиргааны албаны зөвлөл болон Санхүү, эдийн засгийн яам нь ерөнхий менежерт ямар эрх мэдлийг ямар нөхцөл хангасан тохиолдолд шилжүүлэх талаархи шалгуурыг хамтран боловсруулж, энэ тухай ерөнхий менежерт мэдэгдэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

89. Санхүү, эдийн засгийн сайд, Төрийн өмчийн хороо нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно. Энэ нь шинэчлэлийн шаардлагад нийцсэн байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар нь нэг талаас улсын өмчийн чухал хэсгийг бүрдүүлдэг, нөгөө талаас санхүүгийн хувьд эрсдэл ихтэй тооцогддог учраас Санхүү, эдийн засгийн сайд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ерөнхийд нь хяналт тавина. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дараахь шаардлагуудыг тавигдаж байна. Үүнд:

- хувьчлагдах жагсаалтад орсон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлахад чиглэгдсэн Засгийн газрын хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх. Хувьчлагдах жагсаалтад орсон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид шинэчлэлийн үйл ажиллагаа үйлчэхгүй юм. Гэхдээ Засгийн газраас авч явуулж буй бодлого, төрийн өмчит болон төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой асуудлаар шинэчлэлийн хүрээнд эдгээр аж ахуйн нэгж нь төрийн өмчид хэвээр байх нөхцөлд үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах арга замыг эрэлхийлэх болно;
- Засгийн газрын агентлаг нь зах зээлд борлуулах бололцоотой бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ чиг үүргийг хувийн байгууллагад шилжүүлэх шаардлагагүй бол Засгийн газар түүнийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар болгож өөрчлөн байгуулах буюу эсвэл үүргийг нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аль нэг аж ахуйн нэгжид шилжүүлнэ.
- Шинэчлэлд хамрагдах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь Төрийн өмчийн хороонооc өгч буй төлөвлөгөөнийн дагуу Зорилтын саналын эхний төслийг боловсруулж Төрийн өмчийн хороо болон Төлөөлөн удирдах зөвлөл (хэрэв байгаа бол)-д хянуулахаар хүргүүлнэ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар нь Зорилтын санал, ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаат хурлаараа хэлэлцэх бөгөөд хурлаар хэлэлцсэний дараа Зорилтын саналаа Төрийн өмчийн хороонд батлуулахаар хүргүүлнэ. Батлуулсан зорилтын саналыг Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлнэ. Дараагийн санхүүгийн жил эхлэхээс өмнө 9 дүгээр сарын эхний хагаст багтаан Зорилтын саналыг Засгийн газар Улсын Их Хуралд хүргүүлсэн байна;
- Зорилтын саналд тусгасан зорилтуудыг хэрхэн биелүүлсэн талаар тайлагнах. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж Зорилтын саналыг хэрхэн биелүүлж байгаа, үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн асуудал гарч буй бол түүнийг шийдвэрлэхэд ямар арга хэмжээ авч байгаа зэргийг харуулсан тайланг улирал бүр Төрийн өмчийн хороонд гаргаж өгнө. Төрийн өмчийн хороо нь ажлын гүйцэтгэлийн талаарх улирлын дэлгэрэнгүй тайланг Ерөнхий сайд болон Санхүү, эдийн засгийн сайдад хүргүүлнэ. Үүнээс гадна Төрийн өмчийн хороо нь зургаан сард нэг удаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөл (эсхүл ерөнхий менежер (захирал))-тэй уулзаж, Зорилтын саналын биелэлтэд хяналт тавих болон үйл ажиллагаа, эрсдэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэнэ;
- Төрийн өмчийн хороо (болон Санхүү, эдийн засгийн сайд)-той ажлын уялдаа холбоотой ажиллах;

90. Шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө боловсруулах чадавхийг бэхжүүлнэ. Түүнчлэн Засгийн газраас гаргасан шийдвэрээс болоод өртгөө бүрэн нөхөж үл чадах бүтээгдэхүүн болон эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч), Засгийн газрын нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд нийлүүлэх бүтээгдэхүүнийг сайтар тодорхойлж, зохих төлбөрийг олох асуудлыг хариуцна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА

91. Өнөөгийн байдлаар орон нутгийн засаг захиргаа нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дамжуулан ардчилсан төлөөллийг хэрэгжүүлж, нөгөө талаас Засгийн газрын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх үүргийн аль алийг нь хүлээж байна. Засаг дарга нар Ерөнхий сайдад ажлаа тайлагнадаг бөгөөд түүнчлэн орон нутгийн түвшний зарим алба, хэлтэс орон нутгийн түвшинд Засаг даргын өмнө хариуцлага хүлээхээс гадна төвлөрсөн төсвийн байгууллагын өмнө мөн хариуцлага хүлээдэг хоёрдмол тогтолцоо үйлчилж байна.

92. Энэхүү шинэчлэл нь төвлөрлийг сааруулах бодлогын үргэлжлэл юм. Энэ нь Иргэдийн төлөөлөгчдийн хуралд илүү эрх мэдлийг олгож байгаа бөгөөд орон нутгийн засаг захиргааны хүлээх үүрэг, хариуцлагыг (Засгийн газартай харьцуулсан) тодорхой болгож байгаа болно. Энэ нь засагчаллын хоёр түвшинд хөрөнгийг заарлах үндэс суурь болно.

93. Энэхүү процесс нь орон нутгийн засаг захиргаа болон Засгийн газрын хоорондын санхүүгийн харилцаат ил тод болгох, Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны аль аль түвшинд үйл ажиллагааны үр дүнгийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Одоогийн тогтолцооны нөхцөлд энэ нь боломжгүй зүйл билээ.

94. Засгийн газар нь эдгээр процессын улс төрийн агуулгыг хүлээн зөвшөөрч байгаа юм. Орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлагад нөлөөлөх аливаа өөрчлөлт тэдэнд эмзэг тусна гэдэг нь ойлгомжтой. Шинэчлэлтэй холбогдон орон нутгийн түвшний өргөн эрх мэдэл болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон шийдвэр гаргах түвшинг нэмэгдүүлж байгаа бөгөөд Засгийн газраас орон нутгийн засаг захиргаа нь үүнтэй холбогдон тэдгээрийн үүрэг, хариуцлагад гарч болох өөрчлөлтөд зохицож чадна гэж итгэж байгаа.

95. Засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны цар хүрээ томоохон болохыг бүрэн ойлгож байгаа. Орон нутаг дахь шинэчлэлийн хэрэгжилтийг нэг дайралтаар богино хугацаанд хийх зүйл биш юм. Хэрэгжилтийн эхний үе шатуудад дараахь зүйлийг шийдвэрлэх ёстой:

- төвлөрсөн төсвийн байгууллагуудад хэрэгжүүлэх ажлын нэг томоохон хэсэгт Засгийн газар болон төвлөрсөн төсвийн байгууллагын орлого, зарлага, өөрөнгө болон өр төлбөрийг тодорхойлох ажил багтана. Төвлөрсөн төсвийн байгууллагуудын хувьд тэдгээр нь Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг биөэ даасан агентлагийн шинжтэй байх уу, эсхүл орон нутагт биеэ дааж Засгийн газрын түвшний үйл ажиллагаа явуулдаг байгуллага болох уу, эсхүл орон нутгийн Засаг даргын хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн байгуллага байх ёстой юу гэсэн зөрчилтэй асуудлыг нэг мөр болгох шаардлага гарна.
- Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх дэс дарааллын талаарх шийдвэр болон шинэчлэлийн нөлөө, хэрэгжүүлэх шаардлагын талаар 2001 оны явцад зохион байгуулах семинарын дараагаар Засгийн газар нь нийслэл болон аймгууд (түүнчлэн сум, дүүргүүд)-аас санал авч хэрэгжүүлэх явцын талаар зөвшилцөх болно. Үүний үр дүнд Засаг дарга нар орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж холбогдох Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулна.

96. Орон нутагт хэрэгжүүлэхээр Засгийн газраас санал болгож байгаа хуваарь (дээр дурдсан семинаруудын төгсгөлд хэлэлцүүлэх):

Аймаг/ Нийслэл хот ; Хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах хугацаа

Улаанбаатар;	2001
Дархан уул;	2001
Сэлэнгэ;	2001
Архангай;	2001
Хөвсгөл;	2001
Увс;	2001
Сүхбаатар;	2001
Бусад аймаг	2002 онд

97. Аймаг, нийслэл нь шаардлагатай бол шинэчлэлийг хэрэгжүүлэхэд туслалцаа авах талаар Засгийн газартай хамтран ажиллаж шаардагдах санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах болно.

98. Сум, дүүргүүд нь хэрэгжүүлэх асуудлаархи төлөвлөгөөг холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулна. Аймаг, нийслэл нь шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд Засаг дарга нь тухайн аймаг, нийслэлийн харьяа сум, дүүрэг бүрээр хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

99. Хэрэгжилтийн үр дүнд орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь:

- Ажлын төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө болон төсвийн саналыг батална.
- Эдгээрийн дагуу Засаг даргын үйл ажиллагааны үр дүнд хяналт тавина.

100. Орон нутагт шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нягтлан үзэж, батална. Мөн хэрэгжилтийн явцын талаарх тайланг Засаг даргаас тогтмол хүлээн авч байна.

ЗАСАГ ДАРГА

101. Засаг дарга ажлын төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө болон төсвийн саналыг боловсруулна.

- Бүтээгдэхүүн худалдан авах гэрээг хэлэлцэх, удирдах болон хяналт тавина.
- Ерөнхий менежерүүдийг томилж /хуульд өөрөөр заагаагүй бол/, үйл ажиллагаат нь удирдаж, хяналт тавина.
- Боловсон хүчний талаар зөв бодлого явуулна.

102. Хэрэгжилтийн явцад Засаг дарга нь дараахь зүйлийг хариуцна:

- аймаг, нийслэл, сум, дүүргэт хэрэгжүүлэх хуваарийг Ерөнхий сайд (эсвэл түүний төлөөлөгчөө)-тай зөвшилцөх;
- орон нутгийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Засгийн газрынхаас салгаж заагласн талаар зөвшилцөх;
- орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд батлуулахаар оруулах;
- орон нутагт шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах.

103. Засаг дарга шаардлагатай үед тусламж дэмжлэг авч өөрийн аймаг, нийслэл, сум дүүргийн бааз суурь, чадавхийг нягтлан үзнэ. Жишээ нь, судалгаагаар зарим аймгийн хувьд санхүүгийн программ хангамж ашиглаж, төсөөг боловсруулах өндөр чадавхитай байгаа нь харагдсан. Зарим нь төсөө боловсруулах ажлыг үр дүнтэй сайн болгохын тулд бүртгэлийн зөвлөх авч ажиллуулах чадвартай байна.

Ийм чадавхийг бүрдүүлж, хэрэгжилтийн явцад бэхжүүлэх ёстой.

104. Шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхэд дараахь зүйл чухал нөлөөтэй. Үүнд:

- орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл ажиллагаанд сайжруулахын тулд шинэчлэлтэй холбогдон олгож буй боломжийг ашиглах талаархи орон нутгийн, ялангуяа Засгийн газрын байр суурь, хүсэл эрмэлзлэл ;
- орон нутаг болон Засгийн газрын хүлээх үүрэг, хариуцлагын талаархи (мөн тэдгээрийн хоорондын харилцааны талаархи) ойлголтыг мэдэх тодорхой, тод болгох;
- орон нутгийн засаг захиргаа болон Засгийн газрын хоорондох итгэл, хүндэтгэл дээр тулгуурласан хамтын ажиллагааны харилцаа;
- Шинэчлэлийг орон нутагт зохих журмын дагуу хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн салбарт төвлөрлийг сааруулах зарим ажлыг эхлээд байна. Иймэрхүү ажлыг салбарын болон аймаг, нийслэл, сум ба дүүргийн түвшинд илүү их хийх шаардлагатай. Эдгээр тусламж дэмжлэгийн заримыг Засгийн газрын хэмжээнд хэрэгжилтийг тогтворжуулж дуусгасны дараа түүнд оролцон хүмүүсээс үзүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Хэрэгжилтийн удирдлагын зайлшгүй бүрэлдэхүүн хэсгүүд

105. Энэхүү удирдамж нь хэд хэдэн зайлшгүй элементийг агуулна. Үүнд:

- Засгийн газрын бүхий л хүрээнд хэрэгжилтийн талаар тодорхой үүрэг, хариуцлагыг хүлээгээд байгаа албан тушаалтнууд. Ерөнхий сайд, Санхүү, эдийн засгийн сайд болон Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар хамаарна.
- Хэрэгжилтийн үр өгөөжийг ань болох эрт гаргах, хэрэгжилтийн эрсдэлийг багасгах, хэрэгжүүлэх дэс дараалал болон цаашид гарч болох эрсдэлийн удирдлага; хэрэгжилтийг хоорондоо уялдаа холбоо бүхий, удирдан чиглүүх болохоор хэд хэдэн төслүүдэд хуваах замаар үр дүнд хүрнэ.
- Засгийн газрын үйл ажиллагааны аливаа асуудлыг ойлгох чадвартай, болж өгвөл өмнө нь томоохон төслүүд удирдаж байсан ажлын өндөр дадлага туршлага бүхий Ерөнхий төслийн менежер;
- Төслийн менежерт дэмжлэг туслалцаа үзүүлэх холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг; эдгээр нь Засгийн газрын хүрээнд мэргэжлийн онцлог бүрээр мэдлэг, туршлагатай хүмүүс байх бөгөөд шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орно.
- Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах дэмжлэг үзүүлэх болон чадавхийг бэхжүүлэх явцад хувь хүмүүс/агентлагийн хувьд шинэчлэлийн хэрэгжилттэй холбоотой тооцож болохуйц тодорхой үүрэг, хариуцлага;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг бусад орны хэрэгжүүлж байгаа туршлагаас суралцах, эрсдэл тодорхойлох, эдгээр эрсдэлийг үр дүнтэй удирдах боломжийг хангахуйц техникийн (мэргэжлийн) хангалттай тусламж дэмжлэг эдгээр болно.

Хэрэгжүүлэх дараалал

106. Засгийн газраас өгч буй удирдамжийг биелүүлэх дэс дараалал:

	Засгийн газар	*Төвөвийн өрөнхийлөн захиргаач*	*Төвлөрсөн төвөвийн байгууллага*	*Төрийн өмчит үйлдэврийн газар*	*Орон нутаг*
2001	2002 оны Төвийн Хурээний Мэдээдэл (одоогийн бүртгэлийн суурь)	Төвөвийн санал (Эрүүл мэнд ба Боловсролоос бусад нэгтгэл хийдэж, бүртгэлийн одоогийн суурь)	Бизнесийн Стратеги төлөвлөгөө (Эрүүл мэнд болон Боловсролоос бусад) (бүртгэлийн одоогийн суурь, зардал хуваарилах)	Төрийн өмчит үйлдэврийн газрын Зөрилтын Санал	Орлого, хөрөнгө, төвөвийн байгууллага болон бүтээдэхүүнийг салгах (Эрүүл мэнд ба Боловсролоос бусад)
	2002 оны Төвөвийн Бюджет бичиг (бүртгэлийн одоогийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)				ТБУСТХ-ийн хэрэгжүүлэх хувааръг эвэшцүүлэх
2002	Засгийн газрын Жилийн тайлан (одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)		Үзүүлэлт тайлан (Эрүүл мэнд болон Боловсролоос бусад) (бүртгэлийн одоогийн суурь, зардал хуваарилах)	Төрийн өмчит үйлдэврийн газрын үзүүлэлт тайлан	Төвөвийн байгууллагын орлого, хөрөнгө, Эрүүл мэнд ба Боловсролын бүтээдэхүүнийг салгах
	2003 оны Төвийн Хурээний Мэдээдэл (одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)	Төвөвийн санал (Эрүүл мэнд болон Боловсролоос орлуулан нэгтгэл хийдэж, бүртгэлийн өөрчлөл суурь)	Бизнесийн Стратеги төлөвлөгөө (Эрүүл мэнд болон Боловсрол орно) (бүртгэлийн өөрчлөл суурь, зардал хуваарилах)	Төрийн өмчит бүх үйлдэврийн газрын Зөрилтын Санал	Эхний зайлшгүй ойлгоцийг хэрэгжүүлэх ажлын
	2003 Төвөвийн Бюджет бичиг (одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)				хэрэгжүүлэх ажлын
2003	Засгийн газрын Жилийн тайлан(одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)	Төвөвийн өрөнхийлөн захиргаачийн тайлан (Эрүүл мэнд болон Боловсролоос бусад нэгтгэл хийдэж, бүртгэлийн одоогийн суурь)	Жилийн тайлан (Эрүүл мэнд болон Боловсролоос бусад) (бүртгэлийн одоогийн суурь, зардал хуваарилах)	Төрийн өмчит үйлдэврийн газрын жилийн тайлан	Хөөр дахь зайлшгүй аймгуудад хэрэгжүүлэх ажлын
	2003 Төвийн Хурээний Мэдээдэл (одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)	Төвөвийн санал (Эрүүл мэнд болон Боловсролыг орулан нэгтгэл хийдэж, бүртгэлийн өөрчлөл суурь)	Бизнесийн Стратеги төлөвлөгөө (Эрүүл мэнд болон Боловсрол орно) (бүртгэлийн өөрчлөл суурь, зардал хуваарилах)	Төрийн өмчит бүх үйлдэврийн газрын Зөрилтын Санал	
	2003 Төвөвийн Бюджет бичиг (одоогийн бүртгэлийн суурь, бүрэн нэгтгэдэзэгүй)				
2004	Сонгуулийн өмнех Эдийн Засаг, Санхүү ба Төвөвийн зөрдэлийн Мэдээдэл (бүртгэлийн одоогийн суурь, нэгтгэл хийдэзэгүй)	Төвөвийн өрөнхийлөн захиргаачийн тайлан(Эрүүл мэнд болон Боловсролыг орулан нэгтгэл хийдэж, бүртгэлийн одоогийн суурь) Төвөвийн санал (Эрүүл мэнд болон Боловсрол орно, нэгтгэл хийдэж, бүртгэлийн одоогийн суурь)	Мэнгэний удирдлага, хөрөнгийн удирдлага, боловсон хүчний удирдлага ба өрөнхий менежерт олгодог бусад эрх мэдэл	Төрийн өмчит бүх үйлдэврийн газрын жилийн тайлан	Гуравь дахь зайлшгүй аймгуудад хэрэгжүүлэх ажлын
2005	Бүрэн аюулал, Нэгтгэдэзэн Төвөвийн Хурээ, Төсөв ба Тайлагнал	Төвөвийн өрөнхийлөн захиргаачийн тайлан(Эрүүл мэнд болон Боловсролыг орулан нэгтгэл хийдэж, бүртгэлийн өөрчлөл суурь)			Үлдсэн аймгуудад хэрэгжүүлэх ажлын
2006	▼	▼	▼	▼	▼

107. Энэхүү хэрэгжүүлэх дараалалд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байна. Үүнд:

- Аль болох олон төвлөрсөн төсвийн байгууллагыг хамруулах Засгийн газрын байр суурь болон үүнтэй холбогдон шинэ тогтолцооны хүрээнд ажиллах эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч) нарыг аль болох хурдан хугацаанд хамруулах асуудал;
- Нөөцийг тэргүүлэх чиглэлээр нь хуваарилах бодлого явуулснаар Засгийн газрын хязгаарлагдмал нөөцийн хүрээнд стратегийн зорилтуудаа хангаж болох магадлалыг нэмэгдүүлэх илүү арга зам, үндэслэлийг илрүүлэх шаардлага;
- Орон нутгийн асуудлыг тодруулж, төв болон орон нутгийн хооронд заагаа хязгаар тогтоох (орлого, хөрөнгө ба бүтээгдэхүүний хувьд) хэрэгцээ шаардлага. Энэ бол 2001 оны хувьд зөвхөн зарим хэсэг нь л биелэгдэх өргөн цар хүрээтэй асуудал мөн.
- Засгийн газрын түвшинд аккруэл сууриар нэгтгэл хийх системийг авах, ажиллуулах, ашиглах талаар дараагийн 3 жилийн туршид үргэлжлэн учирч болох бэрхшээл, ялангуяа Засгийн газрын түвшинд ашиглах санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг тендер зарлан сонгох явц удааширч байгаа асуудал (Дэлхийн Банкны санхүүжилттэй Төсвийн техникийн туслалцааны төсөл);
- Шийдвэр гаргахад ашиглах дунд хугацааны төсөвлөсөн санхүүгийн тайлан болон түүнтэй зэрэгцүүлсэн санхүүгийн үеийн эцсийн тайлан бэлтгэх чадвар. Эдгээр Төсвийн хүрээний мэдэгдэл (Засгийн газрын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох болон нөөцийг төсвийн ерөнхийлөн захирагчдын хооронд хуваарилах), төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр боловсруулсан төсөв (эрхэлсэн салбарын стратегийн зорилтууд, баримтлах бодлого болон төсвийн зүйл төрөл бүрээр шаардагдах нөөцийн гурван жилийн урьдчилсан таамаглал);
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн Зорилтын санал боловсруулах ажлын үе шатыг тогтоох шаардлага; Шинэчлэлийн шаардлага нь зөвхөн хувьчлалд орохгүй аж ахуйн нэгжид хамаарна.
- Дараагийн сонгуулийн өмнө Засгийн газрын сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү болон төсвийн эрсдэлийн байдлын талаархи мэдээллийг бэлтгэх;
- Орон нутагт шинэчлэлтэй холбогдон тавигдах шаардлагыг хэрэгжүүлэх дараалалыг тогтооходоо түүнийг эхэлж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэл болон чадвар бүхий газруудад тулгуурлах бөгөөд эхлээд төв, орон нутгийн заагийг тогтоох шаардлагудыг хүлээн зөвшөөрөх.

Хэрэгжүүлэх төслүүд болон ажлын хөтөлбөрүүд

108. Засгийн газар удирдамжийг хэрэгжүүлэх явцад дараахь асуудлуудын уялдааг хангахад анхаарвал зохино. Үүнд:

- Шинэчлэлийн хэрэгжилтийг цогц байдлаар болон бүх талаар нь удирдана гэсэн итгэлтэй байх шаардлага;
- Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой чиглэлээр ажиллаж буй хувь хүмүүс болон агентлагуудыг шинэчлэлийн хэрэгжилтийг хангах, мөн өөрийн чиглэлийн үүргийг хариуцуулан ажиллуулах шаардлага;
- Амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг хангах тодорхой зорилго, үндэс тулгуур бүхий дэмжлэг, тусламж, гарын авлага материалаар хангах;
- Шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зам нь удирдамж болохуйц бөгөөд биелэгдэх шаардлага здгээр болно.

109. Энэхүү уялдаа хангах асуудлыг хэрэгжилтийн үзэл санаа алдагдуулахгүйгээр хэрэгжилтийг илүү хялбар удирдаж болох төслүүдэд хуваах замаар шийдвэрлэж болох юм. Эдгээр төслийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа шинэчлэлийн үндсэн санаа, төслүүдийн хэрэгжилтийг нөхцөлдүүлэх ажлыг баттай болгох үүднээс шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийн зүгээс холбогдох талуудтай байнга зөвшилцөж ажиллана.

110. Хэрэгжүүлэх төслүүд:

Төсөл; Хийх ажил

Хэрэгжилтийг ерөнхийд нь удирдах;

- Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг
- Хэрэгжилтийн явцыг байнгын удирдлагаар хангах

Олон нийтэд таниулах, харилцах;

- Сурталчилгааны стратеги зорилтыг боловсруулах
- Семинар, сургалт, танилцах аялал зохион байгуулах
- Хэвлэн нийтлүүлэх гарын авлагын материал бэлтгэх (бусад төслүүдийн ажлын нэг хэсэг болно)

Засгийн газрын стратеги бодлого;
- Үйл ажиллагааны хөтөлбөрт бүй Засгийн газрын үйл ажиллагааны талаархи ойлголтууд;
- Засгийн газрын түвшний нөөцийг хуваарилах аккруэл бүртгэлийн асуудлыг боловсруулах ;
- Шинэчлэлийн хүрээнд бодлого явуулах, шийдвэр гаргах тухай асуудал болон гол үзэл санааг хэрэгжүүлэх.

Засгийн газрын санхүүгийн удирдлага ;
- Төсвийн процессийн тодорхойлолт болон удирдлага
- Төсвийн таамаглал (Дунд хугацааны зарлагын хүрээ удирдлага)
- Мөнгөний, өрийн удирдлага болон банкны зохицуулалт
- Төсвийн саналыг хянах болон хэрэгжүүлэх
- Засгийн газрын түвшний санхүүгийн удирдлагын мэдээллийн систем

Засгийн газрын боловсон хүчнийг томилох асуудал болон удирдлага
- Томилох процесс;
- Боловсон хүчний удирдлага ба ёс зүйн талаархи гарын авлага;
- Үйл ажиллагааны үр дүнгийн удирдлагын талаар төсвийн байгууллагад зөвлөх
- Ерөнхий мөнгежерийн хөдөлмөрийн гэрээ байгуулах (болон бусад ажилтнуудын хувьд)

Хөндлөнгийн хяналт, хяналтын тогтолцоо;
- Эрсдэлд суурилсан аудит;
- Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн аудит;
- Удирдлагыг сайжруулахад чиглэсэн аудит

Төвлөрсөн төсвийн байгууллагад хэрэгжүүлэх;
- Орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолт (Засгийн газар/орон нутаг болон төр/төсвийн байгууллага)
- Төсөв зохиох;
- Бүтээгдэхүүн тодорхойлох, өртөг тооцох болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийг тайлагнах;
- Бүртгэлийн бодлого боловсруулж, түүний удирдлагаар хангах ;
- Санхүүгийн болон санхүүгийн бус урьдчилсан таамаглал, тайлагнал (дунд хугацаагаар);
- Санхүүгийн удирдлага:
  - Систем ба мэдээлэл;
  - Шинжилгээ хийх болон удирдлагын шийдвэр гаргах;
  - Хөрөнгийн удирдлага болон хөрөнгө олох, худалдан авах;
- Санхүүгийн бус удирдлагын систем;
- Мөнгөний болон банкны удирдлага.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд;
- Удирдлага (Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, томилох процессийг оролцуулна);
- Үйл ажиллагааны үр дүнг тодорхойлох (Зорилтын саналыг боловсруулах асуудлыг багтаана);
- Үйл ажиллагааны үр дүнгийн тайлагнал (Зорилтын саналтай зэрэгцүүлсэн);
- Нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн нэгтгэл (төсөвлөсөн болон бодит гүйцэтгэл).

Орон нутагт хэрэгжүүлэх
- ; Үйл ажиллагааны төлөвлөлт;
- Төсөвлөлт;
- Бүтээгдэхүүн тодорхойлох, өртөг тооцох болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийг тайлагнах;
- Бүртгэлийн бодлого боловсруулж, түүний удирдлагаар хангах;
- Санхүүгийн болон санхүүгийн бус урьдчилсан таамаглал ба тайлагнал (дунд хугацаагаар);
- Санхүүгийн удирдлага:
  - Систем ба мэдээлэл;
  - Шинжилгээ хийх болон удирдлагын шийдвэр гаргах;
  - Хөрөнгийн удирдлага ба хөрөнгийг олох, худалдан авах;
- Санхүүгийн бус удирдлагын систем;
- Мөнгөний болон банкны удирдлага.

Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийг байгуулах болон удирдах

111. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг нь Засгийн газрын өмнөөс ажиллах гол оролцогч болно. Ажлын хэсэг нь бие даасан үйл ажиллагаа явуулж (хуваарилагдсан төсвийн хүрээнд) Улсын Их Хурал, Засгийн газрын бүхий л хүрээнд хамтран ажиллана. Ажлын хэсгийн гишүүд нь үйл ажиллагааны онцлог, үе шатууд бүхий ажлын тодорхой хөтөлбөртэй байх бөгөөд үүнийгээ тус бүрдээ өөр өөрсдийн удирдлагатайгаа байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байна.

Шаардлагатай боловсон хүчин

112. Шуурхай ажлын хэсэг нь өөрийн зорилгод нийцэх ажлын чадвар, дадлага, туршлага бүхий хүмүүсээс бүрдсэн ажлын багтай байна. Баг нь Засгийн газрын хэмжээнд болон гадаад талдаа хамгийн өндөр авьяас чадвар бүхий хүмүүс байх (шаардлагатай бол) бөгөөд дараахь бүрэлдэхүүнтэй байна:

Төсөл	Шаардагдах чадвар ба туршлага	Хүний тоо
Төслийн удирдлага /ерөнхий зохицуулалт/ Ерөнхий сайдад тайлагнах	Шинэчлэл болон түүний шаардлагыг маш сайн мэддэг, томоохон төслийг удирдаж байсан туршлагатай менежер байна.	1
Суртalчилгаа, харилцаа холбоо, орчуулга	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд бичих туршлага чадвартай, олон нийттэй харьцдаг, тайлбар суртalчилгааны материалаа бэлдэх, хэвлэн нийтлүүлэх, удирдах чиглэлээр ажилладаг байна. Англи хэлний орчуулагч нэгээс дээш.	3
Стратеги, бодлого, Засгийн газрын түвшинд шийдвэр гаргах	Яам , агентлагийн түвшний бодлогын дэмжлэгтэйгээр Засгийн газрын, дээд түвшний бодлого явуулах туршлага.	1
Төсвийн удирдлага болон хэрэгжилт (төсвийн таамаглалыг оролцуулан)	Шинэчлэлийн мэдлэгээс гадна хийгдэж буй төсвийн шинэчлэлийн тодорхой туршлагатай байна. СЭЗЯ-наас томилогдох бөгөөд яамны гол гол ажилтнуудтай нягт холбоотой байна.	1
Хуулийн зөвлөлгөө	Санхүүжилтийн талаархи шийдвэр болон бэрхшээлтэй асуудалд тулгуурлан зөвлөлгөө өгөх чадвар бүхий хуулийн зөвлөх. Тодорхой бөгөөд энгийн хуулийн зөвлөлгөө өгөх чадвар бүхий байна.	1
Мөнгөний, өрийн удирдлага болон банкны зохицуулалт	Төрийн санхүүн үйл ажиллагаат удирдах талаар улсын болон хувийн хэвшлийн аль алины туршлагатай байна. Санхүү бүртгэл, эдийн засгийн боловсролтой байна.	1
Засгийн газрын түвшний бүртгэлийн систем	Дэлхийн банкны Төсвийн техникийн тусламцааны багаас оролцоно. Системийг ажиллуулах Санхүү, эдийн засгийн яамны ажилтнуудтай нягт холбоотой байна. Хуулийн үзэл баримтлал сананатай систем хэрхэн холбогдох талаар сайн мэддэг байх.	2
Боловсон хүчний удирдлага, томилох процесс болон хүний нөөцийн удирдлага	Төрийн захиргааны албаны зөвлөлөөс томилно. Бусад шаардлагаас гадна удирдлагын мэдлэгтэй байна. Менежерийн хувьд яамд, гол агентлагт ажиллаж байсан удирдлагын арвин туршлагатай, итгэл хүндэтгэл хүлээсэн байх.	1
Хөндлөнгийн хяналт болон хяналтын систем	ТХШХ-ноос томилно. Шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдон ажиллана.	1
Төсвийн байгуулагын төсөвлөлт, төсвийг хэрэгжүүлэх, санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, систем	Төсвийн байгуулагын төсөвлөлтийн талаар өндөр туршлага бүхий санхүүгийн экспертүүд. Төсөв зохиох тайлагнах талаархи хуулийн процесс, үзэл баримтлалыг сайтар ойлгодог байх, аккруэл бүртгэл ба санхүүгийн боловсролоор мэргэжсэн нягтлан бодогч байна.	4
Стратеги зорилтууд болон бүтээгдэхүүн тодорхойлох ба өртөг тооцох	Бүтээгдэхүүн тодорхойлох болон бүртгэлийн чиглэлээр мэдлэгтэй байна. Бүртгэлийн ажилтнууд өртөг тооцох талаар туслалцаа үзүүлнэ.	5
Төсвийн байгуулагын мөнгөний болон банкны удирдлага	Төрийн сангийн удирдлагын чиглэлээр Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газар буюу эсвэл компанид ажиллаж байсан ижил төстэй ажлын өндөр туршлагатай байна.	3
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлага, үйл ажиллагааны үр дүнгийн тодорхойлолт, тайлагнал	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хяналт тавих чиглэлээр хариуцан ажиллаж байгаа хүмүүс байх бөгөөд Төрийн өмчийн хороонооос томилно. Эдгээр хүмүүсийг шинэ арга барилд сургах бэ түүнийгээ Төрийн өмчийн хорооны ажилд ашиглана.	2
Аймаг, нийслэлийн төлөвлөгөө боловсруулах, удирдлагаар хангах болон хэрэгжүүлэх	Орон нутгийн түвшинд ажиллаж байсан туршлага дадлагатай хүмүүс байна. Эдгээр хүмүүс нь төвийн түвшинд удирдлагын туршлагатай, бүртгэлийн болон төсвийн ажлын туршлагатай байна.	4
Нийт		30

Хариуцлага

113. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар хариуцлага хүлээнэ. Шуурхай ажлын хэсгийн үндсэн үүрэг нь Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдэд шинэчлэлийг нийт улс орны хэмжээгээр хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Гэхдээ энэ нь шуурхай ажлын хэсэг гардан хэрэгжүүлнэ гэсэн үг биш юм. Шуурхай ажлын хэсгийн үндсэн зорилго нь дараахь зүйлд оршино:

- Засгийн газрын зүгээс төсвийн байгуллага болон албан тушаалтны шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар хүлээх хариуцлагыг тодорхой болгоход туслалцаа үзүүлэх;
- Техникийн (мэргэжлийн) асуудлаар зөвлөгөө өгөх (тухайлбал баримт бичгүүдийн загвар, тайлбар бүхий материал боловсруулах, холбогдох албан тушаалтнуудад шаардагатай асуудлаар туслалцаа үзүүлэх г.м.);
- Хэрэгжүүлэх ажлыг биечлэн шууд хийхгүй, түүний төлөө хариуцлага хүлээхгүй байх. Хэрэгжүүлэх хариуцлагыг холбогдох чиг үүргийн дагуу байгуллага, албан тушаалтан хүлээнэ;
- Ерөнхий сайдад ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар сар бүр тайлагнаж, тулгарч буй аливаа асуудалтай холбоотойгоор авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөх.

Байршил

114. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийн нэг онцлог нь утас, факс, электрон шуудан болон биеэр уулзаж холбоо тогтоох боломжтой байх явдал юм. Шуурхай ажлын хэсэг нь туслалцаа дэмжлэг хүсч буй байгуллага, хүмүүст ойр, холбоо барихад хялбар байршилтай байх шаардлагатай. Энэ нь гарах асуудал, бэрхшээлийг цаг тухайд нь шийдвэрлэх, зөвлөгөө өгөх боломжийг олгох юм.

Техникийн туслалцаат зохицуулах нь

115. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг нь тусламж шаардсан бүх байгуулага,

албан тушаалтанд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь нөгөө талаас шинэчлэлийн хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтнуудын зүгээс өөрсдийн чадавхийг үнэлэхэд нь хөшүүрэг болно. Эдгээр байгууллага, албан тушаалтны чадавхийг дайчилж, улам бэхжүүлэх, нөгөө талаас ямар зүйл дээр чадавхи сул байгааг тогтооход гол анхаарлаа төвлөрүүлнэ.

116. "Хэрэгжүүлэх явцад нь дэмжлэг үзүүлэх" гэсэн зарчмыг баримтална. Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг болон төсвийн байгууллагын хувьд гол үүрэг гүйцэтгэх хүмүүсийг сургах, чадавхи бэхжүүлэх шаардлага гарна гэсэн үг юм. Эдгээр гол хүмүүс нь улмаар байгууллагын бусад хүмүүсийг сургах, чадавхи бэхжүүлэх үүргийг сургалт зохион байгуулах, үүрэг даалгавар өгөх болон бусад аргаар гүйцэтгэх болно. Энэ нь төсвийн байгууллагын удирдах албан тушаалтны хувьд чухал болохыг тэмдэглэх хэрэгтэй.

Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийг дэмжих нь

117. Шуурхай ажлын хэсэг нь шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар ихээхэн туршлага, мэдлэг, чадвартай байна. Гэвч энэхүү шинэчлэл урьд нь Монгол Улсын төсвийн байгууллагуудад хийгдэж байгаагүй өргөн цар хүрээтэй бөгөөд зарчмын томоохон өөрчлөлтүүдийг авчрах болно.

118. Энэ нөхцөлд шуурхай ажлын хэсэг нь бусад оронд хэрэгжүүлсэн шинэчлэлийн амжилт, алдаа дутагдлаас өөрсдөө суралцах шаардлагатай. Ингэхийн тулд шуурхай ажлын хэсэг нь төсөв санхүү, удирдлагын ижил төстэй шинэчлэлийг бодит амьдрал дээр хэрэгжүүлсэн туршлага бүхий олон улсын зөвлөхүүдтэй хамтран ажиллах болно.

119. Олон улсын зөвлөхүүдийн үүрэг роль нь шуурхай ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллахад оршино. Олон улсын зөвлөхүүд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, төсвийн байгууллагууд, төрийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай аль болох шууд харьцаж ажиллахгүй болно. Өөрөөр хэлбэл шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийн гишүүд нь тухайн улсын нөхцөл байдлыг илүүтэйгээр мэддэг, мөн хэлний хувьд ямарваа нэгэн бэрхшээлгүй тул давуу талыг эдэлнэ. Олон улсын зөвлөхүүд нь шуурхай ажлын хэсгийн гишүүдтэй харьцан ажиллаж, ажлын төлөвлөгөө боловсруулах, гарын авлага материал бэлтгэх, илтгэл зэрэг олон нийтийн хүртээл болох материал боловсруулах, мөн шинэчлэлийн аливаа асуудалтай холбоотой тус дэмжлэг үзүүлэх болно. Олон улсын зөвлөхүүд нь ӯуны түрүүнд шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсгийн өмнө хариуцлага хүлээж, мөн санхүүжүүлэгч байгууллагад тайлагнана.

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллагууд, төрийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд болон орон нуттийн байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлыг зохицуулах нь

120. Техникийн туслалцаа болон чадавхи бэхжүүлэх ажил нь шинэчлэлийг хэрэгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнийг амжилттай гүйцэтгэхийн тулд дараахь зарчмыг баримтлах шаардлагатай:

- чадавхи бэхжүүлэхдээ "пирамид" хэлбэрийн зарчмыг баримтлах. "Сургагч нарыг бэлтгэх" гэдэг нь богино хугацаанд чадавхи бэхжүүлэх боломжийг олгодог арга юм. Энэ нь нөгөө талаас харьцангуй цөөн тооны хүмүүсийг сургахыг шаарддаг бөгөөд тэдгээр нь өөрийн мэдлэгээ цаашнь ӯр ашигтай дамжуулдаг тул зардал хэмнэх боломжийг олгоно;
- чадавхи бэхжүүлэх гол анхаарлыг хамгийн сул бөгөөд ихээхэн хүчин чармайлт шаардах байгууллага, албан тушаалтан, нөгөө талаас шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, бусдад "үлгэр дууриалал" болж чадахуйц байгууллага, албан тушаалтанд чиглүүлэх аргыг хослуулах нь зүйтэй;
- нягтлан бодох бүртгэл, санхүүгийн менежмент, ерөнхий менежментийн асуудлаар мэргэжлийн болон боловсролын байгууллага, их сургуулиуд зэрэгтэй хамтран ажиллах. Энэ нь хоёр ач холбогдолтой юм:

1. мэргэжлийн болон боловсролын байгууллагуудын мэргэжлийн мэдлэг чадварыг ашиглах боломжийг олгоно;
2. мэргэжлийн болон боловсролын байгууллагууд нь төсвийн байгууллагуудад хийгдэж буй шинэчлэлийн талаар ойлголттой болж, мэргэжлийн хүмүүс болон оюутнуудад энэ чиглэлээр мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэх юм.

Чадавхи бэхжүүлэх санаачлагууд

121. Чадавхи бэхжүүлэх талаар эхлүүлсэн ажлууд нь төрийн захиргааны шинэчлэлийн ач холбогдлыг нотолж байна (дараахь хүснэгтийг харна уу). Төрийн хянан шалгах хорооны чадавхийг бэхжүүлэх талаар онцгойлон анхаарч байгаа явдал нь шинэ тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд хариуцлагын тогтолцоог хангахад тус хорооны ач холбогдлыг харуулж байна. Засгийн газраас зохион байгуулах сургалтын хөтөлбөрүүд нь дараахь зүйл дээр нэмэгдэж ирэх болно.

Чадавхийг хөгжүүлэх талаарх санаачлагууд

Байгууллага	Хийгдэх ажил	Дэмжлэг үзүүлэгч
Төрийн захиргааны шинэтгэлийн төсөл	Шинэчлэлийн үзэл баримтлал, загвар болон хэрэгжүүлэлтийн талаарх сургалт	АХБ ТТ. 2868-MON АХБ ТТ. 2931-MON АХБ ТТ. 3316-MON
Санхүү, эдийн засгийн яам	Төсвийн процессийг тодорхойлоход туслах, Улсын хөрөнгө оруулалтын төсвийн хөтөлбөрийн талаарх сургалт, шинэ тогтолцооны шаардлага, зарчмын талаарх сургалт	АХБ ТТ. 2931-MON Япон (JICA) Дэлхийн банкны Төсвийн Техникийн Туслалцаа АХБ ТТ. 3316-MON Австрали (AusAid)
Төрийн хянан шалгах хороо	ТХШХ-ны чадавхийг бэхжүүлэх, шинэ тогтолцоонд ажиллах зарчмыг таниулах сургалт болон аудитын сургалт	Герман (GTZ) Дэлхийн банкны Төсвийн Техникийн Туслалцаа
Төрийн захиргааны албаны эвлел	Шинэ тогтолцооны зарчим болон шаардлагыг таниулах сургалт (цалин урамшуулал ба үр дүнгийн удирдлагыг багтаасан)	АХБ ТТ. 2931-MON АХБ ТТ. 3316-MON
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Шинэ тогтолцооны зарчмыг таниулах сургалт	АХБ ТТ. 2931-MON АХБ ТТ. 3316-MON
Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүд	Танилцах аялал ба шинэ тогтолцооны талаарх семинар	АХБ ТТ. 2868-MON АХБ ТТ. 2931-MON НҮБ ХХ Австрали (AusAid) Шинэ Зеланд (NZODA)
Төсөв болон нягтлан бодох бүртгэл	Санхүүгийн бүртгэл, удирдлагын бүртгэл, дотоод хяналтын тогтолцоо болон мөнгөн хөрөнгийн удирдлагын талаарх сургалтууд	АХБ ТТ. 2931-MON Санал болгож буй АХБ ТТ НҮБ ХХ Дэлхийн банкны Төсвийн Техникийн Туслалцаа
Менежмент (санхүү, хүний нөөц болон төлөвлөлтийг хамруулан)	Богино хугацааны сургалтад туслалцаа Дунд хугацааны сургалт	АХБ ТТ. 2931-MON АХБ ТТ. 3316-MON НҮБ ТАСИС Дэлхийн банкны Төсвийн Техникийн Туслалцаа Австрали (AusAid)
Төрийн өмчийн хороо	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хариуцсан мэргэжилтэн хяналт, үнэлгээ, менежмент болон удирдлагын аргуудын талаар сургалт явуулна	Австрали (AusAid)

122. 1999 онд хандивлагч байгууллагуудын засаглалын чиглэлээр хийсэн сэдэвчилсэн уулзалтаар тохиролцон "Монголын засаглалын матриц" гэсэн баримт бичиг чадавхи бэхжүүлэх асуудал дээр хандивлагч байгууллагуудын үзүүлж буй дэмжлэг туслалцаны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

123. Чадавхи бэхжүүлэх талаар авахаар санал болгож буй арга хэмжээг цаашид хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэй уялдуулах шаардлагатай бөгөөд үүнийг удирдамжийн хавсралтаар харуулав.

АРАВДУГААР БҮЛЭГ

ШИНЭЧЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ҮРГЭЛЖЛЭЛ

124. Шинэчлэлийг цаашид амжилттай үргэлжүүлэхэд дараахь гурван чухал асуудлыг авч үзэх хэрэгтэй юм. Энэ нь :

- шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гарч байгаа зардал болон өгч буй үр өгөөжийг байнга хянаж байх;
- гарч болох эрсдэлийг аль болох бүрэн тодорхойлж удирдах;
- хэрэгжилтийн эхний шат дуусах үед гаргасан хүчин чармайлтаа зогсоохгүй байх явдал юм.

Зардал болон үр өгөөж

125. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд зардал зайлшгүй гарах бөгөөд эдгээр зардлын зарим нь санхүүгийн зардал юм. Бусад нь цаг хугацаа, шаардлагатай хүчин чармайлттай холбоотой зардал болно. Төсвийн хүндрэлтэй байгаа өнөө үед дараахь арга хэмжээг авснаар зардлыг багасгаж чадна. Үүнд:

- "параллель" тогтолцооны (шинэтгэлд хамрагдсан болон хамрагдаагүй) хүрээг багасгах (байгууллагуудыг аль болох түргэн шинэтгэлд хамруулснаар шинэ ба хуучин тогтолцооны хамтдаа оршин байх хүрээг багасгаж чадна);
- төсвийн байгууллагад удирдлагын шинэ арга барил нэвтрүүлэхтэй холбогдон гарах зардлыг одоогийн төсөвт шингээх. Энэ зохицуулалтын агуулга нь яваандаа удирдлагын шинэ арга нь зардлыг бууруулж чадах бөгөөд сайдад нийлүүлэх бүтээгдэхүүнд гарсан өөрчлөлтөөс үүнийг харж болох юм гэдэгт чиглэгдсэн;
- хандивлагчийн дэмжлэг авах бололцоог өргөжүүлэх (хэрэгжүүлэлт нь маш сайн төлөвлөгдсөн ба хянуур хийгдэж буй гэж тооцогдох). Засгийн газрын энэхүү хэрэгжүүлэх төлөвлөгөө нь нарийвчлан боловсрогдсон бусад төлөвлөгөө ба түүний гүйцэтгэлийг ханган удирдлага зохион байгуулалтаас ихээхэн хамаарах болно.

126. Зарим тохиолдолд төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай богино хугацааны зардлууд гарч болох юм. Жишээлбэл, нэмэлт зардал гаргахгүйгээр одоогийн хяналт шалгалтын аргыг ашиглан төсвийн байгууллагад аудит хийх замаар шинэ зарчим, шаардлагыг хэрэгжүүлэх бололцоогүй юм. Засгийн газар шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гарч буй зардлыг байнга хянах бөгөөд хэрэгжилт нь амжилттай болно гэдгийг батлах нь хүнд асуудал байх болно. Засгийн газрын

энэхүү удирдамжийн дагуу хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй хамт зардлын дэлгэрэнгүй тооцоог боловсруулна.

127. Хэрэгжүүлэх явцад үр дүнг нь түрүүлж ашиглаж болохыг баталж болох юм. Чадавхийг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулж бүй нэг шалтгаан нь энэ юм. Шинэ тогтолоог хурдан төлөвшүүлэх хэрэгтэй гэдгийг баталж байна. Төлөвлөсний дагуу шуурхай хэрэгжүүлэх нь Засгийн газар болон сайдуудад илүү мэдээлэл бүхий бодлогын сонголт хийх таатай боломж олгоно. Засгийн газар нь өрөнхий болон тухайн асуудлын хүрээний стратегийн зорилтуудтай холбоотой ямар нөөц одоогоор бий болж байгаа талаар илүү мэдээлэлтэй болно. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагаа нь Засгийн газар өөрийн тэргүүлэх чиглэлтэй холбоотой нөөцийн хуваарилалтыг илүү системтэй аргаар сайжруулах шаардлагатай гэдгийг харуулна.

Эрдэлт тодорхойлох, удирдах

128. Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад учирч болох эрсдэлийг тодорхойлж удирдах нь шинэчлэлээс ухрах, удаашруулах эсхүл шинэчлэлийн үзэл баримтлалаас гажих зэрэг аюулаас зайлсхийх болоцлоо олгоно .

129. Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад гарч болох дараахь хэд хэдэн эрсдэлийг удирдах шаардлагатай юм. Удирдамж нь эдгээр эрсдэлийг аль болох бага байлгахаар боловсруулагдсан болно:

Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад учирч болох эрсдэл болон түүнд хариу арга хэмжээ явах

Хэрэгжүүлэлтийн эрсдэл	Хариу арга хэмжээ
Хэрэгжүүлэх шаардлагыг хангах удирдлагын болон санхүүгийн **уян хатан бус** байдал	Хэрэгжүүлэх явцад хүндрэлтэй асуудал гарах нь гарцаагүй юм. Менежерүүд хэрэгжүүлэх хугацаог уртасгах, хэрэгжүүлэлтийн чанарыг сулруулах эсхүл нөөцийг нэмэгдүүлэх юмуу өөр зүйлд зарцуулах зэргээр үүнд хариу өгч болно . Хэрэгжүүлэх хугацаог сунгах болломж бага, учир нь төсөв 2001 оны 10-р сард өрөн баригдах ёстой. Тэгэхээр дараахь хоёр сонголт үлдэж байна:
	• хэрэгжүүлэлтийн чанарыг сулруулж болно, гэхдээ энэ нь зохистой хувилбар биш юм. • өрөнхий менежерүүд санхүүгийн болон боловсон хүчний нөөцөө уян хатан болгох.
	Санхүү, удийн засгийн яам болон Төрийн захирганы албаны эввлелөөс өрөнхий менежерт дараахь зүйлүүдийг уян хатан байдлаар зохицуулахыг **эввшөөрөх** нь чухал юм (шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад) : • чухал албан тушаалд шинээр байнгын ажилтнууд авах • хэрэгжилтэд домжогт үзүүлэхийн тулд тур хугацаны ажилтан/гэрээлэгчдийг хөлслөх
	шаардлага гарвал ажил үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.
Шинэчлэлийн талаарх ойлголт, шаардлагууд болон оролцооны талаар өрөгн хүрээний **ойлголт тавруу**	Хэрэгжүүлэлтийн үзэл бариимтлал нь өрөнхийдөө, ялангуяа чадавхий бэхжүүлэх хөтөлбөр нь гол гол байгууллагууд шинэчлэлийг хэрэгжүүлэх, оновчтой болгох ёстой гэдгээ ойлгох, төсөвийн байгууллагуудын хүрээнд шинэчлэлийн талаар ханган ойлголт өгөх зорилгоор боловсруулагдсан.
Шинэчлэлийг **өрөгн хүрээнд нийцтэй** байдлаар хэрэгжүүлэх ажил амжилттүй болох	Шинэчлэлийн хэлбэр болон хэрэгжүүлэлт нь машины загвар гаргах, үйлдвэрлэхтэй ижил тестэй юм. Хэрвээ машин нь дөрвөн дугуйтай байхаар зохиож бүтээдэг болөөч үйлдвөрлөлийн явцад, янз бүрийн хэмжээтэй дугуйнууд таарч байвал энэ нь маш муу хийгдэн гэсэн үг. Хатуу чанга чанарын баталгаа болон эввшөөрлийн журам дээр тулгуурласан "тулхүүр" арга хандлага нь тогтолцоо эх загварчайгаа нийцэн байдлаар хэрэгжэн гэдгийг батлагдаг.
Хэрэгжилтийн явцад хэт **туйлширч**, бүрэндэх буй тогтолцоог эдэлх	Байгууллагуд шинэчлэлийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй заавар-чилгаа, ажлын төлөвлөгөө, гарын авлагаар ханган-дсан байх бөгөөд хэрэгжүүлэх хүчин чармайлт нь шаардлагатай нэмэлт тусламцаагаар дэмжигдэх болно. "Тулхүүр" буюу хамгийн оновчтой арга хандлага бол тогтолцоог маш хурдан хугацаанд ажиллуулах боломж олгоно.
	Гэсэн хэдий ч энэ нь дунд хугацаанд анхны зааварчилгаа болон үйл ажиллагаанд **өөрчлөлт** оруулах шаардлагатай болсон үед үндсэн үзэл бариимтлалд бид харин анхны зааварчилгаанд тайлбар хийх зэрэг эрсдэлийг бий болгоно.
Хэрэгжүүлэлтэд оролцогчын **хохирлуулалт сул, нэгдмэл** бус байх	Хүчтэй, өндөр үр чадварттай, төвлөрсөн шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг нь хэрэгжүүлэлтийг нэгдмэл, хохирлуулалттай байлгахын тулд байгууллагдсан. Энэ нь шинэчлэлийг хэрэгжүүлж буй байгууллагуудад бүх талын тусламцаа, дэмжлэг үзүүлнэ. Үүрэг, харицуцлагыг тодорхой болгосон. Энэ нь янз бүрийн хэрэгжүүлэгч төслүүдийг зохицуулах ба нэгдмэл байдлыг хангана.
Гадаад **дэмжлэгийн илүү найдвартай** байдал	Олон улсын эввлэхүүдийг хэрэгжүүлэгчид бус харин жинхэнэ эввлэгч байдлаар авч ажиллуулж байгаа нь чухал юм. Хэрэгжүүлэлтийн явцад энэ байдал улам тодорхой болох бөгөөд эхний шатанд гадаадын эввлэх нарын оролцоо нь мэргэжилтэн талаасаа хэрэгтэй байх болно.
Засгийн газар болон байгууллагуудын чадавхи ханалттай бус (Санхүү, эдийн засгийн яам, Төрийн захирганы албаны эввлел, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн хянан шалгах хороо, Төрийн өмчийн хороо гэх мэт)	Байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулагдсан бөгөөд одоогийн байгаа чадавхийг сургалт эввлүүлэх, ажлын байран дээр нь зааварчилгаа, эввлелгөө өгөх, гаднаас чадварлаг боловсон хүчин авч ажиллуулах замаар богино хугацаанд бэхжүүлэх боломжтой болно.
Хэрэгжүүлэлт **хугацаанаасаа хоцрогдүй** явагдах болон **өртийн үр өгөөж багатай** байх	Хэрэгжүүлэх арга хандлага нь төсөвийн байгууллагуудын хувьд одоогоор хийж гүйцэтгэх байгаа ажлуудыг үргэлжлүүлэн хийх, гэхдээ шинэ арга хандлага хэрэглэхийг шаардах болно гэдгэг ойлгомжтой. Менежментийн шинэ арга хандлага нь үйл ажиллагаа ань болох нарийн тодорхой, мэдээллэгтэй болгоод чиглэх байгаа болно. Түүнээс бус аливаар заавал өөрчлөх гэсэн зорилт биш. Хэрэгжилтийн явцын өртийг хянах механизм нь удирдлагын бүх шатанд тогтож ажилах болно.
Төрөөс үзүүлэх гол үйлчилгээний хувьд **нөөц болон хүчин туслалцаа сулрах**	Төсвийн төсөл, Бизнесийн стратегийн төлөвлөгөө, Үр дүнгийн гэрээ боловсруулах болон ер нь шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь төрөөс (Засгийн газраас) ард түмэнд үзүүлэх гол үйлчилгээнд төвлөрч түүнийг тасралтгүй явуулах талаар төсвийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх зорилготой болно. Иймд хэт олон зүйлд самгардаж нөөц ба хүчин чармайлтаа цалгардахаас зайлсхийх хэрэгтэй.

Хэрэгжүүлэлтийн эхний үеийн шатны дараа

...

130. Төсвийн байгууллагуудыг удирдлага, санхүүжилтийн тухай хуульд (төсөлд) тусгагдсан төсвийн байгууллагын удирдлагын арга нь олон тооны дагаж мөрдөх журам, заавруудыг бодвол илүү хялбар юм. Энэ нь 1990 оноос өмнө Засгийн газрын хэрэглэж байсан орц-гарц, төлөвлөлт, зорилтын аргуудаас ялгаатай бөгөөд бүх түвшинд үр дүнгийн урамшууллыг бий болгоход чиглэгдэгж. Гэвч энэ нь өнөөг хүртэл

орхигдсоор байгаа санхүүгийн бус мэдээллийн системийг одоогийн бүртгэлийн аргад суурилан яаралтай бий болгох бололцоо олгож байгаа юм.

131. Мөн зарим төсвийн байгууллагууд бүтэзгэдэхүүнийг тодорхойлж, түүний өртгийг тооцож дуусан, Бизнесийн стратегийн төлөвлөгөө зөвшөөрөгдсөн, төсвийн төслийг УИХ-аас зөвшөөрч батагдсан нь л бол шинэчлэл хэрэгжиж дуусна гэсэн ойлголттой байж болох юм. Гэвч эдгээр нь шинэчлэл амжилттай хэрэгжиж байгаа нотолгоо биш юм. Хэрэгжилтийн эхний үе шат дуусмагц дараахь зүйлийг хийх шаардлагатай. Үүнд:

- Засгийн газрын стратегийн зорилтууд, эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-ын стратегийн зорилтууд болон сонгосон бодлогын (бүтээгдэхүүнийг оролцуулаад) хоорондын уялдаа холбоог үнэлэхэд ашиглах **үнэлгээний** үндсэн шалгуурыг (чиглүүлэгчийг) бодитойгоор бий болгох. Үнэлгээ нь цаашид ч зайлшгүй хэрэгтэй юм. Сайдууд болон УИХ ямар ажил хийгдэж, эсэхүү хийгдээгүй гэдгийг мэдэх хэрэгтэй болно. Ингэснээр шаардлагатай үед энэ системээр дамжуулан санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын мэдээллийг бүрэн үнэлж хянах арга хэмжээг авч байх хэрэгтэй болно;
- Эрхэлсэн сайд (төсвийн ерөнхийлөн захирагч), төсвийн байгууллагуд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн нийлүүлэх, чадавхыг сайжруулах болон санхүүгийн байдлаа бэхжүүлэх **менежментэд** нь гол анхаарлаа төвлөрүүлэх;
- Шинэчлэлийн **тогтвортой байдлыг** хангахад байгын идэвхи чармайлт гаргах. Сургалт явуулах болон чадавхийг бэхжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэдгийг ямthemы дээд удирдлагын түвшинд дэмжих хэрэгтэй юм.
- Төсвийн байгууллагыг удирдах ерөнхий үүрэг бүхий Засгийн газар дахь нэгж нь Засгийн газрын үр дүнгийн тайланг тайлагнах болно. Ингэснээрээ давуутай болон сул талуудыг олж илрүүлэн, менежментийн туршлагыг нийтэд хүртээх, сул талыг арилгах зэрэг арга хэмжээг авч байх болно.

ХАВСРАЛТ: ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Оршил

Төсвийн байгууллагын түвшинд шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гарцын (бүтээгдэхүүнд суурилсан) удирдлагын шинэ орчинг төвлөрсөн бус орцын удирдлагатай хослуулан үр дүнтэй үйл ажилагаа явуулах чадварыг төсвийн байгууллагуудад бий болгох шаардлагатай юм.

Шинэ тогтолцоог хэрэгжүүлэх, түүнд зохицон ажиллах үндсэн чадварыг богино хугацаанд олгох шаардлагатай байгаа юм. Богино хугацаанд энэ чадвары:

- ажилтнуудад албан сургалт явуулах;
- албан бус сургалт (семинар/ярилцлага) явуулах;
- ажлын байран дээр нь сургах, дадлагажуулах;
- шаардлагатай үр чадвар үзэмшсэн хүмүүсийг шинээр ажилд авах;
- хувийн болон эсхүл улсын байгууллагаар ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх;
- түр хугацааны эвлэх авч ажиллуулах зэрэг замаар бий болгоно.

Сүүлийн гурван аргыг ерөнхий менежерийн эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх бололцоотой.

Чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр нь эхний хоёр арга (ажилтнуудад албан болон албан бус сургалт явуулах)-ыг хамарна. Богино хугацаанд чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр нь хэрэгжилтэд оролцогч теслүүдтэй уялдаж хэрэгжих юм.

Дунд хугацаанд (2002 оноос өмнө):

- шаардлагатай үр чадвар үзэмшсэн хүмүүсийг шинээр ажилд авах;
- байнгын албан ёсны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар чадавхийг бэхжүүлэх болно.

Богино хугацаанд чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр (2001-2002)

Ерөнхийдөө богино хугацаанд чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр нь :

- шинэчлэлийн талаарх ойлголт;
- чадавхийн хэрэгцээг тодорхойлох (энэ нь шинэчлэлд хамрагдсан байгууллага, нэгж бүрт тавигдаж буй шинэтгэлийн үндсэн шаардлагуудын нэг юм);
- чадавхи дутагдалтай байдлыг арилгахад богино хугацааны нөөцийг ашиглах:
  - ерөнхий менежерүүд гадаад нөөц, боломжийг ашиглах талаар зөлт хийх (одоо зарим аймагт төсөв зохиоход гарч байгаа шиг) болон/эсхүл;
  - шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг туслалцаа үзүүлнэ.
- Эн тэргүүнд эзэмшвэл зохих чадварыг дараахь замаар олгох/ хөгжүүлэх:
  - ярилцлага, семинар;
  - гарын авлага материал;
  - заавар, хийх ажлын жагсаалтууд;
  - хэрэгжүүлэх явцыг хэрхэн ашиглаж сурч байгаа талаар эргэх мэдээлэл авах, хариу заавар өгөх;
  - ажлын байран дээр нь дэмжих туслах.

Эдгээр хүчин чармайлт нь хэрэгжүүлэгч төсөл бүрийн үндсэн зорилт болон тавигдах бөгөөд дараахь байдлаар уялдаж байгаа болно:

Төсөл	Богино хугацаанд чадавхийг бэхжүүлэх санаачилга (2001)
Төсөвлөлт ба төлөвлөлт	• Гарын авлага • Төсөв зохиоход ашиглах заавар болон гарын авлага • Төсвийн талаарх семинар • Сайдын товч мэдээлэл • Ерөнхий менежерийн товч мэдээлэл
Банкны данс, мөнгөн хөрөнгийн удирдлага	• Банкны дансны зохицуулалт, мөнгөн хөрөнгийн удирдлагын талаарх гарын авлага • Хэрэгжүүлэх заавар болон хийх ажлын жагсаалт • Дараахь талуудад зориулсан сургалтын хөтөлбөр: • Төрийн сангийн газар;

	• Төсвийн байгууллагын ажилтан. • Дараахь талуудын шууд дэмжлэг: • Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг; • Банкны үйлчилгээгээр хангагчид; • Мөнгөн хөрөнгийн удирдлагын системээр хангагчид.
Бүтээгдэхүүн тодорхойлох, түүний өртөг тооцох болон үнэ зохиох	• Бүтээгдэхүүн тодорхойлох, түүний өртөг тооцох ба үнэ зохиоход ашиглах гарын авлага • Хэрэгжүүлэх заавар болон хийх ажлын жагсаалт • Бүтээгдэхүүн тодорхойлох талаар семинар зохион байгуулах • Эргэх мэдээлэл ба хариу зааварчилга • Дараахь талуудын шууд дэмжлэг: • Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг; • Төсвийн байгууллагын зохицуулагч нар.
Нягтлан бодох бүртгэл, тайлагнал	• Бүртгэл, тайлагналын талаархи гарын авлага • Хэрэгжүүлэх заавар болон хийх ажлын жагсаалт • Бүртгэлийн сургалт, семинар, ярилцлага • Эргэх мэдээлэл болон хариу зааварчилга • Дараахь талуудын шууд дэмжлэг: • Төсвийн байгууллагын зохицуулагч нар.
Эхлэлтийн тайлан тэнцэл	• Хэрэгжүүлэх заавар болон хийх ажлын жагсаалт • Ярилцлага • Эргэх мэдээлэл болон хариу зааварчилга • Дараахь талуудын шууд дэмжлэг: • Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг; • Төсвийн байгууллагын зохицуулагч нар.
Удирдлагын тогтолцоо	• Удирдлагын тогтолцооны талаархи гарын авлага (үр дүнгийн удирдлага гэх мэт) • Хэрэгжүүлэх заавар болон хийх ажлын жагсаалт • Семинар болон санал солилцох уулзалт • Эргэх мэдээлэл ба хариу зааварчилга • Дараахь талуудын шууд дэмжлэг: • Шинэчлэлийг хэрэгжүүлэх шуурхай ажлын хэсэг; • Төсвийн байгууллагын зохицуулагч нар.

Дунд хугацааны чадавхийн бэхжүүлэх хөтөлбөр (ДХЧБХ) (2002 оноос өмнө)

Нэг талаас төсвийн байгууллагуудад шинэчлэлийг хэрэгжүүлэх, шинэ тогтолцоонд ажилах чадвар бий болгох **богино хугацааны чадавхийг бэхжүүлэх бэлтгэл хөтөлбөр** хэрэгжих боловч нөгөө талаас дунд хугацаанд чадавхийг бэхжүүлэх шаардлага зайлшгүй гарна.

ДХЧБХ нь дараахь зүйлд чиглэх болно. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох;
- Төсвийн байгууллагууд дахь удирдлагын тогтолцооны арга ажиллагаат боловсронгуй болгох, хөгжүүлэхэд чиглэсэн чадавхийг бий болгох.

ДХЧБХ ажлыг мэргэжлийн буюу сургалтын байгууллага хариуцан хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд үүнд дор дурдсан цуврал арга хэмжээ хамаарна:

- Семинар / Ярилцлага;
- Ярилцлага / Санал солилцох;
- Дадлага хийх;
- Шалгалт.

ДХЧБХ-ийн хүрээнд дараахь есөн төрлийн сургалт явагдах болно:

Сургалт	Агуулга	Сургалт явуулах арга
1. Төсвийн байгууллагын болон санхүүгийн удирдлагын шинэ тогтолцоог танилцах	..санхүүгийн удирдлагын шинэ тогтолцоо, дэмжих хууль, төрөл бүрийн дэд тогтолцоонууд болон хэрэгжүүлэх явцын талаар танилцуулна.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах
2. Бүтээгдэхүүн тодорхойлох нь	.. оролцогч нар бүтээгдэхүүн тодорхойлох талаар ойлголт олж авахаас гадна өөрийн байгууллагын бүтээгдэхүүнийг хэрхэн тодорхойлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
3. Бүтээгдэхүүний өртөг тооцох болон үнэ зохиох	.. оролцогч нар бүтээгдэхүүний өртөг болон үнийн талаар ойлголт олж авахаас гадна өөрийн байгууллагын бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тооцох, үнэ зохиох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага

4. Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөлт	.. оролцогч нар стратеги төлөвлөлт болон үйл ажиллагааны төлөвлөлтийн үзэл санаа, арга барил, тэдгээрийг өөрийн байгууллага дээр хэрхэн тодорхойлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
5. Төлөвлөлт, санхүүгийн хяналт, эрх мэдэл шилжүүлэлт	…оролцогч нар төсөв зохиох арга барил, санхүүгийн хяналтын аргууд , тэдгээрийг өөрийн байгууллага дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
6. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, удирдлага	.. оролцогч нар хөрөнгө оруулалтын төсөв зохиох, удирдах арга барил, тэдгээрийг өөрийн байгууллага дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
7. Санхүүгийн удирдлага, шинжилгээ	.. оролцогч нар санхүүгийн удирдлагын ерөнхий ойлголт, арга барил, тэдгээрийг өөрийн байгууллага дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
8. Мөнгөн хөрөнгийн удирдлага	.. оролцогч нар мөнгөн хөрөнгийн удирдлагын шинэ тогтолцоо, түүнийг өөрийн байгууллагын хүрээнд хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага
9. Аккруэл буртгэл болон төсөвлөлт	.. оролцогч нар аккруэл суурьт буртгэл болон тайлагналт, төлөвлөлтийн ерөнхий зарчим, аргууд, тэдгээрийг өөрийн байгууллага дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголттой болно.	• Семинар / Ярилцлага • Гарын авлага • Тестийн хэлбэрээр шалгах • Дадлага

Хэрэгжүүлэх явцад эдгээр санал болгож буй сургалтыг боловсронгуй болгох талаар гүйцэтгэгч талаас (их сургууль, бусад сургалтыг явуулагч) шаардаж болно.

Засгийн газрын 2001 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШИНЭЧЛЭЛД ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ОЛГОХ ХӨРӨНГИЙН ХУВААРЬ

Байгууллагын нэр	Олгогдох хөрөнгийн хэмжээ (сая ам.доллар)
Үндэсний статистикийн газар	0.5
Төрийн хяналт шалгах хороо	0.3
Төрийн захиргааны албаны зөвлөл	0.4
Үндэсний татварын ерөнхий газар	0.6
Улсын гаалийн ерөнхий газар	0.5
Сурталчилгаа, ухуулан таниулах үйл ажиллагаа (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар)	0.2
Яамд	1.0
Агентлаг	0.5
Нийслэл, 6 аймаг	1.0
Нийт дүн	5.0

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12 (199)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Кассын машин ашиглах журам батлах тухай*
- *Олон улсын монголч эрдэмтдийн зөлжит VIII их хурлыг хуралдуулах тухай*
- *2001 оныг "Тахир дутуу иргэдийг дэмжих жил" болгох тухай*
- *"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны гуравдугаар сарын 28 №12 (199)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

130. Дүрэм, журам шинэчлэн батлах тухай	Дугаар 11	311
131. Мөнгөн шагнал олгох тухай	Дугаар 12	317
132. Кассын машин ашиглах журам батлах тухай	Дугаар 14	317
133. Олон улсын монголч эрдэмтдийн ээлжит VIII их хурлыг хуралдуулах тухай	Дугаар 15	320
134. 2001 оныг "Тахир дутуу иргэдийг дэмжих жил" болгох тухай	Дугаар 16	320
135. Өвөрхангай аймгийн Уянга сумын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 17	325
136. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 18	325
137. Төсөв захиран зарцуулах эрхийн тухай	Дугаар 19	325
138. Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай	Дугаар 21	326
139. Үндэсний зөвлөл байгуулах тухай	Дугаар 22	327
140. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай	Дугаар 23	330
141. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай	Дугаар 24	330
142. Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 25	331
143. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай	Дугаар 28	331
144. Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай	Дугаар 31	332

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 01 дүгээр сарын 24–ний өдөр **Дугаар 11** **Улаанбаатар хот**

Дүрэм, журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт, "Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэгчийн ажиллах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус батлалсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм, журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2001 оны 11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар /цаашид "газар" гэх/ нь төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаат хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

2. Газрын үндсэн зорилго нь төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа үл хөдлөх эд хөрөнгө, гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэн өмчлөгчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, үл хөдлөх эд хөрөнгийн талаархи мэдээллийн санг бий болгох, үл хөдлөх эд хөрөнгийн талаархи мэдээлэл лавлагаагаар үйлчлэх, иргэд болон хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг хамгаалахад оршино.

3. Газар нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4. Газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд түүний өмнө ажлаа хариуцан тайлагнана.

5. Газар нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Газар нь өөрийн билэгдэлтэй байж болно.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

6. Газрын удирдлага нь дарга, дэд даргаас бүрдэнэ.

7. Газрын даргыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын санал болгосноор Монгол Улсын Ерөнхий сайд, дэд даргыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг харгалзан Хууль зүй, дотоод хэргийн сайд томилж, чөлөөлнө.

Газрын дарга нь үл хөдлөх эд хөрөнгийн улсын ерөнхий бүртгэгч, дэд дарга нь ахлах бүртгэгч байна.

8. Газрын зохион байгуулалтын бүтцийг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална.

9. Газрын дарга Хууль зүй, дотоод хэргийн сайдтай үр дүнгийн гэрээ байгуулж, газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Засгийн газрын өмнө бүрэн хариуцаж тайлагнана.

10. Газрын даргын дэргэд түүнд зөвлөх үүрэг бүхий даргын зөвлөл ажиллана. Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

11.Газрын дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

а/газрын нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцан, байгууллагыг төлөөлөх;

б/Хууль зүй, дотоод хэргийн сайдыг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн талаархи мэдээллээр хангах;

в/иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

г/газрын дотоод журмыг баталж мөрдүүлэх, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

д/улсын бүртгэгчийн гаргасан хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх;

е/газрын хэлтэс, албадын дарга, улсын бүртгэгч болон бусад ажилтныг томилж, чөлөөлөх;

ж/ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах;

з/улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох, сэргээх;

и/газрын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ болон хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сарын 15-ны дотор боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулах;

к/тухайн жил дуусснаас хойш 30 хоногийн дотор үр дүнгийн гэрээг дүгнэж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэх.

12.Газрын дэд дарга үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаат мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулж, ажлаа газрын даргын өмнө хариуцна.

13.Газрын дэд дарга нь төв болон орон нутгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

14.Аймаг дахь Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн товчооны дарга нь тухайн аймгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаат удирдан зохион байгуулж, газрын даргын өмнө ажлаа хариуцан тайлагнана.

Орон нутагт товчоо байгуулах, нэгтгэх, татан буулгах асуудлыг газрын дарга Хууль зүй, дотоод хэргийн сайдтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

15.Газар нь хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, газрын кадастрт хяналт тавих үүрэг бүхий албатай байна. Албаны дүрмийг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална.

16.Хяналтын албаны ахлах мэргэжилтэн нь улсын байцаагчийн эрхтэй байна. Хяналтын алба нь хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, газрын кадастрт холбогдолтой санал, гомдол, зөрчлийг хянан ахлах байцаагч, улмаар ерөнхий байцаагчид санал оруулна.

Гурав.Газрын үйл ажиллагаа

17.Газар нь Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу дараахь үйл ажиллагааг явуулна:

а/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлэг хүлээн авах, хянан шийдвэрлэх;

б/үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн өмчлөх эрхийг бүртгэж, баталгаажуулах;

в/үл хөдлөх хөрөнгөтэй холбогдсон бүх гэрээг бүртгэж, баталгаажуулах;

г/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх;

д/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээг олгох;

е/үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхтэй холбогдсон болон барьцааны гэрээний бүртгэл хөтлөх;

ж/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, кадастрын бүртгэл, үнэлгээнд хяналт тавих;

з/шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагатай хамтарч үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаог зохион байгуулж явуулах;

и/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах;

к/үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой гэрээний талаархи мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах;

л/бүртгэлийн үйлчилгээний хураамжийг зохих журмын дагуу хураан үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулах;

м/үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, зөвлөлгөө өгөх;

н/үл хөдлөх эд хөрөнгийн талаархи мэдээлэл лавлагаа өгөх;

о/үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой газрын кадастрын зураглал, түүний хэмжээ /масштаб/ болон шаардлагатай бусад үзүүлэлтүүдийг бүртгэлд хавсран хадгалах.

Дөрөв.Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэгч,түүний эрх, үүрэг

18. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэгч /цаашид "улсын бүртгэгч" гэх/ хариуцаж явуулна.

19. Улсын бүртгэгчээр хууль зүйн дээд боловсролтой, төрийн захиргааны албаны шалгалтад тэнцсэн, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулна.

20. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлгийг хянаж хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд түүнийг улсын бүртгэлд бүртгэх шийдвэр гаргана.

21. Улсын бүртгэгч нь хувийн дугаар бүхий тэмдэгтэй байх бөгөөд тэмдгийн загварыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална. Тэмдгийг бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

22. Улсын бүртгэгч нь туслах бүртгэгчтэй байна. Туслах бүртгэгч нь улсын бүртгэгчийн удирдлага дор ажиллах бөгөөд хууль зүйн дээд боловсролтой байна.

Засгийн газрын 2001 оны 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭГЧИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэгч нь /цаашид "улсын бүртгэгч" гэх/ Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэхдээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Улсын бүртгэгч нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг сахих, шийдвэр гаргахдаа бусдын нөлөөнд үл автаж шударга байх зарчмыг баримтална.

Хоёр.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авах

3. Мэдүүлгийг хүлээн авахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын батлагаа маягтын дагуу бичигдсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлэг /цаашид "мэдүүлэг" гэх/ болон түүнд хавсаргасан бичиг баримтыг нэг бүрчлэн нягтлан үзэж, шаардлага хангасан тохиолдолд ирүүлсэн бичиг баримтын хуудас бүрийг дугаарлан хүлээн авсан он, сар, өдрийг тодорхой бичиж мэдүүлэгт гарын үсэг зуран хүлээн авна. Ингэхдээ мэдүүлгийн асуултыг мэдүүлэг гаргагч бүрэн гүйцэд, үнэн зөв хариулсан эсэхийг нарийвчлан шалгана.

4. Мэдүүлгийг дараахь тохиолдолд шаардлага хангаагүй гэж үзэж буцаана:

а/мэдүүлэг гаргагч мэдүүлгийн асуултыг гүйцэд хариулаагүй, гарын үсэг зураагүй;

б/мэдүүлэгт хавсаргах бичиг баримтын бүрдэл дутуу;

в/нотариатаар зайлшгүй батлан гэрчлэгдэх бичиг баримт гэрчлэгдээгүй, нотариатын тэмдэг бүрэн тод дарагдаагүй;

г/тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсийг төлөөгүй, эсхүл илүү буюу дутуу төлөөсөн;

д/бүрдүүлсэн бичиг баримт нь илт хуурамч байх.

Мэдүүлгийг буцаахдаа энэ талаархи үндэслэлээ мэдүүлэг гаргагчид тайлбарлан мэдүүлгийн тусгай тэмдэглэлийн хэсэгт бичиж, гарын үсгээ зуран, тэмдгээ дарна.

5. Улсын бүртгэгч нь шаардлагатай гэж үзвэл үнэлгээний тайлан, газар ашиглах, эзэмших гэрээ, гэрчилгээ, газрын кадастрын бичиг баримтыг хяналтын албаар хянуулж, дүгнэлт гаргуулах, үл хөдлөх эд хөрөнгө байгаа газар биечлэн очиж үл хөдлөх эд хөрөнгийн тоо,

хэмжээ, чанарын байдалтай танилцана.

6. Улсын бүртгэгч нь өмчлөх эрхийг нотлох бичиг баримтыг дутуу гэж үзвэл мэдүүлэг гаргагчаас нэмэлт материал шаардах эрхтэй.

7. Улсын бүртгэгч нь дараахь тохиолдолд мэдүүлгийг хүлээн авахаас татгалзана:

а/мэдүүлэгт хавсаргагдсан бичиг баримтаар өмчлөх эрх нотлогдохгүй;

б/бүрдүүлсэн бичиг баримт нь илт хуурамч;

в/уг үл хөдлөх эд хөрөнгө урьд нь бүртгэгдсэн;

г/тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч буюу эзэмшигчийн талаар маргаантай.

Улсын бүртгэгч нь мэдүүлгийг ямар үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаа тухай мэдүүлгийн тусгай тэмдэглэлийн хэсэгт бичиж гарын үсэг зуран, тэмдгээ дарж буцаана.

8. Улсын бүртгэгч нь мэдүүлгийг нягтлан үзээд түүнийг бүртгэх эсэх талаар эргэлзэх тохиолдолд асуудлыг газрын дэд даргад, шаардлагатай бол газрын даргад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

9. Улсын бүртгэгч нь мэдүүлгийг шаардлага хангасан тохиолдолд улсын бүртгэлийн дугаар олгож, улсын бүртгэлийн дэвтэрт бичилтийг зохих журмын дагуу хар бэхээр хөтөлж гарын үсгээ зуран, хувийн тэмдгээ дарна.

10. Улсын бүртгэгч нь бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн тэмдэглэлийг үндэслэн улсын бүртгэлийн гэрчилгээг бичиж бэлэн болгоно. Гэрчилгээ олгох журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд тогтооно.

11. Туслах бүртгэгч нь бүртгэлийн дэвтэрт хавсаргадаг баримт бичгийг хүлээн авсан он, сар, өдрийг дараалал баримтлан дугаарлаж, бүртгэлийн дэвтрийг эмх цэгцтэй, бүрэн бүтэн байлгах ажлыг хариуцан гүйцэтгэж энэ тухайгаа улсын бүртгэгчид танилцуулан гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичиж тэмдэглэнэ.

12. Туслах бүртгэгч нь тэмдэгтийн хураамжийг зөв төлсөн эсэхийг хянаж, улсын бүртгэгчид танилцуулна. Хураамж зөв төлөгдөөгүй тохиолдолд улсын бүртгэгч нь энэ журмын 4 дэх заалтын дагуу зохих арга хэмжээ авна.

13. Туслах бүртгэгч нь улсын бүртгэгчид өөрийн хариуцсан бүртгэлийн дэвтэр болон бусад шаардлагатай бичиг баримтыг ажлын цагаар архиваас хүлээж авах, хүлээлгэж өгөх болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хуулбар хийх, дугаар тодруулах, гэрчилгээ олгох, мэдүүлэг, түүнтэй холбоотой бичиг баримтыг хүлээн авах зэрэг ажилд туслан ажиллана.

Гурав.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, барьцааны гэрээг бүртгэх

14. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгө бусдын өмчлөлд шилжих гэрээ, эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг нь бүртгэлийн шаардлага хангасан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн дэвтэрт өөрчлөлт бичилт хийж, тэмдэглэл хөтлөн гарын үсгээ зурж хувийн тэмдгээ дарна.

15. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэн тохиолдолд түрүүчийн өмчлөгчийн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож, дараагийн өмчлөгчид шинээр гэрчилгээ олгоно.

Хүчингүй болгосон гэрчилгээнд "хүчингүй" гэсэн тэмдэг дарж, гарын үсгээ зуран бүртгэлийн дэвтэрт хавсаргахаар туслах бүртгэгчид өгнө.

16. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах, өв залгамжлах, гэрээслэх болон барьцааны гэрээг бүртгэх бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн, уг гэрээн дээр энэ тухай тэмдэг дарж гарын үсэг зурна.

Дөрөв.Бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх, бүртгэлийг түдгэлзүүлэх

17. Туслах бүртгэгч нь иргэд, хуулийн этгээдийн өмчлөх эрхээ хамгаалуулахаар гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийж энэ тухайгаа улсын бүртгэгчид танилцуулж улсын болон туслах бүртгэгчид гарын үсгээ зурна.

18. Улсын бүртгэгч нь урьдчилсан тэмдэглэл хийсэн тохиолдолд маргагч талууд тохиролцоонд хүртэл, эсхүл шүүхийн шийдвэр эцэслэн гартал уг бүртгэлд ямар нэг хөдөлгөөн хийх эрхгүй.

Тав.Лавлагаа, хуулбар өгөх, архивтай харилцах

19. Улсын бүртгэгч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч (хамтран өмчлөгч)-ийн зөвшөөрсөн баримтыг үндэслэн хуулиар хориглосноос бусад тохиолдолд уг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл лавлагааг хүсэлт тавьсан этгээдэд гаргаж өгөх зөвшөөрөл олгоно.

Энэхүү зөвшөөрлийг үндэслэн туслах бүртгэгч холбогдох мэдээллийг гаргаж өгнө.

20.Архивын ажилтан нь туслах бүртгэгчид архиваас дэвтэр олгох, түүнийг эргүүлэн авахдаа дэвтрийн дугаар, дэвтэрт хавсаргасан бичиг баримт болон хуудасны тоог тэмдэглэн авч бүрэн бүтэн байдлыг нь шалгаж гарын үсэг зуруулна.

Зургаа.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбогдуулан хяналт шалгалт явуулах

21. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулах байцаагчийн эрхтэй байна.

Байцаагчийн эрх олгох журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална.

22. Улсын бүртгэгч нь улсын байцаагчийн хувьд нь хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох этгээдэд шаардлага тавьж, үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлээс нуун дарагдуулсан буюу тоо хэмжээ, үнийг нь үндэслэлгүйгээр өсгөсөн буюу бууруулсан бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, давхар бүртгүүлэхийг оролдсон зэрэг гэм буруутай этгээдэд Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

23. Хяналт шалгалтаар буруу мэдүүлэг гаргасан нь тогтоогдож бүртгэлийн дэвтрийг цаашид хөтлөх боломжгүй болсон бол улсын бүртгэгч нь энэ тухай үндэслэлийг бичиж газрын дарга, дэд даргад танилцуулан шинээр дэвтэр нээж хөтлөх зөвшөөрөл аван хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

24. Холбогдох байгууллагаас хийж буй хяналт, шалгалтад улсын бүртгэгч үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнах үүрэгтэй.

25. Улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд Иргэний хууль, Эрүүгийн хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо.Бусад

26. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн дэвтэр бусад бичвэрт засвар хийхийг хориглоно. Засвар хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд засвар хийсэн улсын бүртгэгч нь энэ тухай дэвтэрт тэмдэглэж, гарын үсэг зурж, хувийн тэмдгээ дарна.

27. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг буруу хийсэн тохиолдолд түүнийг уг бүртгэлийг хийсэн улсын бүртгэгчийн саналыг үндэслэн ерөнхий бүртгэгч хүчингүй болгож залруулга хийх шийдвэр гаргана.

28. Улсын бүртгэгч бүртгэлийн гэрчилгээнд алдаатай бичилт хийсэн бол уг гэрчилгээг хүчингүй болгож байгууллагын санхүүд тушаана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Дугаар 12 **Улаанбаатар хот**

Мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНСУ-ын Кванжу хотод зохиогддог Орчин үеийн шинэ урлагийн төрлүүдийг дэмжих Кванжу-2000 буюу "Хүн ба орон зай" сэдэвтэй олон улсын биенналд оролцож 1 дүгээр байрын шагнал хүртсэн Сэрээтэр овогтой Дагвадоржид 8,0 (найман) сая, БНХАУ-ын Шанхай хотод болсон Азийн шилдэг дуулаачдын олон улсын наадамд оролцож 3 дугаар байр эзэлж хүрэл медаль хүртсэн эстрадын дуучин Баттулга овогтой Мишээлтэд 2,0 (хоёр) сая төгрөгийн мөнгөн шагнал тус тус олгосугай.

2. Мөнгөн шагналд шаардагдах мөнгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Дугаар 14 **Улаанбаатар хот**

Кассын машин ашиглах журам батлах тухай

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах,боловсон үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Кассын машин ашиглах журам"-ыг хавсралт ёсоор батлэсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Нутаг дэвсгэр дээрээ бэлэн мөнгөөр худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 2001 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн кассын машин ашиглах журамд шилжүүлэх, тэдгээрийг хамруулах хүрээ, эзлэх дарааллыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг даалгах нь:

а/хэрэглэж байгаа кассын машин нь түүнд тавигдах шаардлага болон хэрэглэгчдийн эрх ашигт нийцэж байгаа байдалд хяналт тавьж байсугай;

б/кассын машин хэрэглэж байгаа газруудаас худалдаж авсан бараа нь шаардлага хангаагүй тохиолдолд кассын тасалбарыг үндэслэн түүнийг буцаан өгөх журмыг Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран тогтоож мөрдүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 14 дүгээр тогтоолын хавсралт

КАССЫН МАШИН АШИГЛАХ ТУХАЙ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь худалдаа, үйлчилгээг бэлэн мөнгөөр хийж байгаа кассын машин хэрэглэгчийг татварын албанд бүртгэх болон кассын машин ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээг бэлэн мөнгөөр хийж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь кассын машин хэрэглэгч байна.

3. Кассын машин хэрэглэгчийг үндэсний татварын албаа бүртгэнэ.

4. Эрх бүхий байгууллагаас баталсан техник, стандартын шаардлага хангасан, Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглахыг зөвшөөрсөн, санах ой бүхий, бэлэн мөнгөний гүйлгээ хийх зориулалттай тоног төхөөрөмжийг кассын машин гэнэ.

Хоёр. Кассын машинд тавих шаардлага

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах кассын машины улсын стандарт, чанарын баталгаажуулалтыг Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн дагуу Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв тогтоож, байнгын хяналт тавина.

6. Кассын машин нь дараахь тусгай шаардлага хангасан байна:

а/тасалбар дээр аж ахуйн нэгж, байгууллага (дэлгүүр)-ын нэр, татвар төлөгчийн дугаар, тасгийн дугаар, тухайн кассын машины үйлдвэрийн дугаар, гүйлгээ хийгдсэн дугаар, он, сар, өдөр гэх мэт мэдээллийг тэмдэглэх боломжтой байх;

б/тасалбарын мөр тус бүрт 24 үсэг тэмдэгтээр, барааны үнийг 8 орноос дээш тоогоор оруулах боломжтой байх;

в/тэжээллээс үл хамааран мэдээллийг удаан хугацаагаар хадгалах санах ойн байгууламжтай байх;

г/нэмэгдсэн өртгийн албан татварын дүнг тасалбар дээр тусад нь ялгаж бичдэг байх;

д/санах ойг 5 жилээс доош хугацаанд сольдоггүй байх;

е/мөнгө хураагчийн буруу үйлдэл болон бусад буруу (хяналтын лент тасрах) ажиллагааны алдааг дохио өгч мэдээлдэг байх;

ж/татварын байцаагч, эрх бүхий байгууллагын ажилтан, кассын ажилтан тус тусын нууц түлхүүрээр кассын машинд нэвтэрдэг байх;

з/мөнгөн дэвсгэрт болон зоосны тасалгаа бүхий мөнгөний хайрцагтай байх;

и/мөнгө буцааж олгох буюу тасалбарыг хүчингүй болсныг тэмдэглэж болдог байх.

Гурав. Кассын машин хэрэглэгчийн эрх, үүрэг

7. Кассын машин хэрэглэгч дараахь эрхтэй байна:

а/кассын машины хэвийн үйл ажиллагаа алдагдах буюу эвдэрсэн тохиолдолд техникийн засвар, үйлчилгээ хариуцсан ажилтанг дуудах;

б/хэрэглэгчээс үл хамаарах шалтгаанаар кассын машиныг ажиллуулах боломжгүй (цахилгаан тасрах гэх мэт) тохиолдолд харьяалагдах татварын албаанаас олгосон гар тасалбараар худалдаа, үйлчилгээ явуулах.

Гар тасалбарын загварыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

8. Кассын машин хэрэглэгч дараахь үүрэгтэй байна:

а/кассын машин ашиглаж эхлэхээс өмнө харьяалагдах татварын албанд бүртгүүлэх;

б/кассын машин алдаатай, буруу ажилласан, эвдэрсэн тохиолдолд шалтгааныг тодорхойлон акт үйлдэж харьяалагдах татварын албанд 72 цагийн дотор мэдэгдэх;

в/кассын машиныг зориулалт, тогтоосон дүрэм, журмын дагуу ашиглах;

г/бэлэн мөнгөний гүйлгээ хийснийг гэрчлэх кассын машинаар боловсруулсан тасалбарыг үйлчлүүлэгчид олгох;

д/татварын албанаас хяналт, шалгалт хийхээр томилогдсон эрх бүхий татварын улсын байцаагч, кассын машины засвар үйлчилгээ хариуцсан ажилтныг кассын машин дээр ажиллахад саад учруулахгүй байх, шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

е/барааны үнийг бараа тус бүр дээр үнэн зөв бичиж тэмдэглэх, үйлчилгээний үнийн жагсаалтыг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар

байрлуулах, барааны үнийг нэмэгдсэн өртгийн татвартай бичнэ;

ж/эрх бүхий байгууллагаас кассын машинд тавьсан лац, ломбо, бусад тэмдэглэлийг хөдөлгөхгүй байх;

з/мөнгө хураагчийн дэвтэр хөтлөх. Тухайн өдрийн борлуулалтын хураангуй тасалбараа хадгалах;

Мөнгө хураагчийн дэвтрийн загварыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

и/худалдаа, үйлчилгээнд зураасан кодын систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

к/кассын машины паспорт бусад дагалдах бичиг, баримтыг хадгалах.

9.Кассын машин хэрэглэгчид дараахь зүйлийг хориглоно:

а/кассын машин ашиглахгүйгээр худалдаа, үйлчилгээ хийх;

б/кассын машины программыг дур мэдэн өөрчлөх.

Дөрөв. Татварын албаны эрх, үүрэг

10. Татварын алба дараахь эрхтэй байна:

а/Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр чанарын баталгаажуулалт хийлгэж, шаардлага хангасан кассын машиныг бүртгэж, үйлчилгээнд ашиглах эрх олгох;

б/зөрчил байгаа эсэхийг шалгах зорилгоор хяналтын худалдан авалт хийж, илэрсэн зөрчлийн талаар тайлбар, лавлагаа гаргуулах;

в/энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад татварын хуулинд заасны дагуу торгууль ногдуулах бөгөөд банкны харилцах дансыг хаах, худалдаа, үйлчилгээ явуулах эрхийг нь сунгахгүй байх, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоох асуудлыг холбогдох байгууллагад тавих.

11.Татварын алба дараахь үүрэгтэй байна:

а/иргэн, аж ахуйн нэгж, байгууллага кассын машин ашиглахгүйгээр гүйлгээ хийж байгаа болон кассын машины ашиглалтад хяналт тавих, зөрчлийг арилгуулах;

б/үйлчлүүлэгчдэд борлуулалтын тасалбар олгож байгаа эсэхэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах.

Тав. Кассын машин худалдах, түүнд засвар үйлчилгээ хийх

12. Кассын машин худалдах, түүнд засвар, үйлчилгээ хийх аж ахуйн нэгж, байгууллагыг Санхүү, эдийн засгийн сайдын тушаалаар томилогдсон комисс сонгон шалгаруулна.

13. Аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад дор дурдсан зүйлийг харгалзан үзнэ:

а/энэ журмын 5, 6 дугаар заалтад дурдсан шаардлагыг хангасан байдал;

б/техникийн найдвартай ажиллагаа;

в/программ хангамжийг монголын нөхцөлд тохируулсан байх;

г/үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн энэ чиглэлд ажилласан туршлага;

д/засвар, үйлчилгээг бүрэн хариуцан хийх, сэлбэг хэрэгслээр хангах, кассын машины болон сэлбэг хэрэгслийн үнэ харьцангуй хямд байх.

14. Кассын машин худалдах, түүнд засвар, үйлчилгээ хийхээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагатай Үндэсний татварын ерөнхий газрын дарга гэрээ байгуулна.

15. Кассын машин ашиглах журмыг зөрчсөн этгээдэд татварын улсын байцаагч Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 15** **Улаанбаатар хот**

Олон улсын монголч эрдэмтдийн ээлжит ҮШ их хурлыг хуралдуулах тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олон улсын монголч эрдэмтдийн ээлжит ҮШ их хурлыг 2002 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо хуралдуулах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны саналыг зөвшөөрсүгэй.

2. Их хуралд бэлтгэх, түүнийг зохион байгуулах комиссыг яам, агентлаг, Шинжлэх ухааны академи, Олон улсын монгол судлалын холбоо, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, эрдэмтэн, мэргэжилтний оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр томилж ажиллуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад, хурлын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын төвлөрсөн төсвөөс гаргах зардлыг тооцон 2002 оны төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 16** **Улаанбаатар хот**

2001 оныг "Тахир дутуу иргэдийг дэмжих жил" болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгаалллыг сайжруулах, тэдний эрх ашгийг хамгаалахад төрөөс бүх талын дэмжлэг үзүүлэх зорилгоор 2001 оныг "Тахир дутуу иргэдийг дэмжих жил" болгон зарласугай.

2. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн хүрээнд хийх ажлыг зохион байгуулах Үндэсний хороог байгуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

3. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор батлуулж, түүнд шаардагдах 121,0 (нэг зуун хорин нэгэн) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаанд зөвшөөрсүгэй.

4. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг орон нутгийнхаа хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлэн, явц, үр дүнг Үндэсний хороонд тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш. БАТБАЯР**

Засгийн газрын 2001 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНДХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд

Гишүүд -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга;

-Боловсрол,соёл,шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Дэд бүтцийн яамны Барилга, хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн захирал;

-Монголын тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны ерөнхийлөгч /өөртэй нь тохиролцоноор/;

-Хүний төлөө сангийн тэргүүн /өөртэй нь тохиролцоноор/;

-Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгийн тэргүүн /өөртэй нь тохиролцоноор/.

Нарийн бичгийн дарга -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны тахир дутуу иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

Засгийн газрын 2001 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага	Улсын төсвөөс зарцуулах хөрөнгө /сая төг/
1.	Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын арга хэмжээг өргөжүүлэн, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах	Эхний хагас жилд	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын нийгмийн халамжийн газар	
2.	Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборыг өргөжүүлэн тахир дутуу хүүхдийн асрамжийн 2 анги нээн ажиллуулах, тахир дутуу хүүхдийг гэрийн халамж, үйлчилгээнд хамруулах	9 дүгээр сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Улсын нийгмийн халамжийн газар, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар	40,0
3.	Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн үйл ажиллагаа, мэргэжлийн сургалтын төрлийг өргөжүүлэх асуудлыг судлан холбогдох байгууллагад санал тавих	9 дүгээр сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв	

4.	Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой хууль эрхийн актуудыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын нийгмийн халамжийн газар, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
5.	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрхийн актуудыг боловсруулж шийдвэрлэх	Эхний хагас жилд	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр зохицуулалтын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгаал-лын улсын хяналтын алба	
6.	Тахир дутуу иргэдийн мэдээлэл, судалгааны төв байгуулан ажиллуулах	7 дугаар сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	3,0
7.	Зарим албан байгууллага, үйлчилгээний газруудад тахир дутуу иргэд чөлөөтэй нэвтрэх боломж бүрдүүлэх, зам, дохиолол, гарц байгуулах	6 - 10 дугаар сард	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Дэд бүтцийн яам, Эрүүл мэндийн яам, Улсын нийгмийн халамжийн газар	20,0
8.	Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, орон нутагт шалгах, Үндэсний хорооны хурлаар зарим аймгийн Засаг даргын мэдээллийг сонсох, заавар, зөвлөлгөө өгөх	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Үндэсний хороо, Улсын нийгмийн халамжийн газар, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв	
9.	Сонсголгүй, тахир дутуу иргэдэд зориулсан жолооны курс нээн хичээллүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх	9 дүгээр сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Замын цагдаагийн газар, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
10.	Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох зорилгоор төсөл хэрэгжүүлэх, зээл, тусламж авах асуудлыг гадаад, дотоодын байгууллагад тавих	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам, Хөдөлмөр зохицуулалтын газар, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
11.	Протез, ортопедийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, явуулын үйлчилгээ үзүүлэх техник, төхөөрөмжөөр хангах	6 дугаар сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв	8,0

12.	Хараагүй хүмүүсийн номын сан байгуулан, зориулалтын брайлын ном, сонин, сэтгүүл, хуурцаг, компьютер, бусад тоног төхөөрөмжөөр хангах	5 дугаар сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Улсын нийгмийн халамжийн газар, 29 дүгээр тусгай сургууль	5,0
13.	Тахир дутуу иргэдийг зориулалтын тэргэнцэр, мэдрэмжтэй таяг, сонсголын аппарат зэрэг шаардлагатай хэрэгслээр хангах	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн халамжийн газар, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв	
14.	Монголын Үндэсний телевизийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрийг дохионы орчуулгатайгаар нэвтрүүлдэг болгох	2 дугаар сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар	5,0
15.	Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийг Нөхөн сэргээлтийн олон улсын холбоонд гишүүнээр элсэх асуудлыг судлах	Эхний хагас жилд	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Санхүү, эдийн засгийн яам, Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв	
16.	Тусгай сургуулийн буюу дүлий хүүхдийн багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж 21 аймгаас мэргэжилтэн сургах	8 дугаар сард	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, 29 дүгээр тусгай сургууль	5,0
17.	Монгол Улсад дохионы хэлний нэг систем тогтоох, уг дохионы хэлний нэгдсэн стандарт боловсруулах	9 дүгээр сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, 29 дүгээр тусгай сургууль, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
18.	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх үйлдвэрийг өргөжүүлэн үйлдвэрлэлийн чиглэлийг оновчтой тогтоох, санхүү, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. Санхүү, эдийн засгийн яам, Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газар, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх үйлдвэр, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	25,0
19.	Төрийн зарим чиг үүргийг Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоогоор гүйцэтгүүлэх асуудлыг судлах	5 дугаар сараас	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
20.	Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн үйл ажиллагааг сурталчлах, тахир дутуу иргэдийн талаар цуврал нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэх	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, Улсын нийгмийн халамжийн газар, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	

21.	Ердийн хэв шинжтэй өрөнхий боловсролын сургуульд тахир дутуу хүүхдийг суралцахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Жилдээ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам	
22.	Дэлхийн Цагаан таягтны өдрийг "Гэрэл, гэгээ хайрлацгаая" уриан дор тэмдэглэх	10 дугаар сард	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монголын хараагүйчүүдийн нийгэмлэг	
23.	Тахир дутуу хүмүүсийн олон улсын өдрийг "Энэрэнгүй үйлсийг бүх нийтээрээ дэмжицгээе" уриан дор тэмдэглэх	12 дугаар сард	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн халамжийн газар, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
24.	Тахир дутуу иргэдийн сэргээн засах эмчилгээний төв, хувийн эмнэлгүүдийн үйл ажиллагаат дэмжин, туслалцаа үзүүлэх	Жилдээ	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	
25.	Тахир дутуу иргэдийг дэмжүүлэх асуудлыг гадаад орон, олон улсын байгууллагад тавьж тусламж, дэмжлэг авах, төсөл хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан зохицуулах зэргээр гадаад харилцаат өргөжүүлэх	Жилдээ	Гадаад хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
26.	Тахир дутуу иргэдийн дунд зохиогддог олон улсын болон дотоодын уралдаан тэмцээнд тамирчдыг өргөнөөр оролцуулах	10 - 12 дугаар сард	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн халамжийн газар, Монголын Пара-Олимпийн хороо, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
27.	"ЭНЭРЭНГҮЙ ҮЙЛСТЭН" өргөмжлөл бий болгон тахир дутуу хүмүүст тусалдаг аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийг шагнаж урамшуулах, жилийн хүрээнд урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Үндэсний хороо, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	10,0
28.	Үйлдвэрлэлийн осол, тахир дутуу болохоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгаалал, эрүүл аж төрөх ёсны талаар сургалт, семинарыг томоохон үйлдвэр, аж ахуйн газарт зохион байгуулах	5 - 10 дугаар сард	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр зохицуулалтын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын алба	
29.	Тахир дутуу иргэдэд зориулсан хандив, тусламжийн хөрөнгийг тахир дутуу иргэдийн үйл ажиллагаат дэмжих санд төвлөрүүлэн зарцуулах	Жилдээ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	
	ДҮН			121,0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Дугаар 17 **Улаанбаатар хот**

Өвөрхангай аймгийн Уянга сумын талаар авах зарим арга хэмжээний тухай

Өвөрхангай аймгийн Уянга сумын төвийн барилга байгууламж, шугам сүлжээний талаар мэргэжлийн байгууллагуудын гаргасан дүгнэлт болон Дэд бүтцийн яамны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн Уянга сумын төвд шинээр барих барилгуудыг мэргэжлийн байгуллага судалж санал болгосон "Зүүн Түрүүний Зүүн Хажуу" гэдэг газарт төвлөрүүлсүгэй.

2. Дээр дурдсан газарт газрын зураг зохиох, сумын төвийн ерөнхий төлөвлөгөө болон хүн эмнэлгийн барилгын зураг төсөл боловсруулах ажлыг 2001 оны Ш улиралд багтаан гүйцэтгэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгаж, шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргасугай Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Уянга сумын төвд шинээр барилга барихад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үе шаттайгаар тусган хэрэгжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Батмөнх нарт даалгасугай.

4. Уянга сумын төвийг шинээр барилгажуулах үйл ажиллагаат зохицуулах ерөнхий захиалагчийн үүргийг Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газарт хариуцуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Дугаар 18 **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

"Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 5 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Зарим бараг БНМАУ-ын улсын хилээр гаргахыг түр хориглох тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 179 дүгээр тогтоол, "Зарим нэр төрлийн бараг улсын хилээр нэвтрүүлэхийг журамлах тухай" Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Дугаар 19 **Улаанбаатар хот**

Төсөв захиран зарцуулах эрхийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалах салбарын зэвсэглэл, техникийн шинэчлэл, төвлөрсөн журмаар хийгдэх их засвар, Батлан хамгаалах яамны бодлого, захиалгаар хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажил, гадаадад суралцагчдын

сургалтын зардал, хөрөнгө оруулалтын төвлөрсөн төсвийнхөөс бусад урсгал зардлын төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхийг Зэвсэгт хүчний ерөнхий штаб, Улсын иргэний хамгаалалтын газарт олгохыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад зөвшөөрсүгэй.

2. Эрхлэх ажлын хүрээний агентлагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төсөв захиран зарцуулах эрхийн тухай" Засгийн газрын 2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 6 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр **Дугаар 21** **Улаанбаатар хот**

Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад орны Засгийн газар хоорондын байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссууд, түүнтэй адилтгах бүтцийн Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тухайн оронтой явуулж байгаа хамтын ажиллагааны цар хүрээ, зонхилох чиглэл, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай уялдуулан хуралдаанд Монголын талаас оролцох төлөөлөгч, шинжээчдийн бүрэлдэхүүнийг комиссын Монголын хэсгийн дарга нар тухай бүр томилж байхаар тогтоосугай.

3. Монгол-Орос, Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийг нарийн бичгийн дарга нарын газартай болгож, бүрэлдэхүүнийг Монголын хэсгийн дарга томилж байхаар, бусад комиссуудын Монголын хэсгийн нарийн бичгийн даргыг Гадаад хэргийн яамны тухайн орныг хариуцсан ажилтан байхаар тус тус тогтоосугай.

4. Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн үйл ажиллагааны зардлыг төвлөрсөн төсвөөр санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 198 дугаар тогтоол, "Монгол-Казахын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1998 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 78 дугаар тогтоол, "Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 117 дугаар тогтоол, "Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн Үндэсний зохицуулагч, түүний орлогчийг томилох тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 21 дүгээр тогтоол, "Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 11 дугээр сарын 17-ны өдрийн 182 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

Засгийн газрын 2001 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССУУДЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

1. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Дэд бүтцийн сайд
Орлогч дарга	Гадаад хэргийн дэд сайд; Үйлдвэр худалдааны дэд сайд.

2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Дэд бүтцийн сайд
Орлогч дарга	Гадаад хэргийн дэд сайд; Үйлдвэр, худалдааны дэд сайд.

3. Монгол Улс, Европын холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга	Санхүү, эдийн засгийн сайд

4. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол-Италийн Засгийн газар хоорондын холимог Комиссын Монголын хэсэг

Дарга	Үйлдвэр, худалдааны дэд сайд

5. Худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах Монгол-Болгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Байгаль орчны сайд

6. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Украины Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Үйлдвэр, худалдааны сайд

7. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

8. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Хууль зүй, дотоод хэргийн сайд
Орлогч дарга	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд

9. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Хууль зүй, дотоод хэргийн сайд

10. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд

11. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Кубын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Эрүүл мэндийн дэд сайд

12. Монгол-Туркийн эдийн засаг, худалдааны хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

13. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Финландын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга	Гадаад хэргийн дэд сайд

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр **Дугаар 22** **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөл байгуулах тухай

Дэлхийн эмэгтэйчүүдийн IY бага хурал болон 2000 оны YI сард болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тусгай чуулганы шийдвэр, Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эмэгтэйчүүдийн асуудлаархи Үндэсний зөвлөлийг Хүйсийн тэгш байдлын асуудлаархи Үндэсний зөвлөл болгон шинэчлэн зохион

байгуулсугай.

2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1996 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 283 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйл, "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 20 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2001 оны 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫН АСУУДЛААРХИ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Шатар

Орлогч дарга -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд С.Чинзориг

Гишүүд: -Улсын Их Хурлын гишүүн, Эмэгтэй парламентчдын бүлгийн ахлагч Б.Долгор (өөртэй нь тохиролцсоноор);

-Эрүүл мэндийн дэд сайд Н.Удвал;

-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал О.Энхцэцэг;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Д.Мөнхгэрэл;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Дамдинсүрэн;

-Байгаль орчны яамны Стратегийн төлөвлөлт, удирдлагын газрын дарга Н.Сарантуяа;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын Бодлого,төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Пунцагсүрэн;

-Хөдөлмөр, нийгмийн хамгаллын улсын хяналтын албаны дарга Ц.Энхтайван;

-Үндэсний статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга Д.Оюунчимэг (Үндэсний статистикийн газрын даргатай зөвшилцсөнөөр);

-НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн ажилтан О.Оюунцэцэг (өөртэй нь тохиролцсоноор);

-"Баярсонстракшн" ХХК-ийн захирал Н.Баянсайхан (өөртэй нь тохиролцсоноор);

-Гал голомт хөдөлгөөний тэргүүн Д.Мөнхөө (өөртэй нь тохиролцсоноор).

Зохицуулагч -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Жендерийн хөгжлийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн С.Рэгзэн.

Засгийн газрын 2001 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХУЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫН АСУУДЛААРХИ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Хүйсийн тэгш байдлын асуудлаарх Үндэсний зөвлөл /цаашид зөвлөл гэх/ нь улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах, эрх ашгийг нь хамгаалахтай холбогдсон төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагаат нь уялдуулан зохицуулах, мэдээллээр хангахад туслах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Зөвлөлийн үндсэн зорилго нь хүйсийн тэгш байдлыг хангах талаар төрөөс явуулж байгаа бодлого, хууль тогтоомж, манай улсын нэгдэн орсон олон улсын конвенци болон Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, санал дүгнэлт гаргахад оршино.

3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Монгол Улсын олон улсын гэрээг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

4. Зөвлөл нь дарга, дэд дарга, зохицуулагчтай байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батлах бөгөөд дарга нь Засгийн газрын

Хэрэг эрхлэх газрын дэд дарга, орлогч дарга нь нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэд сайд бөгөөд түүс байгууллагын хүйсийн тэгш байдлын асуудал хариуцсан ажилтан нь зөвлөлийн зохицуулагч байна.

5. Зөвлөлийн ажлын албаны үүргийг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

6. Зөвлөл нь ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөх бөгөөд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүр ажлаа тайлагнана.

7. Зөвлөл нь хагас жил тутам 1-ээс доошгүй удаа хуралдана. Ажлын шаардлагаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

8. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

9. Зөвлөл нь дор дурдсан эрхтэй байна:

а/хүйсийн тэгш байдлыг хангах талаар төрөөс явуулж буй бодлого, хууль тогтоомж, энэ чиглэлээр түс улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн хэрэгжилтийн талаар зөвлөмж гаргах, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал оруулах;

б/шинээр боловсруулагдаж буй хууль тогтоомж, хөтөлбөрийн төсөлтэй танилцаж хүйсийн тэгш байдлын асуудлаар санал өгөх, холбогдох байгууллагын зөвшөөрлөөр ажлын хэсэгт зөвлөлийн гишүүдээс томилж оролцуулах;

в/хүйсээр ялгаварлан гадуурхсан, эсвэл хүйсийн тэгш байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан гаргасан тохиолдолд уг асуудлаар санал дүгнэлт гаргах, холбогдох байгууллага болон олон нийтэд хандаж тайлбар гаргах, Хүний эрхийн комисс, шүүхэд хандах;

г/холбогдох мэдээ, материалыг зохих байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

д/улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээнд хүйсийн тэгш байдлыг хангах талаар үйл ажиллагаа явуулж, үр дүнд хүрсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх талаар эрх бүхий байгууллагад санал оруулах.

10. Зөвлөл нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

а/хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн асуудлаархи хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихад төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх;

б/ хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний хэмжээний хөтөлбөр, шийдвэрийн хэрэгжилтийн явц, шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаар Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт мэдээлэл өгөх;

в/олон нийттэй холбоо тогтоох, тэдний санал бодлыг судлах ажлыг холбогдох байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах, санал, зөвлөмж боловсруулж, танилцуулах;

г/төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжиж, үйл ажиллагаагаа нь уялдуулах, арга туршлагаа солилцож хамтран ажиллахад нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

д/хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн асуудлаар олон улсын болон гадаад орнуудын холбогдох байгууллагатай харилцаа тогтоох, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, Монгол улсаас НҮБ болон олон улсын бусад байгууллагуудад оруулах илтгэл, тайлан, мэдээллийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Зөвлөлийн санхүүжилт

11. Зөвлөл нь дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

а/хөтөлбөр, төслийн санхүүжилт, хандив тусламж;

б/бусад.

Тав. Салбар зөвлөл

12. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд салбар зөвлөл ажиллуулж болно.

13. Салбар зөвлөл нь Үндэсний зөвлөлийн зорилт, эрх үүргийг тухайн нутаг дэвсгэрийнх хэмжээнд хэрэгжүүлж, Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй.

14. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны Засаг дарга батална.

15. Салбар зөвлөл нь ажлаа тухайн шатны Засаг даргад тайлагнана.

16. Салбар зөвлөл нь хагас жил тутам ажлын тайлангаа Үндэсний зөвлөлд ирүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Дугаар 23 **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

"Хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2000 оны 30 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тогоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийг сэргээх, энэ чиглэлээр байгуулагдсан тогоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар 2001-2004 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг 2001 оны I улиралд багтаан баталж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 23 дугаар тогтоолын хавсралт

"ОЙ, МОД БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ СЭРГЭЭХ,ТУХАЙН ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАГДСАН ТОГОНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Үйлдвэр, худалдааны сайд

Орлогч дарга -Байгаль орчны дэд сайд

Гишүүд: -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Дэд бүтцийн яамны Барилга, хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга;

-Байгаль орчны яамны Байгалийн нөөцийн газрын дарга;

-Үйлдвэр, худалдааны яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;

-Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;

-Монголын Ойчдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын ой, модны үйлдвэрүүдийн ассоциацийн тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга -Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Дугаар 24 **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 2 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн батлагдсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 24 дүгээр тогтоолын хавсралт

"ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Үйлдвэр, худалдааны сайд

Орлогч дарга -Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Гишүүд: -Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого зохицуулалтын газрын орлогч дарга;

-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн төлөөлөл, удирдлагын газрын дарга;

-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга;

-Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын бизнесийн хөгжлийн агентлагийн захирал (тохиролцсоноор);

-Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга -Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын Жижиг, дунд үйлдвэрийн хэлтсийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр **Дугаар 25** **Улаанбаатар хот**

Журамд өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Урьд нь босгосон хөшөө, дурсгалыг буулгах,..." гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

"Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор батализан журмын 3 дугаар заалтын "в"-гийн "дурсгалын хөшөө босгох, ..." гэснийг, 5 дугаар заалтын "г", 16 дугаар заалтын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 02 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 28** **Улаанбаатар хот**

"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Говь-Алтай аймгийн Тонхил сумын Бүс-уул багийн малчин Сандагсүрэнгийн Бодь, Ховд аймгийн Дарви сумын Мөнгөн-Аяга багийн малчин Гэндэнгийн Давгадорж, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 5 дугаар багийн малчин Шаривханы Битан, Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц багийн малчин Довчингийн Цэдэв, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын 5 дугаар багийн малчин Батхүүгийн Дуламдорж, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 3 дугаар багийн малчин Намсрайн Баатар, Архангай аймгийн Өгийнуур сумын Орхон багийн малчин Жамцын Хишгээ, Сүхбаатар аймгийн Халзан сумын 2 дугаар багийн малчин Лхамжаагийн Цэвээгсүрэн, Булган аймгийн Гурванбулаг сумын Бэрх багийн малчин Пүрвээгийн Мэндсайхан, Төв аймгийн Баянжаргалан сумын Эрдэнэ багийн малчин Гүрийн Бат-Эрдэнэ нарыг "Улсын сайн малчин"-аар; Увс аймгийн Тариалан сумын "Алтандуулга" ХХК, Булган аймгийн Орхон сумын "Халиун тариа" ХХК, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийг "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-оор тус тус шалгаруулсугай.

2. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-д олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлийн үнэд зориулж 4 сая 550 (дөрвөн

сая таван зуун тавин) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. "Улсын сайн малчин, "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах журмыг шинэчлэн энэ оны эхний хагас жилд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 31 Улаанбаатар хот

Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгүүдэд шилжүүлэх тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг, тэдгээрт шилжих журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт олон улсын "А" жагсаалтын малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан эдгээр аймгийн нутгийн захиргааны болон холбогдох бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын албадыг иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2001 оны 2 дугаар сарын 11-нээс эхлэн шилжүүлж, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Асгат, Баруун-Урт, Сүхбаатар, Дарьганга, Дорнод аймгийн Хөлөнбуйр, Хэрлэн, Булган, Баянтүмэн, Чойбалсан, Матад сумын нутаг дэвсгэрт бүхэлд нь хорио цээрийн онцгой дэглэм, эдгээр аймгийн бусад сумын нутаг дэвсгэрт хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

/Энэ зүйлийн "Хөлөнбуйр, Хэрлэн, Булган, Баянтүмэн, Чойбалсан, Матад" гэсэн хэсгийг 2001 оны 32-р тогтоолоор хассан, мөн 2001 оны 33-р тогтоолоор 1-р зүйлийг хүчингүй болсонд тооцсон/

2. Сүхбаатар, Дорнод аймгийн зарим сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан Хэнтий, Дорноговь аймгийн нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын албадыг иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. Сүхбаатар, Дорнод аймгийн Засаг дарга Т.Дашсүрэн, Д.Одбаяр нарт даалгах нь:

а/иргэний хамгаалалтын штаб, мэргэжлийн ангиуд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг зохих журам, удирдамжийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, малын гоц халдварт өвчний халдварын голомт, тархалтыг тогтоох, устгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсүгэй;

б/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон хугацаанд иргэдийн зорчилт, бүх төрлийн тээвэрийн хэрэгсэл, малын шилжилт, хөдөлгөөнийг зогсоон журамлах арга хэмжээ авсугай.

4. Хэнтий, Дорноговь аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар, Ж.Батсуурь нарт даалгах нь:

а/нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хамгаалалтын албадын үйл ажиллагаат өндөржүүлсэн бэлэн байдлын удирдамжийн дагуу зохион байгуулсугай;

б/өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд иргэд, мал сүрэг, машин техникийн шилжилт, хөдөлгөөнийг хязгаарлан журамлах арга хэмжээ авсугай;

в/мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт отрядуудыг бэлэн байдалд оруулж, бүх сум, баг, хот айлын малд гоц халдварт өвчний шинж байгаа эсэхийг магадлан тогтоолгох, малыг байнгын хариулга маллагаанд оруулж, хот айлуудын байршлыг харгалзан 15-20 хот айл тутамд малын эмч мэргэжилтэй хүн томилон хяналт тавиулж, малчдад мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгүүлэх ажлыг зохион байгуулсугай.

5. Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/малын гоц халдварт өвчний

халдвар, тархалтаас сэргийлэх, голомтыг устгах, түүнчлэн иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжэн тухай мэдээллийг нийтэд хүргэн ойлгуулах, таниулах арга хэмжээ авсугай;

б/малын гоц халдварт өвчний шинж тэмдэг, тархалт, халдвар хамгаалал, авч байгаа арга хэмжээний талаархи цагийн байдлыг зохих журмын дагуу Улсын иргэний хамгаалалтын газарт мэдээлж байсугай;

в/энэ тогтоолын 4 дүгээр зүйлийн "в"-д заасны дагуу хэсэгчлэн хяналтад оруулсан хот айлын малд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тэдгээрийг хорио цээрийн арга хэмжээнд яаралтай оруулж, энэ талаар мэдээлэх, халдвар тархахаас хамгаалсан иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байсугай;

г/хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах гол зам, гүүрүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, шалган нэвтрүүлэх цэг байгуулж байнгын ажиллагаанд оруулсугай.

6. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь:

а/малын гоц халдварт өвчний халдварын тархалтын хүрээг бүрэн тодорхойлж, хорио цээр, хязгаарлалтын бүс нутгуудын заагийг 2001 оны 2 дугаар сарын 22-ны дотор багтаан тогтоох арга хэмжээ авсугай;

б/малын гоц халдварт өвчний халдварын эх булаг, дамжсан зам, түүний үүсэгчийн хэвшил, онцлогийг шинжлэн тогтоож, түүнтэй тэмцэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлсүгэй;

в/малын гоц халдварт өвчний халдварын голомтыг устгах арга хэмжээг шуурхай авсугай;

г/Засгийн газар, Улсын байнгын онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь хариуцан зохион байгуулах мэргэжлийн алба, мэргэжилтнүүдийн бэлэн байдлыг хангуулж, халдварын бүс нутагт оруулж ажиллуулах шуурхай арга хэмжээ авсугай;

д/иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, уг өвчинтэй тэмцэх мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээний талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах, гарын авлага, мэргэжил, арга зүйн удирдлага, заавар зөвлөмжөөр хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай мэдээлэх арга хэмжээ авч байсугай.

7. Малын гоц халдварт өвчний халдварын голомт, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт мөрдөж ажиллавал зохих дүрэм, журам, ариун цэврийн горим, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллах, усны эх булгийг ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авахыг Хээрийн штабын дарга, Улсын иргэний хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Ё.Цэрэндавваа, Улсын иргэний хамгаалалтын газрын штабын орлогч дарга, хурандаа О.Намхай нарт даалгасугай.

8. Малын гоц халдварт өвчний үүсгэгчийн гарал, үүсэл, ийлдсийн хэвшлийг тогтоох, оношилгооны цомог олж нийлүүлэх, эмгэгт материалын дээж явуулж шинжлүүлэх асуудлаар холбогдох улс, олон улсын байгууллагад хандахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт үүрэг болгосугай.

9. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгах нь:

а/хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хэв журам сахиулах хүч хэрэгслийг гарган ажиллуулсугай;

б/хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрээс автомашин, мотоцикл, явган болон ердийн хөсгөөр зорчих бүх төрлийн хөдөлгөөнийг зогсоох, хязгаарлах арга хэмжээг 2001 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 00 цагаас эхлэн хэрэгжүүлсүгэй.

10. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгах нь:

а/энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлийн дагуу иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгүүдэд шилжүүлсэн аймгуудад хорио цээр, хязгаарлалт, халдвар хамгааллын арга хэмжээг иргэний хамгаалалтын төлөвлөгөө, тэдгээрийн

тодотголын дагуу шуурхай зохион байгуулсугай;

б/малын гоц халдварт өвчний халдварын голомтууд дахь халдварын эх булаг болж буй өвчилсөн болон үхсөн малын сэг, эмийг зохих журмын дагуу устгах ажлыг шуурхай зохион байгуулсугай;

в/малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдсон мэдээ, мэдээллийг нэгттэн Засгийн газарт едөр тутам танилцуулж байсугай;

г/хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа хүмүүсийг орон байр, хүнс, хоол зэрэг нэн шаардлагатай зүйлсээр хангах арга хэмжээг холбогдох яам, газар, нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх, хүн, малд шаардлагатай эм, тариа, биобэлдмэлийг хүргэх ажлыг шуурхай зохицуулж байсугай;

д/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл, зорчигчдыг нэвтрүүлэх асуудлыг зохих хууль тогтоомж, журмыг чанд сахиулах үндсэн дээр шуурхай зохицуулан шийдвэрлэж байсугай.

11. Малын гоц халдварт өвчний халдварын тархалтаас сэргийлэх, голомтыг устгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эхний ээлжинд 350,0 /гурван зуун тавин/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Улсын байнгын онцгой комиссын мэдэлд шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд, энэ хөрөнгийг зориулалтын дагуу зохистой ашиглахыг Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад тус түс үүрэг болгосугай.

12. Хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбогдон гарах нэмэлт зардлын тооцоо, үндэслэлийг тухай бүр гарган зохих журмын дагуу шийдвэрлүүлж байхын хамтаар өвчилсний улмаас устгагдсан малын нөхөн төлберийн асуудлыг хорио цээрийн хугацааг цуцалснаас хойш 1 сарын дотор багтаан холбогдох акт, баримт бичгийг үндэслэн шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа нарт даалгасугай.

13. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хүний эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээг сайжруулах, малаас өвчний халдвар авахаас урьдчилан сэргийлэх, эм, бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх, хүн амыг мэргэжлийн эвлөмж, мэдээллээр хангах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад үүрэг болгосугай.

14. Улсын хил нэвтэрсэн малыг буцааж оруулах үед мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд оруулж, 21-ээс доошгүй хоног хорио цээрийн хяналтад байлгах, халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй нөхцөлд эздэд нь шилжүүлэн өгдөг журам тогтоож хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

15. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан Дорнод аймгийн Баянхошуу, Хавирга, Сүхбаатар аймгийн Бичигтийн хилийн боомтоор гаргах экспортын зориулалттай мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүний эдийг зохих стандарт, шаардлагын дагуу ариутган халдваргүйжүүлэлт хийж, хил нэвтрүүлж байх асуудлыг БНХАУ-ын холбогдох байгууллагад тавьж шийдвэрлэхийг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд үүрэг болгосугай.

16. Зүүн бүсийн аймгуудад салаа турайт ан амьтдад гоц халдварт өвчний халдварын тандалт хийж, дүгнэлт гаргахыг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (200)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*
- *Шүүгчийн албан тушаалаас чөлөөлсөн, огцруулсан тухай*
- *Элчин сайдыг томилсон тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны дөрөвдүгээр сарын 6 №13 (200)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

145. Хайдавын Лхүнрэвт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай Дугаар 48 336

146. Чойнзонгийн Долгормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 49 336

147. Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч, ажилчин, албан хаагчдыг одон, медалиар шагнах тухай Дугаар 50 337

148. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 52 347

149. Х. Баттулгыг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 53 347

150. Ц.Булганхишигийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай Дугаар 54 347

151. Гэлэгийн Шаравт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 56 347

152. Түдэвийн Галданд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 57 348

153. Жамъянгийн Батбаярт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 58 348

154. Цэдэвийн Баатаржавт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 59 348

155. Цэдэндоржийн Ичинхорлоод Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 60 348

156. Равжирын Чулуухайд Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 61 349

157. Ёндонсүрэнгийн Намжилмаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 62 349

158. Лувсаннямын Лхагвад Монгол Улсын хүний гавьяат

эмч цол хүртээх тухай	Дугаар 63	349
159. Хүрэлдоржийн Батхишигт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 64	349
160. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 65	350
161. Хэнээгийн Сүмбэрээг “Шударга журам” медалиар шагнах тухай	Дугаар 66	352
162. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 67	352
163. Элчин сайдыг томилох тухай	Дугаар 68	353
164. Цэвээнжавын Өөлдөд Монгол Улсын гавьяат агрономич цол хүртээх тухай	Дугаар 69	353
165. Баатарын Чадраад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 70	353
166. Гончигийн Эрдэнэбулганд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 71	353
167. Зарим хүнийг одонгоор шагнах тухай	Дугаар 72	354

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Дугаар 48 **Улаанбаатар хот**

Хайдавын Лхүнрэвт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай

Барилгын цэргийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, цэргийн болон иргэний барилга байгууламжийг барих, зэвсэгт хүчний сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Барилгын цэргийн удирдах газрын дэд дарга, ерөнхий инженер, ерөнхий менежер Хайдавын Лхүнрэвт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Дугаар 49 **Улаанбаатар хот**

Чойнзонгийн Долгормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Бүх цэргийн дуу бүжгийн чуулгад олон жил үр бүтээлтэй ажиллаж, цэрэг армийн сэдвээр мэргэжлийн өндөр түвшинд гоцлон бүжиглэж, цэргийн бүжгийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж тус чуулгын гоцлол бүжигчин Чойнзонгийн Долгормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 3 дугаар сарын 12-ны өдөр **Дугаар 50** **Улаанбаатар хот**

Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч, ажилчин, албан хаагчдыг одон, медалиар шагнах тухай

Зэвсэгт хүчний албанд олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, эх орноо батлах хамгаалах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурьдсан генерал, офицер, ахлагч, ажилчин, албан хаагчдыг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

1. Равдангийн Болд - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга

2. Дагвын Гомбоо - Завсэгт хүчний 186 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа

3. Жүгдэрийн Дагдан - Зэвсэгт хүчний 326 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа

4. Цэрэнбалжидын Дашзэвэг - Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, дэслэгч генерал

5. Надмидын Жаргалсайхан - Барилгын цэргийн 030 дугаар ангийн захирагч, хурандаа

6. Чойжамцын Улаанхүү - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Улсын агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч, хошууч генерал

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

1. Цэвээндоржийн Галбадрах - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга, хурандаа

2. Туваанбуугийн Жигжидсүрэн - Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, хурандаа

3. Жамбын Орсоо - Зэвсэгт хүчний ерөнхий штабын боловсон хүчний хэлтсийн офицер, дэд хурандаа

4. Баастын Пүрэв - Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх

5. Очиржавын Пүрэвжав - Хилийн цэргийн 101 дүгээр ангийн захирагч, хурандаа

6. Раднаабазарын Төмөрсүх - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Цэргийн тагнуулын газрын радио тагнуул, тусгай радио холбооны хэлтсийн дарга, хурандаа

7. Доднонгийн Уламбаяр - Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Цэрэг иргэний хамгаалалтын штабын дарга, хурандаа

8. Будийн Цогтбаатар - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Цэргийн тагнуулын газрын стратеги, тагнуулын хэлтсийн дарга, хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Сүрэнгийн Алтанцэцэг - Цэргийн дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" улсын үйлдвэрийн газрын оёдолчин

2. Ёндонгийн Мягмарсүрэн - Цэргийн дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" улсын үйлдвэрийн газрын оёдолчин

3. Гончигсүрэнгийн Энхбаатар - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч, хурандаа

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР

1. Чойжилжавын Алтансувд - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн холбооны албаны дарга, дэд хурандаа

2. Адьяагийн Аюушжав - Барилгын цэргийн 073 дугаар ангийн ерөнхий нягтлан бодогч, хошууч

3. Бэгзийн Баасанжав - Барилгын цэргийн удирдах газрын ахлах инженер, дэд хурандаа

4. Сүрэнгийн Баасанхүү - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал

5. Дашдондогийн Баатарзолбоо - Зэвсэгт хүчний 318 дугаар ангийн штабын даргын орлогч, дэд хурандаа

6. Жамъянгийн Баатарсүрэн - Бүх

цэргийн дуу бүжгийн чуулгын гоцлол дуучин, ахлах ахлагч

7. Чогсомын Балдар - Зэвсэгт хүчний ерөнхий штабын хүн эмнэлгийн хэлтсийн ерөнхий мэргэжилтэн, хурандаа

8. Бат-Очирын Банзрагч - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

9. Батын Батмөнх - Батлан хамгаалахын их сургуулийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийн техникийн онолын тэнхмийн эрхлэгч, хурандаа

10. Жүгдэрийн Баттулга - Зэвсэгт хүчний цэргийн хэрэг бүртгэх албаны хэрэг бүртгэгч, хошууч

11. Пүрэвжавын Батцэнгэл - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

12. Чимэддоржийн Батчулуун - Улсын иргэний хамгаалалтын газрын гамшиг ослын аюулыг бууруулах хэлтсийн дарга, хурандаа

13. Дашцэрэнгийн Баянбаатар - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн орон сууцны албаны дарга, хошууч

14. Доржваанчигийн Баяндэлгэр - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

15. Пүрэвхоролын Баярсайхан - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хурандаа

16. Тогтохын Баярсайхан - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байлдааны бэлтгэлийн дарга, хошууч

17. Лхүндэвийн Бинъяа - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

18. Аюушийн Бираадорж - Зэвсэгт хүчний ерөнхий штабын жолооч, ахлах ахлагч

19. Лувсанжамцын Бямбагомбо - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн соёлын төвийн дарга, хошууч

20. Содномын Бямбадагва - Зэвсэгт хүчний 318 дугаар ангийн дивизионы захирагч, дэд хурандаа

21. Дуламжавын Бямбасүрэн - Бү цэргийн дуу бүжгийн чуулгын гоцлол дуучин ахлах ахлагч

22. Даваасамбуугийн Галбадрах - Зэвсэг хүчний 123 дугаар ангийн холбооны дарга, дэ хурандаа

23. Лхасрангийн Галбадрах - Зэвсэг хүчний 016 дугаар ангийн дайчилгаа, жагсаа ангийн офицер, дэд хурандаа

24. Ёнронравцагийн Ганхүү - Хилий цэргийн 285 дугаар ангийн захирагч, журандаа

25. Цэдэндамбаагийн Ганхүү - Зэвсэг хүчний 120 дугаар ангийн холбооны албан дарга, дэд хурандаа

26. Шархүүгийн Гантулга - Батла хамгаалах яамны Төрийн захиргаан удирдлагын газрын мэргэжилтэн, дэд хуранда

27. Дондогийн Ганхуяг - Зэвсэгт хүчни 013 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

28. Рагчаагийн Ганхуяг - Сэлэнгэ аймги Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэни хамгаалалтын штабын офицер, дэд хурандаа

29. Нацагдоржийн Даваажаргал - Зэвсэг хүчний 011 дүгээр ангийн жолооч-засварчи ахлах ахлагч

30. Даахарын Дагвадорж - Зэвсэгт хүчни 122 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

31. Шагдарын Дагвасамбуу - Зэвсэг хүчний ерөнхий штабын Цэргийн удирдлаг стратеги төлөвлөлтийн газрын офицер, дэ хурандаа

32. Гэнэнгийн Дашдаваа - Зэвсэгт хүчни 122 дугаар ангийн захирагчийн орлогч, штаб дарга, дэд хурандаа

33. Чимэдийн Дашживаа - Зэвсэгт хүчни ерөнхий штабын барилга, орон сууцны хэлтсий дарга, дэд хурандаа

34. Гэндэнгийн Ёндон - Зэвсэгт хүчни 014 дүгээр ангийн нууцын дарга, хошууч

35. Рустемийн Канад - Зэвсэгт хүчний 18 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хуранда

36. Авидын Лхагваа - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн пуужинт артиллерийн албаны дарга, хошууч

